

ТАЙЛБАР ТОЛЬ • СОЦИОЛОГИ

МОНСУДАР

ТАЙЛБАР ТОЛЬ
СОЦИОЛОГИ

100 ҮНДСЭН ОЙЛГОЛТ



МОНСУДАР

Lexikon Soziologie
Социологийн тайлбар толь

Lexikon Soziologie

Социологийн тайлбар толь

ДАА 030

ННА 92

С-61

Lexikon Soziologie

Социологийн тайлбар толь

Герман хэлнээс орчуулсан	Б.Ганхөлөг Э.Жавзандулам О.Цэрэнчимэд
Ерөнхий редактор	О.Цэрэнчимэд
Редакторууд	Б.Батчимэг Х.Түвшинтүлхүүр
Эхийг бэлтгэсэн	Э.Энэрэл

Монгол орчуулгын эрх © 2022 Монсудар хэвлэлийн газар
© 2008, 2015 Philipp Reclam jun. GmbH & Co. KG, Stuttgart

**FRIEDRICH
EBERT**
STIFTUNG

Тус бүтээлийн орчуулгыг Friedrich-Ebert-Stiftung Mongolia ивээн
тэтгэсэн болно.

ISBN 978-9919-518-12-7

*Бүх эрх хуулиар хамгаалагдсан болно. Энэхүү номын эхийг
хэвлэлийн газрын зөвшөөрөлгүйгээр хэсэгчлэн болон
бүтнээр нь дахин хэвлэх, хайлтын системд байршуулах,
цахим, механик, фото хуулбар зэрэг ямар ч хэлбэрээр хувилж
олируулах, түгээн тараахыг хатуу хориглоно.*

www.monsudar.mn

Адмон Принт ХХК-д хэвлэв

Агуулга

Фридрих Эбертийн сангийн мэндчилгээ.	10
Өмнөх үг	12

Социологийн үгийн тайлбар толь

Авторитет (Autorität).	19
Аж үйлдвэрийн/Аж үйлдвэрийн дараах нийгэм (Industrielle/Postindustrielle Gesellschaft)	22
Ажил/Чөлөөт цаг (Arbeit/Freizeit)	26
Амьдралын хэв маяг (Lebensstile)	31
Анги/Давхарга (Klasse/Schicht).	34
Байгууллага (Organisation)	40
Бие (Körper)	43
Бодит байдал (Wirklichkeit).	47
Боловсрол (Bildung)	50
Бүлэг (Gruppe).	54
Бүтэц (Struktur)	57
Гэр бүл (Familie).	62
Даяаршил/Дэлхийн нийгэмлэг (Globalisierung/Weltgesellschaft)	68
Дискурс (Diskurs).	72
Ёс суртахуун (Moral)	77

Загварууд (Modelle).	80
Зан төлөв (Verhalten).	85
Зан үйл (Ritual)	89
Зөв (Recht)	92
Зөрчил (Konflikte).	97
Идеологи (Ideologie)	101
Ижилсэл (Identität)	105
Институци (Institution)	109
Интеграци/Эв санааны нэгдэл (Integration/Solidarität).	113
Интерсубъектив харилцаа (Intersubjektivität)	117
Капитал (Kapital)	120
Конструктивизм (Konstruktivismus).	124
Масс (Masse).	128
Материалист нийгмийн онол (Materialistische Gesellschaftstheorie)	132
Методологи (Methodologie).	136
Мэдлэг (Wissen).	141
Мэргэжил (Beruf).	145
Нийгмийн онол (Sozialtheorie)	149
Нийгмийн сэтгэл судлал/Нийгмийн антропологи (Sozialpsychologie/Sozialanthropologie)	155
Нийгэм (Gesellschaft).	159
Нийгэмшил (Sozialisation).	166

Ноёрхол (Herrschaft)	171
Ойлгох, тайлбарлах (Verstehen/Erklären)	174
Олон нийт (Öffentlichkeit)	179
Оролцогч (Akteur)	183
Оролцоог хангах/Оролцоог хязгаарлах (Inklusion/Exklusion)	186
Орон зай (Raum)	189
Орчин үе/Модерн (Moderne)	193
Өдөр тутам (Alltag)	197
Өөрчлөлт (Wandel)	200
Постмодерн (Postmoderne)	204
Постструктурализм (Poststrukturalismus)	208
Рационал сонголтын онол (Rational-Choice-Theorie)	212
Симбол (Symbol)	216
Симболик интерактивизм (Symbolischer Interaktionismus)	221
Систем (System)	224
Социологи (Soziologie)	229
Спорт (Sport)	237
Статистик (Statistik)	242
Соёл (Kultur)	246
Соёл иргэншил (Zivilisation)	250
Субъект (Subjekt)	254

Сүлжээ (Netzwerk)	258
Тоглоом (Spiel).	261
Тохиолдлын боломж (Kontingenz).	266
Төр (Staat)	269
Тэгш бус байдал (Ungleichheit).	273
Улс төр (Politik)	278
Утга санаа (Sinn)	282
Утопи (Utopie).	286
Үеийнхэн (Generation).	289
Үйлдэл (Handlung)	292
Үүрэг (Rolle)	299
Үхэл (Tod)	302
Феноменологийн социологи (Phänomenologische Soziologie)	306
Функционализм (Funktionalismus)	309
Хабитус (Habitus).	314
Хамтын нийгэмлэг (Gemeinschaft).	317
Харилцаа (Kommunikation).	320
Харилцан үйлчлэл (Interaktion)	325
Хөгжил (Entwicklung)	328
Хувь хүн/Хувь хүнчлэл (Individuum/Individualisierung)	332
Хувьсал (Evolution)	338
Хүйс (Geschlecht)	342

Хүрээлэл (Milieu)	347
Хүрээлэн буй орчин (Umwelt)	351
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл (Medien)	356
Хэм хэмжээ/Зөрчил (Norm/Devianz)	360
Хяналт (Kontrolle)	364
Цаг хугацаа (Zeit)	368
Цөөнхүүд/Гадуурхагдсан бүлэг (Minderheiten/Randgruppen)	373
Чинээлэг ба нийгмийн баримжаат төр (Wohlfahrts- und Sozialstaat)	377
Шашин (Religion)	380
Шилжилт хөдөлгөөн (Migration).	384
Шинжлэх ухаан (Wissenschaft)	388
Шүүмжлэлт онол (Kritische Theorie).	389
Эдийн засаг (Wirtschaft)	394
Элит (Elite)	398
Эмпирик (Empirie)	401
Эрүүл мэнд/Өвчин (Gesundheit/Krankheit)	406
Эрсдэл (Risiko)	410
Эрх мэдэл/Хүчирхийлэл (Macht/Gewalt)	414
Эрх чөлөө (Freiheit).	418
Этнометодологи (Ethnomethodologie)	422
Ялгарал (Differenzierung)	426

Фридрих Эбертийн Сангийн мэндчилгээ

Эрхэм уншигчид аа,

Фридрих-Эбертийн Сан нь германы ууган улс төрийн ууган сан юм. Манай сан 30-аад жилийн өмнөөс Монгол улсад социал-демократ бодлогын сэдвүүдийн хүрээнд монгол түншүүдтэйгээ хамтран ажиллаж байна.

Энэ хамтын ажиллагааныхаа хүрээнд бид олон сэдвүүдээр хэлэлцүүлэг санаачлан өрнүүлдэг. Хэлэлцүүлэг маань ихэвчлэн жижиг чулуугаар том чулуу доргионо гэдэг монгол түмний хэлц үгэнд хэлсэнчлэн жижгээс том руу шилжин өрнөдөг. Бид тодорхой нэг асуудлаар хэлэлцүүлгээ эхлүүлдэг ч оролцогчид маань эцэст нь нийгмийн шударга ёс зэрэг том асуудал руу шилжсэн байдаг.

Эдгээр нь нөхцөл байдал өөрчлөгдөх бүрд өөрөөр тавигдаж байдаг сэдвүүд учраас хэзээ ч он цагийн эргэлтэд хуучирдаггүй, ахин дахин шинээр тавигдсаар байдаг ойлголтууд билээ.

Эрх чөлөөтэй, шударга, эв санааны нэгдэлтэй нийгэм бол ямагт манай сангийн монгол түншүүдтэйгээ хэрэгжүүлэх хамтын ажиллагааны маань гарааны болон зорилтот цэг нь байсаар ирсэн. Иймээс өнөөдөр би та бүхний ширээн дээр байгаа герман хэлнээс орчуулгын төслийн хүрээнд орчуулагдсан 100 үндсэн үгийн нэр томъёоны лавлах толь маань Монгол улсад өрнөх олон олон хэлэлцүүлэгт өчүүхэн ч атугай хувь нэмэр болох болов уу хэмээн найдаж байна.

Зөвхөн хамтран ажилладаг түншүүддээ төдийгүй энэ 100 ойлголтыг сонирхож буй бүх хүмүүст би хандаж байна. Иймээс Фридрих-Эбертийн Сангийн Монгол дахь салбар өөрийн вебсайт дээр энэ бүтээлийг үнэ төлбөргүйгээр тавих болно. Та бүхэн татан авч ашиглаарай.

Зөвхөн үгчлэн орчуулаагүй, үгсийн цаад утга санаа, үзэл баримтлалуудыг орчуулах арга барилаар энэ гайхамшигтай, нүсэр орчуулгыг хийж гүйцэтгэсэн доктор Отгонтогтоолын Цэрэнчимэдээр ахлуулсан орчуулгын багийн хамт олонд би гүн талархал илэрхийлж байна.

Би энэ нэвтэрхий толийг үйл ажиллагаандаа ашиглах боломжтой болсондоо, мөн энэ номыг монголын олон уншигчдын хүртээл болгож буйдаа нэн баяртай байна.

Гүнээ хүндэтгэсэн ФЭС-гийн Монгол дахь
төлөөлөгчийн газрын захирал

Бенедикт Ивановс



Өмнөх үг

Aristoteles хүнийг бусад хүмүүсээс хамааралтайгаар хамтран амьдрах зохилдлоготой *zoon politikon* буюу “нийгмийн амьтан” гэж аль эрт тодорхойлсон байдаг. Энэхүү нийгмийн хамаарал нь хүмүүсийг өөрсдийн хамтран амьдрах хэлбэр, боломжуудын талаар тунгаан бодоход хүргэж байв. Үүнтэй холбоотой үндсэн асуултуудыг аль хэдийн антикийн үеийн философид боловсруулж байжээ: *Нийгмийн дэг журам хэрхэн бий болдог вэ? Түүний өөрчлөлт хэрхэн явагддаг вэ? Амьдарч буй нийгмийнхээ бүтцэд хүмүүс ямар нөлөө үзүүлдэг вэ? Мөн эсрэгээрээ: Нийгмээс тавигдах шаардлагууд нь хүмүүсийн хандлага, харьцаа, харилцааны арга барилд яаж нөлөөлдөг вэ?*

XIX зуунд нийтэд “орчин үе” гэж нэрлэгддэг нийгмийн хэлбэрт шилжиж, орчин үеийн эхэн үеийн Европыг донсолгож байсан нийгэм, техник, соёлын бослогын хүрээнд эдгээр асуултууд анх бие даасан шинжлэх ухаанд орж иржээ. Хуучин нийгмийг зөвтгөдөг уламжлалт шашинлаг хэв загвар нь бат бөх язгууртны бүтцийнхээ хамтаар мөн алга болсон тул аж үйлдвэржилтийн үр нөлөө, түүнтэй уялдаатай нийгмийн асуудлуудаар тодорхойлогдох шинэ нийгмийн хурдацтай өөрчлөлтүүдийг тайлбарлах шаардлага үүссэн. Энэхүү даалгавар XIX зууны хоёрдугаар хагасаас хойно үүсгэн байгуулагдсан, дотроо социологиос гадна үндэсний эдийн засаг (сүүлд: эдийн засгийн шинжлэх

ухаан), улс төрийн шинжлэх ухаан, антропологиийг багтаасан нийгмийн шинжлэх ухаанд оноогдох нь улам бүр нэмэгдэж байсан. Ингээд тэд нийгэм дэх хүмүүсийн хамтын амьдралын бүх талын асуудалд анхаарлаа төвлөрүүлэх болжээ.

Нийгмийн шинжлэх ухааны хамгийн цогц салбарт тооцогддог социологийн сонирхолтой тал нь түүний судалгааны олон талт байдалд оршдог. Гэхдээ нэгэнд нь олон талтай мэт харагдавч нөгөөд нь төөрөгдүүлэхээр, эцэс төгсгөлгүй мэт санагддаг. Ийм сэтгэгдлийг сөрж ажиллахын тулд, мөн төвлөрдөг асуудлууд, үндсэн судлагдахуунуудтай зохион байгуулалт бүхий ажлын талбар гэдгээр нь социологийг илүү хүртээмжтэй болгохын тулд энэхүү социологийн лавлах толь, нийгмийн онол номыг тухайн салбарыг сонирхож буй шинэ хүмүүст болон ахисан түвшний уншигчдад зориулан гаргаж байна. Нэг зуун үндсэн нэр томъёог ойлгоход хялбар, гэхдээ өнгөцхөн бус нийтлэлүүдээрээ социологийн сэтгэлгээний болон ажлын чухал ангиллуудын тухай ойлголттой болох боломжийг олгож байгаа юм.

Бидний сонгосон гарчиг бэлхнээ илтгэж байгаачлан, эмпирик шинжлэх ухаан гэдэг социологийн уламжлалыг, энэхүү хүрээнд хийгдсэн тодорхойлоход хэцүү “нийгмийн” судлагдахууны талаарх онолын системчилсэн мэтгэлцээнд анхаарал хандуулдаг шиг бас анхааралдаа авах ёстой юм: Нэг талаас нийгмийн бодит байдлыг аль болох нарийвчлалтай, хийж болохуйц ажиглалтаас мэдлэгийг олж авдаг социологийн сэдэв,

дэд салбаруудын талаар хэлэлцэх нь чухал. Нөгөө талаас энэхүү лавлах толь нь нийгмийн онолд чиглэгддэг. “Нийгэм” гэдэг нь социологид нийтлэг байдаг шиг зүгээр нэг хувь хүний үйлдэл эсвэл сэтгэл зүйн төлөв байдлын цогц нийлбэрийг хэлэхгүй, харин өөрийн гэсэн хууль дүрмийн дагуу бүтээгдсэн бодит байдлын талбар юм. Бид “конструктивизм” эсвэл “постструктурализм” гэх мэт анхнаасаа социологийн биш ч социологийн судалгаанд нөлөө бүхий хандлагуудыг хамруулахын тулд өргөн хүрээний нэр томьёо болох “нийгмийн онол”-ыг “социологийн онол”-оос урьтал болгосон. Социологи, нийгмийн онолын энэ лавлах толиор 100 үндсэн нэр томьёонд багтаан аль болох социологийн олон талбарыг тэнцвэртэй байдлаар харуулахыг зорьсон. Мэдээжийн хэрэг, нэр томьёонуудыг сонгосон шалгууруудын талаар, ялангуяа эдгээр нь “үндсэн нэр томьёо” гэдгээр ашиглагдвал маргах орон зай хэзээд гарах нь дамжиггүй юм. Түлхүүр үгээ олохгүй, хайж байгаа уншигчдын хувьд нэрсийн жагсаалтаас лавлан харах боломжтой ба үүгээр дамжуулан тусгайлан авч үзээгүй олон социологийн нэр томьёог ядаж текст дотроос олоход дөхөмтэй болгосон. Түлхүүр үгсийн жагсаалтад “социологи” эсвэл “нийгэм” гэх мэт үндсэн нэр томьёог тоймлон оруулахаас гадна нэг бол онолын тодорхой үзэл баримтлалтай холбоотой судалгааны чиглэлийг заасан нэр томьёонууд (“ялгарал”, “тэгш бус байдал” гэх мэт), эсвэл тухайн ойлголтыг тойроод социологийн тодорхой судалгааны талбар хөгжсөн байдаг нэр томьёонууд (“гэр бүл”, “эдийн

засаг”) багтсан. Эцэст нь социологичдын ажлын арга барил, танин мэдэхүйн стратегийг тодорхойлох (“методологи”, “статистик”, “ойлгох” гэх мэт) түлхүүр үгсийг мөн олж болно. Аль болох илүү ойлгомжтой байлгахын тулд тодорхой онолыг юм уу эсвэл тусгай социологийг нэрлэдэг олон тооны бүрэлдэхүүнийг тусгайлан бүгдийг нь авч жагсаалгүйгээр ижил нэртэй түлхүүр үгсийн (“системийн онол” гэхийн оронд “систем”, “соёлын социологи” гэхийн оронд “соёл” гэх мэт) хүрээнд нь авч үзсэн болно. Мөн дээрхтэй ижил шалтгаанаар “нийгмийн” гэсэн тодотгол үгийг гарчигласан нэр томъёонуудад нийтэд нь хавсарган оруулахаас татгалзсан болно (“нийгмийн бүлэг” гэхийн оронд “бүлэг” гэх мэт). Нийтлэлүүдийн бүтэц нь тохиолдол бүртээ бага зэргийн ялгаатай байж болох нэг загвараар бичигдсэн: Нийтлэл эхлэхдээ тухайн түлхүүр үгийг нэрлэж, товч тодорхойлох ба үүний араас ихэвчлэн нэр томъёоны түүхэн, заримдаа системчилсэн бүтэцтэй танилцуулгын хэсэг залгаж байгаа. Нийтлэл бүрийн төгсгөлд текстэд дурдсан гарчгийг нөхөх, уншигч олонд цааш дэлгэрүүлэн уншихад нь зориулан (аль болох сүүлийн үеийн) тойм бүтээлийн жагсаалтыг оруулсан. Мөн ийм зорилгоор Герман хэл дээрх социологийн гарын авлага болдог бүтээлүүд, нэр бүхий социологийн сэтгүүлүүд, социологи ба нийгмийн онолын талаарх сүүлийн үеийн танилцуулгын жагсаалтуудыг хавсралтаар оруулж өгсөн. Мөн бүтээлд орсон мэргэжлийн үг хэллэг, хүмүүсийн бүртгэлийг хавсаргасан.

Нийтлэлүүдэд давхардаж хөндөгдөх нэг сэдвийг түлхүүр үгийн тусламжтайгаар олох боломжийг сумтай зураас бүхий хөндлөн чиглүүлэгчээр (→) тэмдэглэсэн байгаа. Түлхүүр үгсийн товчлол нь ганц ба олон тоон дээр илэрхийлэгдэж болно. Тиймээс “О” гэж товчилбол энэ нь “оролцогч”, “оролцогчид” аль алиныг нь илэрхийлж болно. Мөн хүйс заасан үг, тоо, тийн ялгалыг товчилсон үгэн дээр харгалзаагүй. Бусад товчлолуудын тухайд ДҮДЭН-ийн зөв бичих дүрмийн стандартыг дагасан юм. Орон зайн давчуу хязгаарлалтаас үүдэн эр/эм хүйс заасан үгсийг хоёуланг нь үргэлж нэрлэж явах боломжгүй байсан тул үүнийг давхар бодолцон хүлээж авах хэрэгтэй гэдгийг анхааруулах нь чухал биз ээ.

Социологи, нийгмийн онолын лавлах толийн зохиогчид дотор зөвхөн социологийн төдийгүй мөн философи, антропологи, түүх, улс төр болон утга зохиол судлалын төлөөллөөс багтсан юм. Тэд бүгдээрээ өөрсдийн нийтлэлийг ойлгоход аль болох хялбар байлгах шаардлагыг харгалзахын зэрэгцээ товч бөгөөд тодорхой байдлыг хадгалах онцгой сорилтоор холбогдсон юм. Зориглон оролцсон бүх хүмүүстээ, хамтын таатай ажиллагаанд нь редакцын зүгээс чин сэтгэлийн талархал дэвшүүлье.

Bremen/München, im April 2008
Sina Farzin, Stefan Jordan

Социологийн тайлбар толь

Авторитет (Autorität)

Авторитет (латинаар *auctoritas* = “нөлөө”, “алдар хүнд”, “сүр сүлд”; *auctor* = “бүтээгч”, “дагуулагч”) гэдэг нь харилцан уялдаа бүхий янз бүрийн хэмжигдэхүүнээр авч үзэхэд эрх мэдэлд итгэгчдээс ихэнхдээ оршихуйн хувьд давуу харагддаг, тиймээс бусад нь өөрийн хүсэл зоригоор түүний эрх мэдэлд орж захирагддаг, эрхэмжийн хувьд байгаагаараа бусдад хүлээн зөвшөөрөгдсөн хүний (→ хувь хүн) тухай ойлголт. Ерөнхийдөө авторитет бол хүлээн зөвшөөрөгдсөн, хүндэтгэл хүлээсэн эрх мэдэл юм. Хэн нэгэнд авторитет эрх мэдэл олгох нь өөрөө сайн дураараа түүний дор захирагдаж, түүнээс хамааралтай байдлаа илтгэж байна гэсэн үг болно. Бусдын давуу байдлыг хүлээн зөвшөөрөх нь өөрийгөө дутуу үнэлж байгаатай адил. Тиймээс авторитет харилцааны гол шинж чанар нь тэгш бус байдал болон зайнаас харьцах асуудал байдаг.

Авторитет байдал хүндлэгддэгийн шалтгаан нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн эрхэм зүйлс, ёс суртахууны илэрхийлэл болж, бусдыг чиглүүлж, аюулгүй байдлыг хангасан дэг журам бий болгодогт оршдог. Авторитет хүнд итгэдэг хүмүүсийн хувьд энэ нь амин хувийн шинж чанараасаа давсан бие хүн буюу “объектив эрх мэдэл” мэт харагддаг (Georg Simmel). Мөн институцийн объектив, халдашгүй байдал, уламжлал нь үүнтэй төстэй нөлөөг үзүүлж болох (жишээ нь, төрийн эрх мэдэл) бөгөөд эрх мэдлийг авторитет гэж, мөн одоо байгаа ноёрхлын харилцаанд доод албан

тушаалтнуудын дасан зохицох механизм гэж хүлээн зөвшөөрч байгаагаар үүнийг тайлбарлаж болох юм (→ Ноёрхол).

Байгууллагын → өдөр тутмын харилцаанд авторитет байдлыг хүлээн зөвшөөрөх нь тэдний албан ёсны албан тушаалын эрх мэдэл (албаны авторитет), тусгай, онцгой мэргэжлийн мэдлэг эсвэл зохион байгуулалтын авьяас чадвар (мэргэшсэн авторитет/функциональ авторитет) эсвэл хувь хүнийхээ хувьд тодорхой үнэлэмжийн хүрээнд үлгэр жишээ болдог гайхалтай чанарууд (хувь хүний авторитет/харизм)-тай холбогдож болно. Авторитетийн эдгээр хэлбэрүүд нь нэг нэгнээсээ хамааралгүй, янз бүрийн холимог эсвэл хурцадмал байдлаар гарч ирж болно. Иймээс жишээ нь, өндөр албан тушаал хашиж буй хүн уг албыг “хашиж” чадахын тулд ихэвчлэн зохих мэргэжлийн ур чадвартай байхаас гадна хамгийн чухал нь тодорхой хэмжээнд хувийн шинж чанарыг хардаг. Эсрэгээрээ харизмтай авторитет нь зарим нэг шаардлагатай тохиолдолд өөрийн албаны авторитет байдлын үндэс болсон бюрократ дүрмийг зөрчиж нэр хүндээ өсгөдөг. Авторитет гэж хэлэгдэхийн тулд, үүнд итгэгчдийн өөрсдийнх нь бас хүсэж тэмүүлдгээр эрхэмжтэй, ёс жудагтай байх хэрэгтэй учраас “бүдүүлэг” эрх мэдлийн хэрэгсэл (сүрдүүлэг, хориг арга хэмжээ)-ээс утгаа бол татгалзаж, бусдын хүлцэнгүй чанарыг тохирох хүндлэлийг харилцан үзүүлэх замаар удирдана. “Бид онцгойлон хүлээн зөвшөөрдөг хүмүүсээрээ онцгойлон хүлээн зөвшөөрөгдөхийг хүсдэг” (Heinrich Popitz,

Phänomene der Macht, 1992). Тиймээс маргаангүй авторитет бол ихэвчлэн дарангуйлагч байдаггүй. Харин дарангуйлдаг, албаны олгогдсон эрх мэдлийг дөвийлгөсөн зохисгүй зан авир бол ихэнхдээ бусдад бүрэн хүлээн зөвшөөрөгдөөгүй, бие даасан бус байдлыг илтгэдэг. Нөгөөтээгүүр, хэрэв авторитетээр төлөөлүүлж буй хэв журам ноцтойгоор зөрчигдөж, эрхэмжтэй зүйлс алдагдахад хүрвэл авторитет өөрт олгогдсон эрх мэдлийг үргэлж шийдэмгий хэрэгжүүлж байх ёстой.

Авторитет харилцааны тэгш бус бүтцээс маргаан үүсэж байдаг. Ингэхдээ авторитет зөрчилд ихэвчлэн дарангуйллын эсрэг “татгалзагч холбооснууд” бий болдог (Richard Sennett, *Authority*, 1980, dt. 1985). Хувийн бие даасан байдлаасаа татгалзан байж эргэлзээгүй хүлээн зөвшөөрөгдсөн авторитет өөрийн төлөөлж буй бүхнээсээ гэнэтийн, огцом шийдвэрээр түдгэлзэх талтай байдаг. Иймэрхүү “талархалгүй байдал”-д үзүүлэх авторитетийн дарангуйлсан хариу үйлдэл нь маргааныг улам хурцатгадаг. Авторитетийн хамаарлаас ангижирч, бие даасан байдалд суралцах даалгавар бол өөрийн зөн совин, танин мэдэхүй, үйл хөдлөлөөрөө түүний нөлөөллөөс алхам алхмаар холдохын зэрэгцээ авторитет гэдэг ойлголтын талаар албан хүчээр тэдэнд очиж наалдахгүйгээр, цаашид ч тэднээс хамааралтай болохгүйгээр тэдний жинхэнэ хүч чадал, ололт амжилтыг хүлээн зөвшөөрч болохоор мэдлэгтэй болох явдал юм.

Heinz Hartmann: Funktionale Autorität. Stuttgart 1964.

Theodor Eschenburg: Über Autorität. Frankfurt a. M. 1965, ²1976.

Lutz Zündorf / Manfred Grunt: Hierarchie in Wirtschaftsunternehmen. Frankfurt a. M. / New York 1980.

Wolfgang Sofsky / Rainer Paris: Figurationen sozialer Macht. Autorität – Stellvertretung – Koalition. Opladen 1991, Neuausg. 1994.

Аж үйлдвэрийн/Аж үйлдвэрийн дараах нийгэм (Industrielle/Postindustrielle Gesellschaft)

Аж үйлдвэрийн нийгэм ба аж үйлдвэрийн дараах нийгэм нь → нийгмийн хөгжлийн эдийн засаг, техникийн түвшнийг илэрхийлдэг ойлголтууд юм. Аж үйлдвэрийн нийгэм уламжлалт хөдөө аж ахуйн нийгмийн тогтцоос ялгаатай нь аж үйлдвэрийн (массын) үйлдвэрлэл болоод техникийн → мэдлэгийг бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлд (→ эдийн засаг) системтэй ашиглаж байгаагаар тодорхойлогддог. Үүний сацуу үйлдвэржилтийн үйл явцтай зэрэгцэн юуны түрүүнд хөдөлмөрийн хуваагдал нэмэгдэх, аж ахуйн болон өрх гэрийн ажлыг тусгаарлах эсвэл хотжилт (→ ажил, мэргэжил) зэрэг нийгмийн-бүтцийн өөрчлөлтүүд дагалдана. Тоон утгаар нь авч үзвэл, хэрэв анхдагч (олборлох) эдийн засгийн секторын (хөдөө аж ахуй, уул уурхай) нэмүү өртөг бий болгох, ажлын байраар хангахад эзлэх хувь нь хоёрдогч (үйлдвэрлэх)

секторынхоос (бүтээгдэхүүн үйлдвэрлэл, гар урлал) доогуур байгаа тохиолдолд энэ нийгмийг үйлдвэржсэнд тооцож болно. Харин аж үйлдвэрийн дараах нийгмийн тухай ойлголтоор XX зууны дунд үеэс хөгжиж буй аж үйлдвэрийн нийгэмд гарсан өөрчлөлтийн үндсэн чиг хандлагуудыг хүргэх зорилготой юм. Аж үйлдвэржилт баруун хойд Европт XVIII зууны дунд үеэс эхэлж, XIX зуунд Европын бусад орнууд болон АНУ-д тархсан. Германд XIX зууны дунд үед нийт ажилчдын дөнгөж 20 орчим хувь нь хоёрдогч секторт ажиллаж байсан. Энэ хувь хэмжээ Германы хаант засгийн өндөр хурдацтай үйлдвэржилтийн үе шатанд 40 орчим хувь хүртэл өсөж, 1960, 1970-аад онд оргилдоо бараг 50 хувьд хүрсэн байна. 1980-аад оноос хойш гуравдагч сектор (үйлчилгээ) нь нэмүү өртгөөр төдийгүй хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн тоогоор аль алинд нь илт давамгайлж ирсэн.

Аж үйлдвэрийн нийгмийг нийгмийн шинэ хэлбэр болох санааг анх XIX зууны эхээр Henri de Saint-Simon гаргаж, дараа нь Auguste Comte, Herbert Spencer нар үргэлжлүүлэн хөндөж байжээ. Saint-Simon (*Du système industriel*, 1821, dt. 1977) аж үйлдвэрийн нийгмийг асар их баян тансаг байдал, шударга цалин хөлс, хөгжил дэвшил, эмх цэгцийг хослуулснаараа ялгарч байх ёстой гэсэн утопи санааг гаргаж байв. Эргээд харахад Saint-Simon-ы ажилд аль хэдийн хоёр үндсэн асуудлын шугам тодордог бөгөөд энэ нь дараах хэлэлцүүлгийг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой болсон. Нэг талаас, сонгодог байдлаар Émile Durkheim (*De la divi-*

sion du travail social, 1893, dt. 1977)-ийн авч үзсэн аж үйлдвэрийн нийгмийн интеграцчиллын (→ интеграци) асуудал; нөгөө талаас, Karl Marx (*Das Kapital*, 3 Bde., 1867–94)-ын бүтээлээр тодорхойлогддог ажиллах хүч ба үйлдвэрлэлийн нөхцөл (үндсэндээ өмчийн харилцаа; → капитал). Сүүлчийн асуудалтай холбоотой асуулт бол нийгмийг илүүтэй ажиллах хүчнийг бодолцож аж үйлдвэрийн нийгэм гэж үзэх үү, эсвэл үйлдвэрлэлийн нөхцөлөө бодож капиталист нийгэм гэж үзэх үү гэсэн асуулт юм. Энэ асуултын хариултаас нийгмийн → тэгш бус байдал, ядуурал эсвэл экологийн → эрсдэл гэх мэт нийгмийн асуудлыг шийдвэрлэх ямар арга зам байж болох, мөн нийгэм, эдийн засгийн хөгжлийн динамикийг юу бүрдүүлэх вэ гэдэг хамаарна. ЗХУ-д аж үйлдвэржилт хурдсахын зэрэгцээ дэлхийн II дайны дараа үйлдвэржилтийн хоёр дахь давлагаатай холбоотойгоор ялангуяа Азид функционалист үзэл баримтлал ба шинэчлэлийн онол (→ орчин үе) юуны түрүүнд социологийн хэлэлцүүлгүүдийн анхаарлын төвд орж байв. Өрнө болон Дорнын хоорондох тогтолцооны зөрчилдөөнөөс үүдэн конвергенцийн маргаан гарч ирсэн бөгөөд түүний хурц хэлбэрийн үр нөлөөгөөр бол аж үйлдвэрийн хөгжлийн динамик тухайн үйлдвэрлэлийн нөхцөлөөс үл хамааран өргөн хүрээнд нэгэн хэвийн бүтцийг бий болгохын зэрэгцээ капитализм ба социализмын тэнцвэржүүлэлтэд хөтөлж болох юм. Эдгээр мэтгэлцээнүүд үр дүнтэй байхын хэрээр аж үйлдвэрийн нийгмийг судалгааны талбар болгон хөгжүүлэх болон улс төр, соёл, нийгэм-

эдийн засгийн ялгааг мэдрэх мэдрэмжийн хоорондох харьцуулалт ихсэх нь харагдсан.

1960-аад оноос хойш болон дараагийн хорин жилд аж үйлдвэрлэлээс үе шаттайгаар бүрэн ангижрах, аж үйлдвэрийн нийгэмд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн сектороос үйлчилгээний сектор руу шилжилт явагдсан онцлогтой. Аж үйлдвэрийн нийгмийн хөгжлийн динамикаар энэ нь цааш хөгжих нь тодорхой болсон. Үүнд дурдахад боловсролын өндөр шаардлага хангасан техникийн, захиргааны болон чөлөөт мэргэжлүүдийн ангилал хөдөлмөр эрхлэлтийн бүтцэд ихээхэн нэмэгдсэн. Daniel Bell (*The Coming of Post-Industrial Society. A Venture in Social Forecasting*, 1973, dt. 1973)-ийн нэвтрүүлсэн “аж үйлдвэрийн дараах нийгэм” гэх өнөөдрийн “мэдээлэл, мэдлэгийн нийгэм” гэж нэрлэгдэх болсон-энэхүү ойлголт нь хөгжингүй аж үйлдвэрийн нийгмийн эдгээр болон бусад чиг хандлагыг үзэл баримтлалын хувьд нэгтгэж, энэхүү шинэ хэлбэрийн нийгмийн загварын үндсэн бүтцийг харуулах зорилготой юм. Энд дөрвөн хэмжигдэхүүн социологийн сонирхлын төвд байна: (1) нэмүү өртгийг бүтээхэд мэдлэг, инновац болон техникийн хөгжил гол үүрэгтэй; (2) “ухаалаг технологи”, дэд бүтцийн матриц болох мэдээлэл, харилцаа холбооны шинэ технологи (→ харилцаа холбоо); (3) нэг талаас хурдтай мэдээлэл болон мэдлэгт суурилсан ажилд, нөгөө талаас энгийн үйлчилгээний ажилд хөдөлмөрийн бүтцийн өөрчлөлт хийх; (4) зохион байгуулалтын → өөрчлөлт аж үйлдвэрийн нийгмийн гол таних тэмдэг болсон

бюрократ бүтцээс илүү хэвтээ бүтэц, → сүлжээний холболтод шилжих.

Jochen Steinbicker

Raymond Aron: Dix-huit leçons sur la société industrielle. Paris 1963. – Dt.: Die industrielle Gesellschaft. Übers. von Gernot Gether. Frankfurt a. M. 1965.

Manuel Castells: The Information Age: Economy, Society and Culture. 3 Bde. Malden/Oxford 1996–98. – Dt.: Das Informationszeitalter. Übers. von Reinhard Kößler. 3 Bde. Opladen 2001–03.

Jochen Steinbicker: Zur Theorie der Informationsgesellschaft. Opladen 2001.

Rainer Geißler: Die Entstehung der Industriegesellschaft: sozioökonomischer Wandel im 19. Jahrhundert. In: R. G.: Die Sozialstruktur Deutschlands. Zur gesellschaftlichen Entwicklung vor und nach der Vereinigung. Opladen 2002. S. 23–47.

Ажил/Чөлөөт цаг (Arbeit/Freizeit)

Ажил (латинаар *labor*; англиар *work, labour*; францаар *travail*) гэж бие махбодын болоод оюуны ачаалал шаардах хүчин чармайлтыг хэлэх ба үүний зорилго нь амьжиргааг баталгаажуулжа хуйн нөөцөө бүрдүүлэхийн тулд биеийн давтан хөдөлмөр эрхлэх явдал юм. Үүний зэрэгцээ ажлыг бусдаас хамааралтай үйл гэдэг

утгаар нь жишээлбэл, Hannah Arendt “үйлдвэрлэх” ба “үйлдэх” гэж тодорхойлсон байдаг (*Vita Activa oder Vom tätigen Leben*, 1960). Ажлаар өөрийгөө нээж, даалгавар биелүүлж, нийгэмд хүлээн зөвшөөрөгдөж байна гэдэг утгаараа ажил нь хүмүүсийн нийгмийн болоод сэтгэл зүйн хэрэгцээг бас хангаж байдаг.

Нийгэм, эдийн засгийн хэлбэрүүд хувьсан өөрчлөгдсөнөөр ажил, түүний утга бас өөрчлөгдсөн. Karl Marx ажлыг капитализмд “хөлсний ажил” (→ Капитал, Материалист нийгмийн онол) гэж тодорхойлдог. Энд ажлын гол онцлог бол ажилчны “хөндийрөл”-өөс шалтгаалсан бүтээгдэхүүний чанар юм. Хөрөнгөтнүүд ажилчны хөдөлмөрийг “мөлжих”-д хүргэдэг шалтгаан бол тэд ажилчдыг нийгмийн хувьд шаардлагатай цагаас хэтрүүлэн ажиллуулдагтай холбоотой. Илүү үйлдвэрлэлээрээ бараа бүтээгдэхүүний зах зээл дээр олж авсан “нэмүү өртөг”-ийг хөрөнгөтөн өөртөө ашгийнхаа суурь болгон авч үлддэг (*Ökonomisch-philosophische Manuskripte*, 1844). Émile Durkheim (*De la division du travail social*, 1893, dt. 1977) нийгмийн хөдөлмөрийн хуваарилалтыг орчин үеийн нийгмийн → эв санааны нэгдлийн үндэс суурь гэж үзсэн байдаг.

→ Аж үйлдвэржсэн нийгэмд бие даасан бус цалинтай ажил эрхлэлт эсвэл хөлсний ажил нь хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх хэсгийг хамаардаг учраас нийгэм, эдийн засгийн чухал ач холбогдолтой. Хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн гэрээн дээр суурилдаг бөгөөд үүнд ажилтан ажил олгогчоос тодорхой хугацааны турш өдөр бүр, долоо хоног болгон цалин авч, ажиллаж

байхыг тусгасан байна. Ажлаас бусад үлдсэн цагийг чөлөөт цаг гэх ба энэ нь гэхдээ ажилгүй гэсэн утга агуулахгүй. Учир нь чөлөөт цагийн ихэнх хугацаа гэрийн ажил эсвэл бусад үйл ажиллагаанд зориулагддаг. Чөлөөт цаг гэж цалинтай хөдөлмөр эрхлэхэд зарцуулах цагийг биш, харин ажилтны хувийн орон зайд бий болж байгаа цагийг хэлэх юм. Ажил/Чөлөөт цаг гэсэн хоёр ойлголт нь аж үйлдвэржсэн нийгэмд ажилчин хүний тогтсон нөхцөл байдлыг илэрхийлж байгаа бөгөөд энэ нь хөдөлмөрийн цагийн зохицуулалтаар тодорхойлогддог. Цагийн зохицуулалтыг ажил олгогчдын байгууллага, ажилчдын ашиг сонирхлын төлөөлөгч болох үйлдвэрчний эвлэлийн хамтын хэлэлцээрийн үндсэн дээр гаргах бөгөөд хууль тогтоомжид ердийн ажлын цаг гэж тусгагдсан байдаг.

Аж үйлдвэржсэн нийгмийн хөгжлийн явцад өдрийн болон долоо хоногийн ажиллах цагийг богиносгож чөлөөт цагийг уртсахад хүргэсэн. Үүнийг “чөлөөт цагийн нийгэм” гэсэн түлхүүр үгээр илэрхийлдэг. Хүмүүсийн чөлөөт цагаа хэрхэн өнгөрөөж байгаа хэв маягийг судалдаг социологийн судалгааны дотроос гэр бүлийн үүрэг хариуцлага (→ гэр бүл), өдөр тутамд хийж гүйцэтгэх шаардлагатай ажил (→ өдөр тутмын амьдрал) болоод хувийн чөлөөт цагаа юунд зарцуулж байгаа зэрэг хувийн амьдрал дахь янз бүрийн үйл ажиллагаанд зориулагдах цаг хугацааны харьцааг судалдаг цаг-төсвийн судалгаа онцгой ач холбогдолтой юм. Ажлын цаг, чөлөөт цагийг судлах нь мөн эдийн засгийн ашиг сонирхлоос (→ эдийн засаг) үүдэлтэй байдаг. Учир нь

үүгээр хэрэглээний цагийг тодорхойлох бөгөөд үүнтэй холбоотойгоор дэлгүүр, худалдааны байгууллагын нээлттэй байх цагийг авч хэлэлцдэг байна.

Ажил, мэргэжилд тавигдах шинэ шаардлагын улмаас сүүлийн үед ажлын цагийн зохион байгуулалтад өөрчлөлт орж “ажлын цагийн уян хатан байдал” гэсэн нэр томьёо гарч ирсэн. Хэдийгээр ажилчдын дийлэнх нь бүтэн өдрийн-тогтмол хөдөлмөрийн цагийн хуваарьтай ажиллаж байгаа хэдий ч ажлын цагийн уян хатан байдлыг (жишээ нь, ажиллах цагаа өөрөө сонгодог, хагас өдрийн, долоо хоногийн дөрвөн өдөр) улам бүр нэвтрүүлж байгаагаас гадна цагийн ажил, гэрээт ажил, хөдөлмөрийн түр гэрээ, бага орлоготой ажил гэх мэт өмнө байгаагүй ердийн бус ажил эрхлэлтийн хэлбэрүүд түгээмэл болж байгаа нь ажлын цаг, чөлөөт цагийн зохион байгуулалтад ч нөлөөлж байна. Зарим тохиолдолд амьжиргааны баталгаажих түвшин буурч хүндрэлд орсон хүмүүсийн хувьд төвөгтэй нөхцөл байдал үүсдэг. Ийм үед хэд хэдэн ажил зэрэг хийж амьжиргаагаа залгуулна. Мөн ажлын үе, хувийн үйл ажиллагааны цагууд нь холилдсон байдаг учраас гэрээсээ ажилладаг хүмүүсийн хувьд энэхүү ажлын цаг/чөлөөт цагийн бүтцэд гарсан өөрчлөлт нь тусгалаа олсон. Энд нэг талаар ажлыг гэрээсээ хийх боломжийг олгоод цалинжуулах тухай асуудал, нөгөө талаас ихэвчлэн бие даасан эрдэм шинжилгээ, судалгаа хийдэг хүмүүсийн ажлын нөхцөл байдлын тухай яригдаж байгаа юм.

Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа, ажлын цагийн

зохион байгуулалтад ийм өөрчлөлтүүд гарсан болохоор (*Work-life-Balance*) ажил амьдралын тэнцвэрт байдалд илүү анхаарал хандуулж байна. Ажлын цагийн уян хатан байдал нь ажилтанд ажлыг хувийн үүрэг хариуцлага, үйл ажиллагаатайгаа илүү сайн уялдуулах замаар давуу талыг авчрах боломж юм. Энэ хүрээнд нөөц хүчин чадлыг илүү сайн ашиглах, ажлын цаг болоод ажил эрхлэлтийн түвшнийг захиалгын нөхцөл байдалтай уялдуулах, улирлын болон эдийн засгийн хэлбэлзэлтэй тааруулах зэрэг үйл ажиллагааны ашиг сонирхлын үүднээс нэвтрүүлсэн байдаг. Орчин үеийн *хөдөлмөржсөн нийгэмд* ажлын байр алдагддаг ч ажил бол дуусахгүй, энэ бүхнийг хувиараа хөдөлмөр эрхлэлт, гэр бүлийн ажил, сайн дурын ажлын ач холбогдол иргэний нийгэмд нэмэгдэж байгаагаас харж болно.

Gertraude Mikl-Horke

Joffre Dumazedier: *Sociologie empirique du loisir*. Paris 1974.

– Engl.: *Sociology of Leisure*. Amsterdam [u. a.] 1974.

Bernhard Teriet: *Neue Strukturen der Arbeitszeitverteilung*. Göttingen 1976.

Claus Offe: *Arbeit als soziologische Schlüsselkategorie*. In: Joachim Matthes (Hrsg.): *Krise der Arbeitsgesellschaft*. Frankfurt a. M. / New York 1983. S. 38–65.

Gertraude Mikl-Horke: *Industrie- und Arbeitssoziologie*. München/Wien 1991, ⁵2000.

Karin Gottschall / G. Günter Voß (Hrsg.): *Entgrenzung von Arbeit und Leben*. München/Mering 2003, ²2005.

Амьдралын хэв маяг (Lebensstile)

Амьдралын хэв маяг гэдэг ойлголт нь орчин үеийн, → олон ургалч нийгмийн өдөр тутмын амьдралын болон нийгмийн шинжлэх ухааны ажиглалтын категори, тодорхойлолтын загварт багтдаг ухагдахуун юм. Амьдралын хэв маяг гэх социологийн ойлголт нь хоёрдмол утгатай. Нэг талаас, амьдралын хэв маяг нь → хувь хүн, → бүлгүүдийг амьдралын нийтлэг байдал болоод утга учрын үнэлэмж (→ хэм хэмжээ, утга), үйл ажиллагааны зааварчилгаа (→ үйлдэл), амьдралыг тодорхойлох хэлбэрүүдээр хангадаг. Үүгээр дамжуулаад тодорхой үүргээ ухамсарласан → оролцогч, бүлэг эсвэл хамтын нийгэмлэгүүд амьдралын тодорхой хэлбэр, хэв маягт харьяалалтай болохоо харуулдаг. Нөгөөтгээгүүр, амьдралын хэв маяг нь бусад хувь хүн, нийтийн үйл ажиллагааны практик, гоо зүйн үнэлэмжээс ялгарах, хил хязгаар тогтоох хэрэгсэл болдог. Тэд өөрийгөө таниулах, бусдын үнэлэмжийн гарааны болон барианы цэг болохын хувьд нийгмийн дэг журмыг бүрдүүлэх, өөрчлөх, хадгалах онцгой мөчийг төдийгүй, бас энэхүү үйл явцад дүн шинжилгээ хийх нийгмийн шинжлэх ухааны категорийг бүрдүүлдэг.

Хувь хүний өөрийгөө илэрхийлэх илэрхийлэлд “гоо зүйн үнэлэмж” улам илүү чухал ач холбогдолтой элемент болохыг мэдрэхийн зэрэгцээ (*Philosophie der Mode*, 1905), “амьдралын хэв маяг”-ийн олон янзын хэлбэрийг орчин үеийн нийгмийн үйл ажиллагааны өөрчлөгдөж буй шаардлагад үзүүлэх зайлшгүй хариу

үйлдэл гэж ухаарсан (*Philosophie des Geldes*, 1900) Georg Simmel-ээс гадна, юуны түрүүнд Max Weber амьдралын хэв маягийн тухай ойлголтыг социологийн үүднээс тодорхойлжээ. Weber-ийн хувьд Karl Marx-аас ялгаатай нь нийгмийн ялгааг дан ганц эдийн засгийн тэнцвэргүй байдлаас үүдэлтэй гэж үзээгүй. Нийгмийн ялгаат бүтцийг үүнээс илүүтэй хэрэглээ, харилцааны зан үйл (→ харилцаа холбоо), хамтрагчийн сонголт, чөлөөт цагийн зохицуулалт, хүмүүжлийн хэлбэрээр илрэх “амьдралын хэв маяг” үндсэндээ тодорхойлдог гэж үзсэн (*Wirtschaft und Gesellschaft. Grundriß der verstehenden Soziologie*, 1922).

Marx болон Weber-ээс гадна бас Thorstein Veblen (*Theory of the Leisure Class*, 1899, dt. 1958), Edmond Goblot (*La barrière et le niveau*, 1925, dt. 1994) нарын үзэл баримтлалыг Pierre Bourdieu үргэлжлүүлж 1970-аад онд Францын нийгэм дэх “нарийн ялгаатай” байдлын талаар судалснаар орчин үеийн амьдралын хэв маягийн социологидонолын болоод эмпирик үндсийг тавигдахад нөлөө бүхий хувь нэмэр оруулсан юм (*La distinction. Critique social du jugement*, 1979, dt. 1982). Соёл судлаач Erwin Panofsky-гийн хабитусын тухай ойлголтоос үүдээд Bourdieu гоо зүйн мэдрэмжийн аливааг илүүд үзэх үзэл амьдралын хэв маягийн жинхэнэ үүсгэгч гэж томъёолсон. Биеэ авч явах байдал, ярианы хэв маяг, мөн тодорхой чиглэлийн хөгжим, уран зохиол, кино болон бусад соёлын бүтээлүүд, дадал зуршилд дурлах, эсвэл дургүй байх нь → нийгэмшлийн эхэн үеэс хойш биед шингэн дамжиж ирсэн. Хууль ёсны хүсэл сонирхлын

(ялгарах) төлөөх далд тулалдсан ангийн тэмцэлд (→ анги) эдгээр төлөвшил нийгмийн орон зай, (→ тэгш бус байдлын) дэг журмыг шинэчилсэн.

Сүүлд Gerhard Schulze амьдралын хэв маягийн талаарх хэлэлцүүлгийн хүрээнд Bourdieu-гийн загварын зохицолдлогоонд шүүмжлэлтэй хандаж, цогц арга хэмжээ авах шаардлагыг Германы нийгэмд хандан тавьжээ (*Die Erlebnisgesellschaft*, 1992). 1980-аад оны үеэр ялангуяа Ulrich Beck (*Risikogesellschaft. Auf dem Weg in eine andere Moderne*, 1986; → *Risiko*)-ийн төлөөлж байсан цаг үе ба нийгмийг үнэлэх судалгааг давхар харгалзсаны үндсэн дээр Schulze ангийн тэмцлийн төгсгөл, нийгмийн давхраажилтын ижил түвшинд ирсэн гэж үзжээ. Энд мөн амьдралын хэв маяг нь сонирхлын бүлгүүдийг бүрдүүлдэг боловч тэдний гишүүд өөрсдийн гоо зүйн сэтгэл ханамжийг мэдрэхээс илүүтэй бусдаас онцгойрох, бусдаас ялгарах гэх нь бага: Орчин үеийн тусгалт байдал нь хувь хүмүүсийн байнгын эргэцүүлээр дамжин ойхдоо тэдний нийгмийн → давхарга дахь өдөр тутмын амьдралын гоо зүйн баримжаа дээр эргэж тусгалаа олдог. Харилцан үйлчлэлийн онолд (→ харилцан үйлчлэл) илүүтэй чиглэсэн арга хандлагууд нь Simmel-ийн антропологи хандлагыг барьж авч, түүнд шингэсэн хоёрдмол шинжийг улам боловсронгуй болгосон. Ийнхүү Hans-Georg Soeffner хэв маягийн албадлагын тухай “Албадмал гоо зүй. Улс төрийн төлөөлөл, ёслол, зан үйл” (in: *Inszenierungsgesellschaft. Ein einführendes Handbuch*, hrsg. von Herbert Willems und Martin Jurga, 1998) хөндөхдөө

амьдралын хэв маягийг энэхүү гоо зүйн сонголтын асуудлыг шийдвэрлэх арга зам бөгөөд нийгмийн ажиллагаат болон хэрэгцээт байдлын өдөр тутмын дарамтаас салах боломж гэж харсан.

Jürgen Raab

Franz Schultheis [u. a.]: Repräsentationen des sozialen Raums im interkulturellen Vergleich. Zur Kritik der gesellschaftlichen Urteilskraft. In: Berliner Journal für Soziologie ¹(1996). S. 43–68.

Werner Georg: Soziale Lage und Lebensstil. Eine Typologie. Opladen 1998.

Monika Kritzmöller: Positionierung im Lebensstil-Labyrinth. Frankfurt a. M. [u. a.] 2002.

Gunnar Otte: Sozialstrukturanalyse mit Lebensstilen. Eine Studie zur theoretischen und methodischen Neuorientierung der Lebensstilforschung. Wiesbaden 2004.

Rudolf Richter: Die Lebensstilgesellschaft. Wiesbaden 2005.

Анги/Давхарга (Klasse/Schicht)

“Анги” (англиар *class*; францаар *classe*), “давхарга” (англиар болон францаар *stratification*) гэсэн нэр томъёонуудыг нийгмийн → тэгш бус байдлын бүтцийг бүхэлд нь ангилж, дүн шинжилгээ хийхэд ашиглагддаг. Эдгээр нь нийгмийг “босоо” буюу шаталсан хэлбэрээр, давуу болон сул талаараа ангилагдсан олон янзын

→ бүлгүүдэд хуваадаг бөгөөд тэдгээр нь ихэвчлэн эдийн засаг, нийгэм, соёлын нөөц, үүнээс хамаарах амьдралын боломжоороо ялгаатай байдаг.

“Анги” нь арай эртний нэр томьёо юм. Үүнийг Karl Marx, Friedrich Engels (*Die deutsche Ideologie*, 1845/46; *Manifest der kommunistischen Partei*, 1848) нар нийгмийн хөгжлийн гол хандлагыг тодорхойлох, тайлбарлах, урьдчилан таамаглахын тулд социологийн үндсэн ангилалд бүрэлдүүлжээ. Ангийн хуваагдлын нэг хэмжээст шалгуур бол эдийн засгийн шалгуур юм. Жишээ нь, үйлдвэрлэлийн хэрэгслийг (→ капитал, хөдөлмөр) эзэмших буюу эзэмшихгүй байх. Үүний дараа капиталист аж үйлдвэрийн нийгэм (→ аж үйлдвэрийн нийгэм) улам бүр эвлэршгүйгээр зэрэгцэн орших хоёр том үндсэн ангиуд болох үйлдвэрлэлийн хэрэгслийг эзэмшдэг, хөрөнгөтний захирагч анги ба капитал эзэмшдэггүй захирагдагч пролетари ангид хуваагдах бөгөөд захирагдагч анги нь улам бүр томордог. Учир нь “дундаж давхаргын завсрын анги” олигополиудын¹ тэмцэлд дарагдан, пролетарийн эгнээнд шилжихтэй зэрэгцээд ангийн тэмцлийн нөлөөгөөр эцэстээ хувьсгалт үйлдлээр ангигүй нийгмийг бий болгох хүртлээ улам бүр үгээгүй ядуурдаг. Marx эдийн засгийн ангийн харьяалал (“анги өөрөө”) хүмүүсийн ашиг сонирхол, ухамсрыг төдийгүй (“ангийн төлөө”) ноёрхлын харилцаа, хамтын улс төрийн үйл ажиллагааг (“анги өөрөө болон ангийн төлөө”) ч тодорхойлдог гэж үзэж байв.

Marx-ын энэ үзэл санаатай зөрчилдсөнөөр Мах

1 Цөөн тооны том компанийн зах зээл давамгайлсан монополын нэг хэлбэр.

Weber (*Wirtschaft und Gesellschaft. Grundriß der verstehenden Soziologie*, 1922) ангийн үзэл баримтлалыг капиталын өмчлөл, ангийн тэмцэлд төвлөрүүлж байсныг өөрийнхөөрөө өөрчлөн, эдийн засгийн (анги), нийгмийн (давхарга) болон улс төрийн (нам) хэмжигдэхүүнд хуваасан. Эдгээр нь зарим талаараа хоорондоо холбоотой боловч давхцахаар ижил биш, бас зөвхөн эдийн засгийн хувьд тодорхойлогддоггүй. Ангийн нэр томъёог Weber эдийн засгийн нөхцөл байдалд зориулан нөөцөлжээ (ангийн нөхцөл байдал): Энэ салбарт өмчлөгч ангитай зэрэгцээд амьдралын боломж нь зах зээл дээр бараа, үйлчилгээнээс ашиг олох эсэхээс ихээхэн хамаардаг хэд хэдэн ажилчин анги бас байна (→ эдийн засаг). Амьдралын өвөрмөц хэв маягтай, түүнтэйгээ уялдаад “нэр хүнд”, нийгмийн үнэлэмжтэй бүлгүүдийг Weber “язгууртан” гэж нэрлэдэг.

Theodor Geiger мөн Marx-ыг шүүмжилж, тодорхой бус бүрхэг утгатай байсан давхаргыг нийгмийн үндсэн нэр томъёо болгон тодорхойлжээ (*Die soziale Schichtung des deutschen Volkes*, 1932). Түүний олон хэмжээст давхаргын талаарх үзэл баримтлал нийгмийг бүхэлд нь шаталсан байдлаар янз бүрийн давуу болон сул талуудтай бүлгүүдэд хуваадаг. Нэг давхаргад эдийн засаг-нийгмийн байр сууриараа ижил төстэй хүмүүсийг багтаадаг. Өөрөөр хэлбэл, жишээ нь, орчин үеийн нийгэмд бол мэргэжил, орлого, мэргэшил, нийгмийн хүндлэл зэргээрээ ойролцоо хүмүүс байна. Орчин нөхцөл дэх адил төстэй амьдралын туршлагаас болж тэд адил төстэй сэтгэлгээ, үнэт зүйлс, хандлага,

→ амьдралын хэв маягийг бий болгосон байдаг. Geiger сэтгэхүй болон амьдралын хэв маягийг Marx шиг нийгэм-эдийн засгийн “объектив” амьдралын нөхцөлөөр тодорхойлоогүй, гэхдээ “объектив” ба “субъектив” түвшний хооронд “ердийн” түвшин байдаг. Өөрөөр хэлбэл, их бага хэмжээгээр холбоо хамаарлын магадлал дунд нь оршдог гэж үзжээ. Нийгмийн байр суурь, давхаргын сэтгэлгээний харилцан үйлчлэл давхаргын онцлог бүхий амьдралын боломж ба эрсдэлд хүргэдэг.

Нийгмийн тэгш бус байдлын нарийн төвөгтэй, хувьсан буй бүтэц нь өнөөдөр “анги”, “давхарга” гэсэн ойлголтуудын янз бүрийн олон хэрэглээ бий болоход, заримдаа хоёулаа ижил утгатай ашиглагдахад хүргэсэн. Марксын жинхэнэ ангийн үзэл баримтлал 1960-1970-аад онд богино хугацааны сэргэн мандалтыг үзсэн хэдий ч социалист систем задран унасны дараа бараг ашиглагдаагүй. “Ангийн” үзэл баримтлалын марксист бус хувилбарууд нь эдийн засгийн чиг баримжаатай бөгөөд ихэвчлэн ангийн хөгжил, нийгмийн → зөрчил, эрх мэдлийн харилцаа (→ ноёрхол) болон тэдгээрийн шалтгааныг судалдаг. Pierre Bourdieu-ийн бүтээлд орчин үеийн ангийн онол ба амьдралын хэв маягийн дүн шинжилгээг хослуулсан нь олон улсын хэмжээнд нөлөөтэй байдаг (*La distinction. Critique sociale du jugement*, 1979, dt. 1982).

Германы нийгэмд танигдсан давхаргын загварууд гэвэл Karl-Martin Bolte-гийн “сонгинын загвар” (*Deutsche Gesellschaft im Wandel*, 2 Bde., 1966/70) болон Geiger-ийн нийгмийн давхаргын сэтгэлгээний загвараас

сэдэвлэж Ralf Dahrendorf-ын бүтээсэн “байшингийн загвар” (*Gesellschaft und Demokratie in Deutschland*, 1965) байна. Dahrendorf хүн амыг нийгмийн байр суурь, түүнтэй холбоотой сэтгэлгээний онцлогийн дагуу долоон давхаргад хуваажээ. Элитүүд (1%-иас доош), үйлчилгээний анги (12%), дунд давхарга (20%), ажилчин элит (5%), ажилчин анги (45%), хуурамч дунд давхарга (12%), доод давхарга (5%), Rainer Geißler (*Die Sozialstruktur Deutschlands*, 2006) Dahrendorf-ын байшинг сүүлийн хэдэн арван жилийн давхаргын өөрчлөлтөд тохируулан сэргээн засварлаж, орчин үеийн болгосон.

Баруун Европхйгээд хойд Америкт “анги”, “давхарга” гэдэг ойлголтууд социологийн үндсэн нэр томъёогоор чөлөөтэй ашиглагддаг. Харин Германы нийгмийн бүтцийн судалгаанд үүний эсрэгээр “босоо парадигм”-ын талаарх таагүй хандлага сүүлийн хорин жилийн турш тархаж, орчин үеийн өөрчлөлт шинэчлэлийн явцад “анги”, “давхарга” нь задраад байна уу эсвэл аль хэдийн задарчихсан уу гэсэн ширүүн маргаан өрнөж байна. Ulrich Beck (*Risikogesellschaft. Auf dem Weg in eine andere Moderne*, 1986), Stefan Hradil (*Sozialstruktur-analyse in einer fortgeschrittenen Gesellschaft*, 1987) зэрэг энэхүү задралын ойлголтын төлөөлөгчид нь 1990-ээд онд Германы нийгмийн бүтцийн шинжилгээний гол чиглэлд давамгайлж байв. Чинээлэг амьдралын хэв маяг нэмэгдэж, боловсролын тэлэлт явагдан (→ боловсрол), амьдралын нөхцөл аажмаар төрөлжиж, → амьдралын хэв маягийн индивидуалчлал, олон ургалч

үзлийн хандлага бий болсноор анги болон давхаргын шинжтэй дэд соёлууд, → ижилслүүд үндсэндээ алга болсон гэж тэд үзэж байв. Michael Vester (M. V. [u. a.], *Soziale Milieus im gesellschaftlichen Strukturwandel*, 1993) Rainer Geißler («Kein Abschied von Klasse und Schicht», in: *Kölner Zeitschrift für Soziologie und Sozialpsychologie* 48, 1996, Nr. 2) зэрэг задралын ойлголтыг шүүмжлэгчдийн онцлон тэмдэглэж байгаагаар, сайн боловсрол, мэргэжлийн ажлын байр, улс төрийн оролцоо эсвэл чухал мэдээллийг интернэтэд ашиглах (“дигитал хуваагдал”) зэрэг амьдралын чухал боломжууд болон цаашлаад ядуурал, ажилгүйдэл, өвчлөл, гэмт хэрэг зэрэг нийгмийн давхраажилтад чухал үүрэг гүйцэтгэх эрсдэлүүд нь өнөөдөр ч бас ихээхэн давхраажилтын шинжтэй хуваарилагдсан хэвээр байна. Rainer Geißler, Sonja Weber-Menges («Natürlich gibt es heute noch Schichten! Bilder der modernen Sozialstruktur in den Köpfen der Menschen», in: *Soziale Milieus und Wandel der Sozialstruktur*, hrsg. von Helmut Bremer und Andrea Lange-Vester, 2006) нар Германы нийгэмд анги, давхаргаар шатлан хуваах тухай ойлголт нийгмийн бараг бүх → оролцогчдын оюун санаанд өнөөдөр ч байсаар байгаа бөгөөд тэдний үйл ажиллагаанд нөлөөлдөг гэдгийг эмпирик туршилтаар нотолжээ.

Rainer Geißler / Sonja Weber-Menges

Hans Paul Bahrdt: Schichten, Klassen, Stände. In: H. P. B.: Schlüsselbegriffe der Soziologie. München 1984. S. 129–160.

Rainer Geißler (Hrsg.): Soziale Schichtung und Lebenschancen in Deutschland. Stuttgart ²1994.

Peter A. Berger / Michael Vester (Hrsg.): Alte Ungleichheiten - neue Spaltungen. Opladen 1998.

Байгууллага (Organisation)

Байгууллага хэмээх ухагдахуун нь сонгодог бизнес, удирдлагын номлолд компани эсвэл захиргааны бүтцийг тодорхойлдог. Байгууллагыг зорилгодоо хүрэх (онцгой) арга хэрэгсэл (хэрэгслийн зохион байгуулалтын үзэл баримтлал) гэж ойлгодог. Нөгөө талаас, социологийн хувьд зохион байгуулалт нь сайн дурын, дахин хянан үзэж болох оролцооны хэлбэр болох гишүүнчлэлд суурилдаг → бүлэг, → гэр бүл эсвэл → харилцан үйлчлэлтэй харьцуулахад нийгмийн тусгай систем юм (байгууллагын зохион байгуулалтын үзэл баримтлал).

Байгууллагын хоёр үндсэн хэлбэрийг ялгаж салгаж болно: (1) Албан ёсны байгууллагууд (үүнд, ажлын байгууллагууд) нь гишүүнчлэлийн хүлээлтийг ерөнхийд нь хүлээн зөвшөөрөх, бие даасан гишүүдийг бусад гишүүдээр солих боломж дээр суурилдаг. Байгууллагад элссэний дараа тухайн байгууллагын хүлээлт, тэр дундаа дээд албан тушаалтны тодорхойгүй зааварчилгааг дагаж мөрдөхийг зөвшөөрсөн хүмүүс л гишүүн болж, гишүүн хэвээр үлдэж, эсвэл өөр хэлбэрээр огцрох боломжтой. Сайн дурын үндсэн дээр үндэслэсэн

гишүүнчлэлийн энэ хэлбэр нь нийгэм дэх хөдөлмөрийн зах зээлийг институцчилэхийг (→ мөнгөний орлогын төлөө ажиллах) шаарддаг. Албан ёсны байгууллагууд нь гишүүдийнхээ хувийн сэдлийг (нийгмийн → орчин) үл тоомсорлож, зорилго, бүтцийг өөрсдийн об'ектив орчин, гишүүн бус (үйлчлүүлэгч, үйлчлүүлэгч, иргэд болон бусад байгууллага) хүлээлттэй уялдуулж болно (байгууллагын зорилго, гишүүдийн сэдлийг салгах).

(2) Холбооны байгууллагууд (сонирхлын байгууллагуудыг оруулаад) нь гишүүдийн сайн дурын үндсэн дээр орж, гарахад суурилдаг боловч байгууллагын зорилго нь гишүүдийн оролцооны гол сэдвүүдийн нэг юм. Тиймээс нийгэмлэгийн байгууллагууд үйл ажиллагаандаа гишүүдийнхээ оролцоо, хувь нэмэр, тэдний зөвшөөрлийн ардчилсан үйл явцаас хамаардаг. Эдгээр байгууллага нь зорилго, бүтэц зохион байгуулалтаа өөрөө шийдэж болох боловч зорилго, сэдэл хоорондын ялгаа байхгүйн улмаас албан ёсны байгууллагуудаас бага өөрчлөгддөг. Холбооны байгууллагуудыг зорилго нь голчлон гадагш чиглэсэн (улс төрийн холбоо эсвэл ашгийн бус холбоодын хувьд) эсвэл зөвхөн гишүүдэд ашиг тустай эсэх, өөрөөр хэлбэл, дотоодод чиглэсэн (нийгмийн клубүүдийн хувьд) үү гэдгээр нь ялгаж болно. Зохион байгуулалтын социологийн онолтүүхийн эхлэлийн цэг нь Мах (*Wirtschaft und Gesellschaft. Grundriß der verstehenden Soziologie*, 1922) хууль ёсны засаглалын бюрократ хэлбэрт анализ хийх явдал байв. Дараа нь бюрократ бүтцийн доголдолд (эсвэл “далд функцүүд”) дүн шинжилгээ хийж, бюрократын нэгдсэн

концептийн бүтцийн ялгааг хэлэлцүүлсэн (Robert K. Merton, Alvin Gouldner, Phillip Selznick). Дэлхийн II дайны дараах судалгааны ажил Webers-ын бюрократын тухай ойлголт аажмаар байгууллага (бюрократ) болон → нийгэм (ноёрхол) хоорондын уялдаа холбооноос салсан. Онолын хүрээний хязгаарлагдмал зохион байгуулалтын хэлбэрүүд болон эмпирик хандлагуудаас гадна (жишээлбэл, нөхцөл байдлын арга, тохиргооны хандлага, хүн ам зүйн экологи) байгууллагуудыг тодорхой байр сууринаас тодорхойлсон олон тооны зохион байгуулалт-онолын хандлага бий болсон. Үүнд, танин мэдэхүйн болон мотивацийн хувьд хязгаарлагдмал шийдвэр гаргах үйл явц (James March, Nils Brunsson), хувь оролцогчдын микро түвшний улс төрийн төлөөх эрх мэдлийн тоглоом (Michel Crozier, Erhard Friedberg), хүрээлэн буй орчны хамааралтай нөөцийн хамаарал (Jeffrey Pfeffer), нийгмийн байгууллагуудын хязгаарлалт, боломжууд (John W. Meyer, Walther W. Powell, Paul J. DiMaggio) зэргийг нэрлэж болно. Байгууллагын судалгааны чухал сонгодог сэдэв, үзэл баримтлалыг (шийдвэр, зорилго, шатлал, албан бус байдал, эрх мэдэл, байгууллагын соёл гэх мэт) социологийн цогц хүрээнд авч үзэхийг оролдсон байгууллагын ерөнхий онолын оролдлого нь өмнөх үеийн социологийн системийн онолд (Niklas Luhmann) оршдог (→ систем). Байгууллагын социологийн судалгаа нь дотоод бүтэц, үйл явцын тодорхойлолтод анхаарлаа төвлөрүүлсний дараа 1980-аад оноос хойш зарим арга барилын (системийн онол, нео-онализм,

бүтцийн онол) хүрээнд байгууллага болон нийгмийн хоорондын уялдаа холбоог судлах асуудал руу буцаж ирсэн.

Veronika Tacke

Niklas Luhmann: Funktionen und Folgen formaler Organisation. Berlin 1964, 5 1999. – Organisation und Entscheidung. Opladen 2000, ²2006.

Renate Mayntz: Bürokratische Organisation. Stuttgart 1968, ²1971.

Giuseppe Bonazzi: Storia del pensiero organizzativo. Mailand 1982, ¹³2002. – Dt.: Geschichte des organisatorischen Denkens. Hrsg. von Veronika Tacke. Übers. von Alessandra Corti. Wiesbaden 2007.

Бие (Körper)

“Бие” (англиар *body*; францаар *corps*; латинаар *corpus*) гэдэг нь ерөнхийдөө хүний бие махбодын өгөгдөл, үзэгдэх төрхийг илэрхийлдэг. Философи-антропологийн үүднээс авч үзвэл хүн угтаа бол хоёр биетэй холбоотой байна гэж үздэг: Helmuth Plessner (*Die Stufen des Organischen und der Mensch*, 1928)-ийн хэлснээр, хүн бол түүний “бие” бөгөөд нэгэн зэрэг түүнд ийм “бие махбод” байдаг. Бие байх, биетэй байх нь харилцан нөхцөлдсөн хүний оршихуйн хоёр талыг бүрдүүлдэг. Бие байна гэдэг нь хүн эд эрхтнээс бүрдэхийг, түүний

үр дүнд энд-одоотой холбогдохыг хэлнэ. Харин биетэй байна гэдэг нь өөрөө өөртэйгөө зайнаас харьцаж чадах хүний өвөрмөц чадварыг илэрхийлдэг: хүн өөрийн бие бялдрын бүтцээс шалтгаалан өөрийн “бие”-ийг бусад эд юмсын нэгэн адил хэрэглүүр болгон ашиглахаас гадна өөрөө өөрийгөө объект болгох, энэ тухайгаа эргэцүүлэн бодох, цаашлаад бие махбодоос хамааралтай энд-одоод хүлэгдсэн хүлээснээс ангижрах боломжтой. Феноменологийн уламжлалд (→ феноменологийн социологи) бие гэдэг үгийг Герман хэлэнд бие “Körper” гэдэг үгийг “Leib” гэдэг үгээр бас хэлж болдог. Объекттой төстэй биет зүйл (= биетэй байх) “Körper” (бие-махбод)-оос ялгаатай нь “Leib” (= бие байх) бол өөрийн биеийн субъектив туршлагыг илэрхийлдэг (бие-сэтгэл). Энэ утгаараа “бие-махбод” нь бусдын хүлээн авч байгаа буюу бусдад ойлгодог бие байдаг бол бие-сэтгэл нь өөрийгөө мэдэрч хүлээн авч байгаа бие юм.

Социологийн үүднээс бол биеийн нийгэм, соёлын хэлбэржилт, ач холбогдлыг авч үздэг. Байгаль ба → соёлын хоорондох (эгзэгтэй) харилцааны тодорхой хэлбэрийг үндсэн асуудал болгодог. Учир нь хүний бие бол нэг талаар байгалийн нэг хэсэг, нөгөө талаар, хүний биеийн байгалийн энэ талыг хэрхэн мэдэрч, үнэлж, амьдарч байгаа нь биологийн хувьд тогтоогдоогүй юм. Биеийн дадал, хандлага, мэдлэг, дүр зураг нь тус бүрдээ түүхэн эрин үе, соёл, → нийгмийн онцлогоос хамаараад өөр өөр байдаг. Жишээ нь, Marcel Mauss-ын харуулснаар, алхах, суух, унтах, идэх эсвэл нулимах

гэх мэт биеийн байгалиасаа гэж боддог үйлдлүүд нь соёлын өвөрмөц “биеийн техник” (»Les techniques du corps«, in: *Journal de psychologie normale et pathologique* 32, 1935, dt. in: M. M., *Soziologie und Anthropologie*, Bd. 2, 1975) бөгөөд нийгэм-соёлын нийгэмших үйл явцын үр дүн юм (→ нийгэмшил).

Социологийн хувьд бие нь нийгмийн бүтэц, соёлын үнэт зүйлсийн үр дүнд бий болсон гэдэг утгаараа нийгмийн үзэгдлийг төлөөлдөг. Үүний зэрэгцээ бие нь нийгмийн дэг журмыг тогтоож, харуулдаг гэдэг утгаараа нийгмийн үзэгдэл мөн. Үүнийг дагаад социологид маш олон төрлийн биеийн онолууд байдаг. Ингээд нийгмийн бүтээн байгуулалтын үүднээс авч үзвэл бие нь (1) нийгмийн → бүтэц, → институци, → технологийн уян хатан объект, (2) нийгмийн → хэлэлцүүлэг, → харилцаа холбооны хэрэглэгдэхүүн, (3) нийгмийн харьяаллын бэлгэдлийн илэрхийлэл (→ бэлгэ тэмдэг), (4) нийгмээр дамжих бие сэтгэлийн туршлагын төв юм. Үүнтэй холбоотой чухал судалгааны салбарууд бол (1) түүхэн социологи ба антропологи, → нийгмийн орчин ба амьдралын хэв маягийн шинжилгээ (→ амьдралын хэв маяг), мөн био болон дахин боловсруулалтын технологи, (2) жендерийн судалгаа, Michel Foucault-ын дагуу эрх мэдлийн шинжилгээ (→ эрх мэдэл) эсвэл спорт ба бэлгийн харилцааны талаар системийн онолын судалгаанууд, (3) залуучуудын соёл ба хэв маягийн шинжилгээ, цаашлаад (4) өвдөлт, ижилсэл, хөгжлийн бэрхшээлийн талаарх судалгаа юм. Биеийн нийгмийг бүрэлдүүлэгч

функцийнх нь хувьд түүнийг (1) өдөр тутмын хэвшсэн үйлдэл, сурсан дадал зуршлын дуу хоолой болгох (2) бие махбодын өөрийгөө харуулах, илэрхийлэх хэрэгсэл, (3) өөрийнхөөрөө, урьдчилан эргэцүүлэх бодсон үйлдлийн субъект болгодог. Энд судалгааны гол салбаруудад (1) → Pierre Bourdieu-тай уялдах хабитус болон праксеологийн² судалгаа, (2) Erving Goffman-ын дагуу харилцан үйлчлэлийн судалгаа, (3) үзэгдэл судлалын чиг баримжаатай үйлдэл, субьектийн шинжилгээ багтдаг. Эдгээр аналитик ялгаа, судалгааны олон чиглэлээс харахад ганц хүний “бие” социологид ч байхгүй гэдэг нь тодорхой харагдаж байна. “Бие”-ийг үргэлж олон тоогоор авч үзэх хэрэгтэй.

Robert Gugutzer

Bryan S. Turner: *The Body & Society. Explorations in Social Theory*. London [u. a.] 1984, 2 1996, Nachdr. 2004.

Chris Shilling: *The Body and Social Theory*. London [u. a.] 1993, ²2003.

Simon J. Williams / Gillian Bendelow: *The Lived Body. Sociological Themes*. London [u. a.] 1998.

Robert Gugutzer: *Soziologie des Körpers*. Bielefeld 2004.

Ulle Jäger: *Der Körper, der Leib und die Soziologie. Entwurf einer Theorie der Inkorporierung*. Königstein (Ts.) 2004.

² Нийгмийг бие махбодын үйл ажиллагаанаас бүрддэг гэж үздэг социологи, философийн нийгэм, соёлын онол: [https://de.wikipedia.org/wiki/Praxeologie_\(Sozialtheorie\)](https://de.wikipedia.org/wiki/Praxeologie_(Sozialtheorie))

Бодит байдал (Wirklichkeit)

Социологийн шинжлэх ухаанд Peter L. Berger und Thomas Luckmann нарын (*The Social Construction of Reality*, 1966, dt. 1969) бүтээлийн дараахан “Бодит байдал” (англиар *reality, actuality*; францаар *réalité*) гэдгийг бидний хүслээс үл хамраана орших үзэгдлүүдийн чанарын тухай ойлголт хэмээн нэрлэжээ. Өдөр тутмын ярианд “бодит байдал” гэх ухагдахуун нь “байгаа байдал”-тай агуулга ижил байдаг. Үүгээрээ “бодит байдал” нь “боломж” гэдгийн эсрэг байр суурийг илэрхийлэх бөгөөд хүний гараар бүтээгдсэн, бий болоход нь оролцсон ертөнцийн эд зүйлс, үйл явдлууд болон (хийсвэр) чанарыг тодорхойлдог. Шинжлэх ухааны практикт “бодит байдал” гэх ухагдахуун нь маргаантай байдаг. Bas C. van Fraassens-ны (*The Scientific Image*, 1980) “конструктив эмпиризм”-ийн онолоор үзэгдлийн ертөнц дэх объектуудыг цэгцтэй болгох хэрэгслийг бий болгодог байна. Онолууд нь бодит бодит байдалтай өөрөө харьцдаггүй, харин загварчлалтай харьцах бөгөөд тэдгээрийн эмпирик хэмжигдэхүүн нь үзэгдлүүдтэй бүтцийн хувьд адил байдаг. Аливаа онолын хүлээн зөвшөөрөгдөх байдал нь бодит байдалтай нийцэх эсэхээс бус, түүний эмпирик байдалтай ижил төстэй (зохистой) байдлаас хамаардаг. Философийн (Англо-Саксоны) урсгалд реализмын тухай ойлголтыг бидний ухамсарт төлөв байдлаас үл хамааран оршдог хэмээн тодорхойлдог. Хэл судлалын философийн хүрээнд энэхүү дүрслэлийг Michael Dum-

mett (*Truth and Other Enigmas*, 1978) илүү тодорхой болгож өгсөн. Бодит байдлын талаарх аливаа нэг мэдэгдлийн зөв эсвэл буруу гэдгийг тухайн хэрэглэгч хэлээрээ (“*объектив чанартай*”) хэлж чадах эсэхээс хамаарна. Dummett реализмын эсрэг хандлагыг өөрөө хөгжүүлж, бодит байдал нь тухайн цаг мөчид ямар чадвартай илтгэгчид юуг зөвтгөж чадахаас бүрддэг гэжээ. Hilary Putnam-ны хувьд аливаа объектууд нь “үзэл баримтлалын схем”-ээс үл хамааран оршдоггүй бөгөөд үүнийг таньж мэдсэнээр ертөнцийг бид эхлээд объект болгон хуваадаг байна. Түүний онолоор “дотоод реализм” (*The Many Faces of Realism*, 1987) зөвшөөрч болохуйц хэд хэдэн төрлийн бодит байдлын тухай дүрслэл зэрэгцэн байдаг бөгөөд энэ нь хувь хүн тэдгээрийн уялдаа холбоотой, хүлээн зөвшөөрч чадахуйц байдлаар, харин бодит байдлыг бурхны мэлмийд (*God's Eye-Sicht*) хүрэх боломжгүй гэсэн үзлээр үнэлж болохгүй юм. Berger und Luckmann нарын үзлээр нийгмийн өөрчлөлт нь гадагшлуулах, объектжүүлэх, олон улсын хүрээнд тэлэх диалектик үйл явцын үр дүн юм. *Гадагшлуулах үйл явцаар дамжуулан → субъектууд өөрсдийн → институцийг үүсгэж, ингэснээр харилцан үйлчлэлийн хэв маягийг (→ интеграци) зохицуулдаг дүрэм (→ норм) тогтоодог. Хүмүүс нийгмийн институцийг хүний бүтээсэн зүйл гэж үзэхээ аль хэдийн больсон, харин хараат бус байдлыг мэдрэх үед объектжүүлэх үйл явц бий болдог байна. Субъектүүд нийгэмшиж (→ нийгэмшүүлэх), өөрсдийн тус бүрийн нийгмийн дүрмийн дагуу амьдрах үед институцийн*

гэрээ хэлэлцэл бий болсноор олон улсын хүрээнд тэлэх явц эхэлдэг байна. Ийнхүү хүмүүс өөрсдийн бүтээсэн → нийгмийн бүтээгдэхүүн болдог: “Нийгэм нь хүний бүтээгдэхүүн. Нийгэм бол объектив бодит байдал. Хүн нь нийгмийн бүтээгдэхүүн” юм (*The Social Construction of Reality*, 1966, dt. 1969).

Субъектив бодит байдал нь (радикал) → конструктивизмын эхлэлийн цэгийг илэрхийлдэг. Ernst von Glasersfeld (*Wissen, Sprache und Wirklichkeit*, 1987) нь бодит байдлын тухай хүлээлтийг шүүмжилж, бид өөрсдийн → мэдлэгийн үнэн зөвийн утгыг бодит байдалтай харьцуулан тодорхойлж чадна гэжээ. Бодит байдлыг илүү их нэр томьёоны сүлжээ гэх бөгөөд энэ нь өнөөдрийг хүртэл хуримтлуулсан туршлагад давтагдсан амьдралын бэрхшээлийг амжилттай даван туулах чадвар эсвэл туршлагын цогц байдлыг нэр томьёонд нэгтгэхэд (хуваарилах) үйлчилдэг байна. Humberto R. Maturanas-ын (*Erkennen: Die Organisation und Verkörperung von Wirklichkeit*, 1982) системийн хандлага нь бодит байдал зөвхөн ажиглагчийн үйл ажиллагаагаар бий болсон нөхцөл байдлын хэсэг буюу тунгаах бодох хэмээн тодорхойлж, социологид Niklas Luhmanns-ны оператив конструктивизмын хүрээнд авч үзжээ.

Alexander Riegler

Paul Watzlawick (Hrsg.): Die erfundene Wirklichkeit. Wie wissen wir, was wir zu wissen glauben? München/ Zürich 1981.

Christiane Floyd [u. a.] (Hrsg.): Software Development and Reality Construction. Berlin [u. a.] 1992.

Hans Jörg Sandkühler (Hrsg.): Wirklichkeit und Wissen. Frankfurt a. M. 1992.

Markus Peschl / Alexander Riegler (Hrsg.): Does Representation Need Reality? Rethinking Epistemological Issues in the Light of Recent Developments and Concepts in Cognitive Science. New York 1999.

Marcus Willaschek (Hrsg.): Realismus. Paderborn [u. a.] 2000.

Боловсрол (Bildung)

Боловсрол бол сурагч болон багшийн → үүргийн хуваарилалттай сурах үйл явц юм. Сурах гэдэг нь зан төлөвийг урамшуулах, шийтгэх арга замаар → орчноос туршлага хуримтлуулахыг хэлнэ (→ зан чанар). Боловсролд аливаа зан чанарыг дагалддаг сурах үйл явц нь тодорхой зорилгод чиглэгдэхээс гадна, багш сурагчийн хоорондын харилцаагаар дамждаг. Ийм учраас боловсрол нь эцэг эх эсвэл “бусад чухал хүмүүс” (*George Herbert Mead*) хүүхдүүддээ зан харилцаагаараа дамжуулан давхар үнэт зүйлийг таниулж байдаг → “нийгэмшил”-ээс ялгаатай юм (→ гэр бүл).

Антикийн болон дундад зууны үед нийгмийн элитүүд хүүхдүүддээ академиас эсвэл сүм хийдээс багш хайдаг байсан. XVI зуунаас сурах орчин болон цагийг (сургууль) өдөр тутмын амьдралаас салгах болсон

бөгөөд тодорхой сургалтын хөтөлбөрүүдийг (хичээл, даалгавар) боловсруулсан. Үүний үр дүнд энэ сургалтын материалын хүрээнд (анги) бүлгүүдийг мэдлэг түгээх мэргэжилтнүүд (багш) өөрсдийнх нь мэдлэгийн түвшнээс хамаарч бие биеэсээ ялгаатай суралцуулах боломжтой болсон. Сургууль нь мэдлэг дамжуулах институциэс шинжлэх ухааны мэдлэг үйлдвэрлэлийн болж хөгжсөн юм (Philippe Aries, *L'enfant et la vie familiale sous l'ancien régime*, 1960, dt. 1977). XIX зууны эхэн үеэс Баруун Европт 14 нас хүртэлх хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд заавал хамруулж эхэлсэн (Peter Flora, »Die Bildungsentwicklung im Prozess der Staaten- und Nationenbildung«, in: *Soziologie und Sozialgeschichte*, hrsg. von Peter C. Ludz, 1973) бөгөөд ингэснээр багшийн мэргэжлийн сургалттай, мөн өөр янз бүрийн чиглэлээр мэргэшүүлж төгсгөх сургуулийн төрлүүд бий болж, гүйцэтгэлийг шалгалтаар үнэлж, дүнгээр илэрхийлдэг болжээ. → Төр үндэсний боловсролын тогтолцоог бий болгож, хянаж байв.

Боловсролын тогтолцоо бол нийгмийн нэг дэд систем бөгөөд энд сурах үйл явц нь нийгмийн бусад хэсгээс өөрийн чиг үүргээрээ ялгарахын зэрэгцээ дотоод шаардлагаасаа хамаараад өөр хоорондоо ч ялгаатай (→ ялгарал) байдаг. Энд амжилтыг шалгалтаар үнэлж, дүнгээр илэрхийлдэг өөрийн гэсэн дэг журам үйлчилж байдаг. Багш нар сурагчдыг амжилтаар нь жагсаадаг болохоор амжилт болон тэгш эрх гэсэн хоёр ойлголт багш, сурагчдын зан төлөвөө чиглүүлдэг боловсролын тогтолцооны гол үнэт зүйл болдог. Ижил

амжилтаар боловсролын дараагийн шатандаа хүн бүр ижил боломжийг хүртдэг байх хэрэгтэй. Сурагчийн боловсролын зам мөрийг түүний амжилтыг нь харгалзахгүйгээр, эсвэл сурагчийн зүгээс хариуцаагүй “гадаад” хүчин зүйлийг үндэслэн тодорхойлж болохгүй (Émile Durkheim, *Leçons de sociologie, physique des mœurs et du droit*, 1950, dt. 1991). Зөвхөн ингэсэн тохиолдолд хүн бүр амжилтын төлөө хичээнэ гэж хүлээх хэрэгтэй. Ажилтын ялгаа, тэгш хандлагыг холбох зам бол тэгш боломжит байдлын шаардлагаар бий болдог. Энэ бол боловсролын тогтолцоо үйл ажиллагааныхаа хүрээнд өөртөө тогтоодог хэмжүүр юм (Heiner Meulemann, *Soziologie von Anfang an*, 2001).

Боловсролын тогтолцоо бол боловсролын социологийн судлагдахуун юм. Боловсролын тогтолцоо дахь оролцогчидтой холбогдуулан боловсролын социологийн судалгааны гурван асуултыг ялгаж үзэж болно. Макро социологийн асуулт (1) нь боловсролын тогтолцоог хамтын оролцоогоор зохион байгуулахтай холбоотой. Улс төрийн эрх баригчид сургуулийн тогтолцоонд суралцах асуудлыг хэрхэн шийддэг, төрийн байгууллагууд сургалтыг хэрхэн зохион байгуулдаг вэ? (Elmar Lange, *Soziologie des Erziehungswesens*, 2005). Микро социологийн асуулт (2) нь боловсролын тогтолцоонд үндсэн үүрэгтэй хоёр оролцогчдыг хамруулна. Багш нар, захирал болон ажлын хамт олон, түүнчлэн сурагчид болон эцэг эхчүүдтэй хэрхэн харилцаж байна вэ? Сурагчид сурлагын амжилтаараа сайн байна уу эсвэл өөр “гадаад”

үзүүлэлтээрээ юу? Микро социологийн өөр нэг асуулт (3) бол боловсролын тогтолцоо дахь бодит тэгш боломжийн түвшин болоод үүнтэй холбоотойгоор нийгмийн тэгш бус байдлын шалтгааныг авч үздэг тул энэ нь хамгийн их судлагдсан байдаг. Туршилтаар хуучны (баруун)³ ХБНГУ-д: Дараагийн шатны сургуулийн сонголт тухайн сурагчийн нийгмийн гарал үүслээс хамаарч тодорхойлогддог байсан хэдий ч 1950-1989 оны хооронд энэ хоёр үзүүлэлтийн хамаарал буурсан байна (Bernhard Schimpl-Neimanns, »Soziale Herkunft und Bildungsbeteiligung«, in: *Kölner Zeitschrift für Soziologie und Sozialpsychologie* 52, 2000); Сургуулийн сонголттой холбогдуулан дүнг нь шалгавал нийгмийн гарал үүслээс шалтгаалсан нөлөө мөн л хэвээр байна (Heiner Meulemann, *Bildung und Lebensplanung*, 1985).

Нийгмийн гарал, сургуулийн шат дамжлага хоёрын хоорондын хамаарлыг үнэлэмж-хүлээлтийн онолоор (→ Rational-Choice-Theorie буюу рационал сонголтын онол) тайлбарлаж болно. Нийгмийн доод давхаргаас гаралтай эцэг эхчүүд нөөц боломжийн хязгаарлагдмал байдлаасаа шалтгаалаад дараагийн дэвших шатны сургуулийн ашиг тусыг төдийлөн үнэлдэггүй, мөн амжилтад хүрэх магадлал өөр бусад сургуулиас бага, эцсийн дүндээ өндөр зардалтай гэж үздэг учраас хүлээлт багатай байдаг. Энэ нь амжилтаараа ижил үнэлэгдсэн хүүхдүүдтэй, нийгмийн дээд давхаргаас гаралтай эцэг эхчүүдийн хувьд харин эсрэгээрээ

3 Хуучны гэдэг үгийг тодотгож баруун герман гэсэн ойлголтыг нэмж оруулсан болно.

байдаг. Энэ шийдвэрүүд нь өгөгдсөн нөхцөл боломж, хязгаарлалтын хүрээнд хийх болсон оновчтой сонголт ч байж болох бөгөөд үүнийг заавал “боловсролоос хол” байхтай холбож үзэх шаардлагагүй юм.

Heiner Meulemann

Kai S. Cortina [u. a.] (Hrsg.): Das Bildungswesen in der Bundesrepublik Deutschland. Neuausgabe. Reinbek 2003, 2005.

Peter A. Berger / Heike Kahlert (Hrsg.): Institutionalisierte Ungleichheiten. Wie das Bildungswesen Chancen blockiert. Weinheim/München 2005.

Werner Georg (Hrsg.): Soziale Ungleichheit im Bildungssystem. Eine empirisch-theoretische Bestandsaufnahme. Konstanz 2006.

Andreas Hadjar / Rolf Becker (Hrsg.): Die Bildungsexpansion. Wiesbaden 2006.

Бүлэг (Gruppe)

Нийгмийн бүлэг нь нэг зорилгын төлөө нэгдсэн, энэ зорилгодоо хүрэхийн төлөө байнгын → харилцаа, хамтын үйл ажиллагаанд харьцангуй тасралтгүй оролцдог тодорхой тооны гишүүдээс бүрдсэн, үүгээрээ нэгдмэл байдал, хамтын харьяаллын мэдрэмжийг хөгжүүлж байдаг бүлгийг хэлнэ. Бүлгийн зорилгыг биелүүлэх, бүлгийн ижилслийн хэв шинжийг бүрэлдүүлэх,

тогтворжуулах нөхцөл нь нийтлэг → нийгмийн хэм хэмжээний тогтолцоог бий болгож, бүлгийн гишүүдийг тодорхой үүргээр (→ чиг үүрэг) ялгаж даалгавар хуваарилах явдал юм.

Аж үйлдвэржилтийн өмнөх үеийн хамтын нийгэмлэгийн харилцааны тогтвортой байдал нэг талаас индивидуалчлал ба нийгмийн дэд системийн функциональ ялгаанаас болоод, нөгөө талаас аж үйлдвэржилт, хотжилт, төвлөрөл, бюрократ үйл явцаас үүдэн улам бүр алдагдсан юм (→ орчин үе). Тэдний оронд заримыг нь хувь хүмүүсийн өөрсдийн сонгосон нийгмийн холбоос бий болсон. Бүлгийн үзэл баримтлалыг хөгжүүлэх тухайд ялангуяа Америкийн социологид эцсийн байдлаар хэрэгжүүлэх хүртэл боловсруулсан жижиг бүлгийн (small group) тухай үзэл баримтлалын талаар Georg Simmel болон Leopold von Wiese нарыг бүтээлүүдийн дурдаж болно. Simmel («Die quantitative Bestimmtheit der Gruppe» und «Die Selbsterhaltung der sozialen Gruppe», beides in: G. S., *Soziologie. Untersuchungen über die Formen der Vergesellschaftung*, 1908) бүтээлдээ тодорхой бүлгүүдийн тоо, хэмжээ, бүтцийн хувьд оршин тогтнох нь хүрээлэн буй нийгмээс хамаарч байдаг бөгөөд бүлэг бүрэлдэх үйл явц, хэлбэрүүдэд тэдний ардчилсан хандлага нөлөөлж байдгийг онцлон тэмдэглэжээ.

Нийгэмд бий болсон бүлгүүдээс ялгаатай нь анхны бүлгүүд олон нийтийн байнгын харилцааны илэрхийлэл болдог (→ хамтын нийгэмлэг). 1900 оны дараахан боловсруулсан үзэл баримтлалдаа Charles

Н. Cooley → гэр бүл, хүүхдүүдийн тоглоомын бүлэг (→ тоглоом), хөрш болон тосгоны хамт олныг хамгийн чухал бөгөөд хамгийн анхдагч үндсэн бүлэг гэж тодорхойлсон бөгөөд энэ нь дараах шинж чанартай: Анхдагч бүлгүүд нь хувийн шууд харилцаатай (face-to-face association) байх ба нийгмийн мөн чанарыг, хувь хүний нийгмийн идеалыг бүрдүүлэхэд оролцдогоороо анхдагч юм. Тэднийг нийгмийн илүү цогц бүтэцтэй (хоёрдогч бүлгүүд) ижил хэмжээнд нийгмийн өөрчлөлтөд өртөөд байдаггүй гэж Cooley үзсэн бөгөөд бүлгийн амьдрал дахь ойр дотно, шууд харилцаанаасаа шалтгаалаад хувь гишүүний туршлагаас хэт холдож, хэт хийсвэр болж төөрөлдөж чадахгүй гэжээ. Хүмүүс үйл ажиллагааг хариуцагчийн хувьд бус харин хувь хүний хувьд анхдагч бүлгүүдэд ордог (Charles H. Cooley u. a., *Introductory Sociology*, 1933).

1930-аас 1940 онд анхдагч бүлгүүдийн ангилалд дахиад өөр нэр томьёо гарч ирсэн бөгөөд энэ нь нэг бол анхдагч бүлгийн шинэ хувилбар эсвэл бүлгийн амьдралд нэмэлт шинж чанарыг онцолсон хэлбэртэй байв. Үүнд албан бус бүлэг, асран хамгаалагчдын бүлэг, нэг үеийнхний, үе тэнгийнхний бүлэг зэргийг дурдах хэрэгтэй (*Einführung in die Gruppensoziologie*, hrsg. von Bernhard Schäfers, ³1999). Энэхүү жижиг бүлгийн судалгаа нь чухал үр дүнг өгсөн, жишээ нь, хэдий чинээ тухайн бүлгийнхээ тодорхой хэм хэмжээ, зорилгыг бүрэн гүйцэт өөрийн болгоно төдий чинээ тухайн хувь хүний бүлэг доторх зэрэглэл илүү дээгүүр байна. Үүнээс гадна бүлгүүд дүгнэлт гаргах, дүгнэлтийн нийцэлд нөлөөлдөг. Бүлгүүдэд ихэвчлэн

хоёр төрлийн манлайлал байна: зохион байгуулалттай, зорилгодоо үнэнч удирдагч ба “нийгмийн” сэтгэл хөдлөлийг тэнцвэржүүлэгч удирдагч (Hans-Dieter Schneider, *Kleingruppenforschung*, 1975). Сүүлийн жилүүдэд явцуу утгаараа гишүүнчлэлийн болон хэм хэмжээний хариуцлагад үндэслэдэггүй нийгмийн сүлжээний концептууд бүлгийн ойлголтыг анализын хэрэгсэл болгон орлуулах явдал нэмэгдэж байна.

Bernhard Schäfers

George C. Homans: *The Human Group*. New York [u. a.] 1950. – Dt.: *Theorie der sozialen Gruppe*. Übers. von Rolf Gruner. Köln/Opladen 1960, ⁷1978.

Friedhelm Neidhardt (Hrsg.): *Gruppensoziologie. Perspektiven und Materialien*. Opladen 1983. (Kölner Zeitschrift für Soziologie und Sozialpsychologie. Sonderheft 25.)

Jan Fuhse: *Gruppe und Netzwerk. Eine begriffsgeschichtliche Rekonstruktion*. In: *Berliner Journal für Soziologie* 16 (2006). Nr. 2: *Organisation und Arbeit*. S. 245–263.

Бүтэц (Struktur)

Бүтэц гэдэг үг нь олон төрлийн утга агуулгатай холбогддог. Бүтэц гэдгийг хийсвэрээр удаан хугацаанд байх бодит хэлбэрийн нэг боломж гэж ойлгож болно. Бүтэц нь үйл явцтай төстэй түр зуурын үзэгдлийн явцыг түүний дараалалд хязгаарлах бөгөөд тэдгээрийн

үйлдлийг зохицуулдаг. Ямар нэгэн зүйлийг зохион байгуулалтын хэлбэрт оруулж, хэлбэр өгөх нь өөрөө харилцааны төлөв байдлыг илэрхийлдэг. Бүтцийг эсрэг ухагдахуунаар аморф (хэлбэргүй) гэсэн нэр томъёог ашиглагддаг бөгөөд социологид мөн бүтцийн сэдвийг *нийгмийн морфологи* хэмээн авч үздэг. → Социологийн өмнөх эхэн үед бүтцийн тухай концептуал ойлголтыг чухалчилж авч үздэг байсан. Социологийн онолын үүднээс тайлбарласан ухагдахууны хувьд XX зууны эхэн үеэс эхлэлтэй. Ийнхүү Émile Durkheim-ийн үзлээр социологи бол бүтцийн онол (→ нийгмийн онол), харин Talcott Parsons энэ онолыг бүтцийн функц (→ функционализм) хэмээн нэрлэсэн. Бүтцийн тухай ойлголт өнөөдөр социологийн онолын үндсэн ухагдахууны нэг хэсэг нь болсон. Энэхүү ухагдахууныг мөн анхааралдаа авч үзэхдээ нийгмийн зохион байгуулалт хэмээн нэрлэдэг. Нийгмийн бүтцийн утгыг хоёр чиглэлд ялгаж болно. Энэ хоёр чиглэлд бүтцийг харьцангуй урт хугацаанд (тийм ч учраас тогтвортой байдлаар нөлөөлдөг) түр зуурын үйл явцтай харьцуулахад нийгмийн ялгарал болон үйл ажиллагаанд холбоотой байх бөгөөд эндээс үүдэн аль нэг ажиллагаанаас бий болох үйл явцад хамааралтай ба харилцах (→ харилцаа) хэлбэр хэмээн ойлгодог. Нэг талаас (1) нийгмийн бүтэц нь нас (бусад хүмүүс) болон бие (би) хоорондын үйл ажиллагаанаас үүдэлтэй үйл явцыг тодорхойлж буй нөхцөл хэмээн ойлгогддог, нөгөө талаас (2) нийгмийн нэгж хэсгийн гишүүдэд нөөцийг болон хэв шинжийг хуваарилах загварчлал

гэж үздэг. Нийгмийн бүтэц гэдэгт хувь хүний үзлээс илүү, нийгэмд чиглэсэн чиг баримжаа, хэв маягийг хэлэх бөгөөд гэхдээ үргэлж хүний нас болон бие нь өөрөө нийгмийн үйл явцын тухайн тээгч байх бөгөөд тэд өөрсдөө нэг нэгэндээ өөрийн нийгмийн үйлдлийг хийхэд шийдвэрлэх ач холбогдолтой хэмээн үзэх чиг баримжааны загвар буюу дүрэм гэсэн утгыг илэрхийлдэг.

Нас болон бие төлөв нь харилцан нэг нэгнээсээ хамааралтай бөгөөд эдгээр нь чиг баримжааны загвар, дүрэм журмуудаар ахин дахин шинийг хэрэгжүүлэх явцдаа тэдний үйлдэл түүнд чиглэгддэг (→ үүрэг роль). Иймэрхүү байдлаар хүлээлтийн тусгал (хүлээлт) нь мөн бүтцийн шинж чанарыг үүсгэдэг. (a) Өөрт хадгалагдсан чиг баримжааны загварын тусламжтайгаар нас болон бие төлөв нь тухайн үеийн нөхцөл байдалд юу хийхийг нөхцөлдүүлдэг, туйлын зорилго нь юу болохоос хамаарч дээр нөхцөл байдлыг улс төр, эдийн засаг, гэр бүл гэх мэтээр тодорхойлогдон, тэнд ямар дүрэм үйлчилж, ямар төрлийн зан үйл хүлээгдэж байгаагаар нэг нэгнээсээ ялгаргадаг. (b) Дүрмүүд нь хийх ёстой үүрэг бөгөөд нас болон бие төлөв нь түүний үйлдлийг тус бүрийн өмнөх үйл ажиллагааны дараа нэг нэгэнд нь нийцүүлдэг. Энэ утгаараа “юу юуг дагах вэ” гэдгийг хязгаарладаг (Niklas Luhmann, *Soziale Systeme*, 1984). Өмнөх үеийн социологид (Durkheim) “нийгмийн бүтцийг үндсэндээ дүрэм, журмаас гадна мөн ялгарал болон жам ёсны үүдэлтэй, тодорхойлогдсон зүйл” хэмээн үзэж байсан бол сүүлийн үеийн үзэл баримтлалд

нэмж чиг баримжааны загварыг хэрэглэсэн (Parsons, Alfred Schütz, Harold Garfinkel, Luhmann, Anthony Giddens, Hartmut Esser). Нийгмийн бүтэц нь зүгээр нэг жам ёсных биш, харин нас болон бие төлөвөөр тайлбарлаж болохуйц үйл ажиллагааны үр дүнд нөлөөлдөг “соёлын” гэж нэрлэгдэх бүтцийн сэдвийн аспекттэй (→ соёл) холбоотой байдаг.

(2) “Нийгмийн бүтэц” эсвэл “нийгэм-бүтэц” гэх ойлголт нь нийгэмд хамаарах нөөцийн хуваарилалтыг буюу нийтийн хүрээнд → хувь хүний хэв шинжийг тодорхойлох шинж чанарыг илэрхийлдэг. Тухайн нөөцүүдийг буюу хэв шинжийг олж тодорхойлохдоо хувь хүмүүсийг нэгтгэх замаар холбодог. Энэ нь бүтцийн хувьд хамааралтай тэдний хэмжээ, хамрах хүрээ байх бөгөөд учир нь энэ нөхцөл хувь хүмүүсийн оролцох боломж, нийгмийн байр суурь эзлэх орон зайг хязгаарлаж байдаг. Peter M. Blau (*Structural Contexts of Opportunities*, 1994) нь нийгэм-бүтэц гэсэн өөрийн судалгааны ажилдаа харилцааны энэ төрлийн хуваарилалтын хэм маягаар дамжуулж, өөрөөр хэлбэл олон янзын группийн гишүүдийн хоорондын шилжилт хөдөлгөөний түвшнийг судалсан. Энэ төрлийн загвар нь тухайлбал, нэгж хэсэг дэх хувь хүмүүсийн хуваарилалтын тухай тайлбарлаж болно. Эдгээр нэгж хэсгүүд нь тодорхой шинж чанарын дагуу нэгтгэгдэх бөгөөд эндээс ялгаатай төрлийн хэв шинжийг, тухайлбал, шашин эсвэл хүйс, мөн тэгш бус байдал гэх мэт шинж чанарууд харагддаг. Энд нийт хүн амын орлого эсвэл боловсрол, мөн → бүлэг хоорондын давхцал зэргийг тодорхойлж болно.

Иймэрхүү байдлаар нэгж хэсгүүдийн хуваарилалтаас үүдэлтэй харилцааны загвард харилцагчийн боломж, мөн шилжилт хөдөлгөөний түвшнийг тодорхойлж болно. Үүнтэй ижил төстэй онолын үзэл баримтлалыг Georg Simmels-ийн “нийгмийн давхаргын огтлолцол” (*Soziologie. Untersuchungen über die Formen der Vergesellschaftung*, 1908) болон Thomas C. Schelling (*Micromotives and Macrobehavior*, 1978) нарын бүтээлээс харж болно. “Нийгмийн бүтэц” гэсэн энэ хоёр төрлийн чиглэл нь хоорондоо ялгаатай. Эхний нэг (оролцогч гэж нэрлэгдэх) хандлага нь нас болон бие гэсэн концептуал ойлголтыг илэрхийлж байхад хоёр дахь хэсэг нь цэвэр хөндлөнгөөс юуны түрүүнд ажиглагч байдлаар асуудалд ханддаг. Өнөө үеийн нийгмийн онолуудад энэхүү хоёр үзэл баримтлал “нийгмийн бүтэц” гэсэн ойлголтоор нэгтгэдэг бөгөөд “нийгмийн бүтцийг” боломжууд, нөөцүүд, институциас тогтоосон дүрэм, журам болон соёлд суурилсан мэдлэгийн загварчлал (Hartmut Esser, *Soziologie. Spezielle Grundlagen*, Bd. 6: *Sinn und Kultur*, 2001) эсвэл хүлээлт-, утга илэрхийлэх- болон бүтцийн тогтолцоогоор (Uwe Schimank, *Handeln und Strukturen*, 2000) нэг нэгнээсээ ялгарах хэдий ч мөн нэг нэгэнтэйгээ холбогдсон байдаг.

Rainer Greshoff

Anthony Giddens: *The Constitution of Society. Outline of the Theory of Structuration*. Cambridge 1984.

– Dt.: *Die Konstitution der Gesellschaft. Grundzüge ein-*

er Theorie der Strukturierung. Übers. von Wolf-Hagen Krauth und Wilfried Spohn. Frankfurt a. M. / New York 1988, Studienausg. 1992, 1997.

Andreas Reckwitz: Struktur. Zur sozialwissenschaftlichen Analyse von Regeln und Regelmäßigkeiten. Opladen 1997.

Rainer Greshoff / Georg Kneer (Hrsg.): Struktur und Ereignis in theorievergleichender Perspektive. Opladen/Wiesbaden 1999.

Гэр бүл (Familie)

“Гэр бүл” гэдэг нэр томъёо ерөнхийдөө (ганц бие) эцэг-эх-хүүхдийг хамтад нь нэрлэж байгаа бөгөөд товчхондоо удам угсаагаар, өргөмөл байдлаар эсвэл тусгайлан нийтээр журамласан хариуцлагын зохицуулалтын дагуу (асрагч гэр бүл) хамгийн багадаа хоёр үеийг хамруулдаг ойлголт юм. Гэр бүлд, цаашлаад мөн нийгэмд бүхэлд нь гишүүдийн бие бялдрын болоод сэтгэл зүйн үе солигдох хүлээлт байдаг. Гэр бүлийн социологи нь тусгай социологийн хувьд ерөнхий социологийн аргуудыг (→ арга зүй) ашигладаг бөгөөд “гэр бүл” гэсэн сэдэвт судалгаан дээр төвлөрдөг. Сүүлийн үед харин энэ сэдэв хамтын амьдралын өөр хэлбэрүүд (жишээ нь, гэрлэлтгүй хамтын амьдрал) гарч ирснээр судалгааны хүрээг тэлсэн. “Гэр бүл” бол эрт үеэс хойш шинжлэх ухааны хэлэлцүүлгийн сэдэв байсаар ирсэн бөгөөд ингэхдээ түүнийг “зорилгодоо

хүрэх арга хэрэгсэл” байдлаар, өөрөөр хэлбэл, төрийн байгуулалт, сүм хийд, хүн амын хөгжил зэргийг судлах хүрээнд авч үзэж байсан. Гэр бүлийн тухай судлах, мөн гэр бүл ба нийгмийн бусад салбаруудын хоорондох шилжилтийн нөлөөний тухай шалгаж болох мэдлэгийг системтэйгээр олж авах зорилго XX зууны дунд үеэс хойш мэргэжлийн социологи үүсгэн байгуулагдсаны дараа л бий болсон. “Гэр бүл” (латинаар *familia*) гэдэг үг XVII зууны сүүл үед герман хэлэнд нэвтэрсэн бөгөөд гэр гэгдэж байсан хуучин хэрэглээний нэршлээ орхисон. “Гэр бүл” нь ихэнхдээ “хамаатан”-тай ижил утгаар хэрэглэгдэж, заримдаа хүүхэдгүй хосуудыг нэрлэх нь ч бий.

Социологид “гэр бүл”-ийг сэтгэл хөдлөл, дотно харилцааны тал дээр төвлөрдөг хамтын амьдралын онцгой харилцан хамаарлын систем (→ харилцан үйлчлэл) гэж зарим судлаачид тодорхойлсон байдаг. Зарим нь үүнийг үндсэн хэрэгцээ хангаж, нийгмийн ижилслийг (*Identität*) таниулж өгдөг нийгмийн нэг гэж нэрлэдэг. Өөр бусад нь “гэр бүл”-ийг өрх тусгаарлаагүй хүүхдүүдийнхээ хамт амьдардаг буюу “гэрээ авч явдаг” эцэг эхийн → бүлэг гэж тодорхойлсон байна. Эцэст нь гэр бүл дэх → нийгэмшүүлэх буюу нөхөн үржихүйн-, байр сууриа олох-, асран халамжлах- зэрэг үүрэг бүхий тодорхой ур чадваруудыг тусгайлан судалдаг судлаачид мөн байна.

Эдгээр тодорхойлолтуудын ихэнх нь “дундаж хүрээний” гэр бүлийн талаарх томьёолол бөгөөд түүний зарим нь орчин үеийн Баруун Европын гэр

бүлийн үндсэн загварыг буюу гэр бүлийн зөвхөн тодорхой нэг төрлийг л хамааруулж байгаа. Энэ нь ялангуяа Talcott Parsons (*Beiträge zur soziologischen Theorie*, 1964)-д илүү хамааралтай бөгөөд түүний гэр бүлийн тодорхойлолт социологийн хүрээнд удаан хугацаанд хүлээн зөвшөөрөгдөн тархаж байсан юм. Parsons-ын хувьд гэр бүлийн чухал шинж чанар нь тодорхой үүргийн бүтэцтэй (→ үүрэг) байх ба өөрөөр хэлбэл аав, ээж, хүүхдийн хамтын амьдрал, тэдний үүргийн тусгай функциональ ялгаанаас (→ ялгаа) бүрэлдэнэ. Тухайлбал, эхнэр нөхрийн хооронд гэрийн дотоод (дотор) ба гаднах (гэрээс гадуур) ажлыг маш тодорхой хуваарилсан байдаг: Нөхөр бол гэрийн санхүүгийн баталгаат байдлыг, эхнэр/ээж хүн бол гэрийн дотоод ажил болон юуны түрүүнд хүүхдүүдээ асран халамжлах, өсгөн хүмүүжүүлэх ажлыг хариуцна. Цаашлаад Parsons тэдний харилцан үйлчлэлийн тодорхой харилцааны онцлогийн авч үзэхдээ: Эх хүний үүрэг “нээлттэй харилцаа”-тай уялдана, эцэг хүний үүрэг “харилцааг зорилгодоо хүрэх арга хэрэгсэл”⁴ болгох хандлагатай уялдана. 1970-аад оныг хүртэл энэ загвараар аж үйлдвэржсэн нийгэм дэх бүх гэр бүлүүдийн дийлэнх хэсгийг тодорхойлж байсан гэж үзэж болно. Одоо энэ загвар нийгмийн бусад салбар дахь олон янзын өөрчлөлтийн үйл явцаас шалтгаалан зөвхөн цөөнхөд үйлчилж байна.

Цаашлаад гэр бүлийн тодорхойлолтуудыг тоймлон авч үзвэл тэднийг зохиогчид өөрсдийн сонгосон танин

4 Хүүхдийнхээ сайн зан чанарыг дэмжих, муут нь өөгшүүлэхгүй байх.

мэдэхүйн онолын парадигмаас хамааран гэр бүлийн бүхэл нийгэм дэх чухал ач холбогдлыг эсвэл түүний бүлгийн шинж чанарыг онцлон тэмдэглэдэг болох нь харагдана. Макро социологийн үүднээс авч үзвэл “гэр бүл” нь нийгэмд тодорхой (үндсэндээ дээр дурдсан) үүрэг гүйцэтгэдэг буюу гүйцэтгэх ёстой нийгмийн хэсэг гэж тодорхойлогдоно. Үүнтэй холбогдуулаад энэ хугацаанд эргэлзээтэй болоод байгаа, гэр бүлүүд, төр болон нийгмийн өөр бүлгүүдэд тодорхой чиг үүргээ шилжүүлсэнтэй холбоотойгоор аж үйлдвэржилтийн өмнөх гэр бүлтэй харьцуулахад орчин үеийн гэр бүлийн (→ орчин үе) тодорхой үүргүүд алдагдаж байгаа талаарх сэдэв гарч ирсэн. Микро түвшинд авч үзвэл “гэр бүл” нь дотоод бүтцийн онцлогоос шалтгаалан “онцгой төрлийн бүлэг” гэж тодорхойлогддог.

Макро болоод микро аль ч түвшинд авч үзсэн ямар ч соёлын амьдралтай гэр бүлүүдийн хувьд бусад нийгмийн тогтолцооноос ялгарах шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан гэр бүлүүдийг түүх, бүс нутаг, соёлын онцлог байдлаас үл хамааран дараах үндсэн хэв маягаар тодорхойлж болно:

Нийгмийн тодорхой үүргийг хариуцаж авснаар нь, наад зах нь биологийн болон сэтгэл зүйн төлөвшил, нийгэмшлээр нь;

Үе хоорондын ялгаагаар нь (Хүүхдүүд, эцэг эхчүүд эсвэл эх болон/эсвэл эцэг, өвөө эмээ, магадгүй элэнц эмээ өвөө);

Гэр бүлийн гишүүдийн хооронд тогтсон, тодорхой хариуцлагад тулгуурласан хамтын үйл ажиллагаа, эв

нэгдлийн харилцаагаар дамжуулаад үүргийг нь тодорхойлж болно.

Удаан хугацааны туршид гэрлэлтийн дэд тогтолцоо нь гэр бүлийн социологид “гэр бүл” гэдэг нэр томъёоны шийдвэрлэх шалгуур гэж тооцогдож байв. Хэдийгээр ихэнхдээ гэрлэх ёслолоор гэр бүл зохиож эсвэл сольж (бэлэвсэрсэн эсвэл салсан тохиолдолд) эсвэл өргөжиж (олон үеийн-эсвэл олон эхнэртэй гэр бүлийн тухайд) байсан ба байх боловч бас хэзээ ч гэрлэлтийн дэд тогтолцоо дээр суурилж байгаагүй юм уу эсвэл үхэл хагацал, гэр бүл цуцлалт, салалтаас шалтгаалан хэн нэгнийх нь үүрэг дутагдсаны улмаас тэдний гэрлэлтийн дэд тогтолцоо гэр бүл зохиох явцдаа нуран унасан гэр бүл (жишээ нь, эх-хүүхэд) бүх цаг үед, бүх соёлд байсан. Тиймээс өнөөдөр гэр бүлийн социологид энэ гэрлэлтийн дэд тогтолцоог гэр бүлийн чухал шалгуур үзүүлэлт гэж үзэхээ больжээ. Хамтарсан өрхөд энэ мөн адил хамаатай юм. Үүний оронд хамт амьдрах боломжит хэлбэрүүдийн олон ургалч байдлыг (хоёр талаасаа хүүхдүүдтэй нийлсэн, гэрлээгүй хамтран амьдрах, ижил хүйстэн гэр бүл) харгалзан үзэж гэр бүлийн амьдралын хэв маягийг судалдаг социологийн тухай илүүтэй ярьж болно. Үүргийн цар хүрээ нь харилцан адилгүй, бүтцийн олон янзын онцлог шинжтэй хэдий ч гэр бүл нь хүн төрөлхтөн хамтаар оршин тогтнох универсал юм. Гэр бүл нь нийгмийн нэг хэсэг гэдэг утгаараа зөвхөн үүгээр тодорхойлогдоод зогсохгүй. Өөрийнхөө зүгээс эргээд нийгмийг өөрчлөх, хадгалахад үргэлж хувь нэмрээ оруулж байдаг. Нийгэм-

эдийн засгийн үүднээс авч үзвэл хүний амьдралын бүхий л салбар, нийгмийн бусад бүх салбар (ялангуяа хөдөлмөрийн зах зээл) гэр бүлийн үүргийн нийгмийн хүртээмжээс хамаарч байдаг бөгөөд үүнийг хүний нөөц бүрдүүлэх, хадгалахад оруулж байгаа хувь нэмэр, эдийн засгийн хөрөнгө оруулалт гэж ойлгож болно (Hans-Günter Krüsselberg, *Ethik, Vermögen und Familie*, 1997). Гэр бүлийн бодлогын хүрээнд гэр бүлийг нийгэмд үүрэг хүлээж байгаагийн хувьд санхүү, хууль эрх зүй болон дэд бүтцийн хүрээнд янз бүрийн байдлаар бодлогоор дэмжих оролдлого хийгдэж байгаа. Гэсэн хэдий ч хамгийн ирээдүйтэй арга хэмжээний тухай улс төр, шинжлэх ухааны хэлэлцүүлэг (жишээ нь, Герман дахь төрөлтийн хувь тасралтгүй буурч байгаа эсвэл хүүхдийн ядуурлыг даван туулах) явцгүй байна.

Rosemarie Nave-Herz

Rosemarie Nave-Herz / Manfred Markefka (Hrsg.): Handbuch der Familien- und Jugendforschung. 2 Bde. Neuwied 1989.

René König: Schriften. Bd. 14: Familiensoziologie. Hrsg. von Rosemarie Nave-Herz. Opladen 2002.

Karl Lenz: Familie – Abschied von einem Begriff? In: Erwägen – Wissen – Ethik 14 (2003). S. 485–498.

Rosemarie Nave-Herz: Ehe- und Familiensoziologie. Weinheim/München 2004, 2006.

Даяаршил/Дэлхийн нийгэмлэг (Globalisierung/Weltgesellschaft)

“Даяаршил” ба “Дэлхийн нийгэмлэг” гэсэн ухагдахуунаар орон зайн асар өргөн цар хүрээг хамарсан нийгмийн харилцаа хамаарлыг үүсэхийг хэлдэг. Өнөө цагт Европын нийгмийн колоницлолын тэлэлтийн нөхцөлд ажиглагдаж байгаа энэхүү үйл явц нь аажмаар дэлхийн хэмжээнд нэг нийгмийн тогтолцоо бүрэлдэхэд хүргэсэн (→ нийгэм). Энэ болж байгаа үйл явдлын зарим үйл явцын тухай (тухайлбал, эдийн засгийн эсвэл улс төрийн даяаршил) судалж авч үзэх үед ихэвчлэн “даяаршил”-ын тухай ойлголт гарч ирэх бол “дэлхийн нийгэмлэг” нь эдгээр үйл явцын үр дүнг хэлдэг: Дэлхий дээрх бүх → харилцаа холбоог багтаасан түүхэн өвөрмөц харилцаа холбооны систем бөгөөд ингэхээр зөвхөн нийгмийн бус (утга учиртай харилцаа холбоонд тулгуурлаагүй) орчинтой.

Даяаршсан нийгмийн утга санаа 2000-аад жилийн өмнөөс дэлхийн иргэншлийн талаарх сэтгэлгээний хэлбэрүүдэд (космополитизм), бүх хүмүүсийг багтаасан байгалийн хуульд захирагдах нийгмийн төсөөлөлд, хүн төрөлхтний тухай үзэл санааны өөр хувилбаруудад оршиж ирсэн. Дэлхий нийтийн худалдаа, үйлдвэрлэл, соёл урлаг, шинжлэх ухааны нөлөөтэй хамаарлууд аль хэдийн бий болсон байх энэ уламжлал дээрээс Immanuel Kant (*Zum ewigen Frieden*, 1795) “дэлхийн иргэний нийгэм” гэдэг санааг гаргасан. Дэлхийн II дайн дууссанаас хойш улс төр судлаачид,

социологичид (түүний дотор: Immanuel Wallerstein, Peter Heintz, John Burton, Niklas Luhmann, John W. Meyer нар) дэлхийн харилцан хамаарал, нийгмийн салбаруудын бие даасан байдал, тухайлбал, → хууль, шинжлэх ухаан, эдийн засаг, шашин шүтлэгийн тухай санааг агуулсан дүгнэлтийг дэлхийн улс төрийн болон дэлхийн нийгэмлэгийн онолуудад хүлээн зөвшөөрөх болжээ. Түүнээс хойш дэлхийн нийгэмлэгийн онолыг нэг талаас мэдээлэл, харилцааны онолоор тайлбарлах болсон бөгөөд учир нь дэлхийн хэмжээнд мэдээлэл дамжуулж, дэлхий даяар харилцаа холбоо тогтоох болсон билээ. Нөгөө талаас энэ нь зэрэгцээд Kant болон зарим түүний үеийнхний (Carl Gottlieb Svarez oder Georg Forster) урьдчилан боловсруулсан байдлаар дэлхийн функцийг онол юм. Нийгмийн → бүтцийг бүрдүүлэх бусад хэлбэрүүд энэ дүр зургийг бүрэн болгох юм: нийгмийн зохион байгуулалтын хэлбэр болон → нийгмийн сүлжээний эдгээр нээлтүүд дэлхий нийтийн харилцан хамаарлыг бий болгоход хэр их тохиромжтой болохыг харуулж байна. Бүтцийн эдгээр хэлбэрүүдийн зэрэгцээ үйл явцтай холбоотой харилцаа холбооны шахалт байдаг, жишээ нь, “дэлхийн дайн” эсвэл “зохион байгуулалттай дэлхийн үйл явдал” (дэлхийн чуулган, олимпын тоглолт гэх мэт) нь дэлхий даяарх нэгдмэл байдал эсвэл задралыг (хуваагдлыг) илэрхийлэх ба зарим тохиолдолд → өөрчлөлтийг тасалдахад хүргэдэг.

Дэлхийн нийгэмлэгийн үүсэл нь тээврийн болон харилцаа холбооны мэдээллийн хэрэгсэлтэй нягт

холбоотой. Дундад зууны үеийн болон шинэ цагийн эхэн үеийн тээврийн хөдөлгөөний болон мэдээлэл харилцааны техникийн харьцангуй зогсонги (ном хэвлэхээс бусад) байдлын дараагаас XIX болон XX зуун тээврийн хөдөлгөөн (төмөр зам, автомашин, онгоц) болон харилцаа холбооны (цахилгаан мэдээ, утас, радио, телевиз, интернэт) үргэлж шинэ техникуудийг маш хурдацтайгаар дараалуулан зохион бүтээж байснаар тодорхойлогддог. Эдгээр бүтээлийн ачаар аялагч өнөө үед дэлхийн бараг бүх цэгт нэг өдрийн дотор хүрч, харилцаа холбоо тогтоох бол ямар ч цагийн хоцролтгүйгээр ижил үр дүнг хүлээн авч чадаж байна. Энд мөн нийгмийн бүтцэд харилцаа холбооны ач холбогдол нэмэгдэж байгаа нь харагдаж байна. 1900 оны үед даяаршлын анхны том давлагаа массыг хамарсан шилжилт хөдөлгөөнөөр тив дамнан өрнөсөн байхад өнөөдөр мэдээллийн хэрэгсэл дээр тулгуурласан бодит нөхцөл байдлыг газар дээрээс нь мэдээлэх явдал давамгайлах болсон нь аялал, шилжилт хөдөлгөөний нийгмийн бүтэц дэх ач холбогдлыг бууруулж байна.

“Дэлхийн нийгэмлэг” нь урьд өмнө хэзээ ч ажиглагдаж байгаагүй → орон зайн болоод → цаг хугацааны хэмжүүр, тооцоолол, зохицуулалт, хяналтыг дэлхий дээрх үйл явдлын нэгэн төрлийн тодорхойлогч хүчин зүйл болгон харуулж байна. Гэхдээ дэлхийн нийгэмлэгийг зөрчилгүй байдал, нийгмийн тэгш байдал эсвэл харилцааны цогц зохицуулалт гэж андуурч болохгүй. Үүний оронд бүс нутаг, улс орнуудын хоорондын тэгш бус байдал нэмэгдэж байгаагаас

→ тэгш бус байдлын даяаршилд, мөн дэлхийн дайн болон байршил харгалзахгүй дэлхийн терроризмд бүртгэгдсэн → зөрчилдөөний даяаршилд асуудал байдаг. Энэ нь нэг талаараа маш өвөрмөц нийгмийн тогтолцоонд дэлхийн хэмжээний харилцааны тодорхой ижилсүүлгийг харуулдаг хэдий ч (хөгжмийн дасгал, спортын төрлөөр хичээллэх гэх мэт) үүнтэй зэрэгцээд функциональ ялгаатай → бодит байдлаар дэлхийн нийгэмлэгийг бүтээдэг олон тооны харилцаа холбооны системийг, олон газрын олон янз (ялгаатай байдал)-ын үйлдвэрлэлийг, түүхэнд ховорхон (→ ялгарал) хэмжээний инновацыг харуулдаг.

Хувьслын болон экологийн үүднээс авч үзвэл “дэлхийн нийгэмлэг” гэдэг нь дэлхийн бөмбөрцгийн олон хэсэгт аль болох бие биеэсээ үл хамаарсан нийгмийн туршилтуудыг явуулж, энэ утгаараа дэлхийн аль нэг бүс нутагт тохиолдсон гамшгийн хохирлыг өөр бүс нутагт бүтээмжтэй инноваци ашиглан нөхөх чадвартай байхад чиглэгдсэн эрсдэлийн хуваарилалт (→ эрсдэл) ажиллахаа больсон гэсэн үг юм. Нэг тогтолцоо дахь → хувьслын утга бидний ирээдүйг тодорхойлох туршлага байх болно.

Rudolf Stichweh

Immanuel Wallerstein: The Modern World-System. 3 Bde. New York 1974–88. – Dt.: Das moderne Weltsystem. 3 Bde. Übers. von Angelika Schweikhart. Frankfurt a. M. / Wien 1986–2004.

Niklas Luhmann: Die Gesellschaft der Gesellschaft. 2 Bde. Frankfurt a. M. 1997.

Rudolf Stichweh: Die Weltgesellschaft. Soziologische Analysen. Frankfurt a. M. 2000.

Bettina Heintz [u. a.] (Hrsg.): Weltgesellschaft. Theoretische Zugänge und empirische Problemlagen. Stuttgart 2005.

John W. Meyer: Weltkultur. Wie die westlichen Prinzipien die Welt durchdringen. Frankfurt a. M. 2005.

Дискурс (Diskurs)

Өдөр тутмын ярианы хэрэглээнд бол дискурс (францаар *discours*, латинаар *discurrere* = *нааш цааш алхах*, энд *харилцан яриа, хэлэлцээр, учир шалтгааныг тодорхойлох хэлэлцүүлгийн утгаар*) гэдэг нь тодорхой үндэслэлийн шалтгааныг тодорхойлохын тулд нээлттэй сэдэв эсвэл цаг үеийн асуудлыг хамруулж хэлэлцэх тухай ойлголт юм. Нөгөө талаас дискурс гэдэг ойлголтын шинжлэх ухааны хэрэглээ бол журамлагдсан ярианы хэлбэр, бүтэцтэй бөгөөд нийгэмд мэдлэгийн чухал хэлбэрүүдийг хамруулж байдаг. Тиймээс нөлөө бүхий дискурс нь тодорхой юмс үзэгдэл эсвэл тодорхой мэдлэгийн салбарт юу бодож, хэлж болох вэ, юут болохгүй вэ гэдгийг тодорхойлдог. Эдгээрт хэлэлцэгдсэн зүйлсийг нэгтгэвэл хувь хүнээс давж, → соёл, → нийгэм, түүхийн эрин үеийн хамтдаа бүтээсэн бодит байдлын (→ бодит байдал) тухай ойлголтыг олж харж болно.

Дискурс нь зөвхөн сэтгэлгээний төрөл, ярианы

утгын боловсруулалтаас илүүг харуулна. Соёлын практик, нийгмийн → харилцааны үйл явдлыг зөвхөн журамлагдсан хэлбэрт бариад байдаггүй. Дискурс нь бүтцийг үүсгэх чадвартай (→ бүтэц). Аливаа зүйлийг нийгэмд тараах хүчтэй. Иймд социологийн хувьд сонирхол татагддаг нь зөвхөн нийгмийн хүрээнд тарж байгаа тодорхой зүй тогтлыг дагаж гарч ирдэг ярианы хэв маяг, дохионы үйл явц, бэлгэдлийн систем биш, харин институцчилэгдсэн практик нөхцөл болон эрх мэдлийн аппаратаар хумигдсан нарийн төвөгтэй дискурсийн цогц системүүд юм.

Утга зохиол судлал, хэл шинжлэл, түүхийн шинжлэх ухаан, философиос үүдэлтэй дискурс нь социологид, ялангуяа соёл, мэдлэгийн социологийн салбараас (→ соёл, мэдлэг) илүүтэй, мөн жендерийн судалгаа, хэвлэл мэдээллийн социологид (→ хүйс, хэвлэл мэдээлэл) ч чухал ач холбогдолтой болсон. Энэ нь ялангуяа Францын структурализм ба постструктурализм дахь хэл шинжлэлийн онолын арга зүйд хамаарах хэд хэдэн онолын хөгжлийг чиглүүлж өгсөн байдаг. (юуны өмнө, Claude LéviStrauss-ын угсаатны зүйн бүтэц, Ferdinand de Saussures-ын хэл шинжлэлийн онол, Jacques Derridas болон Michel Foucaults -ын постструктуралист арга зүй).

Энэхүү дискурсийн концепт нь философи, социологи болон соёл судлалд *Linguistic Turn*⁵ хэл шинжлэлийн

5 Хэл шинжлэлийн эргэлт нь ялангуяа XX зууны эхэн үед барууны сэтгэлгээний философи, утга зохиол судлал, хэл шинжлэлд гарсан эрс тэс өөрчлөлт, үзэл баримтлалыг тодорхойлдог. Энэ нь хэл бол бодит байдлыг ойлгох, дамжуулах “ил тод мэдээллийн хэрэгсэл” гэсэн үндсэн эргэлзэл дээр суурилдаг.

эргэлт хийхийн зэрэгцээ түүний материаллаг, “биеийн” хэмжээсийг өргөтгөж өгсөн. Дискурс нь материаллаг, биет хэлбэртэй байдаг гэсэн суурь ойлголт бий. Энэ нь тэдний хэлж байгаа зүйл бодит байдлыг бий болгох, өөрөөр хэлбэл үгээр бодит байдлыг бүтээх, үгийн болон дискурсийн бүтээлч хүчнээс үүдэж гарсан (John L. Austin, *How To Do Things with Words*, 1962, dt. 1962). Ингэж жишээ нь “эрэгтэй” эсвэл “эмэгтэй” гэх мэт үгнүүд нь өгөгдсөн бодит байдлыг дүрсэлдэггүй, зөвхөн нэрлэсэн зүйлээ л илэрхийлдэг, өөрөөр хэлбэл энэ тохиолдолд → хүйсийн статусаар ялгасан бодит → субъектуудыг зааж байна (Judith Butler, *The Psychic Life of Power*, 1997, dt. 2001). Дискурсийн концептод (пост) структуралист хэл шинжлэлийн дискурс гэсэн ойлголтоос гадна прагматик хандлагатай концептыг ч мөн хамруулах бөгөөд энэ нь давамгайлалгүй → харилцаатай интерсубъектив дискурст гажуудалгүй ярих хамгийн тохиромжтой нөхцөлийг хэлнэ. Энд дискурсийн этик нь нотолгоот ярианд үнэний шаардлагыг сонирхдог (Jürgen Habermas, *Theorie des kommunikativen Handelns*, 2 Bde., 1981).

Нийгэм, соёлын шинжлэх ухаанд, ялангуяа пост-структуралист онолын хүрээнд дискурс гэх ойлголтын өнөөгийн нөлөө, түгээмэл байдал нь юуны түрүүнд Foucault-ын бүтээлтэй холбоотойгоор бий болсон. Түүний “археологи” нь дискурсийг нийгэм эсвэл эрин үеийн соёлын архивыг бүрэлдүүлэх түүхэн өгөгдөлтэй мэдлэгийн хэлбэр, дүрэм журамд захирагддаг туршлага болгон шинээр нээсэн (*L'archéol-*

ogie du savoir, 1969, dt. 1981). Habermas-аас ялгаатай нь Foucault интерсубъектив үндэслэлтэй гэж хүлээн зөвшөөрөгдсөн үнэнийг тогтоох тухай авч үздэггүй. Үүнээс илүүтэйгээр дискурсийг эрх мэдлийн төлөөх түүхэн тоглоомын талбар гэж хардаг. Үүний гол утга нь дискурсийн материаллаг байдал, эрх мэдлийн нөлөөнд оршино, өөрөөр хэлбэл, аливаа зүйлийн материаллаг байдал, биет чанарыг бэлэн болгох, бүтээх туршлага гэж дискурсийг тодорхойлсон. Ийнхүү дискурс гэдэг нэр томьёо нь бүтээх үйл явцын бие даасан байдал, утга зүйн болоод соёлын үйл явцын хөдөлгөгч хүчийг илэрхийлж байна. Эдгээр нь институциуд, хөтөлбөрүүд, материаллаг архитектурууд гэх мэт цогц системтэй холбоотой бөгөөд эрх мэдэл-мэдлэгийн цогцыг бүрдүүлдэг (“диспозитив”). Дискурс нь хэлж байгаа зүйлийг хэлний, семиотикийн⁶ эсвэл утга зүйн үзүүлэлтээр хязгаарладаг биш, харин хэлний бус талуудыг бас багтаасан “дискурсив практик” байдлын нэг хэсэг юм. Дискурс гэдэг ойлголтод хэлний дискурсив болон нийгэм-техникийн үзэгдэл, утга зүй болон биеийн хэлэмж харилцан уялдаатай багтаж байдаг.

Нэг дискурс нь нөгөө дискурсийг өдөөдөг. Эдгээр нь нэгэн бүхэл “дискурсийн ертөнц”-д холбогдсон байдаг.

Дискурсийн үндсэн хэсэг бол ярих юм. Энд юмсын болон нэр томьёоны үүсэл, илэрхийлэх урлаг болон арга техникийн тодорхой дүрмийг дагаж мөрддөг. Энэ дүрэмд аливаа юмсыг дискурс хийх категориудыг бүрдүүлж буй гол нэр томьёогоор тодорхойлж, дискур-

6 Тэмдэг судлал

сийн ган бэхэлгээ мэт холбох бөгөөд утга зүйн гол цогцолбор гэж ойлгогдохоор байна (vgl. Jürgen Link, *Versuch über den Normalismus: Wie Normalität produziert wird*, 1997).

Дискурсийг шууд ойлгох боломжгүй, харин тодорхой арга зүйгээр дискурсийн шинжилгээ хийж тайлдаг байна. Энэ дискурсийн шинжилгээ нь зөвхөн соёлын болон нийгмийн шинжлэх ухааны судалгааны тусгай хөтөлбөр болон хөгжөөд зогсохгүй, мөн нийгмийн бүтцийн түүхэн шинэчлэлийг чиглүүлдэг тусгай арга зүй болсон. Foucault-ын араас Siegfried Jägers (1993)-ийн онол, арга зүйн эргэцүүллийг нарийвчилсан практик дүн шинжилгээтэй хослуулан бичсэн чанарын шүүмж дискурсийн шинжилгээг онцлон дурдах нь зүйтэй. Нийгмийн шинжлэх ухаан дахь нийгмийн шүүмжлэлт дискурсийн шинжилгээний бусад онцлох хэлбэрүүд бол Norman Fairclough “*Critical Discourse Analysis*” (1995) болон Ernesto Laclau, Chantal Mouffe нарын нийгмийн онол болгон томъёолсон “дискурсийн онол” юм. Энэ хоёр хэлбэр нь марксист онолын уламжлалд чухал ач холбогдолтой идеологийн шүүмжлэл (→ идеологи) үзэл баримтлалтай уялдаж байна.

Hannelore Bublit

Reiner Keller: Diskursanalyse. In: Ronald Hitzler (Hrsg.): Sozialwissenschaftliche Hermeneutik. Opladen 1997. S. 309–334.

- [u. a.] (Hrsg.): Handbuch Sozialwissenschaftliche Diskur-

- sanalyse. Bd. 1: Theorien und Methoden. Opladen 2001. S. 225–260.
- Diskursforschung. Eine Einführung für SozialwissenschaftlerInnen. Opladen 2004.
- Andreas Lösch [u. a.]: Technologien als Diskurse. Konstruktionen von Wissen, Medien und Körpern. Heidelberg 2001.
- Hannelore Bublitz: Diskurs. Bielefeld 2003.

Ёс суртахуун (Moral)

Ёс суртахуун (латинаар *mos* = “дадал”, “хууль”, “зан үйл”) нь заавал дагаж мөрдөх → хэм хэмжээний хэвшмэл бус гадагш чиглэсэн (тухайлбал, нэр хүндээ алдах) төрлийг агуулах бөгөөд зөрчсөн тохиолдолд ихэвчлэн дотоод гэмшил (жишээ нь, гэм буруугийн мэдрэмж) үүсдэг. Хүн төрөлхтний соёлт нийгэмд ёс суртахууны болон нийгэм, шашны хэм хэмжээ, эрхэмжит зүйлс хоорондоо ялгаагүй хэр нь хүн бүрд хамаатай байдаг. Орчин цагийн соёлт нийгэмд ёс суртахуун нь шашин шүтлэгээс улам хөндийрч, харилцан зөвшилцөл, сайхан амьдралын талаарх эргэцүүлээс улам зааглагдах болсон. Дотоод ертөнцийн шалтгаант ухамсарт ёс суртахуун нь хүн бүрийн тэгш эрх ашигт нийцдэг тул тэдгээрийн зөвшөөрч болох хэм хэмжээг л хүчин төгөлдөр гэж үздэг. Уламжлалт ёс суртахуунтай харьцуулахад агуулгын хувьд хязгаарлагдмал (бусдад хор хөнөөл учруулахгүй бүхнийг зөвшөөрдөг) хэр

нь нийгэмд түгээмэл (огт танихгүй хүнийг ч хуурч мэхлэх ёсгүй гэх мэт үзэл). Социологи анх үүссэн цагаас эхлэн ёс суртахууны асуултуудтай нүүр тулсаар ирсэн. Философийн ёс зүйтэй харьцуулбал тэрээр ёс суртахууны хэм хэмжээг зөвтгөх тухай биш, харин нийгмийн чиг үүрэг, ёс суртахууны үзэл санааны өөрчлөлтийг судалдаг. Агуулгын хувьд хоёр тохиолдлыг ялгаж зааглах шаардлагатай: нэг талаас нийгмийн онолын бүтээлүүдийг орчин үеийн нийгмийн → өөрчлөлт ба ёс суртахуун хоорондын уялдаа, нөгөө талаас нийгмийн хэрэгцээ шаардлагын судлагдахуун ба хувь хүний ёс суртахууны хөгжлийн явц. Emile Durkheim ёс суртахуун ба нийгмийн → интеграцчилал хоорондын хамаарлыг тодорхойлохдоо (*De la division du travail social*, 1893, dt. 1977) ёс суртахууны тусламжтайгаар хувь хүний үйлдлийг удирдан чиглүүлснээр нийгмийн хэв журмыг сахиулах боломжтой гэж үзсэн. Хуваалцсан ёс суртахууны үзэл баримтлал болон эрхэмжит зүйлс нь Талкотт Парсон (Talcott Parson)-ы бүтцийн функционализм (→ функционализм)-д интеграцчиллын үүрэг хүлээсэн. Niklas Luhmann-ы системийн онолын үүднээс авч үзвэл (*Die Gesellschaft der Gesellschaft*, 1997) орчин цагт ёс суртахуун нь хүн хоорондын харилцааг зохицуулах бөгөөд зөвхөн бусдыг хүндлэх үзэл (→ систем)-ээс ангижирсан. → Нийгмийг бүхэлд нь ёс суртахууны доор нэгтгэх боломжгүй бөгөөд шаардлагагүй юм. Хэм хэмжээг тодорхойлох “дээд ба дунд” түвшин дутагдалтайгаас гадна бие даасан дэд системүүд

зөвхөн бусад дэд системийн өөрт хамааралтай гарцыг чиглэдэг (жишээ нь, төлбөр тооцооны эдийн засаг). Нөгөөтээгүүр Jürgen Habermas (*Facticity and Validity*, 1992) эрх зүйт ардчилсан улс орон (→ улсад)-д ёс суртахууныг Үндсэн хуулийн суурь зарчмуудад шигтгэсэн байдгийг онцолжээ. Эдгээр нь харилцан ойлголцол, олон нийтийн → яриа өрнүүлэх, хамтын амьдралын хэм хэмжээг хянах байдлаар маргаан бүхий → санал зөрөлдөөнийг хэлэлцэн шийдвэрлэх боломжийг олгодог. Эмпирик судалгаагаар иргэд хууль тогтоомжийг сахин биелүүлэх харилцан итгэлцэл ардчиллыг хөгжүүлэхийн зэрэгцээ авлигаас ангид, эдийн засгийн бүтээмжийг нэмэгдүүлдгийг харуулж байна.

Бидний хойч үеийнхэнд ёс суртахууны → нийгэмшил зайлшгүй шаардлагатай. Бихевиорист болон психоаналитик дүн шинжилгээгээр хүүхэд өгөгдсөн хэм хэмжээг шийтгүүлэхээс айсандаа шууд хүлээж авахыг хүмүүжлийн арга барилд идэвхгүй объект гэж үздэг. Харин танин мэдэхүйн хандлага нь хүүхдүүд харилцан үйлчлэлийн туршлагынхаа үндсэн дүрмийг бие даан сэргээх боломжтойг онцолсон (→ Харилцан хамаарал) (Lawrence Kohlberg, *Essays on Moral Development*, Bd. 2: *The Psychology of Moral*, 1984). Бидний өмнөх → үеийнхний хэвшмэл ёс суртахууны сэдэл хэлбэрүүдийн оронд-дасан зохицох хандлага, эсвэл өөрийнхөө эгог давсан хатуу хяналт гэх мэт-одоо цагт ёс суртахууны өөртөө амлалт өгөх сэтгэлгээ давамгайлах болсон (Gertrud Nunner-Winkler, »Ethik

der freiwilligen Selbstbindung», in: *Erwägen – Wissen – Ethik* 14, 2003). Энэхүү шилжилт нь хүмүүжлийн арга барилын өөрчлөлт (эцгийн эрхт ёсноос зөвшилцөлд суурилсан гэр бүлийн бие даасан байдал) болон ёс суртахууны ойлголтын (эрх мэдлийг төвлөрүүлэхийн оронд харилцан ойлголцлыг хүлээн зөвшөөрсөн-хэм хэмжээ бүхий зөвшилцөл) өөрчлөлтөд нийцэж байна.

Gertrud Nunner-Winkler

John Rawls: A Theory of Justice. Cambridge (Mass.) 1971, Nachdr. 2005. – Dt.: Eine Theorie der Gerechtigkeit. Übers. von Hermann Vetter. Frankfurt a. M. 1979, Nachdr. 2003.

Jürgen Habermas: Moralbewußtsein und kommunikatives Handeln. Frankfurt a. M. 1983, 82001.

Walter Herzog: Das moralische Subjekt. Pädagogische Intuition und psychologische Theorie. Bern [u. a.] 1991.

Martin Endreß / Neil Roughley (Hrsg.): Anthropologie und Moral. Philosophische und soziologische Perspektiven. Würzburg 2000.

Leo Montada: Moralische Entwicklung und moralische Sozialisation. In: L. M. / Rolf Oerter (Hrsg.): Entwicklungspsychologie. Weinheim 2000. 5., vollst. überarb. Aufl. 2002. S. 619–647.

Загварууд (Modelle)

Социологийн ойлголтоор “загвар” гэдэг нь ерөнхий нийгмийн үзэгдэл, үйл явцын чухал шинж чанар, холбоо хамаарлыг агуулсан хийсвэрлэл юм. Жишээлэхэд, төгс зах зээлийн загвар эсвэл Max Weber-ийн үйлдлийн хэлбэрүүд байна. Тодорхой утгаараа нийгмийн шинжлэх ухаан, → социологийн хувьд “загвар” нь нийгмийн нөхцөл байдлын талаарх албан ёсны мэдэгдлүүдийн багц юм. Хэрэв онолын таамаглал, мэдэгдлийг зохих албан ёсны хэл рүү хөрвүүлсэн бол үүнийг загвар хэлбэрийн албажуулсан мэдэгдлийн систем гэж нэрлэдэг. Эдгээр нь математикийн загвар эсвэл компьютерын загвар байж болно. Загварууд нь ихэнхдээ нийгмийн үзэгдлийн бодит байдал дээр “цэвэр” хэлбэрээрээ тохиолддоггүй, оюун санааны төсөөллийг илэрхийлдэг. Ийм маягаар танин мэдэхүйн үйл явцад чухал шинж чанаруудыг боловсруулж байдаг бөгөөд энэ нь Max Weber-ийн “идеал хэлбэрүүд”-ийн арга зүйг харуулдагтай адил юм. Тиймээс жишээ нь, “рационал үнэлэмжтэй” үйлдлийн загварыг “рационал зорилготой”-оос нь ялгаж үздэг бол нийгмийн бодит байдал дээр үйлдлийн сэдэл ихэвчлэн холилдсон байдаг. Загварууд норматив шинж чанартай байж болно (→ хэм хэмжээ). “Төгс зах зээлийн” загвар бол эмпирик ажиглалт дээр суурилаагүй, харин неоклассик эдийн засгийн онолын дагуу аль болох бүх боломжийн хүрээнд бодитоор хэрэгжүүлэх *ёстой* идеал гэж үздэг. Үүний эсрэгээр, нийгмийн үзэгдэл, үйл явцыг

тодорхойлох, тайлбарлах, урьдчилан таамаглахад дескриптив загварыг ашигладаг.

Хэлийг албажуулах зорилго нь юуны түрүүнд онолын нарийвчлалдаа байдаг, жишээлбэл, хувьсагчдын хоорондох хамаарлыг нарийвчлан гаргах эсвэл үзэл баримтлалыг яг тодорхой болгох гэх мэт. Үүнээс гадна албаны ёсны хэл нь дедукцийн эсвэл дүгнэлт хийх дүрмийг гаргаж ирдэг. Албажуулсан загвараас математикийн аргаар таамаглал дэвшүүлж болох бөгөөд эндээс ихэвчлэн гайхмаар, шинэ үзэл санааг олж авах боломжтой. Цаашлаад загварын таамаглалуудын нотлогдсон байдал, гаргасан дүгнэлтийн үнэн зөв байдлыг шалгаж болно. Ингэснээр онолын дан амаар хэлэгдсэн хувилбарт танигдаагүй далд таамаглалууд, үр дагаврууд ил гарч ирэх боломжтой юм.

Нийгмийн тархалтын загварт (бүлэгт тархах эсвэл хуваарилах) жишээлбэл, инновац, мэдээ, загварын чиг хандлага хүн амын бүлэгт тархахдаа ихэвчлэн тархалтын үйл явцын өвөрмөц тогтсон хэв маягийг дагадаг. *Логистик тархалтын стандарт загварт* инновац нь хүн амын бүлгийн гишүүдийн хоорондох харилцаа холбооноос хамаарч буюу дуурайх замаар тодорхой халдварлах хэлбэрийн тархалт үүсгэдэг гэж үздэг. Үндсэндээ логистик тархалтын загвар нь хоёр үндсэн таамаглал дээр суурилдаг. (1) Эх олонлогоос төсөөлж болох бүх хосын холбогдох боломж ижил байна (“нэг төрлийн холимог”-ийн таамаглал); (2) Шинэ санаачилгыг нэвтрүүлсэн хүн болон өмнө нь шинийг санаачлаагүй хүмүүс хоорондоо харилцах болгонд

шинийг санаачлагч бус хүн шинийг санаачлагч болох магадлал тогтмол байх бөгөөд бүх хүмүүст адилхан байна. Загварын бүх хувьсагчийг математикийн тэмдэгтээр сольж, тархалтын тэгшитгэлийг гаргавал энэ нь 1 ба 2 дугаар таамаглалын албажсан хэлбэр болох юм. Энэ тэгшитгэлээс шинийг санаачлагчийн өсөлтийн хувь нь шинийг санаачлагч болон шинийг санаачлагч бус хүмүүсийн эзлэх хувиас хамаардаг болохыг харж болох бөгөөд ингэснээр хоёр бүлэг хоорондоо холбогдох магадлал ямар ч үед пропорциональ байна. Тархалтын хурдыг тархалтын үйл явц хэрхэн явагдаж байгааг ажигласны үндсэн дээр статистик ($\rightarrow$ статистик) аргуудыг ашиглан тооцоолж болно. Тархалтын хурдыг эмпирикээр тооцоолж болох үзүүлэлт нь хүн амын бүлэг болон инновацын төрлөөс хамаараад (жишээлбэл, Америкийн тариагчдын дунд шинэ сортын үр тариа тараах тохиолдолд эсвэл сургуулийн нэг ангид мэдээ тараах тохиолдолд) өөр өөр байна. Цаашлах үр дагавар нь шинийг санаачлагч болон шинийг санаачлагч бус хүмүүсийн харьцаа тэнцвэртэй байх үед өсөлтийн хувь хамгийн дээд хэмжээндээ хүрдэг бөгөөд хангалттай урт хугацааны дараа хүн бүр инновацыг нэвтрүүлэх болно (дархлаагүй байдлын үр дүн). Эдгээр үр дүнг эмпирик байдлаар шалгаж, загварын хүчинтэй байдалд зөвлөмж өгч болдог. Бодит байдлыг ихэнхдээ хэт хялбарчилдаг, хатуу таамаглалаас зайлсхийх нь тархалтын янз бүрийн алтернатив цогц загварыг хөгжүүлэхэд түлхэц болдог.

Загвар гаргахад чиглүүлэгч таамаглалууд нь сайндаа л ойртохоор хэмжээнд биелэх идеалчлалыг харуулдаг.

Загварын таамаглал хоорондын зөрүүг хүлээн зөвшөөрөх аргагүй байвал (жишээ нь, загвар нь буруу таамаглал гаргахад хүргэдэг) загвараа зохих хэмжээнд өөрчилж, илүү бодитой таамаглалаар баяжуулах нь зүйтэй.

Хэрэв загвар доторх холбоо хамаарал, харилцан үйлчлэл нь хэт нарийн төвөгтэй бол математик-аналитик аргаар дүгнэлт гаргахад ихэнхдээ боломжгүй болдог. Ийм тохиолдолд компьютерын симуляцийг ашиглана. Өнөөдөр “агентад суурилсан компьютерын симуляцийн” (Nigel Gilbert / Klaus G. Troitzsch, *Simulation for the Social Scientist*, 1999) загвар ихэвчлэн ашиглагдаж байгаа бөгөөд энд → оролцогчид (“агентууд”) нийгмийн орчинд тодорхой дүрмийн дагуу бие биетэйгээ харилцан үйлчлэлд орж байдаг. Энгийн нэг жишээ бол Thomas C. Schelling (*Micro-motives and Macrobehavior*, 1978; → *Rational-Choice-Theorie/рационал сонголтын онол*)-ийн тусгаарлах загвар юм.

Andreas Diekmann

James S. Coleman: *Introduction to Mathematical Sociology*. New York [u. a.] 1964.

Rolf Ziegler: *Theorie und Modell*. München 1972.

Anatol Rapoport: *Mathematische Methoden in den Sozialwissenschaften*. Würzburg/Wien 1980.

Hartmut Esser / Klaus G. Troitzsch (Hrsg.): *Modellierung sozialer Prozesse. Neuere Ansätze und Überlegungen zur soziologischen Theoriebildung*. Bonn 1991.

Andreas Diekmann (Hrsg.): *Methoden der Sozialforschung*. Wiesbaden 2006. [Teil VII.]

Зан төлөв (Verhalten)

Ерөнхий байдлаар “зан төлөв”-ийн онол нь ихэвчлэн амьд биетийн зан төлөвийн хэлбэр, механизмыг тайлбарлахад чиглэгддэг. Нийгмийн шинжлэх ухаанд энэхүү онолууд нь хүний зан төлөвт хамаарах бөгөөд хүний нийгмийн зан харилцаа, үйл ажиллагааг (→ үйлдлийг) онцолдог. Хүн төрөлхийн л байгалиасаа нийгмийн амьтан, *zoon politikon* (Aristoteles) бөгөөд хамтын нийгэмлэгт амьдрахаар зориулагдсан төрөл юм (→ нийгэм).

(Ralf Dahrendorf)-ын *Homo Sociologicus* “нийгэмшсэн хүн” гэдэг нь зүгээр нэг зүйрлэл биш бөгөөд харин хүний амьдралын гол утгыг илэрхийлдэг. Амьтдын ертөнцөд бүлэг үүсэх бөгөөд тухайлбал, хөхтөн амьтад болон шувуудын хувьд өргөн тархсан үзэгдэл. Оцон шувууд колони үүсгэх замаар, чоно сүрэглэн амьдардаг бол заанууд сүрэг үүсгэх гэх мэт. Хүний оршихуйд → бүлэг болж амьдрах нь экологийн тодорхой нөхцөлд амьд үлдэх давуу талтай байдаг. Энэ байдал нь онцгой нөхцөлд өөрийгөө хамгаалах чадвар муутай жижиг амьтад хамаарна (өвсөн тэжээлтэн). Том махчин амьтад (Цагаан баавгай, бар гэх мэт) ганцаар амьдардаг. Учир нь тэд өөрт байгаа нөөцийг илүү сайн ашиглах боломжтой болдог, харин хувь хүний хувьд бүлгээр амьдрах нь илүү хамгаалалтыг өгдөг. Нийтээрээ хүнсээ хангах асуудал дээр давуу талтай юм. Энэ нь нийгмийн харилцаанд суралцахад хялбар болгодог. Залуу амьтад бүлгээр өсөх нь насанд хүрсэн амьтадаас амьд үлдэх

стратегид суралцах боломж олгодог аж. Энгийнээр хэлбэл, бүлэг үүсгэж, нийгэмшин амьдрах нь үр дүнтэй гэсэн үг юм. Edward O. Wilson (*Sociobiology: The New Synthesis*, 1975) нь орчин үеийн социол-биологид амьд амьтдын оршихуй нөхцөлд (хүнийг үүнд хамруулан) нийгмийн зан төлөвийг хувьслын болон генетикийн үзэл баримтлалаар тайлбарласан. Энэ нь бодит байдал дээр нотлогдсон таамаглалд суурилах бөгөөд нийгмийн янз бүрийн, заримдаа маш нарийн төвөгтэй зан төлөвийн төрөл нь генетикийн үндэслэлтэй, амьд үлдэх давуу талыг авчирдаг байна. Түүний онолын үндэс нь биологийн хувьслын онолд суурилах ба бүр нарийвчлан тодруулбал, → хувьслын онолын байгалийн шалгарал эсвэл ялгарлаар үүсдэг. Энэ онолын дагуу нийгмийн зан төлөвийн хэв маяг нь олон зүйлд урт хугацааны туршид нотлогдсон байх бөгөөд энэ нь ялгаралтын явцаар бий болдог. Зан төлөвийн судалгааны чиглэл нь социол-биологийн салбар. Уг салбар нь XVIII, XIX зууны өмнөх үед, зарим нэг хэсэг нь антикийн үеэс эхлэлтэй хэдий ч XX зуунд бие даасан шинжлэх ухааны нэг болж, өргөн цар хүрээнд антропологи, сэтгэл зүй, социологийг хамруулан хөгжсөн. 1960-аад он хүртэл (мөн дараа нь сэтгэл судлал, социологийн салбарт ч) бихевиоризм нь зан төлөвийн онолыг тодорхойлж байсан. John B. Watson-ны (*Behaviorism*, 1924) нөлөөн дор Burrhus F. Skinner (*The Behavior of Organisms*, 1938) хүн болон амьтдын зан төлөвийн хөдлөгч хүч нь төрмөл биш, өгөгдсөн дотоод нөхцөлийн улмаас биш хэмээн үзэж, “зан төлөвт хүн суралцах боломжтой” гэсэн өргөн

агуулгатай таамаглал дэвшүүлсэн. Тиймээс → хувь хүн бүр төрхдөө “*tabula rasa*” буюу хоосон самбар бөгөөд энэ самбар нь хүрээлэн буй орчны нөлөөллөөр (өөрөөр хэлбэл, эцсийн эцэст суралцах замаар) тодорхойлогддог байна. Зохистой мэт санагдсан энэхүү таамаглал нь үзэл баримтлалын хувьд “орчин цагийн хүмүүс”-ийн хүрээнд сонирхол татсан байдлаар найдвар төрүүлж, үүгээр зан төлөвийн харьцуулсан судалгааны эсвэл этнологийн цуврал судалгааны эсрэг байр суурийг илэрхийлж байв. Энэ эсрэг байр суурь нь төрөлхийн зан төлөвийн шинж чанар юм. Аль ч төрлийн амьтан төрлөхийн хоосон цаас мэт байдаггүй, харин өөрсдөө тус бүр өөрийн онцлог шинжтэй, хувьслын явцад байгалийн шалгарлын замаар хөгжүүлсэн, ертөнцөөс өвлөгдсөн чанаруудтай. Эдгээр нь түүний зан төлөвийг нарийвчлан тодорхойлдоггүй, харин түүнд маш ихээр нөлөөлж байдаг (Irenäus Eibl-Eibesfeldt, *Die Biologie des menschlichen Verhaltens. Grundriß der Humanethologie*, 1984).

Хувь хүний суралцахын утга учир нь тухайлбал төрөлхийн зан төлөвийг өөрчлөх, үүний ач холбогдол этнологи судлаачдын (зан төлөвийн судлаачид) дунд маргаан дагуулсан хэвээр байна. Гэхдээ мөн (хувь хүний) суралцах нь төрөл зүйлийн хувьд өвөрмөц хязгаартай байдаг бөгөөд хүн өөрийн байгалийн төрөлх мөн чанарыг зүгээр л даван туулж, устгаж чадахгүй гэдэг нь маргаангүй юм. Социологийн зан төлөвт суралцах онолд бихевиоризм нь явцуу утгаараа хүчтэй нөлөөлсөн тул энэхүү ойлголт нийгмийн шинжлэх

ухаанд аажмаар газар авч байна. Эдгээр шалтгааны нэг үндэслэл бол зан төлөвийг өмнөх шигээ үргэлж биологийн онолын детерминист онол гэж буруугаар ойлгодогт байна. Социологи дахь зан төлөвийн онол иж бүрэн байх утгаараа янз бүрийн салбарын онолын урсгал, эмпирик судалгааны үр дүнг нэгтгэхэд чиглэсэн. Arnold Gehlen (*Der Mensch. Seine Natur und seine Stellung in der Welt*, 1940) болон Helmuth Plessner (*Die Stufen des Organischen und der Mensch. Einleitung in die philosophische Anthropologie*, 1928) нарын бүтээлд иж бүрэн арга зүйг олж болно. Тэд хүний байгалиас өгөгдөлтэй онцгой чанарыг онцолсон хэвээр байгаа бөгөөд антропологи, зан төлөвийн судалгааны сүүлийн үеийн үр дүнгээс тэдний дэвшүүлсэн санааг харгалзах шаардлагатай юм.

Franz M. Wuketits

Konrad Lorenz: Über tierisches und menschliches Verhalten. Aus dem Werdegang der Verhaltenslehre. München 1965, Neuausg. 1988.

Karl-Dieter Opp: Verhaltenstheoretische Soziologie. Eine neue soziologische Forschungsrichtung. Reinbek 1972.

Peter Meyer: Soziobiologie und Soziologie. Eine Einführung in die biologischen Voraussetzungen sozialen Handelns. Darmstadt/Neuwied 1982.

Franz M. Wuketits: Die Entdeckung des Verhaltens. Eine Geschichte der Verhaltensforschung. Darmstadt 1995.

- Was ist Soziobiologie? München 2002.

Зан үйл (Ritual)

Зан үйл буюу зан үйл болсон → үйлдлүүд нь бэлгэдлийн, албан ёсны шинжтэй байх ба хэвшин тогтсон давтамж бүхий жүжигчилсэн → бүтэцтэй, энгийн → харилцаанаас ялгарах өгүүлэмжийн хэлбэртэй нийгмийн → харилцааны онцгой хэв шинж юм. Энэ нь хувь хүн, нийгэм, соёлын → ижилсэх хандлагыг бүрдүүлэхэд буюу амьдралын арга барил, нийгмийн байр суурийг бусдаас тусгаарлах, тодотгох, ялгахад нөлөө үзүүлдэг байна (→ өдөр тутам, ялгарал). Эдгээрт нийгэм соёлын гол агуулга (→ бэлгэдэл, хамтарсан төлөөлөл), парадигматик зан харилцааны хэлбэрүүд (үйлдлийн хэв маяг, бүрэлдэхүүн хэсэг) нь өргөжиж, илэрхийлэгдэж, баталгаажиж, шинэчлэгдэж байдаг.

Саяхныг хүртэл “зан үйл” нь сэтгэл судлал, шашин судлал, угсаатны зүй зэрэг төрөлжсөн салбаруудын судлагдахуун болдог байсан. Нийгэмд зан үйлийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрдөг хэдий ч энэ сэдэв нийгмийн онолын уламжлалд чухал байр суурийг эзэлдэггүй байв. Анх Ronald Grimes-ийн “Зан үйл судлалын эхлэл” (*Beginnings in Ritual Studies*, 1982) судалгаа болон “Зан үйл судлалын сэтгүүл” (*Journal of Ritual Studies*, 1987) онд гарч ирсний дараа л зан үйлийн талаарх шинэ сонирхол нийт хүн төрөлхтний шинж чанартай бөгөөд зан үйлийн судалгааны хүрээнд нийгмийн харилцааны үндсэн ойлголт болж хөгжсөн.

Зан үйлийг албадлагын, рационал бус шинжтэй эсвэл тусгай шашны үйлдлүүд гэж үздэг байсан уламжлалт

дүр зургаас ялгаатайгаар судалсан анхдагчдын дотроос Erving Goffmann (*Interaction Ritual*, 1967, dt. 1971), Clifford Geertz (*The Interpretation of Cultures*, 1973, dt. 1983), Mary Douglas (*Natural Symbols*, 1970, dt. 1974) und Victor W. Turner (*The Ritual Process*, 1977, dt. 1989)–цаашлаад тэдний залгамж халаа болсон Catherine Bell (*Ritual Theory, Ritual Practice*, 1992) болон Roy A. Rappaport (*Ritual and Religion in the Making of Humanity*, 1999) зэрэг судлаачид “зан үйл”-ийн талаар илүү өөр ойлголтыг бий болгож чадсан юм. Эндээс харахад зан үйл нь зүгээр нэг сүм хийд эсвэл тусгайлан бий болгосон шүтлэгийн өрөөнд болдог шашны үйлдэл биш, харин хүн төрөлхтний нийгмийг бүтээн босгох, хадгалахад чухал үүрэг гүйцэтгэдэг нийгмийн харилцааны хэлбэрүүд юм. Тэд нийгмийн болон хувь хүний амьдралын бүхий л салбарт ил, далд хэлбэрээр нийгмийн хамтын ажиллагаа, харилцан ойлголцолд дагалдаж, нөлөөлж байдаг.

Зан үйл, зан үйл болсон үйлдлийн ач холбогдол нь алт эрт Émile Durkheim (*Les formes élémentaires de la vie religieuse*, 1912, dt. 1981)-д танигдсан байсан бөгөөд энэ нь ялангуяа бүлэг бүрдүүлэх (→ бүлэг), ижилсэх байдлыг тодорхойлох, үүрэг солигдоход энгийн бөгөөд шууд нөлөөтэй хэлбэрүүдийн хэрэгцээ маш өндөр байдаг болохоор олон үндэстний нийгэмд илүү тодорхой харагддаг. Зан үйл, зан үйл болсон үйлдлүүд нь нийгмийн цогц байдлыг шийдвэрлэх хүчирхэг хэрэгсэл болдог. Ёс заншил бол хязгаарыг тогтоож, биечилсэн харилцаагаар дамжин харилцан ойлголцлыг

бий болгодог. Энэ нь яг одоо хэн хаана байх, юу хийх эсвэл хийхгүй байх ёстойд, мөн нийгмийн харилцааны аль хүрээ тухайн тохиолдолд хамаатай болоход дохио өгдөг. Зан үйл нь байгууллагын ижилсэх төрөл “*Corporate Identity*” (жишээлбэл, компанийн өөрийгөө тодорхойлох имиж)-өөс авхуулаад дэд соёлд хамаарах анхаарал татахуйц шинж чанаруудыг хүртэлх нийгмийн үйл явдлын хүрээний талаарх шийдвэрлэх мэдээг дамжуулдаг.

Bell зан үйл болсон өдөр тутмын амьдралын үйлдлүүдийг эн тэргүүнд авч үзэж байв. Зан үйл болно гэдэг нь тодорхой нэг үйлдлийн гүйцэтгэх функцийг чухалчлан дурдаж, онцлон тэмдэглэснээр ердийн үйлдлээс ялгаж өгч байгаа явдал. Энэ нь эдгээр онцгой үйлдлүүдийг хэрэгжүүлэхийн тулд өдөр тутмын амьдралын үйл ажиллагаанаас тодорч гарч ирэх онцгой → “оролцогч” эсвэл ижилсэх хандлагыг мөн бий болгодог. Зан үйл болсон үйлдэл нь иймэрхүү оролцогчид, оролцогчдын байр суурь шинэчлэгдэж, баталгаажуулдаг байхаар нийгмийн → бодит байдлыг бүтцийн хувьд зохион байгуулах функцтэй байдаг. Хэрэв жишээ нь, багш ангийнхны өмнө гарч ирээд онцгойлон ярьж, тусгайлан “зааж” байвал тэрээр өөрийгөө багш гэдгээ илэрхийлэхийн тулд үүнийг хийж байгаа юм; Сурагчид үүнийг нь хүлээн авч, зохих ёсоор хандана. Хичээл заах зан үйл болсон энэ үзэгдэл нь сургалтын нөхцөл байдлын талаарх нийгмийн бодит байдлыг бүтээж байдаг.

Зан үйл болсон үйлдэл нь хамтын төлөөлөл, хувь

хүн, нийгэм, соёлын ижилсэх хандлагыг бий болгож, үнэ цэн, авторитет, үнэний илэрхийлэл болж байдаг. Нэмж дурдахад, зан үйл болсон үйлдлээр дамжуулан нийгмийн → зөрчилдөөн виртуал түвшинд явагдан, шийдэгдэж байна. Үүнд хүчирхийлэл (→ эрх мэдэл)-ийг өөрчлөх, чиглүүлэх гэсэн агуулга ч багтаж байгаа. Эцэст нь зан үйл болсон үйлдэл бол даган дуурайх байдлаар хэвшүүлж болдог нийгмийн дэг журмын загварыг харуулж байгаа юм.

Andréa Belliger / David J. Krieger

Andréa Belliger / David J. Krieger (Hrsg.): Ritualtheorien. Ein einführendes Handbuch. Opladen [u. a.] 1998, ³2006.
 Alfred Schäfer / Michael Wimmer (Hrsg.): Rituale und Ritualisierungen. Opladen 1998.

Зөв (Recht)

“Зөв” гэдэг нь “зөв”, “буруу”-гийн ялгааны тусламжтайгаар үйл явдал, бодит баримт, → үйлдэл, эс үйлдлийг үнэлэх зорилготой, улам ихээр үндэсний, европын эсвэл олон улсын шүүхээс “зөв” гэж үзэх бүхий л дүрмүүдийг нэрлэдэг. “Дүрэм”-ээс гадна “дэг журам” эсвэл → “хэм хэмжээ”-г ерөнхий нэр томьёо болгон тодорхойлолтод ашигладаг. “Зөв”, “буруу”-гийн ялгааг ашигласнаар, зөв гэж юу болох эцсийн шийдвэрийг шүүх гаргах учраас “зөв” нь бусад схемээс, тухайлбал, “заншил” эсвэл → “ёс

суртахуун”-аас ялгаатай. Niklas Luhmann-ы системийн онолын (→ систем) үүднээс “зөв” өөрөө юуг хязгаарлахыг тодорхойлж, [...] зөвд юу хамаарч, юу хамаарахгүй (Das Recht der Gesellschaft, 1993) байх нь үйлдлийн социологийн хувьд хангалтгүй. Энэ нь эрх зүйн социологийн ажиглагчийн нэгэн адил “зөв”-д чиглэхийг хүсэж байгаа → хэнд ч тус болохгүй. → Орчин үед зөвийн агуулга, хязгаар нь тодорхойгүй, хоёрдмол утгатай: үүнээс гадна байнгын улс төрийн хөдөлгөөн, динамик үр дүн нь нэг нэгэндээ харилцан үйлчилдэг. Зөвийн тухай ойлголт нь үйл ажиллагааг чиглүүлэхийн тулд үүнийг тодорхой зааж өгөх ёстой. Зөвийн хил хязгаар, агуулга, чадамжийг тодорхойлохын тулд олон зүйлс, төрийн институциас эхлээд эрх зүйн шинжлэх ухаан, иргэн хүртэл шаарддаг. Ихэнх тохойлдолд зөв нь зөвийн талаарх өөрийн үзэл бодлоо илэрхийлэхийн төлөө тэмцэх хүсэлтэй хүмүүсийн санаачилгаар оршдог. Тэдэнд зөвийн тухай зөв гэсэн эцсийн шийдвэр гарах эрх байхгүй, харин энэ эрх нь улсын шүүхэд байдаг. Тухайн улс нь нутаг дэвсгэрийн хүрээндээ зөвийн тухай чадамжийг шаардах бөгөөд тэдгээрийг “үндсэндээ практик байдал”-д хэрэгжүүлдэг (Klaus F. Röhl, Rechtssoziologie, 1987). Тэд мөн онцгой эрхтэй зөвийн тухай шийдвэрийг гүйцэтгэдэг. Тэдний шийдвэрийг энгийнээр ажиглах боломжтой, мэргэжлийн бус хүмүүсээс эхлэн нарийн мэргэжлийн экспертүүд, тухайлбал, эрх зүйн шинжлэх ухаан, хуулийн өмгөөлөгч, холбоодууд, улс төрийн намууд гэх мэт байгууллага байнгын системтэйгээр ажиглаж байдаг. Тиймээс эрх зүйн социологиос гадна эрх зүйн шинжлэх ухааны

хөрш салбаруудад “зөв”-ийн тодорхойлолт нь шүүх дээр төвлөрч байгааг нийтээрээ хүлээн зөвшөөрдөг. Эрх зүйн социологийн судалгааны сонирхол нь гурван чиглэлээр тодорхойлогддог: Энэ нь (1) “зөв байхын тухай асуух бөгөөд орчин үеийн эрх зүйн онцлог шинжээр → нийгэмд “зөв байх ойлголтыг” төлөвшүүлэх аппарат, instansi, мэргэжлүүд, үйл явц, үзэл санаа болон сонирхлын талаар асуудаг. Тэрээр (2) “зөв”-ийг хамааралтай хувьсагчаар тодорхойлж, түүний нийгмийн нөхцөл байдал дахь үүслийн талаар асуудаг. Эсвэл тэрээр “зөв” (3) -ийг хамааралгүй хувьсагчаар тодорхойлж, зөв байх ойлголтын гадаад болон дотоод орчны үр дагаварт анхаарал хандуулдаг. “Зөв байх” тухай ойлголтын асуулт нь хуулийн мэргэжлийн судалгааны үндсэн чиглэлийг бүрдүүлдэг бөгөөд энд шүүгч чухал үүрэгтэй. Max Weber (*Wirtschaft und Gesellschaft. Grundriß der verstehenden Soziologie*, 1922) аль хэдийн бүтээлдээ, хэрэглээнд дадал болсон зөвийг сахиулах дүр зураг хэрхэн “хааны шүүгч”-д ханддаг болсныг тэмдэглэсэн. Шүүгчид энэ чиглэлд улам цааш явах тусам шүүгчийн хараат бус байдал, хуулийн өмнө эрх тэгш байх асуудал улам бүр шүүгчийн бодит цалингийн асуудал болж байна. Шүүгчийн хараат бус үйл ажиллагаа нь хувь хүний хүсэл сонирхол, институцийн хязгаарлалт, гаднын дарамтаас хамааралтай болох нь Веймарын Бүгд Найрамдах Улс, Үндэсний Социализмын болон дараах олон судалгаагаар мөн адил нотлогдсон (Dieter Simon, *Die Unabhängigkeit des Richters*, 1975; Martin Morlock [u. a.], »Recht als soziale Praxis«, in: *Rechtstheorie* 31, 2000). Зөв өөрөө зөв байх шаардлагыг

баталгаажуулахад рационал үндэслэл, тодорхой журмын тусламж шаардлагатай юм. Зөв байх тухай ойлголтын онцлог шинж энд харагдаж байна. Хүчин төгөлдөр байх шаардлага нь эмпирик хүчин зүйлсэд хамаарах бөгөөд энэ нь зөв байх тухай ойлголтын гадна байх талтай, тухайлбал, ашиг сонирхол, хүчин төгөлдөр гэдэгт итгэх итгэл, хамаарал бүхий этгээдийн дагаж мөрдөх хүсэл эрмэлзэл гэх мэт. Үүсэл хөгжлийн асуудалтай холбогдуулан эрх зүйн социологи нь улс төрийн эрх зүйтэй өрсөлдөж байна. Судалгааны хүрээнд парламент нь бага ач холбогдолтой, лобби бүлгүүд, холбоод, улс төрийн нам, байнгын хороод болон захиргааны бюрократ бүтцийн байр суурь хүчтэй нөлөөтэй гэдэг нь батлагдсан (Klaus von Beyme, *Der Gesetzgeber*, 1997; Rüdiger Voigt, *Recht – Spielball der Politik?*, 2000). Эрх мэдлийн хуваарилалтаас эрх мэдлийн зангилаа үүсэж байна. Хууль батлах асуудалд хувь иргэний нөлөө нэмэгдэж байна. Германы стандартчиллын институци зэрэг стандартын эрх зүйн лавлагаагаар дамжуулан хувийн эрх зүй нь төрийн хууль болж байна (тухайлбал, ДОХ-ийн хамгаалалттай бээлий “AIDS-Handschuhe” Hans Albrecht Hesse, *Der Schutzstaat*, 1994). Иймэрхүү болон бусад байдлаар “ардчилал дахь амьдралд” ардчиллын онол, хууль дээдлэх ёс болон практик байдлын хооронд ялгаа байнга нэмэгдэж байна. Эрх зүйн нөлөөллийн тухай асуудалд эрх зүйн социологи нь захиргааны шинжлэх ухаантай өрсөлдөж байна. Энд улс төрийн ашиг сонирхол хамгийн их, тийм ч утгаараа санхүүгийн дэмжлэг хамгийн хүчтэй байдаг. Эрх зүй үр нөлөөтэй байх боломжийг үнэлэх тал дээр өөдрөгөөр

чиглүүлэх асуудал гутранги үзэлтэй өрсөлдөж байна. хоёуланд нь эмпирик нотолгоо байдаг. Үүний зэрэгцээ төрийн үүрэг (→ төр), чиглүүлэх оролдлого, зарим нь дотроосоо, зарим нь гаднаас үүдэлтэй удирдан чиглүүлэх асуудлууд нэмэгдсээр байна. Олон улсын улс төрийн харилцан хамаарал нэмэгдэн сүлжилдэх хэрээр чиглүүлэх үүрэгтэй байгууллагын тоо нэмэгдэж, улмаар удирдан чиглүүлэх асуудал үүсэж байна. Асуудлууд ихэвчлэн хүлээн авагч этгээдийн ялгаатай сонголтоор шийддэг.

Hans Albrecht Hesse

Erhard Blankenburg (Hrsg.): Empirische Rechtssoziologie. München 1975.

Manfred Rehbinder: Rechtssoziologie. Berlin [u. a.] 1977, 52003.

Thomas Raiser: Das lebende Recht. Baden-Baden 31999.

Hans Albrecht Hesse: Einführung in die Rechtssoziologie. Wiesbaden 2004.

Зөрчил (Konflikte)

“Зөрчил” (латинаар *confligere* = “мөргөлдөх”, “цохих”, гэхдээ бас “барьцалдахдаа тулах”, “маргаантай байх”) гэдгийг дор хаяж хоёр тал (→ хувь хүмүүс, → бүлгүүд, → улсууд гэх мэт) оролцсон зөрчилтэй талуудын нийгмийн нөхцөл байдлын ялгаанаас болон/эсвэл

ашиг сонирхлын байр суурийн ялгаатай байдлаас үүдсэн нийгмийн үйл хэргийн уг чанар гэж тодорхойлж болно. Энэхүү тодорхойлолт нь зөрчилдөөний тухай ойлголтыг бодитой болгохгүй, зөрчилдөөний тайлбар, үнэлгээг хольж хутгаагүй гэдгээрээ давуу талтай.

Нийгмийн зөрчилдөөн нь → нийгмийн бүх хэлбэр, төрөлд үндсэн шинж болдог. Энэ талаарх сэтгэлгээ улс төрийн философийн эхэн үеэс эхлэлтэй. Niccolò Machiavelli, Thomas Hobbes, Charles Darwin нарыг зөрчилдөөний талаарх орчин үеийн сэтгэлгээний гол төлөөлөгчид гэж үздэг. Karl Marx, Max Weber, Georg Simmel нарын зөрчилдөөний онолын сонгодог үндэслэлд байгалийн учир шалтгаанаар тайлбарлахаа больж нийгмийн онолын үүднээс аргумент гаргаж мэтгэлцсэн байдаг.

Für Marx (*Manifest der kommunistischen Partei*, 1848)-ын хувьд түүх нь ангийн тэмцлийн цувралаас бүрддэг (→ материалист нийгмийн онол, анги). Түүнийхээр бол зөрчилдөөн нь нийгмийн баялгийн тэгш бус хуваарилалт (→ тэгш бус байдал)-д хүргэдэг нийгмийн босоо бүтэц, шаталсан нийгмийн бүтцээс үүдэлтэй. Энэ үүднээс авч үзвэл зөрчил нь үргэлж ашиг сонирхлын зөрчил байх хэдий ч үүний зэрэгцээ засаглалын шударга бус харилцааг (→ ноёрхол) өөрчлөх хэрэгсэл буюу туслах арга юм. Зөрчилдөөн нь бүтцийн гажуудал дээр суурилах тул нийгмийн хөгжлийн хөдөлгүүр нь болдог. Weber (*Wirtschaft und Gesellschaft. Grundriß der verstehenden Soziologie*, 1922; *Gesammelte Aufsätze zur Religionssoziologie*, 3 Bde., 1920/21)-ийн хувьд үүний эсрэгээр

нийгмийн хэвтээ чиглэлийн → ялгаралд анхаарлаа хандуулдаг. Зөрчилдөөний үйл явц ингэснээр илүү нээлттэй болж байна. Түүний хувьд ертөнцийг үзэх үзлийг рационал болгох явцад үйл ажиллагааны заавал биелүүлэх чиглэлийг (→ үйл ажиллагаа) алдагдуулах нь → үнэ цэний олон ургалч үзэлд, политеизмд, орчин үеийн утга (→ утга учир) алдагдахад хүргэдэг бөгөөд өөр өөр үнэт зүйлс, үнэ цэний хүрээллийн хооронд зөрчилдөөнийг зайлшгүй өдөөж байдаг. Зөрчилдөөн бол нийгмийн шинэчлэл, рационал соёлын зайлшгүй илэрхийлэл. Weber зөрчилдөөнийг нийгмийн харилцааны нэг хэлбэр гэж ойлгож эрх мэдлийг социологийн үүднээс авч үзсэнээрээ зөрчилдөөний онолын сэтгэлгээнд нэгэн шинэ талбарыг нээсэн юм. Нөгөө талаас, Simmels («Der Streit», in: G. S., *Soziologie. Untersuchungen über die Formen der Vergesellschaftung*, 1908)-ийн гавьяа нь зөрчилт харилцааны албан ёсны шинж чанаруудыг судалгааныхаа сэдэв болгосон явдал. Simmel-ийн хувьд зөрчилдөөнийг зөвхөн нийгмийн бүтцийн зайлшгүй үр дүн төдийгүй бие даасан судалгаа хийх шаардлагатай нийгмийн үйл явцын гол бүрэлдэхүүн гэж үзэж байв. Түүнийхээр зөрчил нь хувь хүний үүднээс нийгмийн харьяаллын ялгарлаас үүсдэг. Гэсэн хэдий ч түүний зөрчилдөөний социологийн онцлог нь зөрчилдөөн өөрөө нийгэмшүүлэх нэг хэлбэр болдог бөгөөд нийгмийн бүлгүүдийн → интеграцчиллыг дэмждэг гэдэг нотолгоонд оршиж байгаа юм.

Зөрчилдөөний онол нь дэлхийн II дайны дараа л социологийн бие даасан парадигм болж чадсан

Randall Collins (*Three Sociological Traditions*, 1985). Ялангуяа Ralf Dahrendorf (*Gesellschaft und Freiheit*, 1961) Talcott Parsons-ын зөвшилцөл, дэг журам, тогтвортой байдал, интеграцид суурилсан бүтцийн функционализм (→ функционализм)-тай зөрчилдөж байв. Зөрчилдөөнийг эмгэг үзэгдэл гэж үнэлэхийн эсрэг Dahrendorf нийгмийн зөрчилдөөний ач холбогдлыг нээлттэй нийгэм, тэдгээрийн дэвшилтэт → өөрчлөлт хэмээн дэмжиж байв. Тэрээр зөрчилдөөнийг тайлбарлах олон талбарт матрицад нийгмийн таван нэгжийг (→ үүрэг, бүлэг, салбар, нийгэм, нийгмүүдийн хоорондох холбоо) хуваан авч үзээд, боломжит зөрчилдөөний төрлүүдийг ялгахын тулд тэдгээрийг янз бүрийн түвшинд (тэнцүү ба тэнцүү, дээд ба доод, бүхэл ба хэсэг) холбож үзсэн. Хожим нь тэрээр орчин үеийн нийгмийн зөрчилдөөнийг эрх ба нийлүүлэлт, → улс төр ба → эдийн засаг, иргэний эрх ба эдийн засгийн өсөлтийн антагонизм гэж дүгнэж, түүнээс урган гарах зөрчилдөөний магадлалыг хүний амьдралын боломжуудтай холбон тайлбарлахдаа эрх мэдэл, засаглалын бүтцийн ач холбогдлыг онцлон тэмдэглэж байсан (*Der moderne soziale Konflikt*, 1994). Үүний эсрэг байр сууриар Lewis A. Coser (*The Functions of Social Conflict*, 1956, dt. 1965) функционалист үзлийн хүрээнд Simmel-ийг мөрдлөг болгон нийгмийн зөрчилдөөний эерэг талуудыг олж тогтоохыг оролдож байв. Тогтвортой байдал, зөрчилдөөн хоёр нь эсрэгцэл байх албагүй. Coser функциональ ба функциональ бус, жинхэнэ ба жинхэнэ биш зөрчилдөөнийг ялгааг гаргасан байдаг.

Орчин үеийн нийгэмд зөрчилдөөн эерэг үүрэгтэй болох нь өнөөдөр маргаангүй юм. Нийгмийн зөрчилдөөн орчин үеийн социологийн онолын салшгүй хэсэг болдог. Зөрчилдөөний тухай ойлголтыг олон талаас нь судалж, эрх мэдлийн болон засаглалын харилцаа, нийгмийн → тэгш бус байдал, ижилсэл эсвэл амьдралын хэв маягтай холбон авч үздэг. Үүний дагуу нийгмийн зөрчилдөөний маш олон янзын сэдэв байж болох бөгөөд тухайлбал, хуваарилалтын, эрх мэдлийн, хүлээн зөвшөөрүүлэх эсвэл хууль эрх зүйн зөрчилдөөнүүд үүсдэг. Нийгмийн зөрчилдөөний динамик нь тухайн зөрчилдөөнтэй судлагдахуун хуваагдах буюу институциэс хуваагдах эсэхээс, эсвэл *Cross-Cutting-Conflicts* (салбар хоорондын зөрчил) байгаа эсэхээс хамаарна. Тиймээс зөрчилдөөний бодитой дүн шинжилгээ нь зөвхөн зөрчилдөөний сэдвийг төдийгүй зөрчилдөөний түүх, зөрчилдөөний шалтгаан, зөрчилдөөнтэй талуудын хэлбэр, тоо, зөрчилдөөний тодорхой шийдвэрлэлт, зөрчилдөөнийг шийдвэрлэх хэлбэрүүдийг судалдаг.

Peter Imbusch

Bernhard Giesen: Die Konflikttheorie. In: Günter Endruweit (Hrsg.): Moderne Theorien der Soziologie. Stuttgart 1993. S. 87–134.

Thorsten Bonacker (Hrsg.): Sozialwissenschaftliche Konflikttheorien. Opladen 2002, ³2005.

Ansgar Thiel: Soziale Konflikte. Bielefeld 2003.

Hans Joas / Wolfgang Knöbl: Sozialtheorie. Zwanzig ein-führende Vorlesungen. Frankfurt a. M. 2004. S. 251–283.
 Peter Imbusch: Sozialwissenschaftliche Konflikttheorien, in: P. I. / Ralf Zoll (Hrsg.): Friedens- und Konfliktforschung. Wiesbaden ⁴2006. S. 143–178.

Идеологи (Ideologie)

“Идеологи” (францаар *идеологи* = *idéologie*) нь шууд утгаараа → үзэл бодлын шинжлэх ухааныг хэлдэг. Нийгмийн онолд энэ ойлголт нь бодол санаа, итгэл үнэмшил, сэтгэл мэдрэхүйн агуулгыг нийгмийн бүтцэд хамааруулан тайлбарлах, тодорхой болгохыг зорьдог. Идеологи нь нийгмийн бодит байдлыг үндсэнд нь буруу дүгнэх явдлыг таниулж өгдөг буюу одоо байгаа дэг журмыг тогтворжуулах, үйлдэл хийх чадварт нөлөөлж буй ертөнцийг үзэх үзлийн харах өнцгийн хязгаарлалтыг харуулдаг. Үнэн байдал, объектив харах өнцөг, төвийг сахисан байдал нь үүгээр идеологийн ил буюу далд эсрэг туйлыг бүрдүүлдэг.

Karl Mannheim (*Ideologie und Utopie*, 1929)-ын хувьд идеологи гэдэг ойлголт нь аливаа мэдлэгийн нийгмийн “оршихуйтай холбогдох байдал”-ыг тогтоох ерөнхий мэдлэгийн социологид хамаарагддаг. Тиймээс идеологийн “хамаг” эргэлзээ нийгмийн мэдлэгийн бүх хэлбэрт тархсан. Niklas Luhmann (*Soziologische Aufklärung I*, 1970) харах өнцгийг идеологийн үүднээс хязгаарлах нь аливаа рационал үйлдэлд (→ үйлдэл)

хамаарах ерөнхий нөхцөл гэж үзэж байв. Идеологийн талаарх эдгээр төвийг сахисан тодорхойлолтуудтай харьцуулахад энэ нэр томьёоны түүх нь голчлон → эрх мэдэл, ноёрхлын хэлбэр (→ ноёрхол)-ийг шүүмжилсэн тодорхой харилцаагаар илэрдэг. Идеологийн шинжилгээ нь эрх мэдлийн харилцааг дэмждэг сэтгэлгээний тогтолцоог задлах зорилготой юм. Идеологи гэдэг нэр томьёог Antoine Louis Claude Destutt de Tracy (*Éléments d'idéologie*, 5 Bde., 1801–15) гаргаж байсан хэдий ч анх Karl Marx болон Friedrich Engels нарын бичвэрээр дамжин нийгмийн онолын утгыг олж авсан байдаг. Marx бүх зүйлийг урвуугаар нь харагдуулдаг *camera obscura*⁷-тай идеологийг зүйрлэж байв (*Die deutsche Ideologie*, 1845/46). Marx-ын шүүмжлэлийн дагуу → нийгмийг үйлдвэрлэл болон ангийн эсрэгцэл талаас нь ойлгохын оронд чөлөөт солилцоо, улс төрийн эрхэмжит зүйлсийн талаар бодох нь нийгмийн идеологийн тухай ойлголтын эхлэл болно (→ материалист нийгмийн онол, капитал). Marx өмнөх бичвэрүүддээ идеологийн “хуурмаг ертөнц”-ийг ангийн бүтэц, хөдөлмөрийн хуваарилалтаас эх үүсвэртэй гэдэг байсан бол хожмын текстүүддээ солилцооны бүтцэд гол анхаарлаа хандуулсан байдаг (*Das Kapital*, Bd. 1, 1867). Marx-ын хэлснээр, энэ бүтэц нь юмсын өгөгдсөн ертөнцөд болоод түүний зах зээлийн үнэ цэнд хадгалагдсан хэвээр байх фетишист харилцааг нийгэмд

7 Энэ нь харанхуй өрөө гэсэн утгатай латин үг. Жижиг нүхээр харанхуй өрөө рүү туссан гэрлийн тусгал урвуугаа харсан дүрс үүсгэхийг хүний ойлголтыг зүйрлэхэд ашиглахаас гадна гэрэл зургийн үндсэн зарчмыг үүгээр нээсэн байдаг: https://de.wikipedia.org/wiki/Camera_obscura

бий болгодог (барааны фетишизм⁸).

Үүнтэй уялдуулаад → шүүмжлэлийн онолын төлөөлөгчид орчин үеийн сэтгэлгээний идеологийн шинж чанарыг зөвхөн эдийн засгийн хувьд тооцоолж, техникийн ур чадварт чиглэсэн, одоо байгаа нийгэмд шүүмжлэлт орон зай байхгүй ухамсрын төлөвт явагдагийг олж харсан. Харин Antonio Gramsci (*Quaderni del carcere*, 1975, dt. 1991)-ын хувьд идеологийн тухай ойлголт нь нийгмийн ангиудын хооронд улс төрийн зөрчилдөөний тодорхой харилцааг хадгалж байдаг зүйл юм. Тэрээр Марх-ын идеологийг эдийн засгаас гаргаж болох хуурмаг ертөнц гэж тодорхойлсныг шүүмжилж байсан. Үүний оронд тэрээр “хүмүүсийн зүрх, тархи”-ны төлөөх тэмцлийг улс төр-нийгмийн динамикийн бие даасан үзүүлэлт гэж үзсэн. Тиймээс Gramsci нийгмийн зөвшилцлийг бий болгох талаас дүн шинжилгээ хийхдээ идеологиос илүү “манлайлал”-ын тухай ярьсан. Мөн үүнтэй төстэйгөөр Louis Althusser (*La Pensée*, 1970, dt. 1977) идеологийн аппаратын (сургууль, сүм, → гэр бүл гэх мэт) бие даасан байдал, олон талт байдал, материаллаг байдал нь нийгмийн дэг журмыг дахин шинэчлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байв. Althusser-ын хэлснээр, эдгээр нь → хувь хүнийг эрх чөлөөтэй, сонголт хийх → субъект

8 Цалигчлах үзэл. Байгалийн юмс аврагч ид шидтэй учир сахиус болгон шүтдэг үзэл: <https://nli.gov.mn/gariinavлага/PHILOSOPHY.pdf> Шүтээний объект болох фетиш нь чулуу, мод, соёо, амьтны яс, хүний гараар бүтсэн урлал, ер нь далдын ид шид агуулж байгаа гэж итгэхүйц юу ч байж болно: https://mn.wikipedia.org/wiki/%D0%A2%D0%BE%D1%82%D0%B5%D0%BC_%D1%88%D2%AF%D1%82%D0%BB%D1%8D%D0%B3 Жишээ нь, өөрсдийн гараар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ шүтээн болгож харах.

болгон дуудаж, улмаар хувь хүний нийгэм рүү хандсан идеологийн салшгүй харилцааг үүсгэдэг.

Althusser, Gramsci нарын араас марксистын дараах объектив байдал буюу үнэнийг нэхэмжлэх хэлэлцүүлэг-өөрөөр хэлбэл, идеологийн эсрэг ойлголтууд-өөрөө идеологийн хардалтын цөмд орж ирсэн (→ постструктурализм). Ernesto Laclau (*Emancipation(s)*, 1996, dt. 2002)-ын хувьд нийгмийн анги эсвэл нийгмийн бодит байдлыг объектив байдлаар тодорхойлохын тулд зөвхөн манлайллын нөлөөгөөр зөвшилцөлд хүрэх боломжтой гэж үзсэн. Ямарваа нэгэн идеологиос ангид бодит байдал дээр гарна гэдэг санаа нь эсрэгээрээ хамгийн шилдэг идеологийн дохио болдог. Slavoj Zizek, Terry Eagleton зэрэг зохиолчид идеологи гэдэг ойлголтыг барьж явах саналтай байхад, Michel Foucault, Pierre Bourdieu нар энэ идеологи гэдэг нэр томьёог эрх мэдэл/мэдлэгийн харилцааны (→ дискурс, мэдлэг) дүн шинжилгээ юм уу бэлгэдлийн хүчирхийлэл гэдэг нэр томьёогоор солих санал гаргасан байдаг (→ хабитус).

Ute Tellmann

Kurt Lenk (Hrsg.): Ideologie. Ideologiekritik und Wissenssoziologie. Neuwied 1964, 91984.

Terry Eagleton: Ideology: An Introduction. London [u. a.] 1991. – Dt.: Ideologie: Eine Einführung. Übers. von Anja Tippner. Stuttgart 1993, Nachdr. 2000.

Slavoj Zizek (Hrsg.): Mapping Ideology. London [u. a.] 2000.

Jürgen Ritsert: Ideologie. Theoreme und Probleme der Wissenssoziologie. Münster 2002.

Stuart Hall: Ideologie, Identität, Repräsentation. (Ausgewählte Schriften. Bd. 4.) Übers. von Ulrich Mehlem [u. a.]. Hamburg 2004.

Ижилсэл (Identität)

“Ижилсэл” (латинаар *idem* = “адил”, “ижил”) гэдэг нь би хэн байх эсвэл өөр бусад нь хэн байх вэ гэсэн асуултын хариулт гэж ойлгож болно. Хувь хүний болон коллектив ижилслийг ялган авч үзэж болох юм. Ижилсэл бол үргэлж нийгмийн конструкцийн акт байдаг, бусад хүн буюу бүлгээс ялгарах өөрийн гэсэн онцгой чанараараа холбогдсон сүлжээнд хувь хүн өөрөө юм уу бүлгээрээ эсвэл өөр хэн нэгэн юм уу бүлэг багтаж байдаг.

Хувь хүний ижилсэл гэдэг асуултын тухайд энэ нь бүх нийтийн болон соёлын өвөрмөц хэмжигдэхүүн юм. Ижилсэл нь үргэлж субьектив “дотоод” болон нийгмийн “гадна” хоёрын хоорондын тохироо байдаг. Өөрөөр хэлбэл, антропологийн үүднээс хэзээ ч тогтоогдоогүй, харин эхлээд хувь хүн болон нийгмийн зүгээс → эсвэл → үүрэг гэх мэт нийгмийн загвараар дамжуулан бий болох ёстой субьектүүдийн нийгмийн байршлын тухай яригдана. → Орчин үеийн байдал нь нийгмийн хөдөлгөөнгүй төсөөллийг зөрчиж, байнгын өөрчлөлтийн динамикт орсноороо → хувь хүн тухайн газар нутгийн нийгэм-соёлын жам ёсны байдлаа

өөрөө гээхийн хэрээр ижилслийн хэв шинжийн сэдэв хөндөгдөнө. Zygmunt Bauman (*Life in Fragments. Essays in postmodern Morality*, 1995, dt. 1997)-ын хувьд ижилсэл нь “төрсөн цагаасаа “асуудал” байсан, асуудал болж төрдөг”. Тиймээс ижилсэл нь анхнаасаа л ажлын онцлог чанартай бөгөөд өөрийнхөө болон ертөнцтэй харилцах харилцаандаа идэвхтэй анхаарах ёстой субъектээр амьдардаг. Өөрийн суурьших газрыг төлөвлөж, бүтээн босгодог бөгөөд гаргасан төлөвлөгөө, бүтээн байгуулалтдаа бусдын зөвшөөрлийг авах шаардлагатай болно. Орчин үеийн сонгодог ижилслийн онолчид Georg Wilhelm Friedrich Hegel (*Phänomenologie des Geistes*, 1806/07)-ээс эхлээд George Herbert Mead (*Mind, Self and Society*, 1934, dt. 1975) хүртэл ижилслийг нийгмийн харилцан хүлээн зөвшөөрлөөс хамаарах конструкцийн хэв шинж гэж үзжээ.

Erik H. Erikson (*Identity and the Life Cycle*, 1959, dt. 1966) нийгэм-сэтгэл зүйн сонирхлын үүднээс хувь хүний мэдрэхүйд амьдралын түүхийн болон нөхцөл байдлыг хамарсан тэгш байдал, гадаад өөрчлөлтөөс үл хамааран дотоод эв нэгдэлтэй байх боломжит нөхцөлүүдийн талаарх асуудлыг сонгодог загварынхаа цөм болгожээ. Сэтгэл зүйн аналитик байдлаар өдөөгдсөн энэ загварын хөгжлийн логик бүтэц нь мөн сонгодог байх бөгөөд энэ нь “эпигенетик схем”-д ижилслийн үе шатуудыг зүй ёсны дагуу алхам алхмаар бий болгодог. Өсвөр нас бол ижилслийн хөгжүүлэлт явагдах, дуусгавар болох амьдралын үе шат гэж хүлээн зөвшөөрөгддөг.

Erikson-ийн үзэл баримтлалын талаарх шүүмжлэл

юуны түрүүнд модерн байх төсөлд чиглэгддэг бөгөөд энэ нь түүний үзэл баримтлалтай салшгүй холбоотой байдаг. Орчин үеийн өөрийгөө танин мэдэхүйн үндсэн координатуудыг задлан харвал нэгдмэл байдал, тасралтгүй байх, уялдаа холбоо, хөгжлийн логик эсвэл ахиц дэвшил гэсэн ойлголтууд сарнисан байна. Erikson-оос ялгаатай нь → “гэнэтийн байдал”, “тасалдал”, “хуваагдал”, “хагарал”, “бутрал”, “рефлексив байдал” буюу “шилжилт” гэх мэт нэр томъёо нь дэлхийн туршлагын (→ постмодерн, постструктурализм) гол онцлогуудыг харуулах ёстой. Ижилсэл төлөвшин тогтохдоо бүхэлдээ нийгмийн эдгээр таних тэмдгийн хүрээнд, эдгээрээр дамжин бүрэлддэг. Тиймээс ижилсэл нь дотоод цөмөөс үүссэн гэж яригдахаа больсон бөгөөд харин тогтсон “өдөр тутмын ижилсэх ажил”-ын үйл явцаас, дотоод болон гадаад ертөнцийн хоорондын тасралтгүй зохицолдох үйлдлээс үүдэлтэй гэж үздэг. Ижилслийн конструкци шинжийн талаарх найруулгын хэсгийг тодорхой болгохын тулд театрын зүйрлэл ашигладаг Erving Goffman (*The Presentation of Self in Everyday Life*, 1956, dt. 1969)-ын арга зүй бол эдгээр нөхцөл байдлаас хамаарсан ижилслийг үүсгэх “менежментийн асуудал”-д илүү нээлттэй байдаг.

Ижилсэл гэдэг ойлголт нь хэрэглээний тодорхой арга замаар–ямартай ч яригдахгүйгээр–бүтэмжтэй амьдралын зорилтот төлөвт хөтөлдөг. Чухам энэ утга санаа хатуу шүүмжлэлийн бай болсон байдаг. Үүнийг нийгэм судлалын шүүмжлэгчид болох Theodor W. Adorno (→ шүүмжлэлийн онол) болон Michel Foucault нарын

зүгээс амьдрал дахь субъектив хүслийг системтэйгээр устгаж, холдуулж, үгүй хийдэг нийгэмд бүтэмжтэй амьдрал байх мэт → субъект болон → нийгмийн хоорондын идеологийн эвлэрлийн тухай ойлголт гэж үзсэн. Түүнчлэн феминист шүүмжлэлд ч ижилслийг эмэгтэйлэг субъектив (→ хүйс) байдлын хувьд патриарх гэмээр албадсан дүрслэлтэй гэж шүүмжилдэг. Шүүмжлэлийн эдгээр хэлбэрт ихэнхдээ дарагдаж эсвэл мартагддаг дасан зохицох, хүлцэнгүй байх хэм хэмжээг гадаад болон дотоод зохицолдлогын асуудал болгодог бөгөөд энэ нь яригдахгүй хэвээр байхын хэрээр ижилслийн тухай хэлэлцүүлгийг идеологийн хувьд хүндрүүлдэг.

Heiner Keupp

Anthony Giddens: Modernity and Self-Identity. Self and Society in the Late Modern Age. Cambridge 1991, Nachdr. 2001.

Heiner Keupp / Renate Höfer (Hrsg.): Identitätsarbeit heute. Klassische und aktuelle Perspektiven der Identitätsforschung. Frankfurt a. M. 1997, Nachdr. 2007.

Heiner Keupp [u. a.]: Identitätskonstruktionen. Das Patchwork der Identität in der Spätmoderne. Reinbek 1999, ³2006.

Rolf Eickelpasch / Claudia Rademacher: Identität. Bielefeld 2004. Heinz Abels: Identität. Wiesbaden 2006.

Институци (Institution)

“Институци” (латинаар *institutio* = “байгууллага”) гэдэг ойлголт нь өргөн утгаараа нийгэмд тогтсон, өөрөөр хэлбэл субъект хооронд хуваалцдаг (→ интерсубъектив) үйл ажиллагааны хэм хэмжээт, танин мэдэхүйн болон үнэлгээний (оролцогчийн зорилго, чадвар, хүслийг зохицуулах) утга учиртай чиг баримжаа (→ мэдрэмж)-г тодорхойлоход хэрэглэдэг. “Институци” гэдэг нэр томьёо нь нарийн чанартаа “зохистой зан харилцааны хэм хэмжээ” гэсэн утгатай (Renate Mayntz / Fritz W. Scharpf, »Der Ansatz des akteurzentrierten Institutionalismus«, in: *Gesellschaftliche Selbstregelung und politische Steuerung*, hrsg. von R. M. und F. W. S., 1995). Энэхүү ойлголт нь эцсийн дүндээ институцийг → хэм хэмжээтэй адилтгадаг. Энд гэхдээ нийгэм даяар → хууль болж, зохион байгуулалтад → зохион байгуулалтын журам хэлбэрээр тогтсон албан ёсны хэм хэмжээг зөвхөн хэлэх төдийгүй, албан бус зан заншил, хэрэглээ, дадал хэвшил болсон зүйлсийг, жишээ нь, нутаг нутгийн мэндчилгээний хэлбэрийг хамруулан ойлгодог (→ зан үйл).

Институци гэдэг ухагдахуунаар нийгмийг бурхнаас заяасан хэв маяг гэх ойлголтоос ялгаатайгаар улстөрийн тогтоосон, өөрөөр хэлбэл, хүний гараар бүтээгдсэн нийгмийн дэг журмыг тодорхойлоход Thomas Hobbes (*Leviathan*, 1651) аль эрт ашигласан байдаг. Үүний дагуу “институци” гэсэн ухагдахуун нь → орчин үеийн утга судлалд хамаарах юм. Hobbes-ын гэх мэт нийгмийн

гэрээний онолуудад “хүний гараар бүтсэн” гэдэг хэллэг нь институцийн дэг журмыг ухамсартайгаар, тусгайлан (чухалчлан) тодорхойлох зорилготойгоор бий болгодог гэсэн утгатай. Үүний эсрэгээр, Шотландын ёс суртахууны философи (Adam Ferguson, Adam Smith) институцийн бүтэц нь дийлэнхдээ “үл үзэгдэх гар”-ын нөлөөллийн үр дүн, өөрөөр хэлбэл, огт өөр хүсэл эрмэлзэлд хөтлөгдсөн үйлдлээс анзаарагдахгүй эсвэл санаандгүй байдлаар үүсдэг гэж тодорхойлжээ. Өнөөдрийг хүртэл институцийн тухай нийгмийн шинжлэх ухааны сэтгэлгээг зорилготой загварчлал болон зорилгоос давсан нөлөөний талаарх харилцан солигдох энэ сэдэв тодорхойлж байна.

Институциуд нь нийгмийн → бүтцийн нэг хэлбэр болох тул, нийгэмшил нь нийгмийн бүтэц болоод нийгмийн үйл ажиллагааны харилцан уялдаатай бүрдэл гэдэг ерөнхий шинж чанарын дагуу үргэлж хоёр арга замыг сонирхдог: нэг талаас үйл ажиллагааг хэлбэржүүлэх хэв, нөгөө талаас оролцогчдын үйл ажиллагааны харилцан нөлөөллөөр бий болгосон, хадгалагдаж, өөрчлөгддөг эсвэл устгасан бүтцүүд байдаг. Эхнийхийг Émile Durkheim (*Les règles de la méthode sociologique*, 1885, dt. 1930) онцлохдоо, Институци бол “бид өөрсдийн үйлдлийг цутгах ёстой цутгамал хэв” гэж тодорхойлж байжээ. Хоёр дахь дээр Peter L. Berger болон Thomas Luckmann (*The Social Construction of Reality*, 1966, dt. 1969) зэрэг хүмүүс ажилласан байдаг. Тэд институцчиллийг хувь хүний дадал зуршилд тулгуурлан субъект хоорондын хүлээлтийг бататгах

үйл явцын динамик гэж үзжээ. Бусад арга хандлагууд институцийг эдгээрээс гадна энгийн зохицуулалтаас эхлээд хатуу хуваарилалтын зөрчилдөөн (→ зөрчил) хүртэлх нийгмийн харилцан хамаарлыг шийдвэрлэх янз бүрийн төрлийн асуудлуудын ухамсартай зохицуулалт гэж ойлгодог. Нийтийн бүтээгдэхүүн болохын хувьд оролцогчдод хүлээлтийн зайлшгүй баталгааг өгдөг боловч үүгээр институцчиллийн динамик зогсдоггүй (→ өөрчлөлт). Учир нь институцийн шаардлагууд нь оролцогчдын зорьж буй хувийн зорилтуудтай ахин дахин яах аргагүй зөрчилддөг. Үүнээс үүдэн зорилгодоо хүрэхэд нь саад болж буй институцийн дэг журмыг үл тоомсорлох хандлага нэмэгддэг. Энэ нь зарим үед хориг арга хэмжээнд орохоос зайлсхийхийн тулд далд хэлбэрээр (жишээ нь, татвараас зайлсхийх замаар), зарим үед хэрэв хориг арга хэмжээний зардлыг ийм замаар хүрч болох зорилгын үр өгөөжтэй харьцуулахад дааж болохуйц санагдаж байвал (жишээ нь, бослого гаргах замаар) ил хэлбэрээр тохиолддог. Хэрэв институциуд ийм маягаар аажим аажмаар арчигдаж, эсвэл гэнэт сүйрвэл дараа нь үүсэх хүлээлтийн тодорхойгүй байдал нь чиг баримжааны хоосон орон зайг дүүргэх (→ хувьсал) шинэ институциудыг бий болгох чухал шалтгаан болдог.

Бүх институциуд нь үйл ажиллагааг тодорхойлдог нийгмийн бүтэц юм; Зарим институциуд бүр цаашлаад үйл ажиллагаа явуулах боломжтой байдаг тухайлбал, хувь хүмүүсийн хамтарсан оролцогч байдлаар. Үүнд, албан ёсны → байгууллагууд орно. James S. Coleman n

(*Power and the Structure of Society*, 1974) эдгээр төрлийн байгууллагуудад “корпорацийн оролцогчид” гэсэн нэр томъёог гаргаж ирсэн. Ийм байгууллагууд хамтын үйл ажиллагааны чадамжийг институцчилдэг. Энэ нь хувь гишүүдийн хувьд нэг талаараа ашигтай, учир нь тэд жишээ нь нийтлэг эрх ашгаа илүү сайн хамгаалж чаддаг. Нөгөөтээгүүр, нийгмийн бараг бүх салбарт олон тооны байгууллагууд хаа сайгүй тархсан нь хувь хүний үйл ажиллагааны эрх чөлөөг хумихад ч мөн хүргэдэг. Үүнийг Max Weber (*Wirtschaft und Gesellschaft. Grundriß der verstehenden Soziologie*, 1922) “бюрократ ноёрхол” гэж, мөн → шүүмжлэлийн онолд “захиргаадсан ертөнц” гэсэн бол Coleman *Asymmetric Society* (1982, dt. 1986) хэмээн тэмдэглэсэн байдаг.

Uwe Schimank

Fritz W. Scharpf: Games Real Actors Play. Actor-Centered Institutionalism in Policy Research. Boulder 1997.

Brainard Guy Peters: Institutional Theory in Political Science: The »New Institutionalism«. London [u. a.] 1999, 2005.

Hartmut Esser: Soziologie. Spezielle Grundlagen. Bd. 5: Institutionen. Frankfurt a. M. / New York 2000.

Uwe Schimank: Handeln in Institutionen und handelnde Institutionen. In: Friedrich Jaeger / Jürgen Straub (Hrsg.): Handbuch der Kulturwissenschaften. Bd. 2: Paradigmen und Disziplinen. Stuttgart 2004. S. 293–307.

Интеграци/Эв санааны нэгдэл (Integration/Solidarität)

“Интеграци” (латинаар *integratio* = “дахин сэргээх”, “бүтэн болгох”) гэдэг нэр томъёогоор хэсгүүдийг цогц нэгж болгон нэгтгэх үйл явц хийгээд үр дүнг илэрхийлдэг. Үүний эсрэгээр нэгэн бүхэл хэсгийн бутрал эсвэл нэгдмэл холбоо задрахыг “дисинтеграци” гэж нэрлэдэг. “Эв санааны нэгдэл” (францаар *solidarité* = “хамт олны сэтгэл”, “эв нэгдэл”) гэдэг ойлголт нь түүхийн явцад олон утга санааг олж авсан байдаг. Нийгмийн онолын ухагдахуун болохын хувьд энэ нь хүн төрөлхтний хамтын амьдралын суурь зарчмуудыг илэрхийлдэг. Үүнээс гадна нийгмийн гишүүдийн харилцан хариуцлага, бие биеийгээ дэмжиж туслах гэсэн утгыг агуулдаг. Émile Durkheim, Talcott Parsons нарын уламжлалд “эв санааны нэгдэл” гэдэг нь → нийгэмлэг эсвэл → нийгмийн хамтач байдлын матери буюу өөрөөр хэлбэл бодит чанарыг илэрхийлдэг.

Herbert Spencer (*Social Statics*, 1851) интеграцийн тухай ойлголтыг нэвтрүүлснээс хойш социологид интеграци-дисинтеграцийн динамикийг шинжлэхэд янз бүрийн үндсэн парадигмуудыг ашигласан. Durkheim (*De la division du travail social*, 1893, dt. 1977) нийгмийн нэгжүүдийг нэгтгэдэг эв санааны нэгдлийн ялгаа, хөгжил доторх интеграцид анхаарал хандуулж байв. Хөдөлмөрийн хуваагдал багатай энгийн нийгэмд ижил төстэй байдалд суурилсан механик эв санааны нэгдэл давамгайлдаг бол органик эв санааны нэгдэл

нь илүү цогц нийгэмд байдаг бөгөөд энэ нь олон янзын чадвараас хамаарч харилцан нөхөх зарчмаар дамждаг гэж Durkheim үзжээ. Parsons (*The Social System*, 1951, dt. 1972) өөрийн бүтцийн-функционалист (→ функционализм) чиглэлдээ нийгэм даяарх → эрхэмж, үнэ цэнийн болон зан харилцааны чиг баримжаанаас цөм нь бүрддэг тэнцвэрт загварыг илүүд үзэж байв. Нийцтэй байдлыг бий болгож, хадгалахын тулд нийгэмшүүлэлт ба нийгмийн → хяналтаар дамжуулаад интеграцийн үйл явцыг урагшлуулах юм. → Зөрчилдөөн нь нөгөө талаас эмгэг байгааг илтгэдэг. David Lockwood («Social Integration and System Integration», in: *Explorations and Social Change*, hrsg. von George K. Zollschan und Walter Hirsch, 1964, dt. in: *Theorien des sozialen Wandels*, hrsg. von Wolfgang Zapf, 1969) үйл явцад оролцогчдын нийгмийн интеграци ба системийн интеграцийг нийгмийн дэд системүүдийн хоорондох харилцаа гэж үзэж байснаараа Parsons-оос ялгарч байв. Энд тэрээр мөн зөрчил тээсэн маргаануудын талаар авч хэлэлцэж байсан. Үүнтэй Jürgen Habermas (*Legitimationsprobleme im Spätkapitalismus*, 1973) “систем” ба “амьдралын орчин”-ыхоо ялгаагаар холбогддог. Энэ үүднээс нь харвал, харилцаагаар дамжуулан бий болгох нийгмийн интеграцийн үндсийг нийтлэг эрх зүйн болон ёс суртахууны үзэл баримтлалаар тавих бөгөөд ийм хэлбэрээр нийгмийн хэм хэмжээ, эрхэмжит зүйлсийн тухай дээд зөвшилцөлд хүрнэ гэж Habermas үзэж байв. Түүнийхээр бол систем ба амьдралын орчныг салгахад дисинтеграци үүсэх бөгөөд юуны түрүүнд хууль

интеграцчиллыг хангахад гол үүрэг гүйцэтгэдэг (*Faktizität und Geltung*, 1992). Habermas-ынх шиг норматив арга барилаас Niklas Luhmann (*Die Gesellschaft der Gesellschaft*, 1997) “сайн” нийгмийн үзэл бодолтойгоор холдож, нийгмийн янз бүрийн дэд салбаруудад олон талт оролцоог (→ оруулах) хангахыг онцолсон.

Интеграцийн үзэл баримтлалуудын дотор эрхэмжит үнэ цэнийг эрхэмлэсэн хандлага (жишээлбэл, Durkheim), гэрээний онолууд (жишээлбэл, Habermas), бүтцийн-функционалист онолууд (жишээлбэл, Parsons, Luhmann) гэж хуваадаг. Интеграци-дисинтеграцийн динамикийн талаарх сүүлийн үеийн судалгаанууд нь “механик/органик эв санааны нэгдэл”, “нийцтэй/эмгэгтэй төлөв байдал”, “системийн/нийгмийн интеграци”, “системийн болон амьдралын орчин”, “оролцоог хангах/оролцоог хязгаарлах” гэх мэт заримдаа дотор нь байдаг хуваагдалд шийдэл эрэлхийлдэг. Тэдний хувьд нийгмийн “интеграци” нь зөвхөн нийгмийн-бүтцийн түвшинд нийгмийн материаллаг болоод соёлын баялагт хангалттай оролцоог хангасан үед, институцийн түвшинд зөрчилтэй талуудад эрх тэгш, тэнцвэртэй хэлэлцээрт оролцох боломжийг бүрдүүлсэн үед, хувь хүний түвшинд → бүлгүүдэд тогтвортой харьяалалтай байх, хүмүүс хоорондоо сэтгэл хөдлөлийн харилцаа тогтоох боломжтой тохиолдолд л оршдог байна. Ингэж ялгасны үндсэн дээр объектив ба субъектив үзүүлэлтүүдийн хооронд төдийгүй, нийгмийн болон системийн интеграци, дисинтеграцийн үйл явцын хоорондын ялгааг гаргаж

болно. Дэлхий дахины хөгжлийн явцад ядуурал, гадуурхалт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ямар механизмууд өнөөг хүртэл үр дүнтэй байсан ба эдгээр нь даяарчлалын явцад үр дүнгүй болох аюул нүүрлэж байгаа эсэхийг судлахын тулд эмпирикт суурилсан нийгмийн интеграцийн сүүлийн үеийн үзэл баримтлалд дисинтеграцийг илүү нухацтай авч үзэж байна (*Integrationspotentiale einer modernen Gesellschaft*, hrsg. von Wilhelm Heitmeyer und Peter Imbusch, 2005).

Sandra Hüpping / Wilhelm Heitmeyer

Bernhard Peters: Die Integration moderner Gesellschaften. Frankfurt a. M. 1993.

Wilhelm Heitmeyer (Hrsg.): Was treibt die Gesellschaft auseinander? Frankfurt a. M. 1997, Nachdr. 1999.

(Hrsg.): Was hält die Gesellschaft zusammen? Frankfurt a. M. 1997, Nachdr. 1998.

Jürgen Friedrichs / Wolfgang Jagodzinski (Hrsg.): Soziale Integration. Opladen/Wiesbaden 1999.

Интерсубъектив харилцаа (Intersubjektivität)

“Интерсубъектив харилцаа” гэдэг нь шууд утгаараа → нэг субъектийн хүсэл эрмэлзэл, → үйлдэл, мэдрэмж нөгөөгийн үйл ажиллагааны нөхцөлтэй холбогдохыг хэлдэг гэж ойлгож болно. Хэрэв нийгмийн шинжлэх ухаанд → харилцан үйлчлэл, → харилцаа холбоо,

харилцан хамаарал (харилцан ойлголцол) зэрэг категориудыг нийгмийн үйл хэргийн үндсэн категори болгон ашигладаг бол эдгээр нь интерсубъектив харилцааны ойлголт бүхий нийтлэг нэг санааг агуулж байгаа юм. Гэвч энэ категорийн танин мэдэхүйн онолын үнэлэмж нь нийгмийн шинжлэх ухаанд маргаан дагуулдаг. Энэ нь → хувь хүн болон → нийгмийн хоорондох харилцааны талаарх олон янзын таамаглалууд багтаасан байдаг. Өнөөдрийг хүртэл шийдэгдээгүй байгаа энэ маргааны талаар сонгодог (нийгмийн) философид аль хэдийн урьдчилан тодорхойлж байжээ. Энэ бол хувь хүн ба нийгмийн харилцааны талаар Platon-ы болон Aristoteles-ийн үзэл баримтлал юм. Platon-ы буюу нийгэм төвтэй хандлага нь хүн зөвхөн нийгмийн нөлөөнд хүмүүжсэн тохиолдолд (→ нийгэмшүүлэх) нийгмийн амьтан болж чадна гэсэн үндэслэл дээр суурилдаг. Харин Aristoteles-ийн буюу хувь хүн төвтэй хандлагын хувьд хувь хүнийг төрөлхийн нийгмийн хэв шинжтэй амьтан гэж үздэг байна. Төрөхөөсөө л хамтран амьдрах чадвартай байдаг бөгөөд үүнийхээ дагуу бусад хүмүүстэй харилцаанд орж чаддаг. Энэ нөхцөл дээр тулгуурлаад нийгмийн микро болон макро бүтэц (→ гэр бүл, овог аймаг, үндэстнээс эхлээд → улс хүртэл) хөгжих боломжтой.

Интерсубъектив харилцааны үндэстэй холбоотой янз бүрийн таамаглалуудаар дамжин энэ маргаан өдөөгдсөн байна. Интерсубъектив харилцааг *Conditio humana* (хүний төлөв байдал)-ын үндэс гэж үзэж болох бөгөөд үүнгүйгээр нийгэм байтугай хувь хүний үйлдлийг ч

ойлгох боломжгүй юм. Ийнхүү жишээлбэл, Martin Buber (*Ich und Du* 1923)-т харилцан ярианы зарчмын тусламжтайгаар интерсубъектив харилцаанаас өөрийн → нийгмийн онолын онтологийн төв рүү шилжих санаа төрсөн байна. Интерсубъектив харилцааг үндэс болгосон таамаглалуудыг Alfred Schütz (*Der sinnhafte Aufbau der sozialen Welt*, 1932)-ийн феноменологийн социологиос, мөн үүнтэй залгуулаад → этнометодологи, түүнчлэн George Herbert Mead (*Mind, Self and Society*, 1934, dt. 1975) болон түүний залгамжлагчдын → бэлгэдлийн интеракционизмаас харж болно. Эдгээр судлаачдын зүгээс хүний оршин тогтнох нөхцөлийг нэг бол бие махбодын холбооноос улам бүр бэлгэдлийн шинжтэй интерсубъектив харилцаа болж хөгждөг ба эх, хүүхэд хоёрын хоорондын харилцан үйлчлэлийн хэлбэрүүдэд тогтоодог, нөгөө бол нийгэм-онтологийн хувьд нийгмийн үйл ажиллагааны зайлсхийх аргагүй нөхцөл гэж таамагладаг. Emmanuel Levinas-ын сэтгэлгээнийхээ бүхий л хөгжлийн явцад мэдэрсэн гол санаа зовоосон асуудал нь бусдын ач холбогдлыг үнэлэх, түүнийг өөрийн интерсубъектив харилцааны онолын төвд аваачих явдал байв (*Entre nous*, 1991, dt. 1995). Гагцхүү бусадтай харилцах харилцаа, бусад хүмүүс болон бидний хоорондох ялгаа л надад өөрийнхөө дахин давтагдашгүй хувийн → ижилслийн шинж чанарыг тодорхойлох боломжийг олгодог юм. Интерсубъектив харилцааг тайлбарлах өөр нэг өнцөг бол бусад хүмүүстэй харилцаа тогтоох хэрэгцээ бүхий хувь хүнийг авч үздэг. Нийгмийн хөдөлмөрийн

хуваарилалт эсвэл нийгэм-соёлын амьдралын хэлбэрээс шалтгаалж зайлшгүй шаардлагатай болдог харилцан харилцаа тогтоох үйл явц нь харилцан үйлчлэлийн буюу солилцооны онолын үзэл баримтлалд тусгалаа олсон байдаг. Norbert Elias бие даасан гэж боддог байсан Монадуудаас (*Homo clausus* “хаагдмал хүмүүс”-ээс) үүсгэлтэй энэхүү онолын хандлагыг эрс шүүмжлээд, дүрслэлийн социологидоо олон төрлийн интерсубъектив харилцааны холбооснуудыг харуулсан загварыг боловсруулсан.

Интерсубъектив харилцааны үзэл баримтлал нь субъективист үнэнийг батлах шаардлагыг залруулахын тулд цаашдаа ч танин мэдэхүйн онолын өндөр ач холбогдолтой хэвээр байна. Интерсубъектив харилцааг шалгах боломж нь нийгмийн шинжлэх ухааны судалгааны гол шалгуур болдог.

Heiner Keupp

Alfred Schütz / Thomas Luckmann: *The Structures of the Life-World*. Transl. by Richard M. Zaner and H. Tris- 134
Kapital tram Engelhardt. Evanston 1973. – Dt.: *Strukturen der Lebenswelt*. Neuwied/Darmstadt 1975, Nachdr. 2003.

Jürgen Habermas: *Theorie des kommunikativen Handelns*. 2 Bde. Frankfurt a. M. 1981, Nachdr. 2001.

Nick Crossley: *Intersubjectivity. The Fabric of Social Becoming*. London [u. a.] 1996.

Капитал (Kapital)

“Капитал” гэдэг нэр томьёо нь дундад зууны үеийн *capitale* (латинаар *caput* = “үндсэн”) гэдэг үгнээс үүсэлтэй бөгөөд хүүтэй холбоотой нийт мөнгөний гол эх үүсвэрийг нэрлэдэг. Худалдаачны капитал болон мөнгөний капитал нь хамгийн эртний капиталын хэлбэрүүд юм. Эдгээр нь бараг бүх нийгэм, соёлд тохиолддог. Капитал, түүний хожлын төлөөх тасралтгүй тэмүүлээр тодорхойлогддог орчин үеийн аж үйлдвэрийн нийгмийг (→ орчин үе, аж үйлдвэрийн нийгэм) “капиталист” гэж нэрлэдэг. Капитализм XVIII/ XIX зуунаас хойш Европоос эхлээд дэлхий даяар тархсан бөгөөд нийгмийн нөлөө бүхий хэлбэр болсон.

Adam Smith (*An Inquiry into the Nature and the Causes of the Wealth of Nations*, 1776) дэвшилтэт, зах зээлийн “үл үзэгдэгч гар”-аар дамжин өөрөө өөрийгөө зохицуулах, баялаг нь өсөлт болдог капиталист → чинээлэг нийгмийн алсын харааг тодорхойлсон байдаг. Smith, шинээр хөрөнгө оруулсан капиталын хэмжээ ажилчин ангийн “цалингийн сан”-г бүрдүүлэхэд нөлөөлж, улмаар цалин хөлс нэмэгдэнэ гэж үзжээ. Харин David Ricardo (*On the Principles of Political Economy and Taxation*, 1817) хөрөнгө хуримтлуулах явцад хөрөнгийн улам бүр нэмэгдэх хэсэг нь машин механизмд хөрөнгө оруулалт болж ордог бөгөөд энэ нь ажилчдын эрэлтийг бууруулахад хүргэнэ (→ хөдөлмөр) гэдгийг нотолжээ. Karl Marx (*Das Kapital*, 3 Bde., 1867–94) “ажиллах хүчний үнэ цэн” ба түүнийг үйлдвэрлэлийн явцад ашиглалтын

үнэ цэн болгон ашиглахыг хооронд нь ялгаж авч үзсэн. Марх-ын хэлснээр, зөвхөн энэ “хувьсах капитал” ажиллах хүчний нөхөн үйлдвэрлэлийн дундаж өртөг ба үүнээс хэтэрсэн хөдөлмөрийн мөлжлөг хоёрын зөрүүгээр нэмүү өртгийг бий болгодог. Машин механизмын ашиглалтыг нэмснээр (тогтвортой капитал) нэмүү өртгийн хувь хэмжээ хэвээр байх үед “ашгийн хувь хэмжээ буурах хандлага”-ыг бий болгож, улмаар тогтолцооны эцсийн хямралд хүргэж болзошгүй юм. Марх-ын бүтээлийн улс төрийн эдийн засгийн шүүмжлэл нь философийн үндэслэлийг илэрхийлдэг. Энд эдийн засгийн үзүүлэлтүүд (бараа, мөнгө, капитал) нь түүхийн хувьд өөрчлөгдөж болох нийгмийн нэг өвөрмөц хэлбэрийн илэрхийлэл болохыг харуулдаг бөгөөд социализм/коммунизмыг капитализмын алтернатив хувилбар болгон, эдийн засаг илүү өндөр хөгжсөн нийгмийн хэлбэр хэмээн тодорхойлжээ (→ материалист нийгмийн онол). 1929 оны дэлхийн эдийн засгийн хямралын дараа кейнсизм⁹ үүссэн. John Maynard Keynes (*General Theory of Employment, Interest and Money*, 1935, dt. 1936)-ийн үзсэнээр, капиталыг үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт болгохын тулд хүүгийн түвшнийг бага байлгах ёстой. Түүнчлэн улсын зардлыг циклийн эсрэг (*алдагдлын зарцуулалт буюу deficit spending*) ашиглах ёстой. Эцэст нь дахин хуваарилалтаар хэрэглээний хандлагыг идэвхжүүлэх учиртай. Keynes эдийн засгийн хямралын үед цалин

9 John Maynard Keynes (1883-1946)-ийн төрийн мөнгөний зохицуулалтаар дамжуулан нийт эрэлтэд нөлөөлөх замаар ажилгүйдлийг бага байлгаж, эдийн засгийн үр өгөөжтэй хөгжлийг хангах тухай онолын зарчим юм

хөлсийг бууруулахгүй, харин “дотоодын эрэлт”-ийг нэмэгдүүлэхийг зөвлөж байв. Гэвч Кейнсийн урамшууллыг эдийн засгийн нөхцөл байдал сайн байгаа үед нь цуцлалгүй, нийгмийн баялгийн түвшин болгож хүлээн авсан учраас төсвийн алдагдал, улсын өр нэмэгдсэн. Хожим нь Кейнсийн *Stop-and-Go* бодлого урт хугацааны монетари¹⁰ бодлогоор солигдсон.

Түүнээс хойш аж үйлдвэрлэлийн дараах шинэ корпорацийн хэлбэрүүдээр тодорхойлогдох (→ даяаршил), шинэ мэдээллийн технологи дээр тулгуурласан универсал капитализм дэлхий нийтэд хөгжсөн. Үүнд, банкнуудыг уламжлалт зээл олгодог үйлчилгээнээс хөрөнгө оруулалтын банк руу шилжүүлэх, энэ нь глобал хөрөнгийн нэгтгэлд зөвлөгөө өгөх, үнэт цаасны бие даасан арилжаа хийх, санхүүгийн салбарт инновац хийх зэргээр тодорхойлогддог. Энд (*Hedge-Fonds*) Хэджийн сангууд нэлээдгүй хугацаанд онцгой үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд тэдний асар их санхүүгийн тэлэлтийн зарим хэсгийг АНУ-ын тэтгэврийн сангууд бүрдүүлдэг. Тэд дэлхий даяар үйл ажиллагаа явуулан, компаниудыг худалдан авч, сүйрүүлж эсвэл ашиг авчрахаар бүтцийг нь шинэчилдэг. Эдгээр “царцаа” дэлхийн эдийн засгийн дасан зохицох үйл явцад хэр зэрэг эсвэл ер нь эерэг үүрэг гүйцэтгэж байгаа эсэх нь маргаантай юм.

Марх-ын капиталын динамик бүтцийг бүрдүүлэгч хүчин зүйлийн талаарх эргэцүүлэлд үндэслэн Pierre

¹⁰ Milton Friedman (1912-2006)-ын 1960-аад онд гаргасан эдийн засгийн бодлогын концепт бөгөөд эрэлтэд түлхүү чиглэгддэг Кейнсизмын бодлогыг эсрэгцүүлэн хөгжүүлсэн загвар юм.

Bourdieu («Ökonomisches Kapital, kulturelles Kapital, soziales Kapital», in: *Soziale Ungleichheiten*, hrsg. Von Reinhard Kreckel, 1983) капиталын тухай эдийн засгийн сонгодог ойлголтыг өргөжүүлж, зүйрлэвэл, нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх хэлбэртэй бэлгэдлийн капиталыг бүрдүүлдэг соёлын капитал (жишээ нь, боловсролын зэрэг дэвийн хэлбэрээр институцчилэгдсэн) болон нийгмийн капитал (харилцааны холбоо сүлжээ)-ын ангиллуудыг багтаасан юм. Эндээс харахад нийгмийн дэг журам гэдэг бол нийгмийн янз бүрийн ангиудын хооронд янз бүрийн нийгмийн салбарт хүлээн зөвшөөрөгдөх, хуваарилалтын тэмцлийн үр дүн бөгөөд зөвхөн эдийн засгийн хувьд тодорхойлогддоггүй.

Heinz Dieter Kittsteiner

Immanuel Wallerstein: *The Modern World-System*. New York [u. a.] 1974/80. – Dt.: *Das moderne Weltsystem*. 3 Bde. Übers. von Angelika Schweikhart. Frankfurt a. M. / Wien 1986–2004.

Christopher A. Bayly: *The Birth of the Modern World, 1780–1914*, Malden/Oxford 2004. – Dt.: *Die Geburt der Modernen Welt. Eine Globalgeschichte 1780–1914*. Übers. von Thomas Bertram und Martin Klaus. Frankfurt a. M. / New York 2006.

Elmar Altvater: *Das Ende des Kapitalismus, wie wir ihn kennen. Eine radikale Kapitalismuskritik*. Münster 2005, ³2006. Nicole Gnesotto / Giovanni Grevi: *The New Global Puzzle. What World for the EU in 2025?* Paris 2006.

Конструктивизм (Konstruktivismus)

“Конструктивизм” гэдэг нэршил дэлхийн I дайны өмнөхөн Vladimir Tatlin-ын Орост гаргасан жүжгийн урлагийн хэв маягт анх хэрэглэгджээ. “Конструктивизм”-ыг сэтгэл судлалын, мөн ерөнхийдөө шинжлэх ухааны онол болгохыг Jean Piaget үндэслэсэн байдаг. Конструктивизмын үндсэн үзэл баримтлалаар → мэдлэгийг бодитоор өгөгдсөн гадаад ертөнцийн хуулбар (төлөөлөл) гэж үзэх ёсгүй, харин хүний туршлага дээр үндэслэсэн оюун ухааны бүтээл гэж үздэг.

Piaget “оюун ухаан өөрийгөө цэгцлэх замаар ертөнцийг цэгцэлдэг” (*La construction du réel chez l'enfant*, 1937, dt. 1974) гэдэг санаагаараа арван жилийн дараа Norbert Wiener, Warren McCulloch болон Heinz von Foerster нарын боловсруулсан кибернетикийн үндэс суурь болсон хувийн зохион байгуулалт гэсэн ойлголтыг түрүүлээд таамаглаж байжээ. “Зохицох чадвар” гэсэн ойлголт биологиос гаралтай бөгөөд амьд организмыг хамруулсан, → хүн эсвэл амьтанд тухайн өгөгдсөн нөхцөл байдалд зохицон амьдрах боломж олгодог шинж чанар, чадвар байдаг гэсэн утгатай юм. Конструктивист мэдлэгийн онолд үзэл баримтлал, онол, арга зүйн хэлбэр зэрэг нь зориулагдсан нөхцөл байдалд хүлээж байсанчлан үүргээ гүйцэтгэн харуулж байвал эдгээрийг “зохицох чадвартай” (хийж болохуйц) гэж үзнэ.

Конструктивизмын онол нь хэд хэдэн үзэл дээр суурилдаг:

(1) Мэдлэг, тэр дундаа шинжлэх ухааны мэдлэг бол мэддэг хүнээс үл хамаарах, оршин буй ертөнцийн их бага хэмжээний “үнэн” дүрслэл биш, харин өдийг хүртэл хэрэгцээтэй нь батлагдсан үзэл баримтлал, тэдгээрийн холбоо, онол зэрэг конструкторуудын хөтөлбөр юм. Энэ харилцаанд конструктивизм прагматизмтай нийцэх боловч үүнээс цаашлаад үзэл баримтлалыг боловсруулах, хөгжүүлэх үндсэн ажлаараа ялгаатай.

(2) Мэдлэг, арга барил нь мэдэж байгаа → субъектийн туршлагын хүрээнд хязгаарлагдаж бий болдог тул тухайн субъект өөрийн мэдлэг, үйлдлийнхээ төлөө хариуцлага үүрдэг.

(3) Мэдлэг, арга барилыг хөгжүүлэх нь нийгмийн бүх → харилцан үйлчлэлээс үл шалтгаалан субъектив хэвээр байна. Үүний дагуу хэн нэгний мэдлэгийг нөгөөд шилжүүлэх боломжгүй юм. Илтгэгч бүр зөвхөн өөрийн туршлага дээр тулгуурлан үгсийн утга санаа, бусад хэл ярианы илэрхийллийг бий болгодог.

(4) Үгийн утгын болон мэдлэгийн субъектив чанар нь боловсролын тогтолцоонд эрс өөрчлөлтийг шаардаж байна. Учир нь үзэл баримтлалыг шууд дамжуулах боломжгүй учраас багш сурагчдадаа мэдлэгийг шингээж чадахгүй, харин сурагчдыг шаардлагатай үзэл баримтлалын үйлдлүүдийг өөрсдөөр нь үйлдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх ёстой.

Мэдлэгийн онолын хувьд конструктивизм эсэргүүцэлтэй тулгарсаар байдаг. Хүний оюун ухаан өөрийн ертөнц рүү өөрөөр хэлбэл, мэдэх болсноос өмнө байж болох ертөнц рүү нэвтрэх боломжгүй гэдэг таамаглалыг

аль эрт Immanuel Kant (*Kritik der reinen Vernunft*, 1781) боловсруулсан байсан. Энэ гэхдээ гагцхүү метафизикчдэд хүлээн зөвшөөрөгдөхгүй хэвээр байгаа юм биш, ерөөсөө хэн ч өдий хүртэл өөрийн ертөнцдөө нэвтрэх үйл явц хэрхэн явагдахыг тайлбарлаж чадаагүй юм.

Эдгээр ойлголтуудыг Социологид авч үзсэн: хувь хүмүүс өгөгдсөн нөхцөлд үйлдэл, → харилцаагаараа дамжуулан нийгмийн орчныг бий болгодог нийгмийн процессын талаар асуусан. Peter L. Berger, Thomas Luckmann нарын тодорхойлсноор, нийгмийн конструктивизм бол нийгмийн → бодит байдлыг хувь хүмүүсийн динамик үйл явцад бий болгож, эргээд хариу нөлөөлдөг нийгмийн харилцан үйлчлэлийн дүрмийг институцчилж (→ институци), өөрийн болгосны үр дүн гэж үзжээ (*The Social Construction of Reality*, 1966, dt. 1969). Тайлбарлах социологийн олон чиглэлүүд энэхүү хандлагыг дагаж мөрддөг (→ этнометодологи, → феноменологийн социологи, → символик интеракционизм). Niklas Luhmann-ы системийн онол (→ систем) нь өмнөө байгаа бодит байдалд шууд нэвтрэх боломжийг бүрдүүлэхгүйгээр, үйл ажиллагааны хаалттай системд бодит байдлыг хэрхэн бий болгох талаар асуудаг (*Erkenntnis als Konstruktion*, 1988). Мэдлэг, шинжлэх ухааны социологийн салбарт (→ шинжлэх ухаан) конструктивизм нь мэдлэгийн баазыг нийгэмд бий болгох судалгаанд олон тооны саналуудыг дэвшүүлж, үнэний тухай ойлголтуудыг шинжлэх ухааны тогтолцооны болон практикаар дамжуулан хүргэсэн юм (Karin Knorr-Cetina, *The Manufacture of*

Knowledge. An Essay on the Constructivist and Contextual Nature of Science, 1981, dt. 1984). Ялангуяа *жендер ба колониололын дараах* судалгаанууд, түүнчлэн ерөнхийдөө постструктуралист (→ постструктурализм) чиг хандлага нь нийгмийн ижилслийг бий болгох, бэхжүүлэх нөхцөл байдал, үүнтэй уялдаад холбогдох хүмүүсийн талаарх өсөж буурах үнэлэмжийг судалдаг.

Конструктивизм нь социологийн судалгаа, онолд ихээхэн нөлөө үзүүлэхээс гадна, дидактикийн хөгжилд чухал түлхэц үзүүлсэн бөгөөд түүний цөм нь мэдлэгийг сурагч өөрөө олж авч, өөрөө цэгцтэй болгох явдал юм (Ernst von Glasersfeld, *Radical Constructivism in Mathematics Education*, 1996).

Ernst von Glasersfeld / Sina Farzin

Heinz von Foerster [u. a.]: Einführung in den Konstruktivismus. München 1985, 82005.

Siegfried J. Schmidt: Der Diskurs des Radikalen Konstruktivismus. Frankfurt a. M. 1987, 82000.

Ernst von Glasersfeld: Radical Constructivism. A Way of Knowing and Learning. London 1995. – Dt.: Radikaler Konstruktivismus. Ideen, Ergebnisse, Probleme. Übers. von Wolfram K. Köck. Frankfurt a. M. 1996.

Vivien Burr: An Introduction to Social Constructionism. London 1995. 22003 [u. d. T.: Social Constructionism].

Масс (Masse)

“Масс” (англиар *crowd, mass*; францаар *foule*) гэдэг ухагдахуун нь олон утгатай. Бүх тодорхойлолтуудад нийтлэг байдаг зүйл бол масс гэхээр олон тооны хүмүүсийн тухай яригддаг гэж таамагладаг. “Масс” нь тогтсон нийгмийн ангиллаар нэрлэх боломжгүй зүйлийг (жишээ нь, нийгмийн илүүдлүүд эсвэл үгээгүй пролетари) тодорхойлж, бас голчлон үнэлэмжгүй ханддаг нийгмийн үлдэгдэл, хямралт бүлгийг ихэвчлэн төлөөлдөг.

Эрт үед язгууртан удирдагч ангийн эсрэг ойлголт болох харц гаралтай ардыг нэрлэхдээ сөрөг утгаар “масс”-ыг хэрэглэж байжээ (Platon-ы бүтээлд *ochlos*¹¹). Үүнээс хойш “масс” гэдэг нь улс төрийн дэг журамд аюултай элемент гэж ойлгогдох болсон. XIX зууны төгсгөлд Итали, Францын массын сэтгэл судлалд анх янз бүрийн шинжлэх ухаан, улс төрийн цуврал хэлэлцүүлгүүдийг нэгтгэн судалж, үүнийхээ үндсэн дээр массын үзэгдлийн оньсого мэт логикийг тайлах ёстой байв. Ялангуяа Италийн массын сэтгэл судлал массын дунд үйлдэгдсэн гэмт хэрэгт хувь хүний хариуцлагын талаарх криминологийн хэлэлцүүлгээр тодорхойлогдож байв (Scipio Sighele, *La foule criminelle*, 1892). Массын сэтгэл судлал нь тухайн цаг үеийнхээ сэтгэл судлалын хэлэлцүүлэгтэй уялддаг бөгөөд массыг аль нэг удирдагчид эсвэл харилцан санал болгосон хүндээ анхаарал хандуулснаас үүдсэн коллектив

11 Грекээр *ochlos* нь масс, харц ард, олон түмэн гэсэн утгатай.

ховсдуулалт гэж ойлгож байв. Мөн химийн үйл явцтай адил массын үзэгдлүүдийн илрэлийг тайлбарлахын тулд байгалийн шинжлэх ухааны үгийн санг ашиглах болсон: Анхандаа холбоогүй, дан элементүүдийг хослуулснаар, дангаараа байхад нь гаргаж чадахааргүй гэнэтийн шинж чанарууд үүссэн.

Gustave Le Bon (*Psychologie des foules*, 1895, dt. 1932) энэхүү олон янзын мэдлэгийн хуримтлалыг нөлөө бүхий нийгэм-сэтгэл судлалын массын онол болгон нэгтгэсэн. Le Bon-ы үзсэнээр, массын онцлог бол тэдний таамаглахын аргагүй зан байдал, гишүүдийн хувь хүний шинж чанар нь алдагдсан байдал, тэдний → үйлдлийн ухамсаргүй, сэтгэл хөдлөлөөр хандаж байгаа байдал, харилцан хэтрүүлэгт хүргэдэг санал зөвлөгөө, тэдгээрийн тогтворгүй байдлаас харагдана.

Массын нөгөө талд тэднийг хянахыг оролддог удирдагч гэж байна. Массын чухал нийгмийн хүч нь тэдний яасан ч ялгаагүй гэсэн эрс үйлдэлд харагддаг. Масс оролцогчдын нийгэм, соёлын ялгаа масс дотроо чухал биш байдаг, учир нь тэд хувь хүний шинж чанар, гарал үүслийг чухалчилдаггүй. Ингэж массын сэтгэл судлал нь нийгмийн өргөн хүрээг хамарсан ардчилал нийгмийн дэг журмыг алдагдахад хүргэж болзошгүй гэдэг нийгмийн айдсыг илэрхийлж байв. Удирдагчдад төвлөрсөн массын сэтгэл судлал нь массын улс төрийн боломжуудын талаарх марксист сонирхлыг (z. B. in George Sorels *Theorie des Generalstreiks; Réflexions sur la violence*, 1908, dt. 1928), ялангуяа массыг улс төрийн субъект болгон хувиргах сонирхлыг эсэргүүцэж байв.

Sigmund Freud (*Massenpsychologie und Ich-Analyse*, 1912) массын сэтгэл судлалыг психоаналитикаар өргөжүүлж нийгмийн онол болгон хөгжүүлсэн. Масс болон (→ бүлэг) бүрэлдэх гол механизм нь удирдагчтайгаа ижилсэх хандлага юм. Freud-ын хувьд хуучны массын сэтгэл судлалаас ялгаатай нь масс дотор нийгмийн дэг журам алдагдах биш, харин → нийгэм үүсэж буй нь харагдсан. Gabriel Tarde (*Les lois de l'imitation*, 1890, dt. 2003; *L'opinion et la foule*, 1901)-ын хувьд масс бол нийгэм бүрийн үндэс болсон дуураймал үйл явдал хэтрүүлгийн хэлбэрээр явагддаг талбар юм. Энэ утгаараа “масс” гэдэг нь “үзэгчид” болсон бөгөөд Tarde өөрийн ашигладаг масст зориулсан мэдээллийн хэрэгслээр дамжуулан үзэгчдийг тодорхойлсон.

Массын сэтгэл судлалын улс төрийн консерватив байр сууриас болж, фашист хөдөлгөөнөөр дамжуулан “масс”-ыг функцэд оруулсны дараа энэхүү ухагдахуун XX зууны дунд үед утгаа алдсан. Тэрээр хэрэглээний нийгмийг нэгэн төрлийн болгоход чиглэсэн соёлын шүүмжлэлтэй хандлагын хүрээнд оршиж үлдсэн (David Riesman, *The Lonely Crowd*, 1950, dt. 1956). Британийн соёлын судалгаа нь массын утгыг элит, ардчилсан бус гэж үгүйсгээд, үүнийг “алдартай” гэсэн нэр томъёогоор, “эдгээр хүмүүсийн” онцолсон яриагаар сольсон юм. Elias Canetti (*Masse und Macht*, 1960) өөрийн гэсэн байр суурийг тодорхойлохдоо массын ажиллагааг сэтгэл судлалын ижилсэх механизмаас гадна гаргаж, амьд үлдэх антропологийн зарчмаар батлахыг оролдсон. Социологид масс гэдэг ухагдахууны оронд “бүлэг”,

“коллективтой үйлдэл” гэх ойлголтууд гарч ирэх боловч үзэл баримтлалын цоорхойг нээлттэй үлдээсэн. Үүнд суурилж массын ойлголтод → постмодернизмын шинж тэмдгийг харсан хүн бол Jean Baudrillard (*A l'ombre des majorités silencieuses*, 1982). Өнөөгийн улс төрийн онолд (Baruch de Spinoza, Gilles Deleuze нартай залгуулаад) олон түмнийг нэрлэсэн ойлголт нь массын онолын зарим асуудлыг агуулж байдаг. Чухамхүү тэдний уян хатан, тогтворгүй, урьдчилан таамаглах аргагүй байдал нь олон нийтийг дэлхийн улс төрийн субъект болгодог (Michael Hardt / Antonio Negri, *Empire*, 2000, dt. 2002). Мөн тоглоом, мэдээллийн онолын арга зүйд (→ тоглоом) гэнэтийн, нийгмийн үйл явцыг (жишээ нь, зан үйлийн санхүүд) загварчлахад массыг дахин ашиглаж байна.

Urs Stäheli

Serge Moscovici: *L'âge des foules*. Paris 1981. – Dt.: *Das Zeitalter der Massen*. Übers. von Michael Sommer. München/Wien 1984, Nachdr. 1986.

John MacClelland: *The Crowd and the Mob: From Plato to Canetti*. London [u. a.] 1989.

Jaap van Ginneken: *Crowd, Psychology and Politics*. Cambridge 1992.

Jeffrey Schnapp / Matthew Tiews (Hrsg.): *Crowds*. Stanford 2006.

Материалист нийгмийн онол (Materialistische Gesellschaftstheorie)

(Түүхэн) материалист нийгмийн онол нь → нийгмийг хүн ба байгалийн → хөдөлмөрөөр зуучлагдсан солилцоог зохицуулдаг → тогтолцоо гэж ойлгодог. Нийгэм бүрэлдэж, шинэчлэгдэх үйл явц хийгээд түүний түүхэн өөрчлөлтийн хэлбэрүүдэд ямар ч сэтгэлгээний үйлдлүүд хүний үйл ажиллагаанаас тусдаа чадварыг бий болгодоггүй, харин эдгээр нь нэг талаас тодорхой нейробиологийн нөхцөлүүдээс, нөгөө талаас материаллаг, бэлгэдлийн эд зүйлсийн нийгмийн үйлдвэрлэл, өмчлөлөөс хамааралтай байдаг. Нийгэм ямар арга хэлбэрээр байгальд хандаж байгаа, мөн нийгмийн тодорхой хэлбэрийн → ноёрхлоос хамаарч нийгмийн тогтолцоонд нь их бага хэмжээгээр гүн гүнзгий өөрчлөлт хийх шаардлагатай эрсдэлийн шинжтэй хөгжил бий болж болно. Материалист нийгмийн онолыг үндэслэгч Karl Marx, Friedrich Engels нар өөрсдийн онолыг нийгэм, түүхийн зонхилох идеалист бүтцийн шүүмжлэлтэй хослуулсан (*Die deutsche Ideologie*, 1845/46). Материалист нийгмийн онолыг бодлогоор пролетаритын мөлжлөгт → анги болгон ашиглуулах, тэднийг “капиталист үйлдвэрлэлийн хэв маягийн хүлээснээс” чөлөөлөх оролдлого энэхүү шүүмжлэлтэй нийцэж байв. Капитализмд (→ капитал) Marx, Engels нар “үйлдвэрлэлийн нөхцөл” ба “үйлдвэрлэх хүч”-ний хоорондох бүтцийн зөрчил дээр тогтох, хувьсгалаар даван туулах түүхийн сүүлчийн антагонист нийгмийн хэлбэрийг олж харсан.

Marx, Engels нарын материалист нийгмийн онол орчин үеийн → социологид XIX зууны дунд үеэс хойш олон талын, гүн нөлөө үзүүлсэн. Ялангуяа, капиталист бүтээгдэхүүн үйлдвэрлэл ба ухамсар, хэрэгцээний субъектив хэлбэрүүдийн хоорондох холбоо хамаарлыг Marx-ын хөндийрүүлэх, объектжуулах теоремтой (барааны фетиш чанар) уялдуулан харуулсан бүтээлүүдийг онцлох байна. Жишээлбэл, Georg Lukács-ын “Түүх ба ангийн ухамсар” (1923), Max Horkheimer, Theodor W. Adorno нарын “Гэгээрлийн диалектик” (1947). Энэ сүүлийнх нь соёлыг цэвэр оюун санааны болоод урлагийн бие даасан, зорилгын чөлөөт орон зайг бүрдүүлдэггүй, харин орчин үеийн капитализмд ухамсрын хувьд аливаад автамхай маягийн хүмүүсийг нэгтгэсэн “соёлыг бүтээх” хэлбэрээр засаглаж буй тогтолцоонд үйлчилдэг гэдгийг батлахыг оролдсон (→ шүүмжлэлийн онол). Материалист нийгмийн онол нь нийгмийн ерөнхий социологийн онол болохын хувьд 1980-аад оноос хойш олон улсын нийгмийн шинжлэх ухааны хэлэлцүүлгийн хүрээнд ач холбогдол нь багассан. Үүнд хамааралгүй бүтээлүүдийн нэг бол Америкийн Immanuel Wallerstein (*The Modern World-System*, 3 Bde., 1974–89, dt. 1986–2004)-ын бүтээл юм. Капитализмыг XVIII зууны сүүлчээр аж үйлдвэрийн хувьсгалаар (→ аж үйлдвэржсэн нийгэм) л эхлүүлдэг, капиталист хөгжлийн тодорхой телеологийн шугаман шинж чанартай гэдэг байсан уламжлалт марксист үзэл бодлоос ялгаатай нь Wallerstein капитализмыг аль хэдийн XVI зуунаас эхэлсэн, газар нутаг, эдийн

засаг, улс төрийн цогц харилцаа бүхий дэлхийн тогтолцоонд бэхлэгдсэн үйл явц гэж үзжээ. Энэхүү үйл явцтай холбоотой өөрчлөлтүүд (→ өөрчлөлт) удаан үргэлжилж болох бөгөөд өөрчлөлтийн төв болон захын байршлуудыг бий болгож, өгсөж уруудах хөдөлгөөнийг багтаана. Jürgen Habermas (2 Bde., 1981)-ын харилцааны үйлдлийн онол нь орчин үеийн нийгмийн гол асуудлыг “тогтолцоо” ба → “амьдрах ертөнц” хоёрын ялгаа гэж батлахын тулд Марх-ын “капитал”, “үнэ цэний хууль”, “ажиллах хүч” зэрэг ойлголтуудад тулгуурладаг. Гэвч ингэхдээ Habermas тодорхой түүхэн, материалист, капитализмын шүүмжлэлт зорилгоосоо ухардаг. Түүний үзэж байгаагаар өмнөх капитализмын хувьд тогтсон капитал ба хөлсний ажлын хоорондох эсрэгцэл нь зөрчилдөөнөөр солигдсон бөгөөд энэ бол юуны түрүүнд хуваарилалтын төлөөх тэмцлийн үр дүн биш, харин амьдрах суурь орчны бэлгэдлийн нөхөн сэргэлтэд заналхийлж байна.

Бусад социологийн онолууд ч гэсэн өөрийн чухал гэсэн хэсгүүдээ “материалист нийгмийн онол”-оос авч цааш нь бие даан боловсруулсан байдаг. Жишээ нь, Pierre Bourdieu (*La distinction. Critique sociale du jugement*, 1979, dt. 1982) → хабитус, “капиталын төрлүүд”-ийн онолоороо эдийн засгийн капиталын тухай ойлголт, түүнээс үүдэлтэй ангийн бүтцийн шалгуурыг капитал гэдэг ойлголтын тодорхой социологийн тодорхойлолт болгон өргөжүүлсэн (“нийгмийн”, “соёлын”, “бэлгэдлийн капитал”). Германд Karl Hermann Tjaden (*Mensch – Gesellschaftsformation – Biosphäre*, 1990) хүн

ба байгалийн хоорондын харилцааны зохицуулалт, хяналтыг орчин үеийн нийгмийн нөхөн сэргэлтийн суурь асуудал болж байна гэж дүгнээд, зөвхөн эдийн засгийн хувьд тодорхойлогдсон эрх мэдлийн тухай ойлголтыг нийгмийн гэр бүл, улс төрийн → бүтэц (→ гэр бүл, улс төр) дэх тэгш бус байдал, харилцан хамаарлыг харгалзан үздэг “хүн, эд хөрөнгө, бараа бүтээгдэхүүнийг захирах, зарцуулах эрх” гэсэн илүү өргөн хүрээний ойлголтоор солих замаар материалист нийгмийн онолыг системтэйгээр боловсруулахыг оролдсон.

Иймэрхүү маягаар материалист нийгмийн онолыг феминизм гэх мэт бусад засаглалын шүүмжлэлт хэлэлцүүлгүүдэд холбогдох боломжийг бий болгодог (Frigga Haug, »Geschlechterverhältnisse als Produktionsverhältnisse«, in: *Kritische Wissenschaften im Neoliberalismus*, hrsg. von Christina Kaindl, 2005). Хэдийгээр өнөөгийн социологийн онолын мэтгэлцээнд өөр бусад парадигмууд давамгайлж байгаа ч материалист нийгмийн онол ирээдүйд капиталист, патриарх харилцаа болон даяаршлын хөгжлийн явцад шинэ түлхэц авахыг үгүйсгэх аргагүй юм.

Lothar Peter

Josef Schleifstein: Einführung in das Werk von Marx, Engels und Lenin. München 1972, 41983, Nachdr. 1995.

Gottfried Stiehler: Gesellschaft und Geschichte. Zu den Grundlagen der sozialen Entwicklung. Berlin 1974.

Karl Hermann Tjaden: Gesellschaftsformation – Forma-

tionsfolge und -gliederung. In: Hans Jörg Sandkühler (Hrsg.): Europäische Enzyklopädie zu Philosophie und Wissenschaften. Bd. 2. Hamburg 1990. S. 348–363.

Margarete Tjaden-Steinhauer / Karl Hermann Tjaden: Gesellschaft von Rom bis Ffm. Ungleichheitsverhältnisse in West-Europa und die iberischen Eigenwege. Kassel 2001.

Методологи (Methodologie)

Методологи (грекээр *methodos* = “зам”; мөн шинжлэх ухааны онол, философи; англиар *philosophy of science*) гэдэг нь эрдэмтдийн ажлын арга барилд дүн шинжилгээ хийх тухай юм: энэ нь нийгмийн шинжлэх ухааны онолыг боловсруулах, турших тухай биш. Энэ бол → социологи шиг бие даасан шинжлэх ухааны судлагдахуун юм. Шинжлэх ухааны ажлын арга барилыг нэг талаас *эмпирик* байдлаар судална (өөрөөр хэлбэл, эрдэмтэд хэрхэн ажиллаж байгааг тодорхойлно) эсвэл нөгөө талаас *шүүмжлэлт анализ* хийнэ (жишээ нь, идеал хэлбэрийн нэр томьёо үүсэхэд яаж дүгнэх вэ гэж асуудаг).

Шинжлэх ухааны онолын судалгааны чухал асуудал бол бодит баримтыг *тайлбарлах* тохиромжтой арга зам юу вэ гэдэгт оршино. Тайлбарлах социологийн хувьд (→ этномотодологи, феноменологийн социологи, симболик интеракционизм) герменевтик (→ ойлгосноо заах) арга барилыг хувилбараар санал болгодог. *Ойлгох арга*. Энэ нь яг яаж хийгдэж байгааг, энэ аргыг

хэрхэн үнэлэх, тайлбараас юугаараа ялгаатай болохыг судалж үздэг. Мөн *урьдчилан таамаглах* тохиолдолд тохиромжтой арга барил, асуудлуудад дүн шинжилгээ хийнэ. Энэ нь мөн ухагдахууны *нэр томьёо* үүсэхэд ч хамаатай. Эрдэмтэд өөрсдийн таамаглалуудыг бодит байдалтай холбохыг оролддог. Шинжлэх ухааны онолын дараагийн нэг судлагдахуун бол мэдэгдлийг *эмпирик байдлаар шалгах* тохиромжтой арга замын тухай асуудал юм. Ялангуяа нийгмийн шинжлэх ухаанд *үнэлэмжийн эрх чөлөөний* тухай асуудал өргөн хүрээний маргааныг дагуулдаг. Энэхүү маргааныг өдөөгчид эрдэмтдээс хувийн үнэлэмжээ шинжлэх ухааны мэдэгдлээс тодорхой ялгаж салгах хэрэгтэй гэж шаардаж байв. Энэ байр суурийг аль эрт Max Weber («Die ›Objektivität‹ sozialwissenschaftlicher und sozialpolitischer Erkenntnis», in: *Archiv für Sozialwissenschaft und Sozialpolitik* 19, 1904; »Der Sinn der ›Wertfreiheit‹ der soziologischen und ökonomischen Wissenschaften«, in: *Logos. Internationale Zeitschrift für Philosophie der Kultur* 7, 1918) мөн төлөөлж байжээ. Маргааныг эсэргүүцэгчдийн хувьд харин ингэж тусгаарлахыг үгүйсгэдэг юм. Шинжлэх ухааны онол бол энэ хүрээнд ямар асуудал үүсэж байна, үүнийг хэрхэн шийдвэрлэх вэ гэдгийг сонирхон асуудаг. Тайлбарлах, (а) нэр томьёо үүсэх (б) нь бие даасан шинжлэх ухаанд чухал үүрэгтэй байдаг тул эдгээр хоёр асуултын талаар цааш нь товчхон авч үзье.

(а) Аливаа нэг үйл явдлыг *тайлбарлахад* ихэвчлэн бусад нөхцөл байдлыг шалтгаан болгож дурддаг. 1989/90 оны Лайпцигийн даваа гарагийн жагсаалыг

(тайлбарлах, өөрөөр хэлбэл, тайлбарлах баримтууд) улс төрд сэтгэл дундуур байдал нэмэгдсэнтэй холбон (шалтгаан) тайлбарладаг. Яагаад өөр хүчин зүйл биш, улс төрийн дургүйцлийг шалтгаан болгосон нь тодорхойгүй үлджээ. Ерөнхийдөө улс төрийн үйл ажиллагааны хэлбэрүүд үүсэх нөхцөлүүдийг дурдсан хуультай төстэй мэдэгдлийг (өөрөөр хэлбэл, цаг хугацаа, орон зайд баригдаагүй мэдэгдэл) ашиглан энэ асуултад хариулж болох юм (Carl G. Hempel / Paul Oppenheim, »Studies in the Logic of Explanation«, in: *Philosophy of Science* 15, 1948). “Сэтгэл ханамжгүй байдал нэмэгдэх нь жагсаал цуглаанд хүргэдэг” гэсэн хууль байж болно. Хэрэв 1989 онд сэтгэл дундуур байдал нэмэгдсэн бол энэ нь жагсаалын гарал үүслийг тайлбарлаж байгаа юм. Тэгэхээр энэ хуульд жагсаал цуглаан хийх нэг шалтгаан бол сэтгэл дундуур байдал гэдгийг ерөнхийд нь заажээ. Энэхүү тодорхой нөхцөлийг анхдагч буюу захын нөхцөл гэж нэрлэдэг. Тайлбарлах зүйлийн тайлбар нь хууль болон анхдагч нөхцөлүүдээс логикоор гарч ирнэ. “Тохирох” (өөрөөр хэлбэл, хүлээн зөвшөөрөгдөхүйц) тайлбарт, нэгдүгээрт, хууль нь үнэн байх юм уу эсвэл ерөнхий мэдэгдлийн үнэнийг бид тодорхойлж чадахгүй тул эмпирик байдлаар сайтар батлагдсан байх ёстой. Хоёрдугаарт, тайлбарлах зүйл болон анхдагч нөхцөлүүд үнэхээр бүрдсэн байх ёстой. Ийм процедур бүхий “Hempel-Oppenheim-схем” (ХО схем) бол маргаантай байдаг (siehe Gerhard Schurz, *Erklären und Verstehen in der Wissenschaft*, 1990). Нийгмийн шинжлэх ухаанд хууль байдаггүй гэж ярьдаг. Үүний эсрэг харьцангуй

сайн батлагдсан хуультай мэдэгдлүүдийг, жишээ нь, үнэ цэн-хүлээлтийн онолыг дурдаж болох юм. Хуулийн мэдэгдлийг ихэнхдээ далд хэлбэрээр ашигладаг. Энэ бол хэрэв тайлбар нь ерөнхий мэдлэгтэй холбоотой үед хамаарах юм, жишээ нь, Лайпцигийн даваа гараг болгоны жагсаал Boris Becker, Steffi Graf нарын 1989 оны 6 сарын Уимблданы ялалт зэрэг спортын үйл явдлуудаас шалтгаалаагүй. ХО схем асуудалтай байдаг байлаа ч энэхүү схемээс илүү ямар хувилбар байж болох гэдэг асуулт гарч ирнэ. Энэ хувилбар нь зөвхөн маш тодорхой хүчин зүйлүүд тайлбарлах зүйлийн шалтгаан болдог гэдгийг баттай нотлох баримтуудыг гаргаж ирдэг байх ёстой. Хувилбар гэж үзэж байсан ойлгох аргын гол шүүмжлэл нь үр дүнг интерсубъектив шалгах боломжгүй байдаг бөгөөд судлаачийн мэдрэмжээс хамаардаг гэж үздэг (Heiko Holweg, *Methodologie der qualitativen Sozialforschung. Eine Kritik*, 2005).

(б) Нэр томьёо үүсгэх хамгийн энгийн арга бол *нэрлэсэн тодорхойлолтыг* нэвтрүүлэх явдал юм. Жишээ нь, “оюутан” гэдгийг “их сургуульд элсэн орсон хүн” гэж тодорхойлж болно. *Зан төлөвийн талаарх нэр томьёог* дараах жишээн дээр тайлбарлая: Хэрэв хэн нэгэн Германы иргэншилгүй хүмүүсийг нутгаасаа хөөн гаргахын төлөө дуугарвал түүнийг ихэвчлэн “гаднынхныг эсэргүүцэгч” гэж цоллодог. Эндээс тодорхой нөхцөл байдалд (ярилцлага) ямар хариу үйлдэл үзүүлж байгааг (аман яриа) ажигладаг. Хариу үйлдлээс хамаараад тодорхой шинж чанараар нь (гаднынхныг эсэргүүцэгч болгон) үнэлдэг.

Дараах баримтууд онцгой ач холбогдолтой.

(1) Нэр томъёонууд нь нийтээр заншсан дүрэм байдаг болохоос эмпирик мэдэгдэл биш юм. Тодорхойлолтууд нь үнэн эсвэл худал байж болохгүй. (2) Илэрхийллийг тодорхойлолт эсвэл эмпирик мэдэгдэл эсэхийг тогтооход ихэвчлэн хэцүү, жишээлбэл, “Нийгэм бол бүхнийг хамруулсан амьдралын холбоос юм” гэсэн өгүүлбэр байна. (3) Ихэнхдээ тодорхойлолт болон таамаглалууд холилдсон байдаг, жишээ нь, “Хүрэх ёстой нийгмийн зорилтууд идеологид багтаж, улс төрийн үйл ажиллагаанд нөлөөлдөг”. Сүүлийн хэсэг бол тодорхойлолтод багтахгүй, харин эмпирик мэдэгдэл болно. (4) Аливаа нэр томъёоны ашиглагдах зайлшгүй нөхцөл бол түүний тодорхой байдал юм. (5) Тиймээс нэр томъёонууд оновчтой байх ёстой. Эмпирикийн шинжлэх ухаанд оновчтой байдлын шалгуур нь онолын үржил шимт байдал юм, өөрөөр хэлбэл, нэр томъёонууд хүчинтэй төдийгүй, мэдээлэл сайтай онолын бүрэлдэхүүн хэсэг байх ёстой.

Karl-Dieter Opp

Karl-Dieter Opp: *Methodologie der Sozialwissenschaften. Einführung in Probleme ihrer Theorienbildung und praktischen Anwendung*. Reinbek 1970, 62005.

Alan F. Chalmers: *What Is This Thing Called Science? An Assessment of the Nature and Status of Science and Its Methods*. St. Lucia 1976. – Dt.: *Wege der Wissenschaft. Einführung in die Wissenschaftstheorie*. Übers. von Niels Bergemann. Berlin [u. a.] 1986, 62007.

Daniel Little: *Varieties of Social Explanation. An Introduc-*

tion to the Philosophy of Social Science. Boulder [u. a.] 1991.

Alan Musgrave: Common Sense, Science and Scepticism. A Historical Introduction to the Theory of Knowledge. Cambridge 1993. – Dt.: Alltagswissen, Wissenschaft und Skeptizismus. Eine historische Einführung in die Erkenntnistheorie. Übers. von Hans und Gretl Albert. Tübingen 1993.

Hans Poser: Wissenschaftstheorie. Stuttgart 2001, Nachdr. 2004.

Мэдлэг (Wissen)

“Мэдлэг” гэдэг нь хүн, → байгууллага эсвэл → бүлгүүд хүлээн авч, боловсруулж, дахин сэргээж эсвэл ашиглаж болдог мэдээллийг хэлдэг. Өгөгдөл (тэмдэгтийн дараалал) эсвэл мэдээллээс (тэмдэгтийн утгаар илэрхийлэгдсэн тоон мэдээлэл) ялгаатай нь мэдлэг бол чадавхжуулдаг. Энэ утгаараа мэдлэг бол → хүч юм (Francis Bacon). Мэдлэгийг нийгмээс хамааралтай гэж үздэг. Сүүлийн үеийн хандлагуудад нийгэм ч бас мэдлэгээс хамааралтай гэж батлах болжээ.

Мэдлэгийн социологи 1920-иод оноос хойш мэдлэгийг бүлэг, → нийгэмлэг, → нийгэмд бий болгох, түгээх, хадгалахад чиглэгдсэн нийгмийн үйл явц, бүтцийг судалж байна. Үүний өмнөх хэлбэр нь идеологи шүүмжлэл (→ идеологи) гэж байв. Francis Bacon (*Novum Organum*, 1620, dt. 1962) өөрийн шүтээний онолдоо жинхэнэ

мэдлэгийг бурхан шүтээний дүр төрх, өрөөсгөл ойлголт, эндүүрлээр дамжуулан төөрөгдүүлдэг болохыг харуулсан байна. “Оршихуй нь ухамсрыг тодорхойлдог” гэж Karl Marx, Friedrich Engels нарын түүхэн материалист идеологийн шүүмжлэлд өгүүлжээ (*Die deutsche Ideologie*, 1845/46). Өмнөх мэдлэгийн социологи нь мэдлэгийн хэлбэр, чиг үүргүүдийн талаар судалж байв: Max Scheler (*Die Wissensformen und die Gesellschaft*, 1926) аврал эсвэл гэтэлгэлийн, боловсролын болон гүйцэтгэлийн мэдлэгүүдийг хооронд нь ялган авч үзжээ. Мэдлэгийн төрөл болгон нь тодорхой сонирхлын чиг хандлагад нийцдэг. “Оршихуйтай холбоотой мэдлэг” гэсэн түлхүүр үгийн дор Karl Mannheim (*Wissenssoziologie*, 1964) мэдлэгт нөлөөлөх бусад хүчин зүйлсийг гаргаж ирсэн: → ангийнхны болон өрсөлдөөний сонирхол, үе тэнгийнхний нийгмийн харьяалал (→ үе тэнгийнхэн), сект гэх мэт тодорхой хүрээлүүд, мэргэжлийн бүлгүүд (→ мэргэжил), философийн сургууль, коллектив гаралтай хандлага. 1945 оноос хойш мэдлэгийн социологи юуны өмнө дараах хандлагуудад хуваагдсан: нийгмийн феноменологийн үүднээс (→ феноменологийн социологи) Alfred Schütz (*Collected Papers*, Bd. 1, 1962) амьдралд ойр мэдлэгийг бий болгож, дамжуулж буй өдөр тутмын амьдралын хэвшмэл болсон хийгээд идеалчилсан хэв маягт анхаарлаа хандуулдаг. Peter L. Berger, Thomas Luckmann нар *The Social Construction of Reality* (1966, dt. 1969) номдоо “бүх дэлхийн мэдлэг”-ийг бүтээх талаар авч үзсэн байдаг (→ конструктивизм). Герменевтик мэдлэгийн социологи (Georg Soeffner, *Die*

Auslegung des Alltags – Der Alltag der Auslegung, 1989) нь хувь хүний үйл ажиллагааны талбарын чухал болоод ердийн нөхцөл байдлын талаарх амьдралын явцад хуваалцсан мэдлэгийг төдийгүй үйл ажиллагааны өөр хувилбаруудын талаар эргэцүүлэн тунгаасан мэдлэгийг илэрхийлэх хувь хүний үйлдлүүдийг сонирхдог (→ үйлдэл). Michel Foucault (*L'ordre du discours*, 1970, dt. 1974)-ын → дискурс ба практикийн талаарх (пост) структуралист анализ нь нийгэм-түүхийн тодорхой дискурсээр мэдлэгийг бий болгож, түгээх талаар авч үздэг (→ постструктурализм). Pierre Bourdieu (*La distinction. Critique sociale du jugement*, 1979, dt. 1982) анги, бүлэгт хамаарах мэдлэг хабитус болж тэлэх тухай судалсан. Системийн онолын мэдээллээр хангагдсан Niklas Luhmann (*Gesellschaftsstruktur und Semantik*, Bd. 1, 1980)-ын мэдлэгийн социологи нь мэдлэгийн хуримтлал (семантик) болон нийгмийн бүтцийн ковариацийн (өөрөөр хэлбэл, харилцан хамааралтай өөрчлөлт) талаарх асуултаас үүдэн мэдлэгийг хариуцагч бүлгүүдэд хуваарилах үзэл баримтлалыг гаргасан. Эцэст нь шинжлэх ухааны мэдлэгийн агуулга нь мэдлэгийн социологийн дүн шинжилгээ хийх боломжтой болдог (Michael J. Mulkey, *Science and the Sociology of Knowledge*, 1979): Шинжлэх ухааны үндэслэлтэй үр дүнг оролцогчид тодорхой нийгэм, соёлын нөхцөл байдалд тухай бүр тохиромжтой гэж үнэлэхээр шаардлагууд гэж ойлгож болно.

Мэдлэгийн талаарх социологийн эрчимжсэн үйл ажиллагаанаас үзэхэд орчин үеийн өнөөгийн

нийгэмд мэдлэг бол бүтээмжийн гол хүч болсон гэдэг ойлголттой нийцэж байна. Түүний дотор Nico Stehr зэрэг хүмүүс өнөөгийн нийгмийг “мэдлэгийн нийгэм” гэж тодорхойлжээ (*Knowledge Societies*, 1994): Мэдлэг бүтээдэг институциуд, ялангуяа → шинжлэх ухаан системтэйгээр өргөжсөн. Түүнчлэн мэдлэгээ ашиглан асуудлыг шийдвэрлэх нь зарчим болжээ. Онолын мэдлэгийг төлөвлөх, арга хэмжээнүүдэд ашиглах нь улам бүх нэмэгдэж байна. Сүлжээнд суурилж мэдлэгийг бүтээдэг, зохион байгуулалттай мэдлэгийн ажлын болон мэдлэгийн менежментийн хэлбэрүүд бий болж байна. Үүнээс гадна эрсдэлийн талаарх ойлголт (→ эрсдэл) ихсэж байгаатай холбоотойгоор мэдлэггүй байдлыг хэрхэн шийдвэрлэх вэ гэсэн асуулт гарч ирдэг. Klaus Jarr мэдлэггүй байдлыг судлах нь тодорхойгүй нөхцөл байдалд мэдлэг болох зүйлийнхээ талаараа мэдлэг олж авахад зайлшгүй шаардлагатай гэж үзэж байв («Zur Beobachtung von Nichtwissen», in: *Soziale Systeme* 3, 1997, Н. 2). Мэдлэгийг олон янзаар бүтээх нөхцөл, чиг үүрэг, үр нөлөөний талаар анализ хийх боломжтой үзэл баримтлалыг E. Doyle McCarthy соёл судлалын өнцгөөс гаргаж тавьсан байна (*Knowledge as Culture*, 1996). Энэ нь хуваалцдаг мэдлэгийн төлөвөөс ангижирч, үүний оронд тус бүрдээ тусгай мэдлэг олгодог, бүлэг, газар, мөн түүнчлэн энэ мэдлэгээр анхааралд өртөх, холбоо сүлжээтэй болох, давамгай байдлыг олж авахын төлөө тэмцдэг үйл явцад анхаарлаа хандуулдаг болжээ.

Peter Weingart: Wissensproduktion und soziale Struktur. 2 Bde. Frankfurt a. M. 1976.

Reiner Keller: Wissenssoziologische Diskursanalyse. Grundlegung eines Forschungsprogramms. Wiesbaden 2005.

Sabine Maasen: Wissenssoziologie. Bielefeld 2008.

Мэргэжил (Beruf)

Мэргэжил (англиар *profession*; латинаар *professio* = “хүлээн зөвшөөрөлт”, “ажил мэргэжил”) гэдэг нь амьжиргааныхаа эх үүсвэрийг олохын тулд хүмүүсийн байнга хийдэг үйл гэсэн ойлголт. → Ажлаас ялгаатай нь энэ үйл тусгай мэргэжлийн боловсрол (→ боловсрол) шаардагдах мэргэшсэн болоод хосолсон ур чадварууд дээр суурилдаг.

Мэргэжил гэдэг ухагдахуун нь Ромоос үүсэлтэй. Нэлээн эртнээс хэдий ч дунд зууны үеийн гар урчуудын холбооны дүрэмд болон шинэчлэлийн үед тод илрэлийг олж байсан: Martin Luther мэргэжлийг “*vocatio Dei*”, бурхны дуудлага гэж ойлгож байв. Харин Jean Calvin нь эцэс төгсгөлгүй мэргэжлийн ажлыг тодорхойлохдоо нигүүлслийн зэрэгт хүрэх хэрэгсэл гэж үзсэн. Орчин үеийн эдийн засгийн хөгжлийн үр дүнд улсын төсвийн баялагт мэргэжил чухал ач холбогдолтой болох нь тодорхой болсон ба хувь хүний ажил эрхлэх эрмэлзэл эергээр үнэлэгдэх болсон. Аж үйлдвэржилтийн явцад нийгмийн ангийн зохион байгуулалттай уламжлалт мэргэжил ач холбогдолгүй болсон. Францын хувьсга-

лын дараа хувь хүний мэргэжил сонгох эрх чөлөө хуульчлагдсанаар хуулиар баталгаажсан үндсэн эрх болсон байдаг (→ Эрх). Émile Durkheim (*De la division du travail social*, 1893, dt. 1977) нь мэргэжлийг нийгмийн функциональ дэг журам болох орчин үеийн → нийгмийн “органик эв санааны нэгдэл”-ийн үндэс гэж үзсэн. → Аж үйлдвэржсэн нийгэмд мэргэжлийн чадвар нь хувь хүн болон → бүлгүүдийн нэр хүнд, хангалуун амьдрал, нийгмийн өсөлт дэвшлээ баталгаажуулахад чухал ач холбогдолтой. Нийгмийн давхарга бол юуны түрүүнд мэргэжлийн нэр хүнд, хүндлэгдэх байдлын илэрхийлэл юм.

Ажлын мэргэжлийн дөртэй болох → нийгэмшлийг хүн гэрээсээ, мэргэжлийн боловсролыг сургууль, сургалтын байгууллагаас олж авдаг. Мэргэжлээрээ ажиллах нь нийгмийн → орчин тойрны зүгээс хүлээлтийг бий болгодог. Мэргэжлийн ажил үүргийн хувьд (→ үүрэг) мэргэжлийн хамт олон болон үйлчлүүлэгч/харилцагчид онцгой чухал байдаг. Орчин үед үйлдвэрлэлийн байгууллагуудад голчлон мэргэжлийн хүмүүсийг авч ажиллуулж байхын зэрэгцээ тэдний мэргэжлийн үүрэг нь тухайн байгууллагын шаардлагаас хамаарч өөр байна.

Мэргэшил нь → мэдлэгийн өндөр системчлэлээр, тухайлбал, академик боловсрол, мөн түүнчлэн → нийгэмд үйлчлэх мэргэжлийн ёс суртахуунаар тодорхойлогддог. Мэргэжлийн хүртээмж, гишүүдийн зан төлөвт хяналт тавьдаг мэргэжлийн холбоодод мэргэшсэн байдал нь хувийн зохион байгуулалтын өндөр түвшнийг харуулдаг. Мэргэшсэн мэргэжилтнүүдийн

төрөлд жишээ нь эмч, хуульч, архитект, инженерүүд голлон ордог. Эдгээр нь ихэвчлэн “чөлөөт мэргэжил” боловч орчин үеийн нийгэмд илүү олон мэргэшсэн мэргэжилтнүүд байгууллагын харьяалалд ажиллах болсон (жишээ нь, хувийн эмнэлэгт эсвэл байгууллагын хуулийн хэлтэст). Harold L. Wilensky («*The Professionalization of Everyone*», in: *American Journal of Sociology* 70, 1964, Nr. 2) нь илүү олон мэргэжлийн бүлгүүдийг мэргэшүүлэх хандлага бий болж байгаа талаар хэлж байсан. Мөн бусад судлаачдын дүгнэснээр өөр олон мэргэжлийн хувьд ажлын хуваагдал, стандартчиллын улмаас мэргэжлээсээ хөндийрөх байдал гарч байгааг илтгэжээ. Үйл ажиллагааны онцлогт нийцүүлэх болсноор мэргэжлийн мэдлэг нь улам бүр нэмэлт шаардлага бүхий ур чадваруудыг (жишээ нь, багаар ажиллах, суралцах чадвар) шаардах болсон бөгөөд мэргэжлийн боловсрол олгох сургалт нь мэргэжил эзэмшихэд чиглэгдэж байна. Эдийн засгийн даяаршлын явцад байгууллагуудын шинэ технологи, бүтцийн өөрчлөлтийн улмаас өнөөдөр мэргэжлийн мэдлэг хурдацтай өөрчлөгдөн, цаашид байнга суралцах хэрэгцээ үүсэж, тэр дундаа олон удаа ажлаа солих шаардлага гарч ирэх буюу өөрөөр хэлбэл, мэргэжлийн амьдралд уян хатан зохицуулалтыг шаардах болсон байна. Үүний улмаас мэргэжлийн залгамж чанар алдагдаж, *хөдөлмөр эрхлэлтийг* хангах, хадгалахад илүүтэй чиглэгдсэн хөгжил бий болж байна.

Thomas Luckmann / Walter M. Sprondel (Hrsg.): Berufssoziologie. Köln 1972.

Ulrich Beck [u. A.]: Soziologie der Arbeit und der Berufe. Grundlagen – Problemfelder – Forschungsergebnisse. Reinbek 1980.

Keith M. Macdonald: The Sociology of the Professions. London [u. A.] 1995, Nachdr. 1999.

Friedrich Fürstenberg: Wirtschaftsbürger in der Berufsgesellschaft. Zürich/Osnabrück 1997.

– Michael Hasse: Berufsgesellschaft in der Krise. Berlin 2000.

Нийгмийн онол (Sozialtheorie)

Нийгмийн онол нь хүн төрөлхтний хамтын амьдралыг илүү ойлгомжтой болгох үүднээс үзэл баримтлал, загвар бий болгох асуудалд анхаардаг. Нийгэм-философийн асуудлыг бүх томоохон философичид авч үзсэн байдаг. Тэдгээрийн тухай антикийн үед Platon, Aristoteles нараас, түүнчлэн Thomas von Aquin зэрэг дундад зууны үеийн сэтгэгчдээс олж болно. Шинэ цагийн эхэн үед Thomas Hobbes (*Leviathan*, 1651) нийгмийн онолын загварыг гаргаж ирсэн бөгөөд үүгээрээ John Locke эсвэл David Hume нарт, өнөөгийн гэрээний онол дээр хүртэл (John Rawls) тулгардаг цаашдын хөгжлийн гол асуудлуудыг тодорхойлжээ. Нарийн яривал социологийн онолыг XIX болон XX зууны эхэн үед Karl Marx, Émile Durkheim, Georg Simmel, Max Weber нар

үндэслэсэн юм. Энэ цаг үеэс хойш нийгмийн онолын дөрвөн үндсэн асуудлыг ялган үзэх болсон:

(1) *Байгалийн болон нийгмийн шинжлэх ухаан*: Байгалийн юм үзэгдлээс ялгаатай нь хүмүүсийг ойлгож болдог. Социологичид үйлдлийг нь ойлгож эхлэхээс өмнө хүмүүс өөрсдийн ертөнцөө үргэлж тодорхой арга хэлбэрээр тайлбарлаж ирсэн байдаг. Энэ нь нийгэм, соёлын шинжлэх ухаанд “тайлбарладаг” байгалийн шинжлэх ухаанаас ялгарахуйц “ойлгомжтой” → арга зүй (→ тайлбарлах/ойлгох) боловсруулах үндэслэлийг бүрдүүлсэн. Феноменологийн социологи, → этнометодологи, → символик интеракционизм зэрэг герменевтик хандлагууд (герменевтик = тайлбарлах урлаг) нь хүмүүс өөрсдийн үйлдэл, нийгмийн харилцаандаа тусгадаг → утгад төвлөрч, түүнийг сэргээж, түүнээс онолын загвар боловсруулахыг зөвлөдөг. Байгалийн шинжлэх ухааны үүднээс тайлбарлах боломжгүй байдгийн шалтгаан нь хүний үйлдэл бол байгалийн үйл явдал шиг хуулийн дагуу явагддаггүй, түүгээр тайлбарлагдах аргагүй юм. Нөгөөтээгүүр, юуны өмнө Karl R. Popper (*Logik der Forschung: Zur Erkenntnistheorie der modernen Naturwissenschaft*, 1935)-ын хөгжүүлсэн шүүмжлэлт рационализм нь эсрэгээрээ байгалийн болоод нийгмийн шинжлэх ухааны хооронд ялгаж үздэггүй. Max Weber (*Wirtschaft und Gesellschaft. Grundriß der verstehenden Soziologie*, 1922) нь энэ хоёр харах өнцгийн хослолыг санал болгосон байдаг бөгөөд түүнийгээ “ойлгогдож байгаа тайлбар” гэж нэрлэжээ. Хүмүүсийн үйлдэл, тэдний нийгмийн харилцаанд, тухайлбал, эрх мэдэл, эдийн засгийн

харилцаанд тогтсон зүй тогтол байдаг бөгөөд үүний үндсэн дээр хүний үйлдлийг тайлбарлаж болох боловч энэ нь зөвхөн тухайн зүй тогтлыг үүсгэж байгаа цаад нарийн утгыг нийгэм судлаачид ойлгосон тохиолдолд л боломжтой юм.

(2) *Үнэ цэний эрх чөлөөний асуудал*: Weber («Die Objektivität sozialwissenschaftlicher und sozialpolitischer Erkenntnis», in: *Archiv für Sozialwissenschaft und Sozialpolitik* 19, 1904) социологийг үнэлэмжээс ангид шинжлэх ухаан гэж тодорхойлсон. Хэдийгээр хүмүүс өөрсдийн үйлдлээ үнэлж, тэр үнэлэмжид нь социологи дүн шинжилгээ хийх ёстой боловч социологийн зүгээс эргээд хариу үнэлэлт дүгнэлт өгдөггүй. Ихдээ л янз бүрийн үнэ цэний чиг баримжааны нөхцөл, үр дагавруудыг ил болгоно. Гэвч ямар үнэт зүйлд үнэхээр итгэх хэрэгтэйг хэлж чадахгүй.

Үнэ цэн, мэдлэгийн талаарх энэхүү эсрэг тэсрэг байр суурь 1960-аад оны “позитивизмын маргаан”-аас үүдэлтэй. Popper, Hans Albert, Ernst Topitsch, René König зэрэг шүүмжлэлт рационализмын төлөөлөгчид социологийг норматив эсвэл бодит байдалд шүүмжлэлтэй ханддаг танин мэдэхүйн зорилгод чиглүүлэхээс татгалзаж, тодорхой урьдчилсан нөхцөлийг харгалзан үзээд бодит байдалд тодорхой үйл явдал тохиолдохыг тайлбарлаж болох номологийн (грекээр *nomos* = “хууль”) буюу өөрөөр хэлбэл хууль ёсны мэдэгдлийг олж авах үүрэгтэй гэж үзэж байв. Харин → шүүмжлэлийн онолын төлөөлөгчид (Theodor W. Adorno, Max Horkheimer, Herbert Marcuse, Jürgen Habermas)

үүнийг зөвхөн шүүмжлэлд өртөхүйц нийгмийн нөхцөл байдлыг дахин давтагдахад л хүргэж, улмаар бодит болгох зорилготой гэж эсэргүүцэж байв. Нийгмийн шинжлэх ухаан нь нийгмийн зөрчилдөөнийг илрүүлж, тэдгээрийг чөлөөт харилцаанд хэрхэн шийдвэрлэх тухай саналыг боловсруулах ёстой.

Сүүлийн хэдэн арван жилийн онолын хэлэлцүүлэгт үнэлэмжийн тухай асуудал гагцхүү далд хэлбэрээр оршиж байна. Сүүлийн үеийн хэд хэдэн онолын хөгжилд, коммуитаризмд, шударга нийгмийн төлөөх улс төр, эрх зүйн онолын хандлагад, нийгмийн хөгжлийн жам ёсны хязгаарын талаарх “эрсдэлийн нийгэм” (→ эрсдэл) гэдэг нэрийн дор явагддаг хэлэлцүүлэгт дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх мөчүүд ихэвчлэн зэрэгцэн тохиодог.

(3) *Оролцогч ба системийн онол*: Социологийн эхэн үеэс хойш маргааны сэдэв болж ирсэн нэг үндсэн асуулт бол → оролцогч ба системийн онол (→ систем) буюу индивидуализм ба холизмын тухай юм. Нийгмийн онолын анхдагч тайлбарлах объект нь хүний нийгэм дэх хамтын амьдралын хэлбэрүүд юм. Гэхдээ аль талаас нь эсвэл ямар суурь нэгжээс нийгмийн дэг журмын үүслийг тайлбарлах вэ гэдэг нь маргаантай. Үйлдэл хийгч субъектийг дүн шинжилгээний эхлэл цэгээр сонгон, эндээсээ нийгмийн харилцаа холбоо, дэг журмыг бий болгох ёстой юу? Эсвэл нийгмийн систем анхдагч бөгөөд оролцогч хүн нь түүгээр бүтээгдсэн үү? Социологийн эдгээр үндсэн маргаан дагуулсан асуудлыг эмпирик байдлаар шийдвэрлэхэд бэрх, учир

нь энэ нь эргээд эмпирик өгөгдөл олж авахад нөлөөтэй философийн байр сууринаас хамаардаг юм.

Системийн онол (Talcott Parsons, Niklas Luhmann) биологийн салбараас чухал зөвлөмжийг хүлээн авсан байдаг: Зөвхөн бүхэл организм доторх чиг үүрэг, байрлалыг нь таньж байж л бие даан орших эд эс, эрхтнүүдийг тодорхойлох боломжтой байдгийн адилаар нийгмийн хүрээнд системийг дүн шинжилгээний анхдагч нэгж гэж үздэг. Энд байгаа гол ялгаа нь “систем → орчин” юм. Хуучин системийн онолууд “бүтэн-хэсэг” загвараар ажилладаг байсан. Оролцогчийн онол “үйлдэгч–нөхцөл байдал” гэсэн ялгааг ашигладаг. Энэ нь нэг бол зорилготой, үнэлэмжтэй үйлдэл хийдэг оролцогчийн загварт хөтөлсөн ухамсрын философи дээр суурилдаг (Weber, → оновчтой сонголтын онол, үйлдэл), эсвэл ойлголцох үйл явцыг эн тэргүүнд тавьдаг социологийн оролцогчийн хэл-философид үндэслэгдсэн (Georg Herbert Mead, Habermas, → симболик интеракционизм). “Систем-орчин”, “үйлдэгч–нөхцөл байдал” гэсэн гол чиглүүлэгч ялгаанууд нь социологичдод судалгааны явцад юун дээр анхаарах, нийгмийн үзэгдлийг хэрхэн тайлбарлах талаар баримжаа олгох аналитик удирдамжийг өгдөг.

(4) *Микро, макро асуудал*: Хүн төрөлхтний хамтын оршихуйн хэлбэрүүд нь нийгмийн энгийн нэг харилцаанаас (микро) эхлээд → олон зохион байгуулалтууд (месо)-ыг дамжин иж бүрэн тогтолцоонд (макро) хүрдэг. Нийгмийн онолын гол асуудал бол эдгээр түвшний хоорондын уялдаа холбоог тодруулах

явдал юм. Микро-макро хамаарал нь тухайн сонгогдсон чиглүүлэгч ялгаанаасаа хамаараад тус бүртээ өөр өөр концепттой байдаг: Системийн онол нь нэг системийн түвшнийг нөгөө системийн түвшнээс гаргаж авах боломжгүй байх өөр хоорондоо нөлөөлтэй → харилцан үйлчлэл, зохион байгуулалт, нийгмийн системүүдийг ялгаж үздэг. Харин оролцогчийн онол нь оролцогчийн үйлдлүүдийн жагсаалт, дүрмээс бүрдсэн нийгмийн дэг журмыг тайлбарлахыг оролддог. Нийгмийн дэг журмын бүх үзэгдэл оролцогчийн үйлдлээс улбаатай байх ёстой юу эсвэл шинээр гарч ирж буй үзэгдлүүд байгаа эсэх, өөрөөр хэлбэл нийгмийн түвшин нь өөрийн замыг хөөгөөд үйлдлийн түвшнээр тайлбарлах боломжгүй болох эсэх нь маргаантай юм. Нийгмийн онолын үндсэн дөрвөн асуудал социологийн түүхэнд үргэлж ижил эрчтэйгээр эсвэл маргаантайгаар хэлэлцэгдэж байгаагүй ч үргэлж эдгээр асуудал байсаар ирсэн, цаашдаа ч онолын хэлэлцүүлгүүдийг бүрдүүлэх болно. Одоогийн байдлаар тодорхой парадигмууд, ялангуяа рационал сонголтын онол, системийн онолууд дээр мэргэжлийн универсал нэгдсэн нийгмийн онол гаргах шаардлага үүсээд байгаа. Энэ оролдлого амжилт олох эсэх нь эргэлзээтэй, учир нь дээрх үндсэн дөрвөн асуудал тус бүрд байгаа сонголтуудыг хялбархан нэг чиглэлд оруулж шийдэх боломжгүй юм.

Thomas Schwinn

Max Haller: Soziologische Theorie im systematisch-kritischen Vergleich. Opladen 1999, ²2006.

Wolfgang Ludwig Schneider: Grundlagen der soziologischen Theorie. 3 Bde. Wiesbaden 2002–04.

Hans Joas / Wolfgang Knöbl: Sozialtheorie. Zwanzig einführende Vorlesungen. Frankfurt a. M. 2004, ²2006.

Нийгмийн сэтгэл судлал/Нийгмийн антропологи (Sozialpsychologie/Sozialanthropologie)

XIX зууны хоёрдугаар хагасаас анх эхэлснээсээ хойш “нийгмийн сэтгэл судлал” нь сэтгэл судлал, нийгэм, соёлын шинжлэх ухааныг холбох зорилготой салбар дундын хөтөлбөр гэж тодорхойлогдож байсан. “Нийгмийн сэтгэл судлал” (латинаар *socius* = “хамтдаа”, “холбогдсон”; грекээр *psyche* = “сэтгэл”) гэдэг үг нь сэтгэл зүй болоод нийгмийн нэгдмэл байдлыг онцолдог.

Нийгмийн сэтгэл судлалын анхны ойлголтоор “нийгэм”-ийн ертөнц нь дотроо “соёл”-ыг багтаах бөгөөд хоёр хэсэгт хуваагддаг. Нэг талаас энд хувь хүмүүсийн хоорондох харилцан холбоог, өөрөөр хэлбэл, → харилцан үйлчлэл ба → харилцаа холбоог, нөгөө талаас хувь хүнээс хальсан коллектив бүрдэл ба → бүтцийг хамруулдаг. Нийгмийн сэтгэл судлал нь юуны түрүүнд үзэл санаа, бүтцийн “зөөлөн” бүрдэл хэсгийг сонирхдог: нийгмийн → хэм хэмжээ, үнэ цэн, санаа, олон нийгмийн санаа бодол, мэдрэхүйн коллектив хэв маяг,

санах, сэтгэх, үзэх, мэдрэх. Нийгмийн сэтгэл судлалын асуудал нь хоёр талтай. Сэтгэл зүй–нийгмийн тал нь харилцан үйлчлэл, харилцаа холбоогоор дамжих хувь хүмүүсийн үйл ажиллагаа нь хувь хүнээс давсан бүтэц, бүрэлдэхүүнийг хэрхэн бий болгодог вэ гэсэн асуултыг авч үздэг. Нийгэм–сэтгэл зүйн тал нь эсрэгээрээ хувь хүнээс давсан бүтэц, бүрэлдэхүүн хувь хүнд хэрхэн нөлөөлдөг тухай асуулттай холбогддог. Үүний тодорхой нэг жишээг хэл бүрдүүлэх ба хэл нь хувь хүмүүст нийгэм–соёлын хүрээ болж өгөгдөхийн зэрэгцээ хувь хүмүүсийн харилцан үйлчлэл, харилцааны явцад хүн бүрийн ярианы үйлдлээр бүтээгдэж, өөрчлөгдөж байдаг.

Хүмүүнлэгийн болон нийгмийн шинжлэх ухааны их сургуулийн хичээлүүдийг ялгаж салгаснаар нийгмийн сэтгэл судлал нь хэд хэдэн нийгмийн судлалд хуваагдсан байдаг. Сэтгэл судлал дахь нийгмийн сэтгэл судлал бол хувь хүн, харилцан үйлчлэл, жижиг бүлгүүдийн хоорондын харилцааг яг туршилтын → аргуудыг ашиглан судлах тал дээр мэргэшсэн байдаг. Харин үүний нөгөө талд тайлбарлах болон эмпирик судалгааны аргуудыг голчлон баримталдаг социологи, угсаатны зүй, түүхэн нийгмийн сэтгэл судлал гэж бий. Эндээс судалгааны үндсэн хоёр чиглэл гарч ирдэг: Нийгмийн бүтэц ба хувь хүний судалгаа нь → нийгэм болон үндэсний → соёлын харьяалал, мөн нийгмийн доторх соёл, → анги, давхарга, нийгмийн салбарууд (жишээ нь, → эдийн засаг, улс төр, хууль, шашин, соёл)-ын хамаарал нь хувь хүнд

буюу → хабитуст хэрхэн нөлөөлдөг болохыг судалдаг. Түүхэн сэтгэл судлалын менталитет ба хабитусын судалгаа болон угсаатны сэтгэл судлалын соёл, хувь хүний судалгаанууд нь мөн дээрхтэй төстэй асуудлыг хөндөн судалдаг байна. → Символик интеракционизм нь харилцан үйлчлэлийг сэтгэл зүйн материаллаг ба материаллаг бус урамшуулал, шийтгэлийн солилцоо байдлаар судалж, сэтгэл судлалд үндсэндээ суурилах солилцооны онолыг орлодог (→ рациональ сонголтын онол). Энд хувь хүмүүс харилцан үйлчлэлийн үед нийтлэг утгыг (→ бэлгэ тэмдэг) хэрхэн бий болгож, энэ нь эргээд тэдний зан төлөвт юм уу эсвэл өөрт нь яаж нөлөөлж болохыг судалдаг (Sheldon Stryker, *Symbolic Interactionism. A Social Structural Version*, 1980). Сэтгэл судлал дахь нийгмийн сэтгэл судлал, түүх-нийгмийн шинжлэх ухааны нийгмийн сэтгэл судлалууд нь нэг нэгнээсээ тусгаарлагдахын хэрээр сэтгэл зүй ба нийгмийн, өөрөөр хэлбэл хувь хүн, нийгэм, соёлын нэгдмэл байдалд чиглэсэн хараа нарийсдаг. Сүүлийн үед нийгмийн сэтгэл судлалууд эргээд нэг нэгэндээ ойртож байна. Үүнтэй зэрэгцээд эртний нийгмийн сэтгэл судлалын салбар хоорондын шинжлэх ухааны хөтөлбөрийг сэргээхийг хүссэн саналууд мөн олшрох болжээ (*The Future of Social Psychology*, hrsg. von Cookie W. Stephan [u. a.], 1991; Uwe Laucken, *Individuum, Kultur, Gesellschaft*, 1994; Helmut Nolte, »Sozialpsychologie als integrierende Perspektive. Versuch einer Ortsbestimmung«, in: *Zeitschrift für Sozialpsychologie* 25, 1994).

Тэдний дотор салбар хоорондын шинжлэх ухааны

хөтөлбөрт хамрагдах хүсэлтийг гаргасан өөр нэгэн шинжлэх ухаан бол нийгмийн антропологи юм. Энэ салбар нь нийгэм, соёлын шинжлэх ухааныг хүний тухай шинжлэх ухаан болох антропологи (грекээр *anthropos* = “хүн”)-той хослуулдаг. Эртний нийгмийн сэтгэл судлалын шинжлэх ухааны хөтөлбөр нь XIX зууны хоёрдугаар хагас дахь хүмүүнлэгийн ухааны сэтгэл судлалын үзэл баримтлалтай нийцэж байсан бол өнөө цагт хүн, нийгэм, соёлын шинжлэх ухааныг “хүний судлалын шинжлэх ухаан” гэсэн нэр томъёоны дор нэгтгэсэн үзэл баримтлал газар авч байх шиг санагдана (Norbert Elias, »Adorno-Rede. Respekt und Kritik«, in: N. E. / Wolf Lepenies, *Zwei Reden anlässlich der Verleihung des Theodor W. Adorno-Preises* 1977, 1977). Эртний нийгмийн сэтгэл судлалаас улбаатай “нийгмийн түүхэн сэтгэл судлал” (*Die Geschichtlichkeit des Seelischen*, hrsg. von Gerd Jüttemann, 1986) 1970-аад оноос хойш “түүхэн антропологи” (*Historische Anthropologie*, hrsg. von Hans Süssmuth, 1984) гэсэн нэртэйгээр үргэлжилж байгаа нь энэхүү өөрчлөлтөд нийцэж байгаа юм.

Нийгмийн антропологиогийг Англи улсад аль эрт салбар дундын шинжлэх ухаан болгон хэрэгжүүлсэн байдаг. Энэ нь Америкт нэгэн үе *Social Anthropology* болон *Cultural Anthropology* хоёрын дунд ялгаа бий болгож байсан хуучны нийгэм, соёлын хязгаарлалтыг давж гарснаар *Cultural Anthropology* гэсэн загвараар амжилттай хэрэгжсэн. Германд “нийгмийн антропологи” гэсэн нэр томъёо аажмаар тархаж байна. 1970-аад оныг хүртэл энд Германы угсаатны зүй, угсаатан судлал,

хүмүүнлэгийн шинжлэх ухааны болон философийн антропологийн уламжлалыг нэгтгэсэн “соёлын антропологи” гэдэг нэршил давамгайлж байв. Германы “нийгмийн антропологи” гэдэг нэршлийг өнөөдөр Британийн *Social Anthropology*, Америкийн *Cultural Anthropology*, Германы *соёлын антропологиос* гадна бас түүхэн антропологийн сүүлийн үеийн уламжлалыг нэгтгэснээр ашиглаж болно. Антропологийн салбар болохын хувьд нийгмийн антропологи нь нэг талаас хүний амьдралын нийгэм-соёлын хэлбэрийн олон талт байдлыг харуулдаг. Нөгөөтээгүүр, энэ нь олон талт байдалд хүн болж оршихуйн нийтлэг чанарыг танин мэдэж, ингэснээр хүний зайлшгүй эрх, хүний үнэ цэнтэй чанарын талаар дүгнэлт гаргахад тусалдаг юм (*Der Mensch – ein politisches Tier? Essays zur politischen Anthropologie der Menschenrechte*, hrsg. von Otfried Höffe, 1992; Martha C. Nussbaum, *Gerechtigkeit oder Das gute Leben*, 1999).

Helmut Nolte

Hans-Georg Gadamer / Paul Vogler (Hrsg.): Sozialanthropologie. Stuttgart 1972.

Frank Robert Vivilo: Cultural Anthropology Handbook. New York [u. a.] 1978. – Dt.: Handbuch der Kulturanthropologie. Übers. von Erika Stagl. Stuttgart 1981, ²1995.

Lorenz Fischer / Günter Wiswede: Grundlagen der Sozialpsychologie. München/Wien 1997, ²2002.

John D. DeLamater (Hrsg.): Handbook of Social Psycholo-

gy. New York [u. a.] 2003, Neuausg. 2006.
 Christian Thies: Einführung in die philosophische Anthro-
 pologie. Darmstadt 2004.

Нийгэм (Gesellschaft)

“Нийгэм” (англиар *society*; францаар *société*) гэдэг нэршил нь бүх бусад нэгжүүдийг нэгтгэсэн хамгийн том нийгмийн нэгжийг тодорхойлдог. Энэ нь дэлхий ертөнцийн өөрчлөгдөшгүй хатуу дэг журамтай нийцэхээ больсон түүхэн туршлага дээр үндэслэсэн. Нийгэмд амьдрах нь дэлхийг зохион байгуулалтад оруулах боломж, түүхэн өөрчлөлтийн туршлагыг харуулдаг. Энэхүү туршлагын гурван нэр бүхий түүхэн эх сурвалжийг Thomas Hobbes-ийн “Левиафан”¹² (*Leviathan* 1651, dt. 1794), Jean-Jacques Rousseaus-ын “Нийгмийн гэрээ” (*Du contrat social* 1762, dt. 1763), Georg Wilhelm Friedrich Hegel-ийн “Эрх зүйн философийн зарчмууд” (*Grundlinien der Philosophie des Rechts*, 1821) гэх бүтээлүүд бүрдүүлнэ. Левиафанд нийгэм нь → хувь хүмүүс бусдын халдлагаас хамгаалахын тулд өөрийн бүрэн эрхийнхээ нэг хэсгийг → төрд даатгаж, улмаар нийгмийн дэг журамд өөрийн хүслээр захирагдах виртуал гэрээ хэлбэрээр тодорхойлогддог. Rousseau *Нийгмийн гэрээ*-дээ мөн гэрээний онолын загварыг

¹² Английн философич, төрийн онолч Томас Хобсын 1651 онд гаргасан, барууны улс төрийн философийн алдартай бүтээлүүдийн нэг, шинэ цагийн улс төрийн шинжлэх ухааны онолын үндэс болдог. Эх сурвалж: [https://de.wikipedia.org/wiki/Leviathan_\(Thomas_Hobbes\)](https://de.wikipedia.org/wiki/Leviathan_(Thomas_Hobbes))

дэвшүүлсэн байдаг ч хамгаалагдах хэрэгцээ, аюулаас сэргийлэх гэсэн утгаар бус харин нийгэмдээ эв нэгдэл, нийтлэг би (*moi commun*)-г түгээх нийтлэг хүсэл зоригийг (*volonté générale*) уриалсан шинжтэй юм. Эцэст нь Hegel-ийн хувьд иргэний нийгэм бол хувь хүмүүсийн уулзах газар бөгөөд тэд энд хувийн ашиг сонирхол бүхий иргэн хүнийхээ үүднээс ирдэг. Төр нь “уламжлалт үзэл санааны бодит байдал” гэдэг утгаараа хувь хүний хүсэл сонирхлыг хазаарлах, иргэдээс захирагдахыг шаардах бөгөөд энэхүү захиргаадалтыг өөрөө хэрэгжүүлдэг болохоор үүнийг → эрх чөлөө гэж хардаг.

Социологийн өмнөх эдгээр онолын хэлбэрүүдэд нийгмийн дагалдах асуудал харагддаг: янз бүрийн сонирхол, үзэл бодол, зорилго, төсөөлөлтэй чөлөөт үйл ажиллагаа эрхэлдэг хүмүүсийг хэрхэн бүтээлч хүсэлтэй, бүтээх боломжоор хангагдсан нийгмийн холбоо болгож болох вэ?

“Нийгэм” гэдэг ойлголтод энэхүү дагалдах асуудлыг социологийн үүднээс → интеграциар шийдэж болох ялгарлын (→ ялгах) асуудал гэж үргэлж үздэг байв. Социологийн өмнөх сонгодог онолууд интеграцийн энэ асуудлыг үндсэндээ улс төрийн дэг журмаар (Hobbes) эсвэл ухаалаг нийтлэг шинж чанарын тухай хийсвэр ойлголтоор (Hegel) шийдвэрлэхийг зорьдог байсан бол → социологи нь анхнаасаа ялгах эмпирик туршлагуудыг хийж байв.

Émile Durkheim (*De la division du travail social*, 1893, dt. 1977) төдийгүй Max Weber (*Gesammelte Aufsätze zur Religionssoziologie*, 3 Bde., 1920/21)-ийн хувьд ч “нийгмийн”

тухай санаа нь түүний нэгдмэл байдлыг хэрхэн дотоод ялгарал, хөдөлмөрийн хуваарилалт, нийгмийн тэгш бус байдлын хамт бодолцож үзэх вэ гэдэг асуулттай нягт холбоотой байв. Durkheim, орчин үеэс өмнөх нийгэмд ижил төстэй байдлын зарчим үйлчилдэг байхад харин орчин үеийн нийгэмд өндөр зэрэглэлийн хөдөлмөрийн хуваарилалт (→ хөдөлмөр) гарч ирсэн гэдгийг, өөрөөр хэлбэл, нийгэм олон янзын байдлаар тодорхойлогдож болохыг харуулсан. Түүний нийгмийн онолын суурь асуулт: ийм нийгэмд юуны түрүүнд шашийн шүтлэгээс хамааралтай байсан эртний хамтын ухамсрыг юугаар нөхөх вэ? Түүний хариулт: нийгмийн ялгаатай хэсгүүдийг нэгтгэж чадахуйц хийсвэр хэм хэмжээ, үнэ цэн бүхий хамтын үр нөлөөтэй ёс суртахуунаар. Энэхүү илүү *функционалист* утгаар сонгодог гэрээний онолд байдаг шиг хувь хүний эсвэл нийтийн хүсэл сонирхолд хандахаа больж, харин организмын зүйрлэл гэдэг үүднээс нийгмийн янз бүрийн хэсгүүд хоорондоо зохицоход анхаардаг. Weber үл нийцэх (улс төр, эдийн засаг, шашин шүтлэг, урлагийн) эрхэмж бүхий үнэ цэний орон зай дахь ялгааг дүгнэхдээ төстэй дүр зургийг олж харсан хэдий ч нийгмийн интеграцийн чадавхад итгээгүй, харин гагцхүү үл нийцэх эрхэмж бүхий үнэ цэний орон зайг, энэхүү “бурхдын зөрчилдөөн”-ийг өөрөө өөртөө тэсвэрлэх чадвартай хүчирхэг бие хүнийг бий болгоход л итгэж байв. Эцэст нь тэрээр “нийгэм” гэдэг нэр томьёоноос татгалзсан. Энэ нь социологийн нийгмийн тухай ойлголт ялгарагсдыг интеграцчилах үзэл санаатай, олон талт

нөхцөлд нэгдмэл байх тухай үзэл санаатай хэр хүчтэй холбогдсон байгаагаас харагддаг. “Нийгэм” гэдэг ойлголтод нэг талаас ялгаралтай байдал, хөдөлмөрийн хуваарилалт, үл нийцтэй байдал, нөгөө талаас эдгээр асуудлыг даван туулах гэсэн хоёр төрлийн үзэгдэл хоёулаа агуулагддаг. Энэ асуудлын сонгодог шийдэл бол норматив интеграцчиллын үзэл санаа юм.

Үүний оргил цэг, өнөөг хүртэлх хамгийн нэр бүхий шийдэл бол Talcott Parsons-ын нийгмийн онол юм. Parsons (*The System of Modern Societies*, 1971, dt. 1972) “нийгэм”-ийг хамгийн том бие даасан нийгмийн → тогтолцоо гэж тодорхойлсон. Энэ онол нь нийгмийн үндсэн функцүүдийн хоорондох солилцооны үйл явцаар дамжуулаад цогц нийгмийг хэрхэн бүх тогтолцоог нь интеграцчилах боломжтойгоор зохион байгуулж болохыг сонирхдог (→ функционализм). Нийгэмд Parsons “нийгмийн хамтын нийгэмлэг”-ийг (*societal community*) интеграцийн чиг үүрэгтэй гэж тодорхойлсон бөгөөд ингэхдээ Ferdinand Tönnies (*Gemeinschaft und Gesellschaft*, 1887)-ээс гаралтай хоёр ялгаатай нэр томъёог ашигласан. Tönnies-ийн хувьд нийгэм нь хувийн харилцаа, хотжилт, хөдөлмөрийн нарийн хуваарилалтын кодыг илэрхийлдэг бол → хамтын нийгэмлэг нь орчин үеэс өмнөх, жижиг хотын эсвэл орон нутгийн ижил төстэй хэв маяг, сэтгэл санаагаараа холбогдсон байдлыг төлөөлдөг. Parsons энэ хоёр элементийг хоёуланг нь авч үзээд эндээс нийгмийн үйл явцын нийтлэг элементийг нь эрэлхийлж байв. Социологийн энэхүү шийдэл хэдийгээр олон

янзын шүүмжлэлд өртөж байсан ч өнөөг хүртэл энэ чиглэлийн үндсэн нэр томьёог бүрдүүлсээр байна. Энэ нь өөртөө итгэлтэй барууны үндэстэн улсыг тусгадаг бөгөөд эцсийн дүндээ дэг журмыг зөвхөн төр-улс төрийн хувьд хязгаарлагдмал орон зайд хэм хэмжээний ерөнхий хүрээнд л төсөөлж болно гэсэн түүхийн уламжлалд оршино. Социологид “нийгэм” гэдэг ойлголтыг үндэсний нийгмээс салгахад яагаад одоо болтол ийм хэцүү байдгийг хайх шалтгаан энд бас байна. Европын үндэстэн, улсууд бүрэлдсэн түүхийн туршлагатай зэрэгцээд “нийгэм” гэдэг нэр томьёо улс төрийн нэр томьёо болж тогтсон. Ингэснээр нийгэм нь үндэсний интеграцчиллын тухай, нийгмийн асуудлын талаар, мөн үүгээр ч зогсохгүй соёлын хамаарлын тухай олон нийтийн хэлэлцүүлгийг өрнүүлдэг талбар юм (→ олон нийт). Тиймээс “нийгэм”-ийн хил хязгаарыг үндэстний хил хязгаартай адилтгах нь ойлгомжтой юм.

Энэхүү хандлага өнөөдөр үнэмшилтэй байхаа больсон. Юуны өмнө нийгмийн бүтэц үндэсний хил хязгаарыг давж гарч байгааг анзаарахгүй байхын аргагүй (жишээлбэл, дэлхийн эдийн засгийн үйл ажиллагаа, улс төрийн үндэстэн дамнасан хэв маяг, шинжлэх ухааны судалгааны даяаршсан хэлбэр, дэлхийн шашнууд). Даяаршлын онол социологид (жишээ нь, Anthony Giddens, *Consequences of Modernity*, 1990, dt. 1995) мөн тусгалаа олж эхэлсэн хэдий ч ихэнхдээ Giddens-ийн нэгэн адил нэр томьёоны хувьд үндэстэн улсын нийгмийн тухай ойлголтыг баримталсан хэвээр байна.

1970-аад оноос хойш “нийгэм” гэсэн нэр томьёог

бүс нутгийн агуулгаас нь салгасан. Үүний парадигм болохуйц хоёр бүтээл бол Niklas Luhmann («Die Weltgesellschaft», in: *Archiv für Rechts- und Sozialphilosophie* 57, 1971) болон John W. Burton (*World Society*, 1972) нарынх юм. Аль аль нь нийгмийн амьдралыг зөвхөн улс төрийн утгаараа улсын хилтэй холбож болно гэж үздэг. Ирээдүйн нийгмийн онолын асуудлууд нь даяаршсан ертөнцийн яг шинэ биш ч бас шинэ хэвээр байгаа, урьд өмнө байгаагүйгээрээ радикал болсон харилцан хамаарлыг шударгаар хийж чадах эсэхээр хэмжигддэг байх ёстой. Үүний зэрэгцээ нийгэм нь дэлхийн нийгэм болохын хувьд XIX зууны уламжлалаар үндэстэн улстай холбоотон болдог байсан интегратив, норматив нэгтгэгч механизмд захирагдахаа больсон гэдгийг тэд ухаарах ёстой. Социологи нь зарим талаараа “нийгэм” (Ulrich Beck, «The Cosmopolitan Perspective: Sociology of the Second Age of Modernity», in: *British Journal of Sociology* 51, 2000) гэдэг нэр томъёог дахин улс төржүүлсэн хариу үйлдлийг үзүүлэхдээ улс төрийн норматив интеграцийг шийдэх түүхэнд туршигдсан стратегийг барьдаг. Хариу үйлдлийн өөр нэг хэлбэрийг сүүлийн үед Pierre Bourdieu (*Le sens pratique*, 1980, dt. 1987) эсвэл Niklas Luhmann (*Die Gesellschaft der Gesellschaft*, 1997) нарын танилцуулсан бүтээлүүдээс ажиглаж болно. Иймэрхүү онолууд нь нийгмийн нэгдмэл байдлын тухай санаанаас эхэлдэггүй, харин практик болон үйл ажиллагааг судлахаас эхэлдэг. Bourdieu Weber-ийн нэгэн адил нийгмийн талаар нарийн үзэл баримтлал боловсруулаагүй ч тэрээр нийгмийн дэг журам бол

ялгаатай зүйлүүд үргэлж л интеграцчилагддаг гэсэн баримтад суурилаагүй шинэ туршлагынхаа талаар тодорхой тайлбарласан. Энэ талаар Bourdieu-ийн хэлснээр, энэ бол илүүтэй тодорхой практик үйл ажиллагаа, эрх мэдлийн стратеги, нийгмийн орон зайд явуулж буй тэмцэл, нөлөөлөх боломжийн төлөө өрсөлдөх тухай яриа юм. Харин Luhmann нийгмийн тухай илүү дэвшилтэд байдлаар онолыг боловсруулсан. Нийгэм гэдэг бол энд зөвхөн нийгмийн бүх үйл явцын нэгдэл бөгөөд янз бүрийн логик, чиг үүргийн тогтолцоог (→ эдийн засаг, улс төр, шинжлэх ухаан, хууль, шашин гэх мэт) ялгаж салгаж, зөвхөн тодорхой цаг үед, тус бүр зөвхөн хааяа нэг гүйцэтгэлийн ажиллагаанд нэгдмэл байдлыг бий болгодог гэж үзсэн. “Нийгэм”-ийн тухай энэхүү ойлголт нь нийгмийг норматив интеграциар нэгтгэгдсэн нэгдмэл байдал гэж харагдуулдаг сонгодог ойлголтоос татгалздаг. Эцсийн дүндээ энэхүү ойлголтоор “нийгэм” нь тухайн мөчид суурилсан нөхцөл байдлын хувьд практик шийдлүүд үргэлж байдаг болохоор л зөвхөн нэгддэг байна.

Armin Nassehi

Uwe Schimank: Theorien gesellschaftlicher Differenzierung. Opladen 1996,³2006.

Susanne Lüdemann: Metaphern der Gesellschaft. München 2004.

Armin Nassehi: Der soziologische Diskurs der Moderne. Frankfurt a. M. 2006.

Нийгэмшил (Sozialisation)

“Нийгэмшил” гэдэг нь хүн байгалиас заяасан чадвар (бие, сэтгэлийн үндсэн шинж чанарууд) болоод → хүрээлэн буй орчинтойгоо (соёл, эдийн засаг, нийгмийн хүрээнд, цаашлаад бие мах бодийн амьдралын нөхцөл) үр бүтээлтэй байдлаар тулгарах замаар хувь хүний зан чанарыг хөгжүүлэх үйл явц юм. Нийгэмших явцад хүн хүсэл зориг, хэрэгцээ, төрөлхийн темперамент, хувийн зан чанар зэрэг генетик өгөгдлийнхөө тусламжтайгаар өөрийгөө эргэцүүлэн бодох, → нийгэм, → соёл, → эдийн засаг, экологийн шаардлагыг хангаж чадах ижилсэх чадвараа хадгалах чадвартай → субъект болж өөрчлөгддөг. Нийгэмшлийн онол, судалгаа нь юуны түрүүнд хүн хувийн зан чанараа чөлөөтэй, бие даасан байдлаар хөгжүүлж, ижилсэх хандлага нь баталгаажихад нийгмийн ямар нөхцөлүүд өгөгдсөн байх ёстой вэ гэдэг асуудлыг авч үздэг. Нийгэмшил гэдэг нэр томъёог анх удаа нийтлэг хэлээр Оксфорд толь бичигт (*Oxford Dictionary* 1828) “нийгмийн харилцаанд оруулах, нийгэмд амьдрах чадвартай болгох” гэж нь тодорхойлсон байдаг (John A. Clausen, *Socialization and Society*, 1968). Герман хэлэнд “нийгэмшил” гэдэг үг 1960-аад онд нийгмийн шинжлэх ухааны хэлэлцүүлэгт танилцуулсны дараа л нэвтэрсэн бөгөөд ерөнхийдөө мэдлэг, ур чадварыг нэг үеэс дараагийн үедээ өвлүүлэх, мөн өсвөр насныхныг нийгэмд бэлтгэн оруулах үйл явцыг тодорхойлдог. Энэхүү ойлголт нь “нийгэмшил”-ийг “хүний байгалийн

чанарыг нийгэмшүүлэх” гэж тодорхойлсон Émile Durkheim (*Éducation et sociologie*, 1907, dt. 1972)-ын үзэл баримтлалтай нийцдэг. Durkheim-ын хэлснээр, зөнгөөрөө, хувиа хичээсэн, нийгмээс гажууд хүнийг нийгмийн албадлагын механизмаар дамжуулан нийгэмд орох чадвартай нийгмийн оршихуй болгодог. Нийгэмшлийн талаарх энэхүү дасан зохицох механизмын тухай ойлголтын ач холбогдол хожим нь багассан. Энэ нь тодорхой хэжээгээр Talcott Parsons-ын бүтцийн функциональ онол (*The Social System*, 1951), илүү тогтвортойгоор George Herbert Mead (*Mind, Self and Society*, 1934, dt. 1973)-ын харилцан үйлчлэлийн онол (→ харилцан үйлчлэл) болон Albert Bandura-ын нийгэмд чиглэсэн сургалтын онолууд (*Social Learning Theory*, 1977, dt. 1979) зэрэг арга хандлагууд гарч ирсэнтэй холбоотой. Эдгээр онолын түлхцийн нөлөөний үр дүнд “нийгэмшил”-ийн талаарх албадан интеграцчилахад чиглэгдэж байсан хязгаарлагдмал ойлголтоос салж, *нийгэмшүүлсэн субъектив чанарын үзэл баримтлал руу* (Dieter Geulen, 2005) хөгжих болсон. Нийгэмшилд санаатай, санаандгүй, бүтцийн хувьд бэлтгэгдсэн эсэхээс үл хамааран хувь хүний хөгжлийн бүх түлхцийг (ялангуяа, хүмүүжил, → боловсрол) хамруулдаг. 1960-аад оноос хойш Герман улсад өргөн хүрээг хамарсан, салбар дундын чиг баримжаатай нийгэмшлийн судалгааг хөгжүүлж байна. Эхний ээлжид гол судлах зүйл бол нийгэмших орчны судалгаа буюу юуны түрүүнд → гэр бүлийн чиг үүрэгт анализ хийх явдал байв. Наад зах нь хүний амьдралын

эхний арван жилд гэр бүл нь хүүхдийн хөгжлийн үе шатыг даван туулахад шаардлагатай бүх чадваруудыг зохицуулах давамгай үүрэгтэй инстанци байдаг. Гэр бүлийн энэхүү нийгэмшүүлэх нөлөө нь хүүхдийг өсвөр насанд шилжих үед, үе тэнгийнхний бүлэг, чөлөөт цагаа өнгөрүүлэх газар, түүний дотор хэвлэл, мэдээллийн хэрэгсэл (→ мэдээллийн хэрэгсэл) өсвөр насныхны зан төлөвт хүчтэй нөлөө үзүүлэх үеэс багасаж алга болдог. Түүхээс харахад цэцэрлэг, сургууль, мэргэжлийн боловсролын байгууллага, их сургууль зэрэг албан ёсны нийгмийн хүмүүжил, боловсролын үдэд өсөж бойжиж буй хойч үеийнхний өдөр тутмын болоод амьдралын хэв маягийн улам их цаг хугацаа зарцуулагдаж, улмаар гэр бүлийн нөлөөг багасгадаг байна. 1900 оны үед сурах үүргийг хуульчилж өгснөөс хойш “сургууль” нь хүүхдүүдийг нийгэмшүүлэх маш хүчтэй байгууллага болжээ. Энэ нь өөр хоорондоо шаталсан үүрэг хариуцлага, харилцаа (→ харилцаа холбоо)-ны бүтэц бүхий томоохон нийгмийн тогтолцоог харуулсан зан чанар, харилцан үйлчлэл, харилцааны цогц чадварыг шаарддаг.

Орчин үеийн өндөр хөгжилтэй бүх нийгэмд хүүхдүүдийн сургуулийн амжилтыг зөвхөн хүүхдийн төдийгүй түүний бүхэл гэр бүлийн нийгмийн статусыг баталгаажуулах шийдвэрлэх чухал урьдчилсан нөхцөл гэж үзэж байна. Үүгээрээ сургуульд сурах үеийн амьдралын түүхэн ач холбогдлыг нэмэгдүүлэхээс гадна нийгэмшлийг чухалчилж байгаа явдал юм. 1960-аад оноос хойш хүүхэд залуучуудын ур чадварын хөгжил,

сургуулийн амжилтад үзүүлэх давхаргаас хамаарах нөлөөллийг судлах системтэй судалгаа илүү эрчимжсэн байдаг (Schichtenspezifische Sozialisationsforschung; Matthias Grundmann, *Familienstruktur und Lebensverlauf*, 1992). Олон улсын харьцуулсан судалгаагаар Германд хүүхдүүдийн сургуулийн амжилтад нийгмийн гарал үүсэл харьцангуй хүчтэй нөлөө үзүүлдэг болохыг харуулсан («PISA»-Studien seit 2000). Энэ нь судалгааны энэ чиглэлийг дахин урагшлуулахад хүргэсэн юм. Судалгааны хоёр дахь гол чиглэл нь хүний амьдралын түүхэнд нийгэмших үйл явцын өөрчлөлтөд гарч ирдэг. Амьдралын эхний үе “хүүхэд нас”-нд хүний субъектив чанарын бүрэн байдлыг хангахын тулд хөгжлийн гол даалгавруудыг (Robert J. Havighurst, *Developmental Tasks and Education*, 1948) биелүүлж гүйцэтгэх шаардлагатай юм. Өндөр хөгжилтэй бүх нийгэмд илүү эрт эхэлдэг болоод байгаа бэлгийн бойжилтын үеийг уртасгадаг үе шат буюу 15 нас хүртэлх жилийн амьдралыг багтаах өсвөр нас бол хүүхэд насны хараат үе ба бие дааж насанд хүрэх үе хоёрын дундах шилжилтийн үе гэж тодорхойлогддог. Нийгэмшлийн судалгаа нь амьдралын эдгээр эхний хоёр үе шатанд ихээхэн ач холбогдол өгдөг хэдий ч амьдралын насжилт уртсахын хэрээр, мөн амьдралын явц дахь хувь хүний үйл явцын динамикийг харгалзан “насанд хүрэгчид” болон “ахмад настнууд”-ыг ч бас судалгааны арга зүйд улам бүр татан оролцуулдаг болж байна.

Klaus Hurrelmann / Dieter Ulich (Hrsg.): Neues Handbuch der Sozialisationsforschung. Weinheim/Basel 1980, 62002.

Klaus Hurrelmann: Einführung in die Sozialisationstheorie. Weinheim/Basel 1986, 92006.

Klaus-Jürgen Tillmann: Sozialisationstheorien. Reinbek 1989, 142006.

Matthias Grundmann: Sozialisation. Skizze einer allgemeinen Theorie. Konstanz 2006.

Ноёрхол (Herrschaft)

“Ноёрхол” (англиар *authority, domination*; латинаар *dominium, auctoritas* = “хүчин төгөлдөр байх”, “нөлөөтэй”, → “эрх мэдэл”) гэдэг нь социологид захирах ба захирагдах хууль ёсны хэлбэрүүдийг хэлнэ. Мах Weber өөрийн шийдвэрлэх тодорхойлолтдоо “ноёрхол”-ыг “эрх мэдэл”-ээс ялгаж өгсөн. Weber-ийн хэлснээр, эрх мэдлийн онцгой хэлбэр болсон ноёрхол нь хүлээлтэд нийцэхүйц, утга санаагаар авцалдсан тушаалын биелэлт ба дуулгавартай үйлдлүүд гэж тодорхойлжээ: “Ноёрхол гэдэг нь захирагч хүний тодорхой агуулга бүхий тушаалын дагуу дуулгавартай байх боломжийг хэлнэ” (*Wirtschaft und Gesellschaft. Grundriß der verstehenden Soziologie*, 1922). Ноёрхлын хүч → эрх мэдэл бол тушаалаар бусдыг дуулгавартай байлгах боломжийг нээж өгдөг, учир нь дагагч энэхүү ноёрхлыг хууль ёсны гэж хүлээн зөвшөөрч, “дуулгавартай байх үүрэг”

хүлээдэг. Ноёрхлын дэг журмын албан ёсны легитим байх үндэс нь сэтгэл хөдлөлийн эсвэл эрхэмжийг дагалдсан итгэл үнэмшил буюу/эсвэл эерэг, хууль ёсны уламжлалт дүрэм журам байж болно.

Weber хууль ёсны легитим байдлын талаарх ялгаатай итгэл үнэмшлийн дагуу “цэвэр хууль ёсны ноёрхлын гурван хэлбэр”-ийг ялгаж үзсэн (in: *Gesammelte Aufsätze zur Wissenschaftslehre*, 1922): (1) харизмтай, (2) уламжлалт (3) албан ёсны ноёрхол.

Социологийн хувьд онцгой ач холбогдолтой нь албан ёсны ноёрхлын хамгийн тохиромжтой хэлбэр байх бөгөөд энэ нь захирагч, захирагдагч, түүнчлэн захиргааны нэгжүүдийн үйл ажиллагаа нь өндөр түвшний захиргааны дэг журам дээр тогтдог учраас “тогтоосон журам болон ноёрхлыг хэрэгжүүлэхийн тулд томилогдсон хүмүүсийн зааварчлах эрхийн хууль ёсны байдалд итгэх итгэл дээр” (эдийн засаг, нийгэм) үндэслэсэн, хамгийн их рационал, урьдчилан таамаглах нөхцөлийг бүрдүүлж байдаг хүнд суртал-монакрат засаг захиргааны нэгжтэй байна. Энэхүү хамгийн тохиромжтой хэлбэрт зорилгоо оновчтой тогтоосон дэг журамд тулгуурлах эрх баригч холбоод, жишээ нь, бизнесийн байгууллагууд, улс орнууд эсвэл шинжлэх ухаан, урлагийн байгууллагууд их бага хэмжээгээр ойлтдог.

Улс төр, түүхийн шинжлэх ухаан төдийгүй, салбар хоорондын зохион байгуулалтын судалгаа (→ зохион байгуулалт), цаашлаад мөн социологид Weber-ийн онолын урсгал, үзэл баримтлал өнөөг хүртэл иш

татагдсан хэвээр байна. Түүний үзэл санаатай уялдуулан орчин үеийн зохион байгуулалтуудын тархалт, бүтцийн элементүүд, чиг үүргийг зөвшилцөл, зохицуулалтын оновчтой хэлбэрүүд гэж тодорхойлж, тайлбарлаж, дүгнэдэг болсон. Heinrich Popitz (*Phänomene der Macht*, 1992) эрх мэдлийн үндэс суурийг хэрхэн системчилж, ноёрхлын институцчилэл (→ институци)-ийг эрх мэдэл бий болгох үйл явцаар хэрхэн тайлбарлаж болохыг Weber-ийн үзэл баримтлалтай уялдуулан харуулсан байдаг. Weber-ийн ноёрхлын тухай үзэл баримтлал нь ноёрхлын хэм хэмжээг тогтоох, хэрэгжүүлэх үндэс гэж үздэг хэм хэмжээ ба үүргийн (→ хэм хэмжээ, үүрэг) социологийн онолын чигийг заасан юм. Энэ нь Ralf Dahrendorf-ыг ноёрхлын нийтлэг байдлын тухай сэдвийг боловсруулахад хүргэсэн. Weber-ийн нэр бүхий шүүмжлэгчдийн тоонд оновчтой байдлын тухай ойлголтыг зорилгын оновчтой байдал болгож бууруулсанд тааламжгүй хандсан Jürgen Habermas, хувь хүний болон хамтын ашиг сонирхлыг шууд адилтгаж үзсэнийг хүлээн зөвшөөрөх аргагүй гэж шүүмжилсэн Niklas Luhmann нар багтана. Мөн James S. Coleman-ынхтай адилхан ноёрхлын талаарх оновчтой тайлбаруудад Weber-ийн үзэл баримтлалаас эсрэгээр шинээр уялдаа хайсаар байдаг. Үүнээс ургуулан *governance*-н талаарх сүүлийн үеийн судалгааны ажлуудад шатлан захирах ёс ба ноёрхлын бүтцийн хэлбэржилт, асуудал шийдвэрлэх чадварыг шинжлэх болжээ.

Karl Marx-ын бүтээл өнөөг хүртэл ноёрхол ба эрх мэдлийн онолын шүүмжлэлд лавлах цэг байсаар ирсэн

бөгөөд үйлдвэрлэлийн болон хөдөлмөрийн социологид салбарын ноёрхол ба хяналтын тогтолцооны (→ хяналт) дүн шинжилгээгээр үргэлжилсэн. Гэсэн хэдий ч эрх мэдлийн талаарх шүүмжлэлт дүн шинжилгээг Michel Foucault-ын хэлснээр “засгийн газрын менталитет”-ын үзэл баримтлал болгон танилцуулах байдал нэмэгдэж байгаа бөгөөд субъектив байдлыг (→ субъект) хязгаарлаж, сахилга батжуулах нийгмийн дүрэм, мэдлэгийн тогтолцооны хүчийг сулруулж байна.

Andrea Maurer

Peter Imbusch (Hrsg.): Macht und Herrschaft. Sozialwissenschaftliche Konzeptionen und Theorien. Opladen 1998.

Andrea Maurer: Herrschaftssoziologie. Eine Einführung. Frankfurt a. M. / New York 2004.

Ойлгох, тайлбарлах (Verstehen/Erklären)

“Ойлгох” болон “Тайлбарлах” гэдэг нь юу, яагаад, яаж гэх асуултад хариулах явдал юм. Ойлгох, тайлбарлах гэсэн ухагдахууны хувьд хүчинтэй, зөв, тохиромжтой ойлголтын тухай өргөн хүрээг хамарсан мэтгэлцээн нь өнөөдрийг хүртэл шинжлэх ухааны ерөнхий онол болон бие даасан мэргэжлийн салбаруудын гол сэдэв болсоор байна. Өдөр тутмын болон шинжлэх ухааны хүрээнд ойлгох, тайлбарлах хэлбэрийг хооронд нь

зааглах шалгуурыг тодорхойлох асуудал маргаантай байдаг бөгөөд ямар төрлийн ойлголт, тайлбарыг нэг нэгнээс нь ялгаж болох, тодорхой төрлийн ойлголт, тайлбар шинжлэх ухааны хүрээнд бусад төрлөөс илүү байр суурь эзэлдэг эсэх зэрэг нь гол сэдэв болдог. Үүнээс гадна ойлгох болон тайлбарлах хоёрын хоорондын хамаарал маргаантай. Арга зүйн хосолмол байр суурийн хамрах хүрээ нь нэг талаас “ойлгох” болон “тайлбарлах” асуудал ялгаатай гэж үзэх, нөгөө талаас түүн дотор эсрэг байр суурь гэж ойлгох, мөн “ойлгох” болон “тайлбарлах” гэх ухагдахууныг харилцан уялдаатай, харилцан тайлбарласан эсвэл ижил утгатай хэмээн ашиглах байдал илэрдэг. Ийнхүү хэлэлцэж эхэлсэн мэтгэлцээн нь XIX зууны дунд үеийн хоёр дахь хагас хүртэл ойлгох, тайлбарлах хэлэлцүүлгийн цөмд оршиж, энэ нь хүмүүнлэгийн шинжлэх ухаанд тусгайлсан арга зүй байгаа эсэх асуултаас үүдэлтэй юм. Харин уг асуулт нь байгалийн шинжлэх ухааны тайлбараас ялгаатай. Энэ чиглэлийн олон тооны мэтгэлцээн өнөөдрийг хүртэл ахин дахин гарсаар байгаа бөгөөд → социологид чухал байр суурь эзэлсэн хэвээр байна. Тухайлбал, нийгмийн ертөнцийн зохион байгуулалтын (→ утга) учир нь ойлголтыг нэн тэргүүнд тавьдаг гэж → угсаатны арга зүй, тайлбарлах болон → феноменологийн социологи талаас үндэслэл гаргадаг. Тодорхой арга зүйн дагуу (→ арга зүй) социологийн эмпирик судалгаанд чанарын болон тоон арга зүйд тэргүүлэх ач холбогдол өгөх эсэх талаар хэлэлцэгддэг. Герменевтик (зан төлөвийн шинжлэх

ухаанд, тайлбарлах болон утгыг илэрхийлэх) нь үйл явцыг дүрслэхийн тулд “зан төлөв”-ийг ашигладаг. Зан төлөв нь танил бусыг танил руу чиглүүлж, ойлгох ёстой зүйлсийг тайлбарлах бөгөөд улмаар одоо байгаа ойлголт, → мэдлэг, итгэл үнэмшилтэй холбодог. Нарийн утгаараа “зан төлөв” гэдэг нь үйл явцын утга агуулгыг ойлгомжтой байдлаар тайлбарлах буюу эд зүйлсийн (оршин буй зүйлс) гадаад мөн чанарыг, үг хэллэг, текст, → үйлдэл, үйлдлийн хийх замаар илэрхийлэгддэг. Социологийн хувьд зан төлөвийг хооронд нь субъектив болон объектив гэж ялгаатай байдлаар авч үзэх ба нэг талаас субъектив зан төлөв нь хийж буй үйлдлийн хэтийн төлөвт суурилдаг, нөгөө талаас объектив зан төлөв нь төлөвлөөгүй, харин хувь хүний харилцааг дамнасан эсвэл системийн дотоод холбоосыг (утга, учрыг) анхаарч, үндсэн агуулгаар хэрэгжүүлдэг.

Georg Simmel (*Vom Wesen des historischen Verstehens*, 1918) нь түүхэн-сэтгэл зүйн болон объективд зүйлсийн зан төлөвийн хоорондын тодорхой ялгааг гаргаж дэвшүүлсэн. Энэхүү хэлэлцүүлэгт суурилсан мэтгэлцээний дээрх хоёр зөн төлөвийн ухагдахууныг нарийвчлан тайлбарлах оролдлого нь маргаантай үлдсэн. Хэр их (объектив) зан төлөв нь ач холбогдолтой болох, түүнийг герменевтик нэр томьёотой холбох асуудал мөн маргаантай. Утгыг ойлгох герменевтик үзэл баримтлалын ерөнхий шүүмжлэл нь постструктурализм (→ постструктурализм) болон бүтцийн хандлагыг илэрхийлдэг. Шинжлэх ухааны тайлбарлах үзэл баримтлалын хэлэлцүүлэгт хуулийн

тайлбар болон шалтгаан, үр дагаврын тайлбар онцгой үүрэг гүйцэтгэдэг. Хуулийг тайлбарлах хэлэлцүүлэгт Carl Gustav Hempel und Paul Oppenheim («Studies in the Logic of Explanation» [1948], in: *Readings in the Philosophy of Science*, hrsg. von Herbert Feigl und May Brodbeck, 1953) нарын бүтээл ихээхэн нөлөөлсөн. Тэдний үзлээр үйл явдлын тайлбар нь ерөнхий хуулиуд, магадлалын онол болон тухайн эхлэлийн нөхцөл байдлыг логик дарааллаар авч үзэхэд орших ажээ. Шүүмжлэгчид Hempel-Oppenheim-ын схемийн суурь асуудлуудыг (энэ хүрээнд хэрэглэж буй хуулийн болон шалтгаан, үр дагаврын тухай ойлголтын тодорхой бус байдлыг) онцолж, ерөнхийдөө, түүнтэй холбогдсон бүх зүйлд хүчинтэй байх тухай ойлголтод эргэлздэг. Уг схемийг хүмүүнлэгийн болон нийгмийн шинжлэх ухааны салбарт шилжүүлэн ашиглах тухай асуудал ялангуяа маргаантай. Шалтгаан, үр дагаврын тайлбарууд нь тодорхой шалтгааны үр дагавар, эсвэл эсрэгээр нь тодорхой үр дагаврын шалтгаан гэсэн байр сууринаас тайлбарлах замаар шалтгаан-үр дагаврын схемийг ашигладаг. Өөр нэг өвөрмөц шалтгаан үр дагаврын тайлбарын төрөл нь нөхцөл байдлын шалтгааныг үндэслэл болгон тайлбарлах юм. Энэ хүрээнд өмнө үйлдлийг тайлбарлахыг урьтал болгох бөгөөд → оролцогч талын үйлдлийг өдөөсөн сэдлийг хамруулан тодорхойлдог. Аль хэдийн Max Weber (*Wirtschaft und Gesellschaft. Grundriß der verstehenden Soziologie*, 1922) энэхүү үйлдлийг тайлбарлах асуудал бол субъектив сэдлийг тодорхойлох гэж үзсэн байдаг. Энэ нь дараа

дараагийн хэлэлцүүлэгт тайлбар үндэслэлтэй байгаа эсэх нь маргаантай хэвээр үлдсэн. Учир нь бид учир шалтгааны тайлбарыг огт харгалзан үзэж байна уу? эсвэл энд өөр төрлийн тайлбар, тухайлбал телеологийн (зорилгод чиглэсэн) тайлбар байгаа эсэх тухай асуудал юм. Ер нь хуульд учир шалтгааны тайлбараас гадна өөр тайлбарын хэлбэрүүд хэр зэрэг байгаа нь маргаантай. Niklas Luhmann-ны (*Soziale Systeme*, 1984) *функциональ тайлбаруудыг* ихэвчлэн асуудлын шийдлүүдийн эквивалент функциональ анализ хэмээн үздэг. *Хувьслын онолын тайлбарууд* нь процессын хөгжлийг “хувьсах”, “ялгарал”, “тогтворжуулах” (→ хувьсал, систем) гэсэн гурван механизмын харилцан үйлчлэлийн үр дүн хэмээн тодорхойлдог. Тайлбарыг нэгтгэх үзэл баримтлал нь шинжлэх ухааны тайлбарын уялдаа холбоо, системчлэлийн функцийг онцгойлон авч үздэг. Өнөөг хүртэл нээлттэй хэлэлцэгдэж байгаа мэтгэлцээний хүрээнд учир шалтгааны бус тайлбарын гурван төрөлд шалгаан, үр дагаврыг хэр зэрэг харгалздаг эсэхийг хэлэлцэж байна.

Georg Kneer

Oswald Schwemmer: *Handlung und Struktur. Zur Wissenschaftstheorie der Kulturwissenschaften*. Frankfurt a. M. 1987. S. 87–132.

Andreas Reckwitz: *Die Transformation der Kulturtheorien. Zur Entwicklung eines Theorieprogramms*. Weilerswist 2000. S. 91–169.

Emil Angehrn: Interpretation und Dekonstruktion. Untersuchungen zur Hermeneutik. Weilerswist 2003.

Gerhard Schurz: Erklären und Verstehen: Tradition, Transformation und Aktualität einer klassischen Kontroverse. In: Friedrich Jaeger / Jürgen Straub (Hrsg.): Handbuch der Kulturwissenschaften. Bd. 2: Paradigmen und Disziplinen. Stuttgart [u. a.] 2004. S. 156–174.

Uwe Schimank / Rainer Greshoff (Hrsg.): Was erklärt die Soziologie? Methodologien, Modelle, Perspektiven. Münster/Berlin 2005.

Олон нийт (Öffentlichkeit)

“Олон нийт” (англиар *public space, public sphere* буюу нийтийн орон зай, олон нийтийн газар) гэдэгт XVIII зууны төгсгөл үеэс хойших нийгмийн ялгаатай байдал (→ ялгах)-аас эхлэлтэй хувийн болон эдийн засгийн байдлаас ангид, нийтэд хүртээмжтэй байх зарчмаар тодорхойлогдсон бие даасан нийгэм, улс төрийн хүрээг ойлгодог. Олон нийт гэх ухагдахуун нь XIX зууны эхэн үеийн соён гэгээрлийн болон либерализмын улс төрийн зөрчилдөөний, тэр дундаа 1848 оны хувьсгалын (→ чөлөөлөх) гол хэрэгсэл болж байв. Тэрээр “олон нийтэд түгээх” (өөрөөр хэлбэл, улс төрийн шийдвэр гаргах үйл явцын ил тод байдал) болон үзэл бодол, хэвлэлийн эрх чөлөөний төлөөх соён гэгээрлийн шаардлагыг өвлөж авсан. Олон нийтийг → хамтын нийгэмлэгт бус харин → нийгмийн салбарт хуваарилсан

Ferdinand Tönnies (*Gemeinschaft und Gesellschaft*, 1887) олон тоогоор хэвлэгдсэн үзэл бодлыг “олон нийтийн үзэл бодол”-оос ялгаж заагласан (*Kritik der öffentlichen Meinung*, 1922). Сүүлийнх нь эрдэмт бүгд найрамдах улсын үзэл санаанд үндэслэсэн ухаалаг хүмүүсийн чуулганыг дурджээ. Нийтэд хүртээмжтэй байх үндсэн зарчимд нэмсэн олон нийтийн хэлэлцүүлэгтэй холбоотой үндэслэл бүхий энэхүү таамаглалыг Jürgen Habermas-ын “Олон нийтийн бүтцийн өөрчлөлт”-өөр дэвшүүлж, (1962 оноос цааших зохиолуудад ярианы ёс зүйн хувьд улам боловсронгуй болгосон тухайлбал, *Faktizität und Geltung*, 1992), хожим энэ нь олон нийтийн талаарх онолын суурь (→ шүүмжлэлийн онол) болсон. Habermas-ын хувьд дундад зууны сүүл үеэс XVIII зуун хүртэл язгууртан ангийн төлөөллийн олон нийтийн хүрээлэл (олон нийтийн газар нь төрийн өндөр түвшний төлөөллийн тайз болсон) давамгайлж байсан боловч хөрөнгөтний үзэл давамгайлахтай зэрэгцэн харьцангуй автономи хөрөнгөтний олон нийтийн хүрээлэл бий болж хөгжсөн: эхлээд олон нийтэд хүртээмжтэй болсон соёлын байгууллагууд (уран зохиол, театр гэх мэт), дараа нь Францын хувьсгалын үед дээд цэгтээ хүрсэн улс төржилтийн үйл явцын улмаас илт улс төрийн зорилготой олон нийтийн хүрээллийн хэлбэр бий болжээ. Хөрөнгөтний олон нийтийг хувь хүмүүсээс бүрдсэн үзэгчид бүрдүүлэх бөгөөд тэд олон нийтэд чиглэсэн шалтгаант хэрэгцээ буюу “олон нийтийн зөвшилцөл”-ийг бий болгох зорилготой байв. Үүний үр дүнд олон нийт “төрийн

эрх мэдэл” (энэ хугацаанд → төрийн болон XVI зуунаас хойших байнгын захиргааны аппараттай адилтгаж ирсэн)-ийг маргаантай болгосон. Habermas өнөө цагт хөрөнгөтний олон нийт уналтын үед байгаа талаар дурдсан. Хэрэглэгчийн соёл, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (→ хэвлэл мэдээллийн хэрэгсэл)-ийг хуурах арга хэрэгсэл хэлбэрээр ашиглах нь олон нийтийг “дахин феодалчлах” байдалд хүргэсэн. Феодализмын төлөөллийн олон нийтийн хүрээний нэгэн адил хөрөнгөтний (уран зохиолын төдийгүй улс төрийн) олон нийтийн хүрээг тодорхойлдог учир шалтгааныг олон нийтэд ашиглах нь олон нийтийн сурталчилгаагаар улам бүр солигдож байна. Нэг талаас, олон нийт устаж үгүй болох тухай таамаглалыг Hannah Arendt (*The Human Condition*, 1958, dt. 1960) хожуу мэдэгдсэнийг Richard Sennett зэрэг бусад хүмүүст илэрхийлж байв (үүний дагуу олон нийтийг хотжилт дахь гаднын үл таних хүмүүсийн цугларал хэмээн тодорхойлж, өнөө цагт “интим харилцааны дарангуйлал”-аар заналхийлэгдэх болсон гэж үзжээ; *The Fall of Public Man*, 1974; Eng. 1983); нөгөө талаас Habermas олон нийтийн хүрээ нь “цагаан”, европ, хөрөнгөтний давхаргын эрчүүдэд зориулсан онцгой орон зайг (→ оруулах/хасах) үл тоомсорлож байна гэж шүүмжилсэн. Түүнчлэн, хөрөнгөтний олон нийтийн талбарт төвлөрөхийн хэрээр эсрэг олон нийт жишээлбэл, тариачид, эмэгтэйчүүд эсвэл ажилчдын дэмжлэгтэй гарч ирэхийг үл тоомсорлосон (→ ангиуд, хүйсээр).

Oskar Negt, Alexander Kluge нар (*Öffentlichkeit und Er-*

fahrung) 1972 онд пролетарийн олон нийт болон олон нийтийн эсрэг үүссэн нөхцөл байдлыг судалсан. Тэд пролетарийн олон нийтийн хүрээг зөвхөн хөрөнгөтний нийтийн хүрээллээс ялгаатай гэж ойлгодоггүй, харин нийгмийн нөхцөл байдал, өөрөөр хэлбэл, нийгмийн коллектив туршлагыг хуваалцсан зохион байгуулалтын хэлбэр гэж үзсэн. Үүний үр дүнд тэд “үйлдвэрлэлийн олон нийт”, “туршлагатай олон нийт” гэсэн олон нийтийн хэмжүүр ойлголтын оролдлогуудыг бий болсон. Хамгийн сүүлд Nancy Fraser («Rethinking the Public Sphere», in: *Habermas and the Public Sphere*, hrsg. von Craig J. Calhoun, 1992)-тэй хамтран Habermas-ын нийтийн хүрээний тухай ганцаарчилсан ойлголт олон тооны өрсөлдөгч олон нийтийн ойлголтод уусжээ. Дараалалд оруулсан → нийгэмд (язгууртны нийгэм гэх мэт) Fraser-ын хэлснээр, үүнд захирагдах байдлын эсрэг тэмцдэг болон давамгайлж буй хөрөнгөтний олон нийтийн хүрээнээс (→ тэгш бус байдал, ноёрхол) ялгаатай хөгждөг доод түвшний олон нийт хамаарна; гэхдээ давхраалаг бус (жишээ нь, тэгшитгэсэн, олон соёлт) нийгэмд ч гэсэн олон тооны олон нийтийн төрлүүд тодорхой нөхцөлд л төсөөлөгдөх боломжтой. Ийнхүү Tönnies-ээс хойших мэтгэлцээн нь цор ганц оновчтой нийтийн хүрээний санаа болон зөрчилдөөнтэй (харилцан зөрчилдсөн) олон нийтийн санааны хоорондох зайд шилжсэн.

- Lucian Hölscher: Öffentlichkeit. In: Otto Brunner [u. a.] (Hrsg.): Geschichtliche Grundbegriffe. Historisches Lexikon der politisch-sozialen Sprache in Deutschland. Bd. 4. Stuttgart 1978. S. 413–467.
- Öffentlichkeit und Geheimnis. Stuttgart 1979.
 - Öffentlichkeit. In: Joachim Ritter / Karlfried Gründer (Hrsg.): Historisches Wörterbuch der Philosophie. Bd. 6. Basel/Stuttgart 1984. S. 1134–40.

Оролцогч (Akteur)

“Оролцогч” (францаар *үйлдэгч*; латинаар *actus* = *үйлдэл*) гэж социологийн ухаанд нийгмийн → үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэгч нэгжийг илэрхийлдэг. Үүнд, нийгмийн харилцаанд нэг нэгээрээ бие даан орж буй хүмүүсийг (хувь оролцогч), нийлсэн хүмүүсийг (хамтран оролцогчид), эсвэл байгууллагыг бүхэлд нь (корпорацын оролцогч) хамруулж болно (Uwe Schimank, *Handeln und Strukturen. Eine Einführung in die akteurtheoretische Soziologie*, 2000). Холбогдох социологийн хандлагыг *оролцогчид төвлөрсөн* хандлага гэж нэрлэдэг. Оролцогч гэх ангиллын онолын утга учир нь Max Weber-ийн социологийг нийгмийн харилцааг “тодорхой ойлгох, [...] шалтгааныг тайлбарлах” гэсэн шинжлэх ухаан гэж тодорхойлсноос үүдэлтэй (*Wirtschaft und Gesellschaft. Grundriß der verstehenden Soziologie*, 1922). Оролцогч гэсэн ойлголт нь мөн Talcott Parsons-ын боловсруулсан сайн дурын үйл ажиллагааны онолд үйлдлийн ерөнхий

онолын хамаарах хүрээний салшгүй нэг хэсэг болсон байна (*The Structure of Social Action*, 1937).

Оролцогчдын нийгмийн үйл ажиллагааны хэв маягийг тодорхойлохын тулд олон янзын, нэгийг нь нөгөөгөөр нь илэрхийлэх боломжгүй оролцогчдын загваруудыг хөгжүүлсэн байдаг. Эдийн засгийн шинжлэх ухааны салбарт хөгжүүлсэн *Homo Oeconomicus* загвараар (Gebhard Kirchgässner, *Homo Oeconomicus*, 1991) оролцогч бол юуны түрүүнд өөрийн ашгийг хамгийн их байлгахыг урьтал болгодог бөгөөд тиймээс ч ашиг сонирхолдоо хөтлөгдөн ажилладаг (→ рационал сонголтын онол). Социологи үүнийг сэргүүлэн *Homo Sociologicus* загварыг гаргаж ирсэн (Ralf Dahrendorf, *Homo Sociologicus*, 1956). Энэ загварын санаа нь оролцогчийн үйлдэл нийгмийн хэм хэмжээ, үнэт зүйлс, үүрэгтээ (→ үүрэг, роль) захирагдах явдал гэж үздэг. Харин сүүлийн үед оролцогчийн *Emotional Man* (Helena Flam, *The Emotional Man and the Problem of Collective Action*, 2000) загвараар нийгмийн харилцаан дахь сэтгэл хөдлөлийн үүргийг илүүтэйгээр онцлох болсон. Энд мөн өөрийгөө таниулах нь үйл ажиллагааны чухал хөдөлгөгч хүч болохын ач холбогдлыг тэмдэглээд, оролцогчийг “өөрийгөө таниулагч” болгосон нь онцлогтой (Erwin Goffman, *The Presentation of Self in Everyday Life*, 1959, dt. 1969).

Хамтран оролцогчид нь нийгмийн зохион байгуулалттайгаар нэгдэн ажилладаг бөгөөд оролцогч хувь хүмүүсийн ашиг сонирхлоос хамааралтай байдаг. Хамтын оролцооны нэг чухал дэд хэлбэр бол нийтлэг

ашиг сонирхол, зорилготой нийгмийн хөдөлгөөнүүд байх боловч тусдаа үйл ажиллагааны нөөцтэй байдаг (жишээ нь, Энх тайвны төлөөх эсвэл байгаль хамгаалах хөдөлгөөн). Тэдний гол бэрхшээл бол хэдийгээр ижил хүсэл эрмэлзэл, зорилготой боловч оролцооны бэлэн байдлаараа ялгаатай хувь оролцогчдыг дайчлах явдал байдаг. Холбоод (жишээ нь, Мэргэжлийн холбоод) бол харин коллектив (хамтын) ашиг сонирхлоо дэмжихийн тулд хамтын хүчээ нэгтгэдэг төрлийн хамтрал юм. Тэдний гаргасан үйлчилгээ, бүтээгдэхүүн нь түүнийг бий болгоход оролцоогүй хүмүүст ч ашиг тусаа өгдөг, жишээ нь, хандивын хэлбэрээр (*олон нийтийн үйлчилгээнүүд-Kollektivgüter*) (Fritz W. Scharpf, *Games Real Actors Play. Actor-Centered Institutionalism in Policy Research*, 1997, dt. 2000).

Корпорацийн оролцогчид нь хамтарсан оролцооны буюу өөрөөр хэлбэл зохион байгуулалттай хэлбэрийн онцгой тохиолдол бөгөөд ихэнхдээ өмчлөгч эсвэл шаталсан удирдлагаар хянагддаг (тухайлбал, Компаниуд, улс төрийн намууд). Тэд шийдвэр гаргах удирдлагын төв (удирдагч) болон хэвлэлийн төлөөлөгчтэй (төлөөлөгч) байна. Корпорацуудыг үүгээр жирийн хүн шиг, өөрөөр хэлбэл, хувь оролцогч шиг харилцах боломжийг олгодог гэж үздэг. Хувь хүнээс ялгаатай нь корпорацийн оролцогч бол хуулийн этгээд гэдэг утгаараа зарчмын хувьд тасралтгүй үйл ажиллагаатай байх бөгөөд Корпорацийн дотор зарим нэг оролцогч солигдсон ч тэд, тухайлбал, төлөөлөгч юм уу эсвэл захирал, оршин тогтносоор байх болно. Нэмж дурдахад корпорацуудад

байгууллагын зорилгыг өмнөө тавьсан захирал, хувийн ашиг сонирхлоо хангах сонирхолтой төлөөлөгч хоёрын хооронд сонирхлын зөрчил гарч болзошгүй байдаг (Hartmut Esser, *Soziologie. Spezielle Grundlagen, Bd.2*, 2000).

Patrick Sachweh

Peter Weise: Homo oeconomicus und homo sociologicus: Die Schreckensmänner der Sozialwissenschaften. In: Zeitschrift für Soziologie ¹⁸(1989). S. 141–161.

Helena Flam: Corporate Actors: Definition, Genesis, and Interaction. Köln 1990. (Max-Planck-Institut für Gesellschaftsforschung. Discussion Paper 90/11.)

Manfred Gabriel: Paradigmen der akteurszentrierten Soziologie. Wiesbaden 2004.

Оролцоог хангах/Оролцоог хязгаарлах (Inklusion/Exklusion)

“Оролцоог хангах” (латинаар *inclusio* = “*хорих*”, “*оролцуулах*”) гэдэг нь хүмүүсийг нийгмийн контекстэд хамруулах, анхааралдаа авах хэлбэрийг хэлдэг, жишээ нь, → байгууллагын гишүүн болох эсвэл иргэншлийн эрх олгох (→ улс, хууль). Эсрэг нэршил болох “оролцоог хязгаарлах” (латинаар *exclusio* = “*хасах*”) гэдэг нь эдгээр нийгмийн холбоо харилцаанд → хувь хүмүүс, → бүлгүүдийг оролцуулахгүй, анхаарч авч үзэхгүй байхыг хэлнэ. Энэ хоёр нэр томьёо нь юуны түрүүнд орчин үеийн

нийгэм дэх тусгаарлалт эсвэл гадуурхалтын асуудлыг нийгмийн онолын үүднээс авч үзэх хүрээнд гарч ирдэг.

Talcott Parsons (*The System of Modern Societies*, 1971, dt. 1972) “оролцоог хангах” гэдэг нэр томьёог бүтцийн функционализм (→ функционализм)-ын хүрээнд нийгмийн ялгарах (→ ялгарал) үйл явцын гол шинж чанар болгон нэвтрүүлсэн. Parsons-ын хувьд Thomas H. Marshall (*Citizenship and Social Class*, 1949, dt. 1992)-г мөрдлөг болгож, “оролцоог хангах” гэдгээрээ иж бүрэн оролцооны эрхийн хэлбэрээр нийгмийн бүх гишүүдийг нийгмийн дэд системд оролцуулахыг хэлсэн байдаг.

Орчин үеийн оролцоог хангах дүрмүүд нь бүх нийтэд хүчин төгөлдөр байхыг шаарддагаараа өмнөх үеийн ялгарлын хэлбэрүүдээс өөр юм. Үнэхээр шаардлагатай оролцооны хязгаарлалтыг зөвхөн албан ёсны зөвшөөрлөөр хийж болох ч бусад тохиолдолд энэ нь нийгмийн ялгаварлан гадуурхалт болж хувирна. Үүнийг статус эсвэл → хүйс харгалзахгүйгээр зөвхөн насны хязгаарлалт зааж явуулдаг болсон бүх нийтийн сонгуулийн эрхийн жишээнээс тодорхой харж болох юм. Niklas Luhmann («Inklusion und Exklusion», in: N. L., *Soziologische Aufklärung 6: Die Soziologie und der Mensch*, 1995) Parsons-ын үндэстэн улсад хүчтэй чиглэгдсэн оролцоог хангах концептыг үргэлжлүүлэн, өөрийн функциональ ялгарлын ерөнхий онолдоо дэлгэрүүлсэн байна. “Оролцоог хангах” тохиолдлоос ялгаатай нь “оролцооны хязгаарлалт” цэвэр нийгмийн шинжлэх ухааны нэр томьёоны түүхэнд үндэслэдэггүй. Энэ нэр томьёо социологид 1990-ээд оны үед барууны нийгмийн

хүмүүнлэг улсуудад хэт туйлширсан нийгмийн тэгш бус байдлын талаарх асуудлуудын хүрээнд олон нийтийн улс төрийн мэтгэлцээний үеэр хөндөгдөж байжээ. Ялангуяа, Францын, Германы хэлэлцүүлэгт “оролцоог хязгаарлах” гэдгийг нийгмийн янз бүрийн үзэгдлүүд болох–урт хугацааны ажилгүйчүүд, хууль бус цагаачид (→ шилжилт хөдөлгөөн) эсвэл нийгмийн эмзэг орчны оршин суугчдыг–багтаасан цуглуулгын категори болгож байв. “Оролцоог хангах” гэсэн нэр томъёоны нэгэн адил “оролцоог хязгаарлах” гэдэг нь нийгмийн олон янзын дэд системүүдэд (→ эдийн засаг, улс төр, боловсрол) хамрагдуулахгүй байх, оролцоог нь хасахыг хэлэх бөгөөд үүгээрээ эдийн засгаар хэмжигдсэн ядуурлын тухай ойлголтыг орлуулдаг. “Оролцоог хангах”-аас ялгаатай нь “оролцоог хязгаарлах” нь янз бүрийн хязгаарлалтууд харилцан бататгаж, цаг хугацааг нь тогтоодог.

Тэгш бус байдлын онолд илүүтэй чиглэсэн хандлагаар сонгодог “дээд/доод” босоо бүтцийн схем дээр давхцах нийгмийн хэвтээ хуваагдал нь дотоод хэвийн бүс, оролцоог хязгаарласан задралын бүсүүдэд улам бүр нэмэгдэж байна гэж үздэг. Энэ үүднээс авч үзвэл оролцоог хангахыг ихэвчлэн нийгмийн → интеграцчилалтай адилтгаж, нөгөө талаас оролцоог хязгаарлахыг → тэгш бус байдлын эсвэл гадуурхалтын хэт туйлширсан хэлбэр болгон асуудалд оруулдаг бол системийн онол (→ систем) эсвэл → постструктурализм гэх мэт ялгарлын онолын арга хандлагууд нь энэ хоёр нэр томъёоны хуулиар зохицуулах холбоосыг онцолдог. Дараа нь нийгмийн → ижилслийн бүх конструкци

(→ конструктивизм)-ийн үндэс суурь болж, ил далд оролцооны хязгаарлалтыг бий болгож байгаа заагийг тогтоох механизмууд анхаарлын төвд ордог.

Sina Farzin

Robert Castel: Les métamorphoses de la question sociale.

Une chronique du salariat. Paris 1995. – Dt.: Die Metamorphosen der sozialen Frage: Eine Chronik der Lohnarbeit. Übers. von Andreas Pfeuffer. Konstanz 2000.

Martin Kronauer: Exklusion. Die Gefährdung des Sozialen im hoch entwickelten Kapitalismus. Frankfurt a. M. / New York 2002.

Rudolf Stichweh: Inklusion und Exklusion. Studien zur Gesellschaftstheorie. Bielefeld 2005.

Heinz Bude / Andreas Willisch (Hrsg.): Das Problem der Exklusion. Ausgegrenzte, Entbehrliche, Überflüssige. Hamburg 2006.

Sina Farzin: Inklusion/Exklusion: Entwicklungen und Probleme einer systemtheoretischen Unterscheidung. Bielefeld 2006.

Орон зай (Raum)

Орон зай бол хязгаар, зааг тогтоосны үр дүн юм. Энд, тэнд, ойр, хол, дээр, доор, дотор, гадна гэсэн хязгаарлалт нь аль хэдийн байгаа орон зайг өөр өөр газар хуваагаад байгаа хэрэг биш, харин ерөөсөө орон

зайг эхлээд бий болгож байгаа асуудал юм. Үүгээр орон зай бол ялгаатай зүйлсийг нэг цаг хугацаанд хашсан хаалт гэдгээ харуулж байна. Тиймээс → “цаг хугацаа”-аас гадна “орон зай” нь нийгмийн дэг журмын гол ангилал болдог.

Гэсэн хэдий ч өнөөдрийг хүртэл “орон зай” гэж юуг ойлгож болох талаар тодорхой тайлбар байдаггүй. Харин орон зайн тухай ойлголт нь антикийн үеэс л философийн төдийгүй нийгэм, соёл судлалын аль алиных нь ахин дахин маргаан дагуулдаг сэдэв байсаар ирсэн. Орчин үеийн орон зайн социологийн (→ социологи) төвд байдаг үнэмлэхүй болон харьцангуй орон зайн ялгаа нь ялгаатай байрлалуудыг ангилах загвар болж чаддаг. Isaac Newton материас гадуур орших орон зайн талаарх метафизик санааг бүхнээс түрүүнд эрэмбэлэгддэг орон зай гэж үзсэн бол Gottfried Wilhelm Leibniz-ийн хувьд янз бүрийн харах өнцгөөс шалтгаалаад нэгэн жигд мэдрэгддэггүй нь тогтоогдсон орон зайг харьцангуй ойлголт гэж үзжээ. Харин Immanuel Kant орон зайд өөрийн гэсэн бодит байдал байдаггүй гэж үзэж байв; Түүний хувьд энэ нь цэвэр мэдрэмжтэй холбоотой хэлбэр төдий зарчим юм. Albert Einstein орон зай ба цаг хугацааны аль аль нь харьцангуй зөвхөн ажиглагчтай холбоотой системд оршдог гэдгийг мэдэж авснаар үнэмлэхүй орон зай ба үнэмлэхүй цаг хугацааны талаарх таамаглалыг үгүйсгэсэн байдаг (Max Jammer, *Das Problem des Raumes*, 1960). Үүгээр бодитоор оршин байгаа орон зайн төсөөлөл нь улам бүр мэдрэхүй, ажиглалтаар бий болсон орон зайн материйн хэлбэрт

шилжиж байна. Хэдийгээр энэхүү өөрчлөлтөөр л орон зай нь анх социологийн сэдэв болж чадсан боловч энд ч бас нийгмийн үйл явдлууд өрнөдөг төвийг сахисан хайрцагласан, агуулдаг савны тухай төсөөлөл (ийм маягаар үндэстэн улсыг орон зай гэж ойлгодог) өнөөг хүртэл тодорхой хэмжээгээр давамгайлсан байдалтай байгаа нь хачирхалтай.

Социологи нь “орон зайн” асуудалд аль эртнээс анхаарал хандуулж ирсэн хэдий ч энэ нь эхэндээ социологийн үндсэн нэр томьёо болж чадаагүй юм. 1945 оны дараа орон зайн ойлголтоос зай авах болсон, учир нь энэ үед орон зай газар зүйн хувьд хүчээр булаан эзлэгдэж, үндэсний социалист идеологиор (→ идеологи) (Werner Köster, *Die Rede über den »Raum«*, 2002) улс төрийн дарамтад орчихсон байв. 1990-ээд оноос хойш л бүхэлдээ нийгэм, соёлын шинжлэх ухаанд “орон зай”-г эрчимтэй судлах болсон. Ингэхдээ сонгодог зохиолчдын гол үзэл санааг харгалзан авч үздэг.

Émile Durkheim (*Les formes élémentaires de la vie religieuse*, 1912, dt. 1981) нийгмийн орон зайг “дээр/доор”, “зүүн/баруун”, “хойд/өмнөд” гэх мэтээр хамтын хамааралтайгаар ангилагдаж, хуваагдана гэж үзсэн бөгөөд энэ нь өдөр, долоо хоног, жилээр хуваахтай адил →нийгмийг юуны түрүүнд эмх цэгцэд оруулах үүрэгтэй. Georg Simmel-ийн Kant дээр үндэслэсэн “орон зай”-тай холбоотой маргаанд “орон зай”-г “өөрийн гэсэн нөлөө байхгүй” (»Der Raum und die räumlichen Ordnungen der Gesellschaft«, in: G. S., *Soziologie. Untersuchungen über die Formen der Vergesellschaftung*, 1908), гагцхүү

→ хувь хүмүүсийн бодит ертөнц дээрх хэрэглээгээр л үр нөлөө нь гарч ирдэг гэдгийг онцолсон байна. Pierre Bourdieu-ийн бүхий л бүтээлийнх нь туршид хамт явж байсан “орон зай”-тай холбоотой судалгаанд юуны өмнө нийгмийн орон зай дахь → оролцогчийн байр суурь бие махбодын орон зайд тусгалаа олдог тухай өгүүлсэн байдаг. Anthony Giddens (*The Constitution of Society*, 1984, dt. 1992)-ийн нийгмийн онолын загвар нь “орон зай” (болон “цаг хугацаа”)-г “нийгмийн онолын цөм” болгох цогц оролдлогыг агуулдаг.

Нэг бүрчлэн эдгээр бүх ялгаатай үзэл санаа үл харгалзан социологийн барьдаг байр суурь бол юуны түрүүнд орон зайг байгалийн өгөгдөл биш, харин нийгмийн бүтээл гэж харах байдлаар тодорхойлдог. Ялангуяа хотыг судлахад хот, түүний хороолол, дүүргүүд анхнаасаа байгаагүй, харин эдгээр нь оршин суугчид, зочлон ирэгсдийн өдөр тутмын практик (→ өдөр тутам)-аар л бий болсон гэдгийг мэдэх нь чигийг олоход тустай. Энэ ч утгаараа даяаршлын онолын контекстэд үргэлж гардаг шиг орон зайн ач холбогдолгүй байдал ихсэж байна гэж ярих биш, харин үндэстэн улсуудын (→ улс) дэг журмыг дагадгаа болиод, хил дамнан хэлбэрждэг орон зайн байнгын шинэчлэлтэй тохиргоог бий болгох тухай ярьж болох юм.

Орон зайн ухагдахууныг тухай цаашид хэлэлцэхийн тулд орон зайн детерминизмийн оронд орон зайн үнэмлэхүй ойлголтоос харилцааны үзэл баримтлал хүртэлх ихээр шаардаж байсан шилжилтээр орон зайн

сайн дурынхан гарч ирж байна уу гэсэн асуулт юм. Хэрэв орон зайн дэг журам нь анх нийгмийн → үйл ажиллагаа эсвэл → харилцаагаар бий болсон бол орон зайн хүчний оронд оролцогчдын хүчийг онцлохдоо тэдгээрийн үргэлжлэх хугацаа, тогтвортой байдлыг мартаж болохгүй.

Markus Schroer

Benno Werlen: Gesellschaft, Handlung und Raum. Stuttgart 1987, ³1997.

Martina Löw: Raumsoziologie. Frankfurt a. M. 2001, ⁵2007.

Jörg Dünne / Stephan Günzel (Hrsg.): Raumtheorie. Grundlagentexte aus Philosophie und Kulturwissenschaften. Frankfurt a. M. 2006.

Bernhard Schäfers: Stadtsoziologie. Stadtentwicklung und Theorien – Grundlagen und Praxisfelder. Wiesbaden 2006.

Markus Schroer: Räume, Orte, Grenzen. Auf dem Weg zu einer Soziologie des Raums. Frankfurt a. M. 2006, ²2007.

Орчин үе/Модерн (Moderne)

“Орчин үе” гэдэг нь нийгмийн тодорхой суурь удэд (жишээ нь, хувь хүнд чиглэсэн иргэний улс төр, нийгмийн үндсэн эрхүүд эсвэл үндсэн эрхээр баталгаажсан судалгаа, сургалтын эрх чөлөө) их бага хэмжээгээр хэрэгжсэн буюу хэрэгжиж буй тодорхой

суурь зарчмуудыг (жишээ нь, → хувь хүний бие даасан байдал, эсвэл → шинжлэх ухааны рационал байдал) хэлнэ. Энэхүү хэрэгжилтийн үйл явцыг “шинэчлэл” гэж нэрлэдэг (жишээлбэл, Францын хувьсгалын хэлбэрүүдэд, мөн цэрэг зэвсгийн хүчээр эзлэн түрэмгийлж, колоничлолыг тогтоосны үр нөлөөгөөр). Шинэчлэл гэдэг нь бас дамжин ирсэн уламжлалыг “ид шидгүй болгож” (Max Weber), техник эдийн засгийн инновацийн үйл явцыг үнэмлэхүй хэмжээнд тохируулсан оновчтой болгох үйл явцын чөлөөт хязгаарыг хэлнэ.

“Тусгалтад шинэчлэл” нь суурь институциуд (жишээ нь, үндэстэн улсын улс төрийн байгууллага) барууны аж үйлдвэрийн нийгмийн (→ аж үйлдвэрийн нийгэм) тодорхой, урт хугацааны тогтвортой форматаар өөрчлөгдөж эхлэх нийгмийн → өөрчлөлтийн үйл явцад чиглэгддэг. Тусгалтад шинэчлэлийн тайлбар загвар нь шинэчлэл дэх бүтцийн уналтыг экзоген (гадаад) хүчин зүйлээр бус харин эндогени (дотоосоо) шинэчлэлийн үр дагавар гэж тайлбарладаг. Тусгалтад шинэчлэлийг хэрэгжүүлэх хүрээнд 1960-аад оноос хойш хожим шинэчлэгдсэн нийгмийн гол асуудал болоод байгаа сөрөг үр дагаврыг улс төржүүлэх, ональ байдлаар зохицуулах асуудал яригддаг. Ялангуяа дэлхийн хэмжээнд гамшгийн чанартай → эрсдэлийн талаарх ойлголт (жишээ нь, шинэ технологийн, цаг уурын өөрчлөлтийн, үндэстэн дамнасан зохион байгуулалттай терроризмын эрсдэлүүд) нь энэ хүрээнд институцийн өөрчлөлтийн үйл явцын (→ өөрчлөлт) шалтгаан болдог.

Орчин үеийн суурь зарчмууд одоог хүртэл хэзээ

ч бүрэн дүүрэн хэрэгжиж байгаагүй. Орчин үеийн нийгэм үүсэж бий болохтой зэрэгцээд жишээ нь, амжилтыг ахиулах, оновчтой болгох үйл явцад ордоггүй хязгаарлалт, оролцооны хаалт (→ оролцоог хангах), орчин үеийн эсрэг бүтэц, шинээр үүсгэсэн уламжлал, нийгэмлэгийн хамаарал нь илүүтэй хөгжсөн. Орчин үеийн энэхүү орчин үеийн эсрэг суурь нь шинэчлэлийн динамикийн эсрэг хамгаалалтын бүсийг бий болгосон. Залуу гэр бүл, зэх зээлээс хол эмэгтэйчүүдийн үүрэг (→ гэр бүл, жендер), давхаргын хамтын нийгэмлэг, үндэстэн улс (→ улс) нь нийгэмд интеграцийн чиг үүргийг гүйцэтгэж, аливаа үндэслэлийн шаардлагаас чөлөөлөгддөг. Эдгээр танин мэдэхүйн бүтцүүд нь эрс шинэчлэлийн янз бүрийн үйл явцын (шинэ мэдээллийн, генетикийн болон нано технологи, индивидуалчлал, зах зээлийн үйл явцад оролцуулах, → даяаршил) нөлөөн дор өөрийнхөө баталгаат байдлыг алдан, тохиолдлын (заавал биш, → байх боломжтой) чанартай болж, үндэслэлийн шаардлагатай тулгардаг. Хэдийгээр өнөөг хүртэл орчин үеийн уламжлалын нэг хэсэгт багтдаг байсан нийгэмлэгийн хэлбэрүүд (→ нийгэмлэг), үүргийн хуваарилалтуудыг (→ үүрэг) төрөлжүүлж, татан буулгах нь субъектийн тэгш эрхт байдлын шинэчлэлтэй бүрэн нийцэж байгаа боловч нийгэмлэгийн хорогдол, нийгэмшлийн эргэлзээ, нийгмийн интеграцийн дутагдалтай байдлыг бий болгодог. Эдгээр дутагдал нь иргэний нийгэм болон залуучуудын соёлын бүлэг, хөдөлгөөнүүдээс эхлээд дэлхийн шашны (→ шашин) шинэ утга санаагаар дамжин

фундаменталист угсаатны нийгэмлэг хүртэлх хоёрдогч, нөхөн олговортой хамтын нийгэмлэгийн олон тооны оролдлогуудаас ялгаатай юм. Тусгалтад шийдлүүдийг тогтворжуулах боломжтой эсэх, тухайлбал, байгалийн жамаараа бус дэлхийд нээлттэй байдлаар хуульчлагдсан хамтын нийгэмлэгийн загварууд нь эмпирик байдлаар нээлттэй асуулт юм. Тусгалтад шинэчлэлийн онолын үндсэн ойлголт бол ХХI зууны эхэнд бид орчин үеийн төгсгөлтэй буюу орчин үеийн дараах нийгэмтэй (постмодерн) нүүрэлдээгүй, харин илүү орчин үеийн, өөрийн рационал байдлын үндэс, суурь удыг санаанд оромгүй байдлаар өөрчилж, улмаар уналтад хүргэдэг ч үүнтэй зэрэгцээд бас үйл ажиллагааны шинэ боломжуудыг нээж өгдөг радикалчлалын динамиктай тулгарч байна.

Ulrich Beck

Jürgen Habermas: Der philosophische Diskurs der Moderne. Zwölf Vorlesungen. Frankfurt a. M. 1985, ²2004.

Anthony Giddens: The Consequences of Modernity. Cambridge [u. a.] 1990. – Dt.: Die Konsequenzen der Moderne. Übers. von Joachim Schulte. Frankfurt a. M. 1995, Nachdr. 2004.

Wolfgang Zapf: Entwicklung und Zukunft moderner Gesellschaften. In: Hermann Korte / Bernhard Schäfers (Hrsg.): Einführung in die Hauptbegriffe der Soziologie. Opladen 1992, ²2006. S. 195–210.

Ulrich Beck [u. a.] (Hrsg.): Reflexive Modernization. Poli-

tics, Tradition and Aesthetics in the Modern Social Order. Cambridge [u. a.] 1994. – Dt.: Reflexive Modernisierung. Eine Kontroverse. Frankfurt a. M. 1996, 32007.

Ulrich Beck / Christoph Lau (Hrsg.): Entgrenzung und Entscheidung: Was ist neu an der Theorie reflexiver Modernisierung? Frankfurt a. M. 2004.

Өдөр тутам (Alltag)

“Өдөр тутам” (өдөр тутмын амьдрал эсвэл өдөр тутмын ертөнц; англиар *everyday life*; францаар *vie quotidienne*) гэдэг ойлголт нь (1) амьдралын дадал зуршил, давтамж, хэвийн байдлаар тодорхойлогдох бөгөөд тэмдэглэлт баяр болон онцгой үйл явдлын нөхцөлөөс ялгаатай. “Өдөр тутам” нь (2) тодорхой нөхцөл байдалд туршлагажсан хандлагыг хэлэх бөгөөд мэргэжлийн экспертийн нарийн арга зүйт мэдлэг туршлагаас ялгаатай. Энэ нэр томьёо нь (3) нийгмийн давхарга эсвэл нийгмийн орчин гэдэгтэй адил хязгаарлагдмал хүрээнд туршлагажсан байдлыг хэлэх бөгөөд оюун ухааны ертөнцийн зах хязгааргүй орон зайнаас ялгаатай. Эдгээр ялгаатай байдал нь бүх гурван салбарт зөрчилдөөн үүсгэдэг тул ердийн өдөр гэдэг нэр томьёог зөвхөн тайлбарлахаас гадна мэтгэлцээнд ч ашигладаг.

Чиг үүргийн ялгаралтай → нийгмийн онцгой хэсэг нь давамгайлах хандлагатай болох үед өдөр тутмын амьдрал гэсэн ойлголтод онолын хэрэгцээ үүсдэг. Анхны системчилсэн ойлголтыг Edmund Husserl нь

“Амьд ертөнцийн юмс үзэгдэл” бүтээлээр өгсөн (*Die Krisis der europäischen Wissenschaften und die transzendente Phänomenologie* [1936], 1954).

Энд өгүүлснээр, маш нарийн шинжлэх ухааны бүтээл гаргахаас ялгаатай нь “өдөр тутмын амьдрал”-ын үнэн, тодорхой байдалд хүн өөрийн эрхээр хандаж болдог. Гэхдээ үүний тулд өдөр тутмын амьдралын итгэл үнэмшлээсээ салах, тогтсон амьдралаа өөрчлөх, субъектив болон интерсубъектив үзэл санааг хөгжүүлэх үйл явц руу чиглэх хэрэгтэй (→ мэдрэмж). Өдөр тутмын амьдралаа хүн өөрөө өдөр тутам шүүгээд байдаггүй. Martin Heidegger-ийн хийсэн оршихуйн анализаар (*Sein und Zeit*, 1927) зөвхөн “өөрийн” шийдэмгий байдлаар тэсэрч гарсан тохиолдолд өдөр тутмын амьдралын энгийн хэв маягаас тасарч олон нийтэд танил “хүн”-ий дундаж, өөрийн биш байдалд хүрэх юм. Марксист онолыг баримтлагч Henri Lefebvre (*Critique de la vie quotidienne*, 3 Bde., 1947–81, dt. 1974/75) зэрэг зохиолчид өдөр тутмын амьдралаас хөндийрөх тухай шүүмжлэлийг дээд цэгт нь хүргэж, өдөр тутмын амьдралаас чөлөөлөгдөх утопи¹³ үзлийг гаргасан. Гэсэн хэдий ч амьдралын өдөр тутмын болон өдөр тутмын бус зүйлсийг салгаад эдгээрийн хооронд шилжих үйл явцаас үүдсэн өдөр тутмын амьдрал бол зүгээр нэг ердийн өдөр тутмын амьдралаас илүү буюу өөрөөр хэлбэл, “рационал байдлыг бүрэлдүүлэгч” (Bernhard Waldenfels, *Der Stachel des Fremden*, 1990) юм.

Alfred Schütz (*Gesammelte Schriften*, 1971;

13 Үл гүйцэлдэх үзэл буюу утопи санаа гэсэн агуулгаар хэрэглэв.

→ социологийн феноменологи)-ийн нийгмийн феноменологи нь нийгмийн шинжлэх ухааны өдөр тутмын амьдралын судалгаанд шийдвэрлэх нөлөө үзүүлсэн. Энд өдөр тутмын амьдралыг бидний хөндлөнгөөс шууд оролцдог “гайхалтай бодит байдал” гэж харуулжээ. Өдөр тутмын амьдрал бол дахин давтагдах чанар, ач холбогдлын зэргээс шалтгаалдаг; Мөн ойрын болон холын орон зайд, өмнөх үе, өнөө үе ба хойч үе гэж хуваагддаг. Нийгмийн бодит байдлын талаарх ойлголтыг үзэж туулсан туршлага болон үйл ажиллагааны хэтийн төлбөөс (→ үйлдэл) үүдэж бий болдог. Husserl-ийн аж байдлын талаарх шинжлэх ухааны төслийг Norbert Elias-ийх шиг соёл иргэншлийн судалгааны түүхэн хэлбэрээр (*Über den Prozeß der Zivilisation*, 2 Bde., 1939; → Zivilisation) эсвэл нийгмийн давхарга, мэргэжлийн туршлага (→ ажил мэргэжил), өдөр тутмын зан үйлийн талаар системтэй дүн шинжилгээ хийх маягаар (Pierre Bourdieu, *La distinction. Critique sociale du jugement*, 1979, dt. 1982; → Ritual буюу зан үйл) эмпирик судалгаанд хэрэгжүүлэх боломжтой. Феноменологийн хандлага нь интерактивист (→ харилцан үйлчлэл), этнометодологи, хүүрнэх, тайлбарлах арга зүйтэй байнга холбогддог (Hans-Georg Soeffner, *Auslegung des Alltags – Der Alltag der Auslegung*, 1989, 2 2004; → Verstehen буюу ойлгох). Тэгэхээр “өдөр тутам”-ыг нэгдмэл ойлголт гэж үзэхээс илүүтэй олон талт үзэгдлийн илрэл юм.

Arbeitsgruppe Bielefelder Soziologen (Hrsg.): Alltagswissen, Interaktion und gesellschaftliche Wirklichkeit. 2 Bde. Reinbek 1973, ⁵1981.

Kurt Hammerich / Michael Klein (Hrsg.): Materialien zur Soziologie des Alltags. Opladen 1978.

Walter M. Sprondel / Richard Grathoff (Hrsg.): Alfred Schütz und die Idee des Alltags in den Sozialwissenschaften. Stuttgart 1979.

Bernhard Waldenfels: In den Netzen der Lebenswelt. Frankfurt a. M. 1985, ³2005.

Richard Grathoff: Milieu und Lebenswelt. Frankfurt a. M. 1989, Nachdr. 1995.

Өөрчлөлт (Wandel)

Нийгмийн “өөрчлөлт” гэдгээр харьцангуй тогтвортой нийгмийн бүтцүүдийг хамарсан цогц өөрчлөлтийг илэрхийлдэг. Өөрчлөлт болон тогтвортой байдал нь харилцан хамааралтай оршдог. Өөрчлөлтийг зөвхөн тогтвортой байдлын цаана байгаа шалтгаанаар хүлээн зөвшөөрч болно, мөн эсрэгээрээ байх боломжтой юм. Мөн хүрээлэн буй орчны нөхцөл байдал (→ хүрээлэн буй орчин) өөрчлөгдөж байгаа тул нийгмийн бүтэц, → тогтолцооны (хэт) тогтвортой байдлыг зөвхөн бүтцийн өөрчлөлтөөр л хадгалах боломжтой. Нийгмийн өөрчлөлтийн процессыг өөрчлөлтийн хурд, хамрах хүрээ, чиглэл болон чиглүүлэгдэх боломжтой байдлаар нь ялгаатай авч үздэг. Нийгмийн өргөн цар

хүрээтэй, хурдацтай өөрчлөлтийг “хувьсгал” гэж нэрлэдэг. Нийгмийн өөрчлөлтийг өмнө нь тодорхойлсон чиглэлд өөрчлөгдөхийг нийгмийн “хөгжил” (→ хувьсал) гэж нэрлэдэг. Энэ нь тодорхой зорилгод чиглэсэн эсвэл төгсгөлгүй, ахиц дэвшил рүү эсвэл ухарсан байдалтай, мөн аажмаар эсвэл үе шаттай байж болно. Нийгмийн өөрчлөлтийг ихэвчлэн (Auguste Comte und Karl Marx) нарын бүтээлээр зорилгод чиглэсэн эсвэл хянах боломжтой гэж үздэг байсан бол өнөөдөр телеологийн болон зорилгод хүрч болохуйц төлөвлөх үйл явцын хөгжлийн төсөөллөөр зөвхөн аль нэг салбарт хэрэгжүүлэх боломжтой болжээ. Шинэчлэлийн онолын уламжлалт үзэл баримтлалын дагуу (→ шинэ үе) нийгмийн өөрчлөлт нь → нийгэм доторх болон хоорондын өрсөлдөөнт үйл явцаас үүсдэг. Зорилгоо рационал байдлаар чиглүүлсэн нийгэм нь зохион байгуулалтаар хэрэгждэг. Эдгээр нь функциональ байдлаар илүү ялгаатай (мэргэшсэн), илүү ахисан түвшинд интеграцчилагдсан (хамтын ажиллагаанд суурилсан) байх бөгөөд ингэснээр илүү үр дүнтэй (→ ялгаатай байх, интеграци) ажилладаг. Энэ хүрээнд Herbert Spencer (*Principles of Sociology*, 1874, dt. 1877, § 223) нь шинэчлэлийн дагуу “ижил төстэй холбоос байдлаас”, “холбогдсон олон янз байдал”-руу шилжих хөгжил гэж үзсэн.

Talcott Parsons-ны («Evolutionäre Universalien der Gesellschaft», in: *Theorien sozialen Wandels*, hrsg. von Wolfgang Zapf, 1969) үзлээр нийгмүүд нь зөвхөн тэр нөхцөлд амьд үлддэг, хэрэв тэнд “хувьслын универсал”

байдал бий болох үед: үүнд, хууль ёсоор албажсан нийгмийн хүрээлэл (→ анги), бюрократ тогтолцоо, мөнгө болон зах зээлийн зохион байгуулалт, ерөнхий хүчин төгөлдөр → норм, мөн түүнчлэн ардчиллаар → зохион байгуулагдсан институциуд орно. Орчин үеийн онолууд (Shmuel N. Eisenstadt, *Die Vielfalt der Moderne*, 2000) нь шинэчлэлийг зөрчилдөөнтэй болон хөгжлөөс ухарсан байдлаар хэрэгжүүлдэг. Түүнчлэн энэ нь олон янзын ялгаатай нийгэмд өөр өөр байдлаар өрнөдөг. (Нео) Марксист онолууд илүү гутранги дүгнэлтүүд гаргадаг (→ материалист нийгмийн онол). Тухайлбал, “зохицуулалтын онол”-оор (Michael Aglietta, *Ein neues Akkumulationsregime. Die Regulationstheorie auf dem Prüfstand*, 2000) “Фордизм”-ыг “постфордизм”-оор солив” гэж мэдэгдсэн: тэрээр хөдөлмөрийн хуваарилалтай, эдийн засгийн өсөлттэй, дахин хуваарилалт хийдэг нийгмийн баримжаат төрт улс, ерөнхий массын хэрэглээ (→ масс), стандартчилсан үйлдвэрийн норм болон өмнөх хэрэгжүүлсэн хөгжлийн үзэл баримтлалаас ухарч эхэлсэн гэжээ. Капиталист улс орнууд (→ капитал) нь нийгмийн халамжийн өөрчлөлтийг багасгах, үйлдвэрлэлийг аутсорсинг хийх байдлаар зохицуулах, → индивидуалчлал болон түүний уян хатан байдлыг бий болгох ёстой гэж үзжээ.

Нийгмийг хамарсан бүхэл өөрчлөлт нь олон төрлийн хүчин зүйлсийн нөлөөлөлд байдаг. Энэ нь янз бүрийн судалгааны тэргүүлэх чиглэлийг үүсгэдэг. Мэдээллийн технологийн хурдацтай хөгжлийг дагалдсан технологийн өөрчлөлт нь илүү их өндөр

чадвар шаардахын зэрэгцээ илүү их рационал байдлыг бий болгоход хүргэж байна. Анхдагч (*хөдөө аж ахуйн*) болон хоёрдогч (*үйлдвэрлэлийн*) салбарын дараа нь гуравдагч салбарт бэлэн бус үйлчилгээний ажиллагаа хумигдсан. → Даяарчлалыг дагалдсан мэдээлэл, капитал болон ажиллах хүчний (→ хөдөлмөр) солилцоо эдийн засгийн өсөлтийг хурдасгаж, капиталист нийгмийн оролцогч талуудын бүтцийг бий болгож, үндэсний болон олон улсын түвшинд орлогын тэгш бус байдлыг нэмэгдүүлж байна. Барууны аж үйлдвэржсэн улс орнуудад төрөлт багасаж, хүн амын хэт хөгшрөлт нь *хүн ам зүйн өөрчлөлтийг* бий болгож байна. Нийгмийн даатгалын тогтолцоо нь өндөр насжилт, өвчтөний ачааллыг үүрэх ёстой ч санхүүжилтийн суурь нь харин багасаж байна (→ нийгмийн баримжаат төрт улс). Эрхэмжит зүйлсийн өөрчлөлтөөр материаллаг болон хариуцлагын үнэт зүйлсийн хүрээнд өөрийгөө хөгжүүлэх эрхэмж нь материаллаг зүйлсээр солигдсон. Үүнтэй холбоотойгоор гэр бүлийн хэлбэрийн төрөл (→ гэр бүл) олширч, → амьдралын хэв маяг нь ялгаатай болсноор амьдралын хэв шинж хувь хүний асуудал болжээ. Мөн → шилжилт хөдөлгөөн нь зэрэгцэн орших янз бүрийн соёл, норматив болон шашны эрхэмтэй үнэт үйлсийн загварыг үүсгэж байна. Сүүлийн үеийн эдгээр үйл явц нь *нийгмийн интеграцийн* асуудлын тухай олон тооны нийгэм, социологийн мэтгэлцээний эхлэл болжээ.

Herrmann Strasser / Susan C. Randall: Einführung in die Theorien des sozialen Wandels. Darmstadt/Neuwied 1979.

Stefan Hradil: Sozialer Wandel. Gesellschaftliche Entwicklungstrends. In: Bernhard Schäfers / Wolfgang Zapf (Hrsg.): Handwörterbuch zur Gesellschaft Deutschlands. Opladen 2001. S. 642–653.

– Die Sozialstruktur Deutschlands im internationalen Vergleich. Wiesbaden 2004, 2006.

Постмодерн (Postmoderne)

“Постмодернизм” нь ХХ зууны хоёрдугаар хагаст парадигматик байдлаар илэрсэн олон ургалч байдал, төвлөрлийг сааруулах, хоёрдмол утгатай нөхцөл байдлаар туршлагажсан → орчин үеийг нэрлэдэг. Тиймээс энэхүү илэрхийлэл (зарим үед хожуу модернизм гэсэн нэр томьёогоор) нь олон янзын соёлууд, шинжлэх ухааны хэрэглээнд цаг хугацааны илэрхийлэл, тухайн эрин үеийн нэр томьёо болж, тэр утгаараа орчин үеийн хямрал болон тэдгээрийн гол үзэл (ерөнхий байдлаар хөгжил, хувь хүн → эрх чөлөө, бүх нийтээр хэрэглэгдэх дүрэм), мөн амьдралын шинэ хэлбэрийг хөгжүүлэх, түүнчлэн норматив утгаараа бууршгүй олон талт байдлын утга санааг нэгтгэн илэрхийлдэг. Постмодернизмын үндсэн нэр томьёог анх гоо зүйн салбарт шинэ загварын шинж чанарыг тодорхойлох (тухайлбал, замбараагүй, тодорхой бус байдал) утгаар ашигласан.

Социологийн мэргэжлийн нэршлийн хувьд “постмодернизм” нь хэд хэдэн агуулгаараа хамааралтай: (1) “Постмодернизм” нь орчин үеийн эрхэмжит зүйлсийн хямралд орсон нийгмийн бүхий л салбарт нөлөөлж буй технологи, соёлын → өөрчлөлтийг илэрхийлдэг (Amitai Etzioni, *The Active Society*, 1968, dt. 1975). Daniel Bell (*The Coming of Post-Industrial Society. A Venture in Social Forecasting*, 1973, dt. 1975) нь постмодернизмын үзэл баримтлалтай ижил төстэй байдлаар хүн төрөлхтний өөрийгөө тодорхойлох чадвараас тусгаарлагдсан “постиндустриал нийгэм” буюу аж үйлдвэржсэн нийгмийн дараах үеийн технократ үйл явц хэмээн дүгнэсэн. Юуны өмнө орчин үеийн хөгжлийн талаарх өөдрөг үзэл энэ хүрээнд эргэлзээ төрүүлж байна.

(2) “Постмодернизм” нь бодит байдлын тухай ойлголт өөрчлөгдсөнийг илэрхийлдэг бөгөөд үүгээрээ эх хувь ба хуулбар хоёрын ялгаа, жинхэнэ → бодит байдал ба урлаг хоорондын ялгаа улам бүдгэрч байна. Jean Baudrillard (*L'échange symbolique et la mort*, 1976, dt. 1982) дагасан постмодернизмыг дижитал технологиор бий болгосон хуурамч буюу төсөөллийн бодит байдлын эрин үе гэж үздэг. Гоо зүйн үндсэн шинж чанар нь бодит байдлын өөрийнх нь таних тэмдэг юм (*Wege aus der Moderne: Schlüsseltexte der Postmoderne Diskussion*, hrsg. von Wolfgang Iser, 1988). Постмодернизмын өөр нэг шинж чанар бол нийгмийн үйл явцыг “хурдасгах” явдал (Hartmut Rosa, *Beschleunigung. Die Veränderung der Zeitstrukturen in der Moderne*, 2004).

(3) Зохиол болон бодит байдлын хоёрдмол утгатай (тодорхой бус) байдлаас шалтгаалан Dietmar Kamper («Nach der Moderne – Umriss einer Ästhetik des Posthistoire», in: *Wege aus der Moderne: Schlüsseltexte der Postmoderne-Diskussion*, hrsg. von Wolfgang Iser, 1988) нь гоо зүйн сэдвийн онолын статусыг тодорхойлж, ойлголтыг танин мэдэхүйн давуу тал болгон сайжруулсан.

Jean François Lyotard (*La condition postmoderne*, 1979, dt. 1986) нь хамгийн чухал “постмодерн” онолын үзэл баримтлалыг боловсруулж, тэрээр Michel Foucault-ийн постструктурализмын шүүмжлэлийн (→ постструктурализм) нэгэн адил орчин үеийн антропоцентризм, нэгдмэл сэтгэлгээний талаарх постмодернизмыг “мета өгүүлэмжийн буюу эртний тайлбарын төгсгөл” гэж ойлгосон. Бүхнийг хамарсан нэгдмэл байдал алдагдаж байгаа нь орчин үеийн гэж гомдоллохоо больж, харин бидний хэл, бодит байдлын талаарх олон тооны бүтцийг ухаарах явдал гэж хүлээн авч байна. Постмодернчуудын эцсийн үндэслэл, цогц сэтгэлгээний эсрэг санал нь олон тооны бууруулж боломгүй амьдралын хэлбэр, соён гэгээрүүлэх, рационал хэлэлцүүлгийн уламжлалыг эвдэж, дур зоргын асуудал болж байна уу гэсэн асуулт өөрөө маргаантай сэдэв. Albrecht Wellmer (*Zur Dialektik von Moderne und Postmoderne*, 1985) нь постмодернизмыг орчин үеийн тогтмол өөрчлөлт гэж тайлбарласан. Jacques Derridas (*Marges de la philosophie*, 1972, dt. 1988)-ын нэр томъёоны нуугдмал шилжилтийн анализ (деконструкцийг задлахтай холбоотой) болон Gilles Deleuzes (Gilles Deleuze / Félix Guattari, Rhizome.

Introduction, 1976, dt. 1977)-ын модны ишний бүтцийн загварыг (цаашид газрын гүнд салбарлан дэлгэрэх) Wolfgang Welsch (*Unsere postmoderne Moderne*, 1987) нь постмодерн рационал загвар болгон боловсруулсан. “Хөндлөн сэтгэлгээ” гэх концептоор тэр “гоо зүй, ёс зүй” болон онолын ухамсарт хэлбэрүүдийн хоорондын шилжилтийг онцолсон. 1980-аад онд постмодернизмын талаарх өргөн хүрээг хамарсан мэтгэлцээн нь тодорхой хэмжээнд намжсан. “Постмодернизм”-ын зарим үндэслэл нь одоо хэсэгчилсэн байдлаар тусгаарлагдаж, гэхдээ цаг үеийн үнэлэлт дүгнэлтийг нэхэмжлэлгүйгээр нарийн мэргэжлийн чиглэл хэмээн авч үздэг болсон.

Социологийн хувьд “постмодернизм” нь нийгмийн ижилсэх хандлагыг бий болгох (Richard Harvey Brown, *Society As Text*, 1987; Seyla Benhabib, *Situating the Self*, 1992, dt. 1995; Heinz-Günter Vester, *Soziologie der Postmoderne*, 1993), зохион байгуулалтын өөрчлөгдөж байгаа бүтцийг олон янзаар эргэцүүлэн бодох эхлэлийн цэг юм (*Organisation und Postmoderne*, hrsg. v. Georg Schreyögg, 1999; → ижилсэл, байгууллага).

Ralf Beuthan

Scott Lash: *Sociology of Postmodernism*. London [u. a.] 1990.

Zygmunt Bauman: *Intimations of Postmodernity*. London [u. a.] 1992.

– Dt.: *Ansichten der Postmoderne*. Übers. von Nora Räthzel. Hamburg 1995.

Thomas Docherty (Hrsg.): Postmodernism. A Reader. New York 1993, 31995.

Félix Duque: Moderne/Postmoderne. In: Hans Jörg Sandkühler (Hrsg.): Enzyklopädie Philosophie. Bd. 1. Hamburg 1999. S. 859–864.

Peter V. Zima: Moderne – Postmoderne. Tübingen [u. a.] 1997, 22001.

Постструктурализм (Poststrukturalismus)

“Постструктурализм” нь 1960-аад оноос хойш Франц улсад хөгжсөн, онолын структурализмын үндсэн хэл шинжлэлийн таамаглалыг хадгалахын зэрэгцээ структурализмаас шүүмжлэлт байдлаар ялгардаг, үзэл баримтлалыг нэгтгэсэн ойлголт юм. “Постструктурализм” нь структурализмаас салсан хэсэг биш, “дараах” хэмээн заасанчлан, Manfred Franks-ийн дүрслэлээр “Neostrukturalismus” (Was ist Neostrukturalismus?, 1983) бага боловч шинэ эхлэл шиг, харин структуралист сэтгэлгээний хувьд радикалжилт юм. “Постструктурализм”-ын гол төлөөллүүд нь Jacques Derrida, Michel Foucault, Jacques Lacan, Gilles Deleuze, Jean-Luc Nancy, Judith Butler und Ernesto Laclau нар юм.

Структурализмыг үндэслэгчдийн нэг бол Ferdinand de Saussure, тэр өөрийн ерөнхий хэл шинжлэлдээ (*Cours de linguistique générale*, 1916, dt. 1931) утгыг нөхцөлийг хэл шинжлэлийн өмнөх бодит байдлын дүрслэл гэж үзэх больж, харин → мэдрэхүй болон хэлийн

системийн ялгаагаар болон тэмдгийн харилцаагаар бий болсон хэмээн ойлгож байв (→ систем). de Saussure хэлснээр утгууд нь бусад шинж тэмдгүүдтэй ялгаатай харилцаанаас үүсдэг байна. Тиймээс → бүтцийг бие даасан элементүүдээр нь тайлбарлахгүй, харин элементүүдийн хоорондын хамаарлаар нь тайлбарладаг. Saussures-ын арга барилыг Claude Lévi-Strauss (*Les structures élémentaires de la parenté*, 1949, dt. 1981) авч хэрэгжүүлснээр нийгмийн шинжлэх ухаанд хүчтэй нөлөөлж, тэрээр өөрийн бүтцийн антропологид структуралист арга зүйг ураг төрлийн системдээ өргөжүүлсэн. → Субъект нь бүтцэд захирагдана гэж Lévi-Strauss таамаглал дэвшүүлсэн. Энэ нь зөвхөн тэднээс бүрддэг гэсэн утгыг илэрхийлнэ. Энэ нь ихэнхдээ үл ойлголцолд хүргэж, структурализм нь “субъектийн үхэл”-ийг номлодог гэж буруутгахад хүргэдэг. Saussure-аас гадна Lévi-Strauss, Marcel Mauss нар нь нийгмийн шинжлэх ухаанд структурализмын анхдагч хэмээн тунхагласан. Учир нь тэрээр *Essai sur le don* (1925, dt. 1968) номдоо симболын (→ симбол) социологийн утгыг авч үзсэн бөгөөд харилцаа, харилцан хамаарал (харилцан харилцаа)-ыг анх нээсэн хүмүүсийн нэг юм. Mauss нь Georges Bataille (*La notion de dépense*, 1933, dt. 2001)-ийн хамгийн чухал хамааралтай сэтгэгчээр ажиллаж, түүний социологийн коллежид постструктурализмын бусад шинж тэмдгүүдийн талаарх ишлэл, ижил бус болон ялгаатай байдлыг зохиосон. Бусдад (гаднах байдлаар нь бүтцийн онолоос хасагдсан “үлдсэн хэсэг”) шударга байх шаардлага нь Foucault-ийн хувьд “галзуурал”, “гэмт хэрэг” болон

“бэлгийн харьцаа” сэдвүүдээр, түүнчлэн, Derrida (Adieu à Emmanuel Lévinas, 1997, dt. 1999) нь өөрийн ёс зүй-улс төрийн сэтгэлгээгээ дагаж мөрдсөн. Үүнтэй хамааралтай постструктурализмын шинж тэмдэг бол структурализмыг өөрийн нь нэгдмэл сэтгэлгээний улмаас шүүмжилдэг. Хаалттай, тогтвортой болон статик төвөөр хангагдсан бүтцийг урьдчилсан нөхцөл болгохын оронд постструктурализм нь түүхэн үйл явц, хөндлөнгийн оролцоо, боломжгүй зүйлд мэдрэмжтэй, хэзээ ч бүтцийг хаах эсвэл универсал болгоход чиглэнэ. Учир нь энэ үргэлж өөр ямар нэг зүйлээс, бүтцийг бүрдүүлэгч гаднаас хамаардаг. Бүрдэлдэхүүн хэсгүүдийг авч үзэхээс эхлээд соёлын код болон бүтцийн хэсгийн зааг хоорондыг шилжилтийн харах өнцөг нь төвлөрөл буурах, утгын хамаарлыг багасгах (→ утга) эсвэл дискурсийн шилжилт (→ дискурс) гэж онолддог.

“Бусад” гэсэн төсөөлөлд чиглэсэн структурализмын радикалжилт нь → нийгмийгүзэхүзэлднөлөөлсөнбөгөөд Laclau und Chantal Mouffe (*Hegemony and Socialist Strategy*, 1985, dt. 1991) нар хаалттай тотал байдлаар төлөвших гэдгийг боломжгүй оролдлого гэж тайлбарлаж байв. Бүтцийн төвлөрлийг сааруулах нь субъектив байдлын сэтгэлгээнд нөлөөлөх боломжтой. Тэд Foucault-ийн нэгэн адил дискурсээр болон эрх мэдлийн харилцаанаас (→ эрх мэдэл) бүрдсэн байр суурь (*La volonté de savoir*, 1976, dt. 1983), эсвэл нийгмийн гүйцэтгэлийн практикт давтамжтайгаар бий болох түр зуурын субъектив байдал хэмээн Derrida oder Butler (*Bodies That Matter*, 1993, dt. 1995) нар шиг ойлгож байв. Түүхэн-дискурсив,

төвлөрсөн бус байдалтай, үргэлж өөр нэг субъектийн анхаарлыг татдаг, холимог (өөрөөр хэлбэл, олон янзын хэсгүүдээс бүрдэх, нэгдмэл байдлаар тооцогдохгүй) субъект гэсэн таамаглал нь нийгмийн шинжлэх ухааны анализад (жишээ нь, хүйс, соёл, ангиллын өвөрмөц байдал, колоничлолын дараах; → соёл, анги) → ижилсэлд хамааралтай, нэгдмэл байдлаар биш, харин бүтцээр, эрх мэдлийн харилцаагаар, дискурсад суурилсан, ихэвчлэн ухамсарлагдаагүй ба маргаантай таниулах үйл ажиллагаа гэж ойлгогддог. Нийгмийн практикийн үзэл баримтлалыг нөгөө талаас авч үзэхэд гаднаас нь бүрэлдэн тогтдог тул практик байдалд телеологийн зорилгот чиглэсэн (өөрөөр хэлбэл, зорилготой) үйлдэл ч биш, бүтцээр урьдчилан тодорхойлсон ч биш, харин нэгэн зэрэг бүтцээс бусад бүтцэд (а-бүтэцжисэн) гарч ирсэн гэж тодорхойлдог. Практик гэдэг нь Derrida-гийн (*Politiques de l'amitié*, 1994, dt. 2000) хэлснээр нөгөөгөөр өдөөгдөн давтагдах (давтан тохиолдог) креатив бүтээлч “миний хувьд нөгөө нэгнийх нь идэвхгүй шийдвэр” гэж ойлгогддог. Арга зүйн хувьд дараах хоёр процедур нь постструктурализмын шинж чанартай байдаг: нэг талаас Foucault-аас эхлэлтэй дискурс анализ, нөгөө талаас Derrida-гийн деконструкцийн практик. Энэ нь структурализмын ердийн хос хэв шинжийн (хоёр талт) эсрэг тэсрэг байдлыг урвуу болгодог ба бүх хосолмол логикийг өөрчлөхийг оролддог байна. Тухайлбал, эсрэг хүйстний сексийн хүсэл тэмүүлэлтэй адилтгах нь үндсэндээ эхнийхийг бодож, мэдрэх чадвартай байхын тулд ижил хүйстний бэлгийн харилцаанд

оршдог болохыг харуулсан төдийгүй, харин хоёр дахь шатанд бэлгийн дур хүслийн бүх нийтлэг мэт санагдах хосолмол бүтцийг бүхэлд нь өөрчлөхийн тулд бэлгийн харилцааны талаарх энэхүү нийтлэг дуалист үзэл ч гэсэн энэхүү хоёрдмол бүтцийн (ижил хүйстний бэлгийн харьцаа, транссексуал харилцаа гэх мэт) хасагдсан өөр нэгэнтэй тулгардаг.

Stephan Moebius

François Dosse: Histoire du structuralisme. 2 Bde. Paris 1991/92.

– Dt.: Geschichte des Strukturalismus. 2 Bde. Übers. von Stefan Barmann. Frankfurt a. M. 1996/97, Nachdr. 1999.
Stefan Münker / Alexander Roesler: Poststrukturalismus. Stuttgart/Weimar 2000.

Urs Stäheli: Poststrukturalistische Soziologien. Bielefeld 2000.

Stephan Moebius: Die soziale Konstituierung des Anderen. Grundrisse einer poststrukturalistischen Sozialwissenschaft nach Lévinas und Derrida. New York / Frankfurt a. M. 2003.

– / Andreas Reckwitz (Hrsg.): Poststrukturalistische Sozialwissenschaften. Frankfurt a. M. 2008.

Рационал сонголтын онол (Rational-Choice-Theorie)

“Рационал сонголтын онол” нь социологийн судалгааны чиглэл бөгөөд микро түвшинд → хязгаарлагдмал нөөцтэй → оролцогчид зорилготой (→ үйл ажиллагаа) ажилладаг гэж үздэг. Тиймээс оролцогчид боломжит нөөцөөс эсвэл “үйлдлийн хязгаарлалт”-тай хувилбаруудаас сонголт хийх боломжтой байдаг. “Зорилгот чиглэсэн” гэдэг нь оролцогчид тухайн нөхцөлд аль болох зорилго, хүсэл сонирхол (таашаалыг) гүйцэлдүүлэхийн тулд үйл ажиллагааны чиглэлийг ийм байдлаар сонгохыг хэлнэ. Энэ төрлийн зан үйлийг өргөн утгаараа “рационал” гэж нэрлэж болно. Урьдчилан таамаглах, тайлбарын хувьд хязгаарлалт (хязгаарлалт) нь онцгой ач холбогдолтой. Рационал сонголтын онолын чухал хэсэг бол макро түвшний нийгмийн үйл явдал эсвэл үйл явцыг, тухайлбал, нийгмийн хөдөлгөөн, өөрчлөгдөж буй гэмт хэргийн түвшин, эдийн засгийн өсөлт (→ эдийн засаг), → шилжилт хөдөлгөөн, ажилчин ангийн хүүхдүүдийн боловсрол эзэмших боломж (→ боловсрол) гэх мэтийг нийгмийн нөхцөлд хувь хүмүүсийн үйлдлээр, институцийн өгөгдсөн нөхцөлөөр (→ институци) тайлбарлаж болно. Математик → загварчлал эсвэл компьютерын симуляцийг ихэвчлэн хувь хүмүүсийн макро үр дүнтэй үйлдлүүдийг нэгтгэхэд (нэгтгэх, холбох) ашигладаг. Рационал сонголтын онолыг хэрэглэх (маш хялбаршуулсан) жишээг Thomas C. Schelling (*Micromotives and Macrobehavior*, 1978) нь хоёр

угсаатны $\rightarrow A$ ба B бүлэгт харьяалагддаг, “үлдэх” эсвэл “явах” хувилбаруудын аль нэгийг сонгох боломжтой оролцогчдын нөхцөл байдлын дүн шинжилгээгээр илэрхийлдэг. Оролцогч бүр дээд тал нь найман хөрштэй байхаар оролцогчдын оршин суух газруудыг шатрын самбарын хэв маягаар загварт байрлуулсан. Угсаатны бүлгүүд бие биедээ дайсагналцдаггүй ч ямар ч оролцогч ойр дотнын хүрээнээ цөөнх байхыг хүсдэггүй байна. Микро түвшинд рационал сонголтын онолын таамаглал энгийн байдаг. Хөршүүдийн тал хувь нь ижил төрлийн хүмүүс байвал оролцогчдын зорилго хамгийн сайн биелдэг. Ийм нөхцөлд тэр үлдэх бөгөөд эс тэгвээс тэр нүүх болно. Шийдвэр болгон бусад оролцогчдын шийдвэрт нөлөөлдөг нь ойлгомжтой. Үүгээр нийгмийн динамик өдөөгдөх бөгөөд компьютерын симуляци ашиглан үүнийг судалж болно. Санамсаргүй байдлаар анхны байрлалыг холих үед A ба B бүлгүүдийг бүрэн тусгаарлах (салах) тогтвортой эцсийн төлөв үргэлж ажиглагдаж болно. Үүнтэй зэрэгцэн тухайлбал, рационал сонголтын онол өөр нэг харах өнцөгт анхаарал хандуулдаг. Ихэвчлэн макро үзэгдэл нь хувь оролцогчдын харилцан уялдаатай, зорилгод чиглэсэн үйлдлүүдийн хүсээгүй үр дагавар болж гарч ирдэг. Рационал сонголтын онолын хувилбарууд нь үндсэн шийдвэрийн дүрмээр тодорхойлогдох боломжтой. Стандарт загвар нь субъектив хүлээгдэж буй ашиг тусыг дээд зэргээр нэмэгдүүлэхийг шаарддаг (Subjectively Expected Utility-Theorie). Сонгодог эдийн засгийн онолын homo oeconomicus-аас ялгаатай нь рационал

сонголтын онол бүрэн бус мэдээлэлтэй шийдвэр гаргах нөхцөл байдлыг, шударга ёсыг эсвэл материаллаг бус ашиг сонирхлыг болон нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх байдлыг харгалзан үздэг (Siegwart Lindenberg / Bruno Frey, »Alternatives, Frames, and Relative Prices: A Broader View of Rational Choice«, in: *Acta Sociologica* 36, 1993). Социологийн хувьд хоёр ба түүнээс дээш оролцогчтой шийдвэр гаргах нөхцөл байдлыг ялангуяа, сонирхдог ба энд Schelling-гийн загвар шиг үйл ажиллагааны үр дүн бусад оролцогчдын үйлдлээс хамаардаг. Нийгмийн харилцаанд оролцогчид шийдвэр гаргахдаа бусад оролцогчдын үйл ажиллагааны сонголтыг харилцан харгалзан үзэж байгаа нөхцөлд “стратегийн харилцан хамаарал” гэж үзэх бөгөөд ийм нөхцөлд анализ хийхдээ тоглоомын онолын загваруудыг ($\rightarrow$ тоглоом) ашигладаг. Үүний тод жишээ нь Robert Axelrod (*The Evolution of Cooperation*, 1984, dt. 1986), бүтээл бөгөөд тэр хувиа хичээсэн оролцогчдын дунд ч гэсэн нийгмийн дэг журмын хэлбэрүүд гарч ирж болно гэдгийг олон удаагийн “хоригдлуудын дилемма” төрлийн тоглоомын үндсэн дээр харуулж чадсан юм. (“Хоригдлуудын дилемма”-д хоёр тоглогч хамтран ажиллах (C) эсвэл хамтран ажиллахгүй (D) гэсэн сонголттой байдаг. Тэд нэг нэгнээсээ хамааралгүйгээ сонголтлоо хийдэг. Хэрэв хоёулаа хамтран ажиллахыг (CC) сонгосон бол энэ жишээн дээр тус бүр гурван оноо авна. Хэрэв хоёулаа хамтран ажиллахгүй (DD) нөхцөлд тэд тус бүр нэг оноо авна. Хэрэв нэг тоглогч D, нөгөө нь C сонгосон нөхцөлд D тоглогч таван оноо авдаг бол “хожигдсон” C тоглогч

тэг оноо авна. Хамтран ажиллагааны тоглоом нь нийгмийн олон асуудлын үндэс болсон хувь хүн (DD) болон коллектив рационал байдлын (CC) хоёрдмол бэрхшээлийг харуулдаг). Рационал сонголтын онолыг хөгжүүлэх, түгээхэд Gary S. Beckers (*The Economic Approach to Human Behavior*, 1978, dt. 1993), Mancur Olsons (*The Logic of Collective Action*, 1965, dt. 1968) und James S. Coleman (*Foundations of Social Theory*, 1990, dt. 1991) нарын бүтээл хамгийн чухал хувь нэмрийг гүйцэтгэсэн. Raymond Boudon (*Die Logik des gesellschaftlichen Handelns*, 1980)-ын бүтээл нь сонгодог социологийн судалгаа болон орчин үеийн рационал сонголтын онолын хоорондын зөрүүг холбоход тусалсан. Рационал сонголтын онолын таамаглал, танин мэдэхүйг өнөөдөр социологийн онол авч, социологи болон холбогдох салбаруудын олон судалгааны салбарт хэрэглэж байна.

Andreas Diekmann

Karl-Dieter Opp: Die Entstehung sozialer Normen. Ein Integrationsversuch soziologischer, sozialpsychologischer und ökonomischer Erklärungen. Tübingen 1983.

Erich Weede: Mensch und Gesellschaft. Tübingen 1992.

Hartmut Esser: Soziologie. Allgemeine Grundlagen. Frankfurt a. M. 1993, 31999.

Andreas Diekmann / Thomas Voss (Hrsg.): Rational-Choice-Theorie in den Sozialwissenschaften. München 2004.

Peter Hedström: Dissecting the Social. On the Principles of Analytical Sociology. Cambridge [u. a.] 2005.

Символ (Symbol)

Символ буюу “бэлгэдэл” (грекээр “*symbolon*” = “дахин нэгдсэн”) гэдэгт ерөнхийлөн нэг идеал агуулгыг объекттэй холбох дүрслэл хэмээн ойлгоно. Тиймээс тухайлбал, бөгжний хийсвэр идеал бол үнэнч байх эсвэл мотоцикл бол эрх чөлөөтэй байх гэдгийг бэлгэддэг. Нэг ижил объектийг янз бүрийн өнцгөөс өөр өөр симболд ашиглах боломжтой. Энэ нь тухайлбал, түүхийн болон соёлын хамаарлаар хувьсан өнгөнүүд симболыг илэрхийлж болно. Аль нэг тодорхой объект (байгалийн гадаад шинжийг илэрхийлэх юмс эсвэл урлаг, хэлээр илэрхийлэх үгс, дохио зангаа, → үйлдлүүд гэх зэрэг) нь симболын үнэлэмж, эрхэмжийг илэрхийлэхээс шалтгаалан → оролцогч тал өөрсдийн харах өнцгөөр тухайн утгыг тээгчийг тодорхой ийм төрлийн өвөрмөц → мэдрэмжээр хангагддаг, тэр мэдрэмж нь өдөр тутмын хэвшмэл байдлын заагийг давсан функциональ болон ёс бус байдлаас илүү хамааралтай байдаг. Хэрэв тогтсон үйлдлийн хэв маяг өдөр тутмын бус, чухал симболын утга, үнэ цэнийг олж авсан тохиолдолд үүнийг хүмүүс → зан үйл гэж нэрлэдэг.

Хамгийн тохиромжтой агуулга бүхий утгыг хаалтад оруулах нь хүмүүсийн хувьд ердийн зүйл болох санаа нь ялангуяа Ernst Cassirer-оос эхлэлтэй. Тэр *Homo symbolic* гэсэн нэр томъёог анх хэрэглэсэн (*An Essay on Man*, 1944, dt. 1960; »Der Begriff der symbolischen Form im Aufbau der Geisteswissenschaften« [1923], in: E. C., *Wesen und Wirkung des Symbolbegriffs*, 1997). Соёлоор бэхэжсэн

утга, агуулгын мэдрэмжийн конструкт нь Cassirer-ийн хэлснээр симболд суурилдаг. Тэднээр уламжлан дэлхий ертөнц хүмүүсийн өөрсдийнх нь бүтээсэн утга санааг хүлээн авдаг байна. Өөрсдөө бүтээсэн утга санааны үр дүнг симболоор харах өнцгийг мөн → симболик интерактивизмд болон феноменологийн социологид онцгойлон авч үздэг. Alfred Schütz нь Edmund Husserl-ийн өмнөх бий болгосон ухагдахууныг “*Appräsentation*” буюу тухайн цаг үед хийх үйлдэл гэх агуулгыг симболын онолын үзэл баримтлалын цөм болгон авч үзсэн («Symbol, Wirklichkeit und Gesellschaft» [1955], in: A. S., *Gesammelte Aufsätze I*, 1971).

Тэр симболыг шинж тэмдгээс (“Утаа галыг илтгэх” нь байгалийн шинж тэмдэг), таних тэмдэг (“Алчуурын зангилаа” нь хувь хүний таних тэмдэг), тэмдэг (“субъект хоорондын уламжлалт утгыг тээгч” нь хэл) гэж хооронд нь ялгаатай байдлаар авч үзсэн. Эцэст нь тэрээр субьектийн өвөрмөц байдлын онцлог шинж чанарыг өдөр тутмын амьдралын утга учрыг даван туулахад оршиж байна гэж таамагласан. Утгыг тодорхой илэрхийлэхийн тулд хүмүүс өөрт мэдрэгдэхүйц зүйлээр → бодит байдлыг ашигладаг. Энэ нь бодитойгоор мэдрэгдэх бодит байдлын гадна оршдог. Субьектийн энэхүү шинж чанарыг Karl Jaspers (*Philosophie III. Metaphysik*, 1973) болон Thomas Luckmann (Alfred Schütz u. Thomas Luckmann, *Strukturen der Lebenswelt II*, 1984) нар онцгойлон гаргаж ирсэн. Peter L. Berger und Luckmann (*The Social Construction of Reality. A Treatise in the Sociology of Knowledge*, 1967, dt. 1969)

нарын хувьд “Субъект дэх утгын ертөнц” нь тодорхой функцтэй байдаг бөгөөд тэрээр ертөнцийг үзэх үзлийг хамгийн сүүлчийн инстианциар албажуулдаг гэжээ. Өдөр тутмын бодит байдлыг ахисан түвшний субъекттэй холбогдог. Энэ нь нэг хэлбэр цаашид хэтэрч болохгүй бүхэл утгыг илэрхийлдэг (тухайлбал, → шашнууд). Субъект нь үндсэндээ сэтгэл хөдөл эсвэл оновчтой тайлбарлах боломжгүй агуулгад харилцааны илэрхийлэл (→ харилцаа) болдог гэж Susanne K. Langer (*Philosophy in a New Key*, 1942, dt. 1984) онцолж тэмдэглэсэн. Дискурсив симболын хэл нь Langer-ийн бодлоор аль нэг юмсын агуулгын мэдэгдлийг “алхам алхмаар” тайлдагт оршдог байна. Эсрэгээр төлөөллийн симбол нь тодорхой дүрслэлд нэгэн зэрэг илэрхийлэгдэх, тухайлбал, урлагийн бүтээлд зөвшөөрөгддөг. Victor Turner-ийн үзлээр мөн субъектээр сэтгэл хөдлөлийн сувгийг тодорхойлдог (*The Forest of Symbols*, 1967).

Субъект нь нэг талаас сэтгэл хөдлөлөөр тодорхойлогддог ч мөн нөгөө талаас зэрэгцэн тэр хэмжээгээр мэдээлэл дамжуулдаг. Түүний мэдэрч байгаа хэмжээгээр нь оролцогчийг тодорхой агуулга руу чиглүүлж болно. Сэтгэл хөдлөлийг хадгалах, нөхөх хамгийн чухал социол функц нь Émile Durkheim-аас эхлэлтэй (*Les formes élémentaires de la vie religieuse*, 1912, dt. 1981). Тэрээр симболын харилцааны нийгэмшлийн нөлөөг (→ хамтын нийгэмлэг) онцолсон. Сэтгэл хөдлөлд эзэмдүүлсэн, бүлгийн ижилслийн үндсэн агуулга (→ бүлгүүд) урт хугацаанд үргэлжлэх нь бүлгийн ой санамжтай холбогдсон байх боломжтой. Сүүлийн үеийн

судалгааны чиглэлд Pierre Bourdieu “симболын капитал” гэсэн утгыг гаргаж дэвшүүлсэн (*Le sens pratique*, 1980, dt. 1987). Түүнийхээр симболын → капитал нь нийгэмд нэр хүнд бий болгоход үйлчилдэг. Тодорхой “капиталыг” (эдийн засгийн, нийгмийн эсвэл соёлын капитал) симболын капитал болгож өөрчлөх нь Pierre Bourdieu-гийн хувьд харилцан хамаарал бүхий харилцааны асуудал байв. Симболын үнэ цэн, эрхэмж нь эцсийн дүндээ оролцсон талаар дамжуулан өөрсдийн салбарын логик дотор баталгаажуулахаас хамаарна. Өнөөгийн соёлын социологийн чиглэлийн онолд субъектийн тухай концептуал ойлголт шийдвэрлэх ач холбогдолтой. Түүнтэй хамт нийгмийн болон хүний тухай төсөөллийг рационал тунгаасан харьцуулалт бий болох бөгөөд энэ нь ердийн байдлаар өөрийн дүрслэлд болон → орчин үед хамаарна. Энэ чиглэлийн хандлага нь сэтгэл хөдлөлд хөтлөгдсөн утгын агуулгыг сэдэвчлэн илэрхийлэх чадварыг зөвшөөрдөг. Хаана ижилсэх конструкцион, итгэл үнэмшлийн агуулга болон танин мэдэхүйн зааг байна, тэнд энэ бүхнийг судалгааны сэдэв болгодог.

Christoph Schneider

Horst Jürgen Helle: Soziologie und Symbol. Ein Beitrag zur Handlungstheorie und zur Theorie des sozialen Wandels. Köln/Opladen 1969, ²1980.

Dirk Hülst: Symbol und soziologische Symboltheorie. Untersuchungen zum Symbolbegriff in Geschichte, Sprach-

philosophie, Psychologie und Soziologie. Opladen 1999.
Rudolf Schlögl [u. a.] (Hrsg.): Die Wirklichkeit der Symbole. Grundlagen der Kommunikation in historischen und gegenwärtigen Gesellschaften. Konstanz 2004.
Eckard Rolf: Symboltheorien. Der Symbolbegriff im Theoriekontext. Berlin 2006.

Символик интерактивизм (Symbolischer Interaktionismus)

“Символик интерактивизм” нь тайлбарлах онолуудын нэг бөгөөд тэнд → нийгмийн хэм хэмжээг, → бүтцийг эсвэл дүр, үүргийг биш, харин зөвхөн → хувь хүн, түүний чадвар, үйлдлийн (→ үйлдэл) нөхцөлийг өөрөө зохицуулах нь социологийн анализын цөмд оршдог. Herbert Blumer-ийн онол («The Methodological Position of Symbolic Interactionism», in: H. B., *Symbolic Interactionism*, 1969, dt. in: *Alltagswissen, Interaktion und gesellschaftliche Wirklichkeit*, hrsg. von einer Arbeitsgruppe Bielefelder Soziologen, Bd. 1, 1973) нь символик интерактивизм дээр суурилдаг ба тэрээр 1930-аад оны эхээр өөрийн багш George Herbert Mead-ийн бүтээлд үндэслэн энгийн гурван логик дүгнэлтэд санамсаргүй байдлаар нэр өгсөн:

Хүмүүс аливаа зүйлийг үйлдэхдээ тухайн зүйлийн утгыг үндэс болгодог (*meanings*) ба уг утга нь тэр зүйлд агуулагддаг. Бүх зүйлс бол хүний мэдэрч болох бүх юмс болно. Үүнд физикиал объектууд (тухайлбал, сандал),

бусад хүмүүс эсвэл тэдгээрийн ангилалд хамаарах зүйлс (тухайлбал, дайсан), → (тухайлбал, сургууль), чиглүүлэх идеалууд (тухайлбал, үнэнч байдал), нийгмийн үйлдлүүд (тухайлбал, тушаал) эсвэл өдөр тутмын нөхцөл байдал (→ өдөр тутам) зэрэг нь хамаарна.

Юмсын утга нь нийгмийн → харилцан үйлчлэлээс гаралтай эсвэл зөвхөн эдгээрээс үүсэлтэй харилцан үйлчлэл байдаг. Тэгэхээр утга гэдэг нь нийгмийн бүтээгдэхүүнийг илэрхийлдэг (*social products*).

Энэхүү утга нь тайлбарлах үйл явцад (*interpretative process*) зохицуулагдсан байх ба түүгээр дамжуулан өөрчлөлтөд ордог байна.

Симболын харилцан үйлчлэлийн онолын дагуу нийгмийн харилцан үйлчлэл гэдэг нь хоёроос доошгүй хувь хүмүүсөөр хоорондоо болон харилцан хамааралтай хийх үйлдлийг нэрлэнэ. Энэ нь тэдний нөхцөл байдал, үйлдлийг харилцан тайлбарлах бөгөөд хэл яриагаар дамжуулан тэдний харилцааны зан төлөвийг илтгэдэг. Хэрхэн тэд нэгнээ харах, ямар утга агуулгыг аль нэг тодорхой нөхцөлд ач холбогдол өгч байгааг, өөрсдийн үйлдлийн үр нөлөөг тэд хэрхэн тайлбарлаж байгааг, мөн дараагийн үйлдлийн нөхцөлийг хэрхэн тодорхойлж буй зэрэг нь харагддаг. Хүмүүс харилцан үйлчлэлд нийтлэг → симболыг бий болгох бөгөөд түүндээ өөрсдөө чиглүүлэгддэг. Ийм байдлаар харилцан үйлчлэлийн утга учрыг үргэлжлүүлэн нэгтгэх ба нөхцөл байдлын нийтлэг тодорхойлолтод үүгээр хүрдэг. Тодорхойлолт бүхэн цаашдын харилцан үйлчлэлийг бүтэцжүүлдэг.

Энэхүү микро түвшний онолын суурин дээр симбо-

лын интерактивизм нь макро түвшний онолоо дэвшүүлдэг. Энэ онолын хүрээнд хүмүүсийн → бүлгэм болон нийгэмлэг үндсэндээ зөвхөн хувь хүмүүсийн үйлдлүүдээс үүсдэг. Хүмүүс нэг нэгэнтэйгээ харилцаж, өөрсдөө болон тэдний харилцан хамааралтай үйлдлийг тайлбарладаг. Эндээс дүгнэж үзвэл энэ нь үргэлжлэх үйл ажиллагааны хүрээг тодорхойлдог. Мэдээжийн хэрэг симболын интерактивизм нь байгууллагууд, чиг үүргүүд болон нийгмийн дүрэм, журмыг харгалзан үздэг. Ийм байдлаар харин нийгмийн бодит байдал бий болж, хүмүүс өөрсдийн харилцан үйлчлэлд эдгээр симболоор чиглүүлэгддэг. Симболын интерактивизм нь шууд бус байдлаар сүүлийн үед эмпирик социологийн судалгаанд нөлөөлсөн. Уг нөлөөллөөр хэрхэн хүмүүс симболын ертөнцийг бүтээдэг болохыг, мөн хэрхэн нэг нэгнээ харж нүүр тулсан нөхцөлд харилцдаг болохыг чанарын судалгааны арга зүйгээр хэмжиж байна. Симболын интерактивизмын үндсэн үзэл баримтлал нь Чикагогийн социологийн сургуулийн онолд суурилдаг, *Theorie der Chicago School of Sociology* (William I. Thomas, Florian Znaniecki, Robert E. Park, George Herbert Mead). Тэдний нөлөөлөл → феноменологийн социологи, мэдлэгийн (→ мэдэх) социологи (тухайлбал, Peter L. Berger / Thomas Luckmann, *The Social Construction of Reality*, 1966, dt. 1969), Erving Goffman-ны жүжигчилсэн хандлага (*The Presentation of Self in Everyday Life*, 1959, dt. 1969; *Interaction Ritual*, 1967, dt. 1971), түүнчлэн угсаатан судлалыг (Harold Garfinkel, *Studies in Ethnomethodology*, 1967) хүртэл хамардаг. Jürgen Haber-

mas”-ийн хувьд үүнийг нөхцөл байдлыг тодорхойлон зөвшилцөлд хүрэх тайлбарлах хэрэгсэл гэж үзсэн (*Theorie des kommunikativen Handelns*, 2 Bde., 1981). André Kieserling (*Kommunikation unter Anwesenden. Studien über Interaktionssysteme*, 1999) нь системийн онолтой холбож байв.

Heinz Abels

Heinz Steinert: Das Handlungsmodell des Symbolischen Interaktionismus. In: Hans Lenk (Hrsg.): Handlungstheorien interdisziplinär. Bd. 4. München 1977. S. 79–99.

Heinz Abels: Interaktion, Identität, Präsentation. Wiesbaden 1998, ³2004.

– Einführung in die Soziologie. Bd. 2: Die Individuen in ihrer Gesellschaft. Wiesbaden 2001, ³2007, Kap. 5: Interaktion, S. 184–241.

Horst Jürgen Helle (Hrsg.): Theorie der symbolischen Interaktion. Wiesbaden ³2001.

Hans Joas / Wolfgang Knöbl: Sozialtheorie. Zwanzig einführende Vorlesungen. Frankfurt a. M. 2004, ²2006. [6. Vorlesung: »Interpretative Ansätze«. S. 183–219.]

Систем (System)

“Систем” (грекээр “*systema*” буюу бүтэц, холбогдсон гэх утгатай) гэдэг нь аль нэг дур зоргын үүднээс хувирч, өөрчлөгддөггүй харилцааны хооронд орших янз бүрийн элементээс бүрдсэн нэгж гэж ойлгох бөгөөд энэ

нь цаг хугацааны явцад → хүрээлэн буй орчинтойгоо харилцаанд орохдоо дахин бүтээгддэг байна.

Аливаа элементийг дүрслэх, элементүүд өөр хоорондоо холбогдсон байх, нэг нэгнээсээ ялгарах болон нэг нэгнээс тусгаарлагдсан байх зэргийг танин мэдэх сонирхол нь антикийн үеийн философиос эхтэй. Юуны өмнө хөгжим болон ангаах ухааны салбарт хүмүүс дуу чимээг дүрслэн тогтоох, аль нэг эрхтэнд дүн шинжилгээ хийх, үзэгдлүүдийн нэг хэсэг нь хэрхэн өөрөө өөртэйгөө холбогдох (грекээр *systein* буюу *угсрах*), аль нэг гаднын инстанцийн нөлөөлөл байхгүйгээр энэхүү холбоос нь холбогдох үйлд нөлөөлдөг болохыг олж мэдэхийг сонирхож байв. Орчин цагийн эхэн үед ном хэвлэх ажил бий болохтой зэрэгцэн асар их хэмжээний ном зохиолууд, үзэл санаанууд болон олон тооны үндэслэлүүд гарч ирснээр системчлэх асуудлыг сонирхон хөгжүүлсэн байдаг. Энэ юу болохыг танин мэдэх нийлбэр нь өөрөө систем юм. Энэхүү → мэдлэг нь өөрөө бие даан бий болж үүсэхгүй, харин аль нэгэн зохиогчдын буюу → шинжлэх ухааны мэдлэгийн холбоосоор үүсдэг. Хэрхэн үзэгдлүүд өөр хоорондоо холбогддог болохыг XIX болон XX зууны эхэн үед биологийн онолын хүрээнд асуултаар дэвшүүлсэн байдаг. Энэ хооронд хүрээлэн буй орчны үүрэг рольд хүмүүс ихээр анхаарал хандуулж байна.

Энэхүү үүрэг, роль нь (*ажиглагчийн хувьд ихэнхдээ харагдахгүй*) түүний доторх организмыг хадгалж, түүгээр тэжээгдэж, тэдгээрийн ашигласан бодисоор хангагдаж, өөрөө түүнд хамааралтай оршиж, энэ

бүхэнд өөрөө оролцолгүй, хэзээ ч түүнтэй ялгаралгүй оршдог байна (Jakob Johann von Uexküll). Системийн элементүүдийн дундах холболтын бүтцийг хүрээлэн буй орчин дохь харилцан үйлчлэлийн үйл явцаас салгах гэж хүмүүс оролддог (W. Ross Ashby). Аливаа организм нь хүрээлэн буй орчинд шууд хамааралгүй, түүн дотор өөрөө хөдөлгөөнтэй байх ёстой бөгөөд организм нь хүрээлэн буй орчинтой харилцан хамаарлын хэлбэрт оршдог. Тэнд энэхүү хэлбэр нь өөрийгөө үргэлж бататгах ёстой. Talcott Parsons (*The Social System*, 1951) нь систем гэх ухагдахууныг → нийгмийн онолын хувьд үр өгөөжтэй болгосон. Тэр систем гэдэгт харилцан хамааралтай (харилцан нэг нэгээсээ хамааралтай) харилцааны элементүүдийн хооронд орших нэгж хэсэг гэж үзсэн. Хүрээлэн буй орчны хамааралд зөвхөн систем нь нэг хэсэг болж орших ба тэндээс өөрөө зааглагдсан байх бөгөөд түүнд өөрөө хамаарч оршдог. Түүнээс хойш социологийн системийн онолыг хүмүүс тодорхой нөхцөлд системийн тухай өгөгдлийн мэдээллийг ажиглаж, дүрсэлж өгөхийг зааварчлах, тухайлбал, аливаа системийн элементийг эсвэл системийн хүрээлэн буй орчны объектод хамааруулж болохыг таньж авсан. Parsons системийн нэгж хэсгийн харилцан хамаарлын бүтцийг тодорхойлохдоо бүтцэд системийн элементүүд нь системд тархаж, тодорхой тэнцвэртэй төлөвийг хадгалах боломжтой гэж үзсэн (Allokation). Системийн элементүүд нь ийнхүү нэг нэгэндээ хамааралтай байж, хүрээлэн буй орчны хувиралтыг даван туулах чадвартай болдог

(→ интеграци). Parsons системийн үйлдэл нэг бүрийн тухай өөрийн ойлголтоос улбаалан нийгмийн онолыг хөгжүүлсэн. Түүний онолд зан төлөвийн дөрвөн аспект болох зан үйл, хувь хүний төлөв байдал, → соёл болон → нийгэм нь нэг нэгнээсээ ялгагдах хэдий ч нэг нэгэндээ хамааралтай байдаг (→ функционализм).

Niklas Luhmanns-ны бүтээл (*Soziale Systeme. Grundriß einer allgemeinen Theorie*, 1984; *Einführung in die Systemtheorie*, 2002) нь социологийн системийн онолын цаашдын хөгжилд чухал үүрэгтэй байсан. Энэхүү онол нь биологийн ухагдахуун “Аутопоэзис” буюу өөрөө бий болох үйл явц (грекээр = “өөрийгөө бүтээх”; Humberto R. Maturana, Francisco J. Varela) гэх ойлголтыг болон математикийн ухагдахууны төрлийг (George Spencer-Brown) социологид нэвтрүүлсэн ажээ. Аутопоэзис гэх ойлголтын дагуу нийгмийн систем нь хатуу тогтсон зүйл биш, харин тодорхой элементүүдээс бүрдэх ба тэд бий болж, мөн дахин алга болох, тухайлбал, харилцааны үйл явцаар (→ харилцаа) үүсдэг гэдгийг тодотгож, энэхүү харилцаа нь өөрөө өөртөө болон бусад зүйлд хамааралтай оршдог байна (Өөрийн/Гаднын тодорхойлолт). “Хэлбэр” гэх ухагдахуун нь харилцааны үйлдэл тус бүрийг ялгаатай байдлаар ойлгох ба уг ойлголтоор тодорхой зүйлсийг тодотгож, мөн үүнтэй хамт тодорхой бус зүйлс бий болсноор энэ нь харин нээлттэй, өөрөөр хэлбэл, тодорхой бус үлддэг байна. Нийгмийн систем гэдэг нь → утга агуулгын дундаж дахь систем юм. Энэ нь өөрсдийн утга агуулгад илүүдлийг бий болгох бөгөөд мөн салангид байдлаар

утгыг боловсруулдаг. Тэрхүү утга учир нь гаднаасаа ойлгомжгүй байж болох хэдий ч харин өөрсдийн алга болох, устгалд шалтгаангүй нөлөөлж болно. Учир нь тэд учир шалтгааны холбоосыг зогсоохын тулд өөрсдийн зааг, өөрийн ялгах шалгуурыг ашигладаг. Luhmann ялгаатай байдлаар тодорхой нөхцөл байдал дахь “харилцан үйлчлэлийн систем”, өөрийн тодорхой нөхцөлөөр гишүүнчлэлтэй байх “зохион байгуулалтын систем”, харилцаанд холболт бий болгох нөхцөлийг дахин үйлдвэрлэх үүрэгтэй “нийгмийн систем” гэж авч үзсэн байна. Аутопоэзис гэх ухагдахуун өнөө цагт дэлхийн нийгэмшлийн хэлбэрийг (→ даяарчлал) нийгэм дэх нийгмийн системийн нэг хэсэг гэж дүн шинжилгээ хийхэд хүргэх нь тодорхой бус байгаа ба нийгэм доторх бүх бусад нөхөн үйлдвэрлэгдэх боломжтой нэгж хэсгүүд зарим нэг болон бусад хэсгийг хассан харилцааны төрлүүд гэж ойлгогдоно. Parsons болон Luhmann нар системийн функцийн тухай ойлголтыг ялгаатай байдлаар илэрхийлсэн. Ялгаатай нийгэмд систем тус бүрийн функцийн ялгаа (→ улс төр, эдийн засаг, нийгэм гэх мэт) нь нийгэм болон түүний хүрээлэн буй орчинд өөрийн гэсэн чиг үүрэг бүрийн цэгт давтагддаг бөгөөд түүний нийгмийн үр өгөөжийг нь тодорхой нөхцөлд харьцуулах боломжтой, мөн тэдгээрийг солих боломжтой болгодог байна. Гэхдээ ерөнхий системийн онолын хүрээнд хэрхэн системийн *аутопоэзисийг* системийн доторх нэгж системийн *аутопоэзисээр* төсөөлж болохыг хараахан илрүүлж чадаагүй байна. Энд харин Heinz von Foerster болон

Humberto R. Maturana нарын төлөвлөж байсан бүтээл бичигдээгүй үлдлээ.

Dirk Baecker

Talcott Parsons / Edward A. Shils (Hrsg.): Towards a General Theory of Action. Cambridge (Mass.) 1951.

Niklas Luhmann: Soziale Systeme: Grundriß einer allgemeinen Theorie. Frankfurt a. M. 1984, ¹²2006.

– Einführung in die Systemtheorie. Heidelberg 2002, ²2004.

Dirk Baecker: Wozu Systeme? Berlin 2002.

– (Hrsg.): Schlüsselwerke der Systemtheorie. Wiesbaden 2005.

Социологи (Soziologie)

“Социологи” нь (англиар *sociology*; францаар *sociologie*) гэдэг (латинаар *socius* = “хамтрагч”) болон Грек (*lógos* = “γζ”) гаралтай зохиомол үг бөгөөд хүн төрөлхтний хамтын оршихуйн хэлбэрийг эмпирик түвшинд судалдаг шинжлэх ухааны салбар юм. Антикийн үеэс л хүмүүсийг хүй элгэнээрээ хамтран амьдардаг гэж үздэг байсан (Aristoteles) бөгөөд социологи нь Францын хувьсгал, үйлдвэржилтийн эхлэлийн хариуд соён гэгээрүүлэх зорилгоор бие даасан шинжлэх ухаан болж үүссэн. XVIII зууны сүүл үеэс хойш → орчин үеийн хямралын туршлага нь судлаачдыг → нийгмийн бүтэц, динамикийг системтэйгээр судлах сэдэл өгсөн.

Нийгмийн шинжлэх ухааны эхлэлийн эхэн үеийн хувьд нийгмийг метафизикийн хүч эсвэл зарчмаар (бурхан, байгаль, хувь тавилан) тодорхойлдоггүй, харин үйлдэл хийж байгаа хүмүүс “бүтээдэг” бөгөөд тэгсэн хэдий ч бүтэц, дэг журмыг харуулдаг гэсэн суурь ойлголт шийдвэрлэх ач холбогдолтой байсан. Karl Marx-ын “хүмүүс өөрсдийн гэсэн түүхтэй (бүтээдэг), гэхдээ хоосон хүслээр биш” (*Der achtzehnte Brumaire des Louis Bonaparte*, 1852) гэсэн шиг яг энэ ойлголтыг илэрхийлдэг. Эрт үеийн социализм, ёс суртахууны философиос ялгаатай нь социологийн шинжлэх ухаан анхны нэршлээс (*sciences sociales, physique sociale*) нь харсан ч байгалийн шинжлэх ухаан, түүний эмпирик → арга зүйгээс үлгэрлэдэг байсан. Социологийн нэрийг олгосон Auguste Comte (*Cours de philosophie positive*, 6 Bde., 1830–42, dt. 1883/84) нь шинжлэх ухааны хатуу позитивист ойлголтыг төлөөлж байсан бөгөөд үүнийг нэг ёсны шашны идеологийн тайлбартай хослуулж, тэр уруу таталтад социологи хожим хойно ч автаж байв (→ шашин, идеологи). Харин социологийн мэргэжлийн академик салбарын жинхэнэ үндэс суурь бол XIX зууны төгсгөл үед юуны түрүүнд Émile Durkheim, Max Weber, Georg Simmel нартай хамааралтай. Францын позитивизмын уламжлалаар Durkheim (*Les règles de la méthode sociologique*, 1895, dt. 1961) социологийн судлагдахууны хүрээг нийгмийн баримт гэсэн ухагдахуунаар тодорхойлж байв (*faits sociaux*). Тэрээр үүнийгээ → хувь хүн бүрийн гадаад коллектив хэмнэл гэж үзэж байв. Үүний эсрэгээр гэмээр, тухайлбал,

үйлдэгч хувь хүний үүднээс харж, Weber социологийг “нийгмийн үйлдлийг тайлж ойлгоод улмаар түүний явц, нөлөөг учир шалтгааны үүднээс тайлбарлахыг хүсдэг” шинжлэх ухаан гэж тодорхойлжээ («*Soziologische Grundbegriffe*», in: M. W., *Wirtschaft und Gesellschaft. Grundriß der verstehenden Soziologie*, 1922). Гурав дахь замыг сонгохдоо Simmel социологийг бусад хүмүүнлэгийн шинжлэх ухааны нэгэн адил тусгайлсан агуулгуудыг (урлаг, → улс төр, шашин, эдийн засаг) авч үздэггүй, харин хувь хүмүүсийн хоорондын харилцан үйлчлэлийн хийсвэр хэлбэрийг хамааран судалдаг шинжлэх ухаан гэж ойлгож байв (*Soziologie. Untersuchungen über die Formen der Vergesellschaftung*, 1908).

Өнөөг хүртэл тодорхойлолтын эдгээр болон бусад оролдлогууд социологийн тухай ойлголт, түүний бусад салбаруудтай харилцах харилцааны талаарх маргааныг тодорхойлж байна. Нарийн ширийн зүйлийн талаарх шинжлэх ухааны дотоод бүх маргаанаас хамгийн бага зөвшилцөлд хүргэх дараах зүйлсийг харж болно: Durkheim-ын барьж байсан тогтвортой үзлээр бол сэтгэл судлалаас ялгаатай нь социологийн судалгааны сонирхол юуны түрүүнд коллектив түвшинд байдаг. Түүний судлагдахуун бол хувь хүний онцлог биш, харин нийгмийн үйл ажиллагаа (→ үйлдэл), нийгмийн бүтцийн зүй тогтол юм. Гэхдээ энэхүү зүй тогтлыг онолын түвшинд хэр оновчтой тайлбарлаж болох вэ гэдэг нь социологи дахь гол маргааны нэг хэвээр байна. Ёс суртахууны философи, эрх зүйн шинжлэх ухаан гэх мэт норматив салбаруудаас ялгаатай нь социологи

эмпирик салбар, Max Weber-ийн хэлснээр, “*бодит байдлын шинжлэх ухаан*” гэж ойлгогддог («Die ›Objektivität‹ sozialwissenschaftlicher und sozialpolitischer Erkenntnis», in: *Archiv für Sozialwissenschaft und Sozialpolitik* 19, 1904). Хэдийгээр, Weber-ийн өөрийнх нь бүтээлээс ч харсан, социологийг байгалийн шинжлэх ухаан гэх ойлголт биеллээ олоогүй ч энэ нь бусад нийгмийн шинжлэх ухаан, илүүтэй герменевтик чиг баримжаатай хүмүүнлэгийн шинжлэх ухаанаас эрс ялгардаг. Нийгмийн шинжлэх ухааны бусад салбаруудтай (түүх, улс төр, эдийн засгийн шинжлэх ухаан) харьцуулахад социологийг зөвхөн өөрийн салбарт хамаарах төдийгүй бас “нийгэм”-ийн талаар ерөнхий дүгнэлт хийх чадвартай гэж үздэг. Түүний газарзүйн болоод түүхийн гол фокус угсаатны судлалаас (угсаатны зүй) ялгаатай нь удаан хугацааны туршид Европ болон Хойд Америкийн орчин үеийн нийгэмд чиглэж байсан бөгөөд тэдгээрийг тодорхойлоход чухал хувь нэмрийг үзүүлсэн (→ орчин үе). Тиймээс социологийг ялангуяа орчин үеийн нийгэмд хүн төрөлхтний хамтын оршихуйн хэлбэрийг эмпирик байдлаар тодорхойлох, онолын хувьд тайлбарлах, мөн урьдчилсан таамаглал гаргах ч боломжтой нийгмийн шинжлэх ухаан гэж ойлгож болно.

Өнгөрсөн нэг зуун тавин жилийн хугацаанд орчин үеийн социологийн → хэлэлцүүлэгт олон тооны өрсөлдөгч онол, бие даасан анализ, арга зүйнүүд гарч ирсэн. Ерөнхий социологийн судлагдахуун бол социологи-түүхийн асуултууд байхаас гадна нэр

томъёо тодорхойлох, үйлдэл, нийгмийн дэг журам, нийгмийн → хувьслыг онолын хувьд тайлбарлах юм (Hans Joas / Wolfgang Knöbl, *Sozialtheorie. Zwanzig ein-führende Vorlesungen*, 2004). Үйлдлийн онолууд нь хувь хүний үйлдлийн субъектив → утга, обьектив зүй тогтлыг судалдаг бөгөөд эдгээрээс үүдэн коллектив үзэгдлүүдийг тайлбарлах боломжтой. → Рационал сонголтын онолд зорилго болоод арга хэрэгслийн “рационал” хэмжүүрийг тэргүүн эгнээнд тавьж үздэг бол символик интеракционизм, этнометодологи, прагматистик үйлдлийн онолд үйлдлийг чиглүүлдэг эрхэмжийн үнэ цэнэ, → хэм хэмжээ, зуршил, асуудлыг бүтээлчээр шийдвэрлэх тал руу нь илүү анхаардаг. Харин социологийн дэг журмын онолууд бол юуны түрүүнд нийгмийн үйлдлээс үүсэх, эргээд түүнд нөлөөлөх нийгмийн бүтэц буюу институцийн талаар судалдаг. Энд, жишээ нь, зан үйл гэх мэт энгийн харилцан үйлчлэлийн систем (→ харилцан үйлчлэл) төдийгүй мөн → бүлэг, → байгууллага гэх мэт илүү тогтвортой бүтцийг, цаашлаад нийгмийн бүхэлд нь сонирхдог бөгөөд энэ нь эргээд олон төрлийн, дэд систем, үнэлэмжид хуваагддаг. Хэрэв Talcott Parsons-ын бүтцийн функционалист онолын синтез нь үйлдлийн болон дэг журмын онолыг системтэйгээр хооронд нь холбосон хэвээр байсан ч эдгээр хоёр онол нь хожим гарч ирсэн микро ба макро социологийн харилцааны талаарх маргаанд ихэвчлэн эсрэг тэсрэг онол гэдэг нь ойлгогдоно. Харин сүүлийн үеийн арга хандлагууд үйлдлийн болон дэг журмын онолыг

харилцан нэг нэгнээсээ хамааралтай гэж үздэг болжээ. Тиймээс Микро эсвэл макро социологийн зарчмын хязгаарлалтыг давж гарахдаа хувь хүний болон коллектив түвшний хооронд, үйлдлийн болон бүтцийн хооронд зуучилдаг завсрын, үйл явцын шинжилгээний эсвэл бүтцийн онолын үзэл баримтлалуудаар (месосоциологи, микро-макросоциологи) илүүтэй ашиглах болжээ (Pierre Bourdieu, Anthony Giddens). Коллектив үзэгдэл нь зөвхөн хувь хүний үйл ажиллагааны түвшинд (бичил суурь) эргэж хандсанаар тайлбарлагдах эсэх (James S. Coleman, Hartmut Esser), эсвэл цэвэр макро социологийн загваруудаар томъёологдох уу гэдэг нь маргаантай хэвээр үлдэж байна. Эцэст нь, ерөнхий социологид нийгмийн хувьслын онолууд багтах бөгөөд тэдгээрийн сэдэв нь нийгмийн бүтэц, институцийн өөрчлөлтийн динамик байдаг. Хувьслын онолууд нь нийгмийн төрлүүдийн урт хугацааны алхмуудын дарааллыг тодорхойлохыг оролддог бол түүхийн социологи нь тодорхой хөгжлийг, ялангуяа Европын шинэ цагийн эхэн үеэс хойших капитализм (→ капитал), хүнд сурталтай улсуудын үүслийг тайлбарлахад анхаарлаа хандуулдаг.

Хүн төрөлхтний хамтын амьдралын хэв маягт чиглэгдсэн социологийн нийтлэг сонирхлын улмаас социологийн судалгааны сэдэв болж чадаагүй тодорхой судалгааны талбар гэж бараг байдаггүй. Тиймээс тус мэргэжлийг мэргэшсэн, мэргэжлийн нарийн ур чадвартай болгох явцад тусгай социологийн хувиар нийгмийн олон үзэгдлийг хамардаг судалгааны олон

янзын шинэ чиглэлүүд тодорхой сэдэв, асуудлыг дэвшүүлэн гарч ирсэнд гайхах зүйлгүй юм.

Мөн түүнчлэн шинжлэх ухааны социологийн хувьд полипарадигматик онолын орчин, түүний эмпирик сэдвүүд олон талт байдгийн нэгэн адил түүний судалгааны арга зүй (→ арга зүй) ч бас олон ургалч шинжтэй байдаг. Эмпирик нийгмийн судалгааны “чанарын” болон “тоон” (→ статистик) аргуудын хооронд ч гэсэн удаан хугацааны туршид хуваагдмал байдал (хатуу хуваагдал) үүсэж байсан (Biographieforschung, Feldforschung, *Grounded Theory*, *komparative Methoden*, *objektive Hermeneutik*). Хэдийгээр хоёр талуудын хооронд үе үе тэмцэл гардаг ч одоогоор дундын зуучлалын байр суурь газар аваад байгаа бөгөөд энэхүү хичээнгүйлсэн “арга зүйн хослол”-оор дамжуулан өмнөх нэг талыг барьсан байдлыг арилгахыг хичээдэг.

Социологийн өнөөгийн олон улсын төрхийг ерөнхийд нь авч үзвэл хэд хэдэн чиг хандлагыг тодорхойлж болох бөгөөд эдгээр нь шинжлэх ухааны зөвхөн дотоод хөгжилд анхаараад зогсохгүй бас Европын орчин үеийн тогтсон ойлголт дахь гүн хямрал руу ч орж судалдаг. (1) Социологийн салбарын хувьд үндсэн хуулийн нөхцөл байдалд чиглэсэн (өөрийгөө) эргэцүүлэх хэтийн төлөвийн хүрээнд олон төрлийн хүчин чармайлтыг харж болно. Социологийн сонгодог ангиллуудыг хэлэлцүүлгийн задлан шинжлэл, нэр томъёоны түүхэн нарийвчлалаар дахин сэргээх талаар, мөн зарим талаараа цаг үеийн импрессионист дүгнэлтээр → инди-

видуалчлал, рефлексив шинэчлэл, → орчин үеийн дараах өнөөгийн хэлбэрүүдийг дагадаг социологийн хандлагуудыг энд мөн адил дурдах хэрэгтэй (z. B. Zygmunt Bauman, Ulrich Beck, Bruno Latour oder Richard Sennett). (2) соёлын харилцаа, зөрчлийг хурцатгахад нөлөө үзүүлж байгаа социологийн нэр томьёог үндсэрхэг бус болгох, мөн барууны “орчин үе”-ийн талаарх чухал түүхүүдийг чухалчлахыг болиулах оролдлоготой байнга тулгардаг. Ялангуяа соёл иргэншлийн харьцуулалт болон олон төрлийн орчин үеийн хэлбэрийн талаарх хэлэлцүүлэг (Shmuel N. Eisenstadt, *Neue Historische Soziologie*), мөн → даяарчлал, дэлхийн нийгмийн тухай мэтгэлцээн энд онцгой нөлөөтэй (Niklas Luhmann, John W. Meyer). Үүнтэй нягт уялдаатай нь (3) үндэстэн дамнасан сэтгэлгээний хүчтэй хамаарал бий болж байгаа бөгөөд тэр тусмаа барууны ноёрхогч шинжлэх ухаан нь колоничлолын дараах судалгаа (*Post-Colonial Studies*) уугуул социологид илэрдэг. Тодорхой хэмжээгээр эсрэг чиг хандлагатай нь (4) социологийн сахилга баттай, өөртөө итгэх итгэлийг бэхжүүлэхийн төлөө хүчин чармайлт гаргахын зэрэгцээ эдийн засаг, амьдралын шинжлэх ухааны салбаруудын өнөөгийн шаардлагуудыг хүлээн зөвшөөрч байдаг. Тэдгээрийн цөмд рационал үйлдэл хийгч оролцогчид (Richard Hedström) эсвэл сүлжээнүүд байдаг (Harrison White) тоон судалгаа, албан ёсны загварчлалд суурилсан аналитик социологийн өнөөгийн хөгжил нь утгын ертөнцийг бий болгох, үргэлжлүүлэх, өөрчлөх үзэгдлүүдийг судалж, дүрсэлж, ойлгож-тайлбарлах социологийн амьд

уламжлалын нэгэн адил энэ чиглэлийн үзэгдлүүдийг авч үздэг (z. B. Thomas Luckmann, Anselm Strauss oder Norman Denzin). Энэ нь ирээдүйн социологийн хувьд олон төрлийн, нэлээд үндэслэлтэй эргэцүүлэх, зааглах, олон ургалч хандлагуудыг илүү хурц, сахилга баттай дүр төрхтэй нийцүүлэх онцгой сорилт болж байна.

Dirk Kaesler / Matthias Koenig

Anthony Giddens: Sociology. London [u. a.] 1984. – Dt.: Soziologie. Übers. von Angela Kornberger. Graz 1995, ²1999.

Hans Joas (Hrsg.): Lehrbuch der Soziologie. Frankfurt a. M. / New York 1997, ³2006.

Dirk Kaesler / Ludgera Vogt (Hrsg.): Hauptwerke der Soziologie. Stuttgart 2000, ²2007.

Dirk Kaesler (Hrsg.): Klassiker der Soziologie. 2 Bde. München 1999, ⁵2006/07. – (Hrsg.): Aktuelle Theorien der Soziologie. München 2005.

Спорт (Sport)

“Спорт” (эртний *францаар desport* = “алжаал тайлах”, “баярлах”) гэдэг үг нь XI зуунд англи хэлэнд sports (“цаг нөхцөөх”, “тоглоом”, “цэнгэл”) нэрээр нэвтэрсэн гэж таамагладаг бол XX зуунаас хойш Германд хэлний салшгүй нэг хэсэг болжээ. Өмнөх эрин үеүдийн болон бусад соёлын бие бялдрын дасгал, хөдөлгөөн, тог-

лоомын (→ тоглоом) практикуудаас ялгаатай нь “спорт” орчин үеийн → нийгэмтэй (→ орчин үе) уялдаатай анх үүссэн бие махбодын (→ бие) үйл ажиллагааны хэлбэр → институци юм. XVII/XVIII зууны Английн нийгэмд спорт ардын дунд түгээмэл хөдөлгөөний хэлбэрүүд (жишээлбэл, бейсбол, хёрлинг) болон язгууртнуудын биеийн чилээ гаргадаг хэлбэрүүд (жишээ нь, морь унах, буудлага хийх, ан хийх, туялзуур жад эргүүлэх)-ээр хөгжиж байв. Английн *modern sports* буюу орчин үеийн спорт нь эдгээрээс ялгарах онцлог шинж чанаруудтай: (1) Амжилт, өрсөлдөөний чиг баримжаатай, (2) дасгал-жуулалтын арга барилын рационал, системтэй байдал, (3) амжилтын (харьцуулалт) тоон болон чанарын үзүүлэлт, (4) рекорд тогтоох эрмэлзэл, (5) мэргэшсэн байдал нэмэгдэж байгаа, (6) шударга ёсны зарчим, спортын төрлийн тусгай дүрэм, (7) оролцооны хувьд нийгмийн нээлттэй байдал, (8) спортын байгууллагуудын хөгжил (→ байгууллага), (9) мэргэшүүлэлт (сонирхогчдын спортоос гадна) зэргийг дурдаж болно. Мөн орчин үеийн “спорт”-ыг хөгжүүлэхэд, (10) “бооцоо”-ны, (11) нийгмийн оролцогч болсон үзэгчид, ялангуяа дээд зэрэглэлийн спортод чухал үүрэг гүйцэтгэдэг.

“Спорт”-ын талаарх ойлголт түүх, соёл, институци, улс орон, багийн онцлогоос шалтгаалж харилцан адилгүй байдаг. Спортын гол салбар болох спортын шинжлэх ухааны хүрээнд ч нэгдмэл тодорхойлолт байдаггүй. Тэдгээрийн нийгэм, соёлын дэд салбаруудад “спорт” гэж юу болох талаарх онтологийн асуултыг

“спорт” гэж ямар утгатай болох тухай асуултаар солих нь зүйтэй гэдэгтэй санал нэг байна. Социологийн үүднээс харвал (→ социологи) “спорт” нь нийгмийн конструкци юм. Биеийн тодорхой нэг хөдөлгөөний хэлбэр нь түүний утгыг нийгмээс оноосон үед спорт “болдог”. Энэ нь ерөнхийдөө бие махбодын үйл ажиллагааг → ажил эсвэл чөлөөт цагаас ялгаж “спорт” гэж тодорхойлоход хэрэглэгдэх утгын хуваариалт юм.

Klaus Heinemann (*Einführung in die Soziologie des Sports*, 1980)-ын нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн системчлэлийн саналд багтсан спортын дөрвөн “бүрдүүлэгч элемент”-ийг дурдвал: (1) “биеийн хөдөлгөөн”, (2) “амжилтын зарчим/тэмцээн”, (3) “спортын төрөлд тохирох дүрмийн багц”, (4) “бүтээмжгүй байдал”. Үүнээс спортын төрлөөс хамааран дор хаяж нэг шинж чанар юм уу ихэнхдээ хэд хэдээрээ, заримдаа бүгд илэрнэ. Эдгээр элементүүдийг хослуулаад төрөл бүрийн спортын загварыг гаргаж болох юм. (а) “уламжлалт спортын уралдаан тэмцээн” (жишээлбэл, орон нутгийн хөл бөмбөгийн холбооны тэмцээн)-д дээрх бүх элементүүд бүрдсэн байдаг бол, (б) “мэргэжлийн шоу спорт” (жишээ нь, формел 1), (в) “эрчтэй спортын төрөл” (жишээ нь, ролликтор хоккей), (г) “функционалист спорт загвар” (жишээ нь, нордик алхалт), (д) “уламжлалт тоглоомын соёл” (жишээ нь, өндөр уулын тоглоомууд)-д зарим элементүүд нь бүхлээрээ эсвэл хэсэгчлэн зайлшгүй шаардагддаг. Орчин үеийн спорт эрс ялгаатай, олон ургалч шинжтэй болсон нь тодорхой харагдаж байна. Спортын социологи спортын энэхүү гадаад

болон дотоод ялгарлын (→ ялгарал) түүхэн үйл явцыг судалдаг. Түүнд тавигддаг суурь асуулт бол спорт болон нийгэм хэрхэн харилцан уялддаг вэ? Тодруулбал, нэг талаас спортын социологи нь спортыг нийгмийн үйл ажиллагааны талбар (→ үйл ажиллагаа), нийгмийн хэмээн авч үзээд спорт доторх нийгмийн процесст анализ хийдэг. Нөгөө талаас, спорт болон нийгмийн бусад дэд системүүдийн (→ эдийн засаг, улс төр гэх мэт) хоорондын харилцан хамаарлыг судалдаг. Спортын социологийн онол, үзэл баримтлал, эмпирик арга зүйд социологи тулгуур болдог. Энэ нь мөн спортын шинжлэх ухааны салшгүй хэсэг болохын хувьд спортын практик асуудалд анхаарлаа чиглүүлдэг. Спортын социологи бол Германы шинжлэх ухааны залуу салбар юм. Heinz Risse-ийн *Спортын социологи* 1921 онд хэвлэгдэн гарч байсан хэдий ч түүний бодит хөгжил нь 1960-аад оны эхэнд Зүүн Германд, 1960-аад оны сүүлээр Баруун Германд эхэлсэн юм. 1970-аад оны хоёрдугаар хагаст бие даасан академик салбар болж хөгжсөн байдаг. Өнөөдөр спортын социологи нь Германд спортын шинжлэх ухааны хүрээнд их дээд сургуулийн түвшинд зохион байгуулагддаг бөгөөд эх салбар болох хэдий ч социологи дотроо захын байр суурьтай байдаг.

Спортын социологийн судалгааны гол зорилго нь онолын болон эмпирик анализыг спорт дахь нийгмийн үйл ажиллагаа, нийгмийн бүтцэд хийх явдал юм. Спортын социологийн үндсэн үйл ажиллагааны чиг үүрэг бол (1) спортод нөлөөлөх нийгэм, соёлын хүчин

зүйлүүдийг нээн илрүүлэх, (2) спортын нийгмийн ач холбогдол, нөлөөг судлах, (3) спорт дахь нийгмийн асуудлыг илрүүлэх, (4) спорттой холбоотой өдөр тутмын мэдлэгт (төсөөлөл, таамаглал, ойлгомжтой зүйлс) эргэлзээтэй хандах, (5) спортын онцлог шинжтэй нийгмийн → зөрчил, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, (6) спортын байгууллагуудад нийгмийн → ижилслийг хөгжүүлэхэд нь дэмжих юм. Спортын социологийн хүрээнд (7) спортын практикт зөвлөгөө өгч боломжтой эсвэл хэрэгтэй эсэх нь маргаантай юм.

Спортын социологийн хамгийн чухал судалгааны чиглэлд спортын байгууллагуудын судалгаа (клуб, холбоо, арилжааны зорилготой студиуд), хүчирхийлэл (жишээ нь, хөгжөөн дэмжигчдийн үймээн, эрх мэдэл), допингийн судалгаа, спортоор нийгэмших, спортын нийгмийн зүтгэлтнүүд (тамирчид, дасгалжуулагчид, үзэгчид), нийгмийн тэгш бус байдал (давхарга, хүрээлэл, жендерийн онцлог, анги, хүйс), ялгаварлан гадуурхалт (арьс өнгөөр ялгаварлах үзэл), зөрчилдөөн (жишээ нь, спортын багуудад), спортын → хөгжил, → хувьсал, спорт ба эрүүл мэнд (→ амьдрал), спорт ба мэдээллийн хэрэгслийн судалгаанууд ордог. Сүүлийн жилүүдэд үндсэн хуульт ёсны (спортын тухай ойлголтыг өргөжүүлэх) болоод спортын практикийн (жишээ нь, залуучуудын соёлын хөдөлгөөний хэв маяг, бүжиг) хүрээнд биеийн болон хөдөлгөөний ач холбогдлын талаарх судалгаанууд нэмэгдсээр байна.

- Norbert Elias / Eric Dunning: Quest for Excitement: Sport and Leisure in Civilizing Process. Oxford [u. a.] 1986. – Dt.: Sport und Spannung im Prozess der Zivilisation. Übers. von Detlev Bremecke. Frankfurt a. M. 2003.
- Karl-Heinrich Bette: Systemtheorie und Sport. Frankfurt a. M. 1999.
- Claus Cachay / Ansgar Thiel: Soziologie des Sports. Zur Ausdifferenzierung und Entwicklungsdynamik des Sports der modernen Gesellschaft. Weinheim/München 2000.
- Kurt Weis / Robert Gugutzer (Hrsg.): Handbuch Sport soziologie. Schorndorf 2008.

Статистик (Statistik)

Статистик нь өгөгдлөөс хариуцлагатай суралцах салбар дундын шинжлэх ухаан юм. Энэхүү шинжлэх ухаан нь (→ субъект хоорондын), (→ тоон) мэдээллийг субъект хооронд ойлгомжтой байдлаар нэгтгэх, бүтцийг таних, мэдээлэлд суурилсан таамаглал дэвшүүлэх болон ерөнхийлөн дүгнэлт хийх зэрэг цогц аргуудыг ашигладаг. Иймээс статистик нь бүхий л эмпирик салбаруудад (→ эмпирик) арга зүйн туслах хэрэгслийн хувьд чухал ач холбогдолтой байдаг. → Социологийн шинжлэх ухаанд эмпирик судалгааны өгөгдөл боловсруулахад статистик чухал үүрэг гүйцэтгэдэг. Магдаллын болон шийдвэр гаргалтын онолын → загварууд нь социологийн математик тооцоолол, *рационал сонголтын арга барилд* (→ рационал сонголтын онол)

бусдаас илүү ач холбогдолтой. Герман хэлээр ярьдаг улс орнуудад статистикийг бие даасан суралцах чиглэл гэж үзэх нь ховор байдаг. Мэргэжлийн суурь суралцах чиглэлд хамаарах боловч нийгмийн шинжлэх ухааны чиглэлийн бараг бүх хөтөлбөрт заавал судлах ёстой агуулгаар ордог. Олон нийтийн хүрээнд статистик мэдээллийг ихэвчлэн саармагжуулсан байдлаар хүлээж авдаг. Ардын хэлц ярианд статистикийг нэг талаас толгой эргүүлэх урлаг (өөрөө түүнийг хуурамчаар үйлдээгүй бол статистикийг мэдээнд итгэх хэрэггүй) болон чухал биш мэдээллийн цуглуулга, хэтрүүлсэн мэт боловч нөгөө талаас статистикийн мэдээлэлд үнэн мэдээ агуулагддаг гэж үздэг. Дур зоргын эсрэг статистик нь боловсронгуй → арга зүйг, хэзээ ямар дараалалтай, ашигтай байдлаар ашиглах боломжтой (хэзээ ашиглахгүй байх) гэдгийг дэвшүүлдэг. Хамааралгүй гэж буруутгах нь зарим тохиолдолд мэдээллийн цаана байгаа шинжлэх ухааны онолын суурь үндэслэл муутай хийгдсэн судалгаанд байдаг. Шинжлэх ухааны туслах хэрэгсэл болохын хувьд статистик нь зөвхөн байгаа мэдээллийг системчлэх, тодорхой болгох, ерөнхийлөн дүгнэх боломжтой, харин үнэн биш зүйлээс, суурь онолын үзэл баримтлал байхгүйн улмаас танин мэдэхүйг бүтээж чадахгүй. Статистикийн арга зүйг гурван салбарт хуваан авч үздэг: (1) өгөгдлийг бүтээх, (2) дүрслэн (тодорхойлсон) статистик, (3) индуктив (дүгнэх) статистик. Эхний хэсэгт албан ёсны статистикийн ихэнх чиглэл болон түүвэр бүрдүүлэлтийн онол ялангуяа багтсан байдаг. Тодорхойлох статистик нь байгаа бүхэл

хэсгийг бүтэцлэгдсэн хэлбэрээр (тархалтын давтамжийг илэрхийлэх) болон нөхцөл байдлыг хэмжих тоон утгаар түүний шинж чанарыг (тухайлбал, дундаж утгыг дундаж орлого гэх мэтээр), удирдан чиглүүлэх (тухайлбал, квартал хоорондын зай: энд орлогын доод, дээд хэмжээний зөрүүгээр дундажлан орлогын дүнгийн 50 хувь), мөн төвлөрөлтийг (тухайлбал, лорензын хазайлт ба түүний цэгүүдийг дараах байдлаар тайлбарлах: х улсын хамгийн баян 10 хувь нь оршин суугчдын орлогын 85 хувийг эзэмшдэг) түүнээс гадна янз бүрийн хувьсагч хоорондын уялдаа (тухайлбал, хулсад боловсролын зэрэг болон өндөр орлогын түвшин хооронд хүчтэй хамаарал байна гэх мэт) зэргийг дүрсэлдэг. Эсрэгээр нь индуктив статистик цуглуулсан өгөгдлийг зорилгын хэрэгслээр ашиглахдаа зөвхөн эх олонлогоос санамсаргүй түүврээр төлөөлөх чадвартай дүгнэлт гарахыг зорьдог. Хамгийн чухал нь санамсаргүй түүврийн тооцоолол байдаг. Санамсаргүй байдал өгөгдсөн бол индукцийн алдааг (бүх ерөнхийлсөн дүгнэлтүүд логикийн хувьд бүрэн бус байх ёстой) магадлалын тооцооллын аргаар хянаж болно. Хамгийн чухал процессууд нь мөн процедурт нарийвчлагдсан суурь сургалтын хэсэг байдаг. Эдгээр нь үндсэн эх олонлогийн тоон үзүүлэлтийн тооцооллыг агуулдаг (тухайлбал, интервалын тооцооллоор сонгуулийн урьдчилсан дүгнэлт гаргах: 95 хувийн магадлалтай түүврийн тусламжтайгаар нийтийг хамруулж, аль нэг Y намын бодит сонгогчдын хэсгийн 46, 48 хувь интервалтай төлөөлүүлэн дүгнэлт гаргадаг). Статистикийн хувьд шинэчилсэн байдлаар таамаглалыг

шалгахдаа өгөгдөлд суурилсан шийдвэр гаргах боломжтой, үндэслэл сайтай таамаглалын хүрээнд алдаа гаргах магадлалыг тодорхой хязгаарт байлгах (тухайлбал, х улсад эмэгтэйчүүдийн хувьд хөдөлмөрийн орлого тэгш бус байна), эсвэл үргэлжлүүлэх эсэх, түүнчлэн регрессийн шинжилгээгээр чухал нөлөөлөгч хүчин зүйлс (үл хамаарах хувьсагч) болон тэдгээрийн нөлөөллийн хүч анхдагч анхаарал татагч (хамаарах хувьсагч) хувьсагчид хэр нөлөөлөхийг тодорхойлдог (тухайлбал, х улсад албан боловсрол болон хүйс нь газар зүйн байршлаас биш харин хөдөлмөр эрхлэлтийн орлогод санамсаргүй нөлөөлдөг, [сонирхож байгаа, үл хамаарах хувьсагч]). Ахисан шатны арга зүйн үйлдлүүд нь илүү төвөгтэй регрессийн аргууд болон олон талт арга зүйн үйлдлийг ашигладаг (ялгавартай түүвэрлэлт, кластер болон хүчин зүйлсийн шинжилгээний бүтцийн тэгшитгэлийн загварууд). Сүүлийн үеийн статистикийн хөгжил социологийн шинжлэх ухаанд онцгой ач холбогдолтой болж, нэн ялангуяа амьдралын хугацаа болон үйл явцын дүн шинжилгээнд, түүнчлэн аргуудыг бүрэн биш өгөгдлийг (тухайлбал, хэмжилтийн алдаатай эсвэл дутуу агуулгатай) боловсруулах зэрэгт ашиглаж байна. Мэдээжийн хэрэг статистикийн хэрэглээнд софт программын хөгжлүүд хүчтэй нөлөөлж байна. Өдөр тутмын тогтсон программын хэрэглээнд одоо үед spss (нийгмийн шинжлэх ухааны статистикийн программ) ашиглагдаж байна. Илүү нарийвчлалтай дүн шинжилгээнд тусгайлан тохируулсан программ (ялангуяа амьдралын үргэлжлэх хугацааг хэмжих

программ ТДА) хангамжаас гадна ихэнхдээ СТАТА программ болон улам бүр өргөн хэрэглэгдэх болсон нээлттэй өгөгдлийн R-бүтээгдэхүүнийг ашигладаг.

Thomas Augustin

Ben Jann: Einführung in die Statistik. München 2005.

Andreas Quatember: Statistik ohne Angst vor Formeln.

Ein Lehrbuch für Wirtschafts- und Sozialwissenschaftler. München [u. a.] 2005.

Jürgen Bortz: Statistik für Human- und Sozialwissenschaftler. Berlin 2005.

Helmut Küchenhoff [u. a.]: Statistik für Kommunikationswissenschaftler. Konstanz 2006.

Ludwig Fahrmeir [u. a.]: Statistik. Der Weg zur Datenanalyse. Berlin [u. a.] 2007

Соёл (Kultur)

Олон утгатай нэр томъёо “соёл” (латинаар *cultus* = боловсруулах, барилгажуулах, боловсрол) нь ертөнц ба үйлдлийн шинж чанарыг тодорхойлж, ангилж нийгмийн амьдралын үзэл санааны хэм хэмжээг илэрхийлдэг. Соёл нь → бодит байдлын талаар тодорхой, нийгэмд хамааралтай ойлголтыг бий болгож, улмаар тодорхой үйлдлийг хийх боломжтой болгодог. Үүний дагуу соёлууд нийгмийн бодит байдлын талаарх, юуг үнэн гэж үзэх, энэ ойлголтынхоо хүрээнд нийгмийн

амьдралаа хэрхэн зохион байгуулах вэ гэдэг ойлголтоос хамаараад ялгаатай байна. Энэхүү нийгмийн бодит байдлын дэг журмыг тодорхойлдог → социологийг соёлын социологи гэж нэрлэдэг.

Соёлын тухай ойлголт нь → орчин үеийн өөрийгөө сэдвийн голд авч хэлэлцүүлдэг концепт хэлбэртэй үйл явдлаар дүүрэн түүхийг туулжээ. Антикийн үеийн утгаараа бол *cultura* нь анх газар тариалан, дараа нь хүний шинж чанартай холбогдох зүйлийг нямбайлан арчлахыг хэлдэг байжээ. Энэ нь оюун ухааныг соёлжуулах тухай ойлголт юм. XVIII зуунаас хойш “соёл”-оор хүн төрөлхтний хамтын амьдралын хэлбэрийг илэрхийлэх болсон арга үндсэндээ өнөөдрийг хүртэл хэвээр байна. Орчин үеийн соёлын тухай ойлголт нь энэхүү амьдралын хэлбэрийг гаднаас нь ажиглах боломжтой болгосноороо түүний → болзошгүй тохиолдлуудыг харуулах концепт болж томорсон: Эдгээр амьдралын хэлбэрүүд нь өөр өөр байж болохоос гадна бас түүнийг бүтээх боломж нээлттэй.

Эдгээр болзошгүй тохиолдлыг ерөнхийд нь тэмдэглэх хүрээнд соёлын дөрвөн янзын ойлголт бий болсон.

(1) Immanuel Kant, Matthew Arnold, Alfred Weber болон бусад хүмүүсийн хувьд “соёл” нь норматив стандарттай (→ норм) холбогдох бөгөөд ялангуяа барууны язгууртны соёлын шалгуураас хамааралтай нийгмийн амьдралын дээд зиндааны хэв маягийг (“соёл байдаг эсвэл соёл байдаггүй”) тодорхойлдог.

(2) “Соёл”-ын талаарх нормчлогдоогүй, цаг хугацаа, орон зайн тархалт дахь хүний амьдралын хэв маягийн

олон талт байдалд уялдуулсан ойлголтыг төлөөлж байсан хүмүүс бол Edward Tylor, Franz Boas зэрэг эртний соёлын антропологийн төлөөлөгчид байв (жишээ нь, “Хятадын соёл”, “барууны соёл”).

(3) Нийгмийн зөвхөн үзэл санааг боловсруулах, түгээхэд мэргэшсэн (урлаг, шашин шүтлэг, боловсролын байгууллага гэх мэт) орчинд л ашиглагдах соёлын хязгаарлагдмал ойлголтыг Talcott Parsons, Friedrich Tenbruck нар дэвшүүлжээ.

(4) Эцэст нь соёлын тухай ойлголтыг нийгмийн онолын аргументтай холбодог: Тодорхой объектой холбогдох хүний үйлдэл нь → ухамсарт тодорхой хэв маягаас хамааралтай мэт харагддаг. Ухамсрын энэхүү хамаарал нь юуг яаж илэрхийлэх вэ гэдгийг тодорхойлж, зохицуулж байдаг цэгцтэй → мэдлэгийн хүрээнд явагдана. Энэхүү ойлголтоор соёлыг → нийгмийн ямар нэг хэсгээр хязгаарлагддаггүй. Харин ч энд мэдлэгийн тодорхой хэлбэрүүдийг хэрхэн шинэчилж, яаж энэ маягаар утга санааг нь тохируулах вэ гэдэг үүднээс нь авч үзвэл нийгэм доторх бүх зүйлийг соёл гэж үзэж болох юм. Үүнд, зөвхөн шашин, урлаг, соёлын үзэгдлийг хэлээд зогсохгүй, → эдийн засаг, → шинжлэх ухаан, → төр, → хүйс эсвэл байгалийг хамаарна.

Соёлын тухай энэхүү маш хийсвэр, өргөн утгаараа бол конструктивист (→ конструктивизм) ойлголт нь өмнөх зууны эхэн үеийн сонгодог соёлын социологид бүрэлдсэн. Ялангуяа Max Weber-ийн “Санаанууд” болон “Ертөнцийг үзэх үзэл”-ийн («Die protestantische Ethik und der Geist des Kapitalismus», in: *Archiv für So-*

zialwissenschaften und Sozialpolitik 20/21, 1904/05) үзэл баримтлалд соёлын энэхүү ойлголтыг нийгмийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай суурь шалтгаан гэж үзсэн бол Émile Durkheim-ын хамтын төлөөллийн үзэл баримтлалд мөн энэ үзэл шингэсэн байна (*Les formes élémentaires de la vie religieuse*, 1912, dt. 1981). Ухамсар ба мэдлэгт чиглэгдсэн соёлын ухагдахууныг голчлон дөрөв дэх суурь шалтгаан болгодог өнөөгийн соёлын социологи өөрийн онолын нөөцөө үүнээс гадна бусад эх сурвалжаас авдаг. Структурализм, → постструктурализм ба семиотикийн шинэ онолууд гол байр суурь эзэлдэг нь батлагдах бөгөөд юуны түрүүнд Ferdinand de Saussure, Roland Barthes, Michel Foucault und Jacques Derrida нараас иш татагддаг байна. Соёлыг энд хэлний нэгэн адил → хувь хүмүүсийн ялгаатай систем хамарсан ойлголт гэж үздэг (жишээ нь, эсрэг утгатай үгнүүдэд “хэвийн/хэвийн бус”, “эрэгтэй/эмэгтэй”, “өнгөрсөн/одоо”) бөгөөд үүний тусламжтайгаар “бодож болох, хэлж болох хэм хэмжээ” бий болдог. Хоёрдугаарт, өнөөгийн соёлын социологид гол суурь шалтгаан болдог онол бол тайлбарын онолууд бөгөөд эдгээр нь феноменологи (→ феноменологийн социологи) болон герменевтикээс үүсэл авч, → этнометодологи¹⁴ (жишээ нь, Alfred Schütz эсвэл Harold Garfinkel) хүртэл өргөжсөн. Энд анхаарлын төвд → хүмүүс өдөр тутмын аж амьдралаа

14 Этнометодологи нь Калифорнид (АНУ) Harold Garfinkel үүсгэн байгуулсан социологийн практик судалгааны салбар бөгөөд өдөр тутмын харилцан үйлчлэлийн асуудлыг авч үзэж, үүний үр дүнд бий болсон нийгмийн баримтуудыг судалдаг. Эх сурвалж -<https://de.wikipedia.org/wiki/Ethnomethodologie>

хэрхэн гүйцэлдүүлж байгаа талаарх тайлбарын утгыг ойлгох үйл явцын анализ байдаг.

Соёлын шинжлэх ухааны салбар хоорондын нэг хэсэг болох шинэ соёлын социологи нь хэд хэдэн эмпирик өгөөжтэй үзэл баримтлалуудыг боловсруулсан: Энд нийгмийн мэдлэгийн түүхэн хувьсалтай → хэлэлцүүлэг хэлбэрийн зохион байгуулалтыг асуугаад зогсохгүй бас жишээ нь, Pierre Bourdieu “Хабитус”, “Амьдралын хэв маяг” гэж нэрлэсэн шиг мэдлэгийг өөрийн болгох талаар ч асуудаг. Эмпирик талаас сонирхож буй нь хүйс, үндэс угсаа/гарал үүслийн соёлын бүтэц, “шинэ капитализмын соёл” (Luc Boltanski), түүнчлэн, янз бүрийн техникийн → мэдээллийн хэрэгслээр дамжуулан бодит байдлыг бий болгох, эцэст нь бас эрлийзэжсэн ижилслийг тойрсон маргаан (Manuel Castells) маягийн → даяаршлын соёлын хэмжүүрүүд байна.

Andreas Reckwitz

Raymond Williams: Culture and Society 1780–1950. London 1958. – Dt.: Gesellschaftstheorie als Begriffsgeschichte. Studien zur historischen Semantik von ›Kultur‹. Übers. von Heinz Blumensath. München 1972.

Stuart Hall (Hrsg.): Representations. Cultural Representations and Signifying Practices. London [u. a.] 1997, Nachdr. 2003.

Andreas Reckwitz: Die Transformation der Kulturtheorien. Zur Entwicklung eines Theorieprogramms. Mit einem Nachw. zur Studienausgabe 2006: »Aktuelle Tendenzen

der Kulturtheorie». Weilerswist 2000, Neuausg. 2006.
Friedrich Jaeger / Jörn Rüsen (Hrsg.): Handbuch der Kulturwissenschaften. 3 Bde. Stuttgart/Weimar 2004.

Соёл иргэншил (Zivilisation)

“Соёл иргэншил” (латинаар *civilis* = “иргэний”) гэдэг нь ярианы хэлэнд урт хугацааны үр нөлөөтэй соёлын дэвшил (→ соёл) гэсэн ойлголтыг илэрхийлдэг. Соёлын түүхэн хэлний хэрэглээнд соёл иргэншил нь ихэнхдээ түүх болоод орон зайн хувьд зааглагдсан байдаг (жишээ нь, Вавилоны эсвэл Грекийн соёл иргэншил). Улс төрийн мэтгэлцээнд “соёл иргэншил” нь соёл иргэншил багатайд тооцогддог нийгмүүдээс ялгаатай нь улс төрийн өөртөө итгэлтэй байдлын төлөөх тэмцэл гэсэн ойлголтыг агуулдаг. Социологийн хувьд “соёл иргэншил” гэдгээр нийгмийн өөрчлөлтийн үйл явцыг (→ хөгжил, өөрчлөлт) дагалдан зан үйлийн зохицуулалт өөрчлөлтийг хэлдэг. Соёл иргэншил бол эцсийн төлөв биш, харин үйл явц гэдэгтэй санал нэгддэг. Энэ утгаараа энд үндсэндээ соёл иргэншлийн тухай биш, харин соёлжуулах, иргэншүүлэх үйл явцын тухай яригдаж байгаа юм.

Герман хэлээр ярьдаг улс орнуудад соёл иргэншил гэдэг ухагдахууны үндэс нь Immanuel Kant (*Idee zu einer allgemeinen Geschichte in weltbürgerlicher Absicht*, 1784)-ын үзэл баримтлалтай холбогдох бөгөөд түүний хувьд илүү өндөр зэрэглэлийн, дотоод, ёс суртахуунлаг

шинж чанартай холбогдох соёлыг зөвхөн гаднаасаа соёл иргэншсэн байдлаас ялгаж үзсэн юм. Энэхүү ялгаа нь XIX зууны Германы нийгмийг Францын нийгмээс ялгаж өөрийгөө танин мэдэхэд чухал үүргийг гүйцэтгэсэн. Соёл иргэншлийн энэхүү шүүмжлэлт үзэл нь нийгмийн техникжүүлэлт, үйлдвэржилтийг улам бүр нэмэгдүүлэхийг соёл иргэншил гэж ойлгож байгааг соёлд заналхийлж байгаа явдал гэж үзсэн Oswald Spengler-ээр оргилдоо хүрсэн юм (*Der Untergang des Abendlandes*, 2 Bde., 1918/22). Үүний эсрэгээр, Max Weber, Sigmund Freud нарт тулгуурлан Norbert Elias соёл иргэншлийн үйл явцыг нийгэм (социогенез) ба хувь хүний (психогенез) түвшинд судалсан байна (*Über den Prozeß der Zivilisation*, 2 Bde., 1939). Тэрээр бусдын хязгаарлалтаас өөрийн хязгаарлалтад орсон шилжилтийг харуулахын тулд дундад зууны хаант засаглалтай үеийн нийгмийн зан харилцааны загварыг эхлэл цэг болгон сонгосон. Elias-ын хувьд соёл иргэншлийн чухал үндсэн элемент нь төрийн хүч хэрэглэх (→ эрх мэдлийн) монопол байдал үүсэхтэй зэрэгцээд түүнийг дагалдан гарч ирэх хувь хүний дур зоргоороо авирлах явдлыг багасгахад оршино. Elias-ын Германчуудын тухай судалгаанд (1989) хэлснээр, сэтгэл хөдлөлийн хяналыг нэмэгдүүлэх нь шулуун дардан, айдасгүй явагддаггүй бөгөөд харин ч бүр соёл иргэншлийн эсрэг түлхэц болдог. Elias-аас үл хамааран нийгмийг, тэр дундаа капитализмыг шүүмжилдэг нийгмийн шинжлэх ухааны янз бүрийн чиг хандлагууд (→ шүүмжлэлийн онол, материалист нийгмийн онол) яг тодорхой “соёл иргэншил” гэж

дурдах шаардлагагүйгээр соёл иргэншлийн сөрөг талыг онцолдог (z. B. Max Horkheimer / Theodor W. Adorno, *Dialektik der Aufklärung*, 1947; Michel Foucault, *Surveiller et punir*, 1975, dt. 1976). Zygmunt Bauman өөрийн “дэг журмын диалектик” (*Modernity and the Holocaust*, 1989, dt. 1992)-ийг Elias-тай хийсэн шүүмжлэлт хэлэлцүүлэг гэж үздэг бөгөөд холокост бол түүний хувьд соёл иргэншлийн сүйрэл биш, харин хүнд суртал, рационалчиллын хэт түйлширсан хэлбэр бөгөөд энэ нь соёл иргэншлийн болоод орчин үеийн (→ постмодерн) салшгүй хэсэг юм. Соёл иргэншлийн социологийн судалгаанд нийгмээс нийгэмд өөрчлөгдөх зан үйлийн дэвшилтэт зохицуулалтууд (соёл иргэншлийн оронд соёлжуулах, иргэншүүлэх үйл явц) багтахаас гадна зэрлэг, соёл иргэншилгүй байдлын үзэгдлүүдийн талаар ч авч үздэг. Гол нь сэтгэл хөдлөлийг хянах хандлага хэвээр байна. Соёл иргэншлийн эсрэг Kant-ын соёлын сайжруулалт өнөөдөр ач холбогдолтой байхаа больсон. Соёл болоод соёл иргэншлийг үндсэндээ адилтган авч үздэг.

Annette Treibel

Jörg Fisch: Zivilisation, Kultur. In: Otto Brunner [u. a.] (Hrsg.): *Geschichtliche Grundbegriffe. Historisches Lexikon zur politisch-sozialen Sprache in Deutschland*. Bd. 7. Stuttgart 1992. S. 679–774.

Hermann Korte: Norbert Elias. *Das Werden eines Menschenwissenschaftlers*. Wiesbaden 1997.

Stephen Mennell / John Rundell (Hrsg.): Classical Readings in Culture and Civilization. London 1998.

Annette Treibel [u. a.] (Hrsg.): Zivilisationstheorie in der Bilanz. Beiträge zum 100. Geburtstag von Norbert Elias. Wiesbaden 2000.

Peter Imbusch: Moderne und Gewalt. Zivilisationstheoretische Perspektiven auf das 20. Jahrhundert. Wiesbaden 2005.

Субъект (Subjekt)

Субъект гэдэг нэр томьёо нь латин хэлний “*subiectum*” буюу захирагдсан, хэн нэгний доор гэсэн утга илэрхийлэх боловч орчин цагийн соёлын болон нийгмийн шинжлэх ухаанд нийгэм-соёлыг тодорхойлох хэлбэр. Энэхүү хэлбэрээр хувь хүний бие махбодын болон сэтгэл зүйн нэгдлийг нийгэмд ойлгомжтой, хүлээн зөвшөөрөгдсөн нэгэн болгодог (→ Соёл, Нийгэм, Ойлголт).

“Subiectum” гэх латин нэр томьёо нь хоёрдмол утгыг илэрхийлэг: нэг талаас субъект нь объектоос ялгарах бие даасан байдалтай, идэвхтэй инстанцийг илэрхийлэх ба инстанци нь өөрийгөө болон бусдыг удирдана. Нөгөө талаас, “subiectum” гэдэгт хэн нэгэн этгээдийг буюу тэр нь захирагдсан байх, тухайлбал, тодорхой нэгэн зонхилон байгуулалтын хэлбэр, → бүтцүүдэд захирагдахыг хэлнэ. Субъект нь парадокс сэдэв бөгөөд энд бие даасан байдлыг олж авахын тулд бүтцэд захирагддаг. Энэхүү

хоёрдмол утгыг орчин үеийн сонгодог субъектийн философийн зохиогчид болох René Descartes, Immanuel Kant und Georg Wilhelm Friedrich Hegel нар аль хэдийн тодорхойлсон байдаг. Karl Marx-ын идеалист онолыг нийгмийн онолын хүрээнд шүүмжлэх сэдэлтэй философийн шийдвэрлэх ач холбогдолтой субъектийг тодотгох үзэл санаа Friedrich Nietzsche (*Zur Genealogie der Moral*, 1887)-гийн бүтээлд байдаг. Орчин цагийн субъектийн ухамсарт төлөвт “онцгой шинж бүхий амьтан” гэх ойлголт байх бөгөөд энд урьдчилсан олон нөхцөлүүдийг хүний бие мах бодид нөхцөлдүүлж, ёс суртахуун, танин мэдэхүйн дотоод сэдлийг төлөвшүүлдэг байна. Философиос ялгаатай нь социологи бүх нийтэд хүчин төгөлдөр биш хэдий ч рационал, ухамсарлагдсан хүний соёлын өмнөх шинж чанар байхгүй. Үүний оронд түүхэн өвөрмөц хэлбэрүүдэд анхаарал хандуулдаг. Энэ хэлбэрүүдэд хувь хүн бүр аль нэгэн соёлын онцгой хамааралтай нөхцөлд тодорхой зан чинаруудыг өөрсдөө суралцдаг. → Нийгэмшил гэх ойлголтоос ялгаатай нь субъект гэдэг ухагдахуунд нөлөөлдөг гурван аспектиг бусад постструктурализмын үзлээс онцгойлон авч үздэг.

(1) Субъектийн төлөв байдал, зан чанарын өөрчлөлтийн гол объект нь субъектээс гарч буй үр дүнгүүд, өөрөөр хэлбэл, эдгээр нь → хэм хэмжээ, → дүрүүд, → эрхэмжит зүйлсээс гадна мөн хувь хүний биеийн хөдөлгөөнүүд юм. Тэдгээр нь мэдрэмжээс өмнөх ухамсрын, үйлдлийн болон сэтгэл зүйн схемүүдээр тодорхойлогддог.

(2) Субъектийн онолын үзэл баримтлалууд нь хувь хүний (хувь хүмүүний ижилсэл) болон дүрүүдийн

(нийгмийн ижилсэл) хоорондын ялгааг тодруулахыг оролддог. Энэ явцын хүрээнд хувь хүний соёлжсон төлөв байдлаас буюу аль нэгэн тодорхой соёлын элементүүд индивидуалчлалд асуулт хайхаас гадна мөн энэ байдлын хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг судалдаг. (3) Субъектийг бий болгох асуудал нь эцсийн дүндээ хүүхэд, залуу насны төлөвт анхаарал хандуулдаггүй, харин илүү удаан хугацаанд үргэлжлэх, үргэлжилсэн үйл явц гэж үздэг. Энэ үйл явцыг нийгмийн → дискурсууд ач холбогдолтойгоор чиглүүлдэг.

Субъектийн түүхэн хэлбэрт дүн шинжилгээ хийх орчин үеийн нийгэм, соёлын шинжлэх ухааны чиглүүлэх хөтөлбөр нь 1960-аад оны постструктурализм, мөн Michel Foucaults, Louis Althusser und Jacques Lacans нарын бүтээлээр эхэлсэн байдаг. Nietzsche-гийн бүтээлээс нөлөөлөлтэй Foucault нь “субъектийн төвлөрсөн бус” бүтцийн үзэл баримтлалыг эхлүүлсэн. Субъект бол танин мэдэхүйн эсвэл ёс суртахууны цөм бус, харин түүний ижилсэх хандлага нь соёлын онцлогтой, судлах шаардлагатай системүүдийн ялгаатай үр дүн юм. Энэ ялгаатай хандлага нь хэвийн эсвэл идеал субъектийг хэсэгчилсэн байдлаар тодорхойлдог (→ хувь хүний туршлага). Foucault мөн орчин цагийн тодорхой нөхцөлд субъектийн хэлбэрийг сонирхож байв. Тэр гурван чиглэлээр орчин цагийн нөхцөлд дүн шинжилгээ хийсэн: (а) нийгмийн дискурсийн чиглэлийн хүрээнд: “Сэтгэж болохуйц болон хэлж болохуйц” гэдгийг тодруулахын тулд Foucault-ийн үзлээр тухайлбал, субъектийг хүмүүний шинжлэх

ухааны салбарт тодорхойлсон. Үүнээс гадна, эмгэг судлалын анти-субъект, асуудалтай тусгаарлагдсан бусдын эсрэгцүүлж тавьсан (тухайлбал, XIX зууны субьектийн бэлгийн харилцаа болон эмгэг гажуудлыг тусгаарлах: *Histoire de la sexualité*, 3 Bde., 1976–84, dt. 1983–89):

(b) институцийг бүхлээр нь харах өнцгөөр → эрх мэдэл, мэдлэгт субьектийн бие махбод, сэтгэл зүйг аль нэг чиглэлд бэлтгэж болно (тухайлбал, неолиберал хөдөлмөрийн зах зээл нь өөрийгөө оновчтой болгох хандлагатай неолиберал субьектийн сургалтын талбар);

(c) “технологийг өөрийнхөөр нь” гэх харах өнцгөөр бол субъект нь тодорхой соёлын контекстэд тайлбарлах болон арга зүйн харилцаанд өөрөө өөрийгөө бий болгож байдаг (тухайлбал, шашны зан үйлийн практикт).

Foucaults-ийн нөлөө бүхий соёлын шинжлэх ухааны субьектийн түүхэн хөтөлбөрийн дүн шинжилгээний хажуугаар бусад шинэ судлаачид дотоод агуулгын төрлөх зөрчилдөөн болон субьектийн хэлбэрийн тогтворгүй байдлыг тодорхойлж дэвшүүлсэн байдаг. Judith Butler, Ernesto Laclau, Stuart Hall und Homi Bhabha зэрэг судлаачид нь субъект бий болох асуудлыг үргэлж сэтгэл зүйн ижилсэх, мөн эсрэг, тэсрэгцлийн үйл явцуудаар болон тэдгээрийн заагаар (тухайлбал, арьс өнгөөр ялгаварлан гадуурх үзэл болон экзотикимын хослолд), түүнчлэн, субьектийн загваруудын олон утга илэрхийлэх байдлаар буюу өөр өөр төрлийн холимог хольцтой ялгаатай бүрэлдэхүүн хэсгүүдээс бий болдог

гэж үзсэн. Түүнчлэн асуудал дэвшүүлэх хандлагаар буюу өөрийгөө өөрчлөх мэт харагдах хурдацтай субъектийн хэлбэрүүдээр илэрхийлэгддэг. Социологи дахь орчин үеийн субъектийн шинжилгээний хамрах хүрээ нь зэрэгцээ ойр төрлийн салбарууд болох эдийн засгийн субъектийн хэлбэрийг өргөн хүрээнд авч үзэхийн зэрэгцээ, түүний дотор хэрэглэгч-субъект болон *Gendered Subject* буюу жендерийн субъектийн гоо зүй, мөн постколианал контекстэд өөрийн болон бусад хоорондын ялгаанаас массын мэдээллийн хэрэгсэл (→ хэвлэл мэдээллийн хэрэгсэл) дэх субъектийн төлөөлөл хүртэлх визиуль соёлын хэлбэрт оршиж байна.

Andreas Reckwitz

Stuart Hall / Paul du Gay (Hrsg.): Questions of Cultural Identity. London [u. a.] 1996, Nachdr. 2002.

Ulrich Bröckling [u. a.] (Hrsg.): Gouvernementalität der Gegenwart. Studien zur Ökonomisierung des Sozialen. Frankfurt a. M. 2000.

Urs Stäheli: Poststrukturalistische Soziologien. Bielefeld 2000.

Anthony Elliott: Concepts of the Self. Cambridge [u. a.] 2001.

Andreas Reckwitz: Das hybride Subjekt. Eine Theorie der Subjektkulturen von der bürgerlichen Moderne zur Postmoderne. Weilerswist 2006.

Сүлжээ (Netzwerk)

Сүлжээ гэдэгт ерөнхий байдлаар зах, холбоос, зангилаагаар хоорондоо холбогдсон зангилааны багцыг ойлгодог. Нийгмийн сүлжээний зангилаанууд нь хүмүүс, → хувь хүн, → бүлгүүд, → байгууллага, үндэстэн, → институци, холбоо зэрэг нийгмийн → оролцогчдыг бүрдүүлдэг. Сүлжээний нийгмийн оролцогчдын хоорондын харилцаа нь янз бүр байдаг. Жишээлбэл, нөхөрсөг харилцаа, бизнесийн харилцаа, нийтлэг ашиг сонирхолд тулгуурласан солилцоо. Сүлжээ нь жижиг, (жишээ нь, → гэр бүл, найз нөхдийн хүрээлэл) эсвэл том (жишээ нь, интернэт) байж болно. Эдгээр нь нийтлэг шинж чанартай: гишүүн тус бүрийн харьцангуй бие даасан байдал, хамаарал бүхий оролцогчдын нэгдмэл бус байдал, хувийн ашиг сонирхлын оронд хамтын ажиллагааны үндэс болох итгэлцэл, тогтсон → бүтцийн оронд сул холбоо, шаталсан харилцааны оронд хэвтээ, өөрөө зохион байгуулалт, албан бус, төвлөрсөн бус байдал, шийдвэр гаргах үйл явц, уян хатан байдал, инновацийн боломж, өндөр төвөгтэй байдал гэх зэрэг. Сүлжээний онол нь математик графикийн онол, физикээс чухал түлхэц авсан (Albert-Laszlo Barabási, *Linked*, 2002; Duncan J. Watts, *Six Degrees*, 2003); мөн хувийн харилцааны социологийн судалгаанууд (Stanley Milgram, «The Small World Problem», in: *Psychology Today*, May 1967) болон сул сүлжээний -weak ties- тухай (Mark Granovetter, «The Strength of Weak Ties», in: *American Journal of Sociology* 78, 1973). Сүлжээг → эдийн засаг,

засаг захиргаа, → улс төр, → шинжлэх ухаанаас олж болно. Тэрээр хүмүүс, нийгмийн → систем, байгууллага хоорондын орон зайг дүүргэдэг. Түр зуурын → харилцан үйлчлэл, шаталсан бүтэцтэй байгууллага, функциональ систем биш нийгмийн → харилцааны бүх хэлбэрийг сүлжээ гэж үзэж болно. Инновацийн сүлжээ нь компани, захиргаа, нийгэмлэг, судалгааны хүрээлэнгүүдийг орон нутгийн болон дэлхийн хамтын ажиллагааны хүрээнд холбодог. Улс төрийн бодлогын сүлжээ нь улс төр, нийгмийн хоорондын зайг холбодог бол байгууллагын хүрээнд хэлтэс, салбаруудын хооронд сүлжээ бий болдог. Хувь хүмүүс өөрсдийн “нийгмийн капитал”-ыг тэлэхийн тулд хувийн сүлжээгээ хөгжүүлдэг. Эцэст нь, “оролцогчдын сүлжээ” (Bruno Latour)-ын (*Pandora's Hope: Essays on the Reality of Science Studies*, 1999, dt. 2000) нь байгаль, соёл, объект болон → субъект хоорондын ялгааг холбосон хүн ба техникийн бүрдлийн хосолмол холбоог бүрдүүлдэг. Жишээлбэл, социологичийг зөвхөн хувь хүн гэж үзэхгүй бөгөөд тэрээр бие хүн, номын сан, компьютер, оффис, мэргэжлийн холбоо, олон тооны сэтгүүл, хэвлэл нийтлэл гэх мэт олон зүйлээс бүрдсэн сүлжээ юм. Эдгээр “бүрдэл”-ээс салгавал социологич бас алга болно. Сүлжээ нь шатлан захирах ёс ба зах зээлийн эдийн засаг хоорондын толхилцоон, → үйл ажиллагаа ба бүтэц зэргээс үүдэлтэй нийгмийн эсрэг тэсрэгийг зохицуулах, эсвэл бүлэг хоорондын “бүтцийн цоорхойг” нөхөх үүрэгтэй. Нийгмийн тогтолцооны онолын үүднээс Niklas Luhmann-ы (*Soziale Systeme*, 1984) авч үзвэл сүлжээ нь үндсэндээ функциональ дэд системүүд болон

өөр төрлийн байгууллага хоорондын орон зайд оршдог. Сүлжээ нь нэг талаас бие даасан хувь хүмүүс, нөгөө талаас макро бүтэц, шатлан захиран ёсны тогтолцоо, үйл ажиллагааны хэвшмэл тогтоц, норматив бүлгийн дүрэм хоорондын “дамжуулах функц”-д тооцогддог (Johannes Weyer, *Social Networks. Concepts and Methods of Social Science Network Research*, 2000). Гэхдээ сүлжээ болон нийгмийн тогтолцоо хоорондын ялгаа тодорхойгүй хэвээр байна. Сүлжээг ерөнхийдөө нийгмийн тогтолцооны тодорхой төрөл гэж үздэггүй. Гэсэн хэдий ч сүлжээ нь систем шиг өөрийн гэсэн → оролт, гаралтын дүрэм, тодорхой хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулдгаараа онцлогтой. Гэхдээ сүлжээ нь хүрээлэн буй орчноос тусгаарлагдахгүй бөгөөд түүнд өөрийн гэсэн кодчилал, бэлгэдлийн чанар агуулсан → хэвлэл мэдээллийн болон харилцааны тусгай хэв шинж агуулагддаггүй.

Andréa Belliger / David J. Krieger

Harrison C. White: *Identity and Control: A Structural Theory of Social Action*. Princeton 1992.

Manuel Castells: *The Rise of the Network Society*. Cambridge/Mass. [u. a.] 1996, ²2001. – Dt.: *Der Aufstieg der Netzwerkgesellschaft*. Übers. von Reinhard Kößler. Opladen 2001, Studienausg. 2004.

Dorothea Jansen: *Einführung in die Netzwerkanalyse*. Opladen 1999, ³2006.

Stephan Fuchs: *Against Essentialism. A Theory of Culture and Society*. Cambridge (Mass.) [u. a.] 2001.

Тоглоом (Spiel)

“Ажил”-аас ялгаатай нь “тоглоом” бол сайн дурын үндсэн дээр явагддаг нийгмийн үйл ажиллагаа (→ үйлдэл) юм. Тоглоом нь ихэнхдээ хэд хэдэн тоглогчдын хоорондох → харилцан үйлчлэлийг харуулдаг бөгөөд тодорхой дүрмийг дагаж мөрдөхийн зэрэгцээ нийгмийн зан үйлд сургадаг. Ялангуяа (үүгээр зогсохгүй) хүүхэд насанд хөдөлгөөний ур чадвар суулгах, мэдлэгт суралцах, ертөнцийг танин мэдэх, бусдын оронд өөрийгөө тавьж мэдэрч сурах зэрэгт онцгой ач холбогдолтой юм. Нийгмийн шинжлэх ухаанд тоглоомыг сонирхох (1) социологийн болон онцгойлон (2) тоглоомын онолын хоёр шалтгаан байна.

(1) Социологи нь нийгэм, соёл болон тоглоомын нийгэмшлийн чиг үүргийг голчлон авч үздэг. Johan Huizinga хүмүүсийг *Homo Ludens* (1939, dt. 1956) буюу тоглодог хүмүүс гэж тодорхойлсон байдаг бөгөөд → улс төр, шинжлэх ухаан, эдийн засаг, шашин зэрэгт хэвшил болсон нийгмийн зан харилцааны хэв маягууд нь тоглоомын зан үйлээс үүдэлтэй байдаг гэсэн үзлийг төлөөлж байв. Үүнтэй уялдаад практик онол, нийгэмшлийн онолын төлөөлөгчид тоглоомыг нийгэмд үүрэг хүлээх, нийгмийн эрхэмжит зүйлс, хэм хэмжээг олж авах урьдчилсан нөхцөл болдог гэж үзсэн (z. B. Brian Sutton-Smith, *Die Dialektik des Spiels*, 1978). Тоглоомын тухай социологийн сонгодог тодорхойлолтыг Roger Caillois (*Les jeux et les hommes: Le masque et le vertige*, 1958, dt. 1960) гаргасан бөгөөд тэрээр тоглоомын зургаан гол шинж чанарыг ялган үзжээ. (a) Тоглоом бол тоглогчдын

сайн дурын үндсэн дээр тоглогддог, (б) бүтээмжгүй, (в) орон зай, цаг хугацааны хувьд хязгаарлагдмал үйл явдалтай ба түүний явц нь (г) урьдчилан тогтоосон дүрэмд захирагддаг. Тоглоомд (д) өөрийн гэсэн ертөнц байх бөгөөд (е) гарц нь нээлттэй байдаг. Тоглоомын эдгээр хуучин онолыг даган соёлын социологийн болоод салбар дунд чиглэсэн тоглоомын судалгааг боловсруулсан бөгөөд сүүлийн жилүүдэд юуны өмнө тоглоомын шинэ хэлбэрүүд (видео тоглоом, компьютер тоглоом)-ийн нийгмийн ач холбогдлын талаар ажлууд хийгдэж байна.

(2) Тоглоомын тухай өөр нэгэн, илүү хийсвэр ойлголтыг нийгэм, эдийн засгийн шинжлэх ухаанд өргөн тархсан тоглоомын онол томъёолдог. Үүний дагуу бол үр дүнд нь хэн нэгэн дангаараа нөлөөлөх бус хэд хэдэн шийдвэр гаргагч хүний хамтын оролцоотойгоор шийдэгдэж байгаа нөхцөл бүрийг “тоглоом” гэж үздэг. Тоглогчид тоглоомын янз бүрийн боломжит үр дүнгийн давуу талуудыг тус бүртээ үнэлж, эсрэг тоглогчдын зан төлөвийг харгалзан, тоглоомын дүрмийг баримтлах явцдаа өөрт ашигтай үр дүнд хүрэхийн тулд шийдвэр гаргадаг (→ рационал сонголтын онол).

“Тоглоом” гэдэг нэр томъёо нь нийгмийн сонгодог тоглоомуудын дүрсэлсэн нөхцөл байдал дээр тулгуурладаг бөгөөд тэдгээрээс улбаалан тоглоомын онолыг боловсруулжээ (John von Neumann / Oskar Morgenstern, *The Theory of Games and Economic Behavior*, 1944, dt. 1961). Бодит нөхцөл байдлыг тоглоом хэлбэрээр дүрслэх үйл явцыг загварчлал гэж нэрлэдэг (→ загвар).

Бодит нөхцөл байдлыг тоглоомд оруулах нь бус, харин шийдвэр гаргагч эсвэл судлаачийн тайлбарлах үйл явц тодорхой байна. Дараах тоглоомын үндсэн төрлүүдийг жишээ болгон авч үзье:

Хоёр хүний нийлбэртэй тэг тоглоомд тоглогчдын сонирхол эсрэг тэсрэг байдаг бөгөөд энэ нь тэдний хооронд хамтын ажиллагаа үүсэх боломжгүй болгодог (→ зөрчилдөөн). Нийгмийн олон тоглоомууд (жишээ нь, шатар) нийлбэр нь тэг тоглоомууд тул тоглоомын зөрчилтэй нөхцөл байдалд анализ хийх нь эхэндээ тоглоомын онолын судалгаанд томоохон орон зайг эзэлж байв. Нийгмийн шинжлэх ухаанд нийлбэр нь тэг биш тоглоомууд илүү түгээмэл болж байгаа болохоор иймэрхүү шууд зөрчлийг судлах нь өнөө цагт үндсэндээ ач холбогдолгүй болсон.

Нийгмийн дилемма (бас *хоригдлуудын дилемма* ч гэж нэрлэдэг)-д тоглогч нэг бүрийн хөшүүрэг нийт багийн тоглогчдын (→ бүлэг, нийгэмлэг) ашиг сонирхолтой зөрчилддөг. Өргөн хүрээтэй судалгаагаар (Robert Axelrod, *The Evolution of Cooperation*, 1984, dt. 1987) энэхүү дилемма тоглоомд тоглогчдын хооронд хамтын ажиллагаа хэрхэн бий болж болох, ингэснээр бүх тоглогчдын эв зүйд нийцсэн шийдлүүдийг хэрхэн гаргах талаар судалгаа хийгддэг.

Зохицуулалттай тоглоомуудад тоглогчдын ашиг сонирхол ихэнхдээ эсвэл бүрэн нийцтэй байдаг бөгөөд тоглогчид тусдаа, төвлөрсөн бус байдлаар оролцдог (жишээ нь, хоёр хүн нисэх онгоцны буудал дээр бие биеэ олохыг хичээх). Нийгмийн олон тооны

үзэгдлүүд тоглоомын энэхүү төрлөөр тайлбарлагддаг, жишээлбэл, техникийн стандарт тархах (→ сүлжээ), хэл үүсэх (→ харилцаа холбоо, тэмдэг) эсвэл нийгмийн → тогтолцоонд дэг журмын бүтэц бий болох (→ институци, хэм хэмжээ).

Зохицуулалтгүй тоглоомуудын онцлог нь тоглогчид нэг л сонгосон стратегиа байнга барьж тоглодог бөгөөд шийдэл байдаггүй. Тоглогчид, өөрсдийн арга барилаа санамсаргүйгээр, өөрөөр хэлбэл, өрсөлдөгч нь урьдчилан таамаглах аргагүй байдлаар сонгож болдог *холимог стратегийг* шаарддаг. Ийм төрлийн тоглоомын чухал хэрэглээ бол симбиотик хамаарал, хяналтын тоглоом, эвлүүлдэг тоглоом гэх мэт тайван замаар зөрчил шийдвэрлэх механизмууд юм.

Нийтийн тоглоомыг маш олон тоглогчдод хоорондоо нэгэн зэрэг тоглодог (жишээ нь, хөрөнгийн зах зээл). Энэхүү загварчлал нь нийгмийн шинжлэх ухааны олон асуудалд тохирдог, жишээ нь, парламентын сонгууль эсвэл нэг зах зээлийг бүхэлд нь (→ эдийн засаг). Нэмж хэлэхэд, энд болж байгаа процессууд тоглогчдын рационал хандлага хязгаарлагдмал эсвэл дутмаг байсан ч урьдчилан таамаглах боломжтой үр дүнд хүргэдэг.

Christian Rieck / Stefan Jordan

John Nash: Non-Cooperative Games. In: Annals of Mathematics 54 (1951). S. 286–295.

Thomas C. Schelling: The Strategy of Conflict. Cambridge [u. a.] 1960, Nachdr. 2005.

Micromotives and Macrobehavior. New York [u. a.] 1978.
 Günther Bauer (Hrsg.): Homo ludens – der spielende Mensch. Internationale Beiträge des Institutes für Spielforschung und Spielpädagogik der Universität Mozarteum Salzburg. 10 Bde. München/Salzburg 1991–2000.
 Christian Rieck: Spieltheorie – eine Einführung. Wiesbaden 1993, 72007.

Тохиолдлын боломж (Kontingenз)

“Тохиолдлын боломж” (латинаар *contingentia* = “тохиолдол”, грекээр *to endechomenon* = “боломж”) гэдэг нь Aristoteles-ийн логигоор боломжийн нэг хэлбэрийг дүрсэлдэг: Болзошгүй зүйл нь боломжгүй ч зүйл биш, шаардлагатай ч зүйл биш юм. Энэ нь зарчмын хувьд боломжтой хэдий ч бас зарчмын хувьд байх шаардлагатай биш эсвэл өөрөөр байж болох зүйл юм.

Тохиолдох боломжийн асуудлыг социологид 1900 оны үед мэргэжлийн салбар хөгжиж эхэлснээс нь хойш → нийгмийн үүслийн талаарх асуулттай холбож байв. Émile Durkheim нийгмийн нөхцөл байдлын “гэрээний өмнөх”, өөрөөр хэлбэл, тодорхой хэлцэлгүй нөхцөл байдлын талаар авч үзсэн байдаг (*Les formes élémentaires de la vie religieuse*, 1912, dt. 1981). Georg Simmel (*Soziologie. Untersuchungen über die Formen der Vergesellschaftung*, 1908) нь → хувь хүмүүсийн хоорондын харилцан үйлчлэлийг судалж, энэхүү харилцан үйлчлэлийн тоон

болон чанарын → ялгаатай үзэгдлийн нарийвчилсан дүн шинжилгээнд үндэслэн нийгмийн боломжийн талаарх социологийн үндсэн асуултад хариулахыг оролдож байв. Max Weber (*Wirtschaft und Gesellschaft. Grundriß der verstehenden Soziologie*, 1922) нийгмийн → бүлгүүдийн үйлдлээ (→ үйлдэл) утга санаагаар (→ утга) баяжуулах чадварыг нийгэм тогтвортой хэлбэрээ олох үндсэн нөхцөл гэж харсан. Үйлдэл хийх хүчтэй санаанд биечлэн хөтлөх нь дотооддоо сэтгэлгээний эрчимтэй хүмүүсийн туулдаг амьдралын хэв маягийг бий болгодог. Ийм үнэт зүйлсийг хуваалцах нь нийгэм бүхэлдээ нэг цул болох, → хүч чадалтай болох нөхцөл юм. Энэ бүх арга хандлага нь тохиолдлын боломжид том орон зай өгдөг: Тэд нийгмийн үүсэл эсвэл → хувьсал дахь мэдээжийн болон зайлшгүй шаардлагатай төлөвийн алийг нь ч биш, харин хүчнүүдийн таамаглах боломжгүй, үргэлж нээлттэй тоглолтын үр дүнг хардаг.

Talcott Parsons (*Toward a General Theory of Action*, 1951) үйлдлийн онолынхоо үүднээс, → оролцогчдын бие биетэйгээ хуваалцдаг сэтгэлгээний болон үнэ цэний чиг баримжааг бүхий л үйлдлийг зохицуулж үйл ажиллагааг урьдчилан таамаглахад зориулагдсан далд хүч гэж ойлгож байв. Хүлээлтийн тухай ойлголт болон хооронд нь тооцоолсон хүлээлтүүдийн харилцан холбогдохөөрөөр хэлбэл, хүлээлтүүсгэх таамаглалуудын (урьдчилсан таамаглал) дотоод логикийг үндэслэн Parsons “давхар тохиолдлын боломж” үйлдлийн үндсэн схемээ боловсруулахад хүрсэн: Энэ нь оролцогчдын нөгөө хүнийхээ хувьд тус тусын ухамсарт хүртээмжгүй

байдаг зарчмыг илэрхийлдэг бөгөөд тэр хэрээр нэг оролцогчийн хүлээлт нөгөөгийнхөө хүлээлтээс зарчмын хувьд ямагт өөр байж болдог. Parsons-той залгуулаад Niklas Luhmann (*Soziologische Aufklärung* 3, 1981) орчин үеийн нийгэм эцсийн дүндээ тохиолдох боломжуудын үйлдвэр шиг хүртээмжтэй байх онолыг боловсруулсан. Боломжийг өсгөх нь орчин үеийн нийгмийн шинж чанарын илэрхийлэл болох “ирээдүйн өсөлт” юм. Luhmann-ы онол нь цогц нийгмийг ойлгомжтой болгох зорилготой. Энд өөрийгөө дүгнэх байдлаар хардаг, улмаар зөрүүтэй логикийг бий болгодог ялгаатай үзэгдлүүдийг авч үздэг бөгөөд энэ нь боломжийг нэмэгдүүлж, гэнэтийн тохиолдлыг даван туулахад зайлшгүй шаардлагатай. Энэ нь нийгмийн олон үйл явцын виртуал орон зайг үүсгэх, шийдэгдэх аргагүй байдалтай зэрэгцэн явагдах бөгөөд нийгмийн харилцааг хөнгөвчлөх хамгаалалтуудыг шаарддаг. Ингэхдээ үргэлж төстэй шинж чанаруудыг өөрөөр хэлбэл, системийн бүх тогтвортой бүрэлдэхүүн хэсгүүдээс (→ үүрэг, → зохион байгуулалт) илүү гарсныг нь ашиглагддаг.

Jean Clam

Ernst Troeltsch: Die Bedeutung des Begriffs der Kontingenzt. In: E. T.: Gesammelte Schriften. Bd. 2. Tübingen 1913. S. 769–778.

Catherine Colliot-Thélène: Max Weber et l'histoire. Paris 1990.

Gerhart von Graevenitz / Odo Marquard (Hrsg.): Kontingenz (Poetik und Hermeneutik. Bd. 17.). München 1998.
Jean Clam: Kontingenz, Paradox, Nur-Vollzug. Grundprobleme einer Theorie der Gesellschaft. Konstanz 2004.

Төр (Staat)

Төр (англиар *state*; францаар *e'tat*) нь ялгаатай чиг үүрэг, функцийг хэрэгжүүлдэг → институцийн цогц гэсэн ойлголт. *Нутаг дэвсгэрийн чиг үүрэг* нь улсынхаа нутаг дэвсгэрийг хамгаалах, хууль эрх зүйн болон засаг захиргааны тогтолцоо зэрэг улсын нутаг дэвсгэрийн → зохион байгуулалт, түүний хяналтыг хэрэгжүүлэх чиглэл юм. *Эдийн засгийн чиг үүрэг* нь эрх зүйн норматив хэм хэмжээ болон институцийн зохион байгуулалтаар (→ эдийн засаг) дамжуулан эдийн засагдахь өмчийн харилцааг төрөөс баталгаажуулж, зах зээлийн харилцааг нэвтрүүлдэг. Төр нь *энхийг сахиулах, тогтвортой байдлыг хангах чиг үүргийн* хүрээнд эдийн засгийн системийн үр ашгийг баталгаажуулах, нийгмийн → зөрчилдөөнийг тайвшруулах үүднээс хууль ёсны албадлагыг (→ улс төр) хэрэгжүүлдэг. *Соёлын чиг үүрэг* (→ соёл) нь үндэстний хамтын оршихуйн → нийгмийг бүтээхэд хувь нэмэр оруулахдаа төртэй төвийн захисан харилцаатай оршдог. Антикийн үеэс л төр нь (→ тухайлбал, Aristoteles, Platon) философийн ухааны цөм нь болж байв. Социологийн шинжлэх ухаан үүсэхтэй зэрэгцэн төрийн тухай ойлголтыг

социологи судалж эхэлсэн. Зөвхөн үндэсний эдийн засгийн асуудлаас гадна төрийн шинжлэх ухааны хүрээнд өргөн агуулгатай хөгжсөн тул уг ухагдахууны гол судлагдахуунууд нь төрт улсын газар нутаг, ард түмэн болон төрийн эрх мэдэл байдаг. Төрийн тухай алдартай социологийн анализ нь Karl Marx болон Max Weber-ийн бүтээлд байдаг. Marx нь Hegel-ийн *төрийн эрх зүйн шүүмж* (*Kritik des Hegelschen Staatsrechts*, 1843) бүтээлийг шүүмжлэхдээ төрийг системтэйгээр авч үзсэн хэдий ч үндсэн утгаар нь төрийн тухай анализ боловсруулж чадаагүй. Тэр төрийг нийгмийн ангийн антагонист тэмцэл, зөрчилдөөний үр дүнд болон пролетарийн хувьсгалын дараах нийгмийн институци хэмээн ойлгож байсан (→ материалист нийгмийн онол). Marx-ын сонирхол нь улс төрийн эдийн засагт байсан ба бусдаас ялгаатай нь түүний хувийн сонголтоор төр нь “нийгмийн материаллаг баазын эпифеномен”, “шимэгчдийн институци”, “ангийн ноёрхлын хэрэгсэл”, “эв нэгдлийн хүчин зүйл” эсвэл “хөрөнгөтөн ангийн гүйцэтгэх нэгж” байх боломжтой байв. Weber төрийг улс төрийн өвөрмөц нэгдэл хэмээн авч үзэн судлахдаа төр, засаглалын ноёрхлыг социологийн хүрээнд хэлэлцсэн (*Wirtschaft und Gesellschaft. Grundriss der verstehenden Soziologie*, 1922). Энд төрийн тухай ойлголтод хэд хэдэн харах өнцөг чухал үүрэгтэй. Улс төрийн өвөрмөц нэгдлийн хувьд төр нь хүчирхийллийн хэрэгслийг хянах монопол шинж чанартай байдаг. Өөрөөр хэлбэл, (1) төрд “хууль ёсны” бие махбодын хүчирхийллийн цор ганц эрх мэдэл байдаг. Орчин цагийн төрийн

“рационал-хууль ёсны ноёрхол” нь (2) захирагдаж буй хүмүүсийн хүсэл эрмэлзлээс хамаардаг. Тэд хэрэгжиж байгаа ноёрхлыг хууль ёсны хэмээн хүлээн зөвшөөрдөг: Албадлагад “хууль ёсны итгэлцэл” болон “дагаж мөрдөх хүсэл” (хүлээцтэй байх) захирагдаж буй хүмүүст илэрдэг. Төр нь (3) “хууль ёсны ноёрхлыг” хүсэмжилдэг, засаглал нь тодорхой нутаг дэвсгэрийн бүрэн эрхийг тухайлбал, төрт улсын газар нутгийг хамардаг. Төрийн “бүрэх эрхт байдал” гэх санаа нь (4) улс төрийн нийгэмлэгийн харилцаанд үнэмлэхүй захирах эрх мэдлийг илэрхийлдэг. “Үндсэн хууль/ Үндсэн хуульд нийцсэн байдал” (5) нь улс төрийн үйл явцын тоглоомын үндсэн дүрмийг тодорхойлдог: Энд шийдвэрлэх хүчин зүйл бол батлагдсан хууль байх ба эрх баригч, захирагдаж буй хүмүүс нар хуульд адилхан захирагдана. Төгсгөлд нь, Joseph A. Schumpeter (*Die Krise des Steuerstaats*, 1918) “Татварын төр” (5) гэсэн ухагдахуунаар Weber-ийн тодорхойлсон орчин цагийн төрийг (→ шинэ үе) татвар ноогдуулахгүйгээр төсөөлөхийг аргагүй гэдийг тодорхой болгожээ.

Орчин цагийн төрийн тухай ойлголттой хамгийн нягт холбогдсон институци бол төрт улсын иргэний харьяалал. Орчин цагийн төрт улсын иргэншил бол иргэний эрх, үүргийн цогц харилцаа юм. Энэхүү харилцаа нь хувь хүмүүст хууль ёсны, хувийн шиж чанартай ижилслийг өгдөг. Иргэний, улс төрийн болон ялангуяа нийгмийн эрхийг институцчилснээр иргэншлийн суурь агуулгын хэлбэрийг зохион байгуулалтад оруулж, иргэн бүр тэгш эрхтэй, эрх чөлөөт (→ эрх чөлөө) статустай

болдог. Иргэд нь зүгээр нэг төрийн захирагдагч хэсэг биш харин мөн адил төрийн дур зоргоос хамгаалагдсан байдаг. Тэд бүрэн эрхт байдлаар сонгуульд оролцох замаар төрийн эрх мэдлийн эх сурвалж болж, үйлчлүүлэгч хэлбэрээр → хүмүүнлэг, нийгмийн чиг баримжаат төрт улсын бодлогоор нийгмийн томоохон эрсдэлээс хамгаалагддаг. Социологийн харах өнцгөөс бол төрт улсын иргэншил нь орчин цагийн нийгэмлэгийн нийгмийн интеграцчиллын шийдвэрлэх хэрэгсэл болдог. Thomas H. Marshall (*Citizenship and Class*, 1950 dt. 1992) орчин үеийн нийгмийн анги давхаргын → тэгш бус байдалд төрийн иргэншлийн нөлөөлөл, нийгэмлэгийн → нэгдлийн баталгаат байдлыг хангахад түүний ач холбогдлын тухай авч хэлэлцсэн байдаг. Сүүлийн үед → даяаршил, үндэстэн дамнасан харилцааны тухай хэлэлцүүлгийн нөлөөллөөр төрт улсын иргэншлийн функцийн чиг үүрэгт асуултууд гарч ирэхийн зэрэгцээ төрт улсын иргэншлийн хоцрогдлыг батлах гэж нийгмийн гишүүнчлэлийн олон янзын алтернатив хувилбар, загварчлал болон харьяаллын тухай сурталчилж байна.

Jürgen Mackert

John Peter Nettl: The State as a Conceptual Variable. In: World Politics 20 (1968). S. 559–592.

Peter B. Evans [u. a.] (Hrsg.): Bringing the State Back In. Cambridge [u. a.] 1985, Nachdr. 1999.

Michael Mann: The Sources of Social Power. Bd. 2: The Rise

of Classes and Nation-States. Cambridge [u. a.] 1993, Nachdr. 1998. – Dt.: Geschichte der Macht. Bd. 3: Die Entstehung von Klassen und Nationalstaaten. Übers. von Hanne Herkommer. Frankfurt a. M. / New York 1998. Tl. 1.

Stefan Breuer: Der Staat. Entstehung, Typen, Organisationsformen. Reinbek 1998.

Jürgen Mackert: Staatsbürgerschaft. Eine Einführung. Wiesbaden 2006.

Тэгш бус байдал (Ungleichheit)

Нийгмийн тэгш бус байдал гэдэг нь амьдралын боломжуудыг системчилсэн байдлаар, тухайлбал, → нийгэм дэх → оролцох боломжууд болон нийгэмд хамааралтай нөөцийг зарцуулах эрхийн тэгш бус хуваарилалт юм. Янз бүрийн эрин үед, нийгмийн төрөл байдлаас хамаарч “юуг хамааралтай” гэх, “юуг оролцуулах” замаар холбоотой гэж үзэх нь өөр өөр байсан. Тэгш бус байдлын онцлог шинжүүд нь тухайлбал материаллаг байдлаар сэтгэл хангалуун байх, → боловсрол болон мэргэжлийн нэр хүнд зэргээр илэрдэг. Тэгш бус байдлыг шударга бус байдлаас ялгаж ойлгох ёстой. Харж буй өнцөг тус бүрээс хамаарч тэгш бус байдлын (үр дүн) шударга бус, эсвэл легитим шинжтэй байж болно. Гэхдээ заавал ийм байх албагүй, тухайлбал тэгш бус гүйцэтгэлийн үнэлгээг зөвтгөх үндэслэл гэж үзэхгүй. Эсрэгээрээ орчин үеийн нийгэмд гарааны тэгш боломжийг бүрдүүлэх нь өөрөө улс төрийн чухал үүрэг гэж тооцогддог.

Тэгш бус байдлыг өөрийн нь эмпирик хэлбэр, байгаа нөхцөлөөр шалгаж болно. Боловсролын болон орлогын тэгш бус байдал, мөн $\rightarrow$ хүйсийн тэгш бус байдал нь энэ төрлийн нийгмийн бүтцийн анализ хийхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. 1960 оноос эхэлсэн боловсролын хурдацтай тэлэлт Герман улсад боловсролын гарааны тэгш боломжийг бүрдүүлж чадсан. Энэхүү боломж нь юуны түрүүнд эмэгтэйчүүд болон нийгмийн боломж багатай хүмүүст чиглэгдсэн. Олон улсын харьцуулалтаас авч үзвэл нийгмийн гарал, үүсэл нь хүмүүсийн боловсролд чухал нөлөөтэй байсаар байна. 1950 оноос эхлэн дундаж орлого ихээхэн нэмэгдсэн. Гэсэн хэдий ч өнөөдөр мэдэгдэхүйц тэгш бус хуваарилалт байсаар байна. Тухайлбал, ажилгүй, өрх толгойлсон ганц бие эцэг эхчүүдийг ядууралд өртөх эрсдэлийн бүлэгт тооцдог. Онол арга зүйн хүрээнд эдгээр асуултаас давсан байдлаар асуудалд хандаж байна. Соён гэгээрлийн үеэс эхлэн тэгш бус байдал нь бурхнаас өгсөн эсвэл байгалийн жам ёсны асуудал хэмээн үзэхээ больж, харин нийгмийн дотоод бүтцээс хамааралтай гэдгийг хүлээн зөвшөөрч эхлэхтэй зэрэгцэн илүү ихээр хамаарлыг тайлбарлах загварчлалуудыг боловсруулжээ. Энэ хүрээнд аль нэг нийгэмд “тэгш бус” бүлгүүдийн дунд (шаталсан) бүтэц байгаа эсэх, аль нэг амьдралын хэв маягийн хувьд, бүлгийн гишүүнчлэлийн харьяаллыг дагаж, сэтгэхүй хэв шинж эсвэл боловсрол нь коллектив $\rightarrow$ оролцогч талуудын хувьд болон бусад бүлгүүдтэй ямар холбоо, үр дагавартай байгаа эсэх, тэгш бус байдлаас үүдэн нийгмийн $\rightarrow$ интеграцид ямар

үр дагавар үүсэж болох тухай, юу хувь хүний хөгжлийг болон нийгмийн → өөрчлөлтийг илэрхийлдэг болох зэргийг судалж байна.

XIX зууны эхэн үед эдийн засгийг үндэслэл болгож дэвшүүлсэн нийгмийн онолуудын дундаас (Karl Marx) ноёрхогч болон захирагдагч → анги давхаргын (→ *материалист нийгмийн онол*) хооронд → зөрчилдөөн үүсдэг тухай онцлон тэмдэглэж байсан. XX зууны эхнээс нийгмийн давхаргын загварчлал (Theodor Geiger) нэмэгдэж, эрхэлж буй мэргэжлээс улбаалан, зарим тохиолдолд мөн боловсрол болон орлогоос шалтгаалсан нийгмийн давхарга бий болдог. Янз бүрийн гүйцэтгэлийн чанараас шалтгаалан өсөн дэвжих боломж байгаа нөхцөлд тэгш бус байдлыг энд легитим гэж үзэх боломжтой. Энэ хоёр загварт нийтлэг зүйл бол босоо бүтцийн нэг нэгэнтэйгээ давхардсан тэгш бус байдал, эдийн засагт суурилсан бүлгийн хүлээн зөвшөөрөлт юм.

Бүтцийн түвшинд тодорхойлогдсон бүлгийн харьяаллаас хамаарч хувь хүний амьдралын хэв шинжийг тэндээс харж болно. 1970 он хүртэл энэ хүрээнд өрнөсөн мэтгэлцээний дараа нийгмийн шилжилт (*материаллаг баялагт суурилсан хөгжил, боловсролын тэлэлт, амьдралын хэлбэрийн олон ургалч үзэл*) нь өнөөг хүртэл хөгжүүлсэн онолын хандлагын талаар хоорондын ялгаа байхгүй, хэт хөшингө суурь асуудлыг хөндөж эхэлсэн. Ижил төрлийн мэргэжилтэй хүмүүсийн амьдралын хэв маягаас (тухайлбал, тэдний чөлөөт цагаа өнгөрөөх байдал) бусад тохойлдолд ялгагдах болж, зөвхөн онцгой

нөхцөлүүд болон сонгуулийн сонголт хийх боломжууд нэмэгдсэн байдаг. “Тэгш бус байдлыг” зөвхөн давхаргын ерөнхий нэр томьёо болгон салгасан. Герман дахь тэгш бус байдлын тухай шинэ үеийн онолын хандлагын мэтгэлцээн гурван бүлэгт хуваагддаг:

Нэгдүгээрт, өмнөх үеийнх шиг нийгмийн анги, давхаргын үзэл баримтлалын хандлагыг баримтлах ба гэхдээ нийгмийн өөрчлөлтийг харгалзан үзэх. Rain-er Geißler (*Die Sozialstruktur Deutschlands*, 1992) нь илүү динамик хөдлөлтийг, илүү олон ургалч үзэлтэй нийгмийн давхраажилтын тухай ярьж эхэлсэн. Pierre Bourdieu (*La distinction. Critique sociale du jugement*, 1979, dt. 1982) эдийн засгийн үндэслэлтэй ангийн үзэл баримтлалыг өргөжүүлж, түүгээрээ соёл, нийгмийн → капитал (үүн дотор боловсрол болон → сүлжээ гэсэн утгыг илэрхийлэх) гэх ойлголтыг гаргаж тавьсан.

Тэгш бус байдлын тухай агуулгыг тодорхойлох үүднээс → амьдралын хэв маяг эсвэл → нийгмийн хүрээлэл гэх мэт нэр томьёогоор цаашид хэрэглэх хандлага ажиглагдаж байна (тухайлбал, Bourdieu und Gerhard Schulze, *Die Erlebnis-Gesellschaft*, 1992). Олон төрлийн, тэр дундаа хэвтээ чиглэл дэх тэгш бус байдлыг (тухайлбал, нас) хэмжихийг тэд зорилго болгож, мөн үйлдлийн практик дадал болон хандлагын микро түвшин гэж өнөө хүртэл ойлгогдож байсан бие даасан байдлыг онцолсон (тухайлбал, хөгжим, хэрэглээний сонголт). Нийгмийн хүрээлэл, амьдралын хэв маяг гэх зэрэг загварчлал нь ихэвчлэн тэгш бус байдлын онцлог шинжийг (Schulze-ийн жишээгээр, хамгийн

түрүүнд боловсрол, нас гэх зэрэг) илэрхийлэх байдлаас хамаардаг бөгөөд улмаар өнөөгийн тэгш бус байдлын загварчлалыг сайжруулсан.

Гурав дахь арга зүйн хандлага нь томоохон бүлгүүдийн шинж чанарыг тодорхойлохоос татгалздаг. Хамгийн алдартай жишээ бол Ulrich Beck-ийн дэвшүүлсэн → индивидуалчлал гэсэн таамаглал юм (*Risikogesellschaft. Auf dem Weg in eine andere Moderne*, 1986): тэгш бус байдал өнөөг хүртэл байсаар байгаа ч үүн дээр суурилсан (тухайлбал, давхарга) бүлгүүд хувь хүний үйлдэлд голлох нөлөө үзүүлдэггүй.

Эдгээр арга зүйн хандлагуудыг шүүмжлэлтэй авч үздэг. Жишээ нь, амьдралын хэв маягийн судалгаа нь үргэлж онолоос холхөндий, индивидуалчлалын хүрээнд дэвшүүлсэн таамаглалыг хэтэрхий бүтэцгүйжүүлсэн гэж үздэг. Цаг хугацаанаас үл хамааран өрнөж байгаа эдгээр дискурсууд (тухайлбал, босоо чиглэл дэх тэгш бус байдлыг сүүлийн жилүүдэд илүү ихээр онцолсон) нь үндсэн шинэ хандлагын *mainstream* талаар нэгдсэн нэг саналд хүрэхгүй байна.

Nicole Burzan

Stefan Hradil: Soziale Ungleichheit in Deutschland. Wiesbaden ⁷1999, ⁸2001, Nachdr. 2005.

– Die Sozialstruktur Deutschlands im internationalen Vergleich. Wiesbaden 2004, ²2006.

Nicole Burzan: Soziale Ungleichheit. Eine Einführung in die zentralen Theorien. Wiesbaden 2004, ³2007.

Улс төр (Politik)

Улс төр (грекээр *polis* = “*хот*”, “*хамтрал*”) гэдэг нь ерөнхийдөө нийгмийн гишүүдийн нийтлэг харилцаанд заавал дагаж мөрдөх журам ёстой институцчилэгдсэн шийдвэр гаргах үйл явц юм.

Хэрэв хэн нэгэн улс төр, улс төртэй холбоотой социологийн тодорхой үйл ажиллагааны талаар асуувал агуулга, арга зүйн хандлагын бүх ялгааг үл харгалзан улс төрийн зан үйл, ажиллагаа (→ үйл ажиллагаа) болон улс төрийн институци, эсвэл улс төрийн тогтолцоог “функционал ялгаа” (→ ялгах) гэх мэт нийгмийн хөгжил болон тэдгээрийн хүчин зүйлсээр дамжуулан тайлбарлах оролдлоготой нүүр тулгардаг. Max Weber (*Wirtschaft und Gesellschaft. Grundriß der verstehenden Soziologie*, 1922) үйл ажиллагааны онолын үүднээс улс төрийг эрх мэдэл (→ эрх мэдэл) гэсэн ойлголтоор тодорхойлж, төрийн үйл ажиллагааны хүрээнд “эрх мэдлийг хэрэгжүүлэх” ба улс доторх болон → улс хоорондын “эрх мэдлийн төлөөх тэмцэл” гэжээ; Talcott Parsons (*The System of Modern Societies*, 1971, dt. 1972) нь өөрийн бүтцийн-функционалист системийн онолдоо (→ функционализм) улс төрийн дэд системийн функцийг → нийгэмд “зорилгыг хэрэгжүүлэх”, түүний дараахан улс төр судлаач David Easton (*A Framework for Political Analysis*, 1965) “нийгэмд хэрэгжих үнэт зүйлсийн хуваарилалт” хэмээн тодорхойлсон. Theodore J. Lowis-ийн («Four Systems of Policy, Politics and Choice», in: *Public Administration Review* 33, 1972) тодотгосноор,

эрх мэдлийн хуваарилалт нь бодлогын судалгааны үр дагаврын ялгаатай байдлаар → хэм хэмжээг тогтоох зорилгоор зохицуулалт хийх, материаллаг байдлаар дахин хуваарилах, шийдвэрийг хуваарилах эсвэл дахин хуваарилах зарчмаар шийдвэр тогтоодог. Niklas Luhmann (Die Politik der Gesellschaft, 2000) “улс төрийн зорилго”-ыг “Засгийн газрын болон сөрөг хүчин” хэмээн ялгаатай болгон хялбаршуулсан.

Улс төрийн эмпирик социологи нь XX зууны дунд үеийн зан төлөвийн хувьсгалын явцаар улс төрийн зан үйлд анализ хийх болон тодорхойлох үйл явц руу шилжсэн. → Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, улс төрийн → оролцогчдын төлбөрийн чадвараас улбаалан удаан хугацаанд улс төрийн хандлага болон улс төрийн сонгуулийн шийдвэрт тэдний үзүүлэх нөлөө нь ашиг сонирхлын цөмд байсан. Учир нь “сонгуулийн шийдвэр” эсвэл “сонгуулийн үр дүн” бол бараг туршилтаар тодорхойлох хамраалтай хувьсагч тул сонгуулийн судалгаа нь иймээс улс төрийн социологийн арга зүйн хамгийн хөгжсөн чиглэлийн нэг хэсэг болсон.

Улс төртэй холбоотой хувь хүний хандлага, зан үйл болон тэдгээрийн хөгжил, төлөвшил нь улс төрийн нийгэмшлийн явцаар нийгмийн янз бүрийн шинжлэх ухааны болон практик хэрэглээнд мэдлэгийн үнэ цэнтэй байдаг. Залуучуудын эсвэл хүн амын тусгай бүлгүүдийн (жишээлбэл, цагаачид, цэргүүд) “ардчилсан” эсвэл “ардчиллын эсрэг” (жишээ нь, баруун, зүүний хэт даврагч эсвэл антисемит) хандлагыг судлах нь нэг талаас боловсролын шинжлэх ухаан, нөгөө талаас улс

төрийн шинжлэх ухаантай онолын болон практикийн чухал ач холбогдолтой. Хөгжиж буй улс орнуудын судалгааны (→ хөгжлийн) улс төрийн сонирхол болон колоничлолоос ангижрах явцад улс төрийн харьцуулсан судалгаанд практик жишээ тогтсон. Улс төрийн соёл гэдгийг Gabriel Almond болон Sidney Verba (*The Civic Culture*, 1963) нар олон улсын жишиг тогтоосон харьцуулсан судалгаагаар “улс төрийн асуудалд хандах үндэстэн улсын гишүүдийн зан үйлийн хэв маягийн өвөрмөц хуваарилалт” гэж тодорхойлсон (the particular distribution of patterns of orientation toward political objects among the members of a nation); өргөн цар хүрээний мэдээлэл цуглуулсны үндсэн дээр улс төрийн янз бүрийн төрлүүдээр (иргэний, авторитар; “иргэний нийгэм” эсвэл “авторитар” гэх мэт)-ийн хувь хүний зан байдал, хандлагын өгөгдлийг нэгтгэж, тэдгээрийн институцийн тогтвортой байдал, гүйцэтгэлд үзүүлэх ач холбогдлыг (тус бүрийн бодит төрх) улс төрийн тогтолцооны талаар хэлэлцэх боломжтой юм. Эдгээр асуултууд өнөөдөр ардчиллын харьцуулсан эмпирик болон шилжилтийн судалгаанд чухал үүрэг гүйцэтгэсэн хэвээр байна. Дайны завсарын үед бий болсон сонгодог хувилбар болох “нийгмийн халамжийн бодлого”-оос үүдэлтэй олон улсын хэмжээнд харьцуулсан халамжийн төрийн судалгаа (→ халамжийн төрт улс) нь улс төрийн социологи, улс төрийн болон бага хэмжээгээр эдийн засгийн шинжлэх ухаан хэмээн хуваагддаг. Улс төрийн дэглэмийн түүхэн харьцуулалт болон төрөл бүрийн халамжийн ангилал нь нэг талаас

даяарчлалын цаг үед орчин цагийн халамжийн хамтын нийгэмлэгүүдийн нийтлэг чиг үүргийг харуулах хэдий ч, нөгөө талаас асуудлыг шийдвэрлэхэд “тэдний чиг баримжаанаас хамаарах” өөрчлөлтүүд, түүнчлэн тайлбарлахын тулд институцийн болон улс төр-соёлын хүчин зүйлсийг зэрэгцүүлэн ашигладаг. Гэхдээ социологийн "тайлбар"-ын хувьд улс төрийн хувьд болзошгүй (→ гэнэтийн) шийдвэрүүдийг ихэвчлэн орхигдуулдаг талтай. Улс төрийн үйл ажиллагаа, үйл явц, бүтэц эсвэл тогтолцооны шинжлэх ухааны судалгааны хамрах хүрээний зааг нь нэг нэгэндээ хязгаарлагдахгүй. Улс төрийн болон социологийн судалгааны хамрах хүрээ нь баруун Герман улсад удаан хугацааны турш маргаантай байсаар ирсэн. Германы социологийн нийгэмлэг дотор зохион байгуулалтад орсон социологи нь 1968 оноос хойш “улс төржилт”-өөс болгоомжлон өөрийн салбараа байгуулахаас удаан хугацаагаар татгалзаж байсан бол 1980-аад оны эхээр хоёр германы нэгдэх хүрээнд улс төрийн шинжлэх ухааны хүрээнд байгуулагдсан. → Социологи нийгмийн онолын хувьд улс төрийг өнөөдөр бусад салбарын адил тэгш эрхтэйгээр нийгмийн ялгаатай дэд функц гэж голчлон авч үзэж байгаа бол Michael Th. Greven (*Die politische Gesellschaft*, 1999) хэлснээр, орчин үеийн “улс төрийн нийгэм”-д улс төрийн үндсэн чиг үүргийг үл тоомсорлох аюул нүүрлэж байна. Шинжлэх ухааны позитивизмын нөлөөнд автсан социологийн хувьд Hannah Arendts (*Was ist Politik?*, 1993) эсвэл Chantal Mouffes (*On the Political*, 2005, dt. 2007) утгаар улс төрийн үйл ажиллагаа,

шийдвэр гаргах эрх чөлөөг хангах (→ эрх чөлөө) гэнэтийн шинж чанар (→ болзошгүй)-ыг шийдвэрлэхэд амаргүй билээ.

Michael Th. Greven

Anthony M. Orum: An Introduction to Political Sociology. Englewood Cliffs 1978, ⁴2001.

Andrea Maurer: Herrschaftssoziologie. Frankfurt a. M. / New York 2004.

Thomas Janoski (Hrsg.): The Handbook of Political Sociology: States, Civil Societies and Globalization. Cambridge [u. a.] 2005.

Lothar Bönisch: Politische Soziologie. Eine problemorientierte Einführung. Opladen 2006. Gert Pickel: Politische Soziologie. Eine Einführung. Wiesbaden 2007.

Утга санаа (Sinn)

“Утга учир” (англиар *meaning, sense*; францаар *sens*) гэдэг нь янз бүрийн байдлаар хэрэглэгддэг социологийн үндсэн ухагдахуун юм. Зорилгод суурилсан өнцгөөс нь авч үзвэл “утга учир” гэдэг нь “ямар нэгэн зүйл”-д чин хүсэл эрмэлзлээрээ зорих гэж ойлгогдох бөгөөд ингэхдээ гол нь энэхүү “ямар нэг зүйл” тодорхой хэмжээгээр өгөгдсөн байх явдал юм. Харин функциональ талаас нь авч үзвэл энд “ямар нэг зүйл”-ийг бүхэлд нь, цогц байдлын хүрээнд үнэлэх ангиллын тухай яригдах юм.

Зарим социологийн онолд “утга учир”-ыг нэгдүгээрт, байгаль ба → соёл эсвэл байгаль ба нийгмийн амьдралын анхдагч ялгааг (гарал үүсэлтэй холбоотой) гаргахад ашигладаг. Байгалийг утга учиргүй, шалтгаант болон нөхцөлт хамаарал бүхий ертөнц гэж үздэг бол нийгмийн амьдралыг утга учиртай, болзошгүй (зайлшгүй бус; тохиолдлын) утга учиртай чиг баримжаатай буюу болзошгүй утга учрыг бий болгосон ертөнц гэж үздэг (z. B. Max Weber, »Die ›Objektivität‹ sozialwissenschaftlicher und sozialpolitischer Erkenntnis«, in: *Archiv für Sozialwissenschaft und Sozialpolitik* 19, 1904; Andreas Reckwitz, *Die Transformation der Kulturtheorien*, 2000). Niklas Luhmann (*Soziale Systeme*, 1984) ч мөн утга учиргүй, шалтгаант → тогтолцоо ба утга учиртай ажиллаж байгаа сэтгэл зүйн буюу нийгмийн тогтолцооны хооронд ялгаа гаргадаг.

Хоёрдугаарт, субъектив, нийгмийн утга учир болон хэм хэмжээний утга учир (грекээр *nomos* = “хууль”)-ыг хооронд нь ялгадаг. Weber (*Wirtschaft und Gesellschaft. Grundriß der verstehenden Soziologie*, 1922)-ийн хэлснээр, “субъектив утга учир” гэсэн хэллэг нь → оролцогчийг → зан харилцаа, үйлдэлтэй (→ үйлдэл) холбодог шалтгаан эсвэл зорилгыг илэрхийлж байгаа юм. Феноменологийн чиг хандлагатай нийгмийн онолдоо субъектив утга учрын хуулийг зориудын ухамсарт үйлдлээр тайлбарлахыг оролдсон Alfred Schütz (*Der sinnhafte Aufbau der sozialen Welt*, 1932) энэ уламжлалыг мөн дагадаг. Тухайн нийгмийн хэмжүүрээр субъектив утга учиртай ихэнхдээ ижил байдаггүй үйлдлийн

утга учрыг “нийгмийн утга учир” гэж нэрлэдэг. Энд нэг талаас үйлдлийн утга учрыг нийгмийн үзэгдлийг бий болгох, сэргээх үүрэгтэй эдгээр үйлдлүүдийн ажиллагаанаас илүүтэй объектив байдлаар тодорхойлж болно. Нөгөө талаас, утга учрыг институцийн дэг журам эсвэл харилцааны болон нийгэм-соёлын практикийн дүрмийн хүрээнд үйл ажиллагааны утга санаа болгон илүү, семиологи эсвэл соёлын хүрээнд дахин сэргээж болно. (Pierre Bourdieu, *Le sens pratique*, 1980, dt. 1987; Harold Garfinkel, *Studies in Ethnomethodology*, 1967). Эцэст нь, үйл явдал болон тохиолуудын заавал, зайлсхийх боломжгүй утгыг хуулийн утга гэж ойлгож болно (жишээ нь, “түүхийн утга”, “амьдралын утга учир”). Энд утга учиртай тал нь юуны түрүүнд тавигдахгүй, харин аль нэгэн субъектийн хувьд ямар нэг зүйл утга учиртай байх эсэх тухай асуудал яригдах юм.

Ойлголтын гурав дахь арга нь туршлага өөрөөр хэлбэл, → мэдлэг ба үйлдлийн хооронд ялгаж үздэг. Зарим социологийн онолууд туршлага, → ойлголт эсвэл мэдлэг талаас нь онцлон, утга учрын ач холбогдлыг дэлхийд гарах эсвэл дэлхийг бүтээх зайлшгүй хэлбэр гэж ярьдаг. Энэхүү ойлголтын арга хэлбэр жишээлбэл, Herbert Blumer-ийн → символик интеракционизм (*Symbolic Interactionism*, 1969)-ын үндсэн сэдэвт орсон байдаг ба үүний дагуу хүмүүс интерактив үйл явцад утга учрыг бүрдүүлж, үүний үндсэн дээр аливаа юмс, хүмүүс, үйлдэлтэй харьцдаг байна. Нөгөөтээгүүр, бусад социологичид үйлдлийн хэм хэмжээнд илүүтэй

анхаарч, “утга учир” гэдгийг үйлдлийн зорилго, шалтгаан, хүсэл эрмэлзэл эсвэл зохион байгуулалт гэж хүлээн авдаг.

Дөрөвдүгээрт, “утга учир”-ыг “ойлгох” гэх зэрэг түүнийг орлох нэр томъёоноос ялгаж болно. “Утга учир” нь тэгэхээр нийгмийн баримт, үйлдэл эсвэл үг хэллэгийг нийгэм, соёлын хүрээнд сэргээж, илэрхийлсний үр дүн болох юм. Энэ хэмжигдэхүүн нь тайлбарлах буюу таниулах социологийн бүхий л хувилбаруудад гол байр суурийг эзэлдэг. Өөр нэгэн орлох нэр томъёо бол “хэл” юм. Энэ утгаараа хэлж ярьж байгаа зүйлийн утга учир нь үг хэл эсвэл аман мэдэгдлийн сэдвийг (*Intension/Extension*) хамаарч байдаг (Jürgen Habermas, *Vorlesungen zu einer sprachtheoretischen Grundlegung der Soziologie*, 1970). Сүүлийн үеийн хувилбараар “утга учир”-ыг эцэст нь системийн онолд утга учиртай ялгаа, хэлбэрийг бий болгож болдог зайлшгүй орчныг бүрэн тодорхойлоход ашиглаж байна (Niklas Luhmann, *Die Gesellschaft der Gesellschaft*, 1997).

Rainer Schützeichel

Karl Mannheim: Beiträge zur Theorie der Weltanschauungs-Interpretation. In: Jahrbuch für Kunstgeschichte 1 (15) (1921/22). S. 236–274. – Nachdr. in: K. M.: Wissenssoziologie. Hrsg. von Kurt H. Wolff. Neuwied/ Berlin 1964, 21970. S. 91–154.

Helmuth Plessner: Die Deutung des mimischen Ausdrucks (1925). In: H. P.: Ausdruck und menschliche Natur. (Ge-

- sammelte Schriften. Bd. 7.) Frankfurt a. M. 1982. S. 67–130.
- Niklas Luhmann: Sinn als Grundbegriff der Soziologie. In: Jürgen Habermas / N. L.: Theorie der Gesellschaft oder Sozialtechnologie. Frankfurt a. M. 1971, ¹⁰1990. S. 25–100.
- Jörn Stückrath: »Der Sinn der Geschichte«. Eine moderne Wortverbindung und Vorstellung? In: Klaus E. Müller / Jörn Rüsen (Hrsg.): Historische Sinnbildung. Reinbek 1997. S. 48–78.
- Dirk Rustemeyer: Sinnformen. Konstellationen von Sinn, Subjekt, Zeit und Moral. Hamburg 2001.

Утопи (Utopie)

Утопи (грекээр *μου* = “үгүй”, *topos* = “газар”) гэдэг ухагдахуун нь одоо байгаа нийгмийн → бодит байдлаас гажсан нөхцөл байдлын тухай дүрслэл юм. Утопи дүрслэлийн агуулга, хэлбэр нь түүхэнд хувьсах шинж чанартай. Аль нэг хүссэн төлөв байдлын үүднээс харахад утопи нь одоо байгаа нийгмийн харилцааг шүүмжилдэг. Үзүүлж буй алтернатив бодит байдал нь нийгэм, улс төрийн үйл ажиллагаагаар илэрдэг. Утопи нь ирээдүйн зохиомол бодит байдлыг байгалийн шинжлэх ухаан дахь техникийн хөгжлийн үр дүнд бий болсноор төсөөлдөг шинжлэх ухааны зөгнөлт зохиолоос өөрөө ялгардаг ба уран зөгнөлт өгүүлэлд зохиомол бодит байдлын эсрэг (оршин байгаа бодит

нөхцөлийн үгүйсгэлд) рационал ухамсарлаж болохуйц тайлбар өгдөггүй байна. Platon өөрийн бүтээл “*Politeia*”-даа идеал, мөнхийн → төрт улсын “*Staat*” (*polis*) тухай төсөөллийг бүтээсэн. Тэр үүгээрээ ухамсарт суурилсан оновчтой удирдлагатай нийгмийн дэг журмын тухай төсөөлж буй идеал төлөв нь өгөгдөж буй бодит байдлаас дээгүүр тавигдана гэжээ. Thomas Morus’ *Utopia* (1516), Tomasso Campanellas *Civitas Solis* (1620) und Francis Bacons *Nova Atlantis* (1622) нар нь оршин байгаа бодит байдлын хажууд хамааралтай → нормыг гаргаж, улмаар боломжит хувилбараар дэвшүүлсэн. Утопист “социалистуудын” Claude Henri de Saint-Simon (*Du système industriel*, 1821) und Charles Fourier (*Théorie des quatres mouvements*, 1808) шүүмжлэл нь аж үйлдвэржсэн нийгмийн шинэ зохион байгуулалтыг социал-ёс зүйтэй, рационал-шинжлэх ухааны зарчмаар өөрчлөн байгуулахад чиглэгдсэн байна. Karl Marx und Friedrich Engels нар “*Manifest der kommunistischen Partei*” (1848) коммунист намын тунхаглал бүтээлдээ утопи социализмыг шүүмжилсэн бөгөөд энэ нь ангийн эсрэг чиглэсэн (→ анги) үзлийг даван туулах цэвэр хийсвэр төсөөлөл гэж үзсэн. Тэдний үзлээр бол утопи нь шинжлэх ухаанч социализмын хөгжлийн даван туулсан үе шат байв (Friedrich Engels, *Die Entwicklung des Sozialismus von der Utopie zur Wissenschaft*, 1891).

Karl Mannheim нь идеологи ба утопи (1929) бүтээлдээ утопи ухамсарт төлөвийг “түүний хүрээлэн буй оршихуйтай тохирохгүй ухамсарт төлөв” гэж тодорхойлжээ. Хэрэгжүүлэх шалгуур хамгийн чухал

нь: Хэзээ нэгэн цагт түүхэн-нийгмийн оршихуйн шилжилтэд нөлөөлж байгаа бол тэр нь утопи юм. Гэхдээ тэр нь нийгмийн харилцааг хамруулсан → идеологи юм. Ernst Bloch (*Das Prinzip Hoffnung*, 1954)-ын хувьд бодит байдлыг өөрчилж буй утопи ухамсарт төлөвийн хүч нь утопи үзлийн гол шалгуур байв. “Бодит” утопи бол Bloch-ын хувьд тодорхой утопи бөгөөд эдгээр нь бодит байдлын ирээдүйг харсан шинж чанаруудыг таньж, хэрэгжүүлэх гэжээ. Helmuth Plessner-ын дараа нь Martin Schwonke (*Vom Staatsroman zur Science Fiction*, 1957)-ийхээр утопи бол боломжит төлөв байдлын тухай хүний ухамсрын илэрхийлэл гэж үзсэн. Хүн гэдэг “ухамсарт амьтан” нь өгөгдсөн нөхцөлийг давж туулах чадвартай, энэхүү “бусад төрөл зүйлээс өөр байх” боломж нь утопи хэлбэрийг тэрээр турших боломж гэжээ. Утопи нь тиймээс хүний “утопи-оршихуйн газрын” байгалийн жам ёсны илэрхийлэл аж (Helmuth Plessner, *Die Stufen des Organischen und der Mensch*, 1928). Өнөөдрийн байдлаар утопи бол байгалийн шинжлэх ухаан-техникийн төсөөллүүдийн хэлбэрийн өөр нэг төрөл бөгөөд хүний (биологийн) хил заагыг (хязгаарлалт) даван легитим болгосон судалгааны чиглэл болжээ. Hans Moravec (*Mind Children. The Future of Robot and Human Intelligence*, 1988, dt. 1990) oder Raymond Kurzweil (*The Age of Spiritual Machines*, 1990, dt. 1993) зэрэг технологич эрдэмтдийн судалгааны чиглэл нь ихэвчлэн нийгмийн боломжуудын алтернатив хувилбарт төлөвлөхийг зорьж байв. Зорьж буй алтернатив бодит байдал нь өгөгдсөн байгаа нөхцөлийн дээр эсвэл түүний хажууд

биш, харин хүмүүс өөрсдөө төсөөлж болдог байх тухай юм. Технологийн хөгжлийн дэвшил, “хүмүүний транс үзэлтнүүд”-ийн авралын төсөөлөл нь ирээдүйд цогц бус хүмүүний төрлийг үхэшгүй мөнх, бүхнийг мэдэгч болгох ёстой болж байна.

Gereon Uerz

Wilhelm Voßkamp (Hrsg.): Utopieforschung: Interdisziplinäre Studien zur neuzeitlichen Utopie. 3 Bde. Stuttgart 1982.

Richard Saage: Utopieforschung. Darmstadt 1997.

Utopisches Denken im historischen Prozess. Materialien zur Utopieforschung. Berlin/Münster 2006.

Hiltrud Gnüg: Utopie und utopischer Roman. Stuttgart 1999.

Rudolf Maresch / Florian Rötzer (Hrsg.): Renaissance der Utopie. Zukunftsfiguren des 21. Jahrhunderts. Frankfurt a. M. 2004.

Үеийнхэн (Generation)

“Үеийнхэн” (латинаар *generatio* = “үржих”) гэдэг нь туршлага, хандлага, харилцааны хэв маягаараа адил төстэй ижил насны → бүлэг хүмүүсийг нэршил юм.

Бүр социологийн эхэн үед үеийнхний залгамж халааг нийгмийн → өөрчлөлтийн гол хүчин зүйл гэж онцолж байсан. Auguste Comte (*Cours de philosophie positive*, Bd.

4, 1849) 30 жил тутамд тогтмол өрнөж буй үеийнхний өөрчлөлтийг нийгмийн ахиц дэвшлийн үндэс гэж харж байв. Мөн тэрээр хүний амьдралын үргэлжлэх хугацаа нь түүх болон нийгмийн өөрчлөлтүүдийн хэмнэлийг тодорхойлж байдаг гэж үзжээ. Мөн үүнтэй төстэй үзэл санааг John Stuart Mill (*A System of Logic, Ratiocinative and Inductive*, 1843) дэвшүүлж байв.

Юуны түрүүнд германы хүмүүнлэгийн ухааны салбарт XIX зууны дунд үеэс эхлэн үеийнхний талаар концепт боловсруулж байсан. Wilhelm Dilthey («Über das Studium der Geschichte der Wissenschaften vom Menschen, der Gesellschaft und dem Staat» [1875], in: *W. D., Gesammelte Schriften*, Bd. 5, 1924) нь романтикийн талаар хийсэн судалгаан дээрээ үндэслэж, үе үеийнхэн цаг хугацааны тогтсон хэмнэлээр ирдэг хэдий ч тэдний хувийн шинж байдалд нь өсвөр насандаа хамтдаа үзэж туулсан үйл явдлын туршлагын нөлөө шингэсэн байна гэсэн санааг дэвшүүлсэн. Эндээс харахад бүх үеийнхэнд нийгэм, түүхийн нөхцөл байдал нөлөөлдөг.

Karl Mannheim («Das Problem der Generationen», in: *Kölner Vierteljahrshefte für Soziologie* 7, 1928/29)-ын үеийнхний онол хамгийн нөлөө бүхийд тооцогддог бөгөөд тэрээр өөрийн үзэл бодлоо марксист ангийн (→ анги) үзэл баримтлалд тулгуурлан гаргасан бөгөөд ангийн байр суурьтай адилтгаж “үеийнхний байр суурь” буюу “үеийнхний харьяалал”-ыг → хувь хүний бүрэлдэх түүх-нийгмийн контекст гэж хэлсэн байна. Түүнийхээр үеийнхний байр сууринд орох харьяаллын гол утга учир зөвхөн төлөвшил олгохуйц үйл

явдлуудыг нэгэн үед үзэж туулсанд нь байдаг бөгөөд “нийтлэг хувь тавиланд оролцох” нь “үеийн хамаарал”-ыг бий болгодог. Үеийн хамаарал дотор нэг “үеийн нэгдмэл” нийтлэг хувь тавилангийн өөр өөр, ихэнхдээ туйлширсан тайлбарууд илэрдэг бөгөөд үүнийг үе бүрийн гол цөм гэж үзэх ёстой гэжээ. Мөн Mannheim үеийнхэн дотор байдаг → зөрчил үүсэх боломжийг сэдэв болгон гаргаж тавьсан. Зөрчилдөөн бол зөвхөн нэг үе дотор төдийгүй нэг үеэс нөгөөд шилжих шилжилтийн үед ч тохиолдож болно.

Дайны үеийн хоорондох хугацаанд үеийнхний зөрчлийн тухай энэ санаа үеийнхний онолыг нэлээд олонд хүргэсэн байдаг ч нөгөө талаас энэ нь үндэсний социализмын үед ард түмний хамтын нийгэмлэгийн идеологийг (→ хамтын нийгэмлэг, идеологи) уялдуулах замаар дарагдсан юм. Дэлхийн II дайны дараа “үеийнхэн” нь юуны түрүүнд “улс төрийн үеийнхэн” гэдэг утгаар хэрэглэгдэж байсан, жишээлбэл, Helmut Schelsky *эргэлзээтэй үеийнхэн* (1957), Heinz Budes *“Агаарын довтолгооноос хамгаалах ангид туслагчдын үеийнхэн”* (Deutsche Karrieren, 1987) эсвэл “68 оны үеийнхэн”.

“Үеийнхэн”-д хамруулсан энэ герменевтик¹⁵ чадвар биологийн арга зүйгээс татгалзах хүртэл голдуу ийм аргаар нийгэм, түүхийн өөрчлөлтийн үйл явцын тухай “мэдээжийн” тайлбарыг өгч болно гэсэн таамаглал дээр тулгуурлаж байсан. Өнөөдөр “анги”, “үндэстэн” гэх мэт хамаатуулах утгуудыг ховорхон ашигладаг болсон болохоор “үеийнхэн” нь голчлон хувь хүнийг

15 Тайлбарлах урлаг.

нийгмийн нэг том бүлэгт байршуулах гэсэн утгыг агуулж байна. Гэсэн хэдий ч “үеийнхний онол” маргаантай судалгааны үзэл баримтлал хэвээр байна. Үүний гол шалгаан нь “үеийнхэн” гэсэн ухагдахууныг арга зүйн хувьд ихэвчлэн тодорхой бус ашигладаг, кохорт¹⁶ (жилээр бүлэглэх) гэх нэр томъёоноос тодорхой ялгаж зааглаагүйд оршино.

Christine Hikel

Heinz Bude: Generationen im 20. Jahrhundert. Historische Einschnitte, ideologische Kehrtwendungen, innere Widersprüche. In: Merkur 54 (2000). S. 567–579.

Martin Kohli / Marc Szydlík (Hrsg.): Generationen in Familie und Gesellschaft. Opladen 2000.

Jürgen Reulecke (Hrsg.): Generationalität und Lebensgeschichte im 20. Jahrhundert. München 2003.

Ulrike Jureit / Michael Wildt (Hrsg.): Generationen. Zur Relevanz eines wissenschaftlichen Grundbegriffs. Hamburg 2005.

Үйлдэл (Handlung)

“Үйлдэл” гэдэг нь Max Weber («Soziologische Grundbegriffe», in: M. W., *Wirtschaft und Gesellschaft. Grundriß der verstehenden Soziologie*, 1922)-ийн сонгодог

¹⁶ Урт хугацаанд тодорхой төлөвшүүлэхүйц үйл явдлыг хамтдаа туулсан хүмүүсийг бүлэг болгон судлах: [https://de.wikipedia.org/wiki/Kohorte_\(Sozialwissenschaft\)](https://de.wikipedia.org/wiki/Kohorte_(Sozialwissenschaft))

тодорхойлолтоор үйлдэгчийн тодорхой субъектив → утга санаа (→ субъект) бүхий аливаа зан үйл юм. → Өдөр тутмын амьдралдаа бусад хүний үйлдэлд зохих хариу үйлдэл үзүүлэхийн тулд тухайн зан харилцаагаараа дамжуулаад яг ямар үйлдэл харуулахыг оролдсон бэ гэдгийг ойлгоход хангалттай (жишээ нь, мэндлэхдээ инээмсэглээд толгой дохих). Иймэрхүү тохиолдлыг Weber “одоогийн ойлголт” гэж хэлдэг. Үүнээс цаашлаад аливаа үйлдлийг ойлгоход бас сэдлийг нь анзаарах буюу өөрөөр хэлбэл, харилцагчийн тухайн үйлдлийг хийхэд хүргэсэн шалтгааныг харгалзаж болно (жишээ нь, мэнд мэдсэн хүн саяхан болсон хэрүүл маргаанаа мартсан гэдгээ мэдэгдэхийн тулд ингэж мэндчилснийг ойлгосон бол). Weber энэ сүүлийн тохиолдлыг “сэдэл өгч эсвэл тайлбарлаж ойлгуулах” гэж нэрлэдэг.

Weber-ийн хэлснээр, шинжлэх ухааны ажиглагчийн хувьд хамгийн сайн ойлгох зүйл нь “рационал зорилго”-оор сэдэлжсэн аливаа үйлдэл юм, өөрөөр хэлбэл, тодорхой зорилгоо биелүүлэхийг хүсээд, түүндээ хүрэхийн тулд сонгосон арга хэрэгслийг болзошгүй гаж нөлөөг үнэлсний үндсэн дээр тохиромжид нь тааруулан ашиглах явдал юм. Рационал зорилготой үйлдлийн хажуугаар үйлдлийг тодорхойлдог шалтгаануудын өөр гурван “цэвэр” төрлийг рационал байдлынх нь хувьд буурах эрэмбээр харуулжээ: аливаа үйлдлийн өөрийн туйлын (жишээ нь, ёс зүйн эсвэл гоо зүйн үндэслэлтэй) эрхэмж, үнэ цэнд чиглэгдсэн, ингэхдээ гаж үр нөлөөг ухамсартайгаар анхаарч авч үздэггүй

“эрхэмжийн дагуух рационал үйлдэл”, цаашлаад хоёр рационал бус буюу “сэтгэл хөдлөл” (мэдрэмжийн байдлаар тодорхойлогддог) ба “уламжлалт” (дадсан зан үйлд хөтлөгддөг) үйлдлийн төрлүүд юм. Эмпирик үйлдлийг голчлон эдгээр үйлдлийн төрлүүдийн аль нэгэнд нь хуваарилж болох боловч зөвхөн үүгээр хязгаарладаггүй, учир нь эдгээрт өөр үйлдлийн төрөлд тохирох утга санааг агуулагдаж байж болох юм.

Хожуу үеийн үйлдлийн онолын хэлэлцүүлэгт хоорондоо нягт холбоо бүхий гурван харах өнцгийг онцолжээ: (1) Асуулт: олон тооны хувь хүмүүсийн санамсаргүй сонгосон үйлдлүүдийг тогтвортой нийгмийн дэг журмыг шинэчлэхэд хэрхэн нэгтгэх боломжтой вэ? (2) Асуулт: хэр рационал үйлдэл вэ? (3) Асуулт: үйлдлийн субъектив утга санаа хэрхэн бий болж, бусад оролцогчдод ойлгогддог вэ?

(1) Нийгмийн дэг журмын асуудал Talcott Parsons (*The Structure of Social Action*, 1937; → Функционализм)-ын үйлдлийн онолын төвд байдаг. Энд энэ асуудлыг шийдсэн арга зам бол оролцогчид → нийгэмшлийнхээ явцад өөртөө шингээсэн, мөн хувийн зан чанарын бүрэлдэхүүнд “мэдрэмжээр” холбогдсон нийтлэг эрхэмж, үнэ цэнт байдлыг болон → хэм хэмжээг өөрсдийн үйлдэлдээ дагаж мөрдөх байв (жишээ нь, дүрмээс гажууд үйлдэл хийвэл гэмших мэдрэмж төрдөг). Parsons-оос ялгаатай нь Harold Garfinkel («*Studies in the Routine Grounds of Everyday Activities*», in: H. G., *Studies in Ethnomethodology*, 1967) дэг журмын асуудлыг шийдвэрлэхийн тулд үйлдэл, ойлголтыг удирдан

чиглүүлдэг суурь хүлээлт хэлбэртэй үйлдлийн мэдрэхүйн нийтлэг утга учир, ач холбогдлыг онцлон тэмдэглэжээ. Энэхүү утга учрын хүчин төгөлдөр байдал нь нэг талаас оролцогчдын өдөр тутмын → харилцан үйлчлэлд хэвшил болж нэвтэрсэн байх, нөгөө талаас, тэд тухайн нөхцөл байдлаас хамаарч байнга дахин тайлбарлах шаардлагад хүрдэг. Нийгмийн дэг журмыг тайлбарлах, тусгах хууль дүрмийг онцлон тэмдэглэснээр Garfinkel нийгмийн дэг журмыг зөвхөн тогтвортой, дотоод эрхэмжит зүйлс, хэм хэмжээний үндсэн дээр баталгаажуулах боломжтой гэсэн Parsons-ын сургаалтай зөрчилдөж байсан.

(2) Parsons-оос ялгаатай нь → рационал сонголтын онолын хатуу хувилбарууд нь Weber-ийн рационал зорилгын үзэл баримтлалыг ерөнхийлөн үйлдэл бүрийг удирдан ухамсартайгаар чиглүүлэх хэлбэр гэж үзсэн. Jürgen Habermas (*Theorie des kommunikativen Handelns*, 2 Bde., 1981) түүний хувьд чухал зүйл болох харилцах үйл ажиллагааны төрлөөс үйлдлийг дахин олж харсан (→ харилцаа холбоо) бөгөөд үйлдлийн рационал байдлыг бууруулах боломж зөвхөн монологийн хувьд тооцоолсон зорилгын рационал байдалд байх боломжтой гэдгийг үгүйсгэсэн юм. Үүний оронд, тэрээр баримт нотолгоогоор хүчин төгөлдөр байдлын шаардлагыг хангах харилцан ярианы рационал байдлын тухай үзэл баримтлалыг гаргаж ирсэн. Харилцааны үйлдлийн чиг баримжаатай үед рационал зорилгын арга хэрэгслийн сонголт үүний дагуу ертөнцийн болон эрхэмжит зүйлс, хэм хэмжээний талаарх таамаглалуудыг баримт

нотолгоогоор зөвтгөх боломжтой гэсэн таамаг дээр суурилдаг бөгөөд үүнийг Habermas Parsons-той хамт таамаглагдаж байсанчлан-оролцогч сонголтын шалгуур болгон тодорхой зорилгод хүрэх арга хэрэгслийг сонгох шийдвэрийн үндэс болдог.

(3) Үйлдлийн утга учир, агуулгыг ойлгох дүрмийн асуудал нь Alfred Schütz, George Herbert Mead нарын хийсэн дүн шинжилгээний болон этнометодологийн ярилцлагын дүн шинжилгээний цөмд байдаг. Schütz («Die soziale Welt und die Theorie der sozialen Handlung», in: A. S., *Gesammelte Aufsätze*, Bd. 2, 1972; → Phänomenologische Soziologie)-ийн хувьд аливаа үйлдлийн субьектив утга санаа оролцогчийн “юуны тулд”, “яагаад гэвэл”-гэх сэдлийн системтэй холбогдох бүх холболтоос бүрэлддэг бөгөөд эдгээр нь зөвхөн оролцогчийн сэтгэл зүйн өөрийн туршлагад бүрэн хүртээмжтэй байдаг. Эндээс аливаа нэг үйлдлийн субьектив утга ямар арга замаар интерсубьектив хуваалцсан утга болж болох вэ гэдэг асуудал урган гарна (→ интерсубьектив байдал). Үүнд Schütz-ийн өгсөн хариулт бол аливаа үйлдлийн субьектив бүрэн утгатай адилтган хэмжсэн бүх ойлголт сулруулсан ойлголт байдаг. Учир нь бусад хүмүүс зөвхөн утга хялбаршуулсан схемийн тусламжтайгаар (төрөлжүүлэлт) аливаа үйлдлийн утгыг хүлээн авдаг. Mead (*Mind, Self, and Society*, 1934, dt. 1968) иймэрхүү утгын схемийг хэрхэн нийгэмд бий болгож, хувь хүмүүст хүртээлтэй байлгах вэ гэдгийг судалж үзсэн. Түүний харилцан үйлчлэлийн онол (→ символик интеракционизм) нь нэг оролцогчийн зан

харилцаагаар өдөөгдсөн энэхүү зан харилцааг нөгөө оролцогчийн хариу үйлдлээр тодорхойлох тайлбар гэж хүлээн авч болох юм гэсэн санаанд суурилдаг. Ингэхдээ янз бүрийн → нийгмийн болон өөр өөр нийгэмд нийгэмшсэн хувь хүмүүсийн хоорондох хариу үйлдлийн хэв маяг, цаашлаад харилцан үйлчлэлээр бий болсон утгын хуваарилалт нь ихэнхдээ нэг нэгнээсээ ялгаатай байдаг. Үүний цаана сүүлийн үеийн хэлэлцүүлгүүдэд утгын хуваарилалтыг зохицуулах асуудал анхаарлын төвд орж байна. Schütz, Garfinkel нарыг залгуулаад гарч ирсэн этнометодологийн харилцан ярианы анализ (→ этнометодологи) нь энэ асуудлыг харилцан үйлчлэлийн явцад тасралтгүй шийдвэрлэж байх ёстой гэж үзсэн (John Heritage, *Garfinkel and Ethnomethodology*, 1984). Этнометодологийн харилцан ярианы анализын дагуу харьцааны бүх хариу үйлдэл өмнө хэлэгдсэн зүйл дээр тодорхой нэг утгыг хуваарилсан байдаг. Энэхүү хариу үйлдлийг дагаад дараагийн хэлэх зүйлд (өөрөөр хэлбэл, гурав дахь дарааллын байр суурь) тухайн хариу үйлдэлд орсон утгын хуваарилалт нэг бол илт засагдаж эсвэл харилцан үйлчлэл саадгүй үргэлжлүүлэх явцад далд хэлбэрээр баталгааждаг. Нэг талаас, субъектив зорилготой утга ба нөгөө талаас, гаднаас нь тодорхойлсон утгын хооронд харилцааны тасралтгүй харьцуулалт хийх замаар субъектүүд хоорондоо санал нийцтэйгээр тайлбарлах үйлдлийг бий болгож болох юм. Энэ утгаараа үйлдэл нь Weber-ийхтэй адил нийгмийн анхан шатны нэгж байхаа больсон, харин харилцааны ойлголцлын бүтээгдэхүүн

гэж харагдах болсон. Орчин үеийн нийгэмд чухал ач холбогдолтой болж буй олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (→ хэвлэл мэдээллийн хэрэгслээр) дамжуулагдах харилцаа холбоо бол субъект хоорондын санал нийцтэйгээр тодорхойлогдсон үйлдлийн аливаа нэг харилцан үйлчлэлийн ойлголцолгүйгээр хол замыг туулдаг (зохиогчдын хувьд мэдээлэлд үзүүлэх ихэнх хариу үйлдлүүдийг ажиглах боломжгүй өөрөөр хэлбэл, залруулах боломж байхгүйгээс болдог). Тиймээс Niklas Luhmanns (*Soziale Systeme*, 1984; → System)-ын системийн онолд бусдын харилцааны хариу үйлдлээр гаднаас нь тодорхойлсон утгыг аливаа үйлдлийн нийгмийн утга хэмээн онцолсон байна.

Wolfgang Ludwig Schneider

Bernhard Miebach: Soziologische Handlungstheorie. Op-laden 1991, ²2006.

Thomas Luckmann: Theorie des sozialen Handelns. Berlin / New York 1992.

Hartmut Esser: Soziologie. Spezielle Grundlagen. Bd. 1: Situationslogik und Handeln. Frankfurt a. M. / New York 1999.

Wolfgang Ludwig Schneider: Grundlagen der soziologischen Theorie. Bd. 1 und 2. Wiesbaden 2002, ²2005.

Richard Münch: Soziologische Theorie 2: Handlungstheorie. Frankfurt a. M. / New York 2003. Studienausg. 2004.

Үүрэг (Rolle)

“Үүрэг” (англиар *part, role*; францаар *personnage, rôle*) гэж ерөнхийдөө → хувь хүнээс хүлээсэн зан харилцааг илэрхийлдэг. Социологид “үүрэг” гэдгийг нийгэмд байр суурь буюу статус (→ анги) эзэлдэг нийгмийн → оролцогчид руу чиглэгдсэн, хувь хүнд эсвэл нийгмийн → бүлэгт бий болгосон багц хүлээлт гэж ойлгодог. Эдгээр хүлээлт нь үүрэг гүйцэтгэгчийн тодорхой нэг зан харилцаа эсвэл шинж чанартай холбоотой байж болно. Үүргийн биелэлт эсвэл үл биелэлт ихэвчлэн эерэг болоод сөрөг хориг арга хэмжээг бий болгодог. Энэ нь тухайн хувь хүнд тодорхой үүргийг хариуцуулсан (жишээ нь, → хүйс ба насны үүрэг, хөндлөнгийн хүний үүрэг) эсвэл сайн дураараа хийж байгаа (жишээ нь, холбооны гишүүн) эсэхээс үл хамаардаг.

Антикийн үеэс (Epiktet, Cicero, Plotin) театрын зүйрлэл болгон ихэвчлэн “баг” (латинаар *persona*), “хүн”, “дүр” гэсэн үгнүүдтэй ойролцоо утгаар ашиглагдаж байсан үүрэг гэдэг энэ нэр томъёог George Herbert Mead, Ralph Linton нар → социологи ба → нийгмийн сэтгэл зүйд нэвтрүүлсэн байдаг. Linton энэ ухагдахууныг бүтцийн функционализмын (→ функционализм) хүрээнд “статусын хөдөлгөөнт тал”-ыг тодорхойлоход ашиглаж («Role and Status», in: R. L., *Readings in Social Psychology*, 1947, dt. 1967), харин Talcott Parsons загвар хувьсагчийн үзэл баримтлалдаа цааш нь дэлгэрүүлсэн байна. Linton-ы дараа Robert K. Merton (*Social Theory and Social Structure*, 1949, dt. 1995) статус бүрд цор ганц

хүлээлт оногдуулалгүй хүлээлтийн бөөгнөрөл болсон “багц үүрэг” (Role Set)-ийг хуваарилснаар үүргийн зөрчилдөөний асуудлыг анхаарлын төвд авчирсан юм. Эндээс зөрчилтэй хүлээлтийг цор ганц байршилд тавьсан байдаг үүрэг доторх зөрчилдөөн (жишээ нь, эмч бол өвчтөн болон эрүүл мэндийн даатгалын компанийн дунд зогсож байдаг) ба зөрчилтэй (өөр хоорондоо зөрчилддөг) байршлуудад хүлээлт бий болгосон үүрэг хоорондын зөрчилдөөн (жишээ нь, ажилдаа бүхнийг зориулж байгаа ажилтан болон гэр бүлдээ цаг гаргадаг эцэг/эхийн аль алинд нь ижил хүлээлт үүсдэг) гэж ялгаж үзэж болно. Үүнтэй холбогдуулан Merton хувь хүн нийгэмд бусдаас хамааралтай, бусдаар тодорхойлуулж байдгийг харгалзан шийдвэр гаргах, үйлдэл хийх эрх чөлөөний талаарх гол асуудлыг хөндсөн байдаг (→ эрх чөлөө).

Mead-ын үүрэг хүлээх ба үүрэг гүйцэтгэх хоёрыг ялгадаг арга хандлага (*Mind, Self and Society*, 1934, dt. 1975) нь үүргийн зан үйлийг → бэлгэдлийн харилцан үйлчлэл гэж ойлгодог болох ажлыг идэвхжүүлсэн юм. Тиймээс театр дахь дүрийн тухай ойлголтын гарал үүслийг эргэн хараад Erving Goffman (*The Presentation of Self in Everyday Life*, 1959, dt. 1969) гаднаас ирэх эсвэл дотоод хүлээлтийг зүгээр л биелүүлэх үүрэгтэй хувь хүний багасгасан хувилбарыг санал болгосон: Ингэхдээ Goffman дүрд тоглохыг тоглоом гэж хүлээн авснаар дүр бүтээгч, тоглогчийн хувьд хувь хүнд өөрт нь дүрээ бүтээх (үүрэг гүйцэтгэх) эрх чөлөөг олгож, тухайн “дүрээс зайгаа авдаг”. Ялангуяа ижилсэх хандлага,

нийгэмшил зэрэгтэй холбоотой социологийн ажлын гол түлхэц нь энэхүү харилцан үйлчлэлт үүргийн онолоос үүдэн гардаг.

Ralf Dahrendorf 1959 онд *Homo Sociologicus* бүтээлээрээ үүргийн онолыг АНУ-аас Герман хэлтэй орнуудад нэвтрүүлсэн бөгөөд улмаар үүргийн онолын хоёр хандлагын хоорондох зуучлагчийн байр суурьтай болсон. Dahrendorf “ёстой”, “хэрэгтэй”, “чадах” гэсэн хүлээлтүүдийг хооронд нь ялган авч үзээд, тэдгээрийн биелэлт эсвэл үл биелэлт нь янз бүрийн үр дагаварт хүргэдэг болохыг харуулжээ. Тэрээр Immanuel Kant болон Robert Musil (*Der Mann ohne Eigenschaften*, 2 Tle., 1930/32) нарт үндэслэн үүрэг хариуцлагад суурилсан цогц шийдвэртэй холбоотойгоор чөлөөтэй байх боломжийг олгодог хувь хүний практик үндэслэлийг онцлон тэмдэглэсэн байна. Үүргийн онолыг 1970-аад онд ихэвчлэн нээлттэй нийгмийн бүтэц дэх нийгмийн өсөлт, уналтын үеийн үүргийн зөрчлийг тайлбарлахад ашигладаг байсан. Хэдийгээр энэ одоо нөлөөтэй хэвээр байгаа боловч социологийн мэргэжлийн хэлэлцүүлэгт ховорхон яригддаг болжээ. Харин системийн онол (→ систем) зэрэг өнөө үед илүү хүчтэй хэрэгжиж буй хандлага нь үүргийн онолын бүтцийн-функционалист урсгалаас, ялангуяа “хүн” гэсэн концептоос чухал түлхэц авдаг.

Stefan Jordan

Heinrich Popitz: *Der Begriff der sozialen Rolle als Element der soziologischen Theorie*. Tübingen 1975.

- Günter Wiswede: Rollentheorie. Stuttgart [u. a.] 1977.
- Gottfried Eisermann: Rolle und Maske. Tübingen 1991.
- Ralf Konersmann / Thomas Sachsse: Rolle. In: Joachim Ritter / Karlfried Gründer (Hrsg.): Historisches Wörterbuch der Philosophie. Bd. 8. Basel 1992. Sp. 1064–70.
- Helmut Geller: Position. Rolle. Situation. Zur Aktualisierung soziologischer Analyseinstrumente. Opladen 1994.

Үхэл (Tod)

“Үхэл” гэдгийг ерөнхийдөө бидний соёлд жам ёсны байдлаар, хүчирхийллээр эсвэл өөрийн сайн дурыг үндэслэл болгож бие махбодын төгсгөл болохыг нэрлэдэг. Гэхдээ бүх соёлд биологийн ухагдахуунаар авч үздэггүй. Үхэл гэдэг нь энд амьдралын төгсгөл гэж ойлгогддоггүй, харин хүмүүний шилжих хөдөлгөөн эсвэл түүний сүнс аль нэг шинэ орших хэлбэрт шилжих хэлбэр гэж үздэг. Үхэл гэдэг нь цэвэр био-физиологийн үзэгдлийг илэрхийлж байгаа юм биш, харин үргэлж нийгэм, соёлын → дискурсууд, зан үйлүүд, практик туршлага болон утга илэрхийлэх загварчлалтай нягт уялдсан байдаг. Émile Durkheim (*Le suicide. Étude de sociologie*, 1897, dt. 1973) болон түүний сурагч Schüler Robert Hertz нар үхэл гэдгийг нийгмийн бодит үзэгдэл хэмээн тодорхойлсон. Hertz («Contribution à une étude sur la représentation collective de la mort», in: *Année sociologique* 10, 1907, dt. in: R. H., *Das Sakrale, die Sünder*

und der Tod, hrsg. von Stephan Moebius und Christian Papilloud, 2007) хоёр дахь оршуулгын → зан үйлийн талаарх угсаатны тайланг үндэслэл болгож, үхлийн тухай коллектив төсөөлөлтэй салшгүй холбоотой ойлголт хэмээн үзэж, сүнс, цогцсын төлөв байдал болон үлдсэн хүмүүсийн зан үйл буюу үхлийн гашуудалтай үлдсэн хүмүүсийн → нийгэм дэх байдлыг тодруулсан. Үхэл гэдгийг энэ харах өнцгөөс авч үзвэл нийгэм, соёлоор тодорхойлогддог. Коллектив (үхлийн тухай) төсөөллүүд нь өөрөө био-физик үхлээс нөлөөлөлтэй байна (Marcel Mauss, *Effet physique chez l'individu de l'idée de mort suggérée par la collectivité*, 1926, dt. 1989).

1960 он хүртэл социологичид үхлийн тухай бага судалсан байдаг. Энэхүү бодит нөхцөл нь хувь хүний хөгжлийн үйл явцын (→ орчин үе) орчин үеийн шинж тэмдэг бөгөөд үхлийн тухай асуудлаас зайлсхийсэн, сэдвийг хэлэлцэхгүй орхисныг дагалдсан асуудал хэмээн үнэлсэн байдаг. Энэ цаана нь байгаа шалтгаан болон түүнд чиглэсэн шүүмжлэлийн улмаас Werner Fuchs, Alois Hahn болон Klaus Feldmann нар нийгэм, соёлын шинжлэх ухааны асуудлаар өдөөгдсөн үхлийн тухай хэлэлцүүлгийг өрнүүлсэн. Philippe Ariès (*L'homme devant la mort*, dt. 1980) und – in postmoderner Perspektive – Jean Baudrillard (*L'échange symbolique et la mort*, 1980, dt. 1982) нар нь үхлийн тухай болон түүнийг хэлэлцэхгүй орхидог олон төрлийн хэлбэр байдаг гэж үзсэн. Тухайлбал, *Conditio humana* буюу хүмүүний амьдрах нөхцөлийн нэг хэсгээс амьд үлдэх шаардлагаас үүдэн хүлээн зөвшөөрсөн үхлийг үгүйсгэх эсвэл олон

нийтийн хүрээнээс үхлийг зайлуулах, мэргэжлийн байгууллага болон утга агуулгын дагуу үхлийг ялгаатай авч үзэх зэрэг хэлбэрийг үзүүлсэн. Үхлийг үгүйсгэхийн эсрэг таамаглалын тухай хэдэн жилийн өмнөөс олон нийтийн үхлийн тухай мэтгэлцээнүүд ажиглагдахуйц эрчтэй яригдаж эхэлсэн. Энэхүү мэтгэлцээнүүд нь Elisabeth Kübler-Ross und der Psychologin Verena Kast нарын үхлийг судалдаг судлаачдын ажлаар, үхэлтэй хамааралтай хөдөлгөөнүүд болон институцчилэгдэх үйл явцын өрнөлөөр (тухайлбал, сүмийн орогнох байр, хүнд өвчтөнийг хүлээх авах эрчимт тасаг, ДОХ-ийн хөдөлгөөн), мөн түүнчлэн нийт хүм амын хүрээнд ахмад настны эзлэх хувийн өсөлт зэрэг асуудлаар өдөөгдсөн байна. Сүүлийн үеийн социологийн судалгааны үр дүнгээр дискурсив болон дискурсив биш байдлаар практик туршлага нэмэгдэж, “үхлийн тухай ухамсарт ойлголт”-ын өөрчлөгдөх хандлага ихсэх тусам, тухайлбал, үхлийг ялгаатай байдлаар болон зохион байгуулалтад орсон хүний “сэтгэл зүйчлэл”, субъектив дотоод ертөнцийн дахин нэгтгэл зэргээр тайлбарлаж (Hubert Knoblauch / Arnold Zingerle, *Thanatosozologie. Tod, Hospiz und die Institutionalisierung des Sterbens*, 2005), хэлэлцүүлгийн төвд “бусад үхлийн тухай туршлага” субъект хооронд (Paul Ludwig Landsberg, *Die Erfahrung des Todes*, 1935; Stephan Moebius) социологи, антропологи, философийн сэдвийн холболтын цэг гэж үзэхийн зэрэгцээ мөн мэтгэлцээнээр дамжуулан олон нийтийн санаа бодолд таниулахыг зорьсон. Үхлийн тухай дахин сэргэсэн ялгаатай үйл явц нь рационал

сэтгэхүйд, ангаах ухааны эмчилгээнд болон бюрократ зохион байгуулалт бэхэжсэн байгууллагад болон “үхлээр мэргэшсэн” мэргэжилтнүүдэд нөлөөлсөн (эмч нар, сувилагч нар, оршуулгыг ажлыг зохион байгуулагч нар, оршуулгын газрын манаач нар, ламтан нар гэх мэт). “Үхлийн” тухай сэдвээр судалгааны ажлын тоо нэмэгдэх тусам “үхэх”, “гуниглах”, “оршуулах” хүрээнд Marcel Mauss-ны (in: *L'Année sociologique* 5, 1900/01) тавьсан шаардлага биеллээ олж байх шиг байна. Энэ нь социологийн “үхлийг” судлах нэгж (грекээр *thanatos* буюу үхэл) нь социологийн бие даасан судалгааны нэг талбар болтлоо хөгжсөн.

Stephan Moebius

Armin Nassehi / Georg Weber: Tod, Modernität und Gesellschaft. Entwurf einer Theorie der Todesverdrängung. Opladen 1989.

Julia буюу Schäfer: Tod und Trauerrituale in der modernen Gesellschaft. Perspektiven einer alternativen Trauerkultur. Stuttgart 2002.

Klaus Feldmann: Tod und Gesellschaft. Sozialwissenschaftliche Thanatologie im Überblick. Wiesbaden 2004.

Hubert Knoblauch / Arnold Zingerle: Thanatosoziologie. Tod, Hospiz und die Institutionalisierung des Sterbens. Berlin 2005.

Феноменологийн социологи (Phänomenologische Soziologie)

“Феноменологи” (Грекээр *phainomenon* = ‘үзэгдэл’) нь хувь хүний ухамсрын туршлагад анализ хийхэд чиглэсэн Edmund Husserl-ийн бүтээлд суурилсан философийн нэгэн чиглэл юм. Феноменологийн социологи нь хүмүүсийн туршлагыг хуваалцах замаар тэдний нийгмийн → үйлдлийг зайлшгүй ойлгох эхлэлийн цэг хэмээн үзэж анализ хийдэг. Социологи нь Max Weber-ийн (*Wirtschaft und Gesellschaft. Grundriß der verstehenden Soziologie*, 1922; → ойлгох) “ойлголтын шинжлэх ухаан” гэсэн утгаараа хүний үйлдлийг зүгээр нэг ажиглах ёсгүй, харин үйлдлийг тайлбарлах чадвартай байхын тулд түүний → утгыг ойлгох ёстой. Үүнтэй зэрэгцэн Husserl-ийн араас Alfred Schütz үйлдлүүдийн утга учрыг ойлгохын тулд феноменологийг ашиглахыг санал болгосон (*Der sinnhafte Aufbau der sozialen Welt*, 1932). Феноменологийн социологи нь ертөнцийг мэдэрч буй субъектийн үүднээс хатуу дүрслэхийг эрмэлздэг. Ингэхдээ тэрээр нэгэн эрин үед (грекээр = ‘зогсоох’) үргэлжилдэг: Туршлагатай зүйлс нь юу гэсэн үг болохыг (жишээлбэл, байгаа юмсыг ‘бодит’ гэж үздэг), улмаар энэ утгын хүчин төгөлдөр байдал хэрхэн бий болсныг тодруулах гэж тэд зууралддаг. Schütz-ийн хэлж байсанчлан феноменологийг нийгмийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийхэд ашиглах боломжтой. Үйлдэл хийх гэдэг дор тэр ирээдүйд чиглэсэн зорилгын төсөөллийг агуулсан

туршлагыг ойлгож байв. Schütz-ийн хүчин чармайлт нь нийгэмд, өөрөөр хэлбэл аль нэг бусад оролцогчдод чиглэсэн үйл ажиллагааг ашиглах боломжтой болгоход феноменологийн анализыг ашиглах явдал юм. Бусад эсвэл хоёр дахь би (латинаар = »өөр би«) нь эхнээсээ ухамсарт төлөвт суурилдаггүй, гэхдээ ухамсрын хувьд онцгой шинж чанарыг тодорхойлдог туршлагад тулгуурласан зүйлсийг илэрхийлдэг. Хоёр дахь би нь түүний биед “над шиг” гэж ойлгогдох бөгөөд үүнтэй зэрэгцэн түүнд ухамсарт төлөв байдаг гэж үздэг.

Энэ нь хүний өөрийн ухамсар бие даасан байдалд нэгэн төрлийн сэтгэцийн хэтийн төлөвийг хэрэгжүүлэх замаар өөр нэгэнтэй шууд харилцаа тогтоодог гэсэн үг юм: Бид нөгөө хүнийхээ үзэл бодлыг, тэр ч бүү хэл тэдгээрийн сэдлийг үйлдэх замаар (таамаглах) урьдчилан хүлээж авдаг. Оролцож буй хүмүүс нийтлэг туршлагатай байх явдал нь нийгэмшилд, улмаар нийгмийн үйл ажиллагааны өөр нэг урьдчилсан нөхцөл юм: Бидний амьдралын ертөнцийг он цагийн дарааллаар өмнөх болон хойч үеийн, орон зайн хувьд шууд нэвтрэх, шууд бус нэвтрэх, нэвтрэх боломжгүй бүсүүдэд хуваадаг; үүн дотор бидэнтэй хамт ажилладаг элэг нэгт хүмүүстэй зэрэгцэн үргэлж өвөг дээдэс, хойч үеийнхний хамт гарч ирдэг. Амьдралын ертөнц нь зүүд, төсөөлөл, шашны туршлага гэх мэт зүйлсийг агуулдаг. Эдгээр мэдрэх төрөл, хэлбэрүүд нь өөрсдийн »туршлагын хэв маягийг« хөгжүүлж, улмаар өөрсдийн »утгын орон зай« болж чадна. Ийм байдлаар тэд "зонхилох бодит байдлыг" илэрхийлдэг өдөр тутмын

амьдралын ертөнцөөс ялгаатай. Учир нь → хүрээлэн буй орчны нөлөөлөл нь бусдад нөлөөлдөг бөгөөд энд бид бусадтай бас харилцдаг.

Феноменологийн социологийн хоёр ойлголтыг нэг нэгнээс нь ялгаж болно: Илүү философийн чиг баримжаатай үзэл баримтлал (Max Scheler, George Psathas, Richard Grathoff) нь нийгмийн үйл ажиллагааны дараалал болон нийгмийн →бодит байдлын ихээхэн хэмжээг феноменологийн анализаар тодруулж болно гэж үздэг. Энэхүү үзэл баримтлал нь үйл ажиллагааг ерөнхий бүтцээр нь ойлгох чадвартай байхын тулд илүү хүчтэй социологи, туршлагатай шинжлэх ухааны арга зүйг (von Alfred Schütz, Peter L. Berger, Thomas Luckmann, Ilja Srubar, Hubert Knoblauch) урьдчилсан нөхцөл болгодог бөгөөд нийгмийн үйл ажиллагааны бүтэц, нийгмийн ертөнцийн дэг журмыг хувь хүний ухамсрын үр дүн биш, харин "нийгмийн конструкц"-ийн үр дүн гэж үздэг. Нийгмийн үйл ажиллагааны харилцан үйлчлэл нь өөрийн гэсэн об'ектив байдлыг бий болгодог бөгөөд энэ нь → институци, → харилцааны хэлбэрээр илэрдэг. Ийм учраас Thomas Luckmann (*Lebenswelt und Gesellschaft*, 1980) зөвхөн “феноменологийн чиг баримжаатай социологи”-ийн тухай ярьдаг. Энэ хоёр чиглэлийн нийтлэг зүйл бол тодорхой субъектийн баримжаа (→ субъект) бөгөөд энэ нь сүүлийн үеийн эмпирик судалгаанд (→ эмпиризм) хэрэглэгдэж байна. Феноменологийн социологийн сүүлийн үеийн чиг хандлага нь оролцогчдын субъектив чиг хандлагыг эмпирик, ихэвчлэн чанарын нийгмийн судалгааны

сэдэв болгож байгаагаараа онцлог юм. Нийтлэг байдлаар хүчтэй нөлөөлсөн → этнологийн арга зүй, → символик интеракционизм нь феноменологийн социологийн хувьд → нийгмийн тайлбарлах онолын цөм болж байна.

Hubert Knoblauch

Alfred Schütz / Thomas Luckmann: Strukturen der Lebenswelt. 2 Bde. Frankfurt a. M. 1979/84, Nachdr. Konstanz 2003.

Walter L. Bühl: Phänomenologische Soziologie. Ein kritischer Überblick. Konstanz 2002.

Max van Maanen (Hrsg.): Writing in the Dark. Phenomenological Studies in Interpretive Inquiry. London 2002, Nachdr. 2005.

Функционализм (Funktionalismus)

“Функционализм” нь → нийгэм, антропологийн хүрээнд онолын болон арга зүйн хэлэлцүүлгийг эхнээс нь дагалдаж явсан сэтгэлгээний хэлбэр юм. Энэхүү үзэл санааны анхны системтэй хэрэглээг бий болгосон хүмүүс бол Auguste Comte (*Cours de philosophie positive*, 6 Bde., 1830–42, dt. 1883/84) болон Herbert Spencer (*The Principles of Sociology*, 1874, dt. 1877) нар юм. Тэд нийгмийг биологитой адилтган үзэхдээ тус бүрдээ тодорхой үүрэг гүйцэтгэдэг эд эрхтнүүдээс бүрдэх

өсөж, хөгжиж буй организм гэж ойлгож байв. Эдгээр анхдагчдыг Émile Durkheim (*Les règles de la méthode sociologique*, 1895, dt. 1961) шүүмжлээд, социологийн функционализмын чухал үндсийг тавьсан байдаг. Түүний санаагаар бол, функционализм нь нийгмийн үзэгдлийн хамтач шинж чанараас үүдэлтэй бөгөөд үзэгдлийн тодорхой дарааллыг түүний элементүүдийн функциональ хамтарсан тоглолт хэмээн тайлахыг эрмэлзэж байв. “Функц” гэдэг бол нэг хэсгийн аливаа зүйлийг бүхлээрээ тодорхой → орчинд үргэлжлэн оршин тогтнох, цаашид хөгжихөд нь үзүүлж байгаа хувь нэмэр гэж ойлгож болох бөгөөд харин дисфункц нь дээрхэд заналхийлж буй аюул юм. Функционализмын үндсэн таамаглалуудын нэг бол аливаа нэг элемент (жишээлбэл, моногами гэрлэлт, автократ удирдлага, капиталист зах зээл) өөрөө функциональ эсвэл дисфункциональ байдаггүй, учир нь түүний оруулж байгаа хувь нэмрийнх нь чанар ерөнхий дарааллаас, түүний бие даасан хэсгүүдээс, хүрээлэн буй орчноос энэ хамаардаг. Энэ утгаараа гэмт хэрэг ч тодорхой нөхцөл байдалд функциональ чанартай байж болох талаар Durkheim аль эрт баталж байжээ. Үүний нэгэн адилаар функционализм нь функциональ эквивалентуудыг байдаг гэж үздэг, учир нь бүтцийн хувьд ялгаатай ч ерөнхий дараалалд үргэлж функциональ үүргийг адилхан гүйцэтгэж байдаг олон тооны элементүүд байж болно. Talcott Parsons (*Societies*, 1966, dt. 1975) *бүтцийн функционализмын* тусламжтайгаар орчин үеийн нийгмийн бүтцийг нийгмийн → системийн үндсэн үйл

ажиллагааны шаардлагуудтай онолын хувьд холбох өргөн хүрээний цогц бодлогыг боловсруулжээ. Энд дэвшүүлсэн гол таамаглал бол систем бүр тогтвортой байдлаа хангахын тулд зохицох (*adaption*), зорилгодоо хүрэх (*goal attainment*), интеграцийн (*integration*) болон бүтэц, үнэ цэний хэв маягаа хадгалах (*latent pattern maintenance*) гэсэн дөрвөн функцтэй байх ёстой гэж үзэн үүнийгээ Parsons AGIL-схем гэж нэрлэжээ. Parsons-ын хэлснээр, ялангуяа → орчин үе бол эдгээр чиг үүргүүдийг баталгаажуулж, улмаар тогтолцоог хадгалах боломжийг олгодог институцчилэгдсэн дэд системүүдийн (→ эдийн засаг, → улс төр, нийгэм дэх → нийгэмлэг, итгэмжлэгдсэн тогтолцоо) функциональ ялгаа (ялгарал)-аар тодорхойлогддог. Функционализмыг эмпирикээр туршихад хэцүү, *status quo* (одоогийн байгаа байдал)-г идеалчилдаг, зөрчилдөөн, нийгмийн өөрчлөлтийг үл тоомсорлодог гэж шүүмжилдэг. Сүүлийн үеийн социологийн функционализм эдгээр эсэргүүцэлд хариулт өгчээ. Жишээлбэл, Robert K. Merton (*Social Theory and Social Structure*, 1949, dt. 1995) нийгмийн элемент нь нийгэмд үргэлж функциональ, дисфункциональ нөлөө үзүүлж байдаг учраас комплекс, хоёрдмол нөлөөг олж тогтоох нь онцгой чухал гэж үзсэн. Jeffrey Alexander (*Neofunctionalism*, 1985) орчин үеийн нийгмийн функциональ → дэг журам нь зөрчилдөөн, хэлэлцээрийг үгүйсгэдэггүй, харин ч илүүтэй эндээс үүсэлтэй байдаг гэж үздэг. Niklas Luhmann (*Soziale Systeme*, 1984) функциональ дараалал нь зөвхөн зорилгод нийцсэн байх албагүй,

учир нь чиг үүрэгт хуваагдсан нийгэм өөрийн үр дагаврын асуудлуудтай (жишээ нь, зохицуулалтын эсвэл удирдлагын) тэмцэх шаардлагатай байдаг. Richard Münch (*Dialektik der Kommunikationsgesellschaft*, 1991) орчин үеийн нийгмүүд байнгын өөрчлөлттэй парадоксуудаар тодорхойлогддог гэж онцолжээ. Үүний үр дүнд сүүлийн үеийн парадокс, гаж буруу үзэгдэлд дэг журам ба аноми хоёрын хоорондох, дэг журам ба дэг журам бүрэлдэх буюу өөрчлөлтийн хоорондох харилцан үйлчлэлийн талаар илүү их яригдаж байна. Гэхдээ гол нь функционализм нь өөрийн гэсэн онолын тайлбарын хүчгүй гэж бас шүүмжлэгддэг. Иймээс хуучны функционализм нь аливаа үзэгдлийг түүний (функциональ эсвэл дисфункциональ) үр дагавар, үр нөлөөгөөр тайлбарлах хандлагатай байв. Ингэж тухайн элементийн чиг үүрэг түүний шалтгаан руу орж тайлбарлагддаг (“Функционалист байдлаар буруу дүгнэлт хийх”). Гэвч аливаа элемент зөвхөн ерөнхий бүтцэд шаардлагатай эсвэл ямар нэгэн хэрэгцээтэй учраас л байх ёстой юу? Нийгмийн үзэгдлүүд зөвхөн баталгаат байдлыг хангаж, зорилгод нийцэх учраас л тодорхой нэг чиглэлд хөгждөг үү? Өнөөдөр шийдлийн гурван хувилбарыг харуулахын тулд дан функционалист тайлбараас татгалзаж байна.

Нэгталаас, Durkheim-ын шаардаж байсан шиг, түүнийг цааш нь Münch үргэлжлүүлсээр байгаа функционалист тайлбарыг учир шалтгааны тайлбараар баяжуулах шаардлагатай тухай яригдаж байна. (2) Нөгөө талаас Alexander-ын неофункционализмд харагдаж байсан

шиг макро бүтцийн үзэгдлүүдийг тайлбарлахдаа → хэлэлцүүлэг, хэлэлцээр, зөрчилдөөнөөр дамжин микро түвшинд эргэн холбогдох нь улам ихсэж байна. (3) нарийн учир шалтгаан, үр дагаврын тайлбарыг өөрийгөө удирдах концепц бүхий цогц системээр сольсон. Учир нь системийн түгжээ хэсгүүдийнхээ харилцан үйлчлэлээр тайлагддаг бөгөөд энэхүү үзэл баримтлалаас үүдэн Parsons кибернетик рүү буцаж орсон ба Luhmann-ын *аутопоэзис*¹⁷-ын үзэл баримтлал гарч ирсэн.

Ерөнхийдөө функционализм нь уялдаатай, нэгдмэл онолын сургуулийг бий болгоогүй ч социологийн онол, арга зүйд урам зориг, санаа өгөх олон талт чухал эх сурвалж байсаар ирсэн гэдгийг харж болно.

Christian Lahusen

Heine Andersen / Lars Bo Kaspersen (Hrsg.): Classical and Modern Social Theory. Malden/Oxford 2000 [v. a. Kap. 14 und 15].

Paul Colomy (Hrsg.): Functionalist Sociology. Aldershot 1990.

Jens Jetzkowitz / Carsten Stark (Hrsg.): Soziologischer Funktionalismus. Zur Methodologie einer Theorietradition. Opladen 2003.

Hans-Jürgen Aretz: Funktionalismus und Neofunktionalismus. Eine Einführung. Wiesbaden 2007.

¹⁷ Аутопоэзис (эртний Грекийн αὐτός autos өөрийгөө болон ποιεῖν poiein 'бүтээх, бий болгох') нь систем өөрийгөө бүтээж, хадгалж, авч явах үйл явц юм.

Хабитус (Habitus)

“Хабитус” (латинаар “*биеэ авч яваа байдал*”, “*гадаад төрх*”, “*хандлага*”, “*зан үйл*”, “*үзэл бодол*”) гэдэг ойлголт нь аль эрт Max Weber, Émile Durkheim, Marcel Mauss болон Norbert Elias зэрэг зохиолчдын бүтээлээр социологид орсон байдаг. Тэд энэхүү ойлголтыг сэтгэхүй, үзэл баримтлал, соёл-бэлгэдлийн туршлага, эсвэл мөн хүний гадаад төрх байдлыг нийгмийн орчныг бүрдүүлэгч элемент болгон төсөөлөхөд ашигласан юм. Онолын чанд утгаар “хабитус”-ыг Pierre Bourdieu өөрийн → социологийн практикт гол үзэл баримтлалаа болгон нэвтрүүлсэн байдаг. Ингэхдээ тэрээр энэхүү ухагдахууны философийн уламжлалыг үргэлжлүүлсэн бөгөөд энэ нь Thomas von Aquin-аар дамжин Aristoteles-ийн *hexis*¹⁸ (*Thomas von Aquin үүнийг хабитус гэж орчуулсан*)-ийн тухай ойлголтод хүрдэг. Aristoteles дэлхий дээрх хүмүүс хийж буй зүйлээсээ шалтгаалаад практик → мэдлэгийг бүтээж байдгийг онцолжээ. Энэ мэдлэгийг бид зөвхөн бүтээгээд зогсохгүй бас үүнийг хувь хүмүүсийн олон үйл ажиллагаанаас ертөнцийг үзэх үзлээр дамжуулан төлөвшүүлэх замаар хадгалж авч үлддэг байна.

“Хабитус” гэдгийг Bourdieu → хувь хүний бүхий л үйлдлийг, түүний бүх чухалчилж хэлж ярьсан дадлага туршлагын мэдэгдлүүдийг хувийн шинж чанарын илрэл байдлаар харуулдаг зарчим гэж тодорхойлсон юм.

18 Сурсан “*дадал зуршил*”-аас эхлээд хувцас хунар, эд хөрөнгө гэх мэт, тухайн дүрсэлж буй объектын мөн чанарт хамаарахгүй, харин “*олж авсан*” бүх зүйлийг багтааж болох байнгын нөхцөл байдал: https://link.springer.com/chapter/10.1007/978-3-476-01379-8_25

Энэхүү “практик холбогч” нь хувь хүний доторх сэтгэн бодох чадвар, ертөнцийг үзэх үзэл, мэдрэхүй, шийдвэр гаргалтын болон үнэлгээний зарчим бүхий хэсгийг хариуцдаг гэж ойлгох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, эдгээр нь нийгэмд байдаг бэлгэдлийн зан заншилд (→ бэлгэ тэмдэг) хадгалагддаг. Нэгэнт хабитуст орсон бол ийм маягаар уламжлагдан, шингэсэн мэдрэхүйн болон ангиллын схемээр амьд организмтай адил, өөрөөр хэлбэл механик бус уян хатан логигоор ажилладаг. Хабитус бол бүтээлч байдаг. Тэр шинэ нөхцөл байдалд шинэ зан үйлийг бий болгох чадвартай. Түүнд зохион бүтээх урлагийн *ars inveniendi*¹⁹ чадвар байдаг. Гэхдээ хабитустай төрөөгүй тохиолдолд: Bourdieu-ийн хэлснээр, энэ бол хувь хүн өөрийнхөө ертөнцтэй тулгарах үед үүсэж бий болдог зүйл бөгөөд бага багаар хураагдсан туршлага байдлаар хувь хүний “эзэмшиж, өөрийн болгож, эргээд ийм байдлаар мартагддаг түүх” юм гэжээ (*Le sens pratique*, 1980, dt. 1987). Түүнийг бүтээсэн бүх өнгөрсөн зүйл одоо ч түүнд нөлөөлсөөр байдаг.

Нийгмийн → үүргийн конструкцийн нэгэн адил Bourdieus-ийн хабитусын тухай үзэл баримтлал нь хувь хүнийг нийгэмшсэн субъект гэж ухуулахыг зорьдог. Энэ нь гэхдээ нийгмийн үйл ажиллагааны тэс өөр ойлголтоос гарч ирсэн: Нийгмийн үүрэг, хэм хэмжээндээ сэтгэхээс үүдэлтэй хувь хүн ба нийгмийн хоорондын эсэргүүцлийг хабитусын үзэл баримтлалын тусламжтайгаар даван туулж болно. Bourdieus-ийн

19 Латинаар зохион бүтээх урлаг.

хабитусын үзэл баримтлал үүгээр социологид шинэ аналитик чиг баримжааг нээж өгсөн юм: Зөвхөн хабитусын тусламжтайгаар нийгмийн үйл ажиллагааны өвөрмөц бие махбодыг төдийгүй түүний оюун санааны хэсгийг анхаарч үзэх боломжтой (*La distinction. Critique sociale du jugement*, 1979, dt. 1982). Наад зах нь хабитус үргэлж нийгмийн контекст рүү тухайлбал, нийгмийн орчин, нийгмийн хүрээлэлд чиглэж байдаг нь учиртай. Bourdieu-ийн үзсэнээр, нийгмийг бодитоор харах хоёр хэлбэр байдаг: “нийгмийн бодит байдал нь аливаа юмс болон хүний тархинд, өргөн тал болон хабитуст, оролцогчийн дотор болон гадна талд гээд хоёр янзаар оршдог” (*Réponses. Pour une anthropologie réflexive*, 1996). Оролцогчийн хабитусын талаар түүний төрж өссөн, нөлөө үзүүлэх нийгмийн контекстийг нь харгалзахгүйгээр ярих аргагүй. Эцэст нь, хабитусаар дамжин орчин үед эрх мэдлийн нэг онцгой хэлбэр харагдах болж, Bourdieu үүнийг сүүлд эрэгтэйчүүдийн ноёрхлын тухай жишээнд тайлбарлаж байсан бөгөөд энэ нь хабитуст бэлгэдлийн дэг журмыг хадгалах замаар ирдэг бэлгэдлийн эрх мэдэл юм (*La domination masculine*, 1998, dt. 2006).

Beate Kraus

Gunter Gebauer: Die Konstruktion der Gesellschaft aus dem Geist? Searle versus Bourdieu. In: Kölner Zeitschrift für Soziologie und Sozialpsychologie 52 (2000). S. 428–449.

Irene Dölling: Habitus. In: Wolfgang Fritz Haug (Hrsg.): Historisch-kritisches Wörterbuch des Marxismus. Bd. 5. Berlin 2001. S. 1105–14.

Beate Kraus / Gunter Gebauer: Habitus. Bielefeld 2002.

Margareta Steinrücke (Hrsg.): Pierre Bourdieu. Politisches Forschen, Denken und Eingreifen. Hamburg 2004.

Хамтын нийгэмлэг (Gemeinschaft)

“Хамтын нийгэмлэг²⁰” (англиар *community*; францаар *communaute*; латинаар *communio*) гэдгийг ерөнхийд нь тодорхойлоход нийтлэг хэв шинж болон гадаад хамаарлаараа холбогдсон хувь хүмүүсийн хамтрал юм. Ярианы хэлний утга нь субъектив шинжтэй, үүний-хээ дагуу олон утгатай байх бөгөөд орчин үеийн өмнөх нийгмээс утопи нийгмийн → тогтолцоо хүртэлх, хүсэмжит байдлаас радикал байдал хүртэлхийг хамарна.

“Хамтын нийгэмлэг”-ийг Ferdinand Tönnies (*Gemeinschaft und Gesellschaft*, 1887) социологийн нэр томъёо болгон оруулж ирсэн нь нэг талаас харилцан нэгнийхээ үүрэг, шаардлагыг хүлээн зөвшөөрч биелүүлэх тодорхой нэгдлүүдийг зөвхөн гаднаасаа нэгдмэл мэт харагдах → масс болон → бүлгүүдээс ялгах зорилготой байсан. Нөгөө талаас Tönnies-ын хувьд хүмүүний хамтын оршихуйн талаар судалгааны анализ хийхийн тулд бүтээлчээр хөгжүүлсэн үндсэн ухагдахуун

20 Судлаач Я. Долгоржавын дэвшүүлсэн “хүй элгэн” гэсэн нэршлийг энд ашиглах боломжтой.

шаардлагатай болсон. Нийгмийн амьдралын бүхий л үзэгдлүүд, жишээлбэл, → гэр бүл, холбоод, ард түмэн, → төр, → шашин болон → шинжлэх ухаан зэргийг хоёр өөр энгийн нэр томьёо ашиглан илүү тохиромжтой хэлбэрээр “нийгэм” ба → “хамтын нийгэмлэг” гэж ангилж болно. Ингэхдээ Tönnies ялгаатай шатлал бүхий гэр бүл, ураг төрлийн болон таарч тохирдог хамаатан садны хүмүүсээс бүрдсэн *цусан төрлийн* “хамтын нийгэмлэг”, ойр амьдарч дассан хөршүүдийн нутгийн “хамтын нийгэмлэг”, оюун санаагаа хуваалцсан нөхөрлөл буюу оюуны “хамтын нийгэмлэг”, мөн түүнчлэн хамтын нийгэмлэгийн ноёрхогч дүрүүдийн ой санамжийг хөгжүүлсэн. Хамтын нийгэмлэг ба нийгмийн хэлбэрүүд нь нийгмийн бодит байдлаас шалтгаалсан хүсэл зоригийн үйлдлүүд дээр (зайлшгүй хүсэл ба сайн дурын хүсэл) тулгуурласан байх бөгөөд тэдний бодитой үйлдлүүд нь амьдралын ерөнхий нөхцөл байдалд олон янзын үйл ажиллагааны зохион байгуулалттай байдаг. Эдгээр ялгаатай нийгмийн харилцаанууд нэгэн зэрэг, зэрэгцэн эсвэл хамтдаа гээд янз бүрийн холимог хэлбэрээр оршин байдаг. Тиймээс бодит байдал дээр гэрлэлт бол гэрээний шинж чанартай байж болох бөгөөд холбоод мөн гэр бүлийн шинжтэй байж болох юм.

Нэг талаас Веймарын Бүгд Найрамдах Улс²¹-аас хойш хамтын нийгэмлэгийг социологийн судалгааны үндсэн судлагдахуун гэж үзэх болсон бөгөөд Tönnies-өөс илт

21 Германд анх удаа парламентын ардчилал бий болсон, 1918 оноос 1933 он хүртэл үргэлжилсэн үеийг нэрлэдэг.

эсрэг байр суурьтай “хамтын нийгэмлэгийн социологи” гэж гарч ирсэн. Нөгөө талаас, шинэчлэлийн онолчдын эсэргүүцэх хандлагад энэ нэр томьёо романтик, хоцрогдсон гэсэн шүүмжтэй байв. Үүний дараа “хамтын нийгэмлэг”-ийг Talcott Parsons (*The Social System*, 1951, dt. 1976), бүтцийн функционализм (→ функционализм)-аас соёлын хэв загвар (*pattern variables*)-ын концептоор дамжуулан “хамтын нийгэмлэгийн нийгэм”-ээс салгасан бөгөөд үндсэндээ хэрэглээгүй болсон. “Бүлэг” гэдэг нэр томьёо ч мөн 1970-аад оноос хойш хамтын нийгэмлэгийн үзэл санааг саармагжуулж, илүүц ангилал болж хувирсан.

Өсөн нэмэгдэж буй хувь хүчлэлийн хөгжилтэй холбоотой аноми ба интеграцийн асуудлаас болж ХХ зууны төгсгөл үеэс коммунитаризмын²² мэтгэлцээнээр дамжуулаад (Alasdair Mac Intyre, Michael Walzer и. а.), түүнчлэн Tönnies-ийн үзэл баримтлалыг жинхэнэ утгаар нь тайлбарлах хүчин чармайлтын нөлөөгөөр “хамтын нийгэмлэг” нь одоог хүртэл онолын зөвшилцөлд хүрээгүй ч гэсэн социологийн категорийн хувьд дахин чухал болоод байна.

Rolf Fechner

22 “Коммунитаризм бол нийгмийн амьдралын зохион байгуулалтын зүй зохистой хэлбэр нь иргэний ёс суртахууны эрхэмжит зүйл, гэр бүл, уламжлал, хамтач ёс, нийтийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдлыг эрхэмлэсэн зарчимд үндэслэсэн байвал зохих тухай асуудлыг гол болгож авч үздэг улс төрийн онолын чиглэл болно” Ж.Жаргал: Улс төрийн онолын тухай асуудалд, Цуврал өгүүллийн хоёрдугаар дэвтэр.

Lars Clausen / Carsten Schlüter (Hrsg.): Renaissance der Gemeinschaft? Stabile Theorie und neue Theoreme. Berlin 1990.

- (Hrsg.): Hundert Jahre Gemeinschaft und Gesellschaft. Ferdinand Tönnies in der internationalen Diskussion. Opladen 1991.

Peter-Ulrich Merz-Benz: Tiefsinn und Scharfsinn. Ferdinand Tönnies' begriffliche Konstruktion der Sozialwelt. Frankfurt a. M. 1995.

Stefan Breuer: »Gemeinschaft« in der »deutschen Soziologie«. In: Tönnies-Forum 1 (2003). S. 42–75.

Michael Opielka: Gemeinschaft in Gesellschaft. Soziologie nach Hegel und Parsons. Wiesbaden 2004.

Харилцаа (Kommunikation)

”Харилцаа” (латинаар *communicatio* = “мэдэгдэх”, “нийтлэг байдал”) -аар нийгмийн нийтлэг чанар бодит биеллээ олох үйл явцыг ерөнхийд нь тодорхойлдог. 1900-аад оны хэл-философийн өөрчлөлт, дараа нь *Linguistic Turn* (→ дискурс-хэлэлцүүлэг) болсноос хойш “харилцаа” нь нийгэмшлийн талаарх загварчлалын гол ухагдахуун болж, үйл ажиллагааны тухай ойлголтыг (→ үйлдэл) улам бүр нөхөж, орлож эхэлсэн. Анх Герман хэлээр ярьдаг улс орнуудад 1980-аад оноос хойш “харилцаа” нь социологийн онолыг хөгжүүлэх чухал ойлголт болсон. Үүнээс хойш хоорондоо бараг нийцэхээргүй ойлголтын хоёр хэв маяг явж ирсэн. Харилцаа нь нэг талаас

дамжуулалт, нөгөө талаас тэсрэлт гэж ойлгогддог.

Дамжуулалтын загваруудаар “харилцааны” болон → “хэвлэл мэдээллийн хэрэгсэл”, “мэдээлэл” зэрэг хоорондоо нягт холбоотой ойлголтуудыг → хувь хүмүүсийн хооронд (мэдээлэл түгээгч, хүлээн авагч санал хүсэлт өгөх боломжтой эсвэл боломжгүй) мэдээллүүд (утга санаа, → бэлгэ тэмдэг, мэдээлэл, харилцан ойлголцох санаатай) дамжуулах схемд оруулан загварчилдаг. “Харилцаа”-ны талаарх энэхүү ойлголтод тулгардаг бэрхшээлүүд нь юуны түрүүнд тухайн загварчлалын техникийн талаас шаардагдах хувь хүнд төвлөрсөн байдалтай холбоотой. Хэрэв хувь хүн бүр эмпирик утга төгөлдөр агуулгаараа хувийн онцлогтоо захирагддаг гэж үзвэл агуулгыг дамжуулах боломжгүй: хувь хүний радикал үзэл санааг бусад хүмүүс → ойлгож чадахгүй. Энэ асуудал нь ихэвчлэн мэдээлэл дамжуулах техникийн загварт тулгуурлан эртнээс үүссэн (*Claude E. Shannon / Warren Weaver, The Mathematical Theory of Communication*, 1949, dt. 1976), нэмээд хэлэхэд, тухайн илгээж байгаа хувь хүн нийгэмд илүү хамааралтай байдлаар (өөрөөр хэлбэл, хувь хүний хэрээс давсан) агуулгыг кодолдог бол хүлээн авагч кодыг мөн адил сөргүүлэн тайлж эсвэл тайлбарладаг. Энэхүү шийдлийн гажуудлуудыг Umberto Eco анхааруулж байв (*La struttura assente*, 1968, dt. 1972). Учир нь сайтар тунгаах аваас энэ нь хувь хүнийг төв байр сууринд хүргэх үүрэгтэй. Кодлох нь түүнийг тайлахтай мөн адил үргэлж хувь хүний хэр чинээнээс хэтэрсэн нийгмийн кодоор зохицуулагддаг, өөрөөр хэлбэл, хувь хүнээр биш. Үүгээр социологийн

онол үүсэх эхлэлийг тавьж байсантай ижил асуудал харилцааны талаарх ойлголт дээр ч давтагдаж байна. Эргээд л нийгмийг хэрхэн зүгээр хувь хүмүүсийн нийлбэр биш, харин “бие даасан бодит байдал” (Émile Durkheim, *Les règles de la méthode sociologique*, 1927, dt. 1961) болгож төлөвлөх боломжтой вэ гэдэг асуулт гарч ирнэ. Энэ асуултын хамгийн радикал хариултыг системийн онолын → конструктивизм (→ систем) өгдөг бөгөөд энэ нь харилцааг → нийгэмтэй (Niklas Luhmann, *Die Gesellschaft der Gesellschaft*, 1997) адилтгаж, системийн түвшинд тэсрэлт үүсгэх үе шат гэж тодорхойлдог.

Тэсрэлтийн загварууд нь харилцааг “бие даасан бодит байдал” гэж тодорхойлдог бөгөөд сэтгэл зүйн тогтолцооноос ялгаатай нь нийгмийн тогтолцоог өөрөө бүтээх, өөрөө зохион байгуулах, өөрөө хязгаарлах гэдэг ойлголтуудаар загварчилдаг. Энд Luhmann ялангуяа George Herbert Mead, Америкийн прагматизм, Talcott Parsons нарыг дагаж мөрдсөн. Үүнтэй төстэй аргумент бүхий үндэслэлийг ерөнхийдөө *Linguistic Turn* гэсэн түлхүүр үгэнд хураангуйлсан арга хандлагуудаас олж болно: Семиотик, семиологи, структурализм/→ Постструктурализм болон хэлний философи дахь тодорхой арга зүй. Эдгээр аргументуудын нийтлэг зүйл нь харилцаа бол хэзээ ч хувь хүний (“хувийн”) үйлдэл байх боломжгүй гэсэн энгийн санаа юм. “Хувийн хэл гэж байдаггүй”, хэрэв байсан бол түүгээр харилцах боломжгүй байх байсан, учир нь өөр хэн ч түүнийг нь ойлгож чадахгүй. Үүний зэрэгцээ харилцаа нь сэтгэл зүйн (“хувийн”) нөхцөл байдлыг буюу утга санааг

хувь хүмүүсийн хооронд дамжуулахад хэрэглэгдэх учиргүй. Харилцаа бол утгын сан дахь үргэлж нийтлэг, нийгмийн гэсэн, өөрөөр хэлбэл, хувь хүнээс хальж бүтсэн агуулгаар үйлчилдэг байх ёстой бөгөөд энэ нь оролцогчдын хувь хүний онцлогоос үл хамааран харилцааг харилцаагаар холбож өгдөг. Үүний дагуу, харилцаа холбоо, хэл яриагаараа бие даан, өөрөөр хэлбэл, хувь хүнээс үл хамааран холбоо тогтоох чадварт суурилсан харилцааны болон ихэвчлэн бас ярианы дугуй хэлбэрийн хэв шинжийг илүүд үздэг. Харилцаа ертөнцийн талаар юу илтгэдэг нь (энд харилцааны объектод хамаарах мэдээллийн чанартай зүйлийг авч үзнэ) үндсэндээ нийгмийг бүрдүүлж байгаагаар ажиглагдах бөгөөд ярианы үйлдлийн хувьд *эго* болон *нас* (би болон өөр хүн) хамаарах хоёр туйлын “хоорондох” тусдаа түвшин гэж ойлгогдоно.

Jürgen Habermas-ын *харилцах үйлдлийн онол* (*Theorie des kommunikativen Handelns*, 2 Bde., 1981) онцгой байр суурь эзэлдэг. Амьдралын нөхцөл (→ өдөр тутмын амьдрал) ба тогтолцооны хоорондох гол ялгааг дагаад дамжуулалтын төдийгүй тэсрэлтийн онолын аргумент бүхий үндэслэлүүд гарч ирдэг. “Амьдралын нөхцөл” нь ойлголцлын шаардлагаар (“харилцах үйлдэл”) санаатай бөгөөд ноёрхлоос ангид харилцан ярианы хэлбэрээр санал солилцох (дамжуулах) идеалаас бүрдэж байхад “ар хударгаар нь” харин ойлголцох зорилготой оролцогчдын үйлдлийн чиг баримжаанаас үл хамааран үйлдлийн үр дагаврын функциональ сүлжээнд суурилж, ярилцаад ойлголцох чиглэлийг нь мөнгө (→ эдийн засаг),

→ эрх мэдэл (төрийн хүнд суртал) гэх мэт мэдээллийн хэрэгслийн автомат үйлдлээр сольдог “систем” бий болдог;

“Харилцааны социологи” нь нэг талаас харилцааны дамжуулах загварт, ялангуяа олон нийтийн харилцаа, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд онцгойлон анхаардаг → социологийн хүрээний тусгай салбар гэж тодорхойлогддог. Энэ ухагдахуун нь социологийн онол гаргах нэг хэлбэрт бас ашиглагддаг бөгөөд харилцааг үйл ажиллагааны онолын арга зүйгээс ихэвчлэн маш ойлгомжгүй байдлаар ялгаж, үндсэн ойлголт болгон ашигладаг бөгөөд харилцааны болон ерөнхийдөө нийгмийн шинэ загварууд руу хандуулахыг илүүд үздэг. Огтлолцлын зааг дээр илүү шинэ хэвлэл мэдээллийн шинжлэх ухаан, → феноменологийн социологи, мэдлэгийн социологи (→ мэдлэг), түүнчлэн структурализм/постструктурализмын хандлагууд бий болж байна.

Gaetano Romano

Denis McQuail: Towards a Sociology of Mass Communications. London 1969. – Dt.: Soziologie der Massenkommunikation. Übers. von Bodo Rollka. Berlin 1973.

John R. Searle: Speech Acts. An Essay in the Philosophy of Language. Cambridge 1969. – Dt.: Sprechakte. Ein sprachphilosophischer Essay. Übers. von Renate und Rolf Wiggershaus. Frankfurt a. M. 1983, Sonderausg. 2003.

Niklas Luhmann: Einführung in die Theorie der Gesellschaft. Hrsg. von Dirk Baecker. Berlin 2005.

Харилцан үйлчлэл (Interaktion)

“Харилцан үйлчлэл” нь дор хаяж хоёр хүний хоорондох харилцан яриа болон бусад төрлийн нийгмийн шууд харилцааг (жишээ нь, биеийн тулаан, спортын уралдаан тэмцээн, бэлгийн харьцаа) нэрлэдэг социологийн мэргэжлийн нэр томъёо юм. Georg Simmel-ийн судалгааны чиглэл болон бэлгэдлийн интеракционизмын салбарын санаачилгад тулгуурласан Erving Goffman (*The Presentation of Self in Everyday Life*, 1959, dt. 1969)-ын бүтээлүүдээс хойш харилцан үйлчлэл нь нийгмийн дэг журамд жишээ нь, → нийгэмлэгүүдийн адил өөрийн үндсэн хэлбэрийг бүрдүүлдэг гэж үзэх болсон. Харилцан үйлчлэлийн онцлог шинж чанар бол харилцааны үйлдлийн хувьд барьцгүй, улмаар үгүйсгэх боломжтой бөгөөд нөхцөл байдлыг тодорхойлоход хувь нэмэр оруулах харилцан мэдрэхүйн үйл явц нэгэн зэрэг явагдаж байгаа тохиолдолд л хамт байгаа хүмүүсийн хооронд → харилцаа явагдах боломжтой гэж үздэг. Ийнхүү харилцаан дундаас мэдрэх боломжтой биеийн хэлэмжийн (дууны өнгө, харцны чиглэл) тусламжтайгаар үгийн утгыг зөөлрүүлж, эсвэл бүр онцгойлон асууж шалгаах шаардлагагүйгээр няцааж ч болох юм.

Бүх харилцан үйлчлэл → нийгэмд нэгэн зэрэг явагддаг болохоор харилцан үйлчлэл ба нийгмийн хоорондын харилцааг салангид оршдог юмсын жишгээр ойлгох боломжгүй, харин зөвхөн нийгмийн том зохион байгуулалт дотор орших жижиг зохион байгуулалтын түр зуурын бие даасан байдал гэж ойлгож болох юм.

Харилцан үйлчлэлийг харилцан үйлчлэл өрнөж байгаа нийгэмтэй (магадгүй, албан ёсны байгууллагатай) нь харьцуулахад харьцангуй бие даасан байдаг. Энэ үүднээс Goffman (*Encounters*, 1961, dt. 1973) тодорхой харилцаанд байгаа хүмүүс нэгнийхээ нийгмийн статусын бүх шинж тэмдгийг анхаарч чадахгүй, харин тэндээс зөвхөн тус тусын хувийн харилцан үйлчлэлийн төрөл, сэдэвт хамаарах өчүүхэн сонголт хийдгийг харуулсан байна. Үүний дагуу, оролцогчдын нийгмийн оршин тогтнол тэдний харилцан үйлчлэлдээ ямар оролцоотой байх, бусад хүмүүс үүнд хэрхэн хандахыг тодорхойлдоггүй. Харилцан үйлчлэл илүүтэй өөрөө өөрийгөө удирдах ёстой. Тиймээс Niklas Luhmann (*Soziale Systeme*, 1984) зэрэг бусад онолчид нийгмийн дотоод дахь харилцан үйлчлэлийн бие даасан байдлыг судлахын тулд нийгмийн тогтолцооны тухай ойлголтыг ашигласан.

Luhmann-ы хэлснээр, харилцан үйлчлэлийн энэхүү бие даасан байдал нь ядаж л орчин үеийн нийгмийн бие даасан байдлыг түүний дотор болдог харилцан үйлчлэлтэй нь харьцуулахад тохирч байгаа юм. Нийгмийн асуудлуудыг бүхэлд нь харилцан үйлчлэлийн зан үйлийг өөрчлөх замаар шийдвэрлэх боломжгүй юм. Бие даасан байдлын тухай энэхүү хоёрдох саналыг нийгмийн онолыг харилцан үйлчлэлийн онолд уусгахыг хүсдэг онолчид эсэргүүцдэг. Goffman-аас өмнө харилцан үйлчлэлийг зүгээр л нийгмийн оролцоо гэж тайлбарлах (макро редукционизм) нь хэвийн үзэгдэл байсан бөгөөд тиймээс ч хожим нь “макро социологийн микро сан”-г бий болгохыг зорьж байсан (Randall Col-

lins, in: *American Journal of Sociology* 13, 1981). Энэхүү микро бууралттай хөтөлбөрийг хэрэгжүүлэх оролдлого хийгдээгүй байгаа учраас үүнийг үнэлэхэд бэрх юм.

Сүүлийн үед энэ сэдвийн хүрээнд нийгмийн → ялгарлын талаарх таамаглалаар судалгаа авах ажил хийгдэж байна. Тухайлбал, Nicos Mouzelis (Back to Sociological Theory, 1991) зохион байгуулалттай адилтгаж ойлгох шатлалын тухай бодож, дээд албан тушаалтнуудын харилцан үйлчлэлээс макро социологийн шууд үйл явдлыг хардаг. Luhmann (*Gesellschaftsstruktur und Semantik*, Bd. 1, 1980) орчин үеийн нийгмийн үйл ажиллагааны тогтолцоо дахь харилцан үйлчлэлийг хувийн хамтач байдлын хэлбэрээс ялгаатай авч үздэг. Үүний гол санаа нь, үйл ажиллагааны тогтолцоонд хэвийн явагддаг аливаа “харилцан үйлчлэлээс хөндийрөх” (Erving Goffman, *Interaction Ritual*, 1967)-өөс зайлсхийхийн тулд зөвхөн эв найрамдалтай харилцан үйлчлэлийн замаар амжилтад хүрнэ гэж үздэг байна.

André Kieserling

Niklas Luhmann: Einfache Sozialsysteme. In: N. L.: Soziologische Aufklärung 2. Opladen 1975. S. 25–48.

Erving Goffman: Interaktion und Geschlecht. Hrsg. von Hubert A. Knoblauch. Übers. von H. A. K. und Margarethe Kusenbach. Frankfurt a. M. [u. a.] 1994, ²2001.

André Kieserling: Kommunikation unter Anwesenden. Studien über Interaktionssysteme. Frankfurt a. M. 1999.

Хөгжил (Entwicklung)

Хөгжил (англиар *development*) гэдэг нь социологийн ойлголтоор нийгмийн харилцааны ухралтгүй, байнгын, зорилтот, чанарын → өөрчлөлтийг илэрхийлдэг.

Соён гэгээрлийн үеэс хойш хөгжил гэдэг ухагдахуун хүмүүсийг нийгэм, байгалийн хамаарлаас → чөлөөлж буй “дэвшил” гэсэн утга санаатай нягт уялдах болсон. XIX зууны үеэс “хөгжил”-ийг Европт болон Хойд Америкт нийгмийн → орчин үеийн байдалтай холбон ойлгох болжээ. Соёлын оновчтой бодлого, → төрт улсыг улс төрийн зохион байгуулалт гэж үзэх, зах зээл дээрх аж үйлдвэрийн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл зэрэг нь хөгжлийн чухал хөдөлгөгч хүч болдог. Дэлхийн II дайны дараа хүн амын соёл, эдийн засаг, нийгэм, улс төрийн амьдралын нөхцөлийг хөгжлийн замаар сайжруулах зорилготой тодорхой → оролцогчдын буюу → институциудын нийгмийн өөрчлөлт дэлхий даяар өрнөсөн.

Хөгжлийн талаарх нийгмийн төсөөлөл, үзүүлэлт, үр нөлөөний социологийн анализ нь хөгжлийн социологийн судлагдахуун бөгөөд 1960-аад онд Герман хэлтэй улс орны их сургуулиудад “тусгай социологи” хэлбэрээр нээгдсэн. Энэ үед бүтцийн функционализм (→ функционализм) хүчтэй нөлөөлсөн, хувьслын үйл явц (→ хувьсал) гэдэг утгаараа хөгжлийн нэг шугаман зам дээр загварчилсан шинэчлэлийн онолууд эхэндээ давамгайлж байв (Talcott Parsons, *Societies*, 1966, dt. 1975). Үүний дагуу энэхүү чанарын үйл явц нь ялгах,

бодитой болгох замаар “уламжлалт” байдлаас “орчин үе”-рүү буюу тодруулбал илүү цогц, төрийн зохион байгуулалттай, нийгмийн бүтцийн хувьд ялгаатай, соёлын ерөнхий чиг баримжаатай, “барууны” хэв маягийн капиталист эдийн засагтай (→ капитал) аж үйлдвэржсэн нийгэмд (→ үйлдвэрлэлийн нийгэм) хөтөлсөн. Эдгээр үзүүлэлтүүд илүү сайн “дасан зохицох чадварыг” бий болгох тул аж үйлдвэржсэн нийгэм бол орчин үеийн нийгмийн хамгийн шилдэг загвар, харин бусад бүх нийгмийн хэлбэр хөгжлийн “хоцрогдол” мэт харагдана. Дүн шинжилгээний судлагдахуун болгон ганц нэг (үндэсний) нийгэмд төвлөрөх, хөгжлийн эдийн засгийн үзүүлэлтүүдээс нэг талыг барьж онцлох (жишээ нь, эдийн засгийн өсөлтийг дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөөр хэмжих), хөгжлийн чухал нөхцөл болох янз бүрийн бүтэцтэй нийгмүүдийн харилцан хамаарлыг үл харгалзах, мөн энэхүү шинэчлэлийн онолын тайлбаруудад Европыг төв болгож буй харах өнцөг нь хатуу шүүмжлэлд өртсөн байдаг. 1970-аад онд өөр онолын хувилбар гарч ирсэн нь хараат байдал ба дэлхийн системийн онол (*Kapitalistische Weltökonomie*, hrsg. von Dieter Senghaas, 1979) бөгөөд энд хэдийгээр “хөгжлийн хоцрогдлын явц” болон харилцан хамаарал бүхий системийн шинж чанарыг онцолсон байдаг ч хожим Зүүн Өмнөд Азийн зарим орнуудын амжилттай “гүйцэж ирсэн хөгжил”-ийг мөн л хангалттай тайлбарлаж чадаагүй юм.

Ийнхүү 1990-ээд онд (нийгмийг бүхэлд нь тайлбарлах гэсэн “том онол”-оос ерөнхийдөө татгалзах болсонтой

мөн холбоотой) “хөгжлийн” талаарх социологийн онолын боловсруулалт эгзэгтэй үед орсон юм. Нийгэм хоорондын болоод зарим тохиолдолд глобал харилцан хамаарлыг улам бүр судлах болов. Үүний зэрэгцээ 1980-аад оноос хойш дэлхий даяар аж үйлдвэрийн нөөцийн хэт ашиглалт, хүний амьдралын болоод хүрээлэн буй орчны бохирдол, хүн амын хэт өсөлт, амьдралын тэгш боломжийн шударга бус хуваарилалт ихсэж байгаа зэрэг нь анхаарлын төвд байсаар байв. Рио-де-Жанейро хотод болсон “Хүрээлэн буй орчин ба хөгжил”-ийн талаарх НҮБ-ын бага хурлаар (1992) “тогтвортой хөгжил”-ийн (sustainable development) чиг баримтлалын үзэл санааг хөтөлбөр болгон баталсан. *Рио-гийн тунхаглал* ба *XXI зууны мөрийн хөтөлбөр*-ийн хүрээнд үе хоорондын эв санааны нэгдэл (амьжиргааны баталгаат байдлыг хангах) болон хөгжлийн эерэг үр нөлөөг дэлхий даяар илүү сайн дэлгэрүүлэх зорилтуудыг холбож хийхийг зорьсон бөгөөд ингэхдээ хүлээгдэж буй хүн амын өсөлт, системчилсэн байдлаар нөөцийг ашиглах чиг баримтлалтай хөгжлийн хөтөлбөрийг зөрчихгүй байх ёстой юм.

Зүүн болон барууны сөргөлдөөн дууссаны дараа хөгжлийн социологи дахин ухрах төлөвт орсон байдаг. Юуны түрүүнд ЗХУ задран унасан хийгээд зарим залгамж орнуудын өөрчлөлтийн асуудлууд нь тэдний шинэчлэлийн ухралтыг илтгэж байна гэж үзэн шинэчлэлийн онолын үзэл санааг эргэн харахад хүрсэн. Гэсэн хэдий ч энэ үнэлэмж буурав. Хөгжлийг нэг, тогтвортой замналаар явна гэж үзэхээс илүү хөгжлийн олон чиглэл, үүний дагуу орчин үеийн хэд

хэдэн хэлбэрийг ялгадаг үзэл баримтлал давамгайлах болжээ (Shmuel N. Eisenstadt, *Die Vielfalt der Moderne*, 2000). ЗХУ-ын аж үйлдвэрийн нийгэмд хүрэх зам, түүнчлэн колоничлолын дараах нийгэм эсвэл Азийн хөгжил (жишээ нь, Япон) нь хөгжлийн өөр өөр хувилбарыг харуулдаг. Энэхүү олон янзын замнал өөр хоорондоо нөлөөлж, жим үүсгэдэг. Эдгээр нь үйл явдал, шийдвэрийн учир шалтгааны гинжин хэлхээг бүрдүүлэх бөгөөд тухай бүр эхнийх нь дараагийнхаа магадлалыг тодорхойлох юм уу эсвэл хязгаарлаж байдаг.

Иймээс хөгжлийн үйл явц бол тухайн нөхцөл байдалтайгаа уялддаг бөгөөд юу тохиолдох нь нээлттэй. Хөгжлийн нөхцөл байдлын судалгаа өнөөдөр маш тодорхой онолын олон ургалч үзлээр тодорхойлогдоно. Үүнд төрийн бус байгууллага, орон нутгийн ашиг сонирхлын бүлгүүд, нийгмийн хөдөлгөөн, төрийн институциуд (хоорондын) болон → албан байгууллага, аж ахуйн нэгжүүд гэх мэт сонгогдсон оролцогчдын → харилцан үйлчлэл, бодит нөхцөл байдал болон орон нутгийн хөгжлийн уялдаа холбоо зэрэгт дүн шинжилгээ хийх зэрэг багтана. → Даяаршлын үйл явц нь үндэстэн дамнасан нийгмийн харилцаа, соёлын өөр өөр хэлбэр, → хэм хэмжээ, → бэлгэдлээр дамжин хөгжилд нөлөөлдөг бөгөөд энэ нь дэлхийн нөлөөллийн холбоог орон нутагт нутагшуулахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж, улмаар хөгжлийн явцад шийдвэрлэх хүчин зүйл болж чадах юм.

Wolfgang Knöbl: Spielräume der Modernisierung. Weilerswist 2001.

Reinhart Kößler: Entwicklung. Münster 1998.

Waltraud Schelkle [u. a.] (Hrsg.): Paradigms of Social Change: Modernization, Development, Transformation, Evolution. Frankfurt a. M. [u. a.] 2000.

Dieter Goetze: Entwicklungssoziologie. Eine Einführung. Weinheim/München 2002.

Norman Long: Development Sociology. Actor Perspectives. London [u. a.] 2002.

Хувь хүн/Индивидуалчлал (Individuum/Individualisierung)

Хувь хүн (латинаар *individuus* “хуваагдахгүй”, *individualitas* “нэг оршихуй”) байх хүсэл нь түүхэн явцаар нэмэгдсэн хүний онцгой байх хэрэгцээг илэрхийлдэг. Нэг бүхлийн зүгээр нэгэн хэлтэрхий болж, нэг хэсэгт нь захирагдаж явахын оронд → орчинд үеийн эхэн үед хувь хүнийг чухалчилж үзэх хандлага, хүн өөрөө өөрийгөө бүтээгч гэж үзэх сэтгэлгээ бий болсон. Нийгмийн дэг журмын хүрээнд түүнд оноогдсон нийгмийн байр суурь, → үүрэг хариуцлагыг улам бүр лавшруулах болжээ. Хувь хүн хэн гэдгээ, ямар болж болохоо, юу болохыг хүсэж байгаагаа мэдэхийг хүснэ.

Индивидуалчлал гэдгийг нийгмийн хүлээлтийг хувь хүнд өөрт нь мэдрүүлэхийн тулд уламжлалт нийгмийн харилцаа холбоо, хамтын хамаарал, өгөгдсөн үүргээс

чөлөөлж гаргаж буй аливаа үйл явц гэж ойлгоно. Хэдийгээр (шашны) нийгэмлэгүүд (→ шашин шүтлэг), → гэр бүл, → анги давхарга, статус зэрэг нь оршин тогтносоор байж болох ч эдгээр нь хувь хүн өөрийгөө амьдралынхаа гол утга учир болгох хариуцлагаас хаацайлаад байхгүй. Энэ үйл явц нь тухайн хүнд үйлдэл хийх боломж нэмэгдэнэ (→ үйлдэл) эсвэл нийгмийн аюулгүй байдал алдагдана гэж мэдрэх эсэхээс үл хамаараад энгийн шийдвэрүүдийг ахисан түвшний төлөөллөөр дамжуулан гаргаад байх боломжгүй гэдгийг хүн бүр мэдрэх ёстой. Бие даан шийдвэр гаргахад чадвар хүрэхгүй байсан ч өөрөө илүүтэй шийдвэрээ гаргаж байх ёстой. Энэ нь зөвлөгөө өгөх, экспертийн соёлыг бий болоход хүргэсэн байдаг.

Индивидуалчлалын үйл явц нь дөнгөж өнөө үед гарч ирж байгаа үзэгдэл биш, харин үүний ул мөрийг орчин үеийн нийгмийн үүслээс мөшгөх хэрэгтэй. Дундад зуунаас Сэргэн мандалтын үе хүртэлх шилжилтийг орчин үеийн хувь хүнчлэл бий болж гарсан цаг үе гэж ихэвчлэн ойлгодог (Jacob Burckhardt, *Die Cultur der Renaissance in Italien*, 1860). Хэдий тийм ч индивидуалчлал нь тасралтгүй үргэлжлэх үйл явц гэж хараахан ойлгож болохгүй. Norbert Elias “индивидуалчлалын үечлэл”-ийг өөр өөр цаг үед тохиолдож байсан, заримдаа гэхдээ зогсонги байдалд эргээд орчихдог тухай их ярьдаг (*Die Gesellschaft der Individuen*, 1983).

Индивидуалчлалын үйл явцыг янз бүрийн цаг хугацаанд харахад нийгэм-философийн болон социологийн уламжлалд хоёр эсрэг тэсрэг тайлбарын

хувилбар гарч ирдэг. Нэг талаар хувь хүн бол нийгмийн дарангуйлалд байдаг гэсэн үндэслэлтэй бид тулгарна. Энэ өнцгөөс харвал хувь хүний хөгжлийг түүхийн уналт болгон ярьдаг. Энд нийгэм нь хувь хүнийг чөлөөтэй хөгжихөд саад болдог ба тодорхой үүрэг гүйцэтгэхийг шаарддаг. Нөгөө талаар, нийгэм гэж байхгүй бол хувь хүн гэж огт байхгүй байх байсан гэдэг үндэслэл байна. Нийгэм бол хувь хүнийг хувь хүн гэж мэдрэх боломжийг олгодог. Уламжлалын эхэн үед хувь хүн болон нийгэм эвлэршгүйгээр нүүр тульж байсан бол хоёрдугаар хагаст эсрэг байдлыг үүсгэдэггүй, харин харилцан өсөн дэвших хамаарлыг бүрдүүлдэг. Эхний үндэслэлийн хувьд Jean-Jacques Rousseau, Max Weber, Theodor W. Adorno, Ralf Dahrendorf нарын бүтээлд дурдагдсан байдаг. Хоёр дахь үндэслэлийн хувьд юуны түрүүнд Émile Durkheim, Niklas Luhmann нар төлөөлнө. Үүнтэй төстэй байдлаар аль эрт Johann Friedrich Herbart “хүн бол нийгмээс гадуур хэн ч биш. Юу ч үгүй цор ганц хүнийг бид огт мэдэхгүй” (*Psychologie als Wissenschaft*, Tl. 2, 1824/25) гэсэн үндэслэл гаргаж байсан бол бас Karl Marx хувь хүнийг “нийгмийн харилцаануудын нэгдэл” гэж үзэж байжээ.

Индивидуализаци гэдэг нь индивидуализм буюу хувьч үзэл эсвэл индивидуаци буюу өөрийгөө таних үйл явц гэсэн утгатай адилгүй юм. Индивидуализм гэдэг нь хувь хүний бие даасан байдал, хувийн хариуцлагыг → субъект болгон авч үзсэн улс төрийн үзэл санааны түүхийн (→ улс төр) нэг хэсгийг хэлдэг бол “индивидуаци”-аар сэтгэл судлалын (→ нийгмийн сэтгэл судлал)

мэргэжлийн нэр томьёог илэрхийлдэг бөгөөд онцгой гэдэг утгаараа хувийн шинж чанарын шаардлагаар хувь хүний бүтцийг хөгжүүлэх гэсэн утгатай. Гэсэн хэдий ч социологийн түүхэн дэх “индивидуализаци” сэдвийг сэргээхэд дээрх гурван нэр томьёог тэр бүр нарийн тодорхой ялгаж салгаж авч үзэж байгаагүй нь харагдана. Émile Durkheim, Georg Simmel, Max Weber, Talcott Parsons, Norbert Elias, Theodor W. Adorno, Niklas Luhmann, Ulrich Beck, Michel Foucault, Anthony Giddens, Zygmunt Bauman индивидуализацийн талаар ярих юм бол энэ нь ихэвчлэн индивидуализм, индивидуацийн тухай болж өрнөдөг. Үүнээс гадна тэдний бичвэрүүдийн сэдэв нь зөвхөн одоогийн төдийгүй эртний хувь хүнчлэлийн үйл явцыг ч тодруулж байв. Учир нь хувь хүнчлэл болох үйл явц нь XX зуунд л илэрсэн үзэгдэл биш бөгөөд харин хүн төрөлхтний хөгжлийн түүхийн эхэн үед (ойролцоогоор сэргэн мандалтын үед) ажиглагдаж байжээ. Индивидуалчлалын янз бүрийн үзэл баримтлалуудыг авч үзэхэд уг үзэгдлийн талаарх үнэлгээнд ижил төстэй тайлбар байгаа хэдий ч чухал ялгаануудыг багтаасан нь анзаарагдаж байна. Нэг талаас, хувь хүн орчин үеийн шинэчлэлийн үйл явцад улам бүр нэмэгдэх болсон хяналтын дор орох болсон тул хувь хүний төгсгөлд халаглаж байхад (→ шүүмжлэлийн онол), нөгөө талаас, өөрийгөө чөлөөтэй авч явдаг хувь хүн эв нэгдэл, хамтач сэтгэл дутсан аминч үзэлтэй нийгмийн үүслийг тэтгэж байгаа болохоор нийгмийн төгсгөлийг урьдчилан таамаглаж байна (Kommunitarismus, etwa Robert N. Bellah, *Habits of the Heart*, 1985, dt. 1987).

Хоёр туйлширсан үзлийн хооронд холбогч маягийн гурав дахь уншигддаг хэлбэр нь хувь хүнчлэлийн үйл явцыг тоглолт хийх боломж, шийдвэр гаргах эрх чөлөөг (→ эрх чөлөө) маргаангүй нэмэгдүүлдэг хэдий ч нийгмийн эв нэгдлийг задлахаар хэмжээнд биш, харин түүхийн өмнөх үеийнхэнтэй харьцуулахад хувь хүн өөрөө сонгож болох нийгэмлэгийн (→ хамтын нийгэмлэг) болон нийгэмшүүлэх шинэ хэлбэрийг бий болгох шалтгаан өгдөг гэж тодорхойлжээ (Ulrich Beck, *Risikogesellschaft. Auf dem Weg in eine andere Moderne*, 1986). Гэр бүл салалтын түвшин болоод өрх толгойлсон ганц бие эцэг эхүүд нэмэгдэж байгаад төдийгүй мөн өөрсдөө сонгосон холбоо болон нам доторх карьертай нь огтлолцдог нийгмийн харилцаа холбооны оролцоо ихсэж байгаагийн эмпирик нотолгоо байдаг.

Арга зүйд дөнгөж талсжин гарч ирж байгаа эдгээр шинэ хэлбэрүүдийг илүү нарийн судалж, тэдгээрийн тогтвортой, тэсвэртэй байдлын талаар асуулга хийх нь хувь хүнчлэлийг судлах судалгааны зорилгод багтдаг. Нэг бүрчлэнгийн үр дүн нь ямар ч байлаа гэсэн. Хувь хүн өөрийн хувийн шинж чанарын шаардлагадаа нийгмийг сөрж, тэмцэхэд хүрэх эсэх, эсвэл нийгэм цаашдынхаа оршин тогтнолд шаардлагатай яг нарийн хувь хүний шинж чанар нь бүрдсэн хувь хүнийг бий болгож байгаа эсэх зэрэг сонгодог маргаан хувь хүний нийгэмд тавих шаардлага цаг хугацааны явцад нийгмээс хувь хүнд өгөх хүлээлт болж хувирах байдлаар шийдэгдэж болох мэт санагдаж байна. Нэгэн цагт эрэлт хэрэгцээтэй байсан өөрийгөө таниулах, өөртөө дүн шинжилгээ

хийх эрх чөлөө нь нийгмийн нөлөөнд аль эрт замхарч бүх талаараа бие даах чадвартай хувь хүн орчин үеийн нийгмийн хамгийн тохиромжтой дүр төрх болж дэвшиж байна.

Markus Schroer

Norbert Elias: Die Gesellschaft der Individuen. Frankfurt a. M. 1987, ⁵2003.

Ulrich Beck / Elisabeth Beck-Gernsheim (Hrsg.): Riskante Freiheiten. Individualisierung in modernen Gesellschaften. Frankfurt a. M. 1994, ⁶2004.

Thomas Kron (Hrsg.): Individualisierung und soziologische Theorie. Opladen 2000.

Richard van Dülmen (Hrsg.): Entdeckung des Ich. Die Geschichte der Individualisierung vom Mittelalter bis zur Gegenwart. Köln [u. a.] 2001.

Markus Schroer: Das Individuum der Gesellschaft. Synchrone und diachrone Theorieperspektiven. Frankfurt a. M. 2001, ²2007.

Хувьсал (Evolution)

Хувьсал (латинаар *evolutio* = “дэлгэх” [хуйлсан номыг], “нээх” [номоо]) гэдэг нь хугацаагүй, хувиршгүй “хөдөлгөгч хүч”-ний зарчим дээр суурилдаг тасралтгүй, санамсаргүй бөгөөд буцалтгүй үргэлжлэх өөрчлөлтийн (→ өөрчлөлт) үйл явц юм. Биологийн ойлголтоор “хувьсал” нь

амьдралын хуучин хэв маяг өөрчлөгдөж шинэ хэв маяг бүрэлдэхийг хэлнэ. Социологийн ойлголтоор “хувьсал” нь нийгмийн болон соёлын бүтцийн хөгжилтэй холбоотой байдаг. Францын хувьсгалын туршлагаас “хувьсал” болон “хувьсгал” хоёрын хоорондох ялгаа гарч ирсэн. “Хувьсал” нь “байгалиасаа”, зөнгөөрөө явагдаж байгаа эсвэл шинэчлэлийг даган гарч ирж буй хөгжил гэж ойлгогдож байхад, “хувьсгал” нь хөгжлийн огцом, хүч түрсэн ухралт эсвэл хурдцыг хэлнэ.

Нийгэмд хэрэглэгдэж байсан Turgot, Condorcet болон Auguste Comte нарын хувьслын анхны онолууд олон янзын соёлыг техник талаас нь эсвэл санааны хувьд хамгийн тохиромжтой хөгжлийн цөөн хэдэн үе шатанд хуваарилсан ба бүхий л нийгэм (барууны) хөгжлийн чиг баримжаатай байдаг гэж үзэж байв. Социологийн хувьд XIX зууны онолууд → орчин үеийн эхлэл тавигдах үндсэн өөрчлөлтийн болон динамикийн үйл явцад ихээхэн нөлөөтэй байсан. Herbert Spencer (*First Principles*, 1862) сансар огторгуйн хувьслын үзэл баримтлалдаа амьгүй болон амьд материйн аль алиных нь хувьд илүү том нэгдлүүдийг энгийнээс цогц хэлбэр рүү, хомогенээс хетероген рүү, цаашлаад боловсрол руу, дотоод ялгаа руу чиглэсэн хувьслын тухай таамаглал дэвшүүлсэн байдаг. Хувьслын механизм бол “амьд үлдэхийн төлөөх тэмцэл” (*struggle of the fittest*) бөгөөд энэ нэр томъёоны хэрэглээ юун түрүүнд Charles Darwin (*On the Origins of Species*, 1859)-ын “байгалийн жам ёсны шалгарал”-ын оронд илүү гарч ирэх болжээ. Эдгээр онолын зарим нэг элементүүд нь XIX зууны төгсгөл үед бие даасан

нийгэм ба бүлгийн соёл, угсаатны давуу байдлыг бусдад батлахын тулд ашиглагдаж байсан (нийгмийн дарвинизм). Мөн Karl Marx, Friedrich Engels (*Das kommunistische Manifest*, 1848) нар ч хүн төрөлхтний түүхийг байгалийн хуулийн хатуу чанд байдлын өөрчлөлтийн логигоор тайлбарлахыг оролдож байв. Ажиллах хүч ба үйлдвэрлэлийн нөхцөлийн хоорондох хувьсгалын замаар давж гарах харилцаа бол хүн төрөлхтнийг чөлөөт хөгжилд хөтөлнө (→ материалист нийгмийн онол) гэсэн энэ санаагаараа зохиогчид, анхнаасаа бие биеэ үгүйсгэдэг байсан “хувьсал” ба “хувьсгал” гэсэн нэр томьёог нөхцөлт холбоонд оруулсан.

1900 оны үед Max Weber, Émile Durkheim, Georg Simmel нар марксист түүхэн детерминизм²³ ба нийгмийн харилцааны биологижуулалтыг хоёуланг нь эсэргүүцэж байв. АНУ-ын соёлын угсаатан судлалын эхэн үед ч хувьслын онолын сэтгэлгээнээс татгалзахад хүрч байсан (Franz Boas, Ruth Benedict, Margaret Mead). XIX зууны уламжлалт хувьслын үечлэлийн схем нь эмпирик байдлаар туршигдах нь байтугай ёс суртахууны хувьд ч зөвтгөгдөх боломжгүй.

Нөгөөтээгүүр, Talcott Parsons («Evolutionary Universals in Society», in: *American Sociological Review* 29, 1964, Nr. 3) нь бүтцийн функционалист сэдвийг хувьслын онолын үүднээс нотолж тайлбарлахдаа, худалдааны газар, албан байгууллага эсвэл ардчилсан холбоод зэрэг нийгмийн нэлээдгүй институциуд “хувьслын универсалууд”

²³ Бүх үйл явдлууд, ялангуяа ирээдүйн үйл явдлууд урьдчилсан нөхцөлөөр гарцаагүй тодорхойлогддог гэсэн үзэл: <https://de.wikipedia.org/wiki/Determinismus>

болох бөгөөд үүнийг нэгэнт л бий болсон бол ялгах болон нэгтгэх гэсэн шинж чанаруудаас нь шалтгаалаад (→ ялгах, нэгтгэх) бүрмөсөн буцаах боломжгүй болдог гэж үзэж байв. Norbert Elias (*Über den Prozeß der Zivilisation*, 2 Bde., 1939) нь соёл иргэншлийн онолыг гаргаж ирсэн бөгөөд энд Sigmund Freud-ийн тодорхойлсон сэтгэл зүйн ялгаатай байдлаас өөрийн загварыг олж, нийгмийн харилцан үйлчлэлийн хэлбэрүүд (→ харилцан үйлчлэл)-ийг хөгжүүлэх үүрэг улс төрийн өрсөлдөөнд, ялагчийг тодорхойлох тэмцэлд ирдэг гэж үзжээ. Харин Jürgen Habermas *түүхэн материализмыг шинэчлэх* (1976) оролдлого хийхдээ техникийн ухааны хажуугаар ёс суртахууны хамт суралцах үйл явцад хөгждөг харилцааны ухаан мөн гарч ирдгийг дурджээ. Үүнтэй төстэй байдлаар Günter Dux (*Historisch-genetische Theorie der Kultur*, 2000) нийгэм-соёлын хувьслыг зөвхөн байгалиас өгөгдсөн өгөгдөл, тэр дундаа хүний тархины чадамжтай холбон ойлгох боломжтой гэж үзэж байв. Niklas Luhmann (*Soziale Systeme*, 1984) хувьслыг шинэ биологийн буюу өөрөөр хэлбэл конструктивист хувьслын онолуудтай уялдуулан байгалийн эсвэл нийгэм-соёлын орчин нөхцөлд зохицох чадвар биш, харин нийгмийн → тогтолцооны дотоод бүтцийг бүрдүүлэхээс үүдсэн үр дүн гэж үзжээ. Үүнээс эрс ялгаатай өнөө үед нийгмийн асуудлыг байгалийн шалгарлын үйл явцтай шууд хамааруулах нийгэм-соёлын туршилтууд мөн байгаа (Edward Wilson, *Sociobiology*, 1975; Richard Dawkins, *The Selfish Gene*, 1976).

Wolfgang Wieland: Entwicklung, Evolution. In: Otto Brunner [u. a.] (Hrsg.): Geschichtliche Grundbegriffe. Historisches Lexikon zur politisch-sozialen Sprache in Deutschland. Bd. 2. Stuttgart 1975. S. 199–228.

Tim Ingold: Evolution and Social Life. Cambridge [u. a.] 1986.

Tamás Meleghy / Heinz-Jürgen Niedenzu (Hrsg.): Die Evolutionstheorie und die Sozialwissenschaften. Wiesbaden 2003.

Manuela Lenzen: Evolutionstheorien in den Natur- und Sozialwissenschaften. Frankfurt a. M. [u. a.] 2003.

Хүйс (Geschlecht)

“Хүйс” гэдэг нь биологи-байгалиас заяагдсан ялгаа, тэдгээрээс үүдэлтэй зан чанарын өөр өөр хэв маягт (англиар *gender*) тулгуурлаад хүмүүсийг эрэгтэй, эмэгтэйгээр ерөнхийд нь хуваасныг тодорхойлж буй нэршил юм (англиар *sex*). Социологид “хүйс” нь “нас”, “арьс өнгө”-тэй адил хүн болж төрөхөөс эхлээд тогтоогддог, нийгмийн янз бүрийн статустай холбогдож, улмаар нийгмийн бүтцийг бий болгох нөлөөтэй хувь хүний идентитетийн (*Identität*) салшгүй нэг хэсэг юм. Émile Durkheim (*De la division du travail social*, 1893, dt. 1977) болон Georg Simmel (*Schriften zur Philosophie und Soziologie der Geschlechter*, hrsg. von HeinzJürgen Dahme und Klaus Christian Köhnke, 1985) нарын хувьд XIX зуунд барууны нийгэмд анх бий

болсон үүргийн хуваарилалт, нэг талаас, эрчүүдийг ажиллах орчин, олон нийтийн улс төрийн хандлагад, нөгөө талаас, эмэгтэйчүүдийг гэр бүл, ахуйн ажилд гэж хуваасан нь жам ёсны үндэслэлтэй, орчин үеийн нийгмийн функциональ нийгмийн → ялгарал гэж үзэж байв. Talcott Parsons (*Essays on Sociological Theory*, 1954, dt. 1964)-ын чиглүүлсэн хүйсийн үүргийн тухай нэр томьёо бол гол төлөв эмэгтэйчүүдэд хамааралтай зан чанарын хэв шинж, чадамжийн дүрслэлийг авч үздэг бөгөөд нийгмийн янз бүрийн байр суурийг дагасан нийгмийн ялгаварлал, хараат байдлыг хөндөх нь бага. Уламжлалт болон сүүлийн үеийн анги, давхаргын онолын арга зүй (→ анги) нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондох нийгмийн → тэгш бус байдал, тэр дундаа хөдөлмөр эрхлэлтэд тулгуурласан нөөцийн хуваарилалт, статусын оноолтыг голчлон судалдаг. Нийгмийн практик болон ажлын байран дээрх албан тушаал, хувийн харилцаа болон гэр бүл, цаашлаад олон нийтийн улс төрийн хандлага хоорондын уялдаа холбоог энд анхаарахгүй орхидог тал бий (→ эрх мэдэл, ноёрхол).

Үүний эсрэг 1970-аад онд барууны нийгэмд өрнөсөн эмэгтэйчүүдийн хөдөлгөөнөөр өдөөгдсөн эмэгтэйчүүдийн судалгаа нь “жендер”-ийн судалгааны хэтийн төлөвийг бүтцийн ангиллаар нэвтрүүлж, эмпирикт суурилан хөгжиж ирсэн байдаг. Үүний дагуу, жендерийн ялгаварлал нь нийгмийн бүхий л салбарт нөлөөтэй байж болох нийгмийн бүтэц бөгөөд ихэвчлэн эрэгтэй хүний нийгмийн туршлага, эрэгтэйлэг чанарыг

“хэвийн”, эмэгтэй хүнийхийг, эмэгтэйлэг байдлыг “гажилт” гэж нормчилж, анги давхаргын харьяалал, үндэс угсаа гэх мэтчилэн нийгмийн бусад ялгаварлалд давхар нөлөөлж байдаг.

Эмэгтэйчүүдийн судалгааны өмнөх үеийн хандлагаар юуны түрүүнд бүх нийгэм дэх хөдөлмөрийн хуваарилалтын хүрээнд (→ ажил) эмэгтэйчүүдийн нийгмийн тэгш бус байдлыг хөндөж тавьж байсан. Ilona Ostner болон Elisabeth Beck-Gernsheim («Frauen verändern – Berufe nicht?», in: *Soziale Welt* 29, 1978) нарын Герман дахь хэлэлцүүлэгт чухал нөлөө үзүүлсэн “эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх чадвар”-ын шинэчлэлийн онолын үзэл баримтлал (→ орчин үеийн) нь эмэгтэйчүүдийн гэрийн болон асран халамжлах үүрэг хариуцлагаас үүдэж хөдөлмөр эрхлэлтийн орчинд ялангуяа, эмэгтэйчүүдийн үйл ажиллагааны чиглэл, үнэт зүйлсийн хэв маягийг бий болгоход чиглэдэг. Regina Becker-Schmidt («Frauen und Deklassierung, Klasse und Geschlecht», in: *Klasse Geschlecht. Feministische Gesellschaftsanalyse und Wissenschaftskritik*, hrsg. von Ursula Beer, 1989) болон Gudrun-Axeli Knapp («Zur widersprüchlichen Vergesellschaftung von Frauen», in: *Die doppelte Sozialisation Erwachsener*, hrsg. von Ernst-H. Hoff, 1989) шүүмжлэлийн онолын уламжлалт хандлагын эсрэг (эмэгтэйчүүдийн) “давхар нийгэмшил”-ийн тухай ухагдахууныг гаргаж ирсэн бөгөөд үүнд ажлын дадлага, бүтцийн шаардлага, хоёрдмол туршлагыг зөвхөн хувийн аж ахуйд төдийгүй хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд ч багтааж авч үзсэн байна. Энд бусад эмэгтэйчүүдийн ялгаварлан

гадуурхалтын эртний түүх, тэдний бие даасан байдлыг онцлохын тулд “эцгийн эрхт ёс” нэр томъёог зарим нь хэрэглэдэг бусад Англо-Америк, Францын онолын арга хандлагад хүйсийн харилцааг нийгмийн онцгой харилцаа гэж ойлгуулсан.

Ervin Goffman («The Arrangement between the Sexes», in: *Theory & Society* 4, 1977, dt. in: *Interaktion und Geschlecht*, hrsg. von Hubert Knoblauch, 2001)-ны боловсруулсан, Carol Hagemann-White (*Sozialisation: Weiblich – männlich?*, 1984), мөн Regine Gildemeister, Angelika Wetterer («Wie Geschlechter gemacht werden. Die soziale Konstruktion der Zweigeschlechtlichkeit und ihre Reifizierung in der Frauenforschung», in: *Traditionen Brüche. Entwicklungen feministischer Theorie*, hrsg. von Gudrun-Axeli Knapp und Angelika Wetterer, 1992) нарын Германы хэлэлцүүлэгт оруулж ирсэн хүйсийн тухай нийгмийн конструкцийн (→ конструктивизм)²⁴ үзэл нь 1990-ээд онд нийгмийн бусад конструктивист, постструктуралист (→ постструктурализм)²⁵ анализаар хүчээ авч, феминист онолын хэлэлцүүлгийг өргөжихөд хүргэсэн. Үүнээс хойш жендерийн ялгаварлалын шалтгаан, үр дагаврын талаар ярихаасаа илүүтэй анагаах ухаанаар тогтоодог төрөхөөс эхлээд ангилж (*sex categorisation*) байгаа үйлдэл нь өөрөө хүйсийн ялгааг

24 Нийгмийн конструктивизмын гол зорилго нь нийгмийн бодит байдал, нийгмийн үзэгдлүүд хэрхэн бүтсэнийг судлах явдал юм: <https://de.wikipedia.org/wiki/Sozialkonstruktivismus>

25 Хэл шинжлэлийн практик ба нийгмийн бодит байдлын хоорондын харилцааг янз бүрийн аргаар шүүн хэлэлцдэг хүмүүнлэг, нийгмийн шинжлэх ухааны хандлагыг хэлнэ. Гол санаа нь хэл бол бодит байдлыг зөвхөн дүрсэлдэггүй, харин түүнийг ангилж, ялгах замаар бүтээдэг гэсэн үзэл юм: <https://de.wikipedia.org/wiki/Poststrukturalismus>

бий болгож байгааг илүүтэй хэлэлцэх болжээ. Хуучин конструктивист үзэл баримтлал дээр тулгуурлан *doing gender* нь өдөр тутмын, бие махбодын болон харилцан үйлчлэлээр бүрдсэн, түүнчлэн нийгэм-улс төрийн хувьд олон янзаар члэгдсэн → бодит байдлын конструкци байдлаар судлагддаг. Judith Butler (*Gender Trouble*, 1990, dt. 1991) болон Donna Haraway (*Simians, Cyborgs, and Women. The Reinvention of Nature*, 1991, dt. 1995) нар нөлөө бүхий бүтээлүүдээрээ шүүмжлэлт байдлаар байгаль, бие махбод, хүйсийн талаар орчин үеийн нийгэм, байгалийн шинжлэх ухааны, мөн технологийн конструкцийн мэтгэлцээн өрнүүлдэг.

Жендерийн тухай нийгмийн конструкцийн үзэл санааг жендерийн харилцааны хувьсал, тууштай байдлын талаарх олон тооны, зарим нь улс орны харьцуулсан эмпирик судалгаанаас харж болох бөгөөд тэд эмэгтэйчүүдийг буюу асран халамжлах үүрэг хүлээсэн хүмүүсийг ялгаварладаг ажил олгогч байгууллага, үйлчилгээний соёл, амьдралын хэв маягийн нийгэм-улс төрийн зохицуулалтыг хэвийн нөхцөл дэх конструкци байдлаар судалж үздэг. Өнөөгийн нийгэм-эдийн засаг, соёл, улс төрийн өөрчлөлтүүд хүйсийн тэгш бус байдлыг хэр зэрэг бууруулж эсвэл тэгш бус байдлыг ялгахад хүргэж байна вэ, хүйсийн тэгш бус байдлын легитим чанар өөрчлөгдөж байгаа эсэх, хэрхэн өөрчлөгдөж байгаа зэрэг нь маргаантай сэдэв хэвээр байна (*Geschlechtersoziologie*, hrsg. von Bettina Heintz, 2002; *Achsen der Differenz, Gesellschaftstheorie und feministische Kritik*, hrsg. von Gudrun-Axeli Knapp und

Angelika Wetterer, 2003; Nancy Fraser, *Justice Interruptus*, 1997, dt. 2001).

Эмэгтэйчүүдийн судалгаа нь сүүлийн үеийн, төлөөлөх чадварт чиглэгдсэн, салбар дундын социологийн салбар судлагдахуун бөгөөд бусад дэд салбаруудын нэгэн адил олон тооны онол, арга зүйн хандлагаар тодорхойлогддог. Сүүлийн хэдэн арван жилд энэ судалгаа тодорхой хэмжээнд тогтворжиж хэвийн байдалд хүрсэн нь жендерийн социологийн (*жендер судлал*) таних тэмдэг болж, эрэгтэйчүүдийн оролцоо ч нэмэгдсээр буйгаас харагдана. Нийгмийг соён гэгээрэлд хөтөлнө гэсэн зорилго, хэтийн төлөвтэй энэ чиглэлд социологийн сэтгэлгээ, судалгаанд жендерийн мэдрэмжтэй хандлагыг тусгах, нийгэм-улс төрийн хэлэлцүүлэгт өөрийгөө эргэцүүлэн тунгаах байдлаар оролцох сорилт тулгарч байна.

Karin Gottschall

Regina Becker-Schmidt / Gudrun-Axeli Knapp (Hrsg.): *Feministische Theorien zur Einführung*. Hamburg 2000, ³2003.

Karin Gottschall: *Soziale Ungleichheit und Geschlecht: Kontinuitäten und Brüche, Sackgassen und Erkenntnis-potentiale im deutschen soziologischen Diskurs*. Opladen 2000, ²2006.

Ruth Becker / Beate Kortendiek (Hrsg.): *Handbuch Frauen- und Geschlechterforschung*. Wiesbaden 2004.

Martina Löw / Bettina Mathes (Hrsg.): *Schlüsselwerke der Geschlechterforschung*. Wiesbaden 2005.

Barbara L. Marshall: Gender. In: Austin Harrington [u. a.] (Hrsg.): Encyclopedia of Social Theory. London [u. a.] 2006. S. 219–225.

Хүрээлэл (Milieu)

Нийгмийн “хүрээлэл” (францаар *milieu* = “дунд”; англиар *(sub)culture*) гэдэг нь амьдралын “ердийн” хэв маягаар, өөрөөр хэлбэл ижил төстэй амьдралын гадаад нөхцөл, дотоод бүтцээр холбогдож, нэг нэгнээсээ ялгарах харилцааны эсвэл үйл ажиллагааны орчныг хэлнэ. Хүрээллийн үзэл баримтлал нь “эдийн засгийн” → анги, давхаргын үзэл баримтлалыг олон хэмжээст, цогц практик холбоосоор нөхөж өгдөг. Амьдралын гадаад → хэв маягаас ялгаатай байдлаар хүрээлэл нь гүнзгий, түүхэн тогтвортой хандлагад суурилдаг (сэтгэхүй, → хабитус). Соёлын үнэт зүйлээр өвлөгдөн, нийгэмшүүлэх үйл явцаар дамждаг хүрээлэл аажмаар өөрчлөгддөг. Ийм байдлаар уламжлалт, авторитет хандлагатай хүрээлэл (→ авторитет) хумигдаж, өөрийгөө тодорхойлдог, тусгалтай хүрээлэл нэмэгдэж байна. Хүрээллийг шаталсан босоо хэлбэрийн ойролцоогоор арав орчим (хуваагддаг) давхаргад хуваарилж болох бөгөөд тэдгээр нь тус бүрдээ хэд хэдэн хүрээлэлд хуваагддаг.

Émile Durkheim (*De la division du travail social*, 1893, dt. 1977; *Les règles de la méthode sociologique*, 1895, dt. 1961) “хүрээлэл”-ийг социологийн гол үзэл баримтлал

болгон нэвтрүүлжээ. Түүний хувьд энэ ухагдахуунаар (а) “гэр бүл”, “нутаг дэвсгэр”, “мэргэжлийн хүрээлэл” (→ гэр бүл, мэргэжил) гэсэн “объектив” холбоо болон (б) “ёс суртахууны хабитус”-т шингэсэн “ёс суртахууны дүрмийн бие”-д суурилсан харилцааг илэрхийлдэг. Мэргэжлийн хүрээлэл нь нарийн мэргэжлийн ур чадвар, уян хатан байдал, хувь хүний шинж чанарыг хөдөлмөрийн хуваарилалтаар тодотгож, нийгмийн харилцааны явцуу хязгаарыг давж өргөжүүлдэг. Энэ хүрээллийн туршлага нь эд баялаг, → хууль, → ёс суртахуунаар бэхэжнэ. Тэднийг хөгжлийн амьд хүч болгосноор тэд “ялгарах чанар”-аа олдог. Хэрэв тодорхой хүрээлэл бусад хүрээллийг өөрсдийн захиргааны харьяалалд оруулахаар бол нийгмийн байр суурь, тогтсон хүрээлэл, ангиуд нь мэргэжлийн хүрээллийн тусгай хэлбэрүүдийг бүрдүүлэх юм.

1958 оноос хойш үүнтэй төстэй үзэл баримтлалуудыг хөгжүүлж буй судлаачдыг төлөөлөл болгон дурдвал: (1) Анги давхаргын хүрээллийн соёлын тухайд Raymond Williams (*Culture and Society* 1780–1950, 1958, dt. 1972), Edward P. Thompson (*The Making of the English Working Class*, 1963, dt. 1987), Stuart Hall und Tony Jefferson (*Resistance Through Rituals – Youth Subcultures in Post-War Britain*, 1977, dt. 1979), Paul Willis (*Profane Culture*, 1978, dt. 1981), Pierre Bourdieu (*La distinction*, 1979, dt. 1982); (2) намын улс төрийн хүрээллийн тухайд M. Rainer Lepsius, Franz Walter, Peter Lösche (vgl. *Peter von Oertzen, »Klassen und Milieus als Bedingungen gesellschaftlich-politischen Handelns«, in: Bremer/Lange-Vester;*

(3) хэрэглээ, амьдралын хэв маягийн судалгааны хувьд Синус ба сигма институцийн Jörg Ueltzhöffer («Europa auf dem Weg in die Postmoderne. Transnationale soziale Milieus und gesellschaftliche Spannungslinien in der Europäischen Union», in: *Demokratie in Ost und West*, hrsg. von Wolfgang Merkel und Andreas Busch, 1999); (4) Социологийн хувьд Stefan Hradil, Michael Vester; (5) Хот, орон зайн судалгааны тухайд Heiko Geiling («Milieu und Stadt», in: *Bremer/Lange-Vester*), Ulf Matthiesen гэх мэт. Хүрээллийн талаарх эмпирик анализын шинэ арга зүйг юуны түрүүнд Bourdieu, Ueltzhöffer, Vester, цаашлаад Helmut Bremer, Andrea Lange-Vester нараас олж харах боломжтой.

Bourdieu нийгмийн хүрээллийн туршлагыг хабитус, нийгмийн эрх мэдлийн хэрэгсэл (“капиталын төрөл”; → эрх мэдэл, капитал) болон нийгмийн мэтгэлцээний талбараар тайлбарладаг. Тэрээр хөрөнгөтний хүрээлэл нь өөрсдийн давамгайлал бүхий мэргэжлийн хүрээний байр суурийг → үеийн үед дамжуулж чадахаар гэр бүлийн зохион байгуулалттай байдгийг нотлон харуулжээ. Харин Hradil өөрийгөө тодорхойлдог, → ялгаралтай, зугуухан шилжилтийг онцолжээ. Vester зэрэг судлаачдын хувьд ард иргэдийн болон ажилчдын хүрээллийн ялгарал, өөрийгөө тодорхойлох чадвар болон шууд бус байдлаар тэдний өдөр тутмын амьдралын орчинд нөлөөлөх (консерватив, либерал, социал демократ, барууны популист ба пост материалист) улс төрийн “байр суурь”-нд дүн шинжилгээ хийсэн байна.

Туршлага, дур сонирхол руу хандсан чиг баримжаа нь “хүрээлэл”-ийг зах зээлийн судалгаа, сурган хүмүүжүүлэх ухаан, улс төрийн боловсрол, эрүүл мэндийн шинжлэх ухаан, улс төрийн социологийн хувьд, мөн цаашлаад хотын захиргаа, холбоо, сүм хийд, улс төрийн намуудад нийгмийн боломж, → интеграцчилал, оролцооны асуудлаар зөвлөгөө өгөхөд чухал ач холбогдолтой болгож байна. Хотын социологид хүрээллийн хамаарлыг нийгмийн задралын эсрэг нөлөөлөх хүч хэмээн үздэг болжээ.

Michael Vester

Stefan Hradil: Sozialstrukturanalyse in einer fortgeschrittenen Gesellschaft. Von Klassen und Schichten zu Lagen und Milieus. Opladen 1987.

Ulf Matthiesen: Die Räume der Milieus. Berlin 1998.

Michael Vester [u. a.]: Soziale Milieus im gesellschaftlichen Strukturwandel. Vollst. überarb. Fassung. Frankfurt a. M. 2001.

Aus Politik und Zeitgeschichte. Jg. 2006. Nr. 44–45: Soziale Milieus.

Helmut Bremer / Andrea Lange-Vester (Hrsg.): Soziale Milieus und Wandel der Sozialstruktur. Wiesbaden 2006.

Хүрээлэн буй орчин (Umwelt)

Хүрээлэн буй орчин гэдэгт ихэвчлэн хүний амьдрах орчныг нэрлэх бөгөөд энэхүү орчин шууд болон шууд бус байдлаар амьдралд нөлөө үзүүлдэг. Байгалийн жам ёсны (*natürliche*) хүрээлэн буй орчинд хүний амьдрал болон үйл ажиллагаа уялдсан байдаг. Эдгээрт нь агаар мандал, агаар, ус, хөрс шороо, ургамал болон амьтан орно. Хүрээлэн буй орчин нь хүмүүст нөлөөлж, хүмүүс үүгээр мөн өөрчлөгдөнө. Энэхүү хөндлөнгийн оролцоо нь үргэлж байгаль орчны асуудлыг үүсгэдэг. Тухайлбал, биологийн төрөл зүйлийн амьдрах нөхцөлүүд (тухайлбал, уур амьсгалын өөрчлөлт), мөн түүнчлэн байгалийн жам ёсны орчны болон нөөцийн хомсдол, сүйрэл гэх мэт (тухайлбал, ой модны устгал, ачааллаас хэтэрсэн засаг ангах асуудлууд). Нийгмийн хүрээлэн буй орчин нь нийгмийн харилцааны болон → бүтцүүдийг (→ хүрээлэл) илэрхийлдэг. Энэ нь → хувь хүмүүст шууд болон шууд бус байдлаар нөлөөлдөг. Нийгмийн хүрээлэн буй орчин нь хүмүүсийг, → институцийг болон соёлын уламжлалыг (→ соёл) өөртөө агуулдаг бөгөөд үүгээр хувь хүний үйлдэл болон бодол санаа чиглүүлэгддэг. Системийн онолоор нийгмийн системийн гадна орших ихэнх зүйлс үүсдэг бөгөөд хүрээлэн буй орчин нийгмийн системийг бүрдүүлдэг. *Хүрээлэн буй орчны дотоод нийгмийн систем* нь нэг талаас нийгмийн бусад системийг бүрдүүлдэг бөгөөд нөгөө талаас нийгмийн хэсгээс бүрдээгүй *нийгмийн гадаад хүрээлэн буй орчин* гэсэн хоёр ялгаатай байдлаас бүрдэнэ. 1970 он хүртэл “Хүрээлэн буй орчин”

гэх ухагдахуун нь социологид ерөнхий байгалийн болон нийгмийн хүрээлэн буй орчин гэсэн агуулгаар ашиглагдаж байсан. Хүрээлэн буй орчны асуудлууд болон социологи дохь хүрээлэн буй орчны агуулга нь их дээд сургуулиудад социологийн нэг судалгааны чиглэл болон хэлэлцэж эхлэхтэй зэрэгцэн энэхүү мэргэжлийн агуулгын дотор “хүрээлэн буй орчин” гэдэг нь юуны түрүүнд хүний байгаль дахь хүрээлэн буй орчныг илэрхийлж байв. William R. Catton und Riley E. Dunlap нар нь өөрсдийн хийсэн судалгаа “хүн ба байгалийн хүрээлэн буй орчны харилцан үйлчлэл”-ийн ажиллагаагаар социологид хүрээлэн буй орчны агуулга бий болоход чухал хувь нэмэр оруулсан байдаг (»Environmental Sociology«, in: *Annual Review of Sociology* 5, 1979). Социологи дахь хүрээлэн буй орчны судлагдахуун нь нийгмээс үүдэлтэй шалтгаан, хүрээлэн буй орчны үр дагавар, хүрээлэн буй орчны асуудлуудын харилцаа болон түүний танин мэдэхүйг, орчны талаарх үйл ажиллагааг авч судалдаг байна. Социологи дахь хүрээлэн буй орчны судалгааны гол судлагдахуун нь хүний байгаль дахь хүрээлэн буй орчны харилцан хамаарлыг, түүний түүхэн болон соёлын олон төрөл хувилбаруудыг судлахад чиглэнэ. Олон төрлийн ойлголтоос үүдэлтэй байдаг янз бүрийн байгалийн үзэгдэл, түүний үр дагаврыг судалж байна. Ямар нийгмийн хөгжил нь хүний байгаль дахь хүрээлэн буй орчны сүйрэл болон өсөн нэмэгдэж буй өөрчлөлтийг үүсгэж байгааг судалгааны асуулт болгон авч үзэж байна.

Хүрээлэн буй орчны дискурс нь байгаль орчны асуудлуудын дискурсийн төрөл, хэлбэрийг болон

→ мэдээллийн хэрэгслийн чиг үүргийг судалдаг. Хэзээ, ямар төрлийн хэлбэрээр байгаль дахь хүрээлэн буй орчны өөрчлөлт хүрээлэн буй орчны асуудлууд болж гэдгээр хүлээн зөвшөөрөгдөхийг мөн судалж байна. Социологи дахь хүрээлэн буй орчны өөр нэг гол чиглэл бол төрөл бүрийн нөхцөлийг судлах бөгөөд эдгээр нөхцөлүүд нь хувь хүний, → байгууллагын болон → төрт улс орны үйл ажиллагааг хүрээлэн буй орчинд ээлтэй байхад чиглүүлдэг (Andreas Diekmann / Axel Franzen, *Kooperatives Umweltverhalten*, 1995; Peter Preisendörfer, *Umwelteinstellungen und Umweltverhalten in Deutschland*, 1999; Alfred Endres / Cornelia Ohl, »International Environmental Cooperation in the One Shot Prisoners' Dilemma«, in: *Journal of Applied Social Science Studies* 121, 2003).

Хүрээлэн буй орчинд ээлтэй байхыг дэмжих, хүрээлэн буй орчны асуудлыг ихсэхгүй байхын тулд олон төрлийн онолын үзэл баримтлалын хүрээнд социологи дахь хүрээлэн буй орчны судалгаа өөрийн гарцыг хайж байна. Ulrich Beck (*Risikogesellschaft. Auf dem Weg in eine andere Moderne*, 1986) шинэчлэлийн онолын харах өнцгөөс байгаль дахь хүрээлэн буй орчны өөрчлөлтөөр болон орчин үеийн даяаршил, эргэж буцах, хянах боломжгүй хүрээлэн буй орчны эрсдэлүүд үүсдэг болохыг анхааруулж, эдгээр нь орчин үеийн нийгмийг эрсдүүлэхийг сануулсан байна. Bruno Latour (*Wir sind nie modern gewesen. Versuch einer symmetrischen Anthropologie*, 1995) нь хүрээлэн буй орчны асуудлууд нэмэгдэж байгааг нийгмийн болон байгалийн хооронд гэсэн хатуу ялгаатай авч үзэж байгаад оршиж байгааг тэмдэглэсэн. Учир нь энэ байдал үргэлж шинэ

технологийн хөгжлийг легитим болгож байна. Latour-ийн оролцогч-сүлжээний онолоор (→ сүлжээ) нийгмийн болон байгалийн хооронд эцэс төгсгөлгүй сүлжилдсэн байдаг гэдгийг харуулахыг зорьсон. Niklas Luhmann (*Ökologische Kommunikation. Kann die moderne Gesellschaft sich auf ökologische Gefährdungen einstellen?*, 1986) системийн онолын үзэл баримтлалын харах өнцгөөс нийгмийн системүүд нь өөрөө өөртөө хамааралтай нэгдмэл байдлын улмаас зөвхөн хязгаарлагдсан хариу үйлдэл байгаль дахь хүрээлэн буй орчны сүйрэл болон өөрчлөлтөд үзүүлдэг болохыг сануулж байжээ. Экологийн харилцаа нь зөвхөн системийн дэд хэсэгт кодын дагуу явагддаг. → Рационал сонголтын онол нь хэзээ оролцогч талууд хүрээлэн буй орчны эсрэг эсвэл ээлтэй байдлаар үйл ажиллагаа эрхлэхээр шийдсэн тухай танин мэдэхүйг олж авдаг. Энэхүү танин мэдэхүйгээр, хэрэв байгаль дахь хүрээлэн орчны ашиглалтаар олон оролцогч талууд “хязгаарлагдмал нөөцийг үр ашигтай” (*Allmende-Dilemma*) ашиглах асуудалтай тулгарсан бол рационал оролцогч тал хүрээлэн буй орчинд ээлтэй бус байдлаар ажилладаг болохыг онцолж байсан. Өөрөөр хэлбэл, оролцогч талуудын өөрийг гэмтээх асуудал нь чөлөөтэй ашиглах боломжтой нөөцийг хэтрүүлэн ашиглах замаар үүсэх бөгөөд энэ нь коллектив үр дүнгийн хүрээд хувь хүний рационал зан үйл юм: Garrett Hardin («The Tragedy of the Commons», in: *Science* 162, 1968, dt. in: *Gefährdete Zukunft*, hrsg. von Michael Lohmann, 1970).

Karl-Werner Brand / Fritz Reusswig: Umwelt. In: Hans Joas (Hrsg.): Lehrbuch der Soziologie, Frankfurt a. M. / New York 2001. S. 557–575.

Andreas Diekmann / Carlo C. Jaeger (Hrsg.): Umweltsoziologie. Opladen 1996.

Andreas Diekmann / Peter Preisendörfer: Umweltsoziologie. Eine Einführung. Reinbek 2001.

Joseph Huber: Perspektiven der Umweltsoziologie. In: Barbara Orth [u. a.] (Hrsg.): Soziologische Forschung: Stand und Perspektiven. Ein Handbuch. Wiesbaden 2003.

Matthias Groß: Natur. Bielefeld 2006.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл (Medien)

“Хэвлэл мэдээллийн хэрэгсэл” (латинаар *medium* = “дундах”; англиар *media* буюу *mass media*) гэдгийг ерөнхийдөө харилцаа холбооны харилцааг бий болгоход шаардлагатай, харилцагчдыг холбох “хэрэгсэл” гэж ойлгодог. Явцуу утгаараа бол “хэвлэл мэдээллийн хэрэгсэл” нь мэдээлэл дамжуулах техникийн аппарат хэрэгслүүд, нийгмийн →институциуд (жишээ нь, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл; →масс), өргөн утгаар авч үзвэл бэлгэдлийн утгыг (→символ) хэлэлцэхэд шаардлагатай нийгмийн бүх хувилбарууд (жишээ нь, →соёл, хэл) гэж ойлгогдоно. Нарийвчилсан ойлголт нь харилцаа холбооны нэр томъёонд суурилахдаа ихэвчлэн →харилцаа холбоог илгээгч ба хүлээн авагчийн хооронд мэдээ (мэдээлэл) дамжуулна гэж тодорхойлдог. Ингэхдээ

хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг бол аль болох саадгүй нэвтрүүлэлтийг (дамжуулалт) баталгаажуулах явдал юм. Нөгөө талаас, хэвлэл мэдээллийн хэрэгслийн өргөн хүрээний ойлголт нь харилцаа холбооны нэр томъёонд суурилахдаа түүнийг жишээлбэл, нийтлэг утгыг бий болгоно (жишээ нь, соёлын → зан үйлээр дамжуулан; James W. Carey, *Communication as Culture*, 1989) гэж ойлгож, эсвэл системийн онолд (→ систем) бэлгэдлийн хувьд ерөнхийлсөн харилцаа холбооны мэдээллийн хэрэгслийг (мөнгө, эрх мэдэл, → хууль гэх мэт) ашиглахыг шаарддаг.

Дэлхийн II дайны түүхэн үеийн цаад шалтгаанаар социологи, улс төрийн шинжлэх ухааны олон нийтийн мэдээллийн хэрэгслийн судалгаа АНУ-д ахицтай байсан. Эхэндээ сонирхол нь голчлон хэвлэл мэдээллийн хэрэгслийг мэдээний суртал ухуулга, сурталчилгааны нөлөөнд чиглүүлж байсан бөгөөд ингэхдээ зан харилцааны *Stimulus-Response-Model* (өдөөлт/хариу үйлдэл үзүүлэх загвар)-ыг үндэс болгож байв (хэвлэл мэдээллийн нөлөөнд идэвхгүй автсан үзэгчдийг таамаглаж байсан). Мэдээллийн технологиос (*Claude E. Shannon / Warren Weaver, The Mathematical Theory of Communication*, 1949, dt. 1976) гаралтай дамжуулалтын загвар (илгээгч–хэвлэл мэдээллийн хэрэгсэл–хүлээн авагч) Harold D. Laswell («The Structure and Function of Communication in Society», in: *The Communication of Ideas*, hrsg. von Lyman Bryson, 1948)-ын “хэн ямар сувгаар хэнд юу хэлж, ямар нөлөө үзүүлэв?” гэсэн томъёоллоор дамжин нийгмийн шинжлэх ухаанд

хамааралтай болсон. Өмнөх үеийн → шүүмжлэлийн онолд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь үзэгчдэд ертөнцийг үзэх үзлийн хувьд ялгаатай байсан хэдий ч тэд ижил төстэй байдлаар асар их нөлөө үзүүлдэг гэж үздэг. Max Horkheimer, Theodor W. Adorno (*Dialektik der Aufklärung*, 1947) нар олон нийтийн мэдээллийн хэрэгслийг олон нийтийг хууран мэхлэх технологи гэж ойлгодог байсан бөгөөд энэ нь тодорхой → идеологи түгээхэд төдийлөн үйлчилдэггүй, харин одоогийн нөхцөл байдлын талаарх шүүмжлэлт бус хүлээн зөвшөөрөлтийг үйлдвэрлэдэг фабрик бий болоход тусалсан. Энэхүү шалтгааны улмаар тэд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэдэг явцуу ойлголтыг “соёлын үйлдвэрлэл” болгож сольсон. Энэ үзэл санааг үргэлжлүүлэн Jürgen Habermas (*Strukturwandel der Öffentlichkeit*, 1962) арилжааны болгосноос үүдэлтэй дампуурал, улам нэмэгдэж буй иргэдийн → олон нийтийн “гэрээслэл”-ийн тухай бичиж байв. Нөгөөтээгүүр, Британийн хэвлэл мэдээлэл ба соёлын судалгаанд үзэгчдийн идэвхгүй хүлээн авагчийн үүргийг өөрөөр харсан байдаг (David Morley, *The »Nationwide« Audience*, 1980), Үзэгчид бол олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн нөлөөнд авралгүйгээр автаад байдаггүй, харин ч хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээ мэдээллийг идэвхтэй хэлэлцдэг (энэ нь харилцааны загварт соёл, өөрөөр хэлбэл зан үйлээр нийцдэг). Бирмингемийн их сургуулийн орчин үеийн соёл судлалын төвд 1970-аад онд боловсруулсан хэвлэл мэдээллийн судалгааны дагуу олон нийтийн хэвлэл

мэдээллийн хэрэгсэлд нийгмийг тайлбарлах хүчний төлөөх тэмцэлд гол үүрэг оноогдож байна (Stuart Hall [u. a.], *Culture, Media, Language*, 1980). Энэхүү хандлагын дагуу аливаа үйл явдлыг утга учиртай болгох хүч нь (Horkheimer/Adorno-той адил) олон нийтийг хууран мэхлэх соёлын үйлдвэрлэлийн үйлчилгээнд оршдоггүй, харин олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр илэрхийлэх, хамгийн хурц зэвсгээ олж авдаг нийгмийн хүчний харилцааны хөдөлгөөнт бүтээгдэхүүн юм. Сүүлийнх нь нийгмийн → бүлгүүдийг зураг, санааны хувилбараар хангадаг. Энэ нь тэдэнд нийгэмд бүхэлдээ, бусад бүлгүүдтэй харьцахад нь өөрийгөө олох боломжийг өгдөг. Тиймээс олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийгмийн хүчнүүд өөрсдийн талын байр суурийг нийтээр заавал дагаж мөрдөх зөвшилцөл болгон өргөжүүлэхийн төлөө тэмцэлдэнэ.

Talcott Parsons (*Zur Theorie der sozialen Interaktionsmedien*, 1980)-ын хэвлэл мэдээллийн талаарх үзэл баримтлалыг ашиглан Niklas Luhmann (*Die Gesellschaft der Gesellschaft*, 1997) харилцааны мэдээллийн хэрэгслийг дотор нь хэл яриа түгээх мэдээллийн хэрэгсэл, бэлгэдэл шингээсэн харилцааны хэрэгсэл гэж ялгаатай авч үздэг. Түгээх мэдээллийн хэрэгсэл нь (бичихээс эхлээд өнөөдрийн харилцаа холбооны хэрэгсэл хүртэл) алсын зайнаас харилцаа холбоог техникийн хувьд боломжтой болгож байхад, бэлгэдэл шингээсэн харилцааны хэрэгсэл гэдэгт (мөнгө, шинжлэх ухааны үнэн, эрх мэдэл, хууль гэх мэт) тэрээр нийгмийн харилцааны тогтолцоонд бас “хүсээгүй”

харилцааг хүлээн авах магадлалыг нэмэгдүүлсэн мэдээллийн хэрэгслийг ойлгож байв (тиймээс улс төрд олон тооны сонирхлын зөрчилдөөнийг сөрөн шийдвэрээ гаргахын тулд эрх мэдэл хэрэгтэй). Эцэст нь Luhmann олон нийтийн мэдээллийн хэрэгслийг нарийвчилсан утгаар нь хоёртын (хоёр утгат) кодчилол дээр үндэслэн мэдээлэл/мэдээлэл бишийг нийгмийн үйл ажиллагааны системд ялгаж болох түтээлтийн мэдээллийн хэрэгсэл гэж үзсэн. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь → орчин үеийн нийгмийг тодорхойлох олон нийтийн үзэл бодлыг мэдээллийн хэрэгслээр дамжуулах боломжийг бүрдүүлсэн; учир нь Luhmann-ын хэлснээр, энэ нийгмийн талаар мэдэж байгаа зүйлээ бид “олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулаад мэдэж авсан” (*Die Realität der Massenmedien*, 1996).

Oliver Marchart

Denis McQuail / Sven Windhal: *Communication Models for the Study of Mass Communication*. London / New York 1993.

Lawrence Grossberg [u. a.] (Hrsg.): *Media Making. Mass Media in a Popular Culture*. London 1998.

Klaus Neumann-Braun Stefan Müller-Dohm (Hrsg.): *Medien- und Kommunikationssoziologie. Eine Einführung in zentrale Begriffe und Theorien*. Weinheim/ München 2000.

Georg Christoph Tholen: *Medium, Medien*. In: Alexander

Roesler Bernd Stiegler (Hrsg.): Grundbegriffe der Medien-
theorie. Stuttgart 2005. S. 150–172.

Werner Faulstich: Mediengeschichte. 2 Bde. Göttingen
2006.

Хэм хэмжээ/Зөрчил (Norm/Devianz)

Нийгмийн хэм хэмжээ (латинаар *norma* = “заавар”, “дүрэм”)–г социологийн түвшинд дагаж мөрдөх ёстой зан үйлийн дүрэм гэж үздэг. Нэр томъёог ялгах чухал шалгуур үзүүлэлт бол хүлээлтэд нийцсэн хамаарлын түвшин юм. Үүний дараагаар байх ёстой, хийх ёстой, хийж болно гэсэн хэм хэмжээг ялгаж заагадаг. Энэхүү хэм хэмжээний үзэл баримтлал нь-ихэвчлэн далд хэлбэрээр-хүмүүс зөн совин багатай, төрөлхийн зан авир итгэлгүй тул албадлагын шинж чанараас хамааралтай гэх таамаглал дээр суурилдаг.

Нийгмийн хэм хэмжээний талаарх ойлголтыг албан болон албан бус нийгэмшүүлэх агентлаг, бүтцийн нэгж (→ нийгэмших), мөн дийлэнх тохиолдолд → гэр бүл, орчин үеийн → нийгэм-сургууль (→ боловсролын байгууллага) олгодог. Агентлаг, бүтцийн нэгжээр дамжих нийгмийн хэм хэмжээ нь эдийн засаг, улс төр, ертөнцийг үзэх үзлийн чиг баримжаанд төвлөрсөн эрх мэдлээс улбаатай хэм хэмжээний хувилбаруудыг ихэвчлэн төлөөлдөг. Нийгмийн хэм хэмжээний хүчин төгөлдөр байдал нь эдгээр эрх мэдлийн нөлөөллийн хүрээнээс хамаарч харилцан адилгүй байдаг. Хэм

хэмжээг тогтоох эрх мэдлийн өрсөлдөөн нийгмийн хэм хэмжээний өрсөлдөөнд, улмаар хувь хүний хэм хэмжээний зөрчилдөөнд хүргэж, үймээн самуун дэгдэх, нийгэмд эмх замбараагүй байдал үүсэхэд хүргэж болзошгүй юм. Сүүлийн хэдэн арван жилд хэм хэмжээний ухагдахууны талаарх социологийн мэтгэлцээнийг голчлон бэлгэдлийн интеракционизмын төлөөлөгчид хөндөж байв. Тэд хэм хэмжээний ухагдахууны объектив шинж чанарыг шүүмжилдэг. Нийгмийн хэм хэмжээ нь дээрх аргачлалын дагуу хэл шинжлэлийн бүтэц хэлбэрээр орших боловч объектив бодит дүрэм гэж байхгүй. Илүүтэйгээр үйлдлийн нөхцөл байдлаас шалтгаалж идэвхжих (→ үйлдэл) → оролцогчдын төсөөлөл юм. Эдгээр нь тухайн нөхцөл байдлаас үүдэлтэйгээр аливаа үйлдэлд чиглэсэн шалтгаан болдог (*Alltagswissen, Interaktion und gesellschaftliche Wirklichkeit, Bd. 1, hrsg. von einer Arbeitsgruppe Bielefelder Soziologen, 1978*).

Зөрчил (*гажуудсан зан байдал*; латинаар “*deviare*” = “замаас хазайх”) -ыг олон янзаар тайлбарладаг. Обьективист ойлголтоор зөрчил гэдэг нь хэм хэмжээнээс гажсан гэсэн үг; интеракционист ойлголтын хувьд зөрчил нь нийгэмд тодорхой байр суурь эзлэх иргэн, эсвэл бүтцийн нэгж гажсан үйлдлийг хэлдэг. Гэмт хэрэг бол зөрчлийн хамгийн чухал төрөлд тооцогддог. Зөрчигдсөн зан байдлын социологи эхлээд зөрчигдсөн зан үйлийн объективист тодорхойлолтод үндэслэсэн. Энэ төрлийн социологийн сонгодог жишээ бол Robert K. Merton юм. Тэрээр орчин үеийн нийгэм дэх зөрчлийг

нийгмийн соёл, нийгмийн онцлогтой холбоотой гэж үзжээ. Merton-ы хэлснээр орчин үеийн нийгэм дэх хүмүүсийн дийлэнх нь “материаллаг амжилт”-ын “соёлын зорилго”-д чиглэдэг байна. Нийгмийн дээд давхаргын гишүүдтэй харьцуулахад доод давхаргад харьяалагдах хүмүүс (→ анги) өөрчилж болохуйц хэм хэмжээний хүрээнд уг зорилгод хүрэх боломж маш хязгаарлагдмал. Тиймээс “зөрчил гаргах хамгийн их дарамт доод түвшнийхэнд илүүтэй байдаг” (*Social Structure and Anomie* 1961, dt. 1968). Орчин үеийн нийгэмд чиглүүлэх хэм хэмжээ бага тул эдгээр давхаргын гишүүд энэхүү дарамтыг тэсвэрлэхгүй байх хандлагатай байдаг. Merton-ы анх 1938 онд гаргасан онол хэдэн арван жилийн турш өмчийн эсрэг гэмт хэргийн социологийг тодорхойлж ирсэн. Тэр цагаас хойш Merton-ы онцолсон давхаргын хувьсагч нь социологид бүхэлдээ зөрчил гаргах үйлдлийн, ялангуяа түрэмгийллийн шинж чанартай гэмт хэргийн социологид ихээхэн анхаарал хандуулахад нөлөөлсөн (Albert K. Cohen, *Delinquent Boys: The Culture of the Gang*, 1955). Голчлон суралцах, нийгэмшүүлэх онолд тулгуурласан криминологичид эсрэг байр суурийг илэрхийлэх бөгөөд төлөөлдөг байна. Тэд гэмт үйлдлийг гэмт хэргийн бодит кейст суралцсаны үр дүн, (Donald R. Cressey, *Delinquency, Crime and Differential Association*, 1964) эсвэл хангалтгүй нийгэмшүүлсний, өөрөөр хэлбэл баталгааг бүрэн хангаж чадаагүйн үр дүн гэж үздэг (Michael R. Gottfredson / Travis Hirschi, *A General Theory of Crime*, 1990; John Hagan, *Structural Criminology*, 1989).

Энэ бүх зөрчлийн онолд зөрчил болон гэмт хэрэг нь баримт хэлбэрээр оршдог гэсэн таамаглал дээр тулгуурладаг. Интеракционист онолд суурилсан социологичид энэхүү таамаглалд шүүмжлэлтэй ханддаг. Зөрчил болон гэмт хэрэг бол ихэвчлэн бусдын үйлдлийн шинж тэмдэг юм. Энэхүү аргачлалын дагуу бусдын үйлдлийг субъектив → сэдэлжүүлэх аргаар тодорхойлдог. Энэхүү хамаарал нь эдгээр үйлдлүүдийг багтаасан гэж үзэх нөхцөл дээр үндэслэсэн тул мөн тайлбарлах үйл явц гэж үздэг. “Зөрчлийн” эсвэл “гэмт хэргийн шинжтэй” үйлдэл хэмээх тодорхойлолт ялгаагүй тайлбарын үр дүн юм. Иймээс зөрчил болон гэмт хэргийн талаар судлахыг хүсвэл дээрх тайлбарыг дахин авч үзэх шаардлагатай (Wolfgang Keckeisen, *Die gesellschaftliche Definition abweichenden Verhaltens*, 1974). Эдгээр таамаглалыг эрүүгийн гэмт хэргийн социологийн хэлэлцүүлэгт дэвшүүлэхдээ шошголох аргачлалыг хэрэглэсэн гэхэд болно. Гэмт хэрэг бол атрибуцийн үр дүн гэх таамаглал нь олон тооны социологичдод функционалист тайлбарыг бий болгоход түлхэц өгсөн. Тухайлбал, капиталын төлөө гэмт хэргийн шинж байдлыг тодорхойлох функциональ үйл ажиллагааг нэхэмжилсэн тохиолдол бий (Helga Cremer-Schäfer / Heinz Steinert, *Straflust und Repression*, 1998; → Капитал).

Helge Peters

Heinrich Popitz: Soziale Normen. In: Archives Européennes de Sociologie 2 (1961). S. 185–198.

Siegfried Lamnek: Theorien abweichenden Verhaltens. München 1979, 7 1999, Nachdr. 2001.

– Neue Theorien abweichenden Verhaltens. München 1994.
Helge Peters: Devianz und soziale Kontrolle. Weinheim/München 1989, ²1995.

Хяналт (Kontrolle)

Социологийн ойлголтод “хяналт”-ын талаар өөр хоорондоо ялгаатай хоёр тодорхойлолтыг үндсэнд нь ялгадаг. Нэг талаас, энэ ухагдахуун нь нийгмийн нийцтэй байдалд нөлөөлөх нийгмийн үйл явцыг тодорхойлдог. Нөгөө талаас, “хяналт” нь үйл ажиллагаа явуулж буй тухайн нийгмийн → тогтолцоонд нийгэмд нийцтэй байдлыг хадгалах эсвэл сэргээхэд чиглэсэн үйл ажиллагаанд тооцогддог. Үүнээс үзэхэд, нийгмийн хяналт нь зөвхөн иргэдийн нийцтэй байдлыг хангахад чиглэдэггүй, харин тэднийг нийгмийн тогтолцооноос гаргах нь ч бас хяналтын нэг тохиолдол болж болно.

Нийгмийн хяналтын тухай ойлголтыг ХХ зууны эхэн үед Америкийн социологич Edward A. Ross нэвтрүүлжээ (*Social Control. A Survey of the Foundation of Order*, 1901). Тэрээр нийгмийн хяналтыг гол төлөв нийгмийн үйл явцын болон → институциудын нэг бүрэлдэхүүн хэсэг гэж ойлгож байв. Энэхүү институцчиллийн хувьд ялгараагүй хяналтын тухай ойлголт 1960-аад

он хүртэл АНУ-д социологийн бүх сургуульд байсан. Энэхүү ухагдахуун нь Германы социологид 1958 онд René König-ийн *Fischer Lexikon Soziologie* сэтгүүлд хэвлүүлсэн дэлгэрэнгүй нийтлэлээр дамжин нэвтэрсэн байдаг бөгөөд энд нийгмийн “хяналт”-ыг нарийн зохицуулалттай нийгмийн оршин тогтнохуйн чухал хэсэг гэж тодорхойлсон байна. Гэвч энэ тодорхойлолт удалгүй хүчин төгөлдөр бус болсон юм. Хяналт бол тодорхой хэмжээнд нийгмийн “үл үзэгдэх гар” (*invisible hand*)-ын байгалийн шинж юм гэдэг ойлголтыг халсан байдаг. Үүнээс илүүтэй хянагч байгууллагуудын “үзэгдэх гар”-аар хяналтыг гүйцэтгэнэ гэдэг ойлголтыг хүлээн зөвшөөрөх болсон (Andrew T. Scull, »The New Sociology of Social Control«, in: *Handbook of Sociology*, hrsg. von Neil J. Smelser, 1988).

Ингэснээр зөвхөн энэхүү ухагдахууныг төдийгүй нийгмийн хяналтын объектыг ч бас тодорхой болгож байгаа юм. Энэ нь хэм хэмжээний (→ норм) гажуудлыг таслан зогсоох, ялангуяа гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ гэж ойлгогдоно. Гол хараанд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн байгууллага, цагдаагийн байгууллага байхаас гадна мөн нийгмийн ажил, нийгмийн бодлого, улс төр орж ирнэ. Ийнхүү хоёр хэмжүүрээр дүрсэлж болохуйц хяналтын олон төрлийн санаанууд холбогддог: Нэг талаас, хэм хэмжээ зөрчигдөх (сэжиг төрөх)-ийн өмнө эсвэл дараа нь арга хэмжээ авах эсэх тухай асуудал яригдана; нөгөөтээгүүр, хэм хэмжээ зөрчигдөх шалтгааны талаарх хяналтын горимыг тодорхойлох таамаглалын асуудлыг

хөнддөг. Үндсэндээ тавигдсан *нөхцөлүүдээс* шалтгаалсан хэм хэмжээний зөрчил үү эсвэл сөрөг хориг арга хэмжээг болиулах гэсэн зөрчил гаргагчийн *хүсэл эрмэлзлээс* үүдэлтэй хэм хэмжээний зөрчил үү гэдгийг хооронд нь ялгаж салгах болно. Эдгээр хэмжүүр дээр үндэслэн хяналтын дөрвөн төрлийг хуваан үзэж болно: (1) хэм хэмжээг зөрчихөөс өмнө: сөрөг хориг арга хэмжээ авах нөхцөлүүдийн талаарх мэдэгдэл, жишээ нь, эрүүгийн хууль, (2) хэм хэмжээг зөрчсөний дараа: сөрөг хориг арга хэмжээ, жишээ нь, эрүүгийн шийтгэл, (3) хэм хэмжээг зөрчихөөс өмнө, нөхцөл байдлын өөрчлөлт, жишээ нь, нийгмийн бодлого (хяналтын зорилго нь танигдах боломжтой үед), (4) хэм хэмжээг зөрчсөний дараа, нөхцөл байдлын өөрчлөлт, жишээ нь, нийгмийн ажил (хяналтын зорилго нь танигдах боломжтой үед).

Нийгмийн хяналтын үр нөлөөний судалгаагаар хяналт нь нийцтэй байдлын зорилгоо ихэнхдээ алддаг болохыг тодорхой харуулжээ. Энэхүү бүтэлгүйтлийг хоёр янзаар тайлбарладаг: Нэг талаас, шийтгэлийн хяналт нь хянагдагчийн хэм хэмжээний зөрчлийг ихэвчлэн улам бэхжүүлж байдаг (гэмт хэргийн карьер) гэж үздэг; нөгөө талаас, нийгмийн хяналтын шийтгэл ногдуулдаг байгууллагууд үйлдэлд эхлээд гажуудалтай зан үйл гэсэн нэр зүүснээрээ бусдын ойлголтод түүний хэм хэмжээг зөрчих баталгааг өгч байдаг (*Labeling Approach*).

Одоогийн байдлаар нийгмийн хяналттай холбоотой гурван чиг хандлага гарч ирж байна: (1) Урьдчилан мэдээлэл цуглуулах (жишээ нь, видео хяналтаар дамжуулан), (2) хувьчлах (жишээ нь, хувийн хамгаа-

лалтын албаар дамжуулан), (3) нийгмийн халамжит төр байхаа болих (жишээ нь, нийгмийн халамжийн бодлогыг хумих замаар). Хяналтын талаарх сүүлийн үеийн ажлуудад (жишээлбэл, David Garland, *The Culture of Control. Crime and Social Order in Contemporary Society*, 2001) эдгээр гурван чиг хандлагыг улс төрийн удирдлагын арга барилын сүүлийн үеийн хөгжилтэй холбож үздэг. Голчлон Michel Foucault (жишээлбэл, »Das Subjekt und die Macht«, in: Hubert L. Dreyfus [u. a.], *Jenseits von Strukturalismus und Hermeneutik*, 1987), David Osborne, Ted Gaebler (*Reinventing Government*, 1993) нарын бүтээлтэй холбогдуулан авч үзвэл, → улс нь засаглаж байхдаа “удирдахад” илүүтэй төвлөрөөд “чиглүүлэхэд” бага анхаардаг зохицуулалтын байгууллага юм гэдэгтэй санал нэгджээ (Clifford Shearing, »Die politische Produktion von Sicherheit«, in: *Kriminologisches Journal* 37, 2005, Nr. 2). Улам ихээр “зайнаас” удирддаг болж байна. Хэм хэмжээг зөрчдөг асуудлыг шийдвэрлэх тухайд нөхцөлийг өөрчлөх хяналтыг зөвхөн шаардлагад нийцсэн аюулгүй байдлын хяналтаар сольж, ингэхдээ улам бүр хувьчлах замаар, хяналтын шинэ техникүүдийг ашиглан хэрэгжүүлнэ гэсэн үг юм.

Helge Peters

Stanley Cohen: *Visions of Social Control. Crime, Punishment and Classification*. Cambridge [u. a.] 1985.

Sebastian Scheerer: »Soziale Kontrolle« – schöner Begriff für böse Dinge? In: Helge Peters (Hrsg.): *Soziale Kon-*

trolle. Zum Problem der Normkonformität in der Gesellschaft. Opladen 2000. S. 153–169.

Helge Peters: Soziale Probleme und soziale Kontrolle. Wiesbaden 2002.

Herman Roodenburg / Pieter Spierenburg (Hrsg.): Social Control in Europe. Columbus 2004.

Цаг хугацаа (Zeit)

Цаг хугацаа гэдгийг ерөнхийд нь бодит эсвэл бие махбодын цаг хугацаа гэсэн утгаар нэг бол үйл явдлын залгамж чанарын бодит бүтэц, нөгөөтээ гүүр, календарь, цаг, нийгмийн хэмнэлд зохион байгуулалттайгаар тусгагддаг нийгэм, соёлын хэлцэл гэж ойлгодог. Цаг хугацааны тухай ойлголт үзэл санааны хувьд урт удаан түүхэн уламжлалтай. Тэдгээрийн төвд бодит цаг хугацаа болон цаг хугацааны туршлагын хоорондох хамаарлыг тайлбарлах оролдлого үргэлж байв. Философийн бусад ухагдахууны нэгэн адил цаг хугацааны тухай ойлголт ч туршлагаас үл хамаарах онтологийн хэмжигдэхүүнээс туршлагын тухай ойлголт болж өөрчлөгдсөн.

Социологийн хувьд нийгмийн цаг хугацааны туршлагыг онцлох болсноор цаг хугацааг онолын үүднээс судлах ажил эхэлсэн. Pitirim A. Sorokin, Robert K. Merton нар »Social Time. A Methodological and Functional Analysis« (in: *American Journal of Sociology* 42, 1937) төлөвлөгөөт өгүүлэлдээ бие даасан дэлхийн хэмжигдэхүүн гэж үздэг цаг хугацааны онтологийн бүтцийн тодорхой үндэслэл

нь цаг хугацааг нийгэмд бий болсон зүйл гэж ойлгогдох нөхцөлийг хааж байгааг онцолжээ. Социологийн үүднээс авч үзвэл, цаг хугацааг нийгмийн цаг гэж ойлгодог, өөрөөр хэлбэл, нийгэмд үүсэж, нийгмээр дамжиж, тэнд зохион байгуулагдаж байгаа дараалсан, давхардсан үйл явдлуудын процессын бүрдэл юм.

Социологийн цаг хугацааны хамгийн боловсронгуй онолууд нь нэг талаар цаг хугацааны дотоод мэдрэмжийн феноменологийн онолоос үндэслэлтэй, нөгөө талаар Америкийн прагматизмаас улбаатай байдаг. Эхний тохиолдлын хувьд юуны түрүүнд Alfred Schütz (*Der sinnhafte Aufbau der sozialen Welt*, 1932; → феноменологийн социологи)-ийн Edmund Husserls (*Vorlesungen zur Phänomenologie des inneren Zeitbewußtseins*, 1928)-ийн цаг хугацааны феноменологийн онолоос боловсруулсан хувиргалт орно. Schütz-ийн үзсэнээр, мэдрэмжийн асуудал бол цаг хугацааны асуудал юм. → Мэдрэмж нь үргэлж одоо цагт бий болдог боловч өнгөрсөн үеийн хуримтлагдсан туршлага болон ирээдүйн хүлээлтээс бүрэлддэг. Нийгмийн харилцаанд хувь хүмүүсийн янз бүрийн цаг хугацааны/мэдрэмжийн бүрдлүүд таарч, улмаар амьдралын цаг хугацааны бүтцийг бий болгодог.

Цаг хугацааны нэлээд прагматик социологийн төлөөлөгч бол George Herbert Mead юм (*The Philosophy of the Present*, 1932, dt. 1969). Түүний хувьд цаг хугацаа гэдэг бол үйлдлийн урьдчилсан нөхцөл биш, харин түүнийг баримжаалах цэг ажээ. Өөрөөр хэлбэл, үйлдлүүд нь тус тусын үйл явдлаар дүүрэн оршихуйн дараалалдаа цаг

хугацааны бүтцийг бий болгодог бөгөөд энэ нь юун түрүүнд үйлдлийн ирээдүйд чиглэсэн шинж чанарт оршдог. Schütz хувь хүний, дотоод субъектив туршлага хуримтлуулах явдлыг цаг хугацаагаар хэмжиж байсны адилаар Mead нийгмийн үйл ажиллагаануудаас туршлага хуримтлуулахыг цаг хугацаагаар хэмжсэн. Mead-д социологи талархах шалтгаан бол тэрээр Alfred North Whitehead (*Process and Reality*, 1929, dt. 1987)-д тулгуурлаад, дотоод цаг хугацааны мэдрэмжтэй төстэй өөрийн гэсэн, нийгмийн цаг хугацааны бүтцийг үйл явдлаар баялаг байдлаар нь дамжуулан бүтээдэг нийгмийн үйл ажиллагааны процессын шинж чанарын талаарх ойлголтыг бий болгосонд юм. Энэхүү үзэл санааны загварыг Anthony Giddens-ийн бүтцийн онол дахин авч үзсэн байдаг (*The Constitution of Society*, 1984, dt. 1988).

Mead болон Schütz-ийг залгуулаад системийн онолын цаг хугацааны онолууд бас гарч ирсэн. Niklas Luhmann («Weltzeit und Systemgeschichte», in: *Kölner Zeitschrift für Soziologie und Sozialpsychologie*, Sonderheft 16, 1973), Werner Bergmann (*Die Zeitstrukturen sozialer Systeme*, 1981) нар нийгмийн процессын үйл явдалд суурилсан цагийн бүтцийг боловсруулж, нийгмийн нэгж дэх цаг хугацааны бүтцийн нийгмийн цаг хугацааны бүтцээс хамаарах хамаарлыг тодруулсан. Системийн онолын энэ хандлага нь нийгмийн бүхий л процессын цаг хугацааны шинж чанарт анхаарал хандуулаад зогсохгүй, “удаан” улс төр, “хурдан” эдийн засаг эсвэл → гэр бүлийн болон нөхөн үржихүйн цаг хугацааны хувьд нийгмийн бусад үйл

явцтай үл нийцэх байдал гэх мэт янз бүрийн нийгмийн тогтолцоо дахь цаг хугацааны ялгаатай бүтцүүдийн тохиромжтой цагийг юуны түрүүнд судалжээ. Үүний дагуу орчин үеийн цаг хугацааны талаарх нийгмийн онолын дүн шинжилгээнд тулгардаг үндсэн асуудал бол синхрочлол бөгөөд тодруулбал энэ нь хувь хүний болон хувь хүнээс давсан процессын бүтцийг ижил цаг хугацаанд байлгах, гэхдээ ялангуяа чиг үүргийн болоод зохион байгуулалтын ялгаатай системийг синхрончлох тухай асуудал юм (Armin Nassehi, *Die Zeit der Gesellschaft*, 1993). Энэхүү цогц сэдвийн хүрээнд хурдасгах туршлагууд (Hartmut Rosa, *Beschleunigung. Die Veränderung der Zeitstrukturen in der Moderne*, 2005), цаг хугацааны талаарх нийгэм, хувь хүний хоорондох хандлагын зөрчил (Helga Nowotny, *Eigenzeit*, 1989) зэрэг анализууд ч бас багтдаг. Эдийн засаг, улс төр, хэвлэл мэдээлэл, соёлын процессууд → даяарчлалаар синхрочлолын асуудал нэмэгдэж, өөр өөр соёлын цаг хугацааны зан үйлүүд хоорондоо тулгарахын хэрээр цаг хугацааны тухай ойлголт социологийн гол сэдэв хэвээр байх бөгөөд наад зах нь хувь хүний амьдрах цаг хугацаа, амьдралын хэв маягийн хурдасгасан нийгэмд дасан зохицох тухай асуудал нь нийгмийн баримжаат төрийн (→ нийгмийн баримжаат төр), боловсролын бодлого (→ боловсрол), мэргэжлийн (→ ажил мэргэжил) шинэ зохицуулалтад тулгарах чухал сорилтуудын нэг болж байна.

Norbert Elias: Über die Zeit. Frankfurt a. M. 1984.

Günter Dux: Die Zeit in der Geschichte. Frankfurt a. M. 1989.

Barbara Adam: Time and Social Theory. Oxford 1990.

Karl H. Hörning [u. a.]: Zeitpioniere. Flexible Arbeitszeiten – neuer Lebensstil. Frankfurt a. M. 1990, ³1998.

Цөөнхүүд/Гадуурхагдсан бүлэг (Minderheiten/Randgruppen)

Социологид “цөөнхүүд” (англиар *minorities*; францаар *minorités*) гэдэг нь гарал угсаа, арьс өнгө, соёл, шашин эсвэл бусад нийгмийн чухал шинж чанараараа олонхоос ялгардаг → нийгмийн дэд бүлгүүдийг (→ бүлэг) нэрлэдэг. Эдгээр ялгааг цөөнхүүдээс өөрсдийгөө ихэвчлэн давуу гэж үздэг чадалтай олонхын хувьд сөрөг талаас нь харж болох бөгөөд цөөнхийг ялгаварлах, гадуурхах (→ оролцоог хангах/оролцоог хаах) эсвэл дарлах шалтгаан болж, бүр хүнд хэлбэртээ хавчих, хөөх эсвэл үгүй хийх ч шалтгаан болдог. Ямар хүчин зүйлүүд нийгэмд чухал болоод тодорхой дэд бүлгүүдийг их бага хэмжээгээр ялгаварлагдсан цөөнхүүд болох зан төлөвт ингэж нөлөөлж байгаа нь нийгмээс нийгэмд ялгаатай байдаг бөгөөд тэдгээрийн → бүтэц, эрхэмжит зүйлс, → хэм хэмжээнээс хамаардаг. Социологийн цөөнхийн судалгаа 1920-оод оноос АНУ-ын цагаачлалын нийгэм дэх интеграцийн асуудлаарх эмпирик судалгаагаар эхэлж байсан. Robert E. Park (*Race and Culture*, 1950)

эсвэл Louis Wirth (*The Ghetto*, 1928) зэрэг Чикагогийн сургуулийн төлөөлөгчид нь цагаачдын (→ шилжилт хөдөлгөөн) интеграцчилах үйл явцыг судлахдаа цөөнхөд “тэгш бус хандах”, “коллектив гадуурхах” байдлыг нарийвчлан авч судалсан. 1960-аад оноос хойш цөөнх гэдэг нэр томьёо нь шошголох хандлагаар (бас тодорхойлох хандлага ч гэдэг, англиар *Labeling Approach*) дамжин гажууд зан үйлд нөлөөлөх болжээ. Ижил хүйстэн, ялтан, хар тамхинд донтогчдын гэх зэрэг “гаж” бүлгүүд үзэгдэх болсон. Энд цөөнхийг гадуурхаж байгаа гол шалтгааныг тэдний өвөрмөц байдал, онцлог шинж чанараас эрэлхийлэх шаардлагагүй, харин давамгай олонхын ялгаварлан гадуурхсан хандлагад байна гэдгийг онцолж байв (*Howard S. Becker, Outsiders*, 1963, dt. 1973).

Сүүлийн үеийн цөөнхийн судалгаануудад дэлхий даяарх шилжилт хөдөлгөөн нэмэгдэж байгаагийн үр нөлөөгөөр гарал үүсэл, арьс өнгө, соёлын цөөнхүүдийн интеграцийн асуудлыг дахин тэргүүн эгнээнд тавьж эхлээд байна. Германд хамгийн ач холбогдол бүхий цөөнхүүдийг зочин ажилчнаар ирэгсэд, хожуу Герман улсад шилжин суурьшигчид болон цагаачид бүрдүүлдэг. Давхаргын (→ ангийн) шинжилгээний судалгаанаас харахад Герман улс шилжин ирсэн цөөнхүүдээс шалтгаалж бусад нийгмийн хүрээллийн маш “доогуур ангилагддаг”, өөрөөр хэлбэл, шилжин ирэгсэд нь мэргэшлийн шаардлага багатай, орлого доогуур мэргэжлээр буюу жишээлбэл, үйлдвэр, барилга, хоол үйлдвэрлэл, цэвэрлэгээ үйлчилгээний байгууллагуудад

мэргэжлийн бус ажилтнаар ихэвчлэн ажилладагт байна. Шошголох онолын дүн шинжилгээгээр соёлын гадуурхалт, өөрийгөө тусгаарлах хандлага харагддаг.

Цөөнх, олонх зэрэгцэн орших тухай үзэл санаанууд олон янз байдаг. Ассимиляцийн онолоор цагаач цөөнхүүд нь хүлээн авагч орныхоо соёл, нийгэмд аажмаар уусдаг гэж үздэг. Харин олон соёлт нийгмийн үзэл баримтлал бол олон ургалч байдалдаа нэгдмэл байх зарчимд суурилдаг. Цөөнх, олонх нь нийтлэг хэл, дүрэм, суурь эрхэмжит зүйлсийн үндсэн дээр тухайн нийгэм, соёлын онцлогийг харилцан хүндэтгэх маягаар хамтран амьдрах нөхцөлийг бүрдүүлдэг.

“Гадуурхагдсан бүлгийнхэн” (англиар *marginal groups*) гэдэг нэр томьёо нь 1960-аад оноос хойш байнга ашиглагдах болсон. Нийгмийн шинжлэх ухааны болон улс төрийн хэллэгийн аль алинд нь өөр өөр утгаар, заримдаа цөөнхтэй ижил утгаар, заримдаа онцгой тодотголтойгоор хэрэглэгддэг. Уг нь бол үүгээр халамжийн үйлчилгээнээс халамж хүртдэг, ядуу, орон гэргүй, удаан хугацаагаар ажилгүй байгаа, гудамжны хараа хяналтгүй хүүхдүүд гэх зэрэг эдийн засгийн хувьд чадамжгүй, эсвэл бие бялдар, сэтгэц болон сэтгэл зүйн хөгжлийн хувьд бэрхшээлтэй тул нийгмээс гадуурхагдан амьдрах болсон дэд бүлгүүдийг тодорхойлдог. Тэдэнд эдийн засаг, нийгэм, соёл, улс төрийн амьдралд зохих ёсоор оролцох чухал урьдчилсан нөхцөлүүд дутмаг байдаг. Эдгээр нь яг социологийн утгаараа бүлэг биш, харин илүүтэй статистик бүлгүүд буюу өөрөөр хэлбэл, гадаад нийтлэг шинжээрээ тодорхойлогддог

“бүлгүүд” юм. Орчин үеийн → чинээлэг төрт улс тэднийг асуудалтай бүлэгт хамааруулж, аль болох гадуурхагдсан байдлаас нь гаргахын тулд төрийн анхаарал, → хяналт, тусламжийн объект болгодог.

Тоон үзүүлэлтийн хувьд хамгийн их жин дардаг гадуурхагдсан бүлэг болох харьцангуй ядуу бүлгийн хүмүүс дайны дараах хэдэн арван жилүүдэд Германд багассан боловч 1980-аад оноос хойш эргээд тасралтгүй өсөж байна. Энэ чиг хандлагын гол шалтгаан нь ажилгүйдлийн түвшин өндөр байгаатай холбогдох бөгөөд бусад чухал шалтгаанд гэр бүлийн бүтэц дэх асуудлууд (өрх толгойлсон эцэг эх олширч байгаа, олон хүүхэдтэй → гэр бүлүүдэд санхүүгийн тусламж дутмаг) багтдаг. Германд ядуурал нь ихэвчлэн түр зуурын ядуурал байдаг, зөвхөн цөөнхийн хувьд урт хугацаанд ядуурал байх бөгөөд өнөөг хүртэл Германд АНУ-д байдагтай адил төлөвшсөн “ядуурлын дэд соёл” бүхий тодорхой газар нутаг заасан “доод анги” үүсэх, ядуурлын шугамаас дээш хэлбэлзлийн өндөр түвшнийг урьдчилан сэргийлж байна.

Rainer Geißler / Sonja Weber-Menges

Norbert Elias / John L. Scotson: The Established and the Outsiders. A Sociological Enquiry into Community Problems. London 1965. – Dt.: Etablierte und Außenseiter. Übers. von Michael Schröter. Frankfurt a. M. 1990.
Friedrich Heckmann: Ethnische Minderheiten, Volk und Nation. Stuttgart 1992.

Cornelia Schmalz-Jacobsen / Georg Hansen (Hrsg.): Kleines Lexikon der ethnischen Minderheiten in Deutschland. München 1997.

Albert Scherr: Randgruppen und Minderheiten. In: Bernhard Schäfers / Wolfgang Zapf (Hrsg.): Handwörterbuch zur Gesellschaft Deutschlands. Opladen ²2001. S. 518–528.

Rainer Geißler: »Deutsche Randschichten« und »Ethnische Minderheiten«. In: R. G.: Die Sozialstruktur Deutschlands. Wiesbaden ⁴2006. S. 201–254.

Чинээлэг ба нийгмийн баримжаат төр (Wohlfahrts- und Sozialstaat)

“Нийгмийн баримжаат төр” гэдэг нь амьжиргааны эрсдэлээс (→ эрсдэл) урьдчилан сэргийлэх, зах зээлээс үүдэлтэй тэгш бус байдлыг бууруулах зорилготой төрийн оролцооны бүх төрлийн хэлбэрийг (хөндлөнгийн оролцоо; → төр) хэлнэ. Эдгээр нь өвчин (→ амьдрал), ажилгүйдэл (→ ажил), өндөр насны болон ядуурлын үр дагавраас хамгаалах уд, мөн орон байр, → боловсрол, нийгмийн асуудал, халамж зэрэг салбарууд дахь төрийн хөтөлбөрүүд юм.

Thomas H. Marshall (*Class, Citizenship and Social Development*, 1964)-ын иргэний, улс төрийн, нийгмийн эрхийг үе шаттайгаар нутагшуулах хувьслын загвартаа (→ хувьсал) танилцуулсан нийгмийн → эрхийн үзэл санаа нь нийгмийн баримжаат төрийн онолын үзэл

баримтлалд гол үүрэг гүйцэтгэдэг. Хүмүүнлэгийн үйл (буяны, сайн үйлсэд тулгуурласан) эсвэл нийгмийн халамжийн янз бүрийн хэлбэрээс ялгаатай нь нийгмийн баримжаат төр нь тухайн иргэний нийгмийн халамжийн хууль ёсны эрх дээр суурилдаг.

Нийгмийн баримжаат төрийн онол нь нийгэм дэх улс төрийн хөндлөнгийн оролцооны хөгжил, төлөвшлийн асуудлыг голчлон авч үздэг. → Функционализм нийгмийн баримжаат төрийг өсөн нэмэгдэж буй нийгэм-эдийн засгийн дарамтын хариу үйлдэл гэж үздэг бөгөөд үүнд орчин үеийн бүх шинэчлэгдэж буй нийгмүүд (→ орчин үе) өртөж байна (Harold Wilensky, *The Welfare State and Equality*, 1975). Нийгмийн зохион байгуулалтын энэхүү өөрчлөлт нь нийгэм дэх улс төрийн хөндлөнгийн оролцоо, зохицуулалтыг нэмэгдүүлэхэд хүргэж байна (*The Development of Welfare States in Europe and America*, hrsg. von Peter Flora und Arnold Heidenheimer, 1981). Эрх мэдлийн нөөцийн хандлагын төлөөлөгчид нийгмийн баримжаат төрийн хөгжилд шийдвэрлэх нөлөө үзүүлдэг ангийн тэмцлийг үл тоомсорлох хандлагаас нь болж эдгээр онолд шүүмжлэлтэй ханддаг (Walter Korpi, *The Democratic Class Struggle*, 1983; → материалист нийгмийн онол). Тэд зүүний үзэлтэй нам, үйлдвэрчний эвлэлүүдийн нэмэгдэж байгаа улс төрийн нөлөөг нийгмийн халамжийн тогтолцоог тэлэх хөдөлгөгч хүч гэж үздэг.

Өмнө нь олон төрлийн нийгмийн халамжийн тогтолцооны хоорондох ялгааг юуны өмнө хөгжлийн янз бүрийн түвшнээс хамаарч тодорхойлж болно гэж

ихэнхдээ үздэг байсан бол 1990-ээд оны эхэн үеэс нийгмийн баримжаат төрийн янз бүрийн хэлбэрийн талаар мэтгэлцээнүүд эрчимтэй өрнөж эхэлсэн. Gøsta Esping-Andersen (*The Three Worlds of Welfare Capitalism*, 1990) нийгмийн халамжийн төрийн гурван дэглэмийг ялгаж үзсэн байна. Нийгмийн иргэний эрх нь нийгмийн баримжаат төрийн зарчмын цөм нь болдог гэсэн Marshall-ын таамаглалд тулгуурлан, нийгмийн баримжаат төрийг Esping-Andersen төр-зах, зээл-харилцаа гэсэн харилцаагаар, давхаргажилтад үзүүлэх нөлөө, төлбөрийн чадваргүй байдлаас хамгаалагдах түвшин (өөрөөр хэлбэл, иргэдийн зах зээлээс үл хамаарч нийгмийн баримжаат төрийн халамжийн үйлчилгээнд хамрагдах боломжтой түвшин) гэж гурав ангилсан. *Либерал халамжийн тогтолцоонд* төр нь зах зээлд хамгийн багаар нөлөө үзүүлдэг бөгөөд ядууралтай тэмцэхэд анхаардаг. *Консерватив дэглэмтэй* үе төр нь нийгмийн даатгалын тогтолцоонд суурилах бөгөөд статусаа хадгалах гэсэн үзэл дээр үндэслэдэг. *Социал демократ загварт* төр нь улсынхаа иргэдийг бүх талын үйлчилгээгээр хангах бөгөөд нийгмийн тэгш байдлыг дэмждэг.

Сүүлийн үеийн судалгаанд нийгмийн баримжаат тогтолцооны тэлэлтийн (нэмэх) асуудал нэн тэргүүнд яригдахаа больж, харин хумих үйл явцыг онцлох болжээ (*The New Politics of the Welfare State*, hrsg. von Paul Pierson, 2001). *New Politics*-улс төрийн шинэ үеийн төлөвөөс харахад, засгийн газрууд нь нийгмийн халамжийн үйлчилгээгээ бууруулснаар олон нийтэд

таалагдахгүй бодлого явуулах ёстой болдог бөгөөд нийгмийн баримжаат төр нь институцийн илүү тууштай, тэсвэрлэх чадвараа харуулах шаардлагатай болдог. → Даяарчлал, олон улсын үйл ажиллагааны өрсөлдөх чадамж болон нийгмийн баримжаат төрийн институцийн тогтолцоо нь хэрхэн нөлөөлж байна вэ гэсэн асуулт олны анхаарлыг хүчтэй татаж байна (*Welfare and Work in the Open Economy*, hrsg. von Fritz W. Scharpf und Vivien Schmidt, 2000).

Steffen Mau

Heinz Lampert / Jörg Althammer: Lehrbuch der Sozialpolitik. Berlin [u. a.] 1985, 72004.

Stephan Leibfried / Uwe Wagschal (Hrsg.): Der deutsche Sozialstaat. Bilanzen – Reformen – Perspektiven. Frankfurt a. M. / New York 2000.

Franz-Xaver Kaufmann: Varianten des Wohlfahrtsstaates. Der deutsche Sozialstaat im internationalen Vergleich. Frankfurt a. M. 2003.

Stephan Leibfried / Steffen Mau (Hrsg.): Welfare States: Construction, Deconstruction, Reconstruction. Cheltenham 2008. 3 Bde.

Шашин (Religion)

Өдөр тутмын амьдрал дээр бурханд итгэх итгэл эсвэл ер бусын хүчтэй адилтган ойлгодог “шашин”-ыг социологид тодорхойлох гэсэн оролдлогууд нь ихэвчлэн харьцангуй хэцүү байсан. Ялангуяа, бурхны оролцоог чухалчилдаггүй буддизм гэх мэт дэлхийн шашин байдаг тул бурхны тухай дурдах нь маргаантай байдаг. Émile Durkheim (*Les formes élémentaires de la vie religieuse*, 1912, dt. 1981) шашны тодорхойлолтыг гаргасан анхны хүмүүсийн нэг бөгөөд шашныг “сүм гэж нэрлэгддэг ижил ёс суртахууны нийгэмлэгт харьяалагддаг бүх хүмүүсийг ариун дагшин буюу тусгай, цээртэй зүйл, итгэл үнэмшил, зан үйлээр нь холбон нэгтгэдэг итгэл үнэмшил, зан үйлийн эв нэгдэлт тогтолцоо” гэж тодорхойлжээ. Үүнээс хойш итгэл үнэмшил, зан үйл болон эдгээрт тулгуурласан → хамтын нийгэмлэгийг шашны гол элементүүд гэж нэрлэх болсон юм. Үүнээс гадна, шашныг тодорхойлдог хоёр арга хэлбэр болох “ариун” зүйлийн талаарх үндсэн тодорхойлолт, шашныг интеграцийн чиг үүрэгтэй гэж үздэг функциональ тодорхойлолтуудын талаар дараагийн хэлэлцүүлэгт авч үзэх болно.

Эдгээр хандлагууд нь заримдаа нэг нэгнээ үгүйсгэх байдлаар хэлэлцэгддэг. Үүний нэг томоохон төлөөлөл нь хүний “биологийн мөн чанарын хязгаарыг давсан” үйлдлийг үндсэндээ шашны үйл явц гэж аль хэдийн тодорхойлсон Thomas Luckmann (*The Invisible Religion*, 1967, dt. 1991)-ын шашны функциональ үзэл

баримтлалтай Peter L. Berger (*The Sacred Canopy*, 1967, dt. 1973)-ийн үзэл баримтлалыг харьцуулсан ялгаанаас харагддаг. Ямартай ч шашны үндсэн болон функциональ тодорхойлолтуудыг ялгаж үзэх нь аналитикийн хувьд бодит хандлагыг түүний дагуу нарийн тодорхой ангилахаас илүү өгөөжтэй байдаг. Ер нь бол шашныг тодорхойлоход “ариун” гэдэг үгийн оронд “трансценденц” буюу “хязгаарыг давах” гэсэн хийсвэр ойлголт давамгайлах болсон. Niklas Luhmann (*Funktion der Religion*, 1977) имманенц²⁶ болон трансценденц хоёрын ялгаа болон хамаарал (холбоо)-ыг шашны өөрийнх нь харилцааны код (→ харилцаа) гэж тодорхойлсон байдаг. Ингэснээрээ “бодит байдлыг хоёр дахин нэмэгдүүлэх” буюу өөрөөр хэлбэл, трансцендет (нөгөө ертөнцийн, далд, ер бусын гэх мэт) бодит байдлын үүднээс имманенцийг (энэ ертөнцийн, ил, → өдөр тутмын гэх мэт) авч үзэх ба үүнтэй хамааралтай шинэ үнэлгээ нь шашныг тодорхойлох шалгуур болох юм.

Эртний шашны социологи нь юуны түрүүнд шашны шүүмжлэл, түүх-философийн таамаглалын бүхий нөлөөллийн хүрээнээс 1900 оны үед ангижрах ёстой байв. Max Weber («Die protestantische Ethik und der Geist des Kapitalismus», in: *Archiv für Sozialwissenschaften und Sozialpolitik* 20/21, 1904/05) болон Durkheim нарын бүтээлүүд нь шашныг нийгмийн → өөрчлөлт эсвэл нийгмийн интеграцчилалд чухал үүрэг гүйцэтгэдэг гэж үзсэн бөгөөд шашны талаарх социологийн үзэл баримтлалаас

26 Энэ нь (латинаар *immanere* “дотоор нь байх”) аливаа зүйлийн хязгаарыг давахгүйгээр дотоодод нь орших шинж чанарыг илэрхийлдэг ойлголт юм.

эрс ялгаатай загваруудыг гаргаж ирсэн: Weber-ийн хувьд шашин нь хүний (→ хувь хүн) ухамсарт (→ утга учиртай) үйлдэлд (→ үйлдэл), ялангуяа ёс суртахуун, амьдралын замналд үзүүлэх нөлөөллөөр илрэх бөгөөд энэ утгаараа–массыг хамарсан–капитализмын (→ капитал) болон рационал нийгмийн зохион байгуулалтын шаардлагад нийцсэн тодорхой → хабитусыг үүсгэдэг. Харин Durkheim шашныг хамтын ухамсар, туршлагын хүчээр нь тодорхойлж байсан бөгөөд үүнээс үүдэн хүн → нийгмийн эрх мэдлийн нөлөөнд автахын зэрэгцээ хүчийг нь бас нэмэгдүүлж байгаагаа мэдэрдэг.

Социологи үүссэн цагаасаа эхлэн шашны хувь заяаг нийгмийн шинэчлэлийн (→ орчин үе) үйл явцтай холбоотой харсаар ирсэн. Шашин судлалын олон социологичид нийгмийг шашингүйжүүлэх (шашнаас ангижрах) үзлийг хуваалцдаг байсан бөгөөд ингэх явцад нийгэмд үзүүлэх шашны нөлөө зайлшгүй буурах юм. Үүнийг дагалдан шашныг хувьчлах, → индивидуалчлах тухай асуудлыг байнга дэвшүүлдэг. Эдгээр таамаглалууд 1990-ээд онд ялангуяа Хойд Америкийн шашны социологичдоор няцаагдаж байсан юм. Тухайлбал, José Casanova (*Public Religions in the Modern World*, 1994) орчин үеийн нийгэмд шашны хөгжлийн янз бүрийн урсгал нэгэн зэрэг байдгийг онцолж байв. Шашингүйжүүлэх үзлийг тойрсон энэхүү маргаанд зөрчлийн социологийн хандлага шинэ эргэлтийг авчирсан байдаг (Frank Höllinger, *Popular Religion and Church*, 1996). Энэ үүднээс нь харвал, шашны тогтвортой байдал, хөгжил, уналтыг ерөнхий чиг хандлагын илэрхийлэл биш, харин тодорхой зөрчлийн

нөхцөл байдал гэж тайлбарладаг. Үүнд, шашин, → улс төр, шинжлэх ухааны хоорондын харилцаа онцгой хамааралтай юм (Uta Karstein [u. a.], »Säkularisierung als Konflikt?«, in: *Berliner Journal für Soziologie* 16, 2006, Nr. 4). Дэлхийн олон оронд шашны уламжлалт хэлбэрүүд эргээд сэргэж байгаа нь шашингүйжүүлэх үзлийн тогтсон таамаглалыг ихээхэн эргэлзээтэй болгож байна. Гэсэн хэдий ч иймэрхүү хөгжлийг шашин бас хэлбэрээ өөрчлөхөд хүрдэг нийгмийн өөрчлөлттэй холбон тайлбарлаж ёстой.

Monika Wohlrab-Sahr

Volkhard Krech / Hartmann Tyrell (Hrsg.): Religionssoziologie um 1900. Würzburg 1995.

Hubert Knoblauch: Religionssoziologie. Berlin / New York 1999.

Detlef Pollack: Religion. In: Hans Joas (Hrsg.): Lehrbuch der Soziologie. Frankfurt [u. a.] 2001. S. 335–362.

Michele Dillon (Hrsg.): Handbook of the Sociology of Religion. Cambridge [u. a.] 2003.

Karl Gabriel / Richard Reuter (Hrsg.): Religion und Gesellschaft. Texte zur Religionssoziologie. Paderborn [u. a.] 2004.

Шилжилт хөдөлгөөн (Migration)

“Шилжилт хөдөлгөөн” (латинаар *migrare* = “шилжих”) гэдэг нь ерөнхийдөө нийгмийн шилжих хөдөлгөөний үйл явцыг тодорхойлдог. Энд → улс доторх дотоод шилжилт хөдөлгөөн, олон улсын шилжилт хөдөлгөөн, мөн 1990-ээд оноос → глобалчлалын нөлөөтэйгөөр бараа, → хөрөнгийн болон мэдээллийн урсгалын үндэстэн дамнасан шилжилт хөдөлгөөнийг хооронд нь ялгаж үздэг. Цааш нь задалж үзвэл → хөдөлмөрийн болон дүрвэгчдийн шилжилт хөдөлгөөн, ойрын болон холын шилжилт хөдөлгөөн, нэг удаагийн болон олон/улирлын шилжилт хөдөлгөөн, хувь хүний болон гэр бүл/бүлгийн шилжилт хөдөлгөөн гэж ялгарна. Олон улсын шилжилт хөдөлгөөний сонгодог онолууд (жишээлбэл, Их Британид: *Ernest George Ravenstein*, дараа нь, Чикагогийн сургуульд: *William I. Thomas, Florian W. Znaniecki, Robert E. Park, Ernest W. Burgess*, Герман хэлтэй орнуудад: *Hans-Joachim Hoffmann-Nowotny und Hartmut Esser*) нь юуны түрүүнд хүн амын тодорхой бүлгийн гарсан ба ирсэн бүс нутагт шилжилт хөдөлгөөний үйл явцыг нийгэм, соёл, эдийн засаг, улс төрийн урьдчилсан нөхцөл, хэлбэрүүд, үр дагавраар судлахад чиглэгддэг. Тэд эхний ээлжид шилжилт хөдөлгөөний нэг эсвэл хоёр удаа байршлаа сольсон байдлыг (эх орноосоо гарсан болон эргээд буцаж орж ирсэн) судалдаг. Тэдний үр дүнгээс харахад шилжин суурьшигчдын дийлэнх нь хүн амын нэн ядуу хэсгийнх биш, ихэвчлэн мэргэжлийн өндөр ур чадвартай хүмүүс байдаг. Шилжилтийн үйл явц бол сүлжээний бүтцээр (→ сүлжээ), өөр өөр бүс нутгуудын

хооронд бүрэлдсэн түүхэн харилцааны дагуу явагддаг. Шилжин суурьшигчдыг уусгах буюу интеграцчилах (шинэ улсад дасан зохицох) үйл явц эдийн засаг, нийгэм, соёл, улс төрийн хэм хэмжээнд шаталсан байдлаар явагддаг.

Бараа, хөрөнгө, мэдээллийн урсгалын глобалчлал, олон улсад үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын үйл ажиллагааны тэлэлт, цаашлаад тээвэр болон харилцаа холбооны илүү сайжруулсан, хямд технологи нь шилжилт хөдөлгөөний шинэ үзэгдлийг бий болгож байна. Үүнтэй зэрэгцээд 1990-ээд оноос хойш “үндэстэн дамнасан шилжилт хөдөлгөөн” гэж ихэнхдээ нэрлэгддэг олон улсын шилжилт хөдөлгөөний шинэ онолууд гарч ирсэн (*Michael Kearney, Nina Glick Schiller, Douglas S. Massey, Peggy Levitt, Alejandro Portes, Steven Vertovec, Thomas Faist, Ludger Pries*). Энэ хандлагын дагуу шилжилт хөдөлгөөнийг зүгээр нэг “суурьшмал” (байнгын оршин суудаг), нэг бүс нутгийн, “контейнер-үндэсний нийгэмлэг”-т ууссан амьдралын харилцаанаас нөгөөд шилжиж байгаа ер бусын (онцгой) өөрчлөлт гэж ойлгохоо больсон. Үүнээс илүүтэйгээр шилжилт хөдөлгөөн бол амьдралын үндэстэн дамнасан, байнгын, нягт холбоо харилцаа хийгээд төлөвлөлтийг хил дамна нийгмийн орон зайн шинэ хэлбэрээр бий болгож байгаа хэрэг юм. Нэг эхэлсэн шилжилт хөдөлгөөн шинэ шилжилт хөдөлгөөнийг үүсгэдэг болох нь одоо нэгэнт тодорхой болжээ (хүлээлт өөрчлөгдсөнөөр гарал үүслийн бүс нутаг руугаа буцах юм уу эсвэл шилжилт хөдөлгөөнтэй холбоотой эрэлтийн шинэ бүтэц бий болсноор өөр шинэ бүс нутаг руу шилждэг). Гарал

үүслийн болон ирж буй бүс нутгийн нийгмийн орон зай нь олон газрын, үндэстэн дамнасан нийгмийн шинэ орон зайг бүрэлдүүлж болохоор цогц үйл явцаар (мэргэшсэн хүмүүс гарах, буцаж очих, буцаах мөнгөн шилжүүлэг, эдийн засгийн хүлээлт өөрчлөгдөх, улс төрийн шинэ, хүйсийн үүрэгт тулгуурласан оролцооны шаардлага, цалингийн өрсөлдөөн, хөдөлмөрийн зах зээл дээрх шахалт) холбогдсон байдаг. Эдгээр нь гарал үүслийн болон ирж буй бүс нутгийн (олон өөр газрын) шилжилт хөдөлгөөнд болон нэгтгэх динамикт нөлөөлдөг. Олон улсын шилжилт хөдөлгөөнийг бодлогоор хянаж, удирдах боломж хязгаарлагдмал байдаг. Өөр өөр улс орноор үндэстэн дамнасан шилжин суурьшигчийн хувьд энэ нь дан ганц амьдрах орчны өөрчлөлт биш, харин улс орны хил хязгаарыг давж, олон бүс нутгийг хамарч байгаа үндэстэн дамнасан амьдралын нэг хэв маяг (→ өдөр тутмын амьдрал) болсон байна. Үндэстэн дамнасан нийгмийн орон зай тухайлбал, өдөр тутам утсаар ярих, гарал үүслийн болон ирж буй нийгэмдээ болж байгаа үйл явдалд тогтмол анхаарал хандуулах (үндэсний сонин унших, үндэсний телевиз, радио сонсох), мөн эдгээр бүс нутагт суугаа гэр бүлүүд хоорондоо мөнгө шилжүүлэх, хүнсний бүтээгдэхүүн солилцох, соёлын бүтээл хуваалцах эсвэл өрх, гэр бүлийнхээ чухал шийдвэрт хил дамнасан санал хураах замаар бүрэлддэг. Бие биеэсээ алслагдсан улс орнуудын тухайд, маш ялгаатай мэргэжлийн бүлгүүдийн (мэргэжилгүй гэрийн үйлчлэгчээс авхуулаад өндөр мэргэжлийн мэдээллийн технологийн мэргэжилтэн

хүртэл) хувьд хэд хэдэн үеэрээ үндэстэн дамнасан шилжилт хөдөлгөөн хийсэн нь батлагддаг. Шилжилт хөдөлгөөний уламжлалт болон шинэ хэлбэрийн хооронд нягт уялдаа холбоо байна. Өнөөдөр олон улсын шилжилт хөдөлгөөнийг (1) хэд хэдэн үеийн турш эмзэг (бутрамхай), залруулах боломжтой (буцах боломжтой) хэвээр байдаг ирээдүй болоод үр дүн нь нээлттэй үйл явц гэж, (2) шилжин суурьшигчид болон “уугуул иргэд” хоорондын өөрийгөө болон бусдыг олох/ойлгох диалектик үйл явц гэж, (3) эдийн засаг, улс төр, нийгэм, соёлын интеграцчиллын олон талт, олон бүс нутгийг хамарсан, үүнтэй холбоотойгоор тодорхой дарааллын (залгамж халаатай холбоотой) эсвэл функциональ хамаарлын харилцаа байдаггүй үйл явц гэж ойлгодог.

Ludger Pries

Annette Treibel: Migration in modernen Gesellschaften: Soziale Folgen von Einwanderung, Gastarbeit und Flucht. Weinheim/München 1990, ³2003.

Stephen Castles / Mark J. Miller: The Age of Migration. International Population Movements in the Modern World. New York 1993, ³2003.

Douglas S. Massey [u. a.]: Worlds in Motion. Understanding International Migration at the End of the Millennium. Oxford [u. a.] 1998, Nachdr. 2006.

Petrus Han: Soziologie der Migration. Stuttgart 2000, ²2005.

Шинжлэх ухаан (Wissenschaft)

Шинжлэх ухаан бол орчин үеийн → нийгмийн нэг бие даасан үйл ажиллагааны систем бөгөөд түүний үүрэг нь шинэ → мэдлэгийг бүтээх явдал юм. Энэхүү мэдлэг нь арга зүйн хувьд хяналттайгаар явагдаж бий болдог тул бусад мэдлэгийн хэлбэрүүдтэй харьцуулахад (объектив) үнэн гэж үзэх шаардлагыг тавьж болдгоороо бусад мэдлэгийн хэлбэрүүдээс ялгаатай. Шинжлэх ухааны мэдлэг нь зарчмын хувьд батлагдах, няцаагдах боломжтой байх ёстой, өөрөөр хэлбэл, энэ нь үргэлж зөвхөн түр зуурын үнэн мэдлэгт тооцогддог.

Шинжлэх ухааны цөм удад шинжлэх ухааны тогтолцооны гол үүргийг гүйцэтгэдэг судалгааны (мэдлэгийг бүтээх) болон заах (мэдлэгийг түгээх) чиг үүрэгтэй их сургуулиуд багтдаг. Үүний зэрэгцээ их сургуулиас гадуурх олон тооны эрдэм шинжилгээний байгууллагууд байгуулагдсан. Институцчиллийн ялгаанаас гадна (→ институци) салбар, хүрээлэнгээс хамааран шинжлэх ухааны дотоод ялгаа нь бий болсон. Шинжлэх ухааны социологийн хамгийн алдартай судалгаануудад Robert K. Merton-ын орчин үеийн шинжлэх ухааны тогтолцооны норматив дүрэмд хийсэн дүн шинжилгээ (*On the Shoulders of Giants*, 1965, dt. 1980), мөн Talcott Parsons, Gerald M. Pratt-ын Америкийн дээд боловсролын тогтолцоонд хийсэн институцийн дүн шинжилгээ (*The American University*, 1972, dt. 1990) ордог. Niklas Luhmann (*Die Wissenschaft der Gesellschaft*, 1990)-ын системийн онолд шинжлэх

ухааныг нийгмийн үйл ажиллагааны систем гэж үзсэн бөгөөд нийгмийн бусад дэд системүүдээс бэлгэдлийн хувьд ерөнхийд нь тодорхойлсон харилцааны хэрэгслийн оролцоотойгоор үнэнийг болон ба систем доторх харилцаа холбоог үнэн/үнэн биш байдлаар кодчилох

Rainer Fretschner

Rudolf Stichweh: Wissenschaft, Universität, Professionen:

Soziologische Analysen. Frankfurt a. M. 1994.

Nico Stehr: Die Zerbrechlichkeit moderner Gesellschaften. Weilerswist 2000.

Gerd Bender (Hrsg.): Neue Formen der Wissenserzeugung. Frankfurt a. M. / New York 2001.

Sabine Maasen / Matthias Winterhager (Hrsg.): Science Studies: Probing the Dynamics of Scientific Knowledge. Bielefeld 2001.

Peter Weingart: Wissenschaftssoziologie. Bielefeld 2003.

Шүүмжлэлт онол (Kritische Theorie)

“Шүүмжлэлт онол” гэдэг ухагдахууныг нэвтрүүлсэн хүн бол Франкфуртийн нийгмийн судалгааны хүрээлэнгийн үүсгэн байгуулагч, захирал, “*Нийгмийн судалгааны сэтгүүл*” (1932 оноос хойш)-ийг хамран эрхлэгч Max Horkheimer юм. Horkheimer энэхүү сэтгүүлд 1932-1941 оны хооронд шүүмжлэлийн онолыг хөгжүүлэхэд

удирдлага болгох таамаглалуудыг дэвшүүлж, судалгааны чиглэлийг тогтоон, чиг хандлагыг тодорхойлсон цуврал өгүүлүүдийг нийтлүүлж байсан. Horkheimer психоанализаар баяжуулсан марксист → нийгмийн философиос таамаглалаа гарган дэвшүүлж байв. Ажилтан нэг бүр тусдаа нэг судалгааны салбарыг хариуцдаг: хөгжмийг Theodor W. Adorno, мэргэжлийн философийг Herbert Marcuse, → хуулийг Franz Neumann болон Otto Kirchheimer нар, → нийгмийн сэтгэл судлалыг Erich Fromm, утга зохиолыг Leo Löwenthal, эдийн засгийг Friedrich Pollock гэх мэт. Horkheimer жишээлбэл, капитализм дахь → гэр бүлийн (→ капитал) үүрэг ролийн өөрчлөлтийн тухай философийн өргөн цар хүрээтэй онолыг боловсруулж байх үед нь энэхүү өгөгдлийн талаар нарийвчилсан судалгааг явуулж шалгахын тулд Fromm-ыг бас давхар судалгааны талбарт илгээж байсан. Ингэхдээ Horkheimer аливаа ухамсрын философийн эмпирик дадал зуршлаас тодорхой зааг гарган, өөрийнхөө энэ төслийг метафизикийн дараах материалист рационализмын хүрээнд авч үзсэн бөгөөд нийгмийн философийг эмпирик нийгмийн шинжлэх ухаанд Америкийн прагматизмтай нэлээд төстэй нээж өгсөн. Horkheimer-ын тайлбараар, марксизм нь практикт чиглэсэн, салбар хоорондын судалгааны хөтөлбөрийг тодорхойлдог. 1933 онд национал социалистуудаас Америк руу цөллөгт дүрвэсэн Horkheimer тэндээ шинээр байгуулж, тэрээр энэхүү хөтөлбөртөө марксизмыг шууд иш татахаас үргэлж зайлсхийж, 1930-аад оны дунд үе хүртэл үүнийг “материализм” гэж

нэрлэж байгаад 1940-өөд оны үед АНУ-дант коммунист уур амьсгал ихэссэний дараагаас “шүүмжлэлийн онол” болгосон байдаг. 1930-аад оны сүүл, 1940-өөд оны эхээр Horkheimer Marcuse-ын хамт философийн чухал жинтэй өвийг шүүмжлэлийн онолдоо сэргээж, эмпиризмээс холдсон юм. Түүнийг эмпиризмд холбож байсан хүн бол Rudolf Carnap-ын хүрээллийн, урьд нь ойр дотно харилцаатай байсан Венийн бүлгэмийн гишүүн Otto Neurath байв. Гэсэн хэдий ч 1950-иад оны сүүлчээс *Франкфуртийн сургууль* гэж нэрлэгдсэн Horkheimer-ын эргэн тойрны хүрээллийн довтолдог чиглэл нь ерөнхийдөө метафизикийн эсрэг хэвээр байв. Энэ нь Horkheimer-ын онолын чухал санаа өгдөгт нь талархдаг хамгийн ойрын хамтрагч Adorno-д ч мөн адил хамаатай бөгөөд 1945 оны дараа тэрээр Франкфуртийн сургуулийн тэргүүн саадгүй болж байжээ. Horkheimer, Adorno нарын эцэстээ гүн пессимист танин мэдэхүйн диалектик (1947)-аар оргилдоо хүрсэн шүүмжлэлийн онол нь Карл Марксын нийгмийн онол (→ материалист нийгмийн онол) дээр үндэслэсэн ортодокс ба радикал ревизионизм²⁷-ын өвөрмөц холимог байв. Ортодокс бол Марх-ын “Капитал”-д боловсруулсан үнэ цэний онолын баримтлалтай хэдий ч энэ нь соёлын иж бүрэн онол гэхээсээ илүүтэй эдийн засгийн хувьд хэмнэлт багатай гэж ойлгогдох нь их байсан. Бараа бүтээгдэхүүний чөлөөт, тэгш солилцоо нь зөвхөн үйлдвэрлэл дэх улс төрийн бус, эдийн засгийн ноёрхолт харилцаагаар

27 Марксизм-Ленинизмын үндэслэлийг дахин хянаж, өөрчлөхийг эрмэлздэг засварлах үзэл. Эх сурвалж: <https://mongoltoli.mn/>

тэгш бус, мөлжлөгийн эсрэг тал болоод хувирахгүй, харин солилцоонд дагаж явдаг, амьдралын бүхий л нөхцөлд (нийгмийн цогц байдал) нэвтэрсэн “барааны фетишизм” (Marx) нь нийгмийн харилцаанд нөлөөлж, зүрх сэтгэлийн хандлагыг урьтал болгон → авторитет шинжид оруулж өөрчилдөг. Марксизмыг нийгмийн судалгааны бүтцийн алдаатай байдал (эмпирик шинжлэх ухаанд → мэдлэг нь үргэлж магадлалтай байдаг, гэхдээ хэзээ ч баттай нотлогдохгүй гэсэн итгэл үнэмшил)-д оруулах арга нь радикал ревизионист байв. Шүүмжлэлийн онолын арга зүйгээр амжилттай болсон судалгааны төслүүдээр *Гуравдугаар Эзэнт Улс*²⁸-ын өмнөх өдөр ажилтан, албан хаагчид (Erich Fromm, 1980) → *авторитет ба гэр бүлийн харилцааг* (Max Horkheimer, *Studien über Autorität und Familie*, 1936), мөн *авторитар хувийн зан чанарыг* (Theodor W. Adorno [u. a.], *The Authoritarian Personality*, 1950) судалсан.

Франкфуртийн сургуулийн залуу төлөөлөгч, бусдын түрүүнд Jürgen Habermas 1960-аад оноос хойш өөр нэгэн ревизионист, гэхдээ бас нео-марксист хэвээр байх өөрчлөлтийг орчин үеийн нийгмийн онолд (→ нийгмийн онол) оруулсан. Тэд шүүмжлэлийн онолыг → харилцааны үндсэн ойлголт хэмээн баталж байв. Habermas-ын хувьд хамгийн гол марксист үндсэн ухагдахуунууд болох → “хөдөлмөр” болон “бүтээмжийн

28 1933 онд А. Хитлер засгийн эрхэнд гарч Германы төрийг Нацист буюу Үндэсний социалист нам барих болжээ. Ингэснээр нацист үзэл суртлыг бүх шатны байгууллагуудад түгээж, тоталитар засаглалтай, социалист тогтолцоотой улс байгуулж, түүнийгээ Гуравдугаар Эзэнт Улс хэмээн нэрийджээ: https://mn.wikipedia.org/wiki/Нацист_Герман#Гуравдугаар_Эзэнт_Улс

хүч/үйлдвэрлэлийн нөхцөл"-ийг "ойлголцоход чиглэсэн үйл ажиллагаа" (→ харилцан үйлчлэл) болон "ойлголцлын харилцаа" гэсэн ижил төрлийн үндсэн ойлголтуудыг баяжуулсан. Тэрээр бүтээмжийн үндсэн хүч болох техникийг илүү өргөн хүрээний бүтээмжийн хүчний харилцаатай хослуулан, ялангуяа, → эдийн засаг, → улс төр, хууль эрх зүйн функциональ системийн ярих замаар эдийн засгийн суурь ухагдахууны үндсийг Luhmann-ын "функциональ систем"-ээр сольсон.

Hauke Brunkhorst

Helmut Dubiel: Wissenschaftsorganisation und politische Erfahrung. Studien zur frühen Kritischen Theorie. Frankfurt a. M. 1978.

Thomas McCarthy: The Critical Theory of Jürgen Habermas. London 1978. – Dt.: Kritik der Verständigungsverhältnisse. Zur Theorie von Jürgen Habermas. Übers. von Max Looser. Frankfurt a. M. 1980, Nachdr. 1989.

Rolf Wiggershaus: Die Frankfurter Schule. Geschichte, theoretische Entwicklung, politische Bedeutung. München 1986, 62001.

Stefan Müller-Doohm: Adorno. Eine Biographie. Frankfurt a. M. 2003.

Hauke Brunkhorst: Habermas. Leipzig 2006.

Эдийн засаг (Wirtschaft)

“Эдийн засаг” гэдэг нь → нийгмийн бараа, үйлчилгээний ханган нийлүүлэлтийн баталгаат байдалд зайлшгүй оролцоотой хүмүүсийн үйл ажиллагаа, институци, процессуудыг хэлдэг. Өргөн утгаараа “эдийн засаг” гэдэг нь хэрэгцээ хангах боломжуудын тухай маргааныг нийгэмд өдөөгөөд зогсохгүй сувгийг нь нээдэг хомсдолын аливаа нэг хэлбэрийн институцчилал гэж бас хэлж болно. Хүн амьдралынхаа хэрэгцээг (цангах, өлсөх, хамгаалах, орон байр, гэр бүлээ тэтгэх боломж) хангахын төлөө хичээн зүтгэж байдгийн цаана эдийн засаг бүтээмжтэй (үйлдвэрлэлийн), хэрэгцээтэй (хэрэглэгчийн) үйлчилгээний уялдааг зохицуулж байдаг. Зөвхөн бараа, үйлчилгээ хомс болдог бус, харин бараа, үйлчилгээний хомсдолтой байдлыг бууруулах боломж ч хомс юм.

Антропологи, социологийн үүднээс авч үзвэл “эдийн засаг”-ийг хувь хүн, хамт олон нийгэмд ямар хувь нэмэр оруулж, хэр хэмжээнд бүтээмжтэй гэж үнэлэгдээд хэрэглээний боломжоор шагнагдаж байгаа тухай нийгмийн байнгын маргаан гэж ойлгож болно. Аливаа нэг бараа, үйлчилгээ, үнэ, хөдөлмөрийн хөлс бүрийн цаана тодорхой үйлчилгээ авсан бол хэн, хэнд, юуны өр төлөөстэй болох тухай түр зуур зогсоосон зөрчил байдаг.

Richard Cantillon, David Ricardo нарын эдийн засаг, гадаад худалдааны онол, Adam Smith-ийн хөдөлмөрийн хуваагдлын онол, Maximilien Henri de Saint Simon, Au-

guste Comte нарын нийгмийн зохион байгуулалтад дэвшил ирнэ гэдгийг тайлбарлан таниулсан итгэл найдварыг даган Karl Marx (*Das Kapital*, Bd. 1, 1867) эдийн засгийн талаарх нийгмийн хуулийг онолын түвшинд нэгтгэсэн бөгөөд энд тэрээр хүн хүнтэй ахин дахин шинэ мэтгэлцээн өрнүүлэхийн тухайд шийдвэрлэх шалгуур нь бараа бүтээгдэхүүний солилцооны үнэ цэн гэж харж байв. Гэвч Marx-ын хэлснээр бараа бүтээгдэхүүний солилцооны үнэ нь бас хүмүүсийн энэхүү мэтгэлцээн, түүний нөхцөлүүдийг харах өнцгийг нийгэм дэх үйлдвэрлэлийн нөхцөл байдал руу буруу залдаг. Хүн өөрийгөө “бараа бүтээгдэхүүн шүтэх зан төлөв”-ийн золиос болгодог бөгөөд ингэснээр нийгмийн арай хүмүүнлэг хэлбэрүүд нь үнэгүйддэг (→ материалист нийгмийн онол). 1900 оны үеийн социологи нь эдийн засгийн талаарх нийгмийн нөхцөл байдал руу чиглэсэн Marx-ын энэ үзлийг хадгалж үлдсэн ч түүнтэй холбоотой эсхатологи²⁹ (эцсийн мөч дэх авралын зорилготой холбоотой), хувьсгалт хүлээлтийг хязгаарлахыг оролддог. Мөн үүсэж буй эдийн засгийн шинжлэх ухааны хөгжил, халамжийн үл гүйцэлдэх үзлээс зай барьж байв. Gabriel Tarde (*Psychologie économique*, 1902) → хувь хүмүүс бие биеэ даган дуурайж, улмаар өрсөлдөгчид болсноос дотоод бүх маргаан нь үүсдэг эдийн засгийн зөрчилдөөнтэй шинжийг онцолсон байдаг. Нийгмийн хөдөлмөрийн хуваагдал нь нэмэлт (бие биеэ нөхдөг) хэсэгчилсэн функцүүдийн

29 Хүн болоод ертөнцийн төгсгөл, эцсийн цаг мөчийн талаарх шашны үзэл баримтлал, зөгнөлт сургаал.

хоорондын ялгааг тодосгоход чиглэгддэг бол нийгмийн эв санааны нэгдлийн (→ интеграци) нөхцөл байдлын талаар ойлголттой болоход хүндрэлтэй байдгийг Émile Durkheim (*De la division du travail social*, 1893, dt. 1977) судалж байжээ. Мөнгө бол зөвхөн нийгмийн уламжлалт харилцааг таслаад зогсохгүй бас шинэ холбоо ч үүсгэх чадвартай гэдгийг Georg Simmel (*Philosophie des Geldes*, 1900) харуулсан. Simmel-ийн хэлснээр, хүмүүс уламжлалт харилцааг удаан хугацааных, тиймээс үнэ цэнтэй, харин шинэ холбоог богино хугацааных, тиймээс итгэлтэй бус гэж харах хандлагатай байдаг. Max Weber (*Wirtschaft und Gesellschaft. Grundriß der verstehenden Soziologie*, 1922) эдийн засгийг “захиран зарцуулах эрх мэдлийн тайван замын хэрэгжүүлэлт” гэж тодорхойлсон бөгөөд үүгээрээ эдийн засаг бол иргэний тэмцлийн нэг хэлбэр гэсэн парадоксыг голыг нь олж дүгнэсэн юм. Weber-ийн хэлснээр, хэрэв сайн дурын үндсэн дээр захирагдаж байгаа гэж үзвэл, мөн дараа нь хэрэгцээгээ хангах нөхцөл нь баталгаажиж байвал захиран зарцуулах эрх мэдлийг тайван замынх гэж хэлнэ.

Niklas Luhmann эдийн засгийн цаг хугацааны шинж чанарыг нь судалжээ. Түүний хувьд *Нийгмийн эдийн засаг* (*Wirtschaft der Gesellschaft*, 1988) бол ирээдүйн сэтгэл ханамжтай байх боломжийг баталгаажуулахын төлөө одоогийн хэрэгцээг хангах асуудлыг хойшлуулснаар гарч ирэх цаг хугацааг үр бүтээлтэй ашиглах боломжоор хангагдсан байдаг. Talcott Parsons, Neil J. Smelser (*Economy and Society. A Study in the Integration of Economic and Social Theory*, 1956) нарын

харуулсанчлан, энэ нь гэр бүлийн (→ гэр бүл) дотоод хурцадмал байдлыг намжаах, байгууллага дахь зөрчлийг зохицуулах (→ зөрчил), → хөрөнгө нийлүүлэхэд банкнуудын оруулсан хувь оролцоо, нийгмийн зөвшилцөлд үйлдвэрчний эвлэлийн оруулсан хувь нэмэр, улсын эдийн засагт төсвийн бүрдэлд зориулж (→ улс) татвар ногдуулах зэрэгт хамаарна.

Мөнгө, зах зээл, компани, → хөдөлмөрийн тухай социологийн онол нь эдгээр үзэл баримтлалуудыг дагадаг. Мөнгө бол хэрэгцээг хангах хойшлуулсан хугацааны урсах хэлбэрийг илтгэдэг. Зах зээл нь ямар бүтээмжтэй үйлчилгээг хэрэглээний ямар боломжид зориулж хангахыг тохируулдаг. Мөн компаниуд ажлын талаар → харилцааны хэлбэрийг зохион байгуулдаг бөгөөд энэ нь бусад ажилтай холбож, түүнээс хамааралтай болгох замаар тэдний бүтээмжийг нэмэгдүүлдэг.

Dirk Baecker

Richard Swedberg (Hrsg.): Explorations in Economic Sociology. New York 1993.

Neil J. Smelser / Richard Swedberg (Hrsg.): The Handbook of Economic Sociology. Newbury Park [u. a.] 1994, ²2006.

Mauro F. Guillén [u. a.] (Hrsg.): The New Economic Sociology: Developments in an Emerging Field. New York 2002.

Jens Beckert / Milan Zafirovski (Hrsg.): International Encyclopedia of Economic Sociology. London [u. a.] 2005.

Dirk Baecker: Wirtschaftssoziologie. Bielefeld 2006.

Элит (Elite)

Элит (францаар *élite* = “сонгох”) гэдэг нь ерөнхийдөө онцгой ур чадвараараа үнэлэгддэг, байр сууриасаа хамааран нийгмийн хөгжлийг тодорхойлох өндөр чадвартай нийгмийн → бүлгийг хэлдэг. Элит гэдэг нэр томъёог XVIII зуунд өсөн дэвжиж яваа Францын хөрөнгөтөн язгууртнуудын болон лам нарын эсрэг ардчилсан тэмцлийн нэр томъёо болгон гаргаж ирсэн бөгөөд Герман хэлэнд орсон зээлдмэл үг юм. Хөрөнгөтний элитийн харьяалалд багтах, цаашлаад нийгмийн дээд албан тушаалд орох шалгуур болгож гэр бүлийн удам угсааг харахын оронд хувь хүний ур чадварыг шалгуур болгон харах ёстой. Хөрөнгөтнүүдийн олж авсан байр суурь, эрхшээлдээ оруулсан хэв журам XIX зуунд хотын пролетариудын масс босож ирснээр алдагдахад хүрсний дараагаас элит гэдэг үгийн утга хэрэглээ мэдэгдэхүйц өөрчлөгдсөн. Цөөн тооны, онцгой хэдэн хувь хүнийг нэрлэж байсан элит нь аморф³⁰, аноним, → масс-ын эсрэг консерватив нэршил болсон.

Ийм түүхтэй нөхцөлд Gaetano Mosca (*Elementi di scienza politica*, 1896, dt. 1950), Robert Michels (*Zur Soziologie des Parteiwesens in der modernen Demokratie*, 1911) болон Vilfredo Pareto (*Trattato di sociologia generale*, 1916, dt. 1955) нарын зэрэг хүмүүс элит ба массын хоорондын ялгаатай байдлыг хүн төрөлхтний түүхийн үндсэн зарчим гэж харуулсан сонгодог элитийн онолыг

30 Тогтсон хэлбэр дүрсгүй.

томьёолсон. Тэдний үзэж байгаагаар тухайн түүхэн хөгжлийн үе шат болон тэр болгонд эрх барьж байсан засаглалын хэлбэр (цэргийн дарангуйлал эсвэл хаант засаглалаас аваад парламентын засаглал хүртэл)-ээс үл хамаарч үргэлж жижиг элитүүд олон янзын механизмын тусламжтайгаар (юуны өмнө хүчээр, → эрх мэдлээр) хүн амын дийлэнх хэсгийг захирдаг байна. Энэ онолоороо тэд фашизм, түүний манлайллын зарчмын суурь идеологийг тавьсан.

Фашизмын улс төрийн нөлөөгөөр хүч нь суларсан элит гэдэг нэр томьёо 1945 оноос хойш үндсэндээ функциональ хэлбэрээр тодорхойлогдох болсон. Ralf Dahrendorf (*Gesellschaft und Demokratie in Deutschland*, 1965), Hans Peter Dreitzel (*Elitebegriff und Sozialstruktur*, 1962) болон Suzanne Keller (*Beyond the Ruling Class*, 1963) нарын үзлээр бол орчин үеийн нийгэмд нэгдмэл байдлаар элит юм уу эсвэл захирагч анги гэж байхаа больсон, харин ганц нэг өөр хоорондоо өрсөлдөгч функциональ элит хэсэг нийгмийн чухал салбаруудын тэргүүнд байгаа ажээ. Мөн тэдний дэвшүүлсэн үзлээр элит хэсгийн давамгайлал гэж байхгүй, харин бие биеэ хянах үр дүнтэй систем байна гэж үзсэн. Элит байр сууринд хүрэх асуудал үндсэндээ ур чадварын шалгуураар хэрэгждэг тул энэхүү элитэд орох хаалга зарчмын хувьд хүн бүрд нээлттэй байна. Тиймээс элитүүд нийгмийн хувьд нэг төрлийн байснаа больж олон янз болсон. Элитийн дээд давхаргад одоо ч ажиглагдсаар байгаа давамгай хэсэг бол юуны түрүүнд илүү өндөр зэрэглэлийн боловсрол (→ боловсрол)

тэдний гарц болсонтой холбоотой юм.

Функционалист элитийн онол нь эхнээсээ л хүчтэй шүүмжлэл дагуулсан. Charles Wright Mills (*The Power Elite*, 1956, dt. 1962) болон Pierre Bourdieu (*La noblesse d'état*, 1989, dt. 2004) нар зарчмын хувьд ижил түвшний бие биеэсээ хамааралгүй олон тооны элит хэсэг байдаг хэмээн маргалдсан. Тэд, доторх → ялгаатай байдлаасаа үл хамааран нийтлэг дадал, нийтлэг язгуур ашиг сонирхлынхоо улмаас дотоод хүчтэй эв нэгдлийг харуулдаг цор ганц хүчирхэг элит буюу → захирагч анги байдаг гэсэн хатуу үзэл баримтлалтай байв. Мөн тэд элитийн харьяаллыг ур чадвараар нь бүрдүүлэх нийгмийн нээлттэй байдлын тухай функционалист таамаглалтай санал нийлдэггүй. Энэ байр суурийг Michael Hartmann (*Elitesoziologie*, 2004) туршилтаараа үндэслэлтэй болгосон бөгөөд тэрээр, нийгмийн элитүүдийн пропорциональ бус элсүүлэлтийг зөвхөн нийгмийн боловсролын тогтолцооны гажуудлаар тайлбарлах боломжгүй, харин элитийн хүрээлэлд нэвтрэх шууд бөгөөд хүчтэй нөлөөг хөрөнгөтний гарал үүсэл үзүүлдэг гэдгийг харуулсан.

Michael Hartmann

Thomas B. Bottomore: *Elites and Society*. London 1964. Nachdr. 1993. – Dt.: *Elite und Gesellschaft*. Übers. von Gerda Kurz und Siglinde Summerer. München 1966, ³1974. Beate Kraus (Hrsg.): *An der Spitze. Von Eliten und herrschenden Klassen*. Konstanz 2001.

Stefan Hradil / Peter Imbusch (Hrsg.): Oberschichten – Eliten – Herrschende Klassen. Opladen 2003.

Michael Hartmann: Elitesoziologie. Frankfurt a. M. 2004.

Эмпирик (Empirie)

Эмпирик (грекээр *empeiria* = “туришлага”) гэдэг ухагдахуунаар бодит байдал дээрх ажиглалтад үндэслэсэн шинжлэх ухааны танин мэдэхүйн ололтыг (→ шинжлэх ухаан) хэлдэг. Туршлагад суурилсан мэдлэгийг (→ мэдлэг) системтэйгээр интерсубъектив ойлгомжтой байдлаар олж авч, тайлбарладаг. Нийгмийн шинжлэх ухаанд болон ялангуяа → социологид нийгмийн нөхцөл байдал, зүй тогтлыг судлахын тулд эмпирик өгөгдлийг нийгмийн эмпирик судалгааны аргаар цуглуулдаг. Эмпирик судалгааны зорилго нь (1) онолууд болон тэдгээртэй уялдсан таамаглалуудыг шалгах, (2) зарим нэг өвөрмөц үйл явцыг судлахын тулд (жишээлбэл, Германд орлогын төвлөрөл хэр байна гэх мэт) болон (3) нийгмийн төлөвлөгдсөн арга хэмжээний үр нөлөө болон төлөвлөгдөөгүй үр дүнг судалж мэдэхэд оршино (Үр дүнгийн эсвэл үнэлгээний судалгаа).

Эмпирик нь нийгмийн шинжлэх ухааны онол гаргахтай нягт харилцан холбоотой. Тиймээс судалгааны сонирхол татахуйц таамаглалуудын тусламжтайгаар нийгмийн үзэгдэл, үйл явцад (жишээлбэл, гэр бүлийн бүтцийн → өөрчлөлт, өөр нутаг орноос шилжин

суурьшигчдын хүүхдүүдийн суралцах боломж, нийгмийн → хэм хэмжээний гажуудал, → гэр бүл, боловсрол, шилжилт хөдөлгөөн) ажиглалт явагддаг. Эсрэгээрээ онол болон онолоос гаргаж болох таамаглалууд нь эмпирик байдлаар шалгагдаагүй бол зүгээр л хоосон яриа болж үлдэнэ. Олон онол үнэмшилтэй санагддаг. Гэвч тэдний оновчтой эсэхийг зөвхөн эмпирик байдлаар тодорхойлох боломжтой. Таамаглалууд эсвэл онолын хүлээлтүүд буруу болох нь батлагдаж болно. Ийм учраас эмпирик судалгаа нь үргэлж аливаа “үр дүнд нээлттэй” бөгөөд үр дүнд хүрэхэд ашигласан аргачлал (→ арга зүй) нь бодитоор нотлогддог байх ёстой. Эмпирик судалгаагаар уламжлалт өрөөсгөл ойлголттой зөрчилдөхүйц шинэ, гэнэтийн үр дүн гарах нь цөөнгүй. Энэ утгаараа эмпирик нийгмийн судалгаа нь бас шүүмжлэн таниулж, цаг үеийг оношилж байдаг. XVII зуунд Англид улс төрийн арифметик гарч ирж, Германд их сургуулийн статистик бий болсоор нийгмийн шинжлэх ухааны орчин үеийн эмпирик судалгааны арга зүйн эхлэл тавигдсан байдаг. Өнөөдрийг хүртэл нарийн ажиллагаатай, олон талт судалгааны арга зүй болон хөгжиж ирсэн.

Суурь мэдлэгийн түвшин болоод дэвшүүлсэн асуудал, таамаглалын нарийвчлалаас шалтгаалаад эмпирик судалгааны арга зүйг дотор нь *тодорхойлох, баталгаажуулах* (таамаглалыг шалгах) гэж хувааж болно. Тодорхойлох эмпирик судалгааны аргын онцлог нь нэлээд нээлттэй, стандартчилаагүй байдаг бөгөөд нийгмийн салбарт суурь мэдлэг багатай үед

голчлон ашигладаг. Энд дараах хоёр үйлдлийг хийх шаардлагатай болно. Эхлээд тодорхойлох судалгааны үе шатанд таамаглалуудыг дэвшүүлэх буюу боловсруулах ба түүнийг хоёрдугаар үе шатанд стандартчилсан горимоор эмпирик туршилт хийн шалгана. Тодорхойлох болон таамаглал шалгах эмпирик судалгаа нь нийгмийн судалгааны стандартчилаагүй (чанарын) ба стандартчилсан (тоон) ялгаатай (зарим талаараа) нийцдэг. Тодорхойлох судалгаанд илүүтэй ажиглалт, урьдаас бэлтгэсэн асуулгын дагуу ярилцлага хийх, хүүрнэл ярилцлага хийх гэх мэт стандартчилаагүй чанарын судалгааны аргуудыг ашигладаг. Өнөөгийн хэрэглэгдэж буй энэхүү “чанарын” болон “тоон” гэсэн судалгааны аргуудын нэр томъёоны ялгаа нь үнэндээ төөрөгдүүлдэг. “Стандартчилсан” ба “стандартчилаагүй” эмпирик судалгааны аргууд гэж ярих нь илүү оновчтой санагдана.

Эмпирик нийгмийн судалгааны сонгодог судалгаанд жишээлбэл, стандартчилалгүй ажиглалтын оролцоотой хайлт хийгдэнэ (жишээ нь, William F. Whyte, *Street Corner Society*, 1943, dt. 1996), хайлт, таамаглалд чиглэсэн стандартчилалгүй эсвэл стандартчилсан аль ч аргаар хийгдэнэ (жишээ нь, Marie Jahoda [u.a.], *Die Arbeitslosen von Marienthal*, 1933), эсвэл зөвхөн стандартчилсан аргуудыг ашигладаг (жишээ нь, James S. Coleman [u. a.], *Equality of Educational Opportunity*, 1966). Эдгээр бүх судалгаануудад байгаа нийтлэг зүйл нь ерөнхийлөн дүгнэх боломжтой үр дүн гарах явдал юм. Стандартчилсан асуулгын аргачлал бүхий Колеманы

тайлан (*Coleman-Report*) нь нийгмийн судалгаанд хамгийн түгээмэл тохиолддог судалгааны төрөл байж болох юм. Орчин үеийн хувилбарууд нь боловсролын үнэлгээний PISA³¹-судалгаа эсвэл нийгмийн судалгааны томоохон төслүүд, жишээ нь, 1984 оноос хойш Германы өрхүүдэд тогтмол хийгдсэн нийгэм-эдийн засгийн панел судалгаа, эсвэл 1985 оноос хойш олон улсын судалгааны байгууллагуудын холбоо хариуцаж янз бүрийн сэдвээр жил бүр мэдээлэл цуглуулдаг болсон *олон улсын нийгмийн судалгааны хөтөлбөр* байна.

Эмпирик судалгааны үйл явц дараах үе шатанд хуваагдаж болно:

(1) Юуны түрүүнд судалгааны асуудлыг томъёолно (судалгааны нэг эсвэл нэлээд хэдэн таамаглалыг дэвшүүлнэ).

(2) Дараа нь судалгааны явцыг төлөвлөнө. Үүнд, таамаглал дэвшүүлэхэд чухал ач холбогдолтой хувьсах хэмжигдэхүүнүүдийг тодорхойлох, хэмжих, өгөгдөл цуглуулах аргаа сонгох зэрэг орно.

(3) Цаашлаад судалгааны дизайныг боловсруулна. Өгөгдлийг нэг цаг хугацаанд (босоо загвар) эсвэл хугацааны давтамжтайгаар олон удаа (хэвтээ загвар; тренд эсвэл панел судалгаа) цуглуулж болно. Туршилтын (хяналтын болон туршилтын бүлгүүдийн хооронд санамсаргүй хуваарилалт) эсвэл туршилтын бус загварыг сонгож болно. Мөн хээрийн туршилт хийх боломжтой. Энэ нь лабораторид биш, харин гадуур

31 Programme for International Student Assessment/Суралцагчдын үнэлгээний олон улсын судалгаа.

нийгмийн орчинд хийгддэг туршилтууд юм. Нийгмийн шинжлэх ухаанд санал асуулга (Surveys) бүхий туршилтын бус загварууд давамгайлдаг боловч энэ нь таамаглалын шалтгааныг шалгахад тодорхой үр дүнг тэр бүр өгдөггүй (ихэвчлэн “хуурамч хамаарал” харуулдаг). Эцэст нь, түүврийн хамрах хүрээ, түүвэр хийх эх олонлог, мөн түүвэр хийх арга зүйг тодорхойлно (ингэхдээ шинжлэх ухааны нийгмийн судалгаанд ерөнхийдөө санамсаргүй түүврийн онолыг баримталдаг). Судалгааны хэрэглүүрийг хянаж шалгасны дараа (урьдчилсан тест) өгөгдөл цуглуулах ажлыг гуравдугаар шатанд эхлүүлнэ. Хэдийгээр *нүүр тулсан ярилцлагаас* одоо утсаар болон компьютерын тусламжтайгаар ярилцлага авах (CATI³²-техник), мөн сүүлийн үед онлайн асуулгын хэлбэрт илүүтэй шилжих болсон ч ярилцлага хийх нь хэзээнээс гол ашиглагддаг судалгааны арга хэрэгсэл байсаар ирсэн. Бусад судалгааны мэдээлэл цуглуулах арга хэрэгсэлд ажиглалтын техник, агуулгад анализ хийх, цаашлаад “үйл явцыг харуулсан” өгөгдлийн мэдээллийг цуглуулах (жишээлбэл, гэр бүлийн бүртгэлээс гэр бүл салалтын мэдээлэл, даатгалын байгууллагаас ослын мэдээлэл) зэрэг багтана. Хоёр ба гуравдугаар үе шатуудын өөр нэг хувилбар бол одоо байгаа өгөгдөл дээрээ ажиглалт хийх хоёрдогч анализ юм.

(4) Эцэст нь өгөгдөлд (статистик) анализ хийнэ. Жишээлбэл, эцэг эхийн мэргэжлийн статус болон хүүхдүүдийн суралцах хугацаа хоёрын хоорондын

32 Computer Assisted Telephone Interview.

хамаарлын хүчийг регрессийн болон корреляцийн статистик шинжилгээний аргаар хэмжиж болно. Нийгмийн амьдралд олон үзүүлэлтүүд (хувьсагчид) өөр хоорондоо харилцан уялдаатай байдаг болохоор хамаарлын талаар илүү нарийвчлалтай дүгнэлт гаргахын тулд туршилтын бус судалгаанд ихэнхдээ орчин үеийн, олон хувьсагчтай статистикийн аргуудыг ашигладаг.

Andreas Diekmann / Ben Jann

Morton Hunt: Profiles of Social Research. New York 1985.

– Dt.: Die Praxis der Sozialforschung. Übers. von Margit Popp. Frankfurt a. M. / New York 1991.

Rainer Schnell [u. a.]: Methoden der empirischen Sozialforschung. München [u. a.] 1988, ⁷2005.

Andreas Diekmann: Empirische Sozialforschung. Grundlagen, Methoden, Anwendungen. Reinbek 1995, ¹⁸2007.

Jürgen Bortz / Nicola Döring: Forschungsmethoden und Evaluation für Human- und Sozialwissenschaftler. Berlin 2 1995, ⁴2006.

Эрүүл мэнд/Өвчин (Gesundheit/Krankheit)

“Эрүүл мэнд” (англиар *health*; францаар *santé*) буюу эсвэл “өвчин” (англиар *illness*; францаар *maladie*) гэдгээр ерөнхийдөө амьдралын явц дахь бие махбодын болоод сэтгэл зүйн гэмтэлгүй үйл ажиллагааг буюу

эсвэл гэмтлийг илэрхийлдэг. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (WHO) 1946 онд олон ишлэгддэг тодорхойлолтыг гаргасан хэдий ч норматив хэм хэмжээний төсөөллөөсөө болж шүүмжлэгддэг: “Эрүүл мэнд гэдэг нь бие махбод, сэтгэл санаа болон нийгмийн бүрэн тааламжтай оршихуйн төлөв байдлыг хэлэх ба зүгээр нэг өвчин согоггүй байдлыг хэлэхгүй”. Эрүүл мэнд ба өвчин гэдэг нь зөвхөн биологийн хуулиар зохицуулагдах биш харин нийгмийн амьдралын нөхцөл, системчилсэн байдлаар үүнд нөлөөж байдаг бөгөөд урьдчилан сэргийлэх болон эмчилгээний арга хэмжээ авах хэлбэрээр хөндлөнгийн зохион байгуулалтын оролцоотойгоор өөрчлөлт бий болж, эрүүл мэндийг дэмжих төслүүдээр дамжуулан эерэг нөлөө үзүүлэх боломжтойг харуулсан нотолгоо гарч ирэхийн хэрээр нийгмийн шинжлэх ухааны судалгаа, онолын түвшний судлагдахуун болж байна. Анагаах ухааны социологи болон бусад эрүүл мэндийн шинжлэх ухаанууд (сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх ухаан, *нийгмийн эрүүл мэнд*) эдгээр зорилтуудыг системчилсэн байдлаар хэрэгжүүлдэг. Эрт эрин үе болон бусад соёлд эрүүл мэнд, өвчин эмгэгийн асуудалд хэрхэн хандаж байсан талаарх нийгэм-түүх, соёлын харьцуулалттай нэг бус судалгаагаар нийгмийн конструкци гэдэг утгаар эдгээр ангилал тус бүрд ямар их ач холбогдол өгөх учиртай юм бэ гэдгийг тодорхой болгосон.

Хүн амын дундах өвчлөлийн тархалт, түүний шалтгааныг судалдаг эпидемиологийн судалгаа нь эрүүл мэнд, өвчний нийгмийн шалтгааны талаар эмпирик нотолгоог

өгдөг. Амьдралын чанар, эрүүл мэнд, нас баралтын эрсдэл нь юуны түрүүнд нийгмийн тэгш бус байдлын хэв маягийг дагадаг. Хүйсийн харьяалал (→ хүйс) ч мөн өвчлөх эрсдэлд нөлөөтэй. Нийгмийн шинжлэх ухааны хоёр дахь харах өнцөг нь анагаах ухааны институцийн тогтолцоо, түүний нийгэм-улс төрийн зохион байгуулалтын зарчмуудаар хүлээн зөвшөөрөгдсөн байдаг бөгөөд өвчлөлийн явцад төдийгүй эрүүл мэнд, өвчний талаарх нийгмийн тодорхой → хэлэлцүүлэгт ч нөлөөлж байдаг. Эрүүл мэндийг дэмжих амьдралын хэв маяг, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдэд шаардлагатай нөөцийг бүрдүүлэх зорилгоор эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрүүд (мөн *нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүд*)-ийг боловсруулсан.

Дундад зууны Христийн шашны уламжлалд эрүүл саруул байх, өвдөх, үхэх зэргийг хүмүүсийн нэг их нөлөөлж чадахгүй бурхны зурсан зураг гэж үздэг байсан. Хувь хүний эрүүл мэнд нь хувийн баялаг биш, харин бурхнаас заяасан хувь төөрөгт нэгдсэний илэрхийлэл байв. Энэ нь шинэ цагийн урсгалаар үндсээрээ өөрчлөгдөхөд хүрсэн. Эрүүл мэндийг юун түрүүнд санамсаргүй тохиолдол, хувь тавилан гэж харахаа улам бүр больж, харин хувь хүний амьдралын хэв маягийн илэрхийлэл гэж ойлгодог болжээ. Үүнийг амьдралын хэв маягийн зөв зохицуулалт, амьжиргааны нөөцөд хэмнэлттэй, үр бүтээлтэй хандах хандлагатай холбодог бөгөөд хөдөлмөрийн чадвартай (→ хөдөлмөр) улам бүр адилтгах болсон. Харах өнцөг ийнхүү өөрчлөгдсөн нь туршлагад суурилсан шинжлэх

ухаан дахь орчин үеийн анагаах ухааны (→ орчин үе) дэвшил, түүнд тавьсан хүлээлт болон итгэл найдвартай нягт холбогдох юм. Тэдний амжилт байгалийн болоод нийгмийн үйл явцад хөндлөнгийн оролцоо байх боломжтой бөгөөд шаардлагатай гэж үздэг мэдлэгтэй иргэдийн ухамсрын дотоод итгэл үнэмшлээс харагдана.

Гэвч орчин үеийн анагаах ухааны ололт амжилт, түүний санал болгож буй төрөлжсөн үйлчилгээ нь хэт ихээр эмнэлгийн эм хэрэгслээр эмчлэх гэх, илүү мэргэшсэн түвшинд хүргэх, сүүлийн жилүүдэд бүр илүүтэй хүний эрүүл мэнд, өвчнийг мөнгө болгож харах (зөвхөн санхүүгийн тал нь сонирхолтой) явдал нэмэгдэхэд бас хүргэж байна. Эрүүл мэндтэй холбоотой өөрөө өөртөө туслах бүлгүүд, эмнэлийн үйлчилгээг шүүмжилдэг хөдөлгөөнүүд гэхдээ яг энэхүү боломж дээр тулгуурладаг. Тэд эрүүл мэндийн шинжлэх ухааны шинэ хөтөлбөрүүдээс дэмжлэг авч байна. Ялангуяа Aaron Antonovsky-ын *Salutogenese*³³ (*Unraveling the Mystery of Health*, 1987, dt. 1997) загварт эрүүл мэнд нь сэтгэц-нийгмийн нөхцөлөөс ихээхэн хамаардаг болохыг туршилтын хувьд сайтар баталгаажсан хэлбэрээр харуулсан юм. Эрүүл мэндтэй холбоотой хувь хүний үйл ажиллагаа, биеийн “эсэргүүцэх чадвар”-ыг олж авах нь эрүүл мэндийн эрсдэлийг даван туулахад шийдвэрлэх ач холбогдолтой юм.

Heiner Keupp

33 А. Antonovsky-ын, анагаах ухаанд давамгайлж буй өвчний гарал үүслийг тодорхойлдог (Pathogenese) загвараас ялгаатай нь эрүүл мэндийн гарал үүслийг тайлбарладаг загвар.

- Toni Faltermaier: Gesundheitspsychologie. Stuttgart 2005.
- Alexa Franke: Modelle von Gesundheit und Krankheit. Bern 2006.
- Matthias Richter / Klaus Hurrelmann: Gesundheitliche Ungleichheit. Grundlagen, Probleme, Perspektiven. Wiesbaden 2006.

Эрсдэл (Risiko)

“Эрсдэл” (арабаар *rizq* = “*бурхны нигүүлслийг дагах*”) нь хүний шийдвэрт суурилдаг бөгөөд үүнийг бурхадтай хамаатуулдаг байгалийн гамшиг эсвэл хувь тавилангийн цохилттой андуурч болохгүй. Эрсдэл бол гамшиг биш, харин хүний гараар бүтсэн гамшгийн хүлээлт (урьдчилсан таамаглал), өөрөөр хэлбэл, орчин үеийн оршин тогтнох үндсэн нөхцөлүүдийн нэг болох ирээдүйн хөгжилтэй холбоотой тодорхойгүй байдал юм. Эрсдэл хувь хүнд төдийгүй бүхэл нийгэмд учирч болно. Эрсдэлийн нөлөөг хязгаарлахын тулд нийгмийн удыг (жишээлбэл, хувийн даатгал эсвэл төрийн нийгмийн халамж бүхэлдээ) бий болгосон бөгөөд энэ нь хувь хүмүүсийг хамгаалж, ачааллыг хуваарилах ажлыг зохион байгуулах, урьдчилан сэргийлж, хяналтын арга хэмжээ авах замаар эрсдэлийн хэмжээг хязгаарлах зорилготой юм. Niklas Luhmann (*Soziologie des Risikos*, 1991)-ын анхааруулж байсанчлан, эрсдэл нь шийдвэр гаргагч (тиймээс мөн энэ шийдвэрээс зайлсхийх боломжтой) болон энэхүү шийдвэр гаргалтад ямар нэг

оролцоогүйгээр үр дагаварт нь өртөгчдийн хооронд туйлширсан нийгмийн динамикийг нээж өгдөг.

Энэ үүднээсээ эрсдэлийн тухай ухагдахуун нь шинэчлэлийн (→ орчин үе) үйл явцад шийдвэр гаргалт, тодорхойгүй байдал, магадлалын талаарх ойлголтуудын утга учир нэмэгдсэнтэй салшгүй холбоотой. “Эрсдэл” нь гол зарчим нь → өөрчлөлт бөгөөд өөрийн бүтээх ирээдүйн нээлттэй, тодорхойгүй байдлыг өөртөө эргэцүүлэн тунгаах замаар шийдвэрлэх ёстой нийгэмд ойлголт, сэтгэлгээний загвар болдог. Олон нийгмийн мэдээллийн хэрэгсэл (→ хэвлэл мэдээлэл), нийгмийн хөдөлгөөнүүд, парламент, хуульчид гэх мэт субъектүүдийн оролцооны эрхтэй олон нийтийн эрсдэлийн хэлэлцүүлгүүд нь (хараахан) болоогүй ирээдүй рүү чиглэгдэж байдаг. Тиймээс тэдэнтэй холбоотой айдсыг шинжлэх ухаанаар няцаахад бэрх юм.

Эрсдэлийн динамикийн тухай таамаглал нь тодорхой бус байдлыг хянах институцчилэгдсэн механизмын сорилт, бэрхшээлийг даван туулж чадахааргүй дэлхийд бид амьдарч байгаа гэдэгт үндэслэгдэг. Тиймээс эрсдэлээс хамгаалах үйл ажиллагаа явуулдаг бүх институциуд үндсэн өөрчлөлтөд өртөж байна. Энэ нь юуны түрүүнд эдийн засаг, нийгмийн хөгжлийн явцад уламжлалт бүтцүүд (жишээ нь, → гэр бүлүүд, тосгоны нийгэмлэг харилцан нэг нэгэндээ туслах) задрахад нөлөөлж, үүнтэй холбоотой хөдөлгөөнт байдал, индивидуалитет (→ хувь хүн), мөн эрүүл мэнд (→ эрүүл мэнд), өндөр настны тусламж, нийгмийн халамжийн чиг үүрэгтэй чинээлэг төрт улсын үйл ажиллагааны

чадамжийг нэмэгдүүлэхэд хүргэдэг. Хувийн зах зээлийн хүрээнд (жишээ нь, хувийн тэтгэврийн даатгал) эрсдэлийг хуваарилах (эрсдэлийг хуваарилах, тодорхойлох) төрийн бус механизмууд сүүлийн хэдэн арван жилд хурдацтай хөгжиж байна. Даатгалын зах зээл, санхүүгийн зах зээл эсвэл нийтийн өмчийн зах зээл өнөөдөр эрсдэлээс хамгаалах цогц шийдлээр ажиллаж байгаа. Гэсэн хэдий ч эдгээр механизмын хөгжил нь шинэ эрсдэлийг бий болгож байна. Жишээ нь, залилан, хөрөнгийн зах зээлийн уналт эсвэл банк, даатгалын компаниудын дампуурлын улмаас иргэд хадгаламж, тэтгэврээ алдахад хүрдэг. Түүхэн туршлагаас харахад → төр “хамгийн сүүлийн шатны даатгагч” байх ёстой юу гэдэг асуулт гарч ирдэг.

Зах зээлээр дамжуулан эрсдэлээс хамгаалах механизмыг хөгжүүлэх нь эрсдэлтэй тулгарах тухай шийдвэрийг ухамсартайгаар гаргах, зарим талаараа тоон загварт үндэслэн ухамсартайгаар хянах хандлагын нэг хэсэг юм. Энэ нь шийдвэр гаргах үзэл баримтлалын үндэс, эрсдэлийг удирдахад чиглэгдсэн арга техникийг сайжруулсантай холбоотой. Эдгээр сайжруулалтын нөлөө хоёр талтай (хоёрдмол шинжтэй) бөгөөд тухайн хүмүүс, институцийн зан төлөвөөс хамаардаг. Ямар стратеги барьж байгаагаас хамаараад эрсдэлээс сэргийлэх болон эрсдэлийг нэмэгдүүлэх аль ч тохиолдолд ижил арга техникийг ашиглаж болно. Энэхүү хоёрдмол шинж чанар нь юуны түрүүнд эрсдэлийн сөрөг нөлөөллийг гуравдагч этгээд хариуцаж байгаад эцэст нь эргээд олон нийт хариуцлага үүрэх шаардла-

гатай болох тохиолдолд чухал ач холбогдолтой. Жишээлэхэд, Чернобылд болсон цөмийн цахилгаан станцын ослоор бусад орны хүн ам ч хохирч, түүний үр дагаврыг эцэст нь татвар төлөгчид нуруун дээрээ үүрэх ёстой болсон.

Гуравдагч этгээдийн үүрэх эрсдэлийн тухай асуудал нь ялангуяа нийтлэг ойлголтын хүрээнд мөнгөөр хэмжигдэхээргүй эрхэмжтэй үнэт зүйлс эрсдэлд орох үед үүсдэг. Байгаль орчны сүйрэл, цаг агаарын өөрчлөлт, халдварт өвчний дэгдэлт, терроризмын шинэ хэлбэрүүдийн талаарх олон нийтийн хэлэлцүүлгээс харахад эрсдэлтэй харьцах ухамсарт хандлага гэдэг бол зөвхөн хувь хүмүүсийн шийдвэр гаргалтын төдийгүй нийгмийн шийдвэр гаргах үйл явцын онцлог шинж юм. Хувийн институциудын (жишээ нь, гамшгаас хамгаалах) эрсдэлийн удирдлагад төвлөрдөг үйл ажиллагаанаас ялгаатай нь эдгээр хэлэлцүүлэг эрсдэлийг хянахаар гаргасан боломжуудад илүү үл итгэх хандлагатайгаар тодорхойлогддог. Үүний нөлөөгөөр төрийн үйл ажиллагаанд эргэлт гарч, илэрхий илт аюулаас хамгаалах арга хэмжээ авдаг байснаа урьдчилан сэргийлэх үйл ажиллагаагаар дамжуулан эрсдэлээс сэргийлдэг болоод байна.

Ulrich Beck

Ulrich Beck: Risikogesellschaft. Auf dem Weg in eine andere Moderne. Frankfurt a. M. 1986, ¹⁸2005.

- Weltrisikogesellschaft. Auf der Suche nach der verlorenen Sicherheit. Frankfurt a. M. 2007.

François Ewald: L'état providence. Paris 1986. – Dt.: Der Vorsorgestaat. Übers. von Wolfram Bayer und Hermann Kocyba. Frankfurt a. M. 1993.

Anthony Giddens: Beyond Left and Right. The Future of Radical Politics. Stanford 1994. – Dt.: Jenseits von links und rechts. Die Zukunft radikaler Demokratie. Übers. von Joachim Schulte. Frankfurt a. M. 1997, ³1999.

Christopher Daase (Hrsg.): Internationale Risikopolitik. Der Umgang mit neuen Gefahren in den internationalen Beziehungen. Baden-Baden 2002.

Эрх мэдэл/Хүчирхийлэл (Macht/Gewalt)

“Эрх мэдэл” бол хүний ердийн болон ер бусын гэж тооцоолсон гаднын хүчийг бусад хүмүүсийн эсрэг өөрийгөө батлах сүр хүч гэж Heinrich Popitz (*Phänomene der Macht*, ²1992) тодорхойлжээ. Энэхүү сүр хүч нь хүний төсөөлж болох бүхий л шинж чанарт, төсөөлж болох бүхий л нөхцөл байдалд суурилж болох тул Max Weber («Soziologische Grundbegriffe», in: *M. W., Wirtschaft und Gesellschaft. Grundriß der verstehenden Soziologie*, 1922) социологийн эрх мэдлийн тухай ойлголтыг “аморф” (хэлбэргүй, тодорхойгүй) гэж нэрлээд эрх мэдэл нь контекстээс хамааралгүй гэдгийг онцолжээ.

Эрх мэдэл нь ямар ч төрлийн харилцаанд хэрэгжих боломжтой, → хүйсийн хооронд, өсвөр насныхны бүлэгт (→ бүлэг), → улс хооронд. Эрх мэдлийн хэлбэрүүд нь олон янз боловч үндсэн дөрвөн төрлийн хувилбарт

хуваагдана: (1) *Үйлдэлт* эрх мэдэл нь хүчирхийллээр дамжуулан байгаль эсвэл хүний эд хөрөнгийг сүйтгэх, бусдыг гадуурхах (жишээ нь, хөөх) байдлаар тэр даруйдаа халдаж гэмтээдэг эрх мэдлийн хамгийн шууд хэлбэр юм. Үйлдэлт эрх мэдлийн үед бусдыг алж, дийлж, устгаж, үгүй хийдэг. (2) *Арга хэрэгсэлт* эрх мэдэл нь шийтгүүлэх эсвэл шагнуулах зан үйлийн эрх мэдэл юм. Учир нь амьд биет бол заналхийллээс айж, амлалтаас ашиг хүртдэг. Үүний эсрэг зорилготой. (3) *Авторитет* эрх мэдэл (→ авторитет) нь зан харилцаа, хандлагаар илэрнэ. Авторитетээс хамааралтай хүн авторитетийг бий болгосон хүний (→ хувь хүн) үнэт зүйл, үнэлэлт дүгнэлт, үзэл бодлыг баримталдаг. Энэхүү авторитетийг хүлээн зөвшөөрөх нь хүмүүсийн стандарт хэрэгцээ шаардлага, хүлээн зөвшөөрөгдөх эрмэлзлээс шалтгаалдаг (→ ижилсэл, нийгэмшил). (4) Эцэст нь хүн л байгаль болон бусад хүмүүсийг захирах эрх мэдлийг хэрэгжүүлдэг. Учир нь техникийн үйл ажиллагааны нөлөөгөөр байгалийг өөрчлөөд зогсохгүй, чулуугаар урласан гар сүхнээс авхуулаад дэлхийн өргөн сүлжээ (World Wide Web) хүртэл хүний гараар бүтсэн зүйлсийн “хоёр дахь мөн чанар”-ыг бий болгодог. Энэхүү өгөгдөлд суурилсан эрх мэдэл нь цацраг идэвхт хог хаягдал нөөцөлдөг эцсийн цэгүүдэд өдий хүртэлх хүний хүчин зүйлийн (→ байгаль орчин, эрсдэл, соёл иргэншил) цаг хугацаа, орон зайн болон үе үеийн бүх хил хязгаарыг зөрчдөг. Эрх мэдэл төвлөрөх (*хуримтлагдах*) үйл явцад эрх мэдлийн үндсэн хэлбэрүүд дангаараа болон холимог байдлаар тэлж, эрх мэдлийн дараагийн

хэлбэрүүдэд хуваагдан, түүх, соёлын өвөрмөц эрх мэдлийн хэлбэрүүдээр (жишээ нь, ид шид, цөмийн устгалын хүч, хэвлэл мэдээллийн хүч) холбогддог.

Эрх мэдэл болон хүчирхийллийн бүх хэлбэрт байдаг нийтлэг зүйл бол нэг талаас хүчгүйдэх, эрх чөлөөгүй байх мэдрэмж, нөгөө талаас үйл ажиллагааны болоод → эрх чөлөөт байдлын мэдрэмж гэсэн хоёр туйлт → бодит байдлыг бий болгодогт оршино. Эрх мэдэл болон хүчирхийлэлд хүн зөвхөн түүхэн шалтгаанаар бус, харин “түүхийн тусламжтайгаар” туршлагаждаг (Helmuth Plessner, *Macht und menschliche Natur*, 1931). Их, бага хэмжээгээр тогтсон → ноёрхлын, юуны түрүүнд төрийн хэлбэрт эрх мэдэл болон хүчирхийлэл нь нийгмийн хамгийн үр дагавартай, түүхэн хамгийн хүчирхэг үзэгдэл байдаг (vgl. Michael Mann, *The Sources of Social Power*, 2 Bde., 1986/93, dt. 3 Bde., 1990–2001).

Эрх мэдэл бол зөвтгөх үндэслэлтэй байх ёстой бөгөөд хууль ёсны (→ ноёрхол) тухай асуудал эрх мэдлийн онолын цөмд байдаг. Энэ нь ялангуяа хүчирхийллийн тухайд хамааралтай. Иймэрхүү хүчирхийллийн төрөлд бусдын биед санаатайгаар гэм хор учруулахад хүргэж буй үйлдэлт эрх мэдлийн аливаа хэлбэрийг нэрлэж болно. Хүчирхийллийг зөвтгөх хэрэгцээ хүчирхийлэл гэдэг ухагдахууныг тойрсон хэлэлцүүлэгт буцааж авчирдаг. Хүчирхийлэл гэж юу болох тухай төсөөлөл түүхийн хувьд, мөн нэг болоод нэжгээд соёлын хооронд ихээхэн хувьсах шинжтэй байна. Хүчирхийлэл гэдэг ойлголт нь үнэлэмж, хэмжүүрээр цэнэглэгддэг бөгөөд “бэлгэ тэмдгийн тэмцэл” (Pierre Bourdieu, »Espace so-

cial et pouvoir symbolique», in: P. B., *Choses dites*, 1987, dt. 1992), хууль ёсны талаарх хэлэлцүүлэг, шуугиан тарих үйл явцын нэг хэсэг (→ бэлгэ тэмдэг, хэлэлцүүлэг) юм. Хүчирхийллийн талаарх шинжлэх ухааны хэлэлцүүлгүүдэд эрх мэдэл, хүчирхийллийг хооронд нь эсрэгцүүлэх хандлага (Hannah Arendt, *Macht und Gewalt*, 1970) байхаас гадна, бас хүчирхийллийн талаарх хүний бие махбодын гэмтэмтгий байдалд чиглэсэн явцуу утгыг танигдахын аргагүй болгох хүртэлх ойлголтоор өргөжүүлдэг байдал ажиглагддаг. Сүүлийнхэд тохирох жишээ бол Johan Galtung-ын нөлөө бүхий “бүтцийн хүчирхийлэл” гэсэн нэр томьёо юм («Der besondere Beitrag der Friedensforschung zum Studium der Gewalt», in: *Gewalt*, hrsg. von Kurt Röttgers und Hans Sahner, 1978). Эрх мэдэл болон хүчирхийллийн түүхэн үндсэн хоёрдмол утгат байдал нь хүчирхийллийн тухай ойлголтын маргаантай шинж чанарт → эрх чөлөө, дэг журмын батлан даагч, булшлагч гэдгээр тусгалаа олсон.

Trutz von Trotha

Karl-Georg Faber: Macht, Gewalt. In: Otto Brunner [u. a.] (Hrsg.): *Geschichtliche Grundbegriffe. Historisches Lexikon zur politisch-sozialen Sprache in Deutschland*. Bd. 3. Stuttgart 1982. S. 817–935.

Panajotis Kondylis (Hrsg.): *Der Philosoph und die Macht*. Hamburg 1992.

Wilhelm Heitmeyer / John Hagan (Hrsg.): *Internationales Handbuch der Gewaltforschung*. Wiesbaden 2002.

Christoph Liell / Andreas Pettenkofer (Hrsg.): Kultivierungen von Gewalt. Beiträge zur Soziologie von Gewalt und Ordnung. Würzburg 2004.

Rainer Paris: Normale Macht. Konstanz 2005.

Эрх чөлөө (Freiheit)

“Эрх чөлөө” гэдэг ухагдахуун нь “эрх чөлөөгүй” гэсэн эсрэг ойлголтын адил хүн төрөлхтний зэрэгцэн оршихуйн үндсэн зарчим, үндсэн туршлагыг нэрлэх бөгөөд үүнийг Аристотель (*Politik 1317a40 ff.*) “хүссэн амьдралаараа амьдрах” гэж тодорхойлсон байдаг. Энэхүү ухагдахуунд нэгдсэн тодорхойлолт байхгүй, учир нь эрх чөлөөний хязгаарлалт янз бүрийн хэлбэртэй байх боломжтой. Энэ нь аливаа юмсын мөн чанарт оршин байж болох ба энэ тохиолдолд философийн үүднээс ойлгох хэрэгтэй болно. Мөн бусад хүмүүс, зэрэгцэн оршихуйн хэв маягаас хамаарч байж болох бөгөөд энэ үед улс төрийн гүн ухаан, нийгмийн шинжлэх ухааны судлагдахуун болно.

Зах зээлийн аж үйлдвэрийн болон либерал-ардчилсан хувьсгалын үр дүнд бий болсон “орчин үеийн нийгмүүд” (→ орчин үе) эрх чөлөөт гэдэг ойлголтыг агуулдаг-үйлдвэрлэх эрх чөлөөнд суурилж арилжааны зах зээл (→ эдийн засаг) гарч ирсэн, мөн иргэний эрх чөлөөнд суурилж хүний болон иргэний эрх (→ хууль) бий болсон байдаг. Социологийн үндсэн үүрэг бол эдгээр чөлөөт нийгэмд дүн шинжилгээ хийх явдал.

Тиймээс социологийг эдгээр хувьсгалын үр дүнд бий болсон сорилтын хариу болох эрх чөлөөний нэг хэлбэр гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл XVII, XVIII зууны улс төрийн онолд хүн хараат байдлаас гарч нас биед хүрэх нь ихэвчлэн шинэ, илүү сайн нийгмийн дэг журмын хүлээлттэй шууд холбогддог байсан. Францын хувьсгалаас үүдсэн гамшиг болон худалдаа арилжааны зохион байгуулалт бий болгосны үр нөлөөгөөр хүн амын дийлэнх хэсэг ядууралд автсан нь өөрөө нийгмийн мэдлэгийн шинэ хэлбэрийг өдөөж өгсөн байдаг. Гол асуулт бол эрх чөлөөтэй нөхцөлд нийгмийн эв нэгдэл хэрхэн бий болдог вэ? (Pierre Manent).

Энэ асуултад өгөх социологийн хариулт эрхэмж, итгэл үнэмшил, ашиг сонирхол, урамшууллын хэв маягаас урган гарсан эсвэл зүгээр л статистикийн хувьд тогтвортой гэж тодорхойлсон нийгмийн зүй тогтол, зүй ёсыг илрүүлэхэд оршино. Гэвч энэ хариулт асуудалтай, учир нь тэдгээр зүй тогтлууд эрх чөлөөг хязгаарлах шинэ хэлбэр гэж ойлгогдож бас болно. Үүнээс хойш энэ асуудлыг нийгмийн эсвэл социологийн-детерминизм гэдэг үүднээс байнга хэлэлцэж ирсэн. Хэрэв нийгмийн зохион байгуулалт нь нийгмийн хуулиар явдаг бол хүмүүс яг ч эрх чөлөөтэй биш юм. Энэхүү таамаглалын нийгэм-түүхийн хөгжлийн хувьд урьдчилан харах боломжгүй, барьцгүй байдал нь байнга сөрөг шүүмжлэлд өртдөг. Янз бүрийн нийгмийн хөгжил явагдаж болно, гэвч тэдгээрийн аль нь ч заавал шаардлагатай биш (→ хувьсал) юм.

Нэг талаас, нийгмийн детерминизм, нөгөө талаас,

эрх чөлөөний шаардлагын үр дүнд үүсэх радикал тохиолдлуудын хооронд удаан хугацааны турш алтернатив хувилбар гэж тооцогдож байсан социологийн хоёр тайлбарлах арга зүй бий болсон. Нэг талаар орчин үеийн нийгмүүдийг эрх чөлөөний институцчилал (→ институци) гэж тайлбарладаг. Энэ үүднээс орчин үед хөтлөх хувьсгалууд коллектив ажиллагааныхаа нөлөөгөөр функциональ → ялгааг бий болгодог бөгөөд энэ хүрээнд эв нэгдэл, амжилтаараа нийцэх эрх чөлөөт орон зайг бүтээдэг (Talcott Parsons, *The System of Modern Societies*, 1971, dt. 1972). Нөгөө талаар, эрх чөлөөний институцчиллын үйл явцад эрх чөлөө алдагдаж байдаг гэж шүүмжлэлт социологид үздэг (→ шүүмжлэлийн онол). Хүмүүс бие даан шийдвэр гаргах хязгаарлагдмал байдлынхаа хүлээснээс чөлөөлөгдөхийг оролдохдоо “төмөр тор” бүтээдэг (Max Weber, »Die protestantische Ethik und der Geist des Kapitalismus«, in: *Archiv für Sozialwissenschaften und Sozialpolitik* 20/21, 1904/05) эсвэл эрх чөлөө хүмүүсийн үйлдлийн санамсаргүй үр дагавар хэлбэрээр “ар хударгаар” нь устдаг (Karl Marx, *Das Kapital*, 3 Bde., 1867–94).

Сүүлийн хэдэн арван жилд нийгмийн олон практикийг ач холбогдолгүй болгосны үр дүнд энэ хоёр үзэл хандлага анхаарал татахаа больж байна. Өнөөгийн хувь хүнчлэл, даяаршлын талаарх хэлэлцүүлгүүдэд өмнө болж өнгөрсөн энэ маргаанаас цуурай нь үлдэж. Өнөөдөр зарим “хувь хүнчлэлийн шинэ үзэлтнүүд” эрх чөлөөг бодитоор хүлээн зөвшөөрдөг, зарим даяаршлыг шүүмжлэгчид найдлагагүйгээр алдагдсан гэж үздэг.

Гэвч энд нийгмийн үйл ажиллагаанд оролцогчийн нийгмийн нөхцөл байдалд хандах харилцаа (ихэвчлэн оролцогч–бүтцийн–асуудал гэж хэлэлцдэг; → оролцогч, бүтэц), цаашлаад үйлдлийг зөвтгөх хэм хэмжээний тайлбар, ональ дүрэм журмыг харгалзан үзсэн эрх чөлөө, түүний хязгаарлалтын талаарх анализ ховор хэвээр байгааг үл хайхарсан юм (vgl. z. B. Anthony Giddens, Luc Boltanski / Laurent Thévenot).

Peter Wagner

Jeffrey C. Alexander: Formal and Substantive Voluntarism in the Work of Talcott Parsons: A Theoretical and Ideological Reinterpretation. In: American Sociological Review 43 (1978). S. 177–198.

Anthony Giddens: The Constitution of Society. Outline of the Theory of Structuration. Cambridge 1984. – Dt.: Die Konstitution der Gesellschaft. Grundzüge einer Theorie der Strukturierung. Übers. von Wolf-Hagen Krauth und Wilfried Spohn. Frankfurt a. M. / New York 1988, Studienausg. ³1997.

Luc Boltanski / Laurent Thévenot: De la justification. Les économies de la grandeur. Paris 1991. – Dt.: Über die Rechtfertigung. Eine Soziologie der kritischen Urteilskraft. Übers. von Andreas Pfeuffer. Hamburg 2007.

Pierre Manent: La cité de l'homme. Paris 1994.

Peter Wagner: Soziologie der Moderne. Freiheit und Disziplin. Frankfurt a. M. / New York 1995.

Этнометодологи (Ethnomethodologie)

Этнометодологи бол Harold Garfinkel (*Studies in Ethnomethodology*, 1967)-ын үндэслэсэн мэдлэгийн социологийн конструктивист судалгааны арга зүй (→ мэдлэг, конструктивизм) бөгөөд соёлын зан үйлийн (→ соёл) эмпирик судалгааны тусламжтайгаар нийгмийн онолын асуудлуудыг (→ нийгмийн онол) тодорхойлдог. Этнометодологи гэдэг ухагдахуун нь мэдлэгийн тогтолцооны талаарх угсаатны судалгааг тодорхойлсон угсаатны зүй буюу *ethnoscience* гэх нэр томъёоноос гаралтай. Энд этнометодологийн гурван арга аргачлал гарч ирнэ: (1) соёлыг ажиглах арга, (2) эргэцүүлэн тунгаах арга, (3) практик-онолын арга.

(1) Энэхүү этнометодологи нь өөрийнхөө ертөнц доторх мэдлэгийн судалгааг хэлэх бөгөөд үүнийг судлахын тулд гаднын танихгүй зүйлийг → ойлгоно гэхээсээ илүүтэй доторх танил зүйлдээ “гайхширах” хэрэгтэй болно. Энд хямралын туршилтуудыг этнометодологи зай барих стратеги болгон ашигладаг. Хүмүүсийн өөрсдийн ертөнцөө зүй зохистой удирдах (→ утга учир) чадварыг харуулахын тулд ердийн нөхцөл байдалд нь саад бэрхшээл гаргаж ирээд, энэхүү асуудлыг хэвийн болгох чадварыг нь хардаг.

(2) Энэ этнометодологид этносоциологийн талаар, тодруулбал, → нийгэм доторх нийгмийн талаарх өдөр тутмын амьдралын мэдлэгийг (→ өдөр тутмын амьдрал) авч үздэг. Үүгээр дамжуулан → социологийн сэтгэлгээний таамаглалуудын талаар эргэцүүлэн

бодож таниулах ажил давхар явагдана. Энд амьдралын мэдлэгийг судалж буй шинжлэх ухааны оролдлого нь тэдний байр сууринд хадааж орхидог гэсэн шүүмжлэл ч гардаг. Энэ арга хандлагаар бол мэргэжлийн түвшинд явагдаж байгаа социологи нь өөрийн үндсэн судлагдахуун болох нийгмийн тухай өдөр тутмын амьдралын мэдлэгийг байнга сэтгэлгээний хэрэгсэл, нөөц болгон ашиглаж болохгүй гэж үздэг.

(3) Энэ нь нийгмийн шинжлэх ухааны мэдлэгээс гурван зүйлээр ялгаатай: (а) Түүний хэл ярианы илэрхийлэл туйлын тодорхой бус, тодорхой байдлаа зөвхөн тухайн нөхцөл байдлаас хамаарсан хэрэглээний явцад л олж авдаг. Garfinkel энэхүү тодорхой бус байдлыг (Ludwig Wittgenstein-ийн хэлний философид нийцүүлэн) өдөр тутмын нийгэмшлийн үйл явцад зайлшгүй шаардлагатай оновчтой зүйл гэж үзжээ. (б) Өдөр тутмын амьдралын мэдлэг бол Alfred Schütz-ийн → феноменологийн социологид аль эрт онцолж байсанчлан ярихад хэтэрхий ойлгомжтой чимээгүй таамаглалуудаас бүрддэг. (в) Зарим өдөр тутмын амьдралын мэдлэг огт ярих чадваргүй байх бөгөөд ямар нэг зүйлийг яг яаж хийгээд байгаагаа хэлж чадахгүйгээр хийж чадаад байгаа, илүүтэй чимээгүй бие махбодын чадвар, практик мэдлэг юм. Жишээ нь, яриа өрнүүлэх (das Thema ethnomethodologischer Konversationsanalyse; Paul Atkinson / John Heritage, *Structures of Social Action. Studies in Conversation Analysis*, 1984), эмэгтэй хүний дүр бүтээх (ein Thema ethnomethodologischer Gender Studies; Harold Garfinkel, »Passing and the Managed Achieve-

ment of Sex Status in an Intersexed Person», in: H. G., *Studies in Ethnomethodology*, 1967), төгөлдөр хуур тоглох (eines von vielen Themen ethnomethodologischer *studies of work*; Harold Garfinkel, *Ethnomethodological Studies of Work*, 1986) гэх мэт. Яг үүнийг, хүмүүсийн практик арга барил, тэдний өдөр тутмын ертөнцийг гаргаж ирэхийг этнометодологи гэж хэлээд байгаа юм. Этнометодологи нь рационал шүүмжлэлтэйгээр практик далд мэдлэгийг онцлохдоо бусад практик-онолын арга хандлагаар хуваалцдаг (жишээ нь, Erving Goffman, Pierre Bourdieu, Clifford Geertz нарын арга хандлага).

Нийгмийн онолын үүднээс нь харвал Garfinkel анхандаа нийгмийн бодит нөхцөлийг туршлага, үйлдлээс үл хамаарах өгөгдсөн факт гэж үздэг Émile Durkheim-аас өөр үзэлтэй байв. Этнометодологи нь нийгмийн бодит нөхцөлийн талаарх яг энэхүү туршлагын араас явж, үйлдэгчийн бодит өгөгдөл гэж хүлээн авч байгаа зүйлийг өөрийнх нь практик ур чадвар болгон нээдэг юм. Этнометодологийн хувьд нийгмийн бодит байдал бол зүгээр л байнга “хэрэгжиж” байдаг гүйцэтгэлийн бодит байдал юм. Бидний ажиллаж амьдарч буй ертөнц бол бидний “тохиролцдог”, бидний итгүүлдэг, зөвтгөдөг, биеэр үйлдэж, харилцан бие биедээ харуулдаг, баталгаажуулдаг зүйлүүд юм. Ажиллагааны шаардлага үүсэж байгаа судалгааны нөхцөл байдал руу социологийн анхаарлыг хандуулах зорилгоор этнометодологи *doing* гэсэн угтвар үгийг эдгээр төлөвүүддээ залгадаг: *doing gender*, *doing family*, *doing being angry* гэх мэт.

Talcott Parsons-ын структурализм (→ функционализм) бол оролцогчдыг “соёлын тогтолцоо”-ны зааварчилгаагаар хөдөлдөг утсан хүүхэлдэй болгож, “шүүгдсэн тэнэгүүд” шиг харагдуулдаг гэж Garfinkel эсэргүүцэж байв. Гэвч соёлын дүрэм журам бол дагаж мөрдүүлэх хэлбэрээ өөрөө тодорхойлж чадахгүй учраас үүнийг байнга байршуулж, тайлбарладаг оролцогчид байх зайлшгүй шаардлагатай бөгөөд тэдний энэ утга учир түгээж байгаа ажлыг тэр энд үл хайхарсан юм. Иймээс Garfinkel-ын хувьд нийгмийн дэг журмын асуудал бол харилцан үйлчлэлд оролцогчдын (→ харилцан үйлчлэл) үргэлж шинээр шийдвэрлэх хэрэгтэй болдог “зохион байгуулалт”-ын байнгын асуудал болдог.

Этнометодологи бол бараг үндсэндээ Schütz-ийн нийгмийн феноменологийн эмпирик хэрэгжүүлэлт байхын зэрэгцээ тэдгээрийн ухамсрын философийн байр суурийг эвддэг. Үүний эхлэл → субъект дээрээс биш, харин нийгмийн нөхцөл байдлаас үүдэлтэй юм. Schütz аливаа үйлдлийн утга учрыг үйлдэгчийн өмнө нь гаргаж байсан субъектив хандлагаас эрэлхийлдэг бол этнометодологи хүний хэлж байгаа зүйлийн утга учир нь зөвхөн *ex post* (дараа нь) нөгөө хүнтэйгээ харилцахад л тодорхойлогддог гэж үзжээ. Үйлдэл, үг хэллэг нь тухайн болж буй нөхцөл байдлын контекстээс байнга бөгөөд зайлшгүй хамаарч байдаг. Тиймээс утга учир гэдэг бол ажиглагдаж болох үзэгдэл бөгөөд энэ нь “гавал дотор” биш, харин бүхэлдээ ерөөсөө л хүний зан харилцааны орчинд байдаг гэж Garfinkel үзжээ. Garfinkel социологийг ойлгохдоо George Herbert Mead, Erving

Goffman нарын адилаар харилцааны шинжлэх ухаан хэмээн хүлээн авч байв (→ зан харилцаа).

Stefan Hirschauer

Jörg Bergmann: Ethnomethodologie. In: Uwe Flick [u. a.] (Hrsg.): Qualitative Forschung. Ein Handbuch. Reinbek 2000. S. 118–135.

Don H. Zimmerman / Melvin Pollner: Die Alltagswelt als Phänomen. In: Elmar Weingarten / Fritz Sack (Hrsg.): Ethnomethodologie. Frankfurt a. M. 1976. S. 64–104.

Ялгарал (Differenzierung)

Ялгарал бол → нийгмийн нэг чухал үзэгдэл юм. Ялгарал (латинаар *differentia* = *ялгаа*)-аар зөвхөн аливаа нэгэн үйл явцыг биш, мөн → бүтцийг илэрхийлдэг. *Бүтцийн тухайд ялгарал нь судалгааны бүрэлдэхүүнийг, жишээлбэл, нийгэм хэсгүүдээс бүрдэж байгааг хэлнэ. Эдгээр хэсгүүд нь хуучны нийгмийн үндсэн нэгж болох → гэр бүлүүд шиг нэгэн хэвийн байж болно; эсвэл орчин цагийн нийгмийн → эдийн засаг, → улс төр, → шинжлэх ухаан болон бусад дэд системүүд шиг өөр өөр хэв шинжтэй байж болно. Үйл явцын хувьд нийгмийн ялгарал нь тодорхой нэгэн ялгаатай бүтэц бүрэлдэж бий болох, тогтож үлдэх, өөрчлөгдөх динамикаар тодорхойлогдоно. Нийгмийн онолын үүднээс авч үзвэл юуны түрүүнд орчин үеийн нийгмийн (→ орчин*

үе) функциональ ялгааг агуулж байгаа → бүтэц болон динамикууд анхаарал татна. Үүгээр нийгэм нь хэдэн арван дэд системүүдээс бүрэлдэх тэгш бус байдал дээр суурилсан ялгаатай хэлбэрийг хэлж байгаа бөгөөд дээр дурдсанаас гадна мөн → хууль, цэрэг, → шашин, урлаг, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (→ мэдээллийн хэрэгсэл), → боловсрол, эрүүл мэнд, → спорт, дотно харилцааг хамруулж болно.

Нийгмийн ялгарлын тухай ойлголт нь нийгмийн хөгжлийг эрт цагаас өнөө үеийг хүртэл “эв нэгдэлгүй нэгэн төрлөөс эв нэгдэлтэй олон төрөл рүү” чиглэсэн динамик гэж ойлгодог Herbert Spencer-ийн хувьслын онол (→ хувьсал)-ын дагуу социологийн хүрээнд тархсан (*Principles of Sociology*, 1876, dt. 1877). Spencer үүгээр эртний нийгмийг гэр бүл гэх мэт нэгэн төрлийн элементүүдийн цуглуулга гэж хэтрүүлэн тодорхойлсон бол орчин үеийн нийгэм нь түүний хувьд төрөлжсөн элементүүдийн хоорондох өндөр зэрэглэлийн хөдөлмөрийн хуваарилалтыг харуулдаг гэж үздэг.

Émile Durkheim, Georg Simmel, Talcott Parsons болон Niklas Luhmann нар мөн энэ ойлголтыг судалж, ялгарлын онолоор сэтгэгчдийн чухал төлөөлөгчид болжээ. Нэмээд Karl Marx, Max Weber зэрэг нийгмийн онолчид яг энэ ялгарах нэршлийг ашиглаагүй ч ийм санааг бол илэрхийлж байсан. Сүүлийн үед ялангуяа Luhmann-ий бүтээлийн талаар мэтгэлцдэг Америкийн “нео-функционалистууд” (→ функционализм) болон Германы социологичид ялгарлын онолын хэлэлцүүлгийг өрнүүлсээр байна.

Функциональ ялгарлын хоёр үндсэн үзэл баримтлалыг хувааж үзэж болно. Durkheim болон Parsons нарын хувьд функциональ ялгарал нь функциональ тодорхой бус нэгжийн, тухайлбал, аливаа үүргийн эсвэл институцийн ялгарах үйл явцыг хоёр ба түүнээс дээш функциональ илүү тодорхой нэгжүүдээр харуулдаг. Хэрэв жишээ нь, сургууль байгуулж байгаа бол хүүхдийн хүмүүжлийн асуудлыг хэсэгчлэн гэр бүлтэй нь холбож авч үзэх шаардлагатай болно. Энэ тохиолдолд ирээдүй хойч үеийг хүмүүжүүлэх нийгмийн үүрэг бол эцэг эх болон багшийн үүрэг болж хуваагдана. Эндээс байгууллагуудын хөдөлмөрийн хуваарилалт (→ ажил)-тай адил дүр зураг харагдаж байна. Parsons-ийн хийсвэр аналитик судалгааны хүрээнд (*The System of Modern Societies*, 1971, dt. 1972) нийгэм нь нийгмийн шинэчлэлийн дөрвөн үндсэн функциональ шаардлагын аль нэгийг тус бүрдээ хангахуйц дөрвөн дэд системээс бүрддэг гэжээ (*эдийн засаг, улс төр, нийгмийн хамтын оршихуй болон ухаалаг тогтолцоо*). Энэ утгаараа нийгмийн ялгарлыг эдгээр дэд системүүд тус бүрдээ хоёр дахь эрэмбийн дэд системүүдэд (→ систем) задарч хуваагдах гэх мэтээр ойлгож болно.

Энэ үзэл баримтлалаас өөрөөр харж байсан Weber (*Gesammelte Aufsätze zur Religionssoziologie*, Bd. 1, 1920) орчин үеийн нийгмийн бүрдэл, гарал үүслийг олон бие даасан “үнэ цэний орон зай” (→ соёл) бий болсонтой холбон ойлгож байв. Шинжлэх ухаан, хууль эрх зүй, урлаг, улс төр, эдийн засаг, бэлгийн амьдрал гээд бусад салбарууд хуучин захирагддаг байсан

шашны үзэл суртлаасаа ээлж дараалан чөлөөлөгдсөн. Тиймээс сургууль байгуулах гэдэг нь өмнө гэр бүл дангаараа хийдэг байсан ажлыг одооноос хөдөлмөрийн хуваарилалтаар хуваагаад хийнэ гэсэн үг огт биш юм. Weber-ийн хувьд сургууль гэдэг бол нийгэмд цоо шинээр бий болж байгаа институцийн комплекс бөгөөд гэр бүр мөн шашин, эдийн засаг эсвэл улс төртэй харьцуулахад энд илүүтэй өөрийн гэсэн зорилготой болох, бие даах чадварыг боловсролоор дамжуулж олгодог гэж үзжээ.

Luhmann (*Die Gesellschaft der Gesellschaft*, 1997) нь Weber-ийн энэ “үнэ цэний орон зайн” ойлголтыг үйл ажиллагааны хувьд хаалттай, өөрт холбогдох → харилцаа холбооны хамаарлаас бүрдсэн нийгмийн дэд систем хэмээн бодитоор харсан байдаг. Luhmann-ийн үзсэнээр, жишээлбэл, шинжлэх ухаанд бүх зүйл энэ дэд системд зориулагдсан харилцааны чухал хэлбэр болох нийтлэлийн эргэн тойронд өрнөж байдаг: Нийтлэл нь ишлэгдэх байдлаар дараагийн нийтлэл гарна. Шинжлэх ухааны нийтлэлд гарсан үнэнийг нотлох баримтууд нь гагцхүү бусад нийтлэлүүдийн үнэнд тулгуурлагддаг болохоос биш папстын нэвтэрхий толь бичиг эсвэл намын хөтөлбөрт дурдсан мэдэгдлүүдээс үндэслэхгүй юм. Ингэхдээ Luhmann эдгээр дэд системүүдийн хоорондын олон талт харилцан хамаарлыг үгүйсгээгүй; гэвч тэрээр энэ дэд системүүдийн чуулгыг нийгмийн бүхэл бүтэн үйл ажиллагааг хангах, хадгалахад чиглэгддэг хэсгүүдийн үүргийн хуваагдал гэж ойлгож болохгүй гэдгийг

онцлон тэмдэглэжээ. Weber, Luhmann нар орчин үед олон янзын дэд систем нийгмийн ялгарлаар гарч ирж байгааг илүүтэй онцолж байв. Эдгээр нь өөр хоорондоо болон бүхэл нийгэмд бие даасан байдалтай байна. Тэгэхээр үнэн хэрэгтээ энэ бүхэн зөвхөн талуудын хоорондох олон удаагийн харилцан нөлөөлсөн хэлбэрээр л оршдог байна. Нийгэмд болон нийгмийн гишүүдэд үзүүлэх нөлөөгөөрөө функциональ ялгарлын энэ хоёр үзэл баримтлал нь хоёулаа бүхэлдээ эерэг юм уу эсвэл бүхэлдээ сөргөөр биш, харин “холимог адислал” хэлбэрээр нөлөөтэй байна. Parsons харин техникийн болон эдийн засгийн дэвшил, улам олон нийгмийн хувь оролцогчдыг “нийгмийн хамтрал”-д → хамруулж, цаашлаад эрхэмжит зүйлсийг ерөнхийлөх замаар нийтэд тархсан “иргэний шашны” үндэс болгох гэсэн өөдрөг дүр зургаар харж байсан. Durkheim (*De la division du travail social*, 1893, dt. 1977) нь функциональ ялгаатай нийгэмд шаардлагатай нийгмийн хэсгүүдийн саадгүй харилцан үйлчлэл болох “органик эв санааны нэгдэл”-ийг дэмжих ямар механизмууд байж болох талаар асуусан. Сүүлийн үед функциональ ялгарлын хяналтгүй → хувьслыг нийгмийн → интеграцчиллын аюул гэж харах болсон. Үүнийг Durkheim мөн эртнээс сэрэмжлүүлж аноми³⁴ хэмээх концептыг дэвшүүлж байсан. Нийгмийн нэг гишүүний хувьд хамаарах нь: Нэг талаас нийгмийн бүх дэд системүүдэд асар их сонголтууд гарч ирснээр хүн бүрд өөрийгөө

34 Нийгмийн бүтэц дэх нийгмийн интеграцчиллын хангалтгүй байдал, ялангуяа урьд өмнө хүчин төгөлдөр байсан зан үйлийн хэм хэмжээ алдагдаж, дагаж мөрдөхгүй байх нөхцөл байдал.

тодорхойлох өвөрмөц идентитетийг (ижилсэл-Identität) бий болгох боломжийг олгож байна. Нөгөө талаас энэ → индивидуалчлал (Individualisierung) өмнө нь хүн → нийгэмшил дотроосоо дэмжлэг авдаг байсан тэрхүү утга учиртай уламжлалт холбоо (→ мэдрэмж) тасарснаас үүдэн гарч ирж байгаагаар тодорхой болж байна. Ийнхүү функциональ хуваагдлын үр дагавар нь хөндийрөл болж таарч байна. Хэдий ийм зөрчилтэй үр нөлөөтэй ч функциональ ялгарал бол нийгмийн → өөрчлөлтийн энэ чиг хандлагыг зогсоохын аргагүй гэж харагдаж байна.

Uwe Schimank

Jeffrey C. Alexander / Paul Colomy (Hrsg.): Differentiation Theory and Social Change. Comparative and Historical Perspectives. New York [u. a.] 1990.

Uwe Schimank: Theorien gesellschaftlicher Differenzierung. Opladen 1996, ³2006.

Thomas Schwinn: Differenzierung ohne Gesellschaft. Umstellung eines soziologischen Konzepts. Weilerswist 2001.

Энэхүү лавлах тольд "оролцогч", "ажил/чөлөөт цаг", "гэр бүл", "анги/давхарга", "улс төр"-өөс авхуулаад "хүрээлэн буй орчин", "зан төлөв", "соёл иргэншил" зэрэг социологийн хамгийн чухал нэр томъёог хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтнүүд тайлбарласан болно.

Сэдэв болгон товч тайлбараар эхлэх бөгөөд үүний араас ихэнхдээ түүхэн болон системчилсэн бүтэцтэй бичигдсэн тайлбар бий. Сэдвийн төгсгөлд буй эх сурвалжийн богино жагсаалт нь тухайн сэдвийг илүү гүнзгий судлах боломжийг олгож буй юм.

СОЦИОЛОГИ

ISBN 978-9919-518-12-7



9 789919 518127

monsudar.mn